



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ПАРЛАМЕНТ



СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ

БОТЬ
48

“ПАРЛАМЕНТ”

(Судалгааны эмхэтгэл)



- Эдийн засгийн судалгааны хэсэг
- Нийгмийн судалгааны хэсэг
- Эрх зүй, төрийн байгуулалтын судалгааны хэсэг
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн судалгааны хэсэг

ННА-67
ДАА-340
П-183

ISBN 978-9919-9940-9-9

“Парламент” судалгааны эмхэтгэл (48 дугаар боть)-ийг
Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгээс
эрхлэн гаргав.

Хянасан: Д.Бумдарь (Ph.D.)
Ц.Норовдондог (Ph.D.)

Эмхэтгэсэн: Д.Жигваагүнсэл
Р.Оргилмаа

Эх бэлтгэсэн: Б.Төгсзаяа

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УИХ-ын Тамгын газар ©
“ПАРЛАМЕНТ” СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ - БОТЬ 48

ГАРЧИГ

I БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСАГ

- 1.1 Гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалт, төрөөс үзүүлж буй дэмжлэг: бусад орнуудын туршлага (СТ-24/203) 6

Ц.Норовдондог (Ph.D.), Р.Нургул, И.Жаргалзаяабямба, Х.Очир

- 1.2 Монгол Улсын зарим аймаг, сумын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд (СТ-24/408) 62

Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэг, И.Жаргалзаяабямба, О.Нарантуяа, Ц.Ариунаа

II БҮЛЭГ. НИЙГЭМ

- 2.1 Үндэсний соён гэгээрүүлэх үйл ажиллагаа ба иргэний ёс зүйн боловсролын хөтөлбөр: бусад орнуудын туршлага (СТ-24/206) 158

Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Б.Батцэцэг, Г.Алтан-Оч (Ph.D.), И.Жаргалзаяабямба, Б.Мөнгөнсувд

- 2.2 Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал, эрэгтэйчүүдийн нийгмийн байдлын талаарх тойм мэдээлэл (СТ-24/404) 213

Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, О.Нарантуяа, Б.Батцэцэг

- 2.3 Төрийн алба болон парламентын ажлын албаны мэргэшсэн ахмад ажилтнуудын талаарх хүний нөөцийн бодлого, зохицуулалт: олон улсын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал (СТ-24/208) 238

Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа, Б.Ууганжаргал, Б.Мөнгөнсувд

III БҮЛЭГ. ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛТ

- 3.1 Гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, нөхөн төлбөр олгох олон улсын болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт (СТ-24/204) 288

Г.Билгээ, Ц.Ариунаа, Э.Дашзэвэг, П.Уранчимэг, Э.Билгүүн

- 3.2 Парламент дахь цөөнхийн бүлэг буюу сөрөг хүчин: Онол арга зүй, олон улсын чиг хандлага, Монгол Улсын болон гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт (СТ-24/205) 326

Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэг, Г.Билгээ, Д.Халиун, Ц.Ариунаа, Э.Билгүүн, И.Жаргалзаяабямба, Р.Нургул, П.Уранчимэг, Т.Эрдэнэчимэг, Х.Очир

- 3.3 Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлтэй холбоотой зарим асуудал болон аймгийн төвийн хүн ам ба сонгогдох төлөөлөгчийн тооны харьцааны талаарх лавлагаа (СТ-24/407) 412

Г.Билгээ, Э.Дашзэвэг, П.Уранчимэг, Э.Билгүүн, Ц.Ариунаа

IV БҮЛЭГ. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 4.1 Мал аж ахуйн холбоо, төрөөс малчид руу чиглэсэн дэмжлэг, гадаадын зарим орны туршлага (СТ-24/408) 426

Ц.Норовдондог (Ph.D.), О.Билгүүтэй, Р.Нургүл, Р.Оргилмаа

БҮЛЭГ I

ЭДИЙН ЗАСАГ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ГАРААНЫ БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ
БҮЙ ДЭМЖЛЭГ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Р.Нургүл,
И.Жаргалзаяабямба, Х.Очир*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ
БҮЙ ДЭМЖЛЭГ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

НЭГ. ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

ХОЁР. ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА

1. Бүгд Найрамдах Итали Улс
2. Америкийн Нэгдсэн Улс
3. Израил Улс
4. Бүгд Найрамдах Узбекистан Улс

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн захиалгын дагуу “Гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалт, төрөөс үзүүлж буй дэмжлэг: бусад орнуудын туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэлээ.

Судалгааны хамрах хүрээ: Захиалагчаас ирүүлсэн хүсэлтийн дагуу дээрх сэдвийн хүрээнд Итали, Америк, Израил зэрэг гарааны бизнесээр дэлхийд сайн туршлагатайд тооцогддог орнууд, мөн хөгжиж буй орнуудаас Узбекистан улсын туршлагыг судалсан болно.

Орнуудын туршлагыг судлахдаа гарааны бизнесийн хууль, эрх зүйн зохицуулалт болон төрөөс үзүүлж буй дэмжлэг зэрэг холбогдох асуудлын хүрээнд авч үзлээ.

Судалгааны бүтэц: Судалгаа дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

1. Олон улсын чиг хандлага
2. Дэлхийн зарим орнуудын туршлага

Түлхүүр үг: *гарааны бизнес, стартап, гарааны бизнесийн хууль, эрх зүйн орчин*

Keywords: *start up, startup act, startup legal environment*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Гарааны бизнесийг дэмжих эрх зүйн зохицуулалт

Судалгаанаас үзэхэд, гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалтын чиг хандлага нь гарааны бизнесийг байгуулах, шинэ технологи, инновац бий болгох, түүнийг бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд тулгардаг саад тотгор, зардлыг бууруулах, хүнд суртлыг арилгах, гарааны бизнес бий болж хөгжихөд таатай орчин бүрдүүлэх, мөн гарааны бизнес өргөжих, хөгжихөд шаардлагатай төсөв, татвар, санхүүгийн болон бусад олон талт дэмжлэг үзүүлэх эрх зүйн суурийг бүрдүүлэх зорилготой байна.

Улс орнууд гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалтыг дараах байдлаар хийж ирсэн байна:

- Холбогдох хууль эрх зүйн орчин, бодлогын хүрээнд зохицуулах (жижиг, дунд үйлдвэрлэлийн тухай хууль гэх мэт салбарын болон бусад хууль, бодлогын баримт бичгийн хүрээнд);
- Гарааны бизнест зориулж тусгайлсан хууль батлах замаар.

Холбогдох хууль эрх зүйн орчны хүрээнд зохицуулах. Дэлхийн ихэнх улс орнууд тусгайлсан хууль батлах биш ихэвчлэн холбогдох бусад хуулийн хүрээнд, тэр дундаа жижиг, дунд бизнесийн тухай хуулиар гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулсан нь түгээмэл байна. Үүний зэрэгцээ зарим шаардлагатай асуудлыг, тухайлбал гарааны бизнесийн тодорхой нэг үйл ажиллагааг (жишээ нь, санхүүгийн зах зээлээс хөрөнгө босгох г.м) дэмжих зорилгоор тусгайлсан хууль баталж гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Түүнээс гадна Засгийн газрын хөтөлбөр, санаачилгын хүрээнд дэмжлэг үзүүлж байна.

Гарааны бизнест зориулж тусгайлан хууль батлах. Энэ нь харьцангуй шинэ хандлага бөгөөд гарааны болон технологийн жижиг, дунд бизнесийн үйл ажиллагааг тусгайлан зохицуулж гарааны бизнесийг байгуулах, өргөжүүлэх, хөгжүүлэхэд таатай экосистемийг бүрдүүлэх зорилготой байна.

Судалгаанд авагдсан орнуудын гарааны бизнесийн тусгайлсан хуулийн бүтцийг авч үзвэл дараах асуудлуудыг нийтлэг байдлаар зохицуулсан байна:

- Гарааны бизнесийг тодорхойлох;
- Гарааны бизнесийг байгуулах, татан буулгах;
- Оюуны өмчийн эрхийг хамгаалах;
- Гарааны бизнесийн санхүүжилт;
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт;

- Төрийн санхүүгийн дэмжлэг;
- Гарааны бизнесийн хөдөлмөрийн зах зээл;
- Гарааны бизнес хөгжих дэд бүтцийг бүрдүүлэх;
- Бүтээгдэхүүн борлуулалтын дэмжлэг.

Улс орнуудын гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалт нь тухайн орны хөгжлийн түвшин болон бизнесийн орчноос хамааран өөр өөр байна. Өндөр хөгжилтэй орнуудад бизнесийн орчин нь тааламжтай, эрх зүйн зохицуулалт нь энгийн бөгөөд боловсронгуй, шүүх засаглал нь шударга тул тусгайлсан хууль батлахгүйгээр холбогдох хуулиудын хүрээнд зохицуулсан нь ажиглагдаж байна. Харин хөгжиж буй орнуудын хувьд бизнесийн орчин таатай бус, хүнд суртал ихтэй, хуулийн засаглал муу тул судлаачид гарааны бизнест зориулж тусгайлсан хууль батлахыг зөвлөх болсон байна.

Дэлхийн ихэнх улс орнууд гарааны бизнест зориулж тусгайлсан хууль батлахгүйгээр бусад салбарын болон холбогдох хуулиудаар, ялангуяа жижиг, дунд бизнесийн тухай хуулиар гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулах нь түгээмэл байна. Жишээ нь: Япон, Солонгос, Америк, Их Британи, Малайз, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй, технологи өндөр хөгжсөн улсууд жижиг дунд бизнесийн тухай хуулийн хүрээнд гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулж дэмждэг байна. Одоогийн байдлаар Итали, Испани, Аргентин, Филиппин, Тунис, Сенегал, Нигери гэх мэт цөөн хэдэн улсууд гарааны бизнесийн тусгайлсан хуультай байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

Бүгд Найрамдах Итали Улс (Итали). Италийн Гарааны бизнесийн тухай хууль (Italian Startup Act) Европт сайн туршлага гэж хүлээн зөвшөөрөгддөг. Италид гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан эрх зүйн таатай орчныг бүрдүүлээд зогсохгүй бизнес эрхлэлт, инновацыг дэмжих янз бүрийн санаачилга, урамшууллыг хэрэгжүүлж байна.

Тухайлбал, Италид компани бүртгүүлэх үйл явцыг хялбаршуулж дижитал систем нэвтрүүлсэн. Тухайн гарааны бизнес Италид, эсвэл гадаадад байгаа эсэхэд ямар нэгэн хязгаарлалт тавьдаггүй.

Гарааны бизнесийн хөгжлийг дэмжихийн тулд Италийн Засгийн газраас татварын хөнгөлөлт чөлөөлөлт, буцалтгүй тусламж, санхүүжилтийн хөтөлбөр зэрэг олон янзын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Тухайлбал, гарааны бизнес эрхлэгчдэд татварын хувь хэмжээг бууруулах, зарим төрлийн шимтгэлээс чөлөөлөгдөх, венчурын сан, батлан даалтын санд хамрагдах гэх мэт давуу талуудыг олгодог.

Италид оюуны өмчийн хамгаалалт маш сайн зохицуулагдсан бөгөөд зохиогчийн эрх, патент, барааны тэмдгийн хууль тогтоомжийг сайн дагаж мөрддөг. Гарааны бизнес эрхлэгчид нь оюуны өмчийн эрхийг зохих ёсоор бүртгүүлж хэрэгжүүлснээр шинэлэг санаа, бүтээлээ хамгаалах боломжоор хангагдсан байна.

Гарааны бизнесийн хуулиас гадна Хөдөлмөрийн тухай, Компанийн тухай, Мэдээлэл хамгаалах тухай болон холбогдох бусад салбарын эрх зүйн зохицуулалтын хүрээнд уг асуудлыг зохицуулдаг.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ). Jumpstart Our Business Startups (JOBS) Act нь 2012 онд батлагдсан. Энэ хууль нь санхүүгийн зах зээлээс хөрөнгө татах, ялангуяа хөрөнгийн зах зээлд хувьцаа, үнэт цаас гаргах процессыг илүү хялбаршуулах замаар жижиг болон гарааны бизнес эрхлэгчдийн санхүүжилтийг дэмжих зорилготой.

JOBS хууль нь гарааны болон технологийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүүгийн зах зээлээс санхүүжилт татах, ялангуяа хөрөнгийн зах зээлд хувьцаа, үнэт цаас гаргахад илүү хялбар болгож өгсөн.

Гарааны бизнес эрхлэгчид нь энэ хуулиас гадна татварын, үнэт цаасны, хөдөлмөрийн, мэдээллийн нууцлал, зар сурталчилгаа, худалдаа, харилцаа холбооны, оюуны өмчийн, санхүү үйлчилгээ, даатгалын болон холбогдох бусад хууль тогтоомжуудыг дагаж мөрддөг. Үүний зэрэгцээ Засгийн газрын хөтөлбөр, санаачилгаар гарааны бизнест дэмжлэг үзүүлж байна.

Израил Улс (Израил). Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан эрх зүйн зохицуулалт нь дэмжлэг үзүүлэх тогтолцоо болон оюуны өмчийн эрхийг маш сайн зохицуулсан, хөрөнгө оруулалтад ээлтэй. Түүнээс гадна эрчимтэй технологийн экосистем, инновацын соёл зэрэг нь Израилыг гарааны бизнесээр дэлхийд алдартай, тэргүүлэгч орны нэг болоход нөлөөлсөн гэж үздэг.

Израилыг «Startup Nation» гэж нэрлэх болсон учир нь гарааны бизнесийн хүчирхэг экосистемтэй холбоотой. Гарааны бизнесийн экосистемийг дэмжих бодлого нь олон тооны амжилттай технологийн компаниудыг бий болгосон бөгөөд дэлхийн тавцанд инновац, бизнес эрхлэлтээрээ амжилтад хүргэсэн. Израилд гарааны бизнесийн тусгайлсан хууль байхгүй, бусад хуулийн хүрээнд зохицуулдаг. Түүнээс гадна Засгийн газраас олон талт цогц дэмжлэгүүдийг үзүүлдэг байна.

Израилд Венчур капиталын сан зэрэг янз бүрийн урамшууллаар гарааны бизнесийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд ихээхэн анхаардаг бөгөөд

хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлж байна. Эдгээр нь гарааны бизнест дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг татахад чиглэгддэг.

Засгийн газраас R&D үйл ажиллагаанд ахиу дэмжлэг үзүүлж, ялангуяа технологи, биотехнологийн салбарт шинэлэг төслүүдэд буцалтгүй тусламж, санхүүжилт олгодог. Израилын их дээд сургууль, судалгааны байгууллагууд технологи дамжуулалтад идэвхтэй оролцож, инновацын технологийг бизнес болгох, академи болон үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд анхаардаг.

Дөнгөж эхэлж буй гарааны бизнесийг дэмжих, зөвлөн туслах, нөөцөөр хангах зорилгоор хурдасгуур, гарааны инкубатор зэрэг инновацын төвүүдийг байгуулсан. Гарааны бизнес эрхлэгчдэд шинэ технологи, бизнесийн загваруудыг хяналттай орчинд турших боломж олгодог байна.

Өндөр мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийн тухай хууль (Law for Encouragement of Knowledge-Intensive Industry). Энэ хууль 2023 онд батлагдсан, өндөр технологийн салбарт (гарааны бизнес орно) Израилын хөрөнгө оруулагчдын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд хуулийн хүрээнд Израилын өндөр технологийн компанийн хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлдэг.

Дээрх хуулиас гадна Израилд гарааны бизнесийг дэмжихдээ холбогдох хууль эрх зүйн хүрээнд дараах гол асуудлуудыг зохицуулсан байна:

Компани байгуулах: Шинэ бизнес, тэр дундаа гарааны бизнесүүдийг бүртгэх, нэгтгэх үйл явц нь оновчтой, үр дүнтэй, харьцангуй хялбар байхаар зохион байгуулагдсан. Бизнес эрхлэгчдийг захиргааны дарамт багатайгаар бизнесээ байгуулж, ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн.

Оюуны өмчийг хамгаалах: Израилд оюуны өмчийн эрхийг хамгаалах хууль эрх зүйн орчин сайн бүрдсэн. Үүнд, патент, зохиогчийн эрх, барааны тэмдгийн хамгаалалт сайн, түүнчлэн эдгээр эрхийг хэрэгжүүлэх механизм нь боловсронгуй байдаг.

Хөрөнгө оруулалт ба санхүүжилт: Венчур капиталын экосистемийг сайн хөгжүүлж, гарааны бизнест хөрөнгө оруулагчдад янз бүрийн урамшуулал олгодог. Израилын Засгийн газар инновац, өсөлтийг дэмжих зорилготой буцалтгүй тусламж, зээл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрөөр дамжуулан гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж өгдөг.

Зохицуулалтын дэмжлэг: Израилын Засгийн газар гарааны бизнесийг хөгжүүлэх зорилгоор хяналттай орчинд шинэ технологи, бүтээгдэхүүнийг турших боломжийг олгодог.

Татварын урамшуулал: Гарааны бизнесийн инновац, технологийн хөгжилд хөрөнгө оруулахыг дэмжсэн R&D үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлдэг. Эдгээр урамшуулал нь судалгаа, хөгжүүлэлт хийж буй гарааны бизнес эрхлэгчдийн санхүүгийн ачааллыг бууруулна.

Технологийн дамжуулалт ба хамтын ажиллагаа: Израилын их дээд сургууль, судалгааны байгууллагууд технологи дамжуулах ажилд идэвхтэй оролцож, академи болон гарааны бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг идэвхжүүлдэг. Энэ нь судалгааны ажлаас бизнесийн хэрэглээ хүртэл шинэ технологи, шинэ санааг хэрэгжүүлэх процессыг хөнгөвчилдөг байна.

Бүгд Найрамдах Узбекистан Улс (Узбекистан): Узбекистанд гарааны бизнесийг инновац, технологид тулгуурласан, өсөлтийн өндөр чадамжтай, шинээр байгуулагдсан бизнес гэж тодорхойлдог. Гарааны бизнесийг хөгжүүлэхэд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх, уламжлалт үйлдвэрлэлд технологи нэвтрүүлэх, мөн үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд хөрөнгө оруулалт татахад голлон анхаардаг.

Узбекистанд гарааны бизнес эрхлэх эрх зүйн орчин улам бүр хөгжиж, илүү таатай болж байна гэж үздэг. Засгийн газраас бизнес эрхлэлт, инновацыг дэмжих чиглэлээр бүртгэлийн журмыг хялбарчлах, татварын хөнгөлөлт үзүүлэх, гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан эдийн засгийн тусгай бүс байгуулах зэрэг шинэчлэлийг хэрэгжүүлж байна.

Түүнээс гадна Узбекистаны гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүжилт, зөвлөх үйлчилгээний хөтөлбөр, гарааны бизнесийн сүлжээг дэмжих санаачилга болон энэ бизнест чиглэсэн бусад арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Гарааны бизнес эрхлэгчид Инновацын үйл ажиллагааны тухай, Гэр бүлийн бизнес эрхлэх тухай, Аж ахуй нэгжийн бизнес эрхлэх үйл ажиллагаа, баталгааны тухай, Оюуны өмчийн, Хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны тухай, Жижиг бизнес, аж ахуйн нэгжийн тухай, Өрсөлдөөнийг хамгаалах тухай мэдээлэл хамгаалах тухай зэрэг хуулиуд болон бусад холбогдох хууль эрх зүйн зохицуулалтуудыг дагаж мөрддөг.

Узбекистаны парламент 2020 онд Гарааны бизнесийн тухай хуулийн төслийг боловсруулсан боловч 2024 оны байдлаар батлагдаагүй байна. Одоогоор гарааны бизнесийг зохицуулдаг гол хууль нь инновац, бизнес эрхлэлт, гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх зорилгоор батлагдсан Инновацын үйл ажиллагааны тухай хууль (Law of the Republic of Uzbekistan on Innovative activity) юм. Хуульд гарааны бизнесийг дэмжих

эрх зүйн орчныг бүрдүүлсэн бөгөөд үүнд, оюуны өмчийн эрх, технологи дамжуулах, хөрөнгө оруулалтыг урамшуулах, төрөөс дэмжих хөтөлбөр зэрэг зохицуулалтыг тусгасан байна.

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын гарааны бизнесийн тодорхойлолт болон хуульд тусгасан зохицуулалтууд

<p>Итали</p> <p>Италийн гарааны бизнесийн тухай хууль (Italian Startup Act) нь Италийн гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулдаг тусгайлсан хууль.</p>	<p>АНУ</p> <p>(тусгайлсан хууль батлаагүй)</p> <p>Jumpstart Our Business Startups (JOBS) Act хууль нь гарааны бизнесийн тодорхой нэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой.</p>	<p>Израил</p> <p>(тусгайлсан хууль батлаагүй)</p> <p>Гарааны бизнес болон өндөр технологийн компаниудыг дэмжих чиглэлээр хамгийн сүүлд батлагдсан хуулийн нэг Өндөр мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийн тухай хууль (Law for Encouragement of Knowledge-Intensive Industry)</p>	<p>Узбекистан</p> <p>(2020 онд гарааны бизнесийн хуулийн төсөл боловсруулсан боловч батлагдаагүй)</p> <p>Гарааны бизнесийг зохицуулах гол хууль нь Инновацийн үйл ажиллагааны тухай хууль (Law of the Republic of Uzbekistan on innovative activity)</p>
<p><i>Гарааны бизнесийн тодорхойлолт</i></p>			
<p>Италид гарааны бизнесийг дараах байдлаар тодорхойлжээ:</p> <ul style="list-style-type: none"> • 5-аас дээшгүй жил үйл ажиллагаа явуулж буй, эсвэл шинээр байгуулагдсан; • Итали болон Европын холбооны улсад төвтэй (Италид салбартай) байх; • жилийн эргэлт нь 5 сая еврогоос ихгүй; • компанийн салбар компани бус, эсвэл хуваагдах, нэгдэх үйл ажиллагааны үр дүнд байгуулагдсан компани бус; • эрхэм зорилго нь инновацтай шууд холбоотой; • Хязгаарлагдмал компани байх; 	<p>АНУ-д гарааны бизнесийг тодорхойлсон хууль эрх зүйн тодорхойлолт байхгүй. Гэхдээ энэ нэр томъёо нь ихэвчлэн технологи, инновацын салбарт шинээр байгуулагдсан, хөгжил өсөлтийн эхний үе шатанд байгаа компанийг тодорхойлоход хэрэглэгддэг.</p>	<p>Израилд энэ тодорхойлолтыг хэрэглэдэг боловч хуулийн хүрээнд тодорхойлсон тодорхойлолт олдоогүй болно.</p>	<p>Узбекистанд гарааны бизнесийг инновац, технологид тулгуурласан, өсөлтийн өндөр чадамжтай, шинээр байгуулагдсан бизнес гэж тодорхойлсон байна.</p>

<ul style="list-style-type: none"> • ашиг хуваарилдаггүй байх; • зохицуулалттай зах зээл болон олон талт гэрээ, хэлэлцээрийн системд бүртгэлгүй байх. • Инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлдэг, боловсруулдаг, худалдаалдаг байх. <p>Эдгээрээс гадна гурван шалгуурын аль нэгийг хангасан байх шаардлагатай:</p> <ul style="list-style-type: none"> • R&D (судалгаа ба хөгжүүлэлт) болон инновацыг дэмжихэд жилийн зардал, эсвэл жилийн эргэлтийн хөрөнгийн 15-аас доошгүй хувийг зарцуулдаг байх; • Боловсон хүчний хувьд өндөр мэдлэг боловсролтой, чадварлаг байх. Үүнд, 1/3 нь докторант, доктор, эсвэл судлаач, эсвэл 2/3 нь магистр зэрэгтэй байх; • патент эзэмшигч, депозитор, эсвэл тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсвэл бүртгэлтэй программ хангамжийн эзэмшигч/зохиогч байх. 			
---	--	--	--



Гарааны бизнесийн хуулиар зохицуулсан зохицуулалтууд			
<p>Италийн хууль нь шинэ санаа, инновацын гарааны бизнесийг дэмжихэд чиглэсэн бөгөөд энэ төрлийн бизнес эрхлэхэд илүү таатай орчин, нөхцөл бүрдүүлэхэд анхаарсан.</p> <p>Хуульд гарааны бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж, тэдэнд төрөөс тусгайлан үзүүлж буй дэмжлэгүүдийн талаар тусгасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Дижитал бүртгэл; • Зарим төрлийн хураамжаас чөлөөлөх; • Уян хатан компанийн удирдлага; • Алдагдлаа нөхөхөд нэмэлт хугацаа олгох; • “Dummy” буюу халхавч¹ компанид хамаарах торгуулиас чөлөөлөгдөх; • НӨАТ-ын хөнгөлөлт; • Уян хатан хөдөлмөрийн гэрээ; • Хувьцааны опционоор нэмэлт урамшуулал олгох; • Гарааны бизнест хөрөнгө оруулагчдыг урамшуулах; • “crowdfunding” хөрөнгө оруулалтын хэлбэрээр санхүүжилт босгох; 	<p>Дээрх хууль нь санхүүгийн зах зээлээс хөрөнгө татах, ялангуяа хөрөнгийн зах зээлд хувьцаа, үнэт цаас гаргах процессыг илүү хялбаршуулж хөнгөвчлөх замаар жижиг болон гарааны бизнес эрхлэгчдийн санхүүжилтийг дэмжих зорилготой.</p> <p><u>Хуулиар зохицуулсан гол зохицуулалтууд:</u></p> <p>Crowdfunding: JOBS Act нь жижиг болон гарааны бизнес эрхлэгчдэд Crowdfunding платформоор дамжуулан хувь хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгох боломжийг олгодог. Ингэснээр илүү олон хөрөнгө оруулагчдыг татах боломж олгож уламжлалт аргаар хөрөнгө босгох ачааллыг бууруулна гэж үзжээ.</p> <p>IPO хийх: Уг хууль нь олон нийтэд анхдагч зах зээлийн (IPO) хатуу зохицуулалтуудыг хөнгөлж IPO хийх уламжлалт үйл явцтай холбоотой зардал, тайлагнах шаардлагыг бууруулснаар олон нийтэд нээлттэй болох боломжийг нэмэгдүүлсэн.</p>	<p>Энэ хуулийн хүрээнд Израилын өндөр технологийн компаниудын хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлдэг:</p> <p>Хуулийн эхний хэсэг нь Судалгаа, хөгжлийн компанид хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчдад татварын кредит олгох;</p> <p>Хоёр дахь хэсэг нь Израилын Судалгаа, хөгжлийн компаниудын хувьцаа зарах хүсэлтэй хөрөнгө оруулагчдыг татвараас чөлөөлөх;</p> <p>Гурав дахь хэсэг нь бусад технологийн компаниудыг худалдаж авсан Израилын өндөр технологийн компаниудад татварын хөнгөлөлт үзүүлэх талаар тус тус зохицуулжээ.</p>	<p>Дээрх хууль нь инновацын үйл ажиллагааны харилцааг зохицуулах зорилготой.</p> <p>Хуульд дараах асуудлыг зохицуулсан:</p> <ul style="list-style-type: none"> • Инновацтай холбоотой ойлголтууд; • Инновацын үйл ажиллагаанд төрөөс хийх зохицуулалт; • Инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэх; • Инновацын дэд бүтэц; • Инновацын үйл ажиллагааг санхүүжүүлэх; • бусад.

¹ Үндсэн компаниа эрсдэлээс хамгаалах зорилгоор байгуулсан халхавч компани. <https://www.lsd.law/define/dummy>

<ul style="list-style-type: none"> • Банкны зээл авахдаа Төрийн батлан даалтын санд давуу эрхтэй хамрагдах; • Италийн худалдааны агентлагийн зорилтот дэмжлэг; • Smart&Start Italia санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах; • Italia Startup Visa – визийн тусгай журам; • Italia Startup Hub (ISH). Европын холбооны гишүүн бус орны иргэд өмнө авсан виз, жишээ нь, суралцах зорилгоор авсан визээ хялбаршуулсан журмын дагуу "гарааны бизнес эрхлэх зөвшөөрөл" болгон өөрчлөх; • R&D зориулсан татварын кредит (tax credit) олгох; • Patent Box: оюуны өмчийн эрхтэй холбогдох орлогод татварын хөнгөлөлт үзүүлэх; • Хурдавчилсан элэгдэл хорогдуулалт; • Fail-fast - дампуурлын процесс илүү хурдан, хялбар, зардал багатай • Инновацын ЖДҮ ангилалд шилжих 	<p>A+ зохицуулалт (Reg A+): JOBS хуулийн Reg A+ зохицуулалт нь А зохицуулалтыг 5 сая ам.доллараас 50 сая ам.доллар болгон өргөжүүлсэн. Энэ нь жижиг болон гарааны бизнес эрхлэгчдэд IPO хийхэд бүртгэлд хамрагдахгүйгээр олон нийтэд хувьцаагаа шууд гаргаж хөрөнгө босгох боломж олгох ба хөрөнгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой.</p> <p>D зохицуулалт: Жижиг болон гарааны бизнес эрхлэгчдийн хувьд зар сурталчилгаанд тавигдах ерөнхий хоригоос чөлөөлөгдөх зохицуулалтыг тусгаж өгсөн. Ингэснээр жижиг болон гарааны бизнес эрхлэгчид үйл ажиллагаа, саналаа олон нийтэд илүү сайн сурталчлах, илүү олон хөрөнгө оруулагчдыг татах боломжтой болсон.</p> <p>Хөгжиж буй өсөлтийн компаниуд (Emerging Growth Companies-EGCs): JOBS хуулиар EGCs гэх компанийн шинэ ангиллыг бий болгож, түүнд 1 тэрбум ам. доллароос бага орлоготой, хувьцаа гаргаж буй компаниуд хамрагдахаар зохицуулсан.</p>		
--	--	--	--



(Дэлгэрэнгүй мэдээллийг Судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү)

Судалгаанд авагдсан орнуудын туршлагаас харахад, Италид гарааны бизнес гэж ямар бизнес байхыг хуульдаа тодорхой нарийвчлан зааж өгсөн. Харин АНУ болон Израилд энэ нэр томъёог хэрэглэдэг боловч хууль эрх зүйн тодорхойлолт байдаггүй. Узбекистанд гарааны бизнесийг инновац, технологид тулгуурласан, өсөлтийн потенциал өндөр, шинээр байгуулагдсан бизнес гэж тодорхойлсон байна.

Италийн гарааны бизнесийн тухай хууль гарааны бизнесийн үйл ажиллагааг цогцоор нь дэмжихэд чиглэсэн бол АНУ-ын JOBS Act нь гарааны бизнесийн тодорхой нэг үйл ажиллагаа буюу санхүүгийн зах зээлээс санхүүжилт татах үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн байна.

Израилд гарааны бизнесийг дэмжих тусгайлсан хууль байдаггүй, гэхдээ бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчин маш таатай тул гарааны бизнес сайн хөгжихөд нөлөөлсөн гэж үздэг. Израилын Өндөр мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийн тухай хууль нь өндөр технологийн компанийн (гарааны бизнес орно) хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх замаар өндөр технологийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой. Энэ хууль нь АНУ-ын хуулийн нэгэн адил гарааны бизнесийн тодорхой нэг үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн байна.

Узбекистаны парламент 2020 онд Гарааны бизнесийн тухай хуулийн төслийг боловсруулж хэлэлцүүлсэн боловч батлагдаагүй, одоогоор гарааны бизнесийг дэмжихэд чиглэсэн гол хууль нь Инновацийн үйл ажиллагааны тухай хууль юм.

Судалгаанд авагдсан орнуудын хувьд төрөөс гарааны бизнесийг дэмжихдээ тусгайлсан хууль баталж зохицуулах, эсвэл жижиг, дунд бизнесийн хууль, инновацын хууль гэх мэт бусад хуулийн хүрээнд зохицуулж байна. Түүнээс гадна гарааны бизнесийн тодорхой нэг үйл ажиллагааг (жишээ нь санхүүгийн зах зээлээс санхүүжилт татах) дэмжих хууль батлан хэрэгжүүлдэг.

Гарааны бизнесийг дэмжихдээ хуулийн хүрээнд зохицуулахаас гадна Засгийн газрын санаачилга, хөтөлбөрийн хүрээнд янз бүрийн дэмжлэгүүдийг үзүүлж байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ГАРААНЫ БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТӨРӨӨС ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

НЭГ. ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

Дэлхийн улс орнууд өсөлтийн потенциал бүхий инновац-технологийн жижиг, дунд аж ахуйн нэгж, түүн дотроо гарааны бизнесийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулан ажиллаж байна. Учир нь гарааны бизнес эдийн засгийг солонгоруулж, ажлын байрыг бий болгон, эдийн засаг дахь нийт бүтээмжийг нэмэгдүүлж урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж байдаг. Мөн түүнчлэн гарааны бизнесийн бий болгосон инновац-технологи нь нийгэмд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж үздэг.

Инновац-технологийн гарааны бизнесийг дэмжих бодлого нь гарааны бизнес бий болж хөгжихөд таатай экосистемийг бий болгоход оршиж байна. Өөрөөр хэлбэл, гарааны бизнесийг байгуулах, бий болгосон инновац-технологийг бизнес болгох, мөнгөжүүлэх, гарааны бизнесээ өргөжүүлж, хөгжүүлэх нөхцөлийг хангасан бизнес орчныг бий болгох явдал юм.

Улс орнуудын Засгийн газрын гарааны бизнесийг дэмжих бодлого нь дараах хүрээг хамаарч байна.

- Эрх зүйн зохицуулалт;
- Төрийн дэмжлэг;
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн хүртээмжтэй байдлыг бий болгох;
- Шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ;
- Энтерпренершип буюу бизнес эрхлэх ур чадварыг хөгжүүлэх.

Гарааны бизнесийг дэмжих эрх зүйн зохицуулалт

Гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалт нь гарааны бизнесийг байгуулах, шинэ технологи, инновац бий болгох, түүнийгээ бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд тулгардаг саад тотгор, зардлыг бууруулах, хүнд суртлыг арилгах, гарааны бизнес бий болж хөгжихөд таатай орчин бүрдүүлэхэд оршиж байна. Мөн түүнчлэн гарааны бизнес өргөжих, хөгжихөд шаардлагатай төсөв, татвар, санхүү болон бусад олон талт дэмжлэгийг үзүүлэх эрх зүйн суурийг бүрдүүлэхэд оршино.

Гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалт нь дараах хүрээг хамардаг:

- Захиргааны хүнд суртлыг арилгах: Гарааны бизнесийг байгуулах, лиценз зөвшөөрөл авах, гарааны бизнесээ худалдах, бизнесээ татан буулгахтай холбогдсон саадыг арилгах, захиргааны зардлыг бууруулах;
- Оюуны өмчийн хамгаалал: Тухайн гарааны бизнесийн бий болгосон инновац-технологийг хамгаалах;
- Төсвийн болон татварын дэмжлэг: Төсвөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэг болон татварын хөнгөлөлт;
- Хөдөлмөрийн зохицуулалт: Гарааны бизнесийн хөдөлмөрийн зах зээлийг уян хатан болгох;
- Гарааны бизнесийн санхүүжилт: Гарааны бизнесийн санхүүжилтийг хүртээмжтэй болгох;
- Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх: Хөрөнгө оруулагчдад татварын болон бусад хөнгөлөлтүүдийг үзүүлэх;
- Борлуулалт, зах зээлийн харилцаа: Гарааны бизнес бүтээгдэхүүнээ борлуулах, экспортлоход таатай нөхцөлийг бий болгох;
- Шүүхийн орчин: Гарааны бизнест таатай шударга, хялбар, зардал багатай шүүхийн процедур, практикийг нэвтрүүлэх.

Улс орнуудын гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалт нь үндсэн 2 хандлагатай байна:

1. Салбарын болон холбогдох хууль эрх зүйн зохицуулалтаар зохицуулах (тухайлбал, жижиг, дунд үйлдвэрлэлийн тухай хууль гэх мэт)
2. Гарааны бизнест зориулж тусгайлсан хууль батлах.

Салбарын болон холбогдох хууль эрх зүйн зохицуулалтаар зохицуулах. Дэлхийн ихэнх улс орнууд гарааны бизнест зориулж тусгайлсан хууль батлахгүйгээр бусад хуулиудаар, ялангуяа жижиг, дунд бизнесийн тухай хуулиар гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулах нь түгээмэл байна. Жишээ нь: Япон, Солонгос, Америк, Их Британи, Малайз, Сингапур зэрэг өндөр хөгжилтэй, технологи өндөр хөгжсөн улсууд жижиг дунд бизнесийн тухай хуулийн хүрээнд гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулж дэмждэг байна.

Үүний зэрэгцээ гарааны бизнесийн тодорхой нэг үйл ажиллагааг дэмжих зорилгоор тусгайлсан хууль батлах нь гарааны бизнесийг хөгжүүлэхэд дэмжлэг болдог. Жишээ нь: Америкийн JOBS буюу Jumpstart Our Business Support Act нь гарааны болон технологийн жижиг дунд бизнесийг санхүүгийн зах зээлээс санхүүжилт татах, ялангуяа хөрөнгийн зах зээлд хувьцаа, үнэт цаас гаргахад илүү хялбар болгосон. Харин Солонгост Жижиг дунд бизнесийн технологийг хамгаалах хууль, Жижиг дунд бизнес

дэх инновац-технологийг урамшуулах хууль, Солонгосын Технологийн Корпорацийн тухай хууль гэх мэт хэд хэдэн хууль баталж гарааны бизнес, технологийн жижиг дунд бизнесийг оюуны өмчийн хувьд, санхүүгийн дэмжлэг үзүүлэх хүрээнд, шинэ инновац-технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг болох таатай эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Гарааны бизнесийн үйл ажиллагааг хуулиас гадна Засгийн газрын хөтөлбөрийн хүрээнд зохицуулалт хийж дэмждэг. Тухайлбал, Малайзад гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулах тусгайлсан хууль батлаагүй. Гэхдээ Аж үйлдвэрийн 3-р мастер планы хүрээнд гарааны болон технологийн жижиг дунд бизнесийг дэмжих бодлогыг боловсруулж тэдгээрийг дэмжих RMKe-11 стратеги бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээг Засгийн газрын тусгайлсан агентлаг болох Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх корпорац (SMIDEC) болон Малайзын дижитал эдийн засгийн корпорац хэрэгжүүлдэг. Японд Засгийн газар нь J-Startup санаачилгыг дэвшүүлэн олон улсын гарааны бизнесийг татах, дотоодын гарааны бизнесийг бий болгон хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна.

Гарааны бизнест зориулж тусгайлсан хууль батлахгүйгээр бусад хууль эрх зүйн хүрээнд зохицуулахын давуу тал нь гарааны бизнесээс гадна тогтвортой үйл ажиллагаа явуулдаг технологийн жижиг, дунд бизнест дэмжлэг үзүүлдэг. Гэхдээ тухайн улсын бизнесийн орчны хөгжил муу, эрх зүйн зохицуулалт сул бол гарааны бизнес хөгжихөд саад болох сул талтай гэж үздэг.

Гарааны бизнест зориулж тусгайлан хууль батлах. Энэ нь гарааны бизнесийн эрх зүйн зохицуулалтын харьцангуй шинэ хандлага гэж болно. Одоогийн байдлаар Итали, Испани, Аргентин, Филиппин, Тунис, Сенегал, Нигери гэх мэт цөөн хэдэн улсууд гарааны бизнесийн тусгайлсан хуультай байна.

Гарааны бизнесийн тусгайлсан хууль нь гарааны болон технологийн жижиг, дунд бизнесийн харилцааг тусгайлан зохицуулж дэмжих бөгөөд гарааны бизнесийг байгуулах, өргөжүүлэх, хөгжүүлэхэд таатай экосистемийг бүрдүүлэх зорилготой байна.

Гарааны бизнесийн хууль нь гарааны бизнесийн үйл ажиллагааг зохицуулахаас гадна гарааны бизнесийн хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа, гарааны бизнесийн санхүүжилт, гарааны бизнестэй холбоотой хөдөлмөрийн зохицуулалт, төсөв болон татварын дэмжлэг, төрөөс үзүүлж буй олон талт дэмжлэг зэрэг харилцааг зохицуулсан цогц эрх зүйн зохицуулалт юм.

Гарааны бизнесийн тухай хуульд дараах зохицуулалтуудыг тусгасан байдаг:

- **Гарааны бизнесийг тодорхойлох.** Бүх гарааны бизнес нь жижиг дунд бизнест хамаарах боловч бүх жижиг дунд бизнес нь гарааны бизнес биш юм. Тиймээс юун түрүүнд гарааны бизнесийг тодорхойлох нь чухал гэж үздэг. Гарааны бизнесийг 2 шалгуураар тодорхойлж байна:
 - Компанийн шалгуур (үйл ажиллагаа явуулсан хугацаа, ажилчдын тоо, орлогын хэмжээ г.м)
 - Компанийн үйл ажиллагааны шалгуур (инновац, технологи, өсөлтийн потенциал г.м)
- **Гарааны бизнесийг байгуулах, татан буулгах.** Гарааны бизнесийг байгуулах, бүртгэх, үйл ажиллагааны лиценз авах үйл явцыг хурдан, хялбар, зардал багатай байлгах нь чухал гэж үздэг. Улс орнуудын гарааны бизнесийн хуульд гарааны бизнесийг бүртгэх, лиценз авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж аливаа төлбөр, хураамжаас чөлөөлж байна. Мөн гарааны бизнесийг татан буулгахад аль болох зардал багатай байхаар зохицуулж байна.
- **Оюуны өмчийн эрхийн хамгаалалт.** Гарааны бизнесийн хамгийн чухал актив нь шинэ технологи, инновац байдаг тул оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудал чухалд тооцогддог. Тиймээс гарааны бизнесийн хуульд тухайн гарааны бизнесийн оюуны өмч нь баталгаатай байх болон түүгээрээ орлого олох боломжийг бий болгосон байдаг.
- **Гарааны бизнесийн санхүүжилт.** Гарааны бизнесийг хөгжүүлэх гол хүчин зүйл нь хүртээмжтэй санхүүжилт юм. Гарааны бизнесийн хуульд сахиусан хөрөнгө оруулагч (angel investor), венчур хөрөнгө оруулалтын сан, краудфандын хэлбэрээр хөрөнгө босгох (crowdfunding) зэрэг хөрөнгө оруулалтын арга хэрэгслээр санхүүжилт татах үйл ажиллагааг, мөн хөрөнгийн зах зээлээс хөрөнгө татах, хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагааг зохицуулж өгдөг.
- **Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт.** Энэ нь гарааны бизнесийг дэмжих хамгийн гол хөшүүргийн нэг байдаг. Гарааны бизнесийн хуульд гарааны бизнесийг дэмжих татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн талаар тусгадаг. Гарааны бизнест татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхээс гадна гарааны бизнест хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлж байна.
- **Төрийн санхүүгийн дэмжлэг.** Гарааны бизнесийг дэмжих үүднээс Засгийн газраас тусгай корпорац, хөрөнгө оруулалтын сангууд байгуулж гарааны бизнест гарааны санхүүжилт болон үйл ажиллагааг нь дэмжих зээл олгодог. Мөн Засгийн газрын

зээлийн баталгааны сангаар дамжуулан зээлийн батлан даалт гаргадаг.

- **Гарааны бизнесийн хөдөлмөрийн зах зээл.** Гарааны бизнесийн хуульд хөдөлмөрийн харилцааг илүү уян хатан байхаар зохицуулдаг. Мөн түүнчлэн хувьцааны урамшуулал олгох харилцааг тусгаж цалин, урамшууллын хувьд уян хатан байхаар зохицуулдаг.
- **Гарааны бизнес хөгжих дэд бүтцийг бүрдүүлэх.** Гарааны бизнес бий болж, хөгжих инкубатор төвүүдийг бий болгон, мэдээлэл технологи, цахим дэд бүтцийг бүрдүүлэх харилцааг хуульд тусгасан байдаг.
- **Бүтээгдэхүүн борлуулалтын дэмжлэг.** Гарааны бизнесийн бий болгосон инновац, шинэ технологи, бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулахад таатай нөхцөл бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх талаар гарааны бизнесийн хуульд зохицуулдаг. Мөн түүнчлэн төрийн худалдан авалтад гарааны бизнесийг дэмжих талаар тусгасан байдаг.

Гарааны бизнесийн хууль нь гарааны бизнестэй холбоотой бүхий л харилцааг багтаасан тул гарааны бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчид гарааны бизнестэй холбоотой хуулийн зохицуулалтыг нэг дороос мэдэх боломж олгодог давуу талтай. Мөн гарааны бизнест зориулсан таатай экосистемийг бий болгодог тул хялбар, бага зардлаар гарааны бизнесийг байгуулж, хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлнэ гэж үздэг.

Гарааны бизнес дотроо финтек стартап буюу санхүүгийн гарааны бизнесүүдэд илүү хяналт, зохицуулалт тавих хандлагатай байна. Ялангуяа криптовалют, санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж буй гарааны бизнесийн хувьд илүү нарийн зохицуулалт хийж байна. Тухайлбал, Мексик, Чили зэрэг улсууд финтек гарааны бизнесийг тусгайлан зохицуулдаг хууль баталсан.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁР. ДЭЛХИЙН ЗАРИМ ОРНУУДЫН ТУРШЛАГА

1. Бүгд Найрамдах Итали Улс

Итали Улс нь Гарааны бизнесийн тухай (Italian Startup Act) тусгайлсан хуультай боловч хууль нь интернэт хайлтаар англи, орос зэрэг нийтлэг хэлээр олдоогүй тул судалгаанд Италийн Эдийн засаг хөгжлийн яамны Аж үйлдвэрийн бодлого, өрсөлдөх чадвар, ЖДҮ-ийн ерөнхий газраас гаргасан “Italy’s new industrial policy for innovation Focus on innovative startups”² тайланг ашиглав (Уг тайланд гарааны бизнесийн хуульд гарааны бизнесийн үйл ажиллагааг хэрхэн зохицуулсан, мөн төрөөс үзүүлж буй дэмжлэг, хөнгөлөлтийн талаар тоймлосон).

Италийн Гарааны бизнесийн тухай хуулийг Европт хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлага гэж үздэг. Гарааны бизнес эрхлэгчид нь энэ хуулиас гадна бусад холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх ба үүнд, Хөдөлмөрийн тухай, Компанийн тухай, Мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжууд болон холбогдох бусад салбаруудын хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

Гарааны бизнесийн тухай хуульд гарааны бизнесийг дараах байдлаар тодорхойлсон:

- 5-аас дээшгүй жил үйл ажиллагаа явуулж буй, эсвэл үйл ажиллагаагаа шинээр эхэлж буй;
- Итали болон Европын холбооны улсад төвтэй (Италид салбартай) байх;
- жилийн эргэлт нь 5 сая еврогоос ихгүй;
- компанийн салбар компани бус, эсвэл хуваагдах, нэгдэх үйл ажиллагааны үр дүнд байгуулагдсан компани бус;
- эрхэм зорилго нь инновацтай шууд холбоотой;
- Хязгаарлагдмал компани байх;
- ашиг хуваарилдаггүй байх;
- зохицуулалттай зах зээл болон олон талт гэрээ, хэлэлцээрийн системд бүртгэлгүй байх.
- Инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлдэг, боловсруулдаг, худалдаалдаг байх.

Эдгээрээс гадна гурваншалгуурын аль нэгийг хангасан байх шаардлагатай. Үүнд:

² The Italian Startup Act, Italy’s national strategy to support innovative startups and innovative SMEs, https://www.mimit.gov.it/images/stories/documenti/Executive%20summary%20ISA%2007_2019.pdf

- R&D (судалгаа ба хөгжүүлэлт) болон инновацыг дэмжихэд жилийн зардал, эсвэл жилийн эргэлтийн хөрөнгийн 15-аас доошгүй хувийг зарцуулдаг байх;
- Боловсон хүчний хувьд өндөр мэдлэг боловсролтой, чадварлаг байх. Үүнд, 1/3 нь докторант, доктор, эсвэл судлаач, эсвэл 2/3 нь магистр зэрэгтэй байх;
- патент эзэмшигч, депозитор, эсвэл тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсвэл бүртгэлтэй програм хангамжийн эзэмшигч/зохиогч байх.

Италийн гарааны бизнесийн тухай хууль нь шинэ санаа, инновацын гарааны бизнесийг дэмжихэд чиглэсэн бөгөөд энэ төрлийн бизнес эрхлэхэд илүү таатай орчин, нөхцөл бүрдүүлэхэд анхаарсан.

Хуульд гарааны бизнесийн үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулж, төрөөс тусгайлан үзүүлж буй дэмжлэгүүдийн талаар тусгасан байна. Үүнд:

- **Дижитал бүртгэл.** Дижитал бүртгэлийн систем нэвтрүүлсэн бөгөөд энэ нь хүнд суртал, зардлыг бууруулж (2000 евро хэмнэгдэнэ) бүртгэх процессыг хялбаршуулсан байна. Италид гарааны бизнесийг бүртгүүлэхдээ нотариатаар баталгаажуулах шаардлагагүй. 2016 оны 07 сарын 20-ны өдрөөс гарааны бизнес эрхлэгчид бүртгүүлэх, үүсгэн байгуулах гэрээ болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа стандарт загвар, тоон гарын үсэг ашиглан уг процессыг бүхэлд нь онлайнгаар үнэ төлбөргүй хийдэг болсон. Ингэснээр гарааны бизнес эрхлэгчид итали, англи хэлээр онлайн танилцуулгатай болох бөгөөд тоон гарын үсгээр үнэ төлбөргүй профайл үүсгэх боломжтой. Үүний зорилго нь үндэсний болон олон улсын хөрөнгө оруулагчдад гарааны бизнесийг таниулах боломж нэмэгдэх, инновацыг дэмжихэд оршино.
- **Зарим төрлийн хураамж төлөхгүй.** Худалдааны танхимд төлөх жилийн хураамж болон зарим төрлийн, тухайлбал, улсын тэмдэгтийн хураамж зэрэг голдуу бүртгэлтэй холбоотой хураамж төлөхгүй.
- **Уян хатан компанийн удирдлага:** Тодорхой эрх бүхий хувьцааны ангилал бий болгох, өөрийн хувьцаагаар санхүүгийн үйл ажиллагаагаа явуулах, хувьцаагаа олон нийтэд санал болгох боломжтой.
- **Алдагдлаа нөхөх хугацааг сунгана.** Санхүүгийн алдагдалд орсон тохиолдолд гарааны бизнес эрхлэгчдэд 1 жилийн нэмэлт хугацаа олгодог.

- **“Dummy буюу халхавч”³ компанид хамааралтай зохицуулалтаас чөлөөлөгдөнө.** Бүртгэлтэй боловч үйл ажиллагаа явуулдаггүй болон системийн хямралд өртсөн аж ахуйн нэгж, компанид хамааралтай зохицуулалтууд гарааны бизнес эрхлэгчдэд үйлчлэхгүй. Тухайлбал, гарааны бизнесийн орлогыг “тохиромжгүй” гэж үзвэл “dummy” компаниудад ногдуулдаг татварын торгууль ногдуулахгүй.
- **НӨАТ-ын хөнгөлөлт эдэлнэ.** Дээд тал нь 50000 евро хүртэлх орлогод (бусад төрлийн компаниудад 15000 евро) VAT credit (НӨАТ-ын төлөлтийг хойшлуулах) хөнгөлөлт үзүүлдэг. Мөн энэ хөнгөлөлтийг эдлэхдээ шаардагдах визийг хавсаргах үүргээс чөлөөлдөг.
- **Гарааны бизнест тохиромжтой уян хатан хөдөлмөрийн гэрээ.** Гарааны бизнес эрхлэгчийн ажилтантайгаа байгуулах хугацаат гэрээ нь (fixed-time contracts) энэ төрлийн бизнест тохирсон илүү уян хатан байдаг. Үүнд, гэрээ үргэлжлэх хугацаа болон сунгалтын тоонд хязгаар тогтоогоогүй. Түүнээс гадна тогтмол хугацаатай болон нээлттэй хугацаатай гэрээнд баримтлах ёстой харьцааг хадгалах үүрэггүй.
- **Хувьцааны опцион болон өөрийн хөрөнгийн схемээр урамшуулал олгож болно.** Гарааны бизнесийн компанийн ажилчид, зөвлөхүүд нь хувьцааны опционоор нэмэлт урамшуулалт цалин авч болох бөгөөд үүнд, татвар ногдуулахгүй (үүнийг хамтын гэрээнд заасан доод хэмжээг зөрчихгүйгээр хэрэгжүүлнэ).
- **Хөрөнгө оруулалтын урамшуулал.** Гарааны бизнест хөрөнгө оруулсан хөрөнгө оруулагчдыг урамшуулан дэмжлэг үзүүлж байна. Үүнд:
 - Хувь хүний хувьд, гарааны бизнест хөрөнгө оруулсан 1 сая евро хүртэл хөрөнгөд 30%-ийн татварын хөнгөлөлт үзүүлнэ (2017 оноос өмнө 500 мянган евро, 19%).
 - Компаниудын хувьд, гарааны бизнест хөрөнгө оруулсан 1.8 сая евро хүртэлх хөрөнгөд 30%-ийн татварын хөнгөлөлт үзүүлнэ (2017 оноос өмнө 20%).
 - Гарааны бизнест венчур болон хамтын хөрөнгө оруулалт хийсэн бол дээрх хөнгөлөлтийг мөн адил эдэлнэ.
 - Энэ урамшуулал нь 3-аас доошгүй жил хэрэгжинэ.
- **“Crowdfunding” хөрөнгө оруулалт.** Энэ нь санхүүжилт олох нэг арга хэрэгсэл бөгөөд Итали 2012-2013 онд энэ төрлийн хөрөнгө оруулалттай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлж эхэлсэн анхны улс юм. Италийн гарааны бизнес эрхлэгчид тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд (жишээ нь, хөрөнгийн 5%-ийг мэргэжлийн хөрөнгө оруулагчид эзэмшдэг

³ Үндсэн компаниа эрсдэлээс хамгаалах зорилгоор байгуулсан халхавч компани. <https://www.lsd.law/define/dummy>

байх) интернэтээр дамжуулан хувьцаагаа олон нийтэд санал болгох замаар хөрөнгө босгох боломжтой (2017 оноос хойш Италийн ЖДҮ эрхлэгчид мөн ашигладаг болсон).

- **Банкны зээл авахад хялбар.** Банкнаас зээл авахдаа Төрийн батлан даалтын санд хамрагдах бөгөөд гарааны бизнес эрхлэгчдэд давуу эрх олгодог. Үүнд:
 - Шаардлагатай хяналт шалгалтыг түргэн шуурхай явуулна.
 - Бизнес төлөвлөгөө, тайлан балансын үнэлгээг харгалзахгүйгээр, мөн банкны нэмэлт баталгаа шаардахгүйгээр зээлийн нийт дүнгийн 80% хүртэл батлан даалт гаргана.
 - Баталгаажсан зээлийн дээд хэмжээ 2.5 сая евро бөгөөд үүнийг хэд хэдэн үйл ажиллагаанд хэрэглэж болно.
- **Италийн худалдааны агентлагийн зорилтот дэмжлэг.** Хууль эрх зүй, нийгэм, төсөв, үл хөдлөх хөрөнгө, гэрээ, зээлийн үйлчилгээ авахад 30%-ийн хөнгөлөлт бүхий «Гарааны бизнесийн үйлчилгээний карт»-ыг хэрэглэх боломжтой (Карт авахын тулд «Richiesta Carta Servizi startup» хаягаар хандаж хүсэлтээ илгээнэ). Мөн гарааны бизнес эрхлэгчдэд тодорхой олон улсын үзэсгэлэн, яармагт хөнгөлөлттэй хамрагдах, боломжит хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн байна.
- **Smart&Start Italia.** Үүнийг 2014 онд анх нэвтрүүлсэн бөгөөд гарааны бизнесийг урамшуулах зорилгоор хэрэгжүүлдэг санхүүжилтийн хөтөлбөр юм. Үүнд хамрагдсанаар:
 - Хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 70% хүртэл хүүгүй зээл олгоно. Хэрэв гарааны бизнесийн компанид ажилладаг ажилчдын 80% нь эмэгтэйчүүд, эсвэл 35-аас доош насны залуучууд, эсвэл дор хаяж гадаадад ажилладаг (эх орондоо эргэн ирэх эрмэлзэлтэй) дор хаяж 1 итали доктор (PhD) ажилтантай бол үүнийг 90% хүргэж болно.
 - Италийн өмнөд хэсэг нь бусад хэсгээс хөгжил доогуур байдаг тул өмнөдийн гарааны бизнес эрхлэгчдэд 20%-ийн буцалтгүй тусламж үзүүлдэг.
 - 12 сараас доош настай гарааны бизнес эрхлэгч компаниудад менежментийн болон техник арга зүйн сургалт явуулна.
- **Italia Startup Visa.** 2014 оны 6 сарын 24-нд хэрэгжиж эхэлсэн. Энэ нь Италид гарааны бизнес эрхлэх хүсэлтэй Европын холбооны гишүүн бус орны иргэдэд тусгай журмаар виз олгодог. Үүнд:
 - хурдан шуурхай (30 хоногийн дотор);
 - төвлөрсөн (Эдийн засгийн хөгжлийн яамнаас зохицуулдаг);
 - үнэ төлбөргүй;
 - бүрэн онлайн.

- **Italia Startup Hub (ISH).** 2014 оны 12 сарын 23-ны өдрөөс эхлэн Italia Startup Hub нь гарааны бизнес эрхлэх зорилгоор Италид үлдэх сонирхолтой байнгын оршин суух зөвшөөрөл бүхий Европын холбооны гишүүн бус орны иргэдэд Italia Startup Visa-аас олгодог хялбаршуулсан журам юм. Энэ нь өмнөх виз, жишээ нь, суралцах зорилгоор авсан визээ хялбаршуулсан журмын дагуу “гарааны бизнес эрхлэх зөвшөөрөл” болгон өөрчлөх боломжийг олгодог.
- **R&D зориулсан tax credit (татварын кредит).** Өсөн нэмэгдэх судалгаа шинжилгээний зардалд энэ хөнгөлөлтийг үзүүлнэ. Үүнд:
 - Дотоодод зарцуулсан судалгаа, шинжилгээний зардал болон их сургууль, судалгааны хүрээлэн, инновац-технологийн гарааны бизнес ба ЖДҮ-ийн судалгаанд зарцуулсан зардлын 50%-тай тэнцэх.
 - Судалгаа, шинжилгээнд хамаарах шууд бус зардлын 25%-тай тэнцэх (зөвлөх үйлчилгээ, материалын гэх мэт).
 - Аж үйлдвэрийн 4.0 (I4.0) салбарын ажлын байр дахь сургалт, дадлагатай холбоотой зардалд энэ хөнгөлөлтийг үзүүлнэ. Италид бүртгэлтэй компани нь I4.0 салбарт ажиллах хүчнийг бэлтгэхтэй холбогдсон зардлын 40%-ийг татвар ноогдох орлогоос хасаж тооцож болно.
- **Patent Box.** Оюуны өмчийн эрхтэй холбогдох орлогод 50%-ийн татварын хөнгөлөлт эдэлнэ. Үүнд хамаарах оюуны өмчүүд: патент, оюуны өмч бүхий программ хангамж, шинэ санаа, аж үйлдвэрийн загварчлал орно.
- **Хурдавчилсан элэгдэл хорогдуулалт:** I4.0 салбарын машин, тоног төхөөрөмж, технологид нэмэгдүүлсэн хэмжээгээр элэгдэл, хорогдол тооцно. Ингэснээр татварын дарамтыг бууруулна.
- **Fail-fast.** Гарааны бизнес дампуурсан тохиолдолд дампуурлын процесс илүү хурдан, хялбар, зардал багатай хийгдэхээр зохицуулсан. Энэ нь хямралыг хурдан даван туулах, олон нийтийн зүгээс ирэх дарамтаас (гутаан доромжлох гэх мэт) хамгаалах, бизнес эрхлэгчдэд дахин шинэ санаа, шинэ бизнесээ хурдан хугацаанд эхлүүлэх боломж олгох зорилготой байна.
- **Инновацын ЖДҮ ангилалд шилжих.** Бизнесээ амжилттай явуулж өргөжин томорсон гарааны бизнесийг инновацын ЖДҮ ангилалд шилжүүлэх бөгөөд ижил төстэй урамшуулал, хөнгөлөлт, дэмжлэгт үргэлжлүүлэн хамруулдаг байна.

2. Америкийн Нэгдсэн Улс

АНУ нь гарааны бизнесээрээ дэлхийд тэргүүлдэг бөгөөд маш олон хүн гарааны бизнес эхлүүлэх хамгийн тохиромжтой газар гэж үздэг. Startup

Ranking-с гаргасан амжилттай гарааны бизнесийн жагсаалтаас⁴ харахад эхний 100 байрнаас 45 байрыг АНУ-ын гарааны бизнесүүд эзэлсэн байна. Гэвч АНУ-д албан ёсоор гарааны бизнес гэсэн тодорхойлолт байдаггүй байна. Гарааны бизнесийг жижиг бизнесийн хүрээнд хамруулдаг.

АНУ-ын гарааны бизнесийн хууль эрх зүйн зохицуулалт

Jumpstart Our Business Startups (JOBS) Act

Гарааны бизнесийг дэмжих зорилгоор баталсан хамгийн чухал хуулийн нэг *JOBS Act* юм. Энэ хууль нь Үнэт Цаас, Биржийн Хорооноос (ҮЦБХ) жижиг бизнесийн талаар тогтоосон зохицуулалтыг сулруулсан бөгөөд 1 тэрбум доллароос бага орлоготой компаниудын тайлагнах, ил тод болгох шаардлагыг бууруулж, гарааны бизнесүүд олон нийтэд үнэт цаасаа санал болгох, сурталчлах боломжийг олгодог. Мөн Crowdfunding хөрөнгө оруулалтыг ашиглаж санхүүжилт олох боломжийг гарааны бизнесүүдэд олгож, ҮЦБХ-ны бүртгэлд хамрагдахгүйгээр хувьцаагаа санал болгох боломжийг нээж өгсөн.

Энэ хуулиар “шинэ хөгжиж буй өсөлтийн компаниуд” (Emerging Growth Companies-EGCs) гэсэн ангиллыг бий болгосон бөгөөд тухайн санхүүгийн жилд 1.07 ам.тэрбум доллароос бага орлоготой, хувьцаа гаргаж байгаа компани гэж тодорхойлсон байдаг. Эдгээр компаниудад хуулиар тавигдах тайлагнах, хяналт тавих шаардлагуудыг хөнгөвчилсэн байна.

Түүнээс гадна энэ хууль нь жижиг хөрөнгө оруулагчдад хоёр аргаар гарааны бизнест хөрөнгө оруулах боломжийг олгодог. Нэгдүгээрт, гарааны бизнес эрхлэгчдэд олон жижиг хөрөнгө оруулагчдын нөөцөө нэгтгэн хөрөнгө оруулалт хийх нэг хэлбэр болох Crowdfunding хэлбэрийн хөрөнгө оруулалтаар 1 сая хүртэл ам.доллар босгох боломжийг олгодог. Хоёрдугаарт, ҮЦБХ-ны “А зохицуулалт” хэмээх журмын ангиллыг өргөжүүлж “А+ зохицуулалт” болгож, гарааны бизнесүүдийг бүртгэлийн шаардлагаас чөлөөлсөн бөгөөд жил бүр 50 сая ам.доллар хүртэлх хувьцааг санал болгох боломж олгосон.

Бусад хууль эрх зүйн зохицуулалт

АНУ-д гарааны бизнесийн үйл ажиллагааг мужийн болон холбооны түвшний хууль эрх зүйн зохицуулалтаар зохицуулж байна. Энэ судалгаанд Калифорни мужийн зохицуулалтыг авч үзлээ.

АНУ-д болон Калифорни мужид гарааны бизнесийг дараах хууль тогтоомжуудаар зохицуулдаг. Үүнд ерөнхий бизнесийн тухай хуулиуд болон жижиг бизнест хамаарах хуулиуд орно.

⁴ Startup Ranking <https://www.startupranking.com/top>

Татварын тухай хууль, тогтоомжууд

Холбооны түвшинд:

- Холбооны ажил олгогчийн дугаар (Federal Employer Number)⁵ - Аж ахуйн нэгжид олгодог 9 оронтой өвөрмөц дугаар. Энэ нь Дотоод орлогын газарт татварын тайлан гаргах зорилгоор бизнесийг хялбархан тодорхойлох боломжийг олгодог.
- Орлогын албан татвар (Income Tax)
- Тооцоолсон татвар (Estimated Taxes)⁶ - Энэ нь тухайн тайлант хугацааны тайлангийн орлогод үндэслэн тухайн жилийн татварын улирал тутам төлдөг татвар юм. Улирал бүр татвар төлөх ёстой хүмүүсийн ихэнх нь жижиг бизнес эрхлэгчид, бие даасан ажилчид, бие даасан гэрээлэгч нар байдаг.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн татвар (Self-Employment Tax)
- Хөдөлмөр эрхлэлтийн татвар (Employment Taxes)
- Онцгой албан татвар (Excise Tax)
- Дотоод орлогын хуулийн 409A зүйл (Internal Revenue Code Rule 409A)⁷ - Энэ нь ажилтны авах ёстой боловч ажил олгогчоосоо хараахан аваагүй байгаа нөхөн олговрын тухай зохицуулалт юм. Мөнгөн болон бусад хэлбэрээр нөхөн олговор нь ажилтанд шилжээгүй тул энэ нь ажилтны төлөх татварт тооцогдохгүй.
- Дотоод орлогын хуулийн 422 болон 423 зүйлүүд (Internal Revenue Code Section 422 and 423)⁸ - Энэ хууль нь ажил олголттой холбоотой аливаа шалтгаанаар ажил олгогчийн байгууллага эсвэл төв болон охин компаниас ажилтанд олгосон хувьцааг зохицуулна.
- Дотоод орлогын хуулийн 83b зүйл (Internal Revenue Code Section 83(b))⁹ - Энэ нь ажилтан буюу гарааны үүсгэн байгуулагчдад хязгаарлагдмал хувьцааны нийт бодит зах зээлийн үнэд татвар төлөх боломжийг олгодог заалт юм.

Калифорнийн түвшинд:

- Мужийн ажил олгогчийн дугаар (State Employer Number)
- Foreign Qualification - Энэ нь компанийн үүсгэн байгуулсан мужаас өөр мужид бизнес эрхлэхээр бүртгүүлэх үйл явц бөгөөд ингэснээр бизнес тухайн мужид хууль ёсны дагуу үйл ажиллагаагаа явуулах эрхтэй болно.

⁵ Federal Employer Number, <https://www.irs.gov/businesses/small-businesses-self-employed/employer-id-numbers>

⁶ Estimated Taxes, <https://www.irs.gov/businesses/small-businesses-self-employed/estimated-taxes>

⁷ Internal Revenue Code Section 409A, <https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2011-title26/pdf/USCODE-2011-title26-subtitleA-chap1-subchapD-partI-subpartA-sec409A.pdf>

⁸ Internal Revenue Code Sections 422 & 423, <https://www.govinfo.gov/app/details/USCODE-2010-title26/USCODE-2010-title26-subtitleA-chap1-subchapD-partII-sec422>, <https://www.govinfo.gov/app/details/USCODE-2011-title26/USCODE-2011-title26-subtitleA-chap1-subchapD-partII-sec423>

⁹ Internal Revenue Code Section 83(b), <https://www.law.cornell.edu/uscode/text/26/83>

- Франчайз болон орлогын албан татвар (Franchise and Income Tax)
- Борлуулалтын болон ашиглалтын татвар (Sales and Use Taxes)
- Тусгай татвар, хураамж (Special Taxes and Fees).

Үнэт цаасны тухай хууль, тогтоомжууд

Холбооны түвшинд:

- Үнэт цаасны тухай хууль (Securities Act of 1933);
- Үнэт цаасны биржийн тухай хууль (Securities Exchange Act of 1934);
- Бизнес эхлүүлэх тухай хууль (Jumpstart Our Business Startups Act);
- Дотоод орлогын хуулийн 409A зүйл (Internal Revenue Code Rule 409A);
- Дотоод орлогын хуулийн 422 болон 423 зүйлүүд (Internal Revenue Code Sections 422 and 423);
- Дотоод орлогын хуулийн 83b зүйл (Internal Revenue Code Section 83(b));

Калифорнийн түвшинд:

- Аж ахуйн нэгжийн үнэт цаасны тухай хууль (Corporate Securities Law of 1968)

Монополын эсрэг хууль, тогтоомжууд

Холбооны түвшинд:

- Клейтон хууль (Clayton Antitrust Act)¹⁰ - Энэ хууль нь үнэ тогтоох, монопол гэх мэт бизнесийн ёс зүйгүй үйлдлүүдийг тодорхойлж, хөдөлмөрийн янз бүрийн эрхийг хамгаалсан хууль тогтоомж юм.
- Робинсон-Патманы хууль (Robinson-Patman Act)¹¹ - Робинсон-Патманы хууль нь үнийн ялгаварлан гадуурхалтыг хориглосон холбооны хууль юм. Энэ хууль нь 1914 оны Клэйтоны хуулийн нэмэлт өөрчлөлт бөгөөд “шударга бус” өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх зорилготой юм.
- Шерманы хууль (Sherman Antitrust Act)¹² - Энэ хууль нь бизнес эрхлэгчид монопол байгуулахын тулд хоорондоо тохиролцох, нэгдэхийг хориглосон юм. Энэ хууль нь эдгээр бүлгүүдийг тодорхой зах зээлд үнийг зааж, хянах, удирдахаас сэргийлсэн.

¹⁰ Clayton Antitrust Act of 1914, <https://www.ftc.gov/legal-library/browse/statutes/clayton-act>

¹¹ Robinson-Patman Act, <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-12152/pdf/COMPS-12152.pdf>

¹² Sherman Antitrust Act, <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-3055/pdf/COMPS-3055.pdf>

Калифорнийн түвшинд:

- Картрайтын хууль (Cartwright Act)¹³ - Энэ хууль нь Калифорни мужийн монополын эсрэг хууль бөгөөд өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хориглодог. Энэ хуульд үнэ тогтоох, бүлэг бойкот хийх, зах зээлийг хуваах схем, онцгой наймаа, үнийг ялгаварлан гадуурхах, бүтээгдэхүүнийг уяхыг хориглодог.

Санхүүгийн үйлчилгээ, даатгалын тухай хууль, тогтоомжууд

Холбооны түвшинд:

- Грамм-Лич-Блайлийн Санхүүгийн шинэчлэлийн тухай хууль (Gramm-Leach-Bliley Financial Modernization Act)¹⁴ - Энэ хууль нь санхүүгийн салбарт ажилладаг компаниуд үйл ажиллагаагаа нэгтгэх, бие биеийнхээ бизнест хөрөнгө оруулалт хийх, нэгдэх боломжийг олгосон.
- Шударга, үнэн зөв зээлийн гүйлгээний тухай хууль (Fair and Accurate Credit Transactions Act)
- Шударга зээлийн тайлангийн тухай хууль (Fair Credit Reporting Act)
- Санхүүгийн салбарыг зохицуулах газрын тухай хууль (Financial Industry Regulatory Authority Act)
- Сарбанес-Окслийн хууль (Sarbanes-Oxley Act of 2002)¹⁵ - Энэ хууль нь хөрөнгө оруулагчдыг байгууллагуудын хуурамч санхүүгийн тайлангаас хамгаалдаг. Энэ нь үнэт цаасны журамд хатуу шинэчлэл хийсэн бөгөөд хууль зөрчигчдөд хатуу шийтгэл ногдуулдаг.
- Хууль бус цахим мөрийтэй тоглоомтой тэмцэх тухай хууль (Unlawful Internet Gambling Enforcement Act of 2006)

Калифорнийн түвшинд:

- Санхүүгийн мэдээллийн нууцлалын тухай хууль (Financial Information Privacy Act)
- Сонг-Беверли зээлийн картын тухай хууль (Song-Beverly Credit Card Act of 1971)¹⁶ - Энэ хуульд зээлийн карт эзэмшигчийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар тусгасан байдаг. Үүнд зээлийн картаар төлбөр хийж буй хэрэглэгчдээс тодорхой мэдээлэл авахыг хориглох, картын баримт дахь картын дугаарыг таслах зэрэгт тавигдах шаардлага зэрэг нууцлал, аюулгүй байдлын заалтууд багтсан.

¹³ Cartwright Act, https://www.sheppardmullin.com/media/publication/622_landry_competition.pdf

¹⁴ Gramm-Leach-Bliley Act, <https://www.ftc.gov/legal-library/browse/statutes/gramm-leach-bliley-act>

¹⁵ Sarbanes-Oxley Act, <https://sarbans-oxley-act.com/>

¹⁶ Song-Beverly Credit Card Act of 1971, <https://codes.findlaw.com/ca/civil-code/civ-sect-1747-08/>

АНУ-ын гарааны бизнес эрхлэгчдэд олгодог тэтгэлэг, урамшуулал

Жижиг бизнест олгох татварын кредитүүд (tax credit)

Дотоод орлогын албанаас КОВИД-19-ийн нөлөөлөлд өртсөн бизнесүүдэд ажилтнуудаа авч үлдэх “Ажилтан хадгалах кредит”-ийг бий болгосон. Энэ кредит нь буцаан олгогдох татварын хөнгөлөлт юм.

Ажиллах боломжийн татварын хөнгөлөлтийг ажилд ороход саад бэрхшээлтэй тулгарсан хүмүүсийг ажилд авсан ажил олгогчид олгоно.

Үүнээс гадна 400-аас доошгүй цаг ажилласан ажилчдад эхний жилд төлсөн цалинг үндэслэн татварын хөнгөлөлтийг тооцдог. Жижиг бизнес эрхлэгчид энэхүү татварын хөнгөлөлтийн үзүүлэлтүүдийг хангасан шинэ ажилтан бүр 2400 долларын зээл олгох боломжтой.

Судалгаа, хөгжлийн татварын хөнгөлөлт нь бүтээгдэхүүнийг шинэчилж буй бизнесүүдэд татварын төлбөрийг бууруулах боломжийг олгодог. Татварын хөнгөлөлтийг программ хангамж боловсруулах, архитектурын дизайн, бүтээгдэхүүний сайжруулалт гэх мэт судалгаа шинжилгээний ажил шаардлагатай бүх төрлийн бизнес эрхлэгчдэд олгодог.

Жижиг бизнесийн үнэт цаасны урамшуулал

Мэргэшсэн жижиг бизнесийн хувьцаа (МЖБХ) гэдэг нь Дотоод орлогын хуулиар тодорхойлсон шаардлага хангасан жижиг бизнесийн хувьцааг хэлнэ. Хөрөнгө оруулагч болон компанийн аль аль нь тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд МЖБХ-г хөрөнгийн ашиг гэж тооцно. Хөрөнгө оруулагчид хэдий хэмжээний татварын хөнгөлөлт эдлэх нь хувьцаагаа хэзээ худалдаж авсан, хэр удаан эзэмшиж байгаагаас хамаарна.

Засгийн газрын тэтгэлэг, хөтөлбөрүүд

АНУ-ын Засгийн газар нь жижиг бизнес эрхлэгчдэд олон төрлийн тусламж, дэмжлэг үзүүлдэг. Засгийн газрын үзүүлэх тусламж нь тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байна. Эдгээр тусламж, дэмжлэгт тодорхой хэмжээний хууль эрх зүй, захиргааны урьдчилсан шаардлага тавигддаг бөгөөд байнгын тайлагнах, аудит хийх шаардлага тавьдаг.

АНУ-д гарааны бизнестэй шууд холбоотой байгууллага нь Жижиг бизнесийн удирдлага юм. Энэхүү байгууллагаас:

- Жижиг бизнесийн инновацын судалгааны хөтөлбөр¹⁷ - Жижиг бизнесийн инновацын судалгаа нь жижиг бизнесүүдэд буцалтгүй тусламж санал болгодог бөгөөд ингэснээр жижиг бизнесүүд холбооны түвшний судалгаанд оролцох боломжтой болдог.
- Жижиг бизнесийн технологи хэрэгжүүлэх хөтөлбөр¹⁸ - Жижиг бизнесийн технологи хэрэгжүүлэх хөтөлбөр нь судалгаа, хөгжлийн талбарт судалгааг санхүүжүүлэхэд чиглэдэг.
- АНУ-ын худалдааг өргөжүүлэх хөтөлбөр¹⁹ - АНУ-ын худалдааг өргөжүүлэх хөтөлбөр нь бүтээгдэхүүн экспортлох хүсэлтэй жижиг бизнесүүдэд туслах зорилготой. Энэ хөтөлбөр нь жижиг бизнесүүдэд санхүүгийн тусламжаас гадна гадаад худалдааны төлөөлөгчийн газар, яармаг үзүүлэнд оролцох; гадаад зах зээлд нэвтрэх; цахим хуудас хөгжүүлэх; олон улсын маркетингийн бүтээгдэхүүн, кампанит ажил явуулахад тусламж үзүүлнэ.

Жижиг бизнесийг хөгжүүлэх төвүүд нь Жижиг бизнесийн удирдлага болон орон нутгийн эрдэм шинжилгээний байгууллагатай (жишээ нь, их сургууль) хамтран бүтээгдсэн хөтөлбөрүүд юм. Эдгээр нь АНУ-ын өнцөг булан бүрд байгаа гарааны бизнес эрхлэгчид болон ЖДҮ эрхлэгчдэд өрсөлдөх чадвартай хэвээр үлдэхийн тулд үнэ төлбөргүй сурталчилгаа, санхүүжилт, бизнестэй холбоотой тусламж, сургалт явуулах замаар тусалдаг. Аливаа гарааны бизнес болон ЖДҮ нь энэ хөтөлбөрт хамрагдах боломжтой.

Үүнээс гадна КОВИД-19 цар тахлын үед АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн хүрээлэн болон Өвчний хяналт, урьдчилан сэргийлэх төвөөс олон төрлийн тусламж, дэмжлэгийн хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Эдгээрээс дурдахад:

- Үндэсний эрүүл мэндийн хүрээлэнгийн тэтгэлэг²⁰ - Энэ нь КОВИД-19-ийн судалгаатай холбоотой буцалтгүй тусламж юм. Энэ тэтгэлэг нь биоанагаах ухааны технологийг хөгжүүлж, судалж буй жижиг бизнесүүдэд зориулагдсан.
- Эмнэлгийн хэрэгслийн “Blueprint” жижиг бизнесийн тэтгэлэг²¹ - Энэ тэтгэлэг нь Мэдрэлийн системийн эмгэгийг эмчлэх эмнэлгийн хэрэгсэл бүтээх чиглэлээр ажилладаг жижиг бизнесүүдэд зориулсан Засгийн газрын тэтгэлэг юм. АНУ-ын Хүнс, Эмийн Захиргаанаас зөвшөөрөл авах зорилгоор туршилтын загвар бүтээх, аюулгүй байдлын туршилт хийх, эмнэлзүйн судалгаа хийх зэрэг үйл ажиллагааг дэмждэг. Мөн энэ тэтгэлгийн дагуу Эрүүл мэндийн үндэсний хүрээлэн нь судалгаа төлөвлөх, хянахад тусалдаг.

¹⁷ Small Business Innovation Research, <https://www.sbir.gov/about>

¹⁸ Small Business Technology Transfer, <https://www.sbir.gov/about>

¹⁹ State Trade Expansion Program, <https://www.sba.gov/funding-programs/grants/state-trade-expansion-program-step>

²⁰ National Institute of Health Grants, <https://www.nih.gov/grants-funding>

²¹ Blueprint Medtech Small Business Translator Grant, <https://grants.nih.gov/grants/guide/pa-files/PAR-21-282.html>

- Үндэсний Эрүүл мэндийн хүрээлэнгийн Инновацийн корпус²² - Энэ нь эмнэлгийн шинэ технологиудыг хөгжүүлж, худалдаанд нэвтрүүлэх ажлыг хурдасгах зорилготой юм. Энэхүү тэтгэлэг нь жижиг бизнесүүдэд бизнес эрхлэлт, инновацийн чиглэлээр сургалт явуулж, шинэ бүтээлийнхээ зах зээлийн үнэ цэнийг хэрхэн тодорхойлж, лабораториос арилжааны салбарт шилжүүлэх талаар сургалт, зөвлөгөө өгдөг.

Дээр дурдагдсанаас гадна:

- АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны хөдөөгийн хөгжлийн бизнесийн хөтөлбөр²³ - Энэ хөтөлбөр нь хөдөө орон нутагт эдийн засгийн боломж, ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор зээл, тусламж, баталгаа санал болгодог.
- АНУ-ын Худалдааны яамны үндэсний цөөнхийн бизнесийг хөгжүүлэх агентлаг²⁴
- АНУ-ын Боловсролын яамны тэтгэлгүүд²⁵ - Боловсролын салбарын жижиг бизнесүүдэд олгодог төрөл бүрийн тэтгэлгүүд юм.
- Хөгжлийн бэрхшээл, нөхөн сэргээх судалгааны үндэсний хүрээлэнгийн Жижиг бизнесийн инновацийн судалгааны хөтөлбөр²⁶ - Жижиг бизнесийн инновацийн судалгаа нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралыг сайжруулахад чиглэсэн 10 тэтгэлэг олгодог.

Төрийн гэрээний тусламж

Холбооны засгийн газар жил бүр олон тэрбум ам.долларыг бараа, үйлчилгээнд зарцуулдаг. Энэ мөнгөний дийлэнх нь тендерийн зарчмаар зарцуулагддаг бөгөөд Засгийн газраас жижиг бизнесүүдэд тендерт оролцоход нь туслах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байдаг. Эдгээрээс дурдвал:

Цэргийн алба хаах хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй болсон ахмад дайчдын эзэмшдэг жижиг бизнесийн хөтөлбөр. Холбооны засгийн газар жил бүр тухайн жилийн тендерт төсөвлөсөн зардлын 3-аас доошгүй хувийг ийм бизнесүүдэд олгохыг эрмэлздэг.

²² Innovation Corps at NIH Program for NIH and CDC Translational Research, <https://grants.nih.gov/grants/guide/pa-files/PA-22-073.html>

²³ U.S. Department of Agriculture Rural Development Business Programs, <https://www.rd.usda.gov/programs-services/business-programs>

²⁴ U.S. Department of Commerce Minority Business Development Agency, <https://www.mbda.gov/mbda-programs#3/34.05/-111.95>

²⁵ U.S. Department of Education Grants, <https://www2.ed.gov/fund/grants-apply.html?src=pn>

²⁶ National Institute on Disability, Independent Living, and Rehabilitation Research's Small Business Innovative Research, <https://acl.gov/programs/research-and-development/small-business-innovation-research-program>

Эмэгтэйчүүдийн эзэмшдэг жижиг бизнес гэрээлэх хөтөлбөр. Холбооны засгийн газар жил бүр эмэгтэйчүүдийн эзэмшдэг жижиг бизнесүүдэд тухайн жилийн тендерт төсөвлөсөн зардлын 5-аас доошгүй хувийг олгохыг эрмэлздэг. Энэхүү хөтөлбөрөөр дамжуулан Эмэгтэйчүүдийн Бизнес Эзэмшлийн Алба нь бизнесийн сургалт, зөвлөгөө өгөх, холбооны гэрээ байгуулах, зээлийг санал болгох замаар бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд дэмжлэг үзүүлдэг.

Бизнес хөгжүүлэх 8(а) хөтөлбөр. Энэ хөтөлбөрийн зорилго нь санхүүгийн хувьд бэрхшээлтэй ард иргэдийн эзэмшдэг жижиг бизнесүүдэд туслах юм. Энэ нь 8(а) бизнесийг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдаж буй бизнес эрхлэгчдэд тодорхой хэмжээний Засгийн газрын тендерийг олгох замаар хэрэгждэг.

HUBZone хөтөлбөр. Энэ хөтөлбөр нь бага ашиглалттай бизнесийн бүсийн бизнес эрхлэгчдэд Засгийн газрын тендерт өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой. HUBZone хөтөлбөрт хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд Засгийн газраас тодорхой тооны тендерийг тусгайлан олгохоос гадна нээлттэй тендерт гаргасан үнийн саналыг нь 10%-иар илүү тооцдог.

Байгалийн нөөцийн борлуулалтад туслах хөтөлбөр

Холбооны засгийн газар бараа үйлчилгээ худалдан авахаас гадна их хэмжээний байгалийн баялаг, илүүдэл эд хөрөнгийг зардаг. Байгалийн нөөцийн борлуулалтын тусламжийн хөтөлбөр нь эдгээр барааны тодорхой хувийг зөвхөн жижиг бизнес эрхлэгчдэд санал болгодог. Үүнд, мод ба холбогдох ойн бүтээгдэхүүн; стратегийн материал; газрын тосны хувьцаа; ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн түрээс; үл хөдлөх болон хувийн өмчийн илүүдэл орно.

Мөн хөтөлбөрийн хүрээнд жижиг бизнес эрхлэгчдэд төрийн борлуулалт, лизингийн чиглэлээр сургалт явуулдаг.

3. Израил Улс

Израил Улс нь судалгаа, хөгжүүлэлтийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд (ДНБ) эзлэх хувь, нэг хүнд ногдох шинэлэг компанийн тоо, нэг хүнд ногдох венчур хөрөнгө оруулалт зэргээрээ дэлхийд тэргүүлдэг.²⁷ Израилын хууль эрх зүйн орчин нь гадаадын хөрөнгө оруулалтад ээлтэй байдаг. Гадаадын хөрөнгө оруулагчид хөрөнгөө Израилаас эх орон руугаа чөлөөтэй буцаан авах боломжтой; гадаадын хөрөнгө оруулагчид ерөнхийдөө Израилын хөрөнгийн ашгийн татвараас чөлөөлөгддөг; мөн

²⁷ World Economic Forum, Global Competitiveness Report 2019, https://www3.weforum.org/docs/WEF_TheGlobalCompetitivenessReport2019.pdf

гадаадын иргэд Израилын компанийн хувьцааг эзэмших, компанийн захирал, эсвэл дээд албан тушаалтны үүрэг гүйцэтгэхэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй.

Израилын Засгийн газар нь Инновацын газраар дамжуулан гарааны бизнес, технологийн компаниудыг санхүүжүүлэхэд идэвхтэй оролцдог. Инновацын газар нь Израилын аж үйлдвэрийн судалгаа, хөгжлийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус газар нь 1984 оны Аж үйлдвэрт судалгаа, боловсруулалт, технологийн шинэчлэлийг дэмжих тухай хуулийн дагуу зөвшөөрөгдсөн судалгаа, хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн санхүүжилт олгодог, харин технологийн дэмжлэг үзүүлдэггүй. Инновацын газраас санхүүжилт авсан компаниуд тус газарт тайлагнах үүрэгтэй бөгөөд бүтээгдэхүүн борлогдох тутамд болон оюуны өмч, мэргэшлийг Израилаас гадуур шилжүүлсэн тохиолдолд хураамж төлөх ёстой.

Өндөр мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийн тухай хууль (Law for Encouragement of Knowledge-Intensive Industry)

2023 оны 7 сард батлагдсан уг хууль нь өндөр технологийн салбарт Израилын хөрөнгө оруулагчдын эзлэх хувийг нэмэгдүүлэх зорилгоор Израилын өндөр технологийн компаниудын хөрөнгө оруулагчдад seed шатны хөрөнгө оруулалтын өмнөх болон хөрөнгө оруулалтын үе шатанд татварын хөнгөлөлт үзүүлдэг.

Хуулийн эхний хэсэг нь Судалгаа, хөгжлийн компанид хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчдад татварын кредит авах боломжийг олгодог бөгөөд компанийн хувьцааг зарах хүртэл хугацаагаар татварын зарим төлбөрийг хойшлуулдаг.

Хоёр дахь хэсэг нь Израилын Судалгаа, хөгжлийн компаниудын хувьцаа зарах хүсэлтэй хөрөнгө оруулагчдад хувьцаа зарсан өдрөөс хойш 12 сарын дотор Израилын өөр компанид хөрөнгө оруулалт хийснээр хувьцаагаа зарах үед татвар төлөхгүй байх боломжийг олгодог.

Гурав дахь хэсэг нь бусад технологийн компаниудыг худалдаж авсан Израилын өндөр технологийн компаниудад татварын хөнгөлөлт үзүүлдэг. Эдгээр компаниуд худалдан авсан дүнгээ технологийн орлогоос хасаж тооцсон дүнгээс татвар төлдөг. Өөрөөр хэлбэл, тэдний хөрөнгө оруулалтыг зардалд тооцно.

Өндөр технологийн урамшууллын багц²⁸

2024 оны 01 сарын 16-нд Израилын Засгийн газар дэлхийн өндөр технологийн төв болох Израилын нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн урамшууллын багцыг баталснаа зарласан. Олон талт урамшууллын багцад Израилын өндөр технологийн экосистемийг бэхжүүлэхэд чиглэсэн хэд хэдэн санаачилга багтана:

- *Revolutionary Startup Fund* - Хязгаарлагдмал хөрөнгө оруулалттай гарааны бизнесүүдэд зориулж жил бүр хагас тэрбум шекел (Израилын мөнгөн тэмдэгт) хөрөнгө оруулах, хувийн хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах шинэ гарааны сан нээгдэнэ. Энэхүү сан нь технологийн гүнзгийрэл, нээлтийн инновацыг харуулсан гарааны бизнесүүдэд төвлөрнө.
- *Шинэ YOZMA сан (Институцын хөрөнгө оруулалтын хурдасгуур)* - Fund of Funds²⁹ загварыг ашиглан Израилын институцын байгууллагуудыг Израилын венчур капиталын санд хөрөнгө оруулахыг дэмжих хөрөнгө оруулалтын сан байгуулагдана. 5 жилийн хугацаанд 4 тэрбум гаруй шекел хөрөнгө оруулалт хийж, өндөр технологийн экосистемийг бэхжүүлнэ.
- *Шинэ Венчур бүтээх инкубаторын сан* - Олон улсын компаниудад оролцох боломжийг олгодог тендерийн үйл явцыг багтаасан хөрөнгө оруулалтын дэвшилтэт загвар бүхий инновацын санг байгуулна. Үүнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гүнзгийрүүлсэн технологийн шугам дахь олон улсын хамтын ажиллагааг сайжруулах замаар инновацын инкубаторын төвүүдийг байгуулах зэрэг багтана.

Энэхүү урамшууллын багц нь Хөрөнгө оруулалтын Түргэвчилсэн Хөтөлбөр, Сахиусан хөрөнгө оруулагчдын клубууд, Бүс нутаг-Технологийн инновацын төвүүдийг үүсгэх, Төсөөллийг бий болгох (Tnufa) урамшууллын хөтөлбөрийн буцалтгүй тусламжийг хоёр дахин нэмэгдүүлэх гэх мэт сүүлийн үеийн санаачилгууд дээр тулгуурладаг.

Израил дахь гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрүүд

*Төсөөллийг бий болгох (Tnufa) урамшууллын хөтөлбөр*³⁰

Энэ хөтөлбөр нь шинэлэг технологийн үзэл баримтлалыг боловсруулах, баталгаажуулах зорилгоор шинээр эхэлж буй бизнес эрхлэгчдэд зориулагдсан болно. Энэ нь бизнес эрхлэгчдийг анхан шатны төслүүдийн

²⁸ Israel Innovation Authority, https://innovationisrael.org.il/en/press_release/stimulus-to-boost-israeli-high-tech/

²⁹ Fund of Funds (FOF) Explained: How It Works, Pro & Cons, Example, <https://www.investopedia.com/terms/ff/fundsoffunds.asp>

³⁰ Israel Innovation Authority, Ideation (Tnufa) Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/ideation-tnufa-incentive-program/>

үзэл баримтлал, бизнесийн боломжийн нотолгоонд хүрэхэд нь дэмжлэг үзүүлдэг.

Технологийн инновацын инкубаторын хөтөлбөр³¹

Энэхүү хөтөлбөр нь судалгаа, хөгжлийн анхан шатанд байгаа технологийн санаатай бизнесүүд хувийн санхүүжилт авахад хүндрэлтэй байгаа үед болон төслийн эрсдэлийг бууруулж, санхүүжилтийн чухал үе шатанд хүрэхийн тулд лабораторийн дэмжлэг шаардлагатай байгаа үед бизнесүүдийг дэмжих зорилготой юм.

Гарааны компани байгуулах сонирхолтой бизнес эрхлэгчид технологийн инкубатороор дамжуулан санхүүжилт босгох боломжтой. Инкубатор нь компаниудын анхан шатанд хөрөнгө оруулалт хийж, компанийг байгуулах, санаагаа арилжааны бүтээгдэхүүн болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлдэг.

Хөрөнгө оруулалтын Түргэвчилсэн Хөтөлбөр³²

Энэхүү санхүүжилтийн хөтөлбөр нь Инновацын газрын Судалгаа, хөгжлийн сангаар дамждаг бөгөөд хөрөнгө босгох шатандаа байгаа гарааны богино хугацаатай (6 сар хүртэл) Израилын шинэлэг технологийн компаниудад зориулагдсан. Өнөөгийн (Израил-Хамасын дайн) нөхцөл байдлаас шалтгаалан хөрөнгө босгоход хүндрэлтэй байгаа, bridge санхүүжилт шаардлагатай байгаа компаниуд энэ хөтөлбөрийн зорилт болно.

Анхан шатны компаниудыг урамшуулах хөтөлбөр³³

Энэ хөтөлбөр нь шинэлэг технологийн төсөл боловсруулж, сурталчлах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар зах зээлд нэвтрэхийг зорьж буй гарааны компаниудад зориулагдсан болно. Хөтөлбөрийн зорилго нь Израилын өндөр технологийн салбарын өсөлт, хөгжлийг дэмжих, судалгаа, хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй анхан шатны компаниудад хувийн хөрөнгө оруулалтыг урамшуулах юм.

Сахиусан тэнгэр хөрөнгө оруулагчдын клубууд³⁴

Сахиусан тэнгэр хөрөнгө оруулагчдын клубын гол зорилго нь хувийн хөрөнгө оруулагчдад технологийн янз бүрийн салбарт технологийн

³¹ Israel Innovation Authority, Technological Innovation Incubators Program, <https://innovationisrael.org.il/en/programs/technological-innovation-incubators-program/>

³² Israel Innovation Authority, Fast Track funding program, <https://innovationisrael.org.il/en/programs/fast-track-funding-program/>

³³ Israel Innovation Authority, Early Stage Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/early-stage-companies-incentive-program/>

³⁴ Israel Innovation Authority, Call for Proposals for the Establishment of 3 Angel Investors' Clubs, https://innovationisrael.org.il/en/calls_for_proposal/angel-clubs-establishment/

шинэчлэлтийг үүсгэж буй Израилын гарааны бизнесүүдийг танилцуулах, эдгээр гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулалтыг судлах, хөрөнгө оруулалтыг удирдах үйл явцад туслалцаа үзүүлэх, мөн эдгээр хөрөнгө оруулагчдын клубүүдийг өргөжүүлэхэд оршино.

*Байгууллагын хөрөнгө оруулагчдыг урамшуулах хөтөлбөр*³⁵

Энэхүү хөтөлбөр нь өндөр технологийн хөрөнгө оруулалтыг бий болгохыг зорьж буй хөрөнгө оруулагчдыг дэмжих бас нэгэн чухал алхам бөгөөд Израилын өндөр технологийн салбар болон хөрөнгийн зах зээлийг холбосон зохицуулалтын нэмэлт үйл явцыг бий болгосон. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Израилын хөрөнгийн зах зээл дэх хөрөнгө оруулагчдыг борлуулалт, өсөлтийн анхан үе шатанд Израилын технологийн компаниудад хөрөнгө оруулахад урамшуулах юм.

*Seed шатны хөрөнгө оруулалтыг урамшуулах хөтөлбөр*³⁶

Seed шатны хөрөнгө оруулалтын тоог нэмэгдүүлэх болон илүү туршлагатай венчур хөрөнгө оруулагчдыг эрсдэл өндөртэй ажиллаж байгаа анхан шатны гарааны бизнесүүдэд хөрөнгө оруулахыг урамшуулах зорилготой.

*Гарааны бизнесийн сан – Seed шатны хөрөнгө оруулалтын өмнөх хөтөлбөр*³⁷

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Израил дахь гарааны компаниудын үүсгэн байгуулалт, өсөлтийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлэх бөгөөд энэхүү хөтөлбөр нь шинэ, өндөр эрсдэлтэй, гүнзгийрүүлсэн технологи хөгжүүлж буй гарааны бизнесүүдэд чиглэгддэг. Инновацийн газар нь хувийн хөрөнгө оруулагчдын хамт *Seed шатны хөрөнгө оруулалтын* өмнөх хөрөнгө оруулалтын шатанд оролцоно. Энэхүү хамтын хүчин чармайлт нь хувийн хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хөнгөлөх, хөрөнгө оруулалтын тойргийн хаалтыг дэмжих зорилготой юм.

*Гарааны бизнесийн сан – Seed шатны хөрөнгө оруулалтын хөтөлбөр*³⁸

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Израил дахь гарааны компаниудын үүсгэн байгуулалт, өсөлтийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлэх бөгөөд энэхүү хөтөлбөр нь шинэ, өндөр эрсдэлтэй, гүнзгийрүүлсэн технологи хөгжүүлж буй гарааны бизнесүүдэд чиглэгддэг.

³⁵ Israel Innovation Authority, Institutional Investors – Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/institutional-investors-incentive-program/>

³⁶ Israel Innovation Authority, Seed Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/seed-incentive-program/>

³⁷ Israel Innovation Authority, Startup Fund – Pre-Seed Program, <https://innovationisrael.org.il/en/programs/startup-fund-pre-seed-program/>

³⁸ Israel Innovation Authority, Startup Fund – Seed Program, <https://innovationisrael.org.il/en/programs/startup-fund-seed-program/>

Инновацийн газар нь хувийн хөрөнгө оруулагчдын хамт үржүүлэлтийн хөрөнгө оруулалтын шатанд оролцоно. Энэхүү хамтын хүчин чармайлт нь хувийн хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хөнгөлөх, хөрөнгө оруулалтын тойргийн хаалтыг дэмжих зорилготой юм.

Гарааны бизнесийн сан – А шатлалын хөтөлбөр³⁹

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Израил дахь гарааны бизнес эрхлэгч компаниудын үүсгэн байгуулалт, өсөлтийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг өргөжүүлэх бөгөөд энэхүү хөтөлбөр нь шинэ, өндөр эрсдэлтэй, гүнзгийрүүлсэн технологи хөгжүүлж буй гарааны бизнесүүдэд чиглэгддэг. Инновацийн газар нь хувийн хөрөнгө оруулагчдын хамт А шатлалын хөрөнгө оруулалтын шатанд оролцоно. Энэхүү хамтын хүчин чармайлт нь хувийн хөрөнгө оруулагчдын эрсдэлийг хөнгөлөх, хөрөнгө оруулалтын тойргийн хаалтыг дэмжих зорилготой юм.

4. Бүгд Найрамдах Узбекистан Улс

Узбекистан Улсын Засгийн газар нь сүүлийн жилүүдэд инновацийн экосистемийг хөгжүүлэхийн тулд гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих асуудалд онцгой анхаарал хандуулж байна.

2016 оноос хойш Узбекистаны эдийн засгийг шинжлэх ухаан, инновацад тулгуурлан сайжруулах талаар тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байгаа бөгөөд энэ хүрээнд татварын тогтолцоог боловсронгуй болгох, бизнесийн татварын ачааллыг багасгах, шинжлэх ухааны ололтыг эдийн засгийн секторт нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн асуудлыг шинэлэг аргаар шийдвэрлэх гарцыг нээж өгсөн.

Инновацийн чиглэлээрх гарааны бизнесийг дэмжих зорилгоор 2021 оны Ерөнхийлөгчийн 6198 дугаар зарлигаар 13 бүс нутгийг инновацийн бүс болгон өөрчилсөн. Уг зарлигт бүс нутгийн нийгэм, эдийн засгийн түвшин дээшлүүлэх, жижиг бизнес болон хувийн бизнесийг хөгжүүлэх, шинээр ажлын байрыг бий болгох зэрэг асуудлуудыг хамруулсан байна.

Инновацийн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд 13.1 тэрбум UZS (Узбек мөнгө тэмдэгт SUM) буюу 22 гарааны төслийг буцалтгүй тусламжаар санхүүжүүлсэн. Ингэснээр импортыг орлох бүтээгдэхүүн, бизнесийн төслүүдийг дэмжиж, бүс нутгийн оюуны болон технологийн чадавхыг нэмэгдүүлсэн.

³⁹ Israel Innovation Authority, Startup Fund – Round A Program, <https://innovationisrael.org.il/en/programs/startup-fund-round-a-program/>

Гарааны бизнесийн төслийг санхүүжүүлэх Засгийн газрын 2020 оны 133 тогтоолын 2 дугаар хавсралтаар “Гарааны бизнес”-ийг батлах санхүүжүүлэх, хэрэгжүүлэх журмын дагуу 3 үе шаттай тэмцээнийг зохион байгуулан өрсөлдүүлж, Шинжлэх ухаан, техникийн зөвлөлийн хурлаар шалгаруулдаг байна.

Инновацын хөгжлийн яамны санхүүжилтээр 2019-2021 онд нийт 90 гаруй төслийг санхүүжүүлсэн. Үүний 20 нь эрүүл мэндийн салбарт 18.7 тэрбум UZS, 18 нь мэдээллийн технологийн салбарт 14.5 тэрбум UZS, ХАА салбарт 22 нь 14.1 тэрбум UZS, тээвэр, эрчим хүчний салбарт 9.6 тэрбум UZS, барилгын салбарт 5 тэрбум UZS, хүнсний салбарт 3.3 тэрбум UZS, боловсрол болон бусад салбарт 5,6 тэрбум UZS⁴⁰ тус тус санхүүжүүлсэн байна.

Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалт, бизнес эрхлэх, аж ахуйн нэгжийн бүртгэлийн журмыг хялбаршуулах, бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ, онлайн горим, цахим тайлангийн системийг нэвтрүүлсэн байна. Гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд татварыг хөнгөлөх, гаалийн татвараас чөлөөлөх, бизнесийг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг хялбарчлах зэрэг олон төрлийн урамшууллыг хэрэгжүүлсэн. Тус улс нь ГШХО-ыг татахын тулд 23 эдийн засгийн чөлөөт бүс түүнчлэн 502 орчим жижиг аж үйлдвэрийн тусгай бүсийг байгуулаад байна. Хууль тогтоомжийн хүрээнд хувийн бизнес эрхлэгчдэд татварын нэмэлт урамшууллыг бий болгосон байна.

Тус улсад гарааны бизнест амжилт үзүүлсэн байдлыг дурдвал, аялал жуулчлалын чиглэлээр 3D болон VR BOX загварыг бий болгох “NazzaAR” төсөл хэрэгжүүлж байна. Газар тариалангийн чиглэлээр Агрлоток суулгацыг “in-vitro” аргаар үржүүлэх лаборатори байгуулж, хүнсний үйлдвэрт өргөн хэрэглэгддэг пектин үйлдвэрлэгч компанийг шинээр байгуулсан. Уг төсөл нь биологийн бүтээгдэхүүнийг хатаах механизмыг сайжруулдаг цахилгаан соронзон задралын системийг хөгжүүлж, эрчим хүчний хэрэглээг 4-6 дахин багасгах дэвшилтэт шинэ арга болсон байна. Эрчим хүчний хэмнэлттэй шинэ технологи нэвтэрснээр нөөцийг хэмнэж, өртгийг бууруулж, зах зээлд өрсөлдөх чадвартай шинэ бүтээгдэхүүн гарч ирсэн гэж үздэг байна.

Узбекистан Улсад 2016 оноос эдийн засаг, нийгэм, шүүхийн шинэчлэл, өөрчлөлтүүдийг хийсэн бөгөөд 2017-2021 онд анхны Хөгжлийн стратегийн шинэчлэлийн цогц хөтөлбөрийг боловсруулж баталсан. Энэ хөтөлбөрийн тэргүүлэх таван чиглэлд эдийн засгийн хөгжил, либералчлалыг илүү онцолсон байна.

⁴⁰ Ministry of Innovative Development, <https://mininnovation.uz/en/info/startaplar>


Эдийн засгийн өсөлтийг дэмжих хүрээнд Засгийн газар 2018 оныг бизнес эрхлэх, технологийг дэмжих жил болгон зарлаж, инновацад суурилсан өсөлтийг хурдасгах зорилгоор Инновацын хөгжлийн яам (*Ministry of Innovation Development*)-ыг байгуулжээ. Тус яам нь бүх төрлийн салбарын инновацад тулгуурласан хурдацтай өсөлтийг хангах, гарааны бизнесийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх, дэмжих, бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тус яам нь Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн яам (*Ministry the Development of Information Technologies and Communications*), Төслийн удирдлагын Үндэсний агентлаг (*National agency for Project Management*)-тай хамтран ажилладаг байна.

Инновацын хөгжлийн яамны харьяанд Яшнабад Инновацын Технопарк (*Yashnabad Innovative Technopark*), Дэвшилтэт Технологийн Төв (*Center for Advanced Technologies*), Шинэ санааг дэмжих (6 сая ам.ам доллар) сан (*Fund to Support Innovative Ideas*), Инновацын төсөл хэрэгжүүлэх шинжлэх ухаан, практикийн төв (*Scientntific and Practical Venter for the Implemenntetion of Innovative Projects*) -ийг тус тус байгуулжээ.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны хөгжлийн яам (*Ministry the Development of Information Technologies and Communications*)-ны харьяанд Мэдээллийн технологийн парк (IT Park), Венчур (10 сая ам.доллар) сан (*ICT Venture Park*) тус тус байгуулсан байна.

Төслийн удирдлагын Үндэсний агентлаг (*National agency for Project Management*)-ын харьяанд Мирзо Улукбек Инновац (*Mirzo Uluqbek Innovation*), Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих санг (*Fund for Support of Digital Economy Development*) тус тус байгуулаад байна.

Зураг 1. Гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих сангууд



Эх сурвалж: Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны “Гарааны бизнесийн экосистемийн тайлан”, 2019, <https://www.enpact.org/wp-content/uploads/2020/11/startup-ecosystem-report-tashkent-uzbekistan.pdf>

Эдгээр гарааны бизнесийг дэмжих гол хурдасгах хөтөлбөрүүд нь бизнесийн орчин, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг татах, татварын урамшуулал, оюуны өмчийг хамгаалах, шинэ технологи, бүтээгдэхүүн турших боломжийг олгох, технологийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хамтын ажиллагааг дэмжих зэрэг асуудлуудыг хамруулдаг. Алт, зэс, уран зэрэг байгалийн баялаг, хүнсний үйлдвэрлэл, нэхмэл эдлэл, барилга, аялал жуулчлал, мэдээллийн технологи зэрэг салбаруудад гарааны бизнес эрхлэх боломжийг олгодог байна.

Гарааны бизнес эрхлэгчдийн экосистемийг “Гарааны бизнест ээлтэй байдлын индекс” (*Startup Friendliness Index-SFI*) болон “Аж ахуйн нэгжийн экосистемийн зураглал”(Mapping the Entrepreneurial Ecosystem) гэсэн аргачлалтай хослуулан ашигласан. Энэ хоёр аргачлалыг хослуулсан нь бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалтыг зохицуулах, тэдгээрийн харилцан хамаарал, үйлчлэл, бизнес эрхлэх соёл, хандлага зэргийг тодорхойлжээ.

Тус улс нь эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийн үр дүнд дараах 6 салбарт 80 онооны үзүүлэлтийг “Гарааны бизнест ээлтэй байдлын индекс”(SFI)-ээр тусгасан байна. Үүнд:

- хүний нөөц 100-56.3 оноотой;
- зах зээлийн нөхцөл 100-56.3;
- макро бүтэц (улс төр, эрх зүйн тогтолцоо) 100-48.9;
- дэд бүтэц 100-56;
- санхүү хангамж 100-38.8;
- гарааны бизнесийн орчин 100-9.7 онооны үзүүлэлтүүдтэй гарчээ.

Зураг 2. Узбекистаны Гарааны бизнесийн экосистем



Эх сурвалж: Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны “Гарааны бизнесийн экосистемийн тайлан”, 2019, <https://www.enpact.org/wp-content/uploads/2020/11/startup-ecosystem-report-tashkent-uzbekistan.pdf>

“Аж ахуйн нэгжийн экосистемийн зураглал” (*Mapping the Entrepreneurial Ecosystem*)-аар дараах 3 бүрэлдэхүүн хэсэгт ангилдаг байна. Үүнд:

- бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчин;
- оролцогчдын харилцан үйлчлэл;
- бизнес эрхлэгчдийн соёл, хандлага.

Бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчин нь оролцогчид (хувь хүн, байгууллага, институт) хоорондын харилцах хууль эрх зүй, захиргааны зохицуулалтын тогтолцоог бүрдүүлдэг. Бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчин нь оролцогч талуудын хооронд байнгын харилцан үйлчлэлтэй байдаг. Тиймээс харилцан адилгүй хамааралтай байна. Гурав дахь бүрэлдэхүүн хэсэг болох соёл, хандлага нь бизнесийн болон хөрөнгө оруулалтын орчин, оролцогчдын харилцан хамааралтай холбоотой байна.

Зураг 3. Аж ахуйн нэгжийн экосистемийн зураглал



Эх сурвалж: Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны “Гарааны бизнесийн экосистемийн тайлан”, 2019, <https://www.enpact.org/wp-content/uploads/2020/11/startup-ecosystem-report-tashkent-uzbekistan.pdf>

Хэрэгжүүлж буй бодлого

Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалт, бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжийн бүртгэлийн журмыг хялбаршуулах, бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ, онлайн горим, цахим тайлангийн системийг нэвтрүүлсэн.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд татварыг хөнгөлөх, гаалийн татвараас чөлөөлөх, бизнесийг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг хялбарчлах зэрэг олон төрлийн урамшууллыг хэрэгжүүлсэн. Тус улс нь гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд 23 эдийн засгийн чөлөөт бүс түүнчлэн 502 орчим жижиг аж үйлдвэрийн тусгай бүсийг байгуулаад байна. Хууль тогтоомжийн хүрээнд хувийн бизнес эрхлэгчдэд татварын нэмэлт урамшууллыг бий болгосон байна.

Бизнес эрхлэгчдэд боловсролын түвшин, чанар, мэдлэгийг сайжруулах хүрээнд хүний нөөцийг хөгжүүлэх шаардлагатай байгааг онцолсон. Энэ нь шинжлэх ухааны чадавх, үр нөлөөг дээшлүүлэх шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ, шинэ технологийг бизнес эрхлэлттэй нэгтгэх механизмыг боловсруулсан. Узбекистан Улсыг инновацийн индексээр 2030 онд дэлхийн шилдэг 50 орны тоонд багтаахаар стратегийн төлөвлөгөөндөө тусгасан байна.

2019-2021 он хүртэл инновацын хөгжлийн стратеги төлөвлөгөөнд ажил олгогчдын төлдөг, нийгмийн даатгалын хувь хэмжээ, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээг бууруулж, зардлыг багасгасан.

2018 онд НӨАТ, газрын татвар, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), дэд бүтцийн хөгжлийн албан татвар, байгаль орчны албан татвар, хувь хүний тэтгэврийн сангийн шимтгэл, хуримтлагдсан тэтгэврийн татварын хэмжээг тус тус бууруулсан.

2019 онд аж ахуйн нэгжийн ангиллыг шинээр нэвтрүүлж, аж ахуйн нэгжүүдэд нэг удаа, нийгмийн даатгалын шимтгэлийг тогтмол, нэг ажилтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 65 хувиас багагүй хэмжээгээр тус тус төлөхөөр тусгасан. Харьяа байгууллагуудад гарааны бизнес, аж ахуйн нэгжүүд 2028 он хүртэл хувь хүний орлогын албан татвар, аж ахуйн нэгжийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс тус тус чөлөөлөхөөр болсон байна.

2017-2019 онуудад Засгийн газар нь шинэчлэлийн бодлого, стратегийн хөтөлбөрөөр бизнес эрхлэлт, дэд бүтцийг бий болгох бөгөөд эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, инновац, бизнес эрхлэлтийг дэмжих хэд хэдэн шинэчлэлийг эхлүүлсэн нь эдийн засгийн шинэчлэл болсон гэж үздэг.

2023 оны сүүлээр АХБ-ны санхүүжилтээр Узбекистаны ЖДҮ-ийг хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих чиглэлээр 100 сая ам.долларын зээлийг олгосон байна. Энэ нь ЖДҮ-ийн үйл ажиллагааны орчныг сайжруулах, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, эдийн засгийн өсөлтийг дэмжих, цар тахлын нөлөөг даван туулах чадварыг бэхжүүлэх зорилготой юм. Тус улс нь төрийн өмчийн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих үндсэн бүтцийн шинэчлэлийг үргэлжлүүлэн макро эдийн засгийн бодлогыг баримтлан, ЖДҮ эрхлэгчдэд эдийн засгийн төрөлжсөн өсөлт, бүтээмж, нэмүү өртөг шингээсэн ажлын байрыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж тэмдэглэжээ.⁴¹

Бүгд Найрамдах Узбекистан Улсад гарааны бизнес эхлүүлэхэд компани байгуулах, үүсгэх, хамтарч ажиллахад бизнес эрхлэгчдэд дараах хууль эрх зүйн шаардлагуудыг тавьдаг байна. Үүнд:

Узбекистанд бизнес эрхлэхэд тавигдах хууль эрх зүйн шаардлага:

- **IP:** Тус улсад оршин суудаггүй, гадаадын бизнес эрхлэгчид тусгайлсан, хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК) байгуулж болно.

⁴¹ АХБ, Узбекистаны ЖДҮ хөгжүүлэх 100 сая ам.доллар зээл олгов. <https://lex.uz/docs/5155423>

- **Анхны хөрөнгө:** Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн сан нь 2023 оны 5 сарын байдлаар 400 сая UZS (42,000 ам.доллар) Узбек мөнгөн тэмдэгт байхаар тусгасан.
- **Хууль ёсны бүртгэл:** Узбекистан Улсад компанийг нэгтгэх, хамтрах журмыг хэрэгжүүлэх бөгөөд гадаадын бүх компаниуд хууль ёсны бүртгэлтэй байна.
- **Хувьцаа эзэмшигчдийн гэрээ ба компанийн дүрэм:** Узбекистаны компанийг байгуулахад тавигдах стандарт, хууль ёсны шаардлагад хувьцаа эзэмшигчдийн гэрээ болон компанийн дүрэмтэй байна.

Хууль тогтоомжийн дагуу бизнесийн бүтцийн төрлүүд:

- **Хязгаарлагдмал хариуцлагатай компани:** (ХХК) бизнесийн түгээмэл хэлбэр бөгөөд хувиараа бизнес эрхлэгч эсхүл түншлэлийн давуу талыг корпорацийн хариуцлагатай байдалтай хослуулсан компанийг хэлнэ. ХХК нь гишүүдээсээ тусдаа хуулийн этгээд учраас компанийн гаргасан аливаа өр төлбөр, иргэдийн хөрөнгөөр хамгаалагдсан байдаг.
- **Хувьцаат компани:** (ХК) корпорац шиг захирлуудын зөвлөл удирддаг бөгөөд пүүсийн хувьцааг эзэмшдэг.
- **Нэмэлт хариуцлагатай корпорац:** (СAL) баталгаатай хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хэлнэ. Гишүүд тодорхой хэмжээний өр төлбөрийг биечлэн хариуцахаар тохиролцдог.
- **Эдийн засгийн түншлэл:** хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн бизнесийн байгууллага бөгөөд дүрмийн санг гишүүдийн хувьцаанд хуваасан, түншлэлийн өмнөөс бизнесийн үйл ажиллагаанд биечлэн оролцохыг хэлнэ.
- **Хувийн аж ахуйн нэгж:** (PE) нэг хүн үүсгэн байгуулагч бөгөөд тодорхой хариуцлагыг хүлээдэг. Хувийн компани татвар төлсний дараах ашиг нь өмчлөгчийнх бөгөөд ногдол ашгийн татвар ногдуулдаггүй нь үйл ажиллагааны зардлыг бууруулдаг байна.
- **Төлөөлөгчийн газар:** Тус улсад гадаадын компанийн ашиг сонирхлыг төлөөлөх, хууль ёсны бизнесийн бүтцийн нэг төрөл юм. Зар сурталчилгаа, сүлжээ, зах зээлийн шинжилгээ судалгаа, арилжааны үйл ажиллагаанд оролцох эрхгүй.

Компанийн бүртгэлд бүртгүүлэх үйл явц хэд хэдэн үе шаттай байдаг:

- **Тохиромжтой бизнесийн бүтцийг сонгох:** Гадаадын бизнес эрхлэгчид компани байгуулахдаа өөрийн бизнесийн шаардлагад тохирсон хууль эрх зүйн бүтцийг сонгоно.

- **Хууль эрх зүйн баримт бичгийг бүрдүүлэх:** Бүх хуулийн баримт бичгийг хамтад бүрдүүлнэ. Бизнесийн баримт бичигт өөрчлөлт оруулах боломжтой.
- **Брэндийн нэрийг хадгалах:** Бизнесийн бүтээгдэхүүн нь тодорхой брэндийн нэртэй байна. Барааны тэмдэгтийг Узбекистаны Патентын албанаас авна.
- **Аж ахуйн нэгжийг бүртгүүлэх:** Узбекистан Улсад компани байгуулахдаа өөрийн сонгосон бизнесийн бүтцийг Улсын бүртгэлд бүртгүүлнэ.
- **Анхдагч лац болон тамга тэмдэг авах хүсэлт гаргах:** Узбекистан дахь компанийг бүртгүүлэх үйл ажиллагааны нэг алхам юм. Лац болон тамга тэмдгийг авахдаа албан бичгээр гаргаж, баталгаажуулна.
- **Банкны данс нээлгэх:** Энэ улсад бизнесээ амжилттай явуулахын тулд байгууллагын дансыг банканд нээлгэнэ. Бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлэхдээ хамгийн бага хөрөнгийг байршуулж, судалгаа шинжилгээ хийж, бизнесийн шаардлагад нийцэх банкыг сонгодог байна.

Компанийг бүртгүүлэхдээ дараах хураамжийг төлдөг:

- **ХХК:** Дүрмийн сангийн 2% (*нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тав дахин нэмэгдүүлснээс багагүй байх*);
- **ЖК:** Дүрмийн сангийн ойролцоогоор 0.2%;
- **Гадаадын компани, охин компани, төлөөлөгчийн газар:** нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний шимтгэл төлдөг байна.

Узбекистанд бизнес эхлүүлэх, компани байгуулахад 50 орчим ам.доллар буюу 5,70,508 UZS Узбек мөнгөн тэмдэгт шаардлагатай байдаг. 2022 оны байдлаар бизнес эрхэлж буй хуулийн этгээдэд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 15% хувиар ногдуулдаг. Харин тус улсад оршин суудаггүй, бизнес эрхлэгчдэд 10% хувийн татварын хөнгөлөлт үзүүлдэг байна.

Гадаадын бизнес эрхлэгчдэд компани байгуулахад төрөөс дэмжлэг үзүүлж, дараах салбаруудад татварын хөнгөлөлт үзүүлдэг байна:

- Химийн болон нефть химийн үйлдвэрлэл;
- Инженер техникийн салбар;
- Цахилгаан;
- Хүнсний үйлдвэрлэл
- Альтернатив эрчим хүч;
- Бусад үйлдвэр зэрэгт татварын хөнгөлөлт үзүүлнэ.

Харин гадаадын бизнес эрхлэгчдийг дараах татваруудаас бүрэн чөлөөлдөг. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн ашгийн татвар;
- Эд хөрөнгийн татвар;
- Нийгмийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, сайжруулах татвар;
- Авто замын санд заавал төлөх татвар;
- Хувийн жижиг бизнес, бичил үйлдвэрлэлийн татвар гэх мэт.

Гарааны бизнест дараах онцлог шинж чанаруудыг⁴² тусгажээ. Үүнд:

- залуу компани;
- шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- эдийн засгийн өсөлт өндөр;
- жижиг нийгэмлэг;
- хязгаарлагдмал нөөцтэй;
- инновац, бүтэлгүйтлээс үүссэн эрсдэл;
- уян хатан байдал, гарааны бизнесүүд эрч хүчтэй, зах зээлийн өөрчлөлт, шинэ технологи, өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнд хариу үзүүлэх чадвартай байдаг.

Гарааны бизнесүүд нь шинэлэг технологийг бүтээсэн орчин үеийн аж ахуйн нэгжүүд эсхүл өвөрмөц бизнесийн загварыг бий болгоход одоо байгаа технологийг ашиглан өргөнөөр тэлэх бололцоотой, хурдацтай өсөлт, интернэтэд суурилсан байдаг. Гарааны бизнесийн гол шинж чанар нь хурдацтай өсөлт юм. Тус улс нь гарааны бизнесийн хөгжлийг дэмжихэд экосистемд илүү анхаарал хандуулсан байна.

Экосистем нь энэ гол шинж чанарыг агуулсан, шинэлэг систем бөгөөд Засгийн газрын бодлого, дэмжлэгийн хөтөлбөрөөр хязгаарлагдахгүй. Бизнес инкубатор болон хурдасгуур, венчур сангуудаас бүрдсэн экосистемийн үйл ажиллагаанд оролцогчдын хувьд шинэ санааг бий болгохоос эхлээд бизнес хүртэл гарааны бизнесийг дэмждэг.

Гарааны бизнесийн экосистем нь бизнес эрхлэгчид, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, банкнууд, хөрөнгө оруулагчид, венчурын сан, инкубатор болон хурдасгах хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх байгууллага, Засгийн газар гэх мэтчилэн олон байгууллагуудаас бүрддэг байна.

Бизнес эрхлэгчдид нь шинэ санаа боловсруулж, инновацыг зах зээлд нэвтрүүлэх чадамжтай байхаас гадна экосистемийн давуу болон сул талуудыг хүлээн зөвшөөрч, бизнес, хөрөнгө оруулалтын орчин, оролцогч талуудын чадавхыг сайжруулах, хамтын ажиллагааны хөгжил, үр нөлөөг сайжруулахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг байна.

⁴² Ministry of Innovative Development, <https://mininnovation.uz/en/info/startaplar>

Гарааны бизнес нь хэд хэдэн үе шатаар дамжин хөгждөг. Үе шат бүр өвөрмөц сорилтуудтай бөгөөд тодорхой дэмжлэгийн хүрээнд өөр нэрийг санал болгодог нийтлэг аргатай.

Эхний үе шат- Үүсгэх үе шат: Энэ нь шинэ санаа үүсгэх, бүтээгдэхүүн боловсруулах, тодорхойлох, эрхэм зорилго, стратеги, бизнесийн загварыг гаргах арга юм. Гарааны бизнесийн үе шатыг ихэвчлэн үүсгэн байгуулагч нь өөрөө санхүүжүүлдэг бөгөөд гэр бүл, найз нөхдийн дэмээр хөрөнгө оруулсан байдаг. Мөн Засгийн газрын буцалтгүй тусламж болон бусад хөрөнгө оруулалтаас үүдэлтэй.

Хоёр дахь үе шат- Хөгжлийн үе шат: Үүнд: баг бүрдүүлэх, хөгжүүлэх, удаан амьдрах чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, зах зээлийн баталгаажуулалт хийнэ. Энэ үе шатанд санхүүжилт хийх боломжтой бизнесийн хөрөнгө оруулалт болон венчур капитал, хөрөнгө оруулалтыг хамруулна.

Гурав дахь үе шат нь: Өргөтгөх үе шат: Энэ үе шатанд гарааны бизнесүүдийг татах, хөгжүүлэх, зах зээлд татан оролцуулна. Санхүүжилт нь энэ үе шатанд венчур капитал болон хувийн өмчийн хөрөнгүүд байна. Гарааны бизнес нь орлого олох хөрөнгөтэй тул барьцаа тавьж, банкны зээл авах бололцоотой байдаг.

Гарааны бизнесийн давуу тал: уян хатан байдал, ажилчдын харилцаа холбоо, хандлага, ажлын байрны боломж, сургалт явуулах, хариуцлага өндөржүүлэх, туршлага нэмэгдэх, инновац нэвтрүүлэх, бүтээгдэхүүний төрөл, технологи, шинэ санааг дэмжих, хурдасгах зэрэг асуудлуудыг хамруулдаг байна.

Гарааны бизнесийн сул тал: бизнес амжилтгүй болох, хөрөнгө оруулахад эрсдэл үүсэх, хөрөнгө босгох хүндрэл, стресс өндөр байх, бизнесийн орчны өрсөлдөөн их зэрэг асуудлууд сул тал болдог байна.

Хууль тогтоомжууд

Узбекистан Улсын гарааны бизнестэй холбоотой харилцааг:

- “Аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх үйл ажиллагааны баталгааны тухай хууль” (*On guarantees of freedom of entrepreneurial activity, 2012*),
- Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгчийн зарлиг “Бизнесийн орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бүрдүүлэх шинэчлэлийн тухай” (*On next reforms to create conditions for*

stable economic growth by improving business environment and developing private sector),

- Инновацын үйл ажиллагааны тухай” (*On innovative activity 2022*) хуулиудаар тус тус зохицуулдаг.

Гарааны бизнесийн тухай хуулийн төслийг (*Стартаплар тўғрисида ID 17135*) Парламентаар 2020 оны 06 сарын 27-ны өдөр хэлэлцсэн боловч батлагдаагүй байна.

1.Аж ахуй нэгжийн бизнес эрхлэх үйл ажиллагааны баталгааны тухай хууль, 2012⁴³ (*On guarantees of freedom of entrepreneurial activity*) нь 2012 оны 05 сарын 03-ны өдөр батлагдсан бөгөөд 6 бүлэг, 52 зүйлтэй байна. Энэхүү хуулийн зорилго нь бизнес эрхлэх иргэдийг чөлөөтэй оролцуулах, сонирхлыг төрүүлэх, баталгаагаар хангах, эдийн засгийн өсөлтийг идэвхжүүлэх, аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад оршино.

Энэ хуулийн 5 дугаар бүлгийн 43 дугаар зүйлд **төрөөс дэмжих үзүүлэх асуудлыг** дараах байдлаар тусгажээ. Үүнд:

- аж ахуйн нэгжийн бизнес эрхлэлтийг хөгжүүлэх, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- аж ахуйн нэгжийн бизнес эрхлэх үйл ажиллагаа, түүний баталгаа, болон түүнийг хөгжүүлэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, тулгамдсан асуудлыг судлах, хууль, эрх зүйн баталгааг боловсронгуй болгох;
- аж ахуйн нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- аж ахуйн нэгжийн санхүү хангамж, техник мэдээллийн нөөцөөр хангахад туслалцаа үзүүлэх;
- аж ахуйн нэгж бараа (ажил, үйлчилгээ)-гаа гадаад болон дотоод зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлэх, төрийн худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх үйл явцад аж ахуйн нэгжийг татан оролцуулах, бараа бүтээгдэхүүнээ сурталчлах, мэргэшсэн байгууллагатай гэрээ байгуулах;
- аж ахуйн нэгжүүдийн хооронд мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ, түрээс болон даатгал, бусад үйлчилгээг хөгжүүлэх;
- аж ахуйн нэгжийн хүний нөөцийг сургах, ур чадварыг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх;
- төрийн байгууллага нь хуулийн дагуу аж ахуйн нэгжийг болон бусад асуудлаар дэмжих зэрэг асуудлуудыг хамруулжээ.

⁴³ LAW OF THE REPUBLIC OF UZBEKISTAN ON GUARANTEES OF FREEDOM OF ENTREPRENEURIAL ACTIVITY, <https://lex.uz/docs/4403340>

2.Гэр бүлийн бизнес эрхлэх тухай хууль⁴⁴ (*On Family Entrepreneurship, 2012*)-ийг Хууль тогтоох танхимд 2012 оны 03 сарын 16-ны өдөр, Сенатын танхимд 2012 оны 03 сарын 23-ны өдөр тус тус баталсан. Энэхүү хууль нь 7 бүлэг, 35 зүйлтэй бөгөөд гэр бүлийн гишүүд бизнес эрхлэхийг дэмжсэн харилцааг зохицуулсан байна.

Гэр бүлийн гишүүд бизнес эрхлэх гэдэг нь гэр бүлийн гишүүдийн өөрсдийн эрсдэл, эд хөрөнгийн орлого (ашиг) олж авах зорилгоор хэрэгжүүлдэг санаачилгатай үйл ажиллагааг хэлнэ. Гэр бүлийн бизнес эрхлэх нь гишүүдийн сайн дурын үйл ажиллагаанд суурилдаг бизнес юм.

Гэр бүлийн өрхийн үйлдвэрлэл нь тухайн өрхийн гишүүдийн эзэмшиж байгаа буюу хамтран эзэмших дундын өмч хөрөнгө, өөрийн сайн дурын үндсэн дээр үүсгэн байгуулсан жижиг аж ахуйн нэгж юм. Өрхийн үйлдвэрлэл нь гишүүдийн хувийн хөдөлмөр дээр суурилдаг. Өрхийн үйлдвэрлэлийг жижиг бизнесийн адил улсын бүртгэлд бүртгүүлнэ. Гэр бүлийн дүрмийн сан нь бэлэн мөнгө, үнэт цаас, бусад эд хөрөнгө, түүний дотор эд хөрөнгийн эрх эсхүл мөнгөн үнэ цэнтэй бусад өмчлөх эрхийн зардлаас бүрддэг. Өрхийн бизнесийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 4 жилд 1-ээс илүүгүй удаа хийдэг байна. Гэр бүлийн бизнес эрхлэлтээр гарааны бизнесийг хөгжүүлнэ гэж үздэг.

3.Гарааны бизнесийн тухай хууль (*Стартаптар тўғрусида ID 17135,2020*)-ийн төслийг боловсруулж 2020 онд Парламентаар хэлэлцүүлсэн боловч одоогоор батлагдаагүй байна. Хуулийн төсөлд тусгаснаар бизнес эхлүүлэх явцыг зохион байгуулах, хөгжүүлэх, урамшуулах үйл ажиллагаанд шинэ санааг дэмжих харилцаагаар зохицуулах зорилготой байна. Энэхүү хуулийн төсөл нь 8 бүлэг, 33 зүйлтэй.

Гарааны бизнес гэдэг нь шинэ санаа, шинэлэг бүтээгдэхүүн, өндөр эрсдэлд суурилсан, тодорхой хөрөнгө оруулалт шаардагдах, өргөжүүлэх боломжтой бизнесийн загварыг хайж, хэрэгжүүлэхэд зориулагдсан бүтцийг хэлнэ.

Гарааны бизнесийн экосистем нь дэд бүтэц, санхүүгийн эх үүсвэр, үйл ажиллагаа, менторын зөвлөгөөгөөр гарааны бизнесийг хөгжүүлэх нөхцөл юм.

Гарааны бизнесийн хөгжлийг хурдасгах хүчин зүйл нь (*Startup Accelerator*) бизнест суурилсан сургалт, санхүүгийн болон мэргэжилтнүүдийн туслалцаатайгаар гарааны бизнесийг эрчимтэй хөгжүүлэх богино хугацааны хөтөлбөрүүдийг зохион байгуулах юм.

⁴⁴ LAW OF THE REPUBLIC OF UZBEKISTAN ON FAMILY ENTREPRENEURSHIP, <https://lex.uz/ru/docs/4550923>

Дэмжлэг, тусламж нь төрөөс гарааны бизнесийг хөгжүүлэх хүрээнд дэмжлэг туслалцаа үзүүлэхийг хэлнэ.

Гарааны бизнесийг зохион байгуулахад дараах зарчмуудыг баримтална:

- гарааны бизнесийг хэрэгжүүлэх чиглэл, нөөц бололцоог сонгох;
- төрөөс үзүүлэх дэмжлэгийг тэгш хүртэх;
- экологи, шинжлэх ухаан, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;
- амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байх гэсэн зарчмуудтай байна.

Төрөөс үзүүлэх дэмжлэг нь гарааны бизнесийн экосистемийг зохион байгуулах, хөгжүүлэхэд дараах чиглэлийг баримталдаг байна. Үүнд:

- гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх нийгэм, эдийн засгийн таатай нөхцөлийг бүрдүүлэх;
- гарааны бизнесийн экосистемийг дэмжих чиглэлийг тодорхойлж, арга хэмжээг хэрэгжүүлэх;
- гарааны бизнесийг хөгжүүлэх, аж ахуйн нэгжийг урамшуулах, төрөөс хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- гарааны бизнесийн экосистемд оролцогчдыг төрөөс дэмжих, урамшуулах;
- венчур хөрөнгийн салбарын хөгжлийг дэмжих, венчур капиталын байгууллагуудыг гарааны бизнест хөрөнгө оруулахыг дэмжих;
- гарааны бизнесийн экосистемийг хөгжүүлэх олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх.

Гарааны бизнесийн экосистемийг зохион байгуулах, хөгжүүлэх чиглэлээр тус улсын яамдууд нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангах бөгөөд олон улсын хамтын ажиллагааг зохицуулахаар, мөн төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, гарааны бизнесийн стратеги төлөвлөгөө боловсруулах, төрөөс үзүүлэх дэмжлэгийг зохицуулахаар тусгасан.

Хуулийн төслийн 7 дугаар бүлэгт Гарааны бизнесийн экосистемийг зохион байгуулах, хөгжүүлэх төрийн эрх бүхий байгууллага нь Инновацийн хөгжлийн яам байхаар заасан. Тус яам нь гарааны бизнесийг бүртгэх, хянах, хөгжүүлэх, бизнес инкубатор, гарааны бизнесийг баталгаажуулах, гарааны бизнесийн экосистемийг зохион байгуулах, хөгжүүлэх төрийн нэгдсэн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, орон нутгийн байгууллага болон харьяа агентлагийн хоорондын үйл ажиллагааг уялдуулах, дүрэм журмыг боловсруулан батлах, тусламж дэмжлэг үзүүлэх, гарааны бизнес, бизнес инкубатор, гарааны хурдасгуурыг бүртгэх, бүртгэх нэгдсэн цахим платформыг зохион байгуулан зохицуулах, олон улсын хамтын ажиллагааг хангах зэрэг асуудлуудыг хариуцан хэрэгжүүлдэг байна.

Гарааны бизнес нь хувь хүний венчур хөрөнгө оруулагч болон корпорацын мэргэшсэн венчур хөрөнгө оруулагч гэсэн төрөлтэй:

- Бүртгэлтэй гарааны бизнесийн компанийн дүрмийн санд үндсэн дүнгийн 225 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, харин дүрмийн сангийн 30 хувиас дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн **хувь хүнийг венчур хөрөнгө оруулагч** гэнэ. Хувь хүний венчур хөрөнгө оруулагчид бүртгэлтэй гарааны бизнест оруулсан хөрөнгө оруулалтынхаа 50 хувийг, үндсэн дүнгээс 450 дахин их хэмжээгээр оруулсан этгээд зардлынхаа тодорхой хэсгийг нөхөх зорилгоор төрөлжсөн сангаас санхүүжилт авах давуу талтай.
- Бүртгэлтэй гарааны бизнесийн компанийн дүрмийн санд үндсэн дүнгийн 900 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний, харин дүрмийн сангийн 30 хувиас дээшгүй хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээдийг **мэргэшсэн венчур хөрөнгө оруулагч** гэнэ. Корпорацын мэргэшсэн венчур хөрөнгө оруулагч нь шаардлага хангасан компанийн хувьцааг худалдсан тохиолдолд 10 жил хүртэлх хугацаанд татвараас чөлөөлөгдөнө.

4. Инновацын үйл ажиллагааны тухай (On innovative activity, 2020) хуулийг Хууль тогтоох танхимд 2020 оны 04 сарын 07-ны өдөр, Сенатын танхимд 2020 оны 06 сарын 19-ний өдөр тус тус баталсан байна. Уг хуулийн зорилт нь инновацын үйл ажиллагааны харилцааг зохицуулахад оршино.

Инновац гэдэг нь өөрийн хэрэгцээнд ашигладаг шинэ бүтээн байгуулалт, түүнийг практикт ашиглаж, нийгэм, эдийн засгийн чухал үр дүнд хүрэх боломжийг олгохыг хэлнэ.

Шинэ төсөл гэдэг нь шинэ бүтээн байгуулалтыг бий болгох, хугацаа, гүйцэтгэгч, санхүүжилтийн эх үүсвэр, дэд бүтцийг бүрдүүлэх, арга хэмжээ юм.

Инновацын үйл ажиллагаа гэдэг нь шинэ бүтээн байгуулалтыг бий болгох, үйлдвэрлэлийн салбарт шилжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлнэ.

Инновацын үйл ажиллагааны зарчмууд:

- инновацын үйл ажиллагаа;
- инновацад төрөөс үзүүлэх дэмжлэгийг тэгш хүртээх;
- инновацын үйл ажиллагаанд төрөөс үзүүлэх дэмжлэгийг сурталчлах, чиглүүлэх;

- өрсөлдөөнийг дэмжих;
- мэдээлэл солилцох;
- инновацын үйл ажиллагааны үр дүнд бий болсон оюуны өмчийн объектын эрх зүйн хамгаалалт;
- иргэдийн амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учруулахгүй байх зэрэг болно.

Төрөөс инновацын үйл ажиллагааны чиглэлээр:

- инновацын хөгжлийн эрх зүйн зохицуулалтыг хангах;
- инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг, технологийн хөгжлийг урьдчилан таамаглах үндсэн дээр тодорхойлох;
- инновацын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгох;
- инновацын үйл ажиллагааны субъектийг төрөөс дэмжих, урамшуулах;
- инновацын үйл ажиллагааны чиглэлээр орон нутгийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх;
- инновацын үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт татахад туслах;
- инновацын үйл ажиллагааны чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- инновацын үйл ажиллагааны чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;
- инновацын үйл ажиллагааны чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг асуудлыг тус тус хэрэгжүүлдэг байна.

Инновацын төрлийг 4 хэсэгт хуваадаг:

- **бүтээгдэхүүний инновац:** техник, технологийн хувьд шинэ буюу сайжруулсан бүтээгдэхүүн (ажил, үйлчилгээ) боловсруулах, хэрэгжүүлэхэд чиглэсэн;
- **үйл ажиллагааны инновац:** техник, технологийн хувьд шинэ буюу сайжруулсан үйлдвэрлэл, аргыг боловсруулах, хэрэгжүүлэх, түүнчлэн технологи дамжуулахыг хэрэгжүүлэхэд чиглэсэн;
- **маркетингийн инновац:** бүтээгдэхүүний дизайн, сав баглаа боодлын өөрчлөлтийг хамарсан шинэ буюу сайжруулсан аргуудыг нэвтрүүлэх, бүтээгдэхүүн борлуулах, танилцуулах шинэ аргыг ашиглах, үнийн шинэ стратеги боловсруулахад чиглэсэн;
- **байгууллагын инновац:** бизнесийг зохион байгуулах, явуулах, ажлын байр бий болгох, гадаад харилцаа тогтоох шинэ буюу сайжруулсан аргуудыг нэвтрүүлэхэд чиглэгддэг.

Инновацийн үйл ажиллагааг дэмжих сангуудтай байна. Энэ сангууд нь шинэ бүтээн байгуулалтыг бий болгох, хэрэгжүүлэх, үйлдвэрлэх, технологи дамжуулах, арилжаанд оруулахтай холбоотой зардал, хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх, шинжлэх ухааны лаборатори баазыг бэхжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх зорилготой. Инновацийн үйл ажиллагааг дэмжих сан нь эргэн төлөлт эсхүл үнэ төлбөргүй санхүүжилт олгохоос гадна инновацийн үйл ажиллагааны субъектийн үүрэг хариуцлагын баталгаа болж чаддаг.

5. “Бизнесийн орчныг сайжруулах, хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бүрдүүлэх шинэчлэлтийн тухай” (*Decree of the President of the Republic of Uzbekistan “On next reforms to create conditions for stable economic growth by improving business environment and developing private sector” № DP-101*) зарлигийг 2022 оны 04 сарын 09-ний өдөр Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгч гаргажээ.

Уг зарлигт Узбекистан Улсыг 2022-2026 онд хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлэхийн тулд эдийн засгийн хүртээмжтэй, тогтвортой өсөлтөөр хангах, эдийн засаг дахь өрсөлдөөнийг дэмжих, аж ахуйн нэгжүүдэд эрх тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн харилцаанд бүрэн шилжих, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг хоёр дахин бууруулах, эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх, бизнес эрхлэх итгэлийг төрүүлэх, баталгаажуулах зэрэг асуудлуудыг хамруулсан.

Түүнчлэн өмч хувьчлалын үйл ажиллагааг хурдасгах, хөрөнгө оруулалтыг татах, төрийн өмчийг худалдах, газар тариалангийн бус газрыг дуудлага худалдаагаар худалдах ажлыг 3 жилийн хугацаагаар сунгах, төрийн өмчийн болон газар тариалангийн бус газрын 35 хувийг төлсөн тохиолдолд худалдан авагчдад үл хөдлөх хөрөнгө, газрыг зээлийн баталгаанд барьцаалах эрх олгох зэрэг асуудлуудыг тусгасан байна.

Бизнес эрхлэх аж ахуйн нэгжийг зах зээлд өрсөлдөх тэгш боломжийг бүрдүүлэхийн тулд татвар болон гаалийн татварыг 2022 оны 5 сарын 01-ний өдрөөс эхлэн хөнгөлөхөөр тусгасан.

Мөн жижиг, дунд оврын усан цахилгаан станц шинээр барих, хувийн хэвшлийн оролцоотой, төр, хувийн хэвшлийн түншлэлийн үндсэн дээр төсөл хэрэгжүүлэхийг нэн тэргүүнд авч үзсэн байна. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, гүйцэтгэх байгууллагын гишүүдийн цалин хөлсийг нэмэгдүүлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлсэн байна. Хяналтын зөвлөл нь хувьчлах үйл явцыг цаг тухайд нь, чанартай гүйцэтгэсэн,

түүний дотор хувьцааг нийтэд санал болгох (IPO), Төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн эдийн засаг дахь оролцоог хязгаарлах, багасгах, үл хөдлөх хөрөнгийн шинэ объектыг барих, өрсөлдөөнийг хөгжүүлэх, нэмэлт үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгжийн дүрмийн санд оролцох, хувь эзэмших, төрийн болон арилжааны банкуудын 50 хувийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн өмчийг бусдад шилжүүлэх, худалдах, дүрмийн санд хөрөнгө оруулах тухай гэрээ байгуулах, ногдол ашгийн хэмжээг тогтоох, санхүүгийн үр дүнг зөв бүрдүүлэхэд хяналт тавих зэрэг өргөн асуудлуудыг хамруулсан байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Итали

- The Italian Startup Act, Italy’s national strategy to support innovative startups and innovative SMEs, https://www.mimit.gov.it/images/stories/documenti/Executive%20summary%20ISA%2007_2019.pdf
- The Italian development agency, <https://www.invitalia.it/eng/what-we-do/services/startups>
- Italy’s new industrial policy for innovation Focus on innovative startups, http://ipr.mofcom.gov.cn/hwwq_2/zn/Europe/Ita/file/Innovative_startups_10_02_2017.pdf
- THE EVALUATION OF THE ITALIAN “START-UP ACT” OECD science, technology and industry policy papers, September 2018 No. 54, <https://www.oecd-ilibrary.org/docserver/02ab0eb7-enpdf?expires=1709022976&id=id&accname=guest&checksum=37B5042DE185CA9FDF7C32F632B88AB3>

АНУ

- Startup Ranking <https://www.startupranking.com/top>
- Federal Employer Number, <https://www.irs.gov/businesses/small-businesses-self-employed/employer-id-numbers>
- Estimated Taxes, <https://www.irs.gov/businesses/small-businesses-self-employed/estimated-taxes>
- Internal Revenue Code Section 409A, <https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2011-title26/pdf/USCODE-2011-title26-subtitleA-chap1-subchapD-partI-subpartA-sec409A.pdf>
- Internal Revenue Code Sections 422 & 423, <https://www.govinfo.gov/app/details/USCODE-2010-title26/USCODE-2010-title26-subtitleA-chap1-subchapD-partII-sec422>, <https://www.govinfo.gov/app/details/USCODE-2011-title26/USCODE-2011-title26-subtitleA-chap1-subchapD-partII-sec423>
- Internal Revenue Code Section 83(b), <https://www.law.cornell.edu/uscode/text/26/83>
- Unruh Civil Rights Act, <https://www.dor.ca.gov/Home/UnruhCivilRightsAct>
- Gramm-Leach-Bliley Act, <https://www.ftc.gov/legal-library/browse/statutes/gramm-leach-bliley-act>
- Shine the Light Law, <https://law.justia.com/codes/california/2009/civ/1798.80-1798.84.html>
- Clayton Antitrust Act of 1914, <https://www.ftc.gov/legal-library/browse/statutes/clayton-act>
- Robinson-Patman Act, <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-12152/pdf/COMPS-12152.pdf>

- Sherman Antitrust Act, <https://www.govinfo.gov/content/pkg/COMPS-3055/pdf/COMPS-3055.pdf>
- Cartwright Act, https://www.sheppardmullin.com/media/publication/622_landry_competition.pdf
- Anticybersquatting Consumer Protection Act, <https://www.govinfo.gov/content/pkg/CRPT-106srpt140/html/CRPT-106srpt140.htm>
- Digital Millennium Copyright Act, <https://www.copyright.gov/legislation/dmca.pdf>
- Lanham Act, <https://www.govinfo.gov/app/details/COMPS-1624>
- Leahy-Smith America Invents Act, https://www.uspto.gov/sites/default/files/aia_implementation/20110916-pub-l112-29.pdf
- Gramm-Leach-Bliley Act, <https://www.ftc.gov/legal-library/browse/statutes/gramm-leach-bliley-act>
- Dodd-Frank Act, <https://www.cftc.gov/LawRegulation/DoddFrankAct/index.htm>
- Sarbanes-Oxley Act, <https://sarbanes-oxley-act.com/>
- Song-Beverly Credit Card Act of 1971, <https://codes.findlaw.com/ca/civil-code/civ-sect-1747-08/>
- Small Business Innovation Research, <https://www.sbir.gov/about>
- Small Business Technology Transfer - <https://www.sbir.gov/about>
- State Trade Expansion Program, <https://www.sba.gov/funding-programs/grants/state-trade-expansion-program-step>
- National Institute of Health Grants, <https://www.nih.gov/grants-funding>
- Blueprint Medtech Small Business Translator Grant, <https://grants.nih.gov/grants/guide/pa-files/PAR-21-282.html>
- Innovation Corps at NIH Program for NIH and CDC Translational Research, <https://grants.nih.gov/grants/guide/pa-files/PAR-22-073.html>
- U.S. Department of Agriculture Rural Development Business Programs, <https://www.rd.usda.gov/programs-services/business-programs>
- U.S. Department of Commerce Minority Business Development Agency, <https://www.mbda.gov/mbda-programs#3/34.05/-111.95>
- U.S. Department of Education Grants, <https://www2.ed.gov/fund/grants-apply.html?src=pn>
- National Institute on Disability, Independent Living, and Rehabilitation Research’s Small Business Innovative Research, <https://acl.gov/programs/research-and-development/small-business-innovation-research-program>

Израил

- World Economic Forum, Global Competitiveness Report 2019, https://www3.weforum.org/docs/WEF_TheGlobalCompetitivenessReport2019.pdf

- Israel Innovation Authority, https://innovationisrael.org.il/en/press_release/stimulus-to-boost-israeli-high-tech/
- Fund of Funds (FOF) Explained: How It Works, Pro & Cons, Example, <https://www.investopedia.com/terms/f/fundsoffunds.asp>
- Israel Innovation Authority, Ideation (Tnufa) Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/ideation-tnufa-incentive-program/>
- Israel Innovation Authority, Technological Innovation Incubators Program, <https://innovationisrael.org.il/en/programs/technological-innovation-incubators-program/>
- Israel Innovation Authority, Fast Track funding program, <https://innovationisrael.org.il/en/programs/fast-track-funding-program/>
- Israel Innovation Authority, Early Stage Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/early-stage-companies-incentive-program/>
- Israel Innovation Authority, Call for Proposals for the Establishment of 3 Angel Investors' Clubs, https://innovationisrael.org.il/en/calls_for_proposal/angel-clubs-establishment/
- Israel Innovation Authority, Institutional Investors – Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/institutional-investors-incentive-program/>
- Israel Innovation Authority, Seed Incentive Program, <https://innovationisrael.org.il/en/programs/seed-incentive-program/>

Узбекистан

- Гарааны бизнесийн тухай хуулийн төсөл, 2020, <https://regulation.gov.uz/uz/document/17135>
- АХБ “Узбекистаны экосистем, гарааны бизнесийн технологи” тайлан, 2023 <https://www.adb.org/sites/default/files/publication/905251/uzbekistan-ecosystem-technology-startups.pdf>
- Узбекистан дахь бизнесийн боломжууд, <https://www.usemultiplier.com/uzbekistan/company-registration>
- Узбекистан бизнес орчин, тайлан, 2023, https://assets.ey.com/content/dam/ey-sites/ey-com/en_uz/home/doing-business-uzbekistan-2023.pdf
- Төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, 2022 <https://kostalegal.com/publications/joint-publication/public-private-partnership-law-review>
- Аж ахуйн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны баталгааны тухай хууль, 2012 <https://lex.uz/docs/4403340>
- Узбекистан Улсын Инновац хөгжлийн яамны цахим хуудас, <https://mininnovation.uz/en/info/startaplar>
- БНУЗУ-ын Ерөнхийлөгчийн “Бизнесийн орчныг сайжруулах,

хувийн хэвшлийг хөгжүүлэх замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг бүрдүүлэх, шинэчлэлтийн тухай” зарлиг <https://lex.uz/docs/6359076?ondate=09.04.2022>

- АХБ, Узбекистаны ЖДҮ-ийг хөгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилгоор 100 сая ам.долларын зээл олгосон. <https://daryo.uz/en/2023/12/10/adb-allocates-100mn-to-boost-smes-and-propel-economic-growth-in-uzbekistan>
- Гэр бүлийн бизнес эрхлэх тухай хууль, 2012 <https://lex.uz/ru/docs/4550923>
- Инновацийн үйл ажиллагааны тухай хууль, 2020 <https://lex.uz/docs/5155423>
- Германы Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны “Гарааны бизнесийн экосистемийн тайлан”, 2019, <https://www.enpact.org/wp-content/uploads/2020/11/startup-ecosystem-report-tashkent-uzbekistan.pdf>

Бусад

- Icreport - start up act: an emerging instrument to foster the development of innovative high-growth firms ; giz, British council, Expertise france, SNV, https://www.icr-facility.eu/wp-content/uploads/2023/08/icreport_startupacts.pdf
- ADBI Working Paper Series: comparative study on regulatory and policy frameworks for promotion of startups and smes in Japan, the Republic of Korea, Malaysia, and Thailand - ADB Institute, Asian Development Bank, <https://www.adb.org/sites/default/files/publication/668331/adbi-wp1206.pdf>
- Regulation for startups in Indonesia: Problems and recommendations - Cogent Business & Management, <https://www.tandfonline.com/doi/epdf/10.1080/23311975.2023.2276993?needAccess=true>
- Framework conditions for high-growth innovative enterprises (HGIE) - European Commission, <https://op.europa.eu/en/publication-detail/-/publication/e326b62f-24cd-11e7-b611-01aa75ed71a1>
- Start-up Law in Israel - by EHUD Kamar, Ayal Shenhav and Shay Yanovsky, <https://deliverypdf.ssrn.com/delivery.php>

**МОНГОЛ УЛСЫН ЗАРИМ АЙМАГ, СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**
(Мэдээлэл, лавлагаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэ,
И.Жаргалзаяабямба, О.Нарантуяа, Ц.Ариунаа*

АГУУЛГА

**I БҮЛЭГ. АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Нэг.Тойм лавлагаа

Хоёр.Хүн ам зүйн үзүүлэлтүүд

Гурав.Нийгмийн үзүүлэлтүүд

Дөрөв.Эдийн засгийн үзүүлэлтүүд

Тав.Сумдын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

**II БҮЛЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Нэг.Тойм лавлагаа

Хоёр.Хүн ам зүйн үзүүлэлтүүд

Гурав.Нийгмийн үзүүлэлтүүд

Дөрөв.Эдийн засгийн үзүүлэлтүүд

Тав.Сумдын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

**III БҮЛЭГ. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Нэг.Тойм лавлагаа

Хоёр.Хүн ам зүйн үзүүлэлтүүд

Гурав.Нийгмийн үзүүлэлтүүд

Дөрөв.Эдийн засгийн үзүүлэлтүүд

Тав. Сумдын нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



I БҮЛЭГ. АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НЭГ.ТОЙМ ЛАВЛАГАА

1.Товч түүх:

Халхын Сайн ноён хан аймаг 1725 онд байгуулагдсан. 1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний дараа Богд хаант Монгол Улсын Сайн ноён хан аймаг нэртэй байсан бөгөөд Ардын Засгийн газрын 1923 оны 10 дугаар сарын 19-ний хурлын 39 дүгээр тогтоолоор аймгуудын нэрийг өөрчлөхөд тус аймгийн нэрийг Цэцэрлэг мандал уулын аймаг болгон өөрчилжээ. БНМАУ-ын Бага хурлын 1931 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 5 дугаар хурлын тогтоолоор 5 аймгийг 13 аймаг болгосонтой холбоотойгоор 71 сум, 16 хошуутай байсан Цэцэрлэг мандал уулын аймаг 35 сумтай Архангай аймаг болсон түүхтэй.⁴⁵

2.Газар зүйн байршил:

Монгол Улсын төв хэсэгт Хангайн нурууны ар, түүний салбар уулс болох Тарвагатайн нурууны зүүн өвөрт тэдгээрээс эх авсан Орхон, Тамир, Чулуут Хануй, Хүнүй голын бэлчирт оршдог. Далайн түвшнээс дээш дунджаар 2,414 метр өндөршилтэй, хамгийн өндөр цэг нь 3,529 метр Харлагтайн сарьдаг уул, хамгийн нам дор цэг нь 1,290 метр өндөр Орхон Тамирын бэлчир. Баруун урд талаараа Баянхонгор, баруун талаараа Завхан, хойд талаараа Хөвсгөл, зүүн талаараа Булган, өмнө талаараа Өвөрхангай аймагтай тус тус хиллэдэг.⁴⁶

3.Хүн амын тоо:

2022	2023
95,253	93,616

4.Нутаг дэвсгэрийн хэмжээ: Нийт **55,300** км² нутаг дэвсгэртэй. Аймгийн бүх нутгийн **70.7%**-ийг малын бэлчээр, **1.8%**-ийг хадлангийн талбай, **0.6** %-ийг тариалангийн талбай, **15.7** %-ийг ой мод тус тус эзэлдэг байна.⁴⁷

5.Аймгийн төвийн нэр: Цэцэрлэг хот

6.Засаг захиргааны хуваарь: 19 сум, 101 багтай.

7.Угсаатны зүйн байдал: Халх **99%**, бусад **1%**

⁴⁵ <https://arkhangai.gov.mn/2023/06/18/to-23/>

⁴⁶ <https://arkhangai.gov.mn/2023/06/18/to-22/>

⁴⁷ <https://arkhangai.nso.mn/uploads/users/77/files/Arkhangain%20aimgiin%20taniitsuulga.pdf>

8.ёс заншил, өв уламжлал:

Монголын төв халхын өв уламжлал, ёс заншлыг өвлөн уламжилсан Монгол ардын уртын дуу, ерөөл магтаал, морин хуур, лимбэ, хөөмий, монгол үндэсний уран хатгамал, зээгт наамал, уран нугаралт, битүү амьсгаагаар лимбэ тоглох, үндэсний хээ угалз, ган сийлбэр зэрэг онцлог бөгөөд баялаг өв уламжлалтай. Түүнчлэн Заяын хүрээнээс гаралтай мөсөн шагайн наадгайн онцгой төрлийг өвлөн хөгжүүлж байна.

9.Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар:**Байгалийн 9 гайхамшиг:**

1. Хорго, Тэрхийн цагаан нуур (Тариат сум);
2. Тайхар чулуу (Ихтамир сум);
3. Суварга хайрхан, Хошготын хүрхрээ (Цэнхэр сум);
4. Чулуут голын хавцал, Суман Чулуут голын бэлчир (Өндөр-Улаан,Тариат сум);
5. Булган уул (Эрдэнэбулган сум);
6. Ноён хангай. Хатан хангай, Дашдагва уулс (Хангай сум);
7. Хөх нуур (Ихтамир сум);
8. Өгийнуур (Өгийнуур сум);
9. Бух чулуу, гурван голын бэлчир (Цэцэрлэг сум).

Түүх, соёлын 9 гайхамшиг:

1. Хөшөө цайдам (Хашаат сум);
2. Заяын хүрээ (Эрдэнэбулган сум);
3. Чулуут голын хадны сүг зураг (Тариат, Өндөр-Улаан, Жаргалант сумууд);
4. Хүнүйн голын хөндий дэх хүннүгийн дурсгалууд (Ихтамир, Эрдэнэмандал, Хайрхан сумууд);
5. Балгасан тал дахь Хүннүгийн цогцолбор, Бичигт хангай (Өндөр-Улаан сум);
6. Уйгарын Хар балгас, Дойтын балгас, Ану хатны бунхан дурсгалт газрууд (Хотонт сум);
7. Хул хар хааны балгас, домогт газрууд (Эрдэнэмандал сум);
8. Гэсэр ламын бунхан (Цахир сум);
9. Мухар хужирт (Цэцэрлэг сум).

10.Дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн голлох салбар:

2021	2022
744.0 тб.төг	864.1 тб.төг
Голлох салбар: ХАА - 476.8 тб.төг, үйлдвэрлэл - 115.9 тб.төг, үйлчилгээ 151.2 тб.төг эзэлж байна.	Голлох салбар: ХАА - 562.9 тб.төг, үйлдвэрлэл - 125.9 тб.төг, үйлчилгээ - 175.2 тб.төг тус тус эзэлж байна.

11.Төрийн албан хаагчдын тоо:

2022	2023
5,705	5,726

ХОЁР. ХҮН АМ ЗҮЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**1.Суурин хүн амын тоо:**

2022	2023
95,253	93,616

2.Суурин хүн амын хүйсийн харьцаа:

2022	2023
100.7	101.2

3.Хүн амын дундаж наслалт:

2022	2023
73.34	73.33

4.Өрхийн тоо:

2022	2023
28,219	28,257

5.Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо (2020):

Нийт **26,828** өрх үүнээс: эх үүсвэртэй нь **26,492 (98.7%)**, эх үүсвэргүй нь **336** буюу **(0.5%)** байна.

6.Төрөлтийн тоо:

2022	2023
1,893	1,909

7.Нас баралтын тоо:

2022	2023
556	577

8.Шилжин ирсэн хүн амын тоо:

2022	2023
явсан 2,859	явсан 2,833
ирсэн 466	ирсэн 695

9.Гэрлэлт, цуцлалтын тоо:

2022	2023
Гэрлэлт 269	Гэрлэлт 296
Цуцлалт 51	Цуцлалт 34

ГУРАВ. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.ЕБС-ийн бүлэг дүүргэлт:

2022	2023
27.9	28.4

2.ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа:

2022	2023
19.3	19.6

3.Нийт өнчин хүүхдийн тоо:


2022	2023
бүтэн 97	бүтэн 59
хагас 1,426	хагас 1,625

4.Өрх толгойлсон эх:

2021	2022
2,401	2,141

5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:

2022	2023
3,652.0	3,833.0



6.Хөдөлмөр эрхэлдэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:

2022	2023
288	330

7.Бүртгэгдсэн гэмт хэрэг

2022	2023
524	397

8.Ядуурал (Хангайн бүс)

2020	2022
31.4	33.5

9.Ажилгүйдлийн түвшин:

2021	2022
2.8%	1%

10.Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын сарын бодит дундаж цалин:

2022	2023
645.3 мян.төг	784.2 мян.төг

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**1.Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс:**

2022	2023
13.6%	5.8%
	Үүнээс, бусад бараа 14.1%, хүнс бараа, ундаа ус 12.3%, зочид буудал, нийтийн хоол 9.0%, согтууруулах ундаа, тамхи 7.6%,соёлын бараа 4%, гар ахуйн тавилга 3.4%, эмнэлгийн үйлчилгээ, эм тариа 2.2%, боловсрол 1.4%, тээвэр 0.4% зэрэг тус тус нөлөөлжээ. ⁴⁸

⁴⁸ АР аймгийн 2023 оны нийгэм эдийн засгийн байдал (статистик мэдээлэл)

2.Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн цэвэр өөрчлөлт:

2022	2023
113.8	105.8
	Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 338 нэрийн барааны үнэ тарифын 156 (46.2%) нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ өсөж, 16 (4.7%) нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ буурч, 166 (49.1%) нэр төрлийн бүтээгдэхүүний үнэ тогтвортой байлаа.

3.Хүн амын сарын дундаж хэрэглээ (Хангайн бүс):

2020	2022
276,526 төг	417,421 төг

4.Иргэдийн хадгаламжийн данс:

2022	2024 II
53.2 мянга	52.4 мянга

5.Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл:

2022	2023
155.1 тэрбум.төг	173.3 тэрбум.төг

6.Малтай өрх:

2022	2023
19.9 мянга	19.8 мянга

7.Малчин өрх:

2022	2023
16.2 мянга	16.2 мянга

8.Малчдын тоо:

2022	2023
26.7 мянга	26.2 мянга

9.Малын тоо:

2022	2023
Нийт 5,886.1 мян.тол, үүнээс: тэмээ- 1.7 мянга, адуу- 467.9 мянга, үхэр- 814,5 мянга, хонь- 3.0 сая, ямаа 1.5 сая тус тус эзэлжээ.	Нийт 4,847.4 мян.тол, өмнөх оноос 1,038.7 мянган (17.6%) толгой малаар буурсанаас тэмээ 1.5 мянга, адуу 448.5 мянга, үхэр 741 мянга, хонь 2.4 сая, ямаа 1.3 сая болж тус тус буурчээ.

10.Том малын зүй бус хорогдол:

2022	2023
Нийт 73.3 мянган мал хорогдсон.	Нийт 881,480 Үүнээс: тэмээ- 48 , адуу- 52,134 , үхэр- 167,778 , хонь- 464,444 , ямаа- 197,076 тус тус хорогдсон байна. Шалгаан нь: өвчнөөр- 5,733 , хээлтэгчийн улмаас - 129,969 толгой мал, бусад зүй бус хорогдол зэргээс болно.

11.Шинэ хоршоолол хөдөлгөөнд хамрагдсан иргэдийн тоо:

Шинэ хоршоо хөдөлгөөнд хамрагдсан **297** иргэд. үүнээс: шинэ хоршоо байгуулсан - **96**, материал тараасан - **155**, хоршооны дүрэмдээ өөрчлөлт оруулсан - **40**, зээл авсан - **6** байна.

12.Аймгийн удирдлагын тогтвор суурьшил:

аймгийн ИТХ-ын дарга:

- 2020 оноос Б.Батжаргал

аймгийн Засаг дарга:

- 2020-2021онд Д.Золжаргал,
- 2021-2022 онд М.Батжаргал
- 2023 оноос Б.Цэрэннадмид



13.Хүлээн авсан жуулчдын тоо 2023-2024:

Гадаадын **20,804**, дотоодын **306,317**, нийт **327,121** жуулчин

14.Аймгийн бүтээн байгуулалт 2020-2024:

2020 онд

- Соёлын төв -1.6 тб.төг
- Гичгэнэ багийн төв - 69 сая.төг

2021 онд

- III сургуулийн урлаг заалны барилга угсралт - 700 сая.төг
- I сургуулийн 320 хүүхдийн өргөтгөлийн барилга - 3.3 тб.төг
- Цэцэрлэг сумын 50 Хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөл - 485 сая.төг
- Цахир сумын 50 хүүхдийн цэцэрлэгийн барилга - 486 сая.төг

2022 онд

- Төвшрүүлэх сумын 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга-2.4 тб.₮
- Хайрхан сумын Холбооны барилга

2023 онд

- Булган сумын Соёлын төвийн 240 суудалтай барилга
- Чулуут сумын 320 хүүхэдтэй Сургуулийн өргөтгөл
- Багшийн хөгжил, судалгааны арга зүйн төвийн барилга
- Жаргалант сумын 240 суудал бүхий Соёлын төв
- Батцэнгэл сумын 150 ортой Хүүхдийн цэцэрлэг
- Эрдэнэбулган сумын150 ортой 2-р цэцэрлэг

2024 онд

- Эрдэнэбулган сумын 160 хүүхэдтэй IV сургууль - 3.8 тб.төг
- 300 ортой нэгдсэн эмнэлэг – 25.2 тб.төг

15.Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт:

2022	2023
12.7 тб.төг	10.9 тб.төгрөг Өмнөх оноос нийт үйлдвэрлэл буурсан нь нийт үйлдвэрлэлийн 27.8%-ийн хүнс ундаа, 1.3%-ийг хэвлэл, 40.8%-ийг дулаан, эрчим хүч, 13.5%-ийг усан хангамж, 1.0%-ийг модон эдлэл, 12.7%-ийг бусад үйлдвэрлэл тус тус эзэлж байна.

16.Үйл ажиллагаа эрхэлж буй ААН:

2021	2022
Хуулийн этгээдий тоо - 1,920 ЖДҮ-ийн тоо – 557 уул уурхайн ААН-ын тоо - 2	Хуулийн этгээдийн тоо - 1,992 ЖДҮ-ийн тоо – 653 уул уурхайн ААН-ын тоо - 1

17.Хувиараа хөдөлмөр эрхлэгчид (2021):

Нийт **953**, үүнээс: эрэгтэй **519**, эмэгтэй **434** байна.

18.Орон нутгийн төсвийн орлого, зарлага

	2022	2023
Орон нутгийн төсвийн нийт орлого	42,556.2 сая.төг	55,284.5 сая.төг
Орон нутгийн төсвийн нийт зарлага	42,166.7 сая.төг	54,964.6 сая.төг

ТАВ.СУМДЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**1.АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Тойм лавлагаа		
Товч түүх	1586 онд Булган уулын өвөр “Чонотын хөндий” хэмээх газарт Заяын хүрээний шавыг тавьж, анхны дуганг барьсан байна. 1631 онд өргөтгөн тэлж, Заяын хүрээний анхны томоохон дуган, сүмүүдийг барьж эхэлсэн. Хожим II Зая гэгээн Лувсанпэрэнлэй 1679 онд Төвөдийн орноос нутагтаа морилоод хүрээний суурин дээр 4 их дацан байгуулж, “Заяын хүрээ”-ний суурин дээр Архангай аймгийн төв Цэцэрлэг хот (Эрдэнэбулган сум) үүсэж хөгжсөн түүхтэй ⁴⁹ .	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Булган, Ихтамир, Батцэнгэл сумтай хил залгана. Тоомын нуруу, Булган уул зэрэг өндөр уулстай, хойд Тамир, урд Тамир голын өргөн хөндий хоёр талаас нь эмжин оршдог. Сумын төв Цэцэрлэг хот, Улаанбаатар хотоос 230 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	21,603	21,586
Нутаг дэвсгэрийн хэмжээ	536 км ² нутаг дэвсгэртэй. Нийт нутгийн 36%-ийг ой эзэлдэг.	
Сумын төвийн нэр	Цэцэрлэг хот	
Засаг захиргааны хуваарь	Цагаан даваа, Арслан цохио, Цагдуулт, Бор толгой, Наранбулаг, Цагаан дэл гэсэн 6 багт хуваагддаг.	

⁴⁹ http://www.touristinfocenter.mn/cate13_more.aspx?ItemID=106

<p>Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар</p>	<p>Тус сумын Булган уул нь дэлхийд зул өргөдөг 3 уулын нэг бөгөөд 1965 онд дархан газар, 1995 онд Улсын тусгай хамгаалалтад авчээ.</p> <p>Байгалийн түүх, дурсгалт газрууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Чонон хөшөө; 2. Булган уулын бурханы зосон зураг; 3. Галдан зуу хийд зэрэг дугантай. <p>Түүх соёлын өв болсон гэрэлт хөшөө дурсгалууд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зая гэгээний дүр Лувсанпэрэнлэйн хөшөө; 2. Бурхан багшийн сэрэг дүр хөшөө; 3. Г.Дэмид жанжны хөшөө; 4. Н.Жамъян аваргын хөшөө; 5. Р.Минжүүр аваргын хөшөө; 6. Бөх Билэгтийн хөшөө; 7. Самойл Мойсолевич Немойны хөшөө; 8. Виктор Станиславович Кияковскийн хөшөө; 9. Хэлмэгдэгсдийн хөшөө. 	
<p>Төрийн албан хаагчдын тоо</p>	<p>2,396</p>	<p>1,130</p>
<p>Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд</p>		
	<p>2022</p>	<p>2023</p>
<p>Өрхийн тоо</p>	<p>6,364</p>	<p>6,508</p>
<p>Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо</p>	<p>772</p>	<p>716</p>
<p>Төрөлтийн тоо</p>	<p>427</p>	<p>428</p>
<p>Нас баралтын тоо</p>	<p>155</p>	<p>148</p>
<p>ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт</p>		<p>255</p>
<p>Бүртгэгдсэн гэмт хэрэг</p>	<p>157</p>	
<p>Эдийн засгийн үзүүлэлтүүд</p>		
	<p>2022</p>	<p>2023</p>
<p>Малтай өрх,</p>	<p>1,265</p>	<p>1261</p>
<p>Малчин өрх,</p>	<p>0,79 мян.өрх</p>	<p>0,73 мян.өрх</p>
<p>Малчдын тоо</p>	<p>1,190</p>	<p>1,112</p>
<p>Малын тоо</p>	<p>233.79 мян.тол</p>	<p>206.89 мян.тол</p>
<p>Том малын зүй бус хорогдол</p>	<p>7.47 мян.тол</p>	<p>37.3 мян.тол</p>
<p>Хуулийн этгээдийн тоо (ААН)</p>	<p>881</p>	<p>899</p>
<p>Хувиараа хөдөлмөр эрхлэгчид</p>	<p>449</p>	<p>468</p>
<p>Орон нутгийн төсвийн нийт орлого</p>		<p>8,854.8 мян.төг</p>

**2.АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Тойм лавлагаа		
Товч түүх	Цэцэрлэг мандал уулын аймгийн Батцэнгэл уулын хошуунаас байгуулагдсан түүхтэй. Засаг захиргааны хуваарь, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр 1952 онд тус сумын нутгаас 2 багийг тасалж, Өгийнуур сумыг байгуулсан бөгөөд 1968 онд Баян-Уул сумыг татан буулгаж Батцэнгэл суманд нэгтгэсэн түүхтэй.	
Газар зүйн байршил	Тус аймгийн Ихтамир, Эрдэнэмандал, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Төвшрүүлэх, Цэнхэр, Эрдэнэбулган, Булган сумтай хил залгадаг. Сумын төв Жаргалант суурин, аймгийн төвөөс зүүн хойш 71 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	3,774	3,695
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3500 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Жаргалант суурин	
Засаг захиргааны хуваарь	Улаанчулуу, Хөнөг, Дэл, Баян-Уул, Цац, Дайр бор гэсэн 6 багт хуваагдана.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Түүхийн дурсгалт <ul style="list-style-type: none"> Халзангийн хүрээ (1832); Тарвачэнболин хийд; Байгалийн түүх, дурсгалын газар : <ul style="list-style-type: none"> Дайр бор уулыг жил бүр тахидаг шүтээн уул; Гурван Тамирын бэлчир. 	
Төрийн албан хаагчдын тоо		162
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,168	1,147
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	781	753
Төрөлтийн тоо	63	71
Нас баралтын тоо	15	23
Бүртгэгдсэн гэмт хэрэг	4	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,042	1,026
малчин өрх,	0,9 мян.өрх	0,85 мян.өрх
малчдын тоо	1,443	1,343
Малын тоо	437.23 мян.тол	334.94 мян.тол
Том малын зүй бус хорогдол	3 мян.тол	49.27 мян.тол
Хуулийн этгээдийн тоо ААН	61 үүнээс: 2020-2024 онд уул уурхайн чиглэлээр хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 4 компани байна.	62

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	32	34
Орон нутгийн төсвийн нийт орлого		471,034.1 мян.төг

3.АРХАНГАЙ АЙМГИЙН БУЛГАН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1954 онд Төвшрүүлэх сумыг татан буулгаж, Булган, Баян-Улаан суманд нийлүүлсэн бөгөөд 1959 онд сумдаас тасалж, Урд Тамир сумыг байгуулжээ.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Ихтамир, Батцэнгэл, Цэнхэр, Эрдэнэбулган, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Галуут сумтай хил залгадаг. Сумын төв нь Булгийн дэнж суурин, аймгийн төвөөс баруун урагш 36 км-т оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	2,838	2,814
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,100 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Булгийн дэнж	
Засаг захиргааны хуваарь	Тусгалт, Зуунмод, Тамир, Баянбулаг гэсэн 4 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Майдар чулуу (18-р зуун); • Буган хөшөө; • Бөх мод; • Хуучин цагийн Бэйсийн хүрээ хийд; • Шинэ барууны дуган; • Урд Тамирын гол түүний цутгалан Хоромсого, Хушгат, Хүхрээ, Нарийн, Бугат, Жаргалант, Могойн гол, Хөх даваа, Өвөр, Тээл зэрэг олон горхитой. 	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		146
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	912	9074,
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	473	510
Төрөлтийн тоо	44	53
Нас баралтын тоо	12	13
Бүртгэгдсэн гэмт хэрэг	15	
Ажилгүйдлийн түвшин		
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	714	702
Малчин өрх,	0.58 мян.өрх	0.58 мян.өрх
Малчдын тоо	967	988

Малын тоо	142.26 мян.тол	122.65 мян.тол
Том малын зүй бус хорогдол	1.3 мян.тол	12.57 мян.тол
Хуулийн этгээдийн тоо ААН	52	50
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	28	28
Орон нутгийн төсвийн нийт орлого		730,548.7 мян.төг

4.АРХАНГАЙ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Жаргалант сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Рашаант уулын хошуунаас 1931 онд байгуулагджээ. Засаг захиргааны хуваарь, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр 1959 онд тус сумын нутгаас тасалж, Туулант сумыг байгуулан 2 жилийн дараа буцаан нийлүүлсэн түүхтэй.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Тариат, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Хөвсгөлийн Галт сумтай хил залгана. Сумын төв нь Баянцагаан суурин аймгийн төвөөс 230 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	4,383	4,379
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,832 км² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Баянцагаан суурин	
Засаг захиргааны хуваарь	Асайт, Хоолт, Эрдэнэ-Уул, Зуслан, Баянцагаан гэсэн 5 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Чулуутын гол, Дулаанхан уулыг сумаас тусгай хамгаалалтай газар бүртгэсэн; • Хайрханд зэс молибден; • Баянголд алтны илэрцтэй, чулуун нүүрс, шохойн чулуу, хар тугалганы баялагтай. • Хуучин цагийн Ажраг хийд; • Улиастайн хүрээ хийд; • Завдалын хийд; • Асайтын хүрээ хийд. 	
Төрийн албан хаагчдын тоо		211
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,201	1,193
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	762	708
Төрөлтийн тоо	83	89
Нас баралтын тоо	22	23

Бүртгэгдсэн гэмт хэрэг	7	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,043	1,028
Малчин өрх,	0.88 мян.өрх	0.88 мян.өрх
Малчдын тоо	1,663	1,644
Малын тоо	265.71 мян.тол	192.73 мян.тол
Том малын зүй бус хорогдол	2.26 мян.тол	17.63 мян.тол
Хуулийн этгээдийн тоо ААН	56	57
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	37	38
Орон нутгийн төсвийн нийт орлого	1,058,695.3 мян.төг	

5.АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Ихтамир сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Хан-Өндөр уулын хошуунаас байгуулагджээ. Засаг захиргааны хуваарь, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр тус сумын нутгаас тасалж, 1959 онд Тайхар сумыг байгуулжээ. 1960 онд Бугат, Тайхар сумыг нэгтгэж, улмаар уг сумыг 1961 онд Ихтамирт нийлүүлсэн түүхтэй.	
Газар зүйн байршил	Ихтамир сум нь Архангай аймгийн Чулуут, Өндөр-Улаан, Эрдэнэмандал, Батцэнгэл, Эрдэнэбулган, Булган, Баянхонгор аймгийн Галуут сумтай хил залгадаг. Сумын төв Заанхошуу суурин, аймгийн төвөөс баруун тийш 30 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	5,696	5,540
Нутаг дэвсгэрийн хэмжээ	4800 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Заанхошуу суурин	
Засаг захиргааны хуваарь	Хөхнуур, Хан-Өндөр, Борт, Бугат, Тайхар, Эрдэнэтолгой гэсэн 6 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Хүннү, түрэгийн үеийн булш, бунхан, хүн чулуу, буган хөшөө, бичээс хадтай; • Хангайн нурууны салбар, Цохиот, Шалхаг, Хоромсог, Улиастай, Тогоо, Байц зэрэг өндөр уулстай; • Хөх нуурыг тахин шүтдэг; • Улаалзайн болон Хужиртын даваа, Сүмт уул, Бугатын нуруу; • Харлагтайн битүү, Хөх нуур, Улаан булуугийн нуур; • Хөрөөгийн үзүүрт нүүрс, Улайстайд болорын илэрц, балт чулуу, барилгын түүхий эдийн нөөцтэй; • Норбулан дуган, Хан-Өндөрийн хүрээ, Хужиртын дуган, Тамирын хүрээ. 	

Төрийн албан хаагчдын тоо		193
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,593	1,580
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	1,026	928
Төрөлтийн тоо	113	121
Нас баралтын тоо	34	43
Бүртгэгдсэн гэмт хэрэг	26	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1.260	1,261
малчин өрх,	1,120	1,080
малчдын тоо	1,859	1,844
Малын тоо	380.08 мян.тол	313.92 мян.тол
Том малын зүй бус хорогдол	5.01 мян.тол	37.95 мян.тол
Хуулийн этгээдийн тоо ААН	74 үүнээс: уул уурхайн чиглэлээр ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 3 компани байна.	84
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	31	38
Орон нутгийн төсвийн нийт орлого		675,789.6 мян.төг

6.АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙНУУР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Тойм лавлагаа		
Товч түүх	Өгийнуур сумыг 1952 онд Хотонт, Батцэнгэл, Өлзийт сумын хэд хэдэн багийг нийлүүлж байгуулжээ. Засаг захиргааны хуваарь, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр 1956 онд Архангай аймгийн Лүн сумыг татан буулгахад тус гурван багийг Өгийнуур суманд шилжүүлжээ.	
Газар зүйн байршил	Өгийнуур сум нь Архангай аймгийн Хашаат, Хотонт, Төвшрүүлэх, Батцэнгэл, Өлзийт, Булган аймгийн Могод, Гурванбулаг сумтай хил залгадаг. Сумын төв Зэгстэй суурин, аймгийн төвөөс зүүн тийш 100 км-т оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	3,129	3,052
Нутаг дэвсгэрийн хэмжээ	1,686 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Зэгстэй суурин	

Засаг захиргааны хуваарь	Тоглох, Дойт, Өгий, Орхон, Зэгстэй гэсэн 5 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Тамир, Орхон, Хөгшин Орхон, тэдгээрийн цутгал гол; • Өгийнуур, Дойтын цагаан, Шорвог, Зүүн цагаан нуур; • Мухар булаг, Хад модны тохой, Сарлагийн рашаан; • Лавран, Хорчингийн хийд. 	
Төрийн албан хаагчдын тоо		141
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	952	937
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	601	561
Төрөлтийн тоо	76	81
Нас баралтын тоо	15	15
Бүртгэгдсэн гэмт хэрэг	36	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	862	871
Малчин өрх,	0.71 мян.өрх	0.72 мян.өрх
Малчдын тоо	1,149 хүн	1,093 хүн
Малын тоо	347.39 мян.өрх	298.05 мян.өрх
Том малын зүй бус хорогдол	2.21 мян.өрх	50.13 мян.өрх
Хуулийн этгээдийн тоо, ААН	45	44
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	25	25
Орон нутгийн төсвийн нийт орлого		404,979.1 мян.төг

7. АРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өлзийт сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Батцэнгэл уулын хошуунаас байгуулагдсан. 1952 онд Өгийнуур сумыг байгуулахдаа Өлзийт, Хотонт, Батцэнгэл сумаас нутаг, баг шилжүүлэн авсан байна.	
Газар зүйн байршил	Өлзийт сум нь Архангай аймгийн Өгийнуур, Батцэнгэл, Хайрхан, Булган аймгийн Сайхан, Могод сумтай хил залгадаг. Сумын төв Хөшөөт суурин, аймгийн төвөөс зүүн хойш 140 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	3,403	3,310

Нутаг дэвсгэрийн хэмжээ	1,700 м² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Хөшөөт суурин	
Засаг захиргааны хуваарь	Ямаат, Бодонт, Байшир, Хөшөөт гэсэн 4 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> Их хужирт, Рашаант, Улаан чулуут, Их булаг, Ар булаг, Хөх хошуу зэрэг 20 шахам булаг шанд, рашаантай; Цайдмын их, бага нуур, Олгой, Их дэрст,Зодох, Дээд, доод цагаан нуур тойромтой; Өөлд бэйсийн хүрээ, Цогчин, Жүд, Чойр, Мамба дацан байсан; Алтан зуу хийдийн турь нь Гомбо сахиус, Жигжид бурхантай, зуу шүтээнтэй. 	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		164
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,119	1,100
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	480	395
Төрөлтийн тоо	49	62
Нас баралтын тоо	20	38
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	874	863
малчин өрх,	0.64 мян.өрх	0.67 мян.өрх
малчдын тоо	908	940
Малын тоо	396.77 мян.тол	354.97 мян.тол
Том малын зүй бус хорөгдол	7.06 мян.тол	55.44 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	53 үүнээс: уул уурхайн чиглэлээр ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 1 компани байна.	58
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	29	31
Орон нутгийн төсвийн нийт орлого		455,828.4 мян.төг



8.АРХАНГАЙ АЙМГИЙН ӨНДӨР-УЛААН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өндөр-Улаан сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Хан-Өндөр уулын хошуунаас байгуулагдсан. 1959 онд Хануй сумыг Өндөр-Улаан, Бугат сумаас тасалж байгуулаад 1961 онд Өндөр-Улаан суманд буцаан нэгтгэжээ.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Чулуут, Хангай, Тариат, Жаргалант, Эрдэнэмандал, Ихтамир сумтай хил залгана. Сумын төв Тээл суурин, аймгийн төвөөс баруун хойш 122 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	5,870	5,749
Нутаг дэвсгэрийн хэмжээ	4,000 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Тээл суурин	
Засаг захиргааны хуваарь	Азарга, Хануй, Донгой, Бэлхи, Тээл гэсэн 5 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Жаргалтайн амны Буган хөшөө түүх соёлын дурсгалтай; • Далтын овоо, Бэлхийн рашаан, Зуун салаа мод, Их Тамир сумын савлах Бугатын нуруу зэргийг орон нутгаас хамгаалтад авсан; • Чулуут, Хануй гол, Шар булаг, Донгой, Нист, Бугат, Элстийн зэрэг олон гол, горхитой; • Арбулаг, Булан, Бэлх, Төмөртэйн зэрэг эмчилгээний рашаантай; • Хуучин цагт Бор бургас, Дарь эх, Дүйнхор тэргүүн, Жанцан, Маань, Махгал, Олон туруу, Очирваань, Палан тэргүүн, Тээл, Шагжийн зэрэг хурал номын газартай байсан. 	
Төрийн албан хаагчдын тоо		231
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,649	1,648
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	916	974
Төрөлтийн тоо	126	106
Нас баралтын тоо	22	26
Бүртгэгдсэн гэмт хэрэг	33	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,449	1,447
Малчин өрх,	1.19 мян. өрх	1.18 мян. өрх
Малчдын тоо	2,009	2,001
Малын тоо	385.76 мян.тол	354.97 мян.тол

Том малын зүй бус хорогдол	8.1 мян.тол	51.42 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	70	70
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	35	37
Орон нутгийн төсвийн нийт орлого		649,735.7 мян.төг

9. АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Тариат сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Чандмань-Өлзийт далай хошуунаас байгуулагдсан. 1961 онд Мөрөн сумыг татан буулгаж, 1966 онд Цахир сумын нэг хэсгийг Тариатад нийлүүлсэн.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Жаргалант, Өндөр-Улаан, Хангай, Цахир, Завханы Их-Уул сумтай хил залгадаг.	
	2022	2023
Хүн амын тоо	5,064	4,912
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,800 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Хорго суурин	
Засаг захиргааны хуваарь	Тэрх, Цагааннуур, Хорго, Суман, Бөөрөлжүүт, Мөрөн, Алтаад гэсэн 7 багт хуваагдана.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Тариат, Чулуут голын ай сав, Өндөр-Улаан сумын нутгийг савлан орших Зүүн салаа модны орчныг орон нутгийн хамгаалалтад авсан; • Чулуут, Суман, Тэрх, Хөнжлийн гол, Тэрхийн цагаан, Хөдөө, Шивэрт, Хунт зэрэг нууртай; • Хоргын тогоо уул, Тэрхийн цагаан нуур нь төрийн тусгай хамгаалалттай; • Баянбулаг, Хадат, Равдангийн булаг, Ороох эмчилгээний рашаантай; • Өвөр мөст, Улаан эрэг, Их Жаргалант зэрэг булаг шандтай. 	
Төрийн албан хаагчдын тоо		212
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,577	1,599
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	846	831
Төрөлтийн тоо	98	106
Нас баралтын тоо	27	30
Бүртгэгдсэн гэмт хэрэг	32	

Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,271	1,252
малчин өрх,	94 мян.өрх	98 мян.өрх
малчдын тоо	1,651	1,670
Малын тоо	286.75 мян.тол	202.98 мян.тол
Том малын зүй бус хорогдол	2.25 мян.тол	18.49 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	80 үүнээс: уул уурхайн чиглэлээр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 3 газар байна.	87
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	43	49
Орон нутгийн төсвийн нийт орлого		639,143.8 мян.төг

10. АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Төвшрүүлэх сумыг 1938 онд Хотонт, Цэнхэр сумаас тасалж байгуулсан. 1941 онд мөн сумыг татан буулгаж, 1943 онд дахин байгуулжээ. 1954 онд дахин татан буулгаж, Баян-Улаан, Булган суманд нийлүүлсэн бөгөөд Төвшрүүлэхийн сангийн аж ахуйг байгуулахад уг сумыг байгуулж харьяалуулсан.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Өгийнуур, Хотонт, Цэнхэр, Батцэнгэл сумтай хил залгана. Сумын төв нь Таванбулаг суурин, аймгийн төвөөс зүүн урагш 44 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	2,907	2,800
Нутаг дэвсгэрийн хэмжээ	1,200 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Таванбулаг суурин	
Засаг захиргааны хуваарь	Хөх сүм, Баян-Өндөр, Урантолгой, Өртөнт гэсэн 4 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Мандахын хөндийг аймгийн, Бор бургастын рашаан, Эрдэнэ толгой, Богино, урт чулуутыг сумын тусгай хамгаалалттай нутаг болгосон; • Урд Тамирын цутгал гол горхи, Буйлан, Хүйтэн, Цац, Хүрэмт давст нуур тойромтой; • Бор бургас, Сөрт, Өртөнт, Гялаан түрүү, Асга түрүү, цагаан сүм, Хөх сүм, Ногоон сүмийн рашаантай; • Жанрайсэгийн дуганы туурь үлдсэн; • Гурван хэц уул шүтээн уулаас эх авсан Бор бургастын рашаан эмчилгээний удистай. 	

Төрийн албан хаагчдын тоо		157
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	870	836
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	338	374
Төрөлтийн тоо	61	73
Нас баралтын тоо	20	13
Бүртгэгдсэн гэмт хэрэг	19	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	636	633
малчин өрх,	0.51 мян.өрх	0.49 мян.өрх
малчдын тоо	787	752
Малын тоо	191.77 мян.тол	156.15 мян.тол
Том малын зүй бус хорогдол	43 мян.тол	33.47 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	49 үүнээс: уул уурхайн чиглэлээр ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 5 газар байна.	51
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	28	28
Орон нутгийн төсвийн нийт орлого		356,409 мян.төг

11.АРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Тойм лавлагаа		
Товч түүх	Хайрхан сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Батцэнгэл уулын хошуунаас байгуулагдсан. Засаг захиргааны хуваарь, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр 1956 онд Архангай аймгийн Хан-Оюут сумыг татан буулгахад гурван багийг нь Хайрхан суманд шилжүүлжээ.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Өлзийт, Батцэнгэл, Эрдэнэмандал, Цэцэрлэг, Булган аймгийн Баян-Агт, Сайхан сумтай хил залгана. Сумын төв нь Уубулан суурин, аймгийн төвөөс зүүн хойш 230 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	3,673	3,603
Нутаг дэвсгэрийн хэмжээ	2,500 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Уубулан суурин	
Засаг захиргааны хуваарь	Хайрхан, Асгат, Жарантай, Могой, Өгөөмөр гэсэн 5 багт хуваагддаг.	

Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар:	
	<ul style="list-style-type: none"> Хайрхан уулыг орон нутгийн тусгай хамгаалалтай газар нутаг болгосон; Агуйт, Тоглойн хар хунх, Дэлэнгийн жирээ, Чойдогийн цохио зээг өвөрмөгц сонин тогтоцтой хад асга, агуйтай; Хануй, Хүнүй гол, түүний цутгал Жарантай, Могой, асгат цэнгэг уст, Дуут, Гүн, Шинэ ус, Шарга, Мааньт, Цагаан ус зэрэг нуур тойромтой; Шанаган, Тахилт, Ланс, Өгөөмөр зэрэг хүхэрлэг рашаантай. 	
Төрийн албан хаагчдын тоо		171
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,134	1,119
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	702	841
Төрөлтийн тоо	70	88
Нас баралтын тоо	22	23
Бүртгэгдсэн гэмт хэрэг	15	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,056	1,059
малчин өрх,	0.86 мян.өрх	0.9 мян.өрх
малчдын тоо	1,376	1,320
Малын тоо	399.67 мян.тол	334.59 мян.тол
Том малын зүй бус хорогдол	2.53 мян.тол	50.72 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	55	54
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	34	35
Орон нутгийн төсвийн нийт орлого		442,703.9 мян.төг

12.АРХАНГАЙ АЙМГИЙН ХАНГАЙ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Хангай сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Чандмань-Өлзийт далай хошуунаас байгуулагдсан.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Цахир, Тариат, Чулуут, Баянхонгор аймгийн Жаргалант, Гурванбулаг сумтай хил залгадаг. Сумын төв нь Хунт суурин, аймгийн төвөөс баруун хойш 230 км зайд оршдог.	
	2022	2023
Хүн амын тоо	3,228	3,150

Нутаг дэвсгэрийн хэмжээ	4,400 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Хунт суурин	
Засаг захиргааны хуваарь	Чандмань, Гичгэнэ, Арбаясгалан, Баян-Улаан, Тэрх, Ноён хангай гэсэн 6 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Цэцэгт, Зоо, Овоот зэрэг 30 гаруй нуур, цөөрөмтэй; • Ёл, Ангархай, Ноён хангайн халуун хүйтэн рашаантай; • Мөнх цастай Дашдагва уул; • Хуучин цагт Бүлээн, Төмөртийн дуган, Гичгэнэ, Зоог, Мөрөнгийн хүрээ хийдтэй байсан; • Улаан номд орсон цоохор ирвэс, хүдэр, угалз, шивэр, хилэм загастай; • Алт, цагаан тугалга, төмрийн хүдэр, үнэт чулуу, барилга, химийн түүхий эдийн баялагтай. 	
Төрийн албан хаагчдын тоо		155
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	986	969
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	496	527
Төрөлтийн тоо	62	77
Нас баралтын тоо	23	23
Бүртгэгдсэн гэмт хэрэг	16	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	806	810
Малчин өрх,	0.6 мян.өрх	0.61 мян.өрх
Малчдын тоо	1,030	1,051
Малын тоо	120.37 мян.тол	98.33 мян.тол
Том малын зүй бус хорогдол	2.37 мян.тол	9.93 мян.тол
Хуулийн этгээдийн тоо ААН	38	37
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	18	18
Орон нутгийн төсвийн нийт орлого		355,380.3 мян.төг



13.АРХАНГАЙ АЙМГИЙН ХАШААТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Хашаат сум нь Богдхан уулын аймгийн Хангай хайрхан уулын хошуунаас байгуулагджээ. Засаг захиргааны хуваарь, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр 1956 онд Архангай аймгийн Лүн сум татан буугдахад гурван баг нь Хашаат суманд шилжин иржээ. 1959 онд Лүн сумыг дахин байгуулж, 1960 онд Хашаатад нийлүүлжээ.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Хотонт, Өгийнуур, Өвөрхангай аймгийн Бүрд, Хархорин, Булган аймгийн Гурванбулаг сумтай хил залгадаг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,150	3,047
Нутаг дэвсгэрийн хэмжээ	2,600 км² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Баян суурин	
Засаг захиргааны хуваарь	Жаргалант, Номгон, Цайдам, Цагаан хад, Баян гэсэн 5 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> Гашууны гол, Долоон гол, Хөөврийн гол зэрэг гол горхитой; Хуучин цагийн Долоон, Хорхой, Цоохор, Мирхайн хурал, Номгоны сүм хийд байсан; Хөшөөний Цайдам музей хосгүй үнэт зүйл. 	
Төрийн албан хаагчдын тоо		161
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	940	921
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	659	728
Төрөлтийн тоо	46	49
Нас баралтын тоо	17	21
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	827	804
малчин өрх,	0.73 мян.өрх	0.73 мян.өрх
малчдын тоо	1,189	1,174
Малын тоо	342.1 мян.тол	326.25 мян.тол
Том малын зүй бус хорогдол	4.19 мян.тол	18.28 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	39 үүнээс: уул уурхайн чиглэлээр хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 2 компани байна	37
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	25	25
Орон нутгийн төсвийн нийт орлого		611,168.9 мян.төг

14.АРХАНГАЙ АЙМГИЙН ХОТОНТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Хотонт сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Эрдэнэбулган уулын хошуунаас байгуулагдсан. 1938 онд Төвшрүүлэх сум, 1952 онд Өгийнуур сумыг Хотонт сумаас нутаг тасалж байгуулсан. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн өөрчлөлтөөр 1955 онд Төвшрүүлэх сумаас хоёр баг, 1956 онд Лүн сумаас нэг баг шилжиж ирсэн. 1961 онд Өндөрсант сумыг татан буулгаж, Хотон суманд нийлүүлсэн.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Цэнхэр, Төвшрүүлэх, Өгийнуур, Хашаат, Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий сумтай хил залгадаг. Сумын төв Хотонт суурин, аймгийн төвөөс зүүн урагш 91 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	4,349	4,250
Нутаг дэвсгэрийн хэмжээ	2,200 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Хотонт суурин	
Засаг захиргааны хуваарь	Хотонт, Хөөвөр, Бургалдай, Улаан чулуу, Орхон, Өндөр сант гэсэн 6 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<ul style="list-style-type: none"> • Орхон Түшээ, түүний цутгал Цагаан сүм, Хужирт, Улаанчулуу, Жарантай, Их булаг гол горхи, Хөөвөр, Хонхор, Чавганц гэдэг нуур тойромтой; • Цагаан сүм, Чулуун даваа, Байшингийн булаг, Мухар булаг, халуун хүйтэн рашаантай; • Хатант хайрхан уулан дахь Найман талт чулуун байгууламжтай; • Хотонтын хүрээ буюу Ганданпэлжээлин хийдтэй. 	
Төрийн албан хаагчдын тоо		220
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,320	1,318
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	797	865
Төрөлтийн тоо	69	80
Нас баралтын тоо	23	24
Бүртгэгдсэн гэмт хэрэг	15	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,177	1,177
малчин өрх,	0.97 мян.өрх	0.94 мян.өрх
малчдын тоо	1,567	1,465
Малын тоо	357.59 мян.тол	308.11 мян.тол
Том малын зүй бус хорогдол	3.63 мян.тол	70.47 мян.тол

Хуулийн этгээдийн тоо, ААН	59 үүнээс: уул уурхайн чиглэлээр хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 1 компани байна.	64
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	29	31
Орон нутгийн төсвийн нийт орлого		612,411 мян.төг

15.АРХАНГАЙ АЙМГИЙН ЦАХИР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Цахир сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Чандмань-Өлзийт далайн хошуунаас байгуулагдсан. 1966 онд татан буугдаж, Тариат, Хангай суманд хувааж нийлүүлээд 1991 онд дахин байгуулагдсан.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Тариат, Хангай, Баянхонгор аймгийн Гурванбулаг, Завхан аймгийн Отгон, Тосонцэнгэл, Их-уул сумтай хил залгадаг. Сумын төв Хан-Уул суурин, аймгийн төвөөс баруун хойш 230 км ² зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	2,485	2,435
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,398 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Хан-Уул суурин	
Засаг захиргааны хуваарь	Баянгол, Хан-уул, Цахир, Жинст гэсэн 4 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> Хуучин цагт Байцын Жанчивлан жалгын хурал, Талын манал хурал, Загастайн хийд хурал номын газрууд байсан бол 1992 онд Дамбаравжаалин хийдийг цогцлоожээ; Содномдаржаа ууланд өвгөн Гэсэр лам Цэвээнраашийн Чүлтэмжамц, баруун гарын шавь, цорж аграмба Р.Санжжав нарын гүдэнг залж, сүсэгтэн олон эргэл, мөргөл хийдэг. 	
Төрийн албан хаагчдын тоо		147
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	719	726
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	459	499
Төрөлтийн тоо	64	47
Нас баралтын тоо	16	8
Бүртгэгдсэн гэмт хэрэг	12	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		

	2022	2023
Малтай өрх,	645	643
малчин өрх,	0.53 мян.өрх	0.53.мян.өрх
малчдын тоо	859	848
Малын тоо	115.42 мян.тол	78.4мян.тол
Том малын зүй бус хорогдол	4.63 мян.тол	9.42 мян.тол
Хуулийн этгээдийн тоо,ААН	59	59
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	23	24
Орон нутгийн төсвийн нийт орлого		584.815.1 мян.төг

16.АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭНХЭР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Цэнхэр сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Эрдэнэбулган уулын хошуунаас байгуулагдсан. 1938 онд Төвшрүүлэх сумыг байгуулахдаа Цэнхэр сумаас тасалж байгуулсан. 1961 онд Урд Тамир сумыг татан буулгаж, Цэнхэр суманд нийлүүлжээ.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Булган, Эрдэнэбулган, Батцэнгэл, Төвшрүүлэх, Хотонт, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумтай хил залгана.	
	2022	2023
Хүн амын тоо	6,107	6,019
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,200 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Алтан-Овоо суурин	
Засаг захиргааны хуваарь	Орхон, Цэцэрлэг, Цэнхэр, Алтан-Овоо, Буйлан, Тамир гэсэн 6 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> Хангайн нурууны тусгай хамгаалалттай газар; Орхоны эх, Урд тамир, Цэнхэрийн гол, тэдгээрийн цутгалан, Буйлан, Дангийн зэрэг олон нуур, халуун хүйтэн рашаантай; Цэнхэрийн халуун усны рашаан 90 градусын халуунтай. Урд Тамирын гол, Хонгорын ам, Хар эрэг, Гозгор, Хойд, урд Тэлээ, Баянбулаг, Бага халзан нутгийн ихэнх хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг болгожээ; Төсрийн хүдэр, гянтболд, үнэ чулуу, барилгын түүхий эдийн баялагтай; Алтан-Овоо уулыг нутгийнхан шүтдэг. 	
Төрийн албан хаагчдын тоо		185

Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,786	1,793
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	1,054	1,151
Төрөлтийн тоо	160	82
Нас баралтын тоо	34	38
Бүртгэгдсэн гэмт хэрэг	40	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,530 мян.өрх	1,559 мян.өрх
Малчин өрх,	1.39 мян.өрх	1.42 мян.өрх
Малчдын тоо	2,343 хүн	2,336 хүн
Малын тоо	366.73 мян.тол	305.38 мян.тол
Том малын зүй бус хорогдол	3.91 мян.тол	72.06 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	117 үүнээс: уул уурхайн чиглэлээр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 11 ААН байна.	124
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	49	56
Орон нутгийн төсвийн нийт орлого		862,945.7 мян.төг

17.АРХАНГАЙ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Цэцэрлэг сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Рашаант уулын хошуунаас байгуулагдсан. 1959 онд Туулант сумыг Цэцэрлэг зэрэг сумаас тасалж байгуулан 1961 онд мөн сумдад буцааж нийлүүлжээ.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Хайрхан, Эрдэнэмандал, Жаргалант, Хөвсгөл аймгийн Галт, Төмөрбулаг, Рашаант, Булган аймгийн Баян-Агт сумтай хил залгана. Сумын төв Хужирт суурин, аймгийн төвөөс хойш 220 км зайд оршдог.	
	2022	2023
Хүн амын тоо	3,784	3,703
Нутаг дэвсгэрийн хэмжээ	2,500 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Хужирт суурин	
Засаг захиргааны хуваарь	Чулуут, Туулант, Хужирт, Хонгорж, Их булаг гэсэн 5 багт хуваагддаг.	

Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> Идэр, Чулуут, Хануй, Хужирт гол, Айраг, Дөрөө, Цайдам, Тойром зэрэг 10 орчим нуур, 50 гаруй булаг, шанд, рашаан ус, байгалийн үзэсгэлэнт газартай; Бух хайрхан; Сүм хийдийн бүртгэлд Агьтын хурал, Бухын хүрээ, Дөрвөн хийд тэмдэглэсэн. 	
Төрийн албан хаагчдын тоо		1,429
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,108	1,127
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	774	769
Төрөлтийн тоо	80	78
Нас баралтын тоо	23	16
Бүртгэгдсэн гэмт хэрэг	18	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	983	986
Малчин өрх	0.86 мян.өрх	0.87мян.өрх
Малчдын тоо	1,405	1,314
Малын тоо	396.21 мян.тол	358.55 мян тол
Том малын зүй бус хорогдол	1.43 мян.тол	13.6 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	63	63
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	30	30
Орон нутгийн төсвийн нийт орлого		446,517.1 мян.төг

18.АРХАНГАЙ АЙМГИЙН ЧУЛУУТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Чулуут сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Хан-Өндөр уулын хошуунаас байгуулагдсан.	
Газар зүйн байршил	Архангай аймгийн Хангай, Өндөр-Улаан, Ихтамир, Баянхонгор аймгийн Галуут, Жаргалант сумтай хил залгадаг. Сумын төв Жаргалант суурин, аймгийн төвөөс баруун хойш 127 км зайд оршино.	
	2022	2023
Хүн амын тоо	4,199	4,113
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,900 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Жаргалант суурин	
Засаг захиргааны хуваарь	Өлзийт гол, Зуунмод, Халуун-Ус, Хайрхан, Хүрэм гэсэн 5 багт хуваагддаг.	

Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалт газар:	
	<ul style="list-style-type: none"> • Чулуут, Хануй, түүний цутгал голууд, олон нуур, халуун хүйтэн рашаантай; • Төмрийн хүдэр, цагаа тугалга, алт, үнэт чулуу, барилгын түүхий эдийн баялагтай; • Бүрдийн хийд, Хангал, Намсрай тэргүүтний дуган, Цогт хайрхан, Хажид, Зуун модон, Төмөрт, Улаан овооны хурал байснаас Шива ширээт гэгээн Лувсаннамхайдоржийн үүсгэсэн Ширээтийн хүрээ их алдар цуутай; • Чулуутын гол нь өвөрмөгц онцлогтой. 	
Төрийн албан хаагчдын тоо		185
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,181	1,206
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	589	445
Төрөлтийн тоо	80	97
Нас баралтын тоо	24	25
Бүртгэгдсэн гэмт хэрэг	19	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	990	997
малчин өрх,	760	820
малчдын тоо	1,336	1,366
Малын тоо	210.78 мян.тол	178.5 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	75	80
	Үүнээс: уул уурхайн чиглэлээр Баянхайрхан дахь ашиглалтын 1 тусгай зөвшөөрлийн хугацаа 2018-2048 он хүртэл хүчин төгөлдөр байна.	
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	40	42
Орон нутгийн төсвийн нийт орлого		494,527.4 мян.төг

19.АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа	
Товч түүх	Эрдэнэмандал сум нь Цэцэрлэг мандал уулын аймгийн Эрдэнэбулган уулын хошуунаас байгуулагдсан. 1956 онд Хан-Оюут сумыг татан буулгаж, дөрвөн багийг Эрдэнэмандалд нэгтгэсэн бөгөөд 1959 онд дахин байгуулж, 1960 онд Эрдэнэмандал суман дахин нийлүүлсэн.
Газар зүйн байршил	Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл, Ихтамир, Өндөр-Улаан, Жаргалант, Цэцэрлэг сумтай залгана.

	2022	2023
Хүн амын тоо	5,611	5,456
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,400 км ² нутаг дэвсгэртэй.	
Сумын төвийн нэр	Өлзийт суурин	
Засаг захиргааны хуваарь	Алаг-Уул, Идэр-Улаан, Эрдэнэ-Уул, Хан-Өндөр, Тээл, Өлзийт гэсэн 6 багт хуваагддаг.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн түүх, дурсгалын газар: <ul style="list-style-type: none"> • Хануй, Хүнүй гол, Улаанчулуут, Тээл, Цагаанчулуут гол; • Их нуур, Хан-Өндөр, Асгат түрүү рашаан устай; • Улаан номд орсон хилэм загас Хануй голд байдаг; • Төмөр, гянтболд, зэсийн хүдэр, үнэт чулуу, барилгын түүхий эдийн баялагтай; • Сүм хийдийн бүртгэлд Гүнрэгийн хурал, Дэмчиг дацан, Дашчойнхорлин хийд бүртгэгдсэн; • Хан-Өндөр хайрхан уул шүтээн, рашаан нь эмийн шидтэй. 	
Төрийн албан хаагчдын тоо		326
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Өрхийн тоо	1,640	1,623
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	885	930
Төрөлтийн тоо	122	121
Нас баралтын тоо	32	27
Бүртгэгдсэн гэмт хэрэг	25	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
	2022	2023
Малтай өрх,	1,427	1,409
Малчин өрх,	1,220	1,220
Малчдын тоо	1,969	1,934
Малын тоо	509.72 мян.тол	376.13 мян.тол
Том малын зүй бус хорогдол	9.87 мян.тол	50.56 мян.тол
Хуулийн этгээдийн тоо, ААН	66	72
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ААН	27	33
Орон нутгийн төсвийн нийт орлого		627,737.5 мян.төг

II БҮЛЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НЭГ.ТОЙМ ЛАВЛАГАА

1.Товч түүх:

Баянхонгор аймаг нь Улсын Бага Хурлын 1941 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор 16 сум, 112 баг, 11,8 мянган өрх, 41,8 мянган хүн амтай байгуулагдсан. Анх Говьбөмбөгөр гэж нэрлэгдэж байгаад дараахан нь Баянхонгор болж өөрчлөгдсөн. 1945 оны 10 дугаар сарын 20-нд явагдсан бүх нийтийн тусгаар тогтнолын санал асуулгад гарын үсэг зурах хөдөлгөөнд тус аймаг 24,114 хүний гарын үсэг цуглуулж өгсөн бөгөөд түүний дурсгалд зориулсан “Тусгаар тогтнолын багана”-ыг сүндэрлүүлжээ. 1961 онд аймгийн төв Баянхонгор хот одоогийн байршилдаа суурьшсан байдаг.

2.Газар зүйн байршил:

Баянхонгор аймаг нь Монголын Улсын баруун өмнөд хэсэгт Хангайн нурууны өмнөх өндөрлөг, Говь-Алтайн нурууны уулс, Алтайн өврийн говийг хамран говь, хангайн бүсийг дамнан оршдог. Баруун талаараа Говь-Алтай, баруун хойд талаараа Завхан, хойд талаараа Архангай, зүүн хойд талаараа Өвөрхангай, зүүн өмнөд талаараа Өмнөговь, урд талаараа БНХАУ-тай хиллэдэг.

3.Хүн амын тоо:

2022	2023
89.643	88.499

4.Нутаг дэвсгэрийн хэмжээ: Баянхонгор аймаг нь **116.0** мян.км³ нутаг дэвсгэртэй бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрийн 7.8 хувийг эзэлдэг томоохон аймгийн нэг.

5.Аймгийн төвийн нэр: Баянхонгор хот

6.Засаг захиргааны хуваарь: **20** сум, **105** багтай.

7.Угсаатны зүйн байдал: Халх **99%**, бусад **1%**

8.ёс заншил, өв уламжлал:

Баянхонгор аймаг нь төв халхын соёлын биет бус өвийг өвлөн үлдсэн голомт бүс нутаг. Тус аймагт 5 ай савд багтах 64 төрөл зүйлийн биет бус

өв өвлөгдсөн бөгөөд 316 өвлөн уламжлагчийг бүртгэн баримтжуулж, улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд орсон. Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билиг авьяастны улсын нэгдсэн жагсаалтад 3 өвлөн уламжлагч бүртгэгдсэн байдаг. Биет бус онцлог өвүүд:

- Гүр дуу;
- Дуутай хуруу;
- Төв халхын тууль;
- Төв халхын морин хуурын татлага “Халх жонон”;
- Чулуун царгил хөгжмийг урлах, тоглох арга технологи;
- Цагаан идээ боловсруулах арга технологи “Бууцагаан сумын ямааны ааруул”;
- Ардын хөгжмийн зэмсэг урлал “Жимбүүр, хулсан хуур, сүүлийн үед мазаалай хуур”.

9.Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар:

Томоохон уулс: Их богд, Эрхэт хайрхан, Аргалант, Залаа хайрхан

Томоохон гол: Байдраг, Түйн, Заг

Томоохон нуур: Бөөнцагаан, Орог, Хөх нуур, Биндэрьяа

Баянхонгор аймгийн есөн гайхамшиг:⁵⁰

1. Цагаан агуй
2. Бичигт хад
3. Шаргалжуут рашаан
4. Бүгийн цав
5. Шатар чулуу
6. Хүрэн бэлчир
7. Мазаалай
8. Орог нуур орчмын говийн байгалийн үзэсгэлэнт газар
9. Ян-иг /шашны уншлагын нотлох баримт/

10.Дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн голлох салбар:

2021	2022
350.0 тб.төг	<p style="text-align: center;">541.3 тб.төг үүнээс:</p> <p>мал аж ахуйн салбар 48,1 хувь, газар тариалан 0.5 хувь, худалдаа, үйлчилгээний салбар 37,6 хувь, аж үйлдвэрийн салбар 13,7 (Үүн дотроос уул уурхай 0.54 хувь) хувийг тус тус эзэлж байна.</p>

⁵⁰ <https://www2.1212.mn/>

11.Төрийн албан хаагчдын тоо:

2022	2023
5,490	5,544

ХОЁР. ХҮН АМ ЗҮЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**1.Суурин хүн амын тоо:**

2022	2023
89,643	88,499

2.Суурин хүн амын хүйсийн харьцаа:

2022	2023
97.2	97.5

3.Хүн амын дундаж наслалт:

2022	2023
71.63	72.05

4.Өрхийн тоо:

2022	2023
26,737	27,101

5.Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо (2020):

25.169 өрхийн **99.1** хувь буюу **25,169** өрх цахилгааны ямар нэгэн эх үүсвэрт холбогдож, **222** өрх буюу **0.9** хувь нь холбогдоогүй байна.

6.Төрөлтийн тоо:

2022	2023
1,844	1,835

7.Нас баралтын тоо:

2022	2023
508	539

8.Шилжин ирсэн хүн амын тоо:

2022	2023
Явсан 2,475	Явсан 2,027
Ирсэн 410	Ирсэн 500

9.Гэрлэлт, цуцлалтын тоо:

2022	2023
Гэрлэлт 341	Гэрлэлт 354
Цуцлалт 68	Цуцлалт 54

ГУРАВ. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.ЕБС-ийн бүлэг дүүргэлт:

2022	2023
27.1	27.6

2.ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа:

2022	2023
18.9	19.1

3.Нийт өнчин хүүхдийн тоо:

2022	2023
1,127	971

4.Өрх толгойлсон эх:

2021	2022
3,737	3,519

5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:

2022	2023
3,988	3,869.0

6.Хөдөлмөр эрхэлдэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:

2022	2023
522	708

7.Бүртгэгдсэн гэмт хэрэг

2022	2023
439	395

8.Ядуурал (Хангайн бүс)

2020	2022
31.4	33.5

9.Ажилгүйдлийн түвшин:

2021	2022
15.5	12.7

10.Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын сарын бодит дундаж цалин:

2022	2023
бүгд 663.3 мянга	бүгд 793.6 мянга
эрэгтэй 619.8 мянга	эрэгтэй 766.9 мянга
эмэгтэй 693.3 мянга	эмэгтэй 811.3 мянга

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**1.Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс:**

2022	2023
107.7	101.3

2.Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн цэвэр өөрчлөлт:

2022	2023
14.6	7.7

3.Хүн амын сарын дундаж хэрэглээ (Хангайн бүс):

2020	2022
276,526 төг	417,421 төг

4.Иргэдийн хадгаламжийн данс:

2022	2024 II
64.2 мянга	64.7 мянга

5.Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл:

2022	2023
134,543.80 сая.төг	154,976.90 сая.төг

6.Малтай өрх:

2022	2023
15.3 мянга	15.2 мянга

7.Малчин өрх:

2022	2023
13.1 мянга	13.0 мянга

8.Малчдын тоо:

2022	2023
22.6 мянга	22.0 мянга

9.Малын тоо:

2022	2023
3,719.6 мян.тол Үүнээс:	4,072.2 мян.тол
Адуу 160.37 мян.тол	Адуу 177.3 мян.тол
Үхэр 222.96 мян.тол	Үхэр 238.2 мян.тол
Тэмээ 45.53 мян.тол	Тэмээ 48.95 мян.тол
Хонь 1,108.03 мян.тол	Хонь 1,218.43 мян.тол
Ямаа 2,182.7 мян.тол	Ямаа 2,389.33 мян.тол

10.Том малын зүй бус хорогдол:

2022	2023
42.74 мян.тол (2023)	2023-2024 оны зуднаар аймгийн хэмжээнд 254,229 толгой мал хорогдсон байна, Үүнээс Тэмээ 262 , Адуу 10,259 , Үхэр 32,111 , Хонь 73,522 , ямаа 129,075 (2024.5 сар)

11.Аймгийн удирдлагын тогтвор суурьшил:

аймгийн ИТХ-ын дарга:

2020 - Э.Энхбат

аймгийн Засаг дарга:

2020 - Д.Мөнхсайхан

12.Хүлээн авсан жуулчдын тоо 2023-2024:

гадаадын **368**, дотоод **45,832**, нийт **46,200**

13.Аймгийн бүтээн байгуулалт 2020-2024:

2016-2024 оны хугацаанд Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт **264** төсөл арга хэмжээнд **429.8** тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэсэн. Үүнээс 2020-2024 онуудад шинээр **49** төсөл, арга хэмжээнд **267.6** тэрбум төгрөг, түүнчлэн их засварын **101** төсөл, арга хэмжээнд **24.2** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус хийж бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэсэн байна. Онцлох зарим ажлуудаас дурдвал:

- Нийт **9,300** хүүхдийн суудалтай **23** сургуулийг **101,230.9** сая.төг төсөвт өртгөөр;
- Нийт **1,835** хүүхдийн ортой **16** цэцэрлэгийн барилгыг **25,186** сая. төг төсөвт өртгөөр;
- Нийт **950** хүүхдийн ортой **8** дотуур байрны барилгыг **17,770** сая. төг төсөвт өртгөөр;
- Нийт **3,570** хүний суудалтай **15** соёлын төвийн барилгыг **23,747.1** сая.төг төсөвт өртгөөр;
- Нийт **13** спорт заалыг **20,342** сая.төг төсөвт өртгөөр
- Нийт **144** ортой **16** эрүүл мэндийн төвийн барилгыг **31,570.9** сая. төг төсөвт өртгөөр;
- Нийт **12** төрлийн инженерийн шугам сүлжээ болон дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажлуудыг **61,309.5** сая.төг төсөвт өртгөөр;
- Шинээр **5** сумын нутгийн удирдлагын ордны барилгыг **5,771** сая/төг төсөвт өртгөөр тус тус гүйцэтгэсэн.

Мөн орон нутгийн чанартай **80** орчим км хатуу хучилттай авто замын ажил хийсэн.

14.Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт:

2021	2022
58,336.3 сая.төг	78,289.7 сая.төг

15.Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй ААН:

2022	2023
18 (Баян-Овоо суманд “Наран мандал Интерпрайзес” ХХК, Стархолдинг ХХК, Монголболгаргео ХХК, Бөмбөгөр суманд Ай Эн Ди ХХК, Эрдэнэцагаан ХХК, Волтерминериялресурс ХХК, Галуут суманд Баялаг орд ХХК, “Шижир аранжин” ХХК, “Империал гоулд майнинг” ХХК, Монголболгаргео ХХК, Гурванбулаг суманд “Жи Энд Юу Гоулд” ХХК, Шинэжинст суманд Эрдэнэсмонгол ХХК, “Сэкери ресурс монголиа” ХХК)	14 (Өлзийт суманд “Би Эс Ай” ХХК, Баян-Овоо суманд “Наран мандал Интерпрайзес” ХХК, Бөмбөгөр суманд “Ай Эн Ди” ХХК, Галуут суманд “Империал гоулд майнинг” ХХК, “Шижир аранжин” ХХК, “Баялаг орд” ХХК, Шинэжинст суманд “Эрдэнэс монгол” ХХК, “Сэкери ресурс монголиа” ХХК зэрэг ААН-үүд үйл ажиллагаагаа эхлүүлэх бэлтгэл хийж байна.)

16.Хувиараа хөдөлмөр эрхлэгчид (2021):

нийт **874** үүнээс: эрэгтэй **456**, эмэгтэй **418**

17.Орон нутгийн төсвийн орлого, зарлага

	2022	2023
Орон нутгийн төсвийн нийт орлого	53,264.0 сая.төг	69,538.7 сая.төг
Орон нутгийн төсвийн нийт зарлага	51,058.2 сая.төг	69,916.6 сая.төг

ТАВ.СУМДЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНХОНГОР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 115 дугаар тогтоолоор анх 3 хоринтой нэгж захиргааг байгуулснаар Баянхонгор хот бие даасан нэгж болох үндэс тавигджээ. Гэвч Баянхонгор хайрханы өвөр газар нь мөнхийн цэвдэгтэй, цаашид аймгийн төв байршуулахад тохиромжгүй байсан тул 1961 онд Баянхонгор аймгийн төвийг нүүлгэн Номгон уулын ар, Түйн голын хөвөөнд байгуулсан түүхтэй.	
Газар зүйн байршил	Номгон уулын ар, Түйн голын хөвөөнд 1,859 м өндөрт оршино.	
	2022	2023
Хүн амын тоо ⁵¹	32,560	32,750
Нутаг дэвсгэрийн хэмжээ	71.0 км ² талбайтай	
Сумын төвийн нэр	Баянхонгор хот	
Засаг захиргааны хуваарь	Номгон, Эрдэнэмандал, Дуурсах, Угалз, Цагаанчулуут, Гэгээн шавь, Цахир, Шаргалжуут, Есөнбулаг, Рашаант гэсэн 10 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Шаргалжуут рашаан сувилал нь Хангайн нурууны өвөр хэсэгт Шаргалжуутын хөндийд байрладаг. 300 гаруй булагтай, 10 га талбайг хамран урсдаг Монголын хамгийн том рашаан орд. Шаргалжуутын рашааныг анх 7-р зуунд Хиргисүүд өвчин эмгэгээ анагаан илаарьшуулахад хэрэглэж байсан талаар түүхэнд тэмдэглэгдсэн байдаг. Үүнээс хойш 17-р зуунд Ламын Гэгээн зэрэг Монголын ихэс дээдэс Энэтхэгээс эрдмийн хүн урьж авчран 3 даян хийж судлан эмчилгээний боть гаргаж анх системтэйгээр эмчилгээ үйлчилгээнд ашиглаж ирсэн. 1954 онд Нэгдэл дундын амралт нэртэйгээр сувилал үүсгэн байгуулагдаж өнөөг хүртэл тасралтгүй үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна. ⁵²	


⁵¹ <https://www2.1212.mn>

⁵² <https://bayanhongor.bkh.gov.mn>

Төрийн албан хаагчдын тоо ⁵³		2,885
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	9,746	10,089 ⁵⁴
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо ⁵⁵ 2023 он	11,410	
Төрөлтийн тоо ⁵⁶	677	684
Нас баралтын тоо ⁵⁷	193	210
Гэрлэлтийн тоо	108	159
Гэр бүл цуцлалтын тоо ⁵⁸	43	39
Бүртгэгдсэн гэмт хэрэг ⁵⁹	263	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх ⁶⁰	13.11 мянга	12.95 мянга
Малын тоо		153,948
Хуулийн этгээд, ААН-ын тоо ⁶¹	2,571	

2. БАЯНХОНГОР АЙМГИЙН БААЦАГААН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1924 оны өөрчлөн байгуулалтаар Цэцэрлэг мандал уулын аймгийн Гучин уулын хошууны дотор хоёр сум байсны нэг буюу Цагаан гол сум нь хожим энэ Баянхонгор аймгийн Баацагаан сум болсон түүхтэй. ⁶²	
Газар зүйн байршил	Баянхонгор хотоос 127 км зайд байрладаг. Улаан-Аргалант, Хар-Аргалант, Нарийн хар, Билгэх, Хөвших, Холбоо зэрэг уулсаар хүрээлэгдэн оршдог.	
	2022	2023
Хүн амын тоо	3,222	3,120
Нутаг дэвсгэрийн хэмжээ	74.47 км ²	
Сумын төвийн нэр	Баянсайр	
Засаг захиргааны хуваарь	Баянбулаг, Оройнбуу, Буйлсан, Могой, Товгор, Зүүнхаяа, Баянсайр гэсэн 7 багтай.	



⁵³ <https://d.parliament.mn/>

⁵⁴ Монгол Улсын нийгэм, эдийн засгийн танилцуулга 2019-2023 Үндэсний статистикийн хороо 2024 он

⁵⁵ <https://www2.1212.mn>

⁵⁶ <https://www2.1212.mn>

⁵⁷ <https://www2.1212.mn>

⁵⁸ <https://www2.1212.mn>

⁵⁹ <https://nso.mn>

⁶⁰ <https://www2.1212.mn>

⁶¹ <https://www2.1212.mn>

⁶² <https://baatsagaan.bkh.gov.mn>

<p>Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар</p>	<p>Хянганы дурсгал нь хадны сийлбэр бичээсний цогцолбор бөгөөд одоогоор ихэнхдээ буга, нум сум, ан гөрөө хийж буй хүний дүрслэлтэй. Уг дурсгалт газар нийт 45 орчим бичээс бий.</p> <p>Тоглохын чулуун дурсгал нь түүх соёлын үл хөдлөх өв бөгөөд аймгийн хамгаалалтад байдаг эртний бичээстэй чулуу билээ.</p> <p>Бөөнцагаан нуур нь Баянхонгор аймаг дахь Нууруудын хөндийн хамгийн том, давст нуур юм. Энэ нуурыг алсаас харахад цагаан өнгөтэй харагддаг учраас Бөөн цагаан нуур хэмээн нэрлэсэн түүхтэй. Бөөн цагаан нуурт 96 зүйлийн шувууд хуран цугладаг, дэлхийд гайхагдсан ховорхон нуур юм. Монгол улсад оршдог нийт нууруудын хамгийн том талбайтай нууруудын эхний аравт ордог.</p> <p>Бөөнцагаан нуурын домог Эрт галавын үед хорон санаат баян ноёны санаархаж байсан үзэсгэлэнт бүсгүй нутгийн ядуу бор залуу хоёр хайр сэтгэлтэй болжээ. Тэр хоёрыг элдвээр оролдоод ч салгаж чадсангүй. Тиймээс хоёулыг нь хороож, хангайн уулын өвөрт нутаглуулжээ. Гэтэл тэнд нь хоёр сайхан мод ургаж, орой оройгоор нийлж мөчир нь хоорондоо сүлжин найрсан ургасан байна. Өширсөн баян тэр даруй модыг тас хөрөөдүүлж, шатаагаад үнсийг нь хоорондоо гурван өртөө хол зайтай хоёр ууланд аваачиж булжээ. Түдэлгүй тэр хоёр цэгээс нэг нэг булаг дэлбэрэн оргилж замын булаг шандтай нийлэн томорсоор гурван өртөөний цаана хоёул хоорондоо уулзан нийлж нэг том гол болон урсаж Алтайн нурууны ар хоолойд тогтон, Бөөнцагаан нуурыг үүсгэсэн гэдэг.</p>	
<p>Төрийн албан хаагчдын тоо</p>		<p>141</p>
<p>Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд</p>		
<p>Өрхийн тоо</p>	<p>1030</p>	<p>1038</p>
<p>Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо</p>	<p>714</p>	
<p>Төрөлтийн тоо</p>	<p>57</p>	<p>63</p>
<p>Нас баралтын тоо</p>	<p>16</p>	<p>22</p>
<p>Шилжин ирсэн хүн амын тоо</p>		
<p>Гэрлэлт,</p>	<p>11</p>	<p>2</p>
<p>цуцлалтын тоо</p>	<p>4</p>	<p>2</p>
<p>Бүртгэгдсэн гэмт хэрэг</p>	<p>11</p>	
<p>Эдийн засгийн үзүүлэлтүүд</p>		
<p>Малчин өрх,</p>	<p>0.8 мян.өрх</p>	<p>0.81 мян.өрх</p>
<p>Малын тоо</p>	<p>328,599</p>	
<p>Хуулийн этгээд, ААН-ын тоо</p>	<p>66</p>	

3.БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНБУЛАГ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1924 оны анхны хуваариар Цэцэрлэг мандал уулын аймгийн Хүрээмарал уулын хошууны бүрэлдэхүүнд багтаж байсан 18 сумдаас Тэгшбуянт, Эрдэнэмандал хоёр сумыг нэгтгэн Баянбулаг уулын хормойд орших Хөдөө нуурын дэнж дээр сум болон төвлөрснөөр Баянбулаг сум үүссэн түүхтэй.	
Газар зүйн байршил	Хойд талаараа Завхан аймгийн Отгон сум, баруун талаараа Говь-Алтай аймгийн Дэлгэр сум, зүүн, зүүн хойд, урд талаараа Баянхонгор аймгийн Гурванбулаг, Заг, Хүрээмарал сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	1,775	1,748
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3170 км ²	
Сумын төвийн нэр	Баянбулаг	
Засаг захиргааны хуваарь	Сангийн далай, Ар жаргалант, Хангал, Бүрд гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<p>Дааган чулуу нэртэй сондгой ганц цул боржин хад Баянбулаг сумын төвөөс зүүн хойш 10 км-т Даагын өндөр улаан хэмээх уулын өвөр бэлээс ундарсан Даагын булгийн зүүн этгээдэд буй. Нутгийн хөгшдийн хуучилснаар “Дааган чулуу” хэмээх нэр нь дээр цагт уяачид наадамд уралдуулах даага, шүдлэнгээ бага гэрийн дайтай энэхүү хадыг тойруулан уяж сойдог байсантай холбоотой гэх ба нэгэн жишээ нь мөн Сэрвэн уулнаас гарч ирсэн аварга могойг дарсан чулуу хэмээх домог ч байдаг.</p> <p>Дааган чулуун дээр дүрсэлсэн зүйлс нь эртний нүүдэлчдийн од эрхсийг шүтэх шүтлэг, цаг улирлын солигдол, одон гарагийн орчил хөдөлгөөнтэй холбоо бүхий одтой тэнгэрийн зураг байхыг үгүйсгэх аргагүй юм.⁶³</p> <p><u>Дөшингийн даваа</u> нь урьд цагт Бээжингээс Улиастайг холбосон гол зам байжээ. Тиймээс энэ давааг манж хятадууд их тахиж тайж байсан ба Бээжингээс Улиастай хүрэх замын хамгийн өндөр даваа байсан учир Манжийн хаанаас Баа хэмээх цол хайрлаж том ширмэн Хонхоор шагнаснаас хойш Дөшинбаагийн даваа нэртэй болжээ.</p>	
Төрийн албан хаагчдын тоо		139
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	473	483
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	270	
Төрөлтийн тоо	38	37
Нас баралтын тоо	10	10
Гэрлэлт,	8	14
цуцлалтын тоо	1	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	3	

⁶³ <https://bayanbulag.bkh.gov.mn>

Эдийн засгийн үзүүлэлтүүд		
малчин өрх,	0.28 мянга	0.3 мянга
Малын тоо		109,513
Хуулийн этгээд, ААН-ын тоо	31	

4.БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНГОВЬ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1942 06 сарын 25 өдрийн 35-р тогтоолоор Баян-Өндөр, Жинст сумаас тус бүр 3 баг, Богд сумаас 1 баг шилжүүлэн авч анх 6 баг, 400 өрхтэй, 70000 малтай, конторын 2 гэртэй "Баянхөөвөр" нэртэйгээр байгуулагдсан түүхтэй. ⁶⁴	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн өмнөд хэсэгт оршдог, бүхэлдээ говийн бүст багтана. Өөрийн аймгийн Богд, Баянлиг, Жинст, Шинэжинст, Баянцагаан Өмнөговь аймгийн Гурван тэс сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,075	3,046
Нутаг дэвсгэрийн хэмжээ	4,662 км ²	
Сумын төвийн нэр	Өргөн	
Засаг захиргааны хуваарь	Хэлтгий булаг, Өрхт, Залаа, Цоохор, Өргөн гэсэн 5 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Сумын төвөөс зүүн зүгт 90 км зайд 750,000 жилийн тэртээ хүн амьдарч байсан Цагаан агуй хэмээх агуй бий. Мөн сумын төвөөс өмнө зүгт 18 км зайд орших Цагаан Булагт хэмээх өвөрмөц тогтоцтой хүний хөл, гарын мөртэй цагаан хад бий.	
Төрийн албан хаагчдын тоо		134
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	915	907
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	650	
Төрөлтийн тоо	81	73
Нас баралтын тоо	13	14
Гэрлэлт,	18	11
цуцлалтын тоо	3	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	7	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.68 мянга	0.67 мянга
Малын тоо		205,301
Хуулийн этгээд, ААН-ын тоо	35	

⁶⁴ <https://bayangovi.bkh.gov.mn>

5.БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЛИГ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Баянлиг сум нь 1925 оны 05 дугаар сард БНМАУ-ын Засгийн газрын 19 тоот тогтоолоор байгуулагдсан. Тус сумын нутаг дэвсгэр нь хуучнаар Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандида хутагтын /Ламын гэгээн/ шавийн хошуунд харьяалагдаж байсан. ⁶⁵	
Газар зүйн байршил	Зүүн талаараа Өвөрхангай аймгийн Богд, өмнөд хэсгээрээ Өмнөговь аймгийн Гурвантэс, Сэврэй, Баруун хойд талаараа Баянхонгор аймгийн Баянговь, Богд сумуудтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,814	3,757
Нутаг дэвсгэрийн хэмжээ	11,918 км ²	
Сумын төвийн нэр	Хатансуудал	
Засаг захиргааны хуваарь	Их халбаганат,Баян-Аараг, Багабаян, Ихбаян, Хатансуудал гэсэн 5 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<p><u>Бичигт хад</u> одоогоос хэдэн мянган жилийн тэртээд холбогдох эртний хүмүүсийн хаданд бичиж үлдээсэн бичиг соёлын нандин өв болох сүг зургууд бүхий байгалийн уран зураг. Энэ нь зөвхөн монгол төдийгүй Өмнөд Сибирь, Казакстан, Киргиз, Узбекистан, баруун хойд хятадын хадны зургийн дотор эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой томоохон дурсгал. Зургийг МЭӨ 3000 жилийн өмнөх үеийн бүтээл гэж үзжээ. <u>Зоог зуух</u> хэмээх суурины ул мөр. Энд Орос, Монголын археологичдын хийсэн судалгааны үр дүнгээр археологийн дурсгал бүхий дөрвөн суурин газар олдсоны нэг нь хуучин чулуун зэвсгийн дээд үе, хоёр нь шинэ чулуун зэвсгийн үе, нэг нь хүрэл зэвсгийн түрүү үеийн дурсгалтайг нотолсон байдаг. Эдгээр зуух нь зэсийн хүдрээ хайлуулдаг байсныг олдворууд нь баталгаажуулдаг.</p> <p><u>Хатан суудал</u> унтарсан галт уул. Оройдоо триагуляцын цэгтэй. Хүрэл зэвсгийн үеийн цөөн тооны булштай.</p> <p><u>Цагаан агуй</u> Монгол-Орос-Америкийн хамтарсан шинжилгээний анги тус агуйгаас хуучин чулуун зэвсгийн үеийн 14 соёлт үе давхаргыг олж тогтоосон билээ. Уг судалгааны үр дүнд Төв Азийн бүс нутагт хүн амьдарч байсан он цагийн тооллыг даруй 200 мянган жилээр урагш ахиулж, энэ судалгаа нь дэлхийн чулуун зэвсгийн сонгодог онолоор Монгол нутагт хүн Олдувайн үед буюу МЭӨ 700 мянган жилийн тэртээгээс суурьшин амьдарч байжээ гэдгийг нотолжээ. Баянлиг сумын Цагаан агуй нь зөвхөн манай оронд төдийгүй тив дэлхийн хэмжээнд яригдах байгаль, түүхийн ховор хосгүй дурсгалт газар.⁶⁶</p>	
Төрийн албан хаагчдын тоо		181

⁶⁵ <https://bayanlig.bkh.gov.mn>

⁶⁶ <https://bayanlig.bkh.gov.mn/77/all>

Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,083	1,076
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	733	
Төрөлтийн тоо	82	64
Нас баралтын тоо	21	19
Гэрлэлт,	25	12
цуцлалтын тоо	2	2
Бүртгэгдсэн гэмт хэрэг	3	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
малчин өрх,	0.79 мянга	0.77 мянга
Малын тоо		206,938
Хуулийн этгээд, ААН-ын тоо	53	

6.БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн дунд хэсэгт Галуут, Эрдэнэцогт, Өлзийт, Жинст, Баацагаан, Бөмбөгөр сумдтай хил залгадаг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,576	2,495
Нутаг дэвсгэрийн хэмжээ	32,443 км ²	
Сумын төвийн нэр	Хөхбүрд	
Засаг захиргааны хуваарь	Мандалхайрхан, Уранхайрхан, Асгамба, Мэргэн гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Уртын голын хөндий Нүхэн хад хэмээх газраас монгол дахь зоосон зургийн хамгийн олон тэмдэгт бүхий дурсгалт газар бий. ⁶⁷	
Төрийн албан хаагчдын тоо		155
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	863	868
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	607	
Төрөлтийн тоо	67	49
Нас баралтын тоо	21	21
Шилжин ирсэн хүн амын тоо		
Гэрлэлт,	15	20
цуцлалтын тоо	0	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	25	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
малчдын тоо	0.6 мянга	0.61 мянга
Хуулийн этгээд, ААН-ын тоо	69	

⁶⁷ <https://www.mongolianguideschool.com>

7.БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1923 онд Хантайшир уулын (Говь-Алтай) аймгийн Тэгшмандал сум нэртэй байгуулагдаж, 1941 онд Баянхонгор (Бөмбөгөр) аймагт харьяалагдан орсон түүхтэй.	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн баруун урд байрладаг. БНХАУ, өөрийн аймгийн Баянцагаан, Шинэжинст болон Говь Алтай аймгийн Эрдэнэ сумтай тус тус хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,597	2,532
Нутаг дэвсгэрийн хэмжээ	16,891 км ²	
Сумын төвийн нэр	Булган	
Засаг захиргааны хуваарь	Улаан-Үзүүр, Элгэн, Булган, Идрэн гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Чихэн агуйн дурсгалыг Монгол-Орос-Америкийн судлаачид 1997-2000 онд малтан шинжилсэн. Агуйгаас ихээхэн хэмжээний чулуун зэвсгийн зүйл, урт удаан хугацаанд гал түлж байсан ором, амьтны яс болон ургамлын үлдэгдэл бүхий хүний амьдралын ул мөрийг хадгалсан 4-н соёлт давхарга илэрсэн. Агуйн чулуун зэвсгийн суурин нь дунд палеолитын(100000-40000) төгсгөлөөс мезолит(40000-8000), неолитын(8000-30000) үеийн, өөрөөр хэлбэл чулуун зэвсэг үйлдвэрлэлийн 3 үеийн дурсгалыг хадгалсан, урт удаан хугацааны турш хүн амьдарч байсан суурин газар. ⁶⁸	
Төрийн албан хаагчдын тоо		125
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	733	734
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	342	
Төрөлтийн тоо	69	46
Нас баралтын тоо	14	15
Шилжин ирсэн хүн амын тоо		
Гэрлэлт,	3	10
цуцлалтын тоо	1	0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	6	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.5 мянга	0.47 мянга
Малын тоо		153,691
Хуулийн этгээд, ААН-ын тоо	45	

⁶⁸ <http://bayan-undur.bayankhongor.khural.mn>

8. БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНЦАГААН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Хуучнаар Засагт хан аймгийн Жонон вангийн хошуунд харьяалагдаж байжээ. Улмаар БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн 1931 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн тогтоолоор Говь-Алтай аймгийн Баянцагаан сум анхлан байгуулагдаж байсан. <ul style="list-style-type: none"> • 1931-1934 онд Говь-Алтай аймгийн Баянцагаан сум, • 1934-1940 онд Завхан аймгийн Баянцагаан сум, • 1940-1941 онд дахин Говь-Алтай аймагт, 1942 оноос Баянхонгор аймгийн Баянцагаан сум болон шилжин харьяалагдаж ирсэн түүхтэй. ⁶⁹	
Газар зүйн байршил	Монгол-Алтай нурууны төгсгөл Гичгэнэ уул, Говь-Алтай уулсын эхлэл Баянцагаан уул, түүний салбар уулс, тал хөндийд өөрийн аймгийн Бууцагаан, Баацагаан, Жинст, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр Говь-Алтай аймгийн Чандмана сумуудтай хил залгаа оршдог.	
	2022	2023
Хүн амын тоо	3,555	3,491
Нутаг дэвсгэрийн хэмжээ	5,395 км ²	
Сумын төвийн нэр	Баянбулаг	
Засаг захиргааны хуваарь	Гилчгэнэ, Дэлгэрэх, Цэцэн, Жаргалант, Баянбулаг гэсэн 5 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Явуутын рашааныг ходоод, элэг, цөсний өвчинд олон жил ууж хэрэглэж ирсэн. Уг рашааныг түшиглэн Бэлийн нарангийн суварга, Баянцагаан уул дахь Хатан ноёны бунхан, Хүнгэнэхийн амны том хэрэгсүүр, Адгийн хөшөөний цэрэг хөшөө, Алаг бунхан, Бага амны сүмийн туурь зэрэг түүхийн дурсгалт газар, Цагаан бургас, Дөрөө шуудаг, Шар мухрын хүрхрээ зэрэг байгалийн үзэсгэлэнт газарт амралт, аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх бүрэн боломжтой.	
Төрийн албан хаагчдын тоо		156
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	995	980
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	551	
Төрөлтийн тоо	79	73
Нас баралтын тоо	13	17
Гэрлэлт,	16	16
цуцлалтын тоо	2	0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	6	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх	0.63 мянга	0.65 мянга
Малын тоо		180,438
Хуулийн этгээд, ААН-ын тоо	66	

⁶⁹ <https://bayntsagaan.bkh.gov.mn>

9.БАЯНХОНГОР АЙМГИЙН БОГД СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Сайн ноён хан Намнансүрэнгийн захирч байсан гол хошууны их хамжлага албатууд суудаг байсан нутаг.	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн баруун урд хэсэгт Өлзийт, Жинст, Баянговь, Баянлиг сумдтай хил залган оршдог.	
	2022	2023
Хүн амын тоо	3,093	3,024
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,983 км ²	
Сумын төвийн нэр	Хориулт	
Засаг захиргааны хуваарь	Луугар, Гурван гол, Алтай, Цэлгэр, Буянт, Хориулт гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Их Богд уул түүний салбар Бага Богд уул, Жаранбогд уул, Дулаан Богд уул зэрэг сүрлэг сайхан уулс, 140 хавтгай дөрвөлжин км талбайтай Орог нуур, Холбоолжийн их бага улаан давст нуур, Түйн голын цутгалан зэрэг тогтмол ба урсгал устай гол, нуурууд үзэсгэлэнт газрууд байдаг. Арц Богд ууланд нь дэлхийд ховор чүнчигноров чулуу, өнгө нь гэрэлд үргэлж хувирч харагддаг судалт болор хэмээх эрдэнийн чулуунууд байдаг. Мөн эртний чулуун зэвсгийн доод үед хамаарагдах Дархны газар, Илжгэн чихт хааны мөр хөвийн хоолойн чулуун хана, Сэрвэнгийн арын Гамингийн тойром, Ноён хутагтын хийдийн туурь, Тэвш уулын хадны моринд хөллөсөн дөрвөн дугуйт тэрэгтэй хүмүүсийн сүг зураг бүхий бичигт хад зэрэг түүхэн дурсгалт газрууд олон бий.	
Төрийн албан хаагчдын тоо		153
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	893	898
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	623	
Төрөлтийн тоо	68	75
Нас баралтын тоо	11	19
Гэрлэлт,	10	8
цуцлалтын тоо	0	0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	14	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.64 мянга	0.65 мянга
Малын тоо		212,692
Хуулийн этгээд, ААН-ын тоо	60	

10.БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1923 оны зун Баянхонгор хайрхан уулын хошуу болгон зохион байгуулахдаа түүний дотор багтааж Баянхонгор, Бөмбөгөр, Хуримт, Зүрх хайрхан, Цогт хайрхан, Цагаан гол, Цагаан хайрхан, Баяннуур, Эрдэнэтээл зэрэг 12 сум байгуулснаар Бөмбөгөр сумын бие даасан түүх эхэлсэн. Бөмбөгөр сум 1923 онд байгуулагдсан. 1923 оны Засгийн газрын шийдвэрийн дагуу хамжлагыг халж, хошуудын нэрийг өөрчилж, Цогтой гүний хошууг Баянхонгор хайрхан уулын хошуу хэмээн нэрлэсэн байна. Аж ахуйн шинжээр сумдыг байгуулахад тус сум анх 50 өрх, 8 багтай Цэцэрлэг мандал уулын аймгийн Бөмбөгөр Хайрхан нэртэй сум байгуулагдаж 1924 оноос ажиллаж эхэлжээ. Сумын төв нь 1930-аад оны үед нүүдлийн байдалтайгаар тус сумын нутаг Тай, Цагаан ингэний гүн, Улаан худаг зэрэг газруудад нүүдэллэж, захиргаа нь гэр контортой ажиллаж байсан ба 1938 оноос одоогийн сумын төв байгаа Худаг сүүжийн дэнжид суурьшжээ. ⁷⁰	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн төв хэсэгт Галуут, Баян-Овоо, Баацагаан, Бууцагаан Заг сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,384	3,336
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,044 км ²	
Сумын төвийн нэр	Задгай	
Засаг захиргааны хуваарь	Улаан сайр, Хөх толгой, Бургас, Задгай гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Монгол орны хамгийн анхны хуурай газрын дурсгалыг хадгалж үлдсэн нутаг бол Бөмбөгөр сум бөгөөд 2,500 сая жилийн настай боржин чулуу, бараг 2 тэрбум жилийн настай гантиг чулуу тус сумын Жугамын ам гэдэг газраас олдож байжээ.	
Төрийн албан хаагчдын тоо		140
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,052	1,054
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	732	
Төрөлтийн тоо	77	81
Нас баралтын тоо	23	20
Шилжин ирсэн хүн амын тоо		
Гэрлэлт	8	9
Гэрлэлт цуцлалтын тоо	0	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	15	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.83 мянга	0.83 мянга
Малын тоо		314.199
Хуулийн этгээд, ААН-ын тоо	128	

⁷⁰ <https://bumbergur.bkh.gov.mn>

11.БАЯНХОНГОР АЙМГИЙН БУУЦАГААН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Хуучнаар Сайн ноён хан аймгийн Эрдэнэ Жүн Ван Жамьяндоржийн хошуу юм.	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн баруун захад өөрийн аймгийн Хүрээмарал, Заг, Бөмбөгөр, Баацагаан, Баянцагаан сумдтай хиллэн байрлах газар нутгийн хувьд говь, хангай, тал хээр хосолсон өвөрмөц тогтоцтой сум. ⁷¹	
	2022	2023
Хүн амын тоо	3,703	3,665
Нутаг дэвсгэрийн хэмжээ	5,840 км ²	
Сумын төвийн нэр	Буянт	
Засаг захиргааны хуваарь	Тэмээт, Баян, Өлзийт, Баянбүрд, Наран, Буянт гэсэн 6 багай.	
Алдар гавьяатнууд	Тус сумаас 3 хөдөлмөрийн баатар, 10 гавьяат, 2 улсын начин, 1 Улсын алдарт уяач төрөн гарсан.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Тус сумын хамгийн өндөр цэг Богд хайрхан уул нь хуучин хошууны тахилгатай уул байсныг 2006 онд сэргээн тахисан түүхтэй. Бүрэг хайрхан, Тарианы Богд, Богд аав уул, Баянгийн гол зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай. ⁷²	
Төрийн албан хаагчдын тоо		193
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1070	1060
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	742	
Төрөлтийн тоо	64	58
Нас баралтын тоо	19	25
Шилжин ирсэн хүн амын тоо		
Гэрлэлт,	7	8
цуцлалтын тоо	0	0
Нийгмийн үзүүлэлтүүд		
Бүртгэгдсэн гэмт хэрэг	12	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.8 мянга	0.79 мянга
Малын тоо		266,080
Хуулийн этгээд, ААН-ын тоо	72	

⁷¹ <https://buutsagaan.bkh.gov.mn>

⁷² <https://buutsagaan.bkh.gov.mn>

12.БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	<p>1931 оны засаг захиргааны өөрчлөлтөөр 1931-1934 онд Өвөрхангай аймгийн Баянхонгор сум, 1934-1941 онд Архангай аймгийн Баянхонгор сум болж, БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 81-р тогтоолоор Баянхонгор аймгийг (Анх Говьбөмбөгөр нэрээр) шинээр байгуулахад нэгэн сум нь болж, 1955 онд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигаар Баянхонгор сумаас 6 баг, Бөмбөгөр сумаас 2 баг таслан авч Галуут нэртэй шинэ сумыг “Өвөр Галуут”-д байгуулсан.</p> <p>1957 онд Баянхонгор сумыг татан буулгаж, хангайн чиглэлийн багуудыг Мандал суманд, бусад багийг Галуут суманд шилжүүлж, Галуут сумын төвийг Өвөр Галуутаас Баянхонгор сумын төвд /Баянхонгор хайрхан уулын өвөрт/ шилжүүлсэн түүхтэй.⁷³</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 221 дүгээр тогтоолоор Баянхонгор аймгийн Галуут сумыг “Улсын тэргүүний сум”-аар шалгаруулсан.</p>	
Газар зүйн байршил	Галуут сум нь хойд талаараа Архангай аймгийн Чулуут, Ихтамир сум, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Баян-Овоо, Бөмбөгөр, Заг, Жаргалант сумтай хил залгадаг.	
	2022	2023
Хүн амын тоо	4,208	4,189
Нутаг дэвсгэрийн хэмжээ	5,047 км ²	
Сумын төвийн нэр	Баянхошуу	
Засаг захиргааны хуваарь	Хайрхан, Сүмбэр, Үнэгт, Баяннуур, Мандал, Баянхошуу гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<p>Галуутын хавцал, Холбоо нуур, Үхэгийн рашаан, Тээлийн рашаан, Нарийн цохиотын рашаан, Өргөөтийн харз, Эрдэнэ тээл, Жаргалантын гол, Цагаан туруутын гол, Ёлын гол, Хуримт нуур, Бөөрөг нуур, Цэцгийн хонхор, Сойлонгийн хавцал, Хөх нуур зэрэг үзэсгэлэнт байгальтай.</p> <p>Чин сүжигт номун ханы хийдийн сум дуган, Бурхант хясаа, Буянт голын хүн чулуу, Харганын агуй, Тээлийн хөндийн бичигт хад, Цохиотын булан дахь хүн чулуу, Тээлийн амны балгас, Өргөөтийн овооны буган чулуу, Бага цохиотын дөрвөлжин хиргисүүр, Чингис хааны гүүн зэлний гадас, Сумын төв дэх хөшөө чулуунууд зэрэг эрт үеийн өвөг дээдсийн бүтээсэн дурсгалт түүхт газрууд олон.</p>	
Төрийн албан хаагчдын тоо		158
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,237	1,261
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	860	
Төрөлтийн тоо	113	83
Нас баралтын тоо	17	24

⁷³ <https://galuut.bkh.gov.mn>

Гэрлэлт,	14	15
цуцлалтын тоо	1	0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	22	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
малчин өрх,	0.96 мянга	0.93 мянга
Малын тоо		275,194
Хуулийн этгээд, ААН-ын тоо	93	

13.БАЯНХОНГОР АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Гурванбулаг сум нь Ардын хувьсгалын өмнө Сайн ноён хан аймгийн Жонон гүний хошуу гэж нэрлэгдэж ардын хувьсгал ялсны дараа 1924 оноос Цэцэрлэг мандал уулын аймгийн “Богд марал уулын хошуу” хэмээн нэрлэгдсэн бөгөөд 1931 онд Баруун Гурванбулаг сум болжээ.1942 онд Архангай, Өвөрхангай, Говь-Алтай аймгуудаас нэлээд сумыг таслан Баянхонгор аймаг байгуулагдахад тус аймгийн Гурванбулаг сум болсон түүхтэй. /Сумын төв нь 3 удаа нүүж Цэнгэл, Хар ус, Шар усны хөвөөнд төвлөрөн суурьшсан юм/ 1962 онд одоогийн төв Хөвийн аманд суурьшсан.	
Газар зүйн байршил	Баянбулаг, Хүрээмарал, Заг, Жаргалант, Завхан аймгийн Отгон сум, Архангай аймгийн Цахир, Хангай сумуудтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,304	2,264
Нутаг дэвсгэрийн хэмжээ	4,442 км ²	
Сумын төвийн нэр	Хөвийн ам	
Засаг захиргааны хуваарь	Цэнгэл, Давааны ам, Буга, Хөвийн ам, Пионер толгой гэсэн 5 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Гэр асга, Хөх нуур, Гурванбулаг, Морин мөрт, Хонгио, Өндөр улаан зэрэг сүрлэг уул, цэнгэг нууртай төрөл бүрийн ховор ургамал цэцэг, ан амьтан, жигүүртэн шувууд элбэгтэй нутаг. Хар ус, Шар ус, Түргэн, Билүүт, Нарийн тээл, Өлзийт зэрэг голуудтай, Нарийны рашаан булагтай энэ нутаг алт эрдэнэсээр баялаг юм. “Чинтийн тохой”, “Гурван ноёны шарил”, “Чингисийн тогоо” гэх мэт газрууд байдаг.	
Төрийн албан хаагчдын тоо		134
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	672	666
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	399	
Төрөлтийн тоо	58	57
Нас баралтын тоо	13	15
Шилжин ирсэн хүн амын тоо		

Гэрлэлт,	14	6
цуцлалтын тоо	0	0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	4	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
малчин өрх,	0.44 мянга	0.43 мянга
Малын тоо		152,507
Хуулийн этгээд, ААН-ын тоо	43	

14.БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Жаргалант нь 1940 онд Заг сумаас салж Байдрагийн үржлийн сангийн аж ахуйг түшиглэн байгуулагджээ. Байдраг үржлийн сангийн аж ахуй нь нарийн, нарийвтар ноосны чиглэлийн хонин сүргийн бүтцийг шинээр бий болгож түүнийгээ "Чамаар" (Байдраг) үүлдрийн хонь гэж нэрлэсэн. Энэхүү сангийн аж ахуй нь тухайн үедээ "Эрдэнэт хивс" компанид ноосоо нийлүүлдэг байсан ба Эрдэнэт хивсний үндсэн түүхий эд нь мөнөөх нарийн, нарийвтар ноос юм. Жаргалант сум нь Байдрагийн сангийн аж ахуйг түшиглэн байгуулагдсан.	
Газар зүйн байршил	Жаргалант сум нь аймгийнхаа хамгийн хойд талын сум бөгөөд өөрийн аймгийнхаа Галуут, Гурванбулаг, Заг сумд болон Архангай аймгийн Чулуут, Хангай сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,936	2,874
Нутаг дэвсгэрийн хэмжээ	4,175 км ²	
Сумын төвийн нэр	Жаргалант	
Засаг захиргааны хуваарь	Намтойгой, Өлзийт-Өндөр, Хөндлөнбулаг, Эмээлттолгой гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Тус суманд Байдраг, Мандал, Цохиот, Хүрэм, Хавцгай, Нарийн тээл, Цагаан дөрөлж зэрэг гол, Биндэръяа Хөх нуур, Байцагааны давсан нуур зэрэг нуур, Эг, Нам зэрэг өндөр даваа бий. Газрын зурагт тэмдэглэгддэг. Монгол улсын томоохон голуудын нэг Байдраг гол нь тус сумын Гурван голын эх хэмээх газраас эх авч Баянхонгор аймгийнхаа нутгаар урссаар Бөөнцагаан нуурт цутгана.	
Төрийн албан хаагчдын тоо		153
Хүн ам зүйн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	849	843
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	542	
Төрөлтийн тоо	43	46
Нас баралтын тоо	23	17
Гэрлэлт,	15	11
цуцлалтын тоо	3	0

Бүртгэгдсэн гэмт хэрэг	9	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.66 мянга	0.65 мянга
Малын тоо		126,750
Хуулийн этгээд, ААН-ын тоо	62	

15.БАЯНХОНГОР АЙМГИЙН ЖИНСТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1930 онд одоогийн Жинст сумын нутагт байсан Тариат, Сар, Хөвших сумуудыг нэгтгэж Нарийн хар сум гэж нэрлэв. Улмаар 1931 онд Өвөрхангай аймагт харьяалагдах болсон ба 1933 онд Жинст сум болгожээ. 1941онд Баянхонгор аймаг байгуулагдахад Өвөрхангай аймгаас шилжиж ирсэн таван сумын нэг нь юм.	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн төвөөс зүүн урагш 100 км зайд оршдог. Зүүн ба хойд талаараа Өлзийт, зүүн талаараа Богд, урд талаараа Баянговь, баруун өмнө талаараа Баянцагаан, баруун ба баруун хойд талаараа Баацагаан, Баян-Овоо сумдтай тус тус хиллэнэ.	
	2022	2023
Хүн амын тоо	2,242	2,183
Нутаг дэвсгэрийн хэмжээ	5,313 км ²	
Сумын төвийн нэр	Бодь	
Засаг захиргааны хуваарь	Уубулан, Хүйс, Хөнөг, Цагаан-Ус, Бодь гэсэн 5 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<ul style="list-style-type: none"> • Бүлээний амны дурсгал • Бодь уулын дурсгал • Цагаан тээгийн дурсгал • Цохиогийн дурсгал • Бөө хүрэнгийн дурсгал • Мааньтын цохиотын дурсгал • Уушгийн арын дурсгал • Засмалын дурсгал • Бултын булангийн дурсгал • Модон овоо⁷⁴ 	
Төрийн албан хаагчдын тоо		120
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	645	632
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	437	
Төрөлтийн тоо	49	50
Нас баралтын тоо	16	12
Шилжин ирсэн хүн амын тоо		

⁷⁴ <https://jinstd.bkh.gov.mn>

Гэрлэлтийн тоо	17	6
Гэр бүл цуцлалтын тоо	3	0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	9	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.5 мянга	0.49 мянга
Малчдын тоо		
Малын тоо		181,719
Хуулийн этгээд, ААН-ын тоо	50	

16.БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАГ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1924 онд “Чандмань” сум нэртэй байгуулагдаж 1934 оноос “Загийн гол” сум болж Өвөрхангай аймагт харьяалагдаж байгаад 1934 оноос Архангай аймагт, 1942 онд Баянхонгор аймгийн харьяат сум болжээ.	
Газар зүйн байршил	Заг сум аймгийнхаа баруун хойд хэсэгт орших бөгөөд зүүн талаараа Жаргалант, Галуут, баруун хойт, урд талаараа Гурванбулаг, Хүрээмарал, Бууцагаан сумдтай хиллэнэ.	
	2022	2023
Хүн амын тоо	2,136	2,103
Нутаг дэвсгэрийн хэмжээ	2,561 км ²	
Сумын төвийн нэр	Заг	
Засаг захиргааны хуваарь	Баянбулаг, Байн Улаан, Чандмань Овоо, Залаа Овоо гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Овоон таг, Баянбулаг, Данхарын тагууд, Хөх хайрхан, Тахилга хайрхан, Баянцагаан уул, Ямбат хайрхан зэрэг үзэсгэлэнт сайхан уул нуруудтай.	
Төрийн албан хаагчдын тоо		108
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	638	646
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	405	
Төрөлтийн тоо	43	45
Нас баралтын тоо	20	10
Гэрлэлт,	7	11
цуцлалтын тоо	1	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	3	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.45 мянга	0.45 мянга
Малын тоо		128,186
Хуулийн этгээд, ААН-ын тоо	60	

17.БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өлзийт сум нь хуучнаар Халхын Сайн ноён хан аймгийн Эрдэнэбандидын хошуу нутаг бөгөөд Олноо өргөгдсөн арван дөрөвдүгээр он буюу 1924 онд Цэцэрлэг мандал уулын аймгийн Баянзүрхийн хошууг сумдын зохион байгуулалтад оруулсны нэгийг Өлзийт сум хэмээн нэрлэснээр байгуулагдсан түүхтэй. ⁷⁵	
Газар зүйн байршил	Өлзийт сум нь зүүн хэсгээрээ Өвөрхангай аймгийн Уянга, Нарийн тээл, Баруунбаян-Улаан сум, урд хэсгээрээ өөрийн аймгийн Богд, Жинст сум, баруун хэсгээрээ Баян-Овоо сум, хойд хэсгээрээ Эрдэнэцогт сумдтай тус тус хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,906	3,860
Нутаг дэвсгэрийн хэмжээ	3,853 км ²	
Сумын төвийн нэр		
Засаг захиргааны хуваарь	Бурхант, Байн ам, Ёлын ам, Хулаг урт, Бийрийн уулзвар, Улаан-Уул гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Булган уул, Түйн бор балгас, Бийрийн хөндийн Буган чулуу, Хийдийн туурь, Хөшөөтийн буган хөшөө, Дөрвөн баатрын хөшөө, Ээжийн цагаан хөшөө, Гэгээний лата, Шатрын агуй, Уушийн хад, Бага шаргалжуут, Балин чулуу, Сэнжин цохио гэх мэт газруудтай. ⁷⁶	
Төрийн албан хаагчдын тоо		146
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,174	1,185
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	732	
Төрөлтийн тоо	67	75
Нас баралтын тоо	18	20
Шилжин ирсэн хүн амын тоо		
Гэрлэлт, цуцлалтын тоо	13	13
	1	2
ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт		2 дотуур байр 155 ортой
Бүртгэгдсэн гэмт хэрэг	14	
Ажилгүйдлийн түвшин		
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.91 мянга	0.84 мянга
Малын тоо		276,124
Хуулийн этгээд, ААН-ын тоо	55	

⁷⁵ <https://ulziit.bkh.gov.mn>

⁷⁶ <https://ulziit.bkh.gov.mn>

**18.БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮРЭЭМАРАЛ СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Тойм лавлагаа		
Газар зүйн байршил	Сумын төв нь аймгийн төвөөсөө 220 км зайтай.	
	2022	2023
Хүн амын тоо	1759	1710
Нутаг дэвсгэрийн хэмжээ	4328 км ² талбайтай	
Сумын төвийн нэр		
Засаг захиргааны хуваарь	Хөх бүрд, Сонор, Норовлин, Цорж, Дэлгэр мөрөн гэсэн 5 багтай.	
Алдар гавьяатнууд		
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<ul style="list-style-type: none"> • Мандал хайрхан • Дашдаржаалин хийд • Богд хайрхан • Боржин чулуун суврага сангийн байлар • Өвчүү цагаан дэнгийн хөшөө • Давсны цалам овоо⁷⁷ 	
Төрийн албан хаагчдын тоо		102
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	524	521
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	362	
Төрөлтийн тоо	25	26
Нас баралтын тоо	11	8
Шилжин ирсэн хүн амын тоо		
Гэрлэлт,	3	3
цуцлалтын тоо	0	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	3	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх,	0.39 мянга	0.37 мянга
Малын тоо		203 029
Хуулийн этгээд, ААН-ын тоо	39	


⁷⁷ <https://hureemaraal.bkh.gov.mn>

**19.БАЯНХОНГОР АЙМГИЙН ШИНЭЖИНСТ СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Тойм лавлагаа		
Товч түүх	Анх Хантайшир уулын аймгийн Баян-Өндөр уулын хошуу буюу Жонон вангийн хошууны хамжлага ардуудаас бүрдсэн сумыг таслан байгуулж нутгийнхны шүтээн “Залаажинст” уулаар нэрлэж, “Ямаан дээлт” хэмээх хочтой Гоонсүрэн хэмээх хүнээр даргалуулсан түүхтэй ажээ. Гэтэл “Баартагчингуудын хөдөлгөөн” гэгч өрнөж шинэ сумын удирдлагад захирагдахгүй зөрчилдсөнөөс 1932 оны үеэс сумыг буцаан нэгтгэхэд хүргэжээ. Хожим 1956 онд нэгдэлжих хөдөлгөөний ялалттай давхцуулан Шинэжинст сумыг сэргээн байгуулсан байна.	
Газар зүйн байршил	Шинэжинст сум нь аймгийн төвөөс урагшаа өөрийн аймгийн Баян Өндөр, Баянцагаан, Баянговь, Баянлиг сумдтай болон БНХАУ-тай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,538	2,563
Нутаг дэвсгэрийн хэмжээ	16,501 км ²	
Сумын төвийн нэр	Залаа	
Засаг захиргааны хуваарь	Зараа, Уртынгол, Эрдэнэшанд, Эхэнхавцгай гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Бурхант, Бамбуу, Эхийн гол, Цагаан бургас, Өлзийт, Мухар задгай зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай. ЮНЕСКО-гийн шим мандлын санд бүртгэлтэй Сэгс Цагаан Богд хайрхан энэ сумд байдаг. Шинэжинст сум цагаан ямаагаар алдартай бөгөөд дэлхийд хамгийн нарийн ширхэгтэй цагаан ноолуур бэлтгэж гаргадаг.	
Төрийн албан хаагчдын тоо		126
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	823	836
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	478	
Төрөлтийн тоо	65	56
Нас баралтын тоо	13	11
Гэрлэлт,	6	7
цуцлалтын тоо	3	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	3	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх	0.59 мянга	0.59 мянга
Малчдын тоо		
Малын тоо		174 531
Хуулийн этгээд, ААН-ын тоо	67	

**20.БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРДЭНЭЦОГТ СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Тойм лавлагаа		
Товч түүх	Эрдэнэцогт сум нь 1923 онд байгуулагдсан. Тус сум нь Ардын хувьсгалын өмнө Богд хаант Монгол Улсын Сайн ноён хан аймаг, Дайчин вангийн хошуу, 1921 онд ардын засаг тогтсоноор 1923 онд Цэцэрлэг мандал уулын /Архангай/ аймгийн Түйн голын хошуу гэж Засаг захиргааны нэгж болон дараа нь Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад харьяалагдаж ирсэн түүхтэй.	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн хойд хэсэгт байрладаг. Өөрийн аймгийн Өлзийт Баян-Овоо Галуут, Архангай аймгийн Булган, Цэнхэр, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий, Уянга сумдтай тус тус хиллэнэ.	
	2022	2023
Хүн амын тоо	4,432	4,361
Нутаг дэвсгэрийн хэмжээ	4,100 км ²	
Засаг захиргааны хуваарь	Сэнжид, Ямаат, Өвгөнжаргалант, Жанжин, Эрхэтхайрхан, Цагаан дэнж гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ, толгод, хад асга бүхий Хангайн өндөр уулс ойт хээрийн бүсэд зонхилон мал аж ахуй, газар тариалан эрхлэхэд тохиромжтой.	
Төрийн албан хаагчдын тоо		135
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,322	1,324
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	849	
Төрөлтийн тоо	105	95
Нас баралтын тоо	23	30
Гэрлэлт	23	13
Гэрлэлт цуцлалтын тоо	3	1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	7	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх	1 мянга	1 мянга
Малын тоо		189,272
Хуулийн этгээд, ААН-ын тоо	52	



III БҮЛЭГ. ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НЭГ.ТОЙМ ЛАВЛАГАА

1.Товч түүх:

БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1931 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 07 дугаар тогтоолоор тухайн үеийн Цэцэрлэг мандал уулын аймгийн гол хошуудаас одоогийн Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан 31 сумтай Түйн голын Цагаан эрэгт төвлөрүүлж нэг том аймаг болон анх байгуулагдсан. 1934 онд Өвөрхангай аймгийн төв бууриа сэлгэж одоогийн Арвайхээр хотод шилжин төвлөрч, Баянхонгор аймгийн зарим сумдыг Архангай, Завхан аймгуудад шилжүүлэн, Архангай аймгаас Өвөрхангай аймгийн Хархорин, Хужирт, Бат-Өлзий, Бүрд, Баян-Өндөр, Төв аймгийн Эрдэнэсант сумдыг нэгтгэн, шинэчлэн зохион байгуулж байжээ. Хожим нь зарим сумдыг шинээр байгуулж, заримыг нь татан буулгаж, нэгтгэснээр өдгөө Өвөрхангай аймаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 19 сумтайгаар тогтворжин хөгжсөн.

2.Газар зүйн байршил:

Монгол Улсын газар нутгийн төв хэсэгт баруун талаараа Баянхонгор, хойд талаараа Архангай, зүүн хойд талаараа Төв, зүүн талаараа Дундговь, урд талаараа Өмнөговь аймагтай хиллэн оршдог. Нутгийн хойд хэсэгт хангайн нурууны салбар уулс, төв хэсгээр нь хөндийн тал, өмнө хэсгээр нь Алтай нурууны салбар уулс, элсэрхэг тал хээрийн нутагтай.

3.Хүн амын тоо:

2022	2023
114,962	114,630

4.Нутаг дэвсгэрийн хэмжээ: **62,895.33** км²

5.Аймгийн төвийн нэр: Арвайхээр хот

6.Засаг захиргааны хуваарь: **19** сум, **112** багтай.

7.Угсаатны зүйн байдал: Халх **99%**, бусад **1%**

8.ёс заншил, өв уламжлал:

“Торгоны зам-Хархорум хот” соёл, аялал жуулчлалын эвент Хархорин сум, “Монгол эсгий урлалын баяр” Хужирт сум, “Сарлагийн баяр”, Өвлийн

аялал жуулчлалыг хөгжүүлж, улирлын хамаарлыг бууруулах чиглэлээр “Тэмээний баяр” эвент, “Kharakhorum Ice Festival”-ийг Бат-Өлзий суманд тус тус уламжлал болгон зохион байгуулдаг.

9.Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар:

Тус аймагт Хөшөө цайдам дахь Түрэгийн дурсгалууд, Ордубалык буюу Хар балгас, Хархорин хотын туурь, Эрдэнэзуу хийд, Төвхөн хийд, Дойт толгойн ордны туурь, Хутаг уулын булш, Талын дөрвөлжин дэх эртний хотын туурь, Хар бондгорын эртний хотын туурь, Баянголын амны эртний хотын туурь, Мэлхийт толгойн ордны туурь, Захын булгийн хэрмийн туурь, Гүмбийн дэнжийн буган хөшөө, Нарийны амны дөрвөлжин булш, Мэлхий чулуун дурсгал, Майхан толгойн Хүннүгийн булш, Ар бөөргийн эртний булшнууд, Хужиртын амны ордны туурь, Орхоны хөндий дэх эртний булш, Ширээт уулын буган чулуу, Шанхын хийд, Шунхлай уулын булш зэрэг түүх соёлын ул мөр бүхий газрууд их байдаг.

Тус аймгийн 7 гайхамшгаар Арц богд уул, Хужиртын рашаан, Монгол түмний морины их шүтээн, Хархорум хот, Эрдэнэзуу хийд, Тэвш уул, Төвхөн хийд зэрэг газрууд тодорчээ.

10.Дотоодын нийт бүтээгдэхүүн, эдийн засгийн голлох салбар:

2021	2022
608.3 тб.төг	803.6 тб.төг. үүнээс: хөдөө аж ахуйн салбар – 44,8 хувь, худалдаа, үйлчилгээний салбар – 37,9 хувь, аж үйлдвэрийн салбар – 17,3 хувийг тус тус эзэлж байна.

11.Төрийн албан хаагчдын тоо:

2022	2023
6,334	6,308

ХОЁР. ХҮН АМ ЗҮЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.Суурин хүн амын тоо:

2022	2023
117,089	115,575

2.Суурин хүн амын хүйсийн харьцаа:

2022	2023
98.9	98.9

3.Хүн амын дундаж наслалт:

2022	2023
72.54	72.64

4.Өрхийн тоо:

2022	2023
34,436	34,448

5.Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо (2020):

20,451 өрхийн **99.4** хувь буюу **20,330** өрх цахилгааны ямар нэгэн эх үүсвэрт холбогдож, **121** өрх буюу **0.6** хувь нь холбогдоогүй байна.

6.Төрөлтийн тоо:

2022	2023
2,342	2,268

7.Нас баралтын тоо:

2022	2023
711	702

8.Шилжин ирсэн хүн амын тоо:

2022	2023
явсан 3,125	явсан 3,037
ирсэн 724	ирсэн 1,139

9.Гэрлэлт, цуцлалтын тоо:

2022	2023
гэрлэлт 429	гэрлэлт 354
цуцлалт 92	цуцлалт 83

ГУРАВ. НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**1.ЕБС-ийн бүлэг дүүргэлт:**

2022	2023
26.7	27.3

2.ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа:

2022	2023
18.9	19.2

3.Нийт өнчин хүүхдийн тоо:

2022	2023
1,665	1,656

4.Өрх толгойлсон эх:

2021	2022
3,600	2,994

5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:

2022	2023
4,450	4,304

6.Хөдөлмөр эрхэлдэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо:

2022	2023
625	559

7.Бүртгэгдсэн гэмт хэрэг

2022	2023
696	516

8.Ядуурал (Хангайн бүс)

2020	2022
31.4	33.5

9.Ажилгүйдлийн түвшин:

2021	2022
3.8	6.1

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

10. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдын сарын бодит дундаж цалин:

2022	2023
бүгд 703.6 мян.төг	бүгд 829.1 мян.төг
эрэгтэй 669.5 мян.төг	эрэгтэй 805.9 мян.төг
эмэгтэй 726.8 мян.төг	эмэгтэй 844.6 мян.төг

ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс:

2022	2023
15.2	8.5

2. Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн цэвэр өөрчлөлт:

2022	2023
8.5	10.3

3. Хүн амын сарын дундаж хэрэглээ (Хангайн бүс):

2020	2022
276,526 төг	417,421 төг (2022)

4. Иргэдийн хадгаламжийн данс:

2022	2024 II
74.0 мянга	77.6 мянга

5. Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл:

2022	2023
162,483.10 сая.төг	192,081.80 сая.төг

6. Малтай өрх:

2022	2023
19.7 мянга	19.7 мянга

7. Малчин өрх:

2022	2023
17.8 мянга	17.8 мянга

8.Малчдын тоо:

2022	2023
27.9 мянга	27.6 мянга

9.Малын тоо:

2022	2023
4590.4 мян.тол. Үүнээс: Адуу 320.15 мян.тол Үхэр 277.64 мян.тол Тэмээ 19.26 мян.тол Хонь 2,265.2 мян.тол Ямаа 1,708.16 мян.тол	4734.7 мян.тол. Үүнээс: Адуу 349.39 мян.тол Үхэр 312.36 мян.тол Тэмээ 20.68 мян.тол Хонь 2,7324.75 мян.тол Ямаа 1,725.5 мян.тол

10.Том малын зүй бус хорогдол:

2022	2023
178.7 мян.тол (2023)	2023-2024 оны зуднаар аймгийн хэмжээнд 4,636 өрхийн 83,441 толгой мал хорогдсон байна. Үүнээс Тэмээ 19 , Адуу 3,970 , Үхэр 3,208 , Хонь 40,455 , ямаа 35,789 (2024.4 сар)

11.Шинэ хоршоолол хөдөлгөөнд хамрагдсан иргэдийн тоо:

Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд **3,572** хүн зөвлөгөө, мэдээлэлд хамрагдаж, нэг хоршоо шинээр байгуулагдан **178.0** сая төгрөгийн зээл аваад байна.

12.Аймгийн удирдлагын тогтвор суурьшил:

аймгийн ИТХ-ын дарга:

2020 оноос О.Пүрэвдорж

аймгийн Засаг дарга:

2020-2023 А.Ишдорж,

2024 оноос И.Доржсүрэн

13.Хүлээн авсан жуулчдын тоо 2023-2024:

Гадаадын **20,804**, дотоодын **35,811**, нийт **56,615**



14.Аймгийн бүтээн байгуулалт 2020-2024:

Эрүүл мэндийн салбарт: улс, орон нутгийн төсвийн **31.2** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар **50** ортой Хүүхдийн төрөлжсөн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, Богд, Сант, Төгрөг, Гучин-Ус сумын эрүүл мэндийн төв, Хайрхандулаан, Бат-Өлзий сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгууд ашиглалтад орж, Хархорин сумын **100** ортой Нэгдсэн эмнэлгийн барилга **60**, Хужирт сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга **70** хувьтай тус тус баригдаж байна.

Боловсролын салбарт: улс, орон нутгийн төсвийн **80.2** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Арвайхээр, Сант, Өлзийт сумдад **240**, Хужирт суманд **320**, Арвайхээр сумын 1, 2 дугаар сургууль тус бүрд **320**, Бат-Өлзий суманд **440** суудалтай сургуулийн барилга тус тус баригдаж ашиглалтад орсон. Баянгол суманд **240**, Баян-Өндөр суманд **320**, Хархорин суманд **320** суудалтай сургуулийн барилга барихаар гэрээ байгуулаад байна. Бат-Өлзий суманд **150**, Арвайхээр суманд **150** ортой **1, 15** дугаар цэцэрлэгүүд баригдаж ашиглалтад орж, энэ онд Арвайхээр суманд **150** ортой тусгай хэрэгцээт цэцэрлэгийн барилга барихаар гэрээ байгуулсан. Мөн Хархорин суманд **100** ортой дотуур байрын барилга, Арвайхээр, Хархорин суманд **250** суудалтай спорт заал баригдаж ашиглалтад орж, Уянга, Гучин-Ус сумдад **250** суудалтай спорт заал баригдахаар гэрээ байгуулсан.

Улсын болон төсөл хөтөлбөрийн **30.8** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сумын төвийн шинэчлэл төслийг Хайрхандулаан, Хужирт, Төгрөг сумдад хэрэгжүүлж, Бат-Өлзий, Хужирт, Төгрөг сумдад 40-90 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байнга.

Улсын болон төсөл хөтөлбөрийн **138.1** тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн **57,56** км авто замын их засвар шинэчлэлийн ажил бүрэн хийгдэж, Бат-Өлзий-Хужирт **49** км авто замын гүйцэтгэл 36 хувьтай, Хайрхандулаан сумыг А0302 дугаартай улсын чанартай авто замтай холбох **3.2** км ажил **30** хувьтай, Арвайхээр-Хужирт чиглэлийн **43.3** км авто зам, Мөн Есөнзүйл сумыг улсын чанартай авто замтай холбох **14.7** км авто замын ажил энэ онд эхэлнэ.

15.Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт:

2022	2023
63,331.3 сая.төг	57,940.6 сая.төг

16.Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй ААН:

2022	2023
7 ААН	6 ААН

Өвөрхангай аймагт үйл ажиллагаа явуулж буй 7 ААН байна. Үүнээс Уянга суманд “АУМ АЛТ”, “Өгөөмөр-Өргөө”, “Баярсгоулд”, Тарагт суманд “Галт-Үнэг”, Зүүнбаян-Улаан суманд “Эм Эс Бэл майнинг” ХХК, Нарийнтээл суманд “Империо майнинг” ХХК алт олборлох чиглэлээр, “Баянтээг” ХК нүүрс олборлох чиглэлээр тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Богд, Уянга, Нарийнтээл, Хайрхандулаан, Бат-Өлзий, Төгрөг, Зүүнбаян-Улаан, Баруунбаян-Улаан,Тарагт зэрэг нийт 11 сумын нутаг дэвсгэрт ашиглалтын 29 тусгай зөвшөөрөл, хайгуулын 35 тусгай зөвшөөрөл тус тус олгогдсон байна.

17.Хувиараа хөдөлмөр эрхлэгчид (2021):

нийт **1,429**, үүнээс: эрэгтэй **648**; эмэгтэй **781**

18.Орон нутгийн төсвийн орлого, зарлага

	2022	2023
Орон нутгийн төсвийн нийт орлого	55,145.3 сая.төг	68,876.5 сая.төг
Орон нутгийн төсвийн нийт зарлага	51,016.5 сая.төг	65,547.5 сая.төг

ТАВ.СУМДЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРВАЙХЭЭР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа	
Товч түүх	1707 онд Сайн ноён хан Жамбын хоёрдугаар хөвгүүн Цэрэндашид зэрэг хэргэм, албат хамжлага, газар нутгаа эзэмшүүлэн өгч, тусгай хошуу байгуулжээ. Тэр нь 1924 он хүртэл тогтсон Үйзэн гүний хошуу юм. Бэлчээр ус тэгш Онги голын сав газраар хошууны хамжлага ард нутаглан засаг захиргаа байгуулсан түүхтэй. Дэлгэрэх булаг, Тэмээчин булаг, Зэргэмжийн газраар нэлээд хэдэн жил нүүдэллэн хожим 1726-1727 онд Дэлгэрэх булагт модон дуган барьснаар өнөөдрийн Арвайхээр хотын анхны шав тавигдсан түүхтэй. 1957 онд Дэлгэрэх сумын 1 дүгээр багийг өөрчлөн 6 хоринтой хороо захиргааг, БНМАУ-ын АИХурлын Тэргүүлэгчдийн 1963 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 196 дугаар зарлигаар Арвайхээр хороог “Хот”, УИХ-ын 1994 оны 05 дугаар сарын 6-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Өвөрхангай аймгийн төвд Арвайхээр сум байгуулж, төв нь Арвайхээр хот байхаар тус тус шийдвэрлэжээ.

Газар зүйн байршил	Тарагт, Зүүнбаян-Улаан сумдуудтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	35,725	36,782
Нутаг дэвсгэрийн хэмжээ	17303 га	
Сумын төвийн нэр	Арвайхээр сум	
Засаг захиргааны хуваарь	Согоот, Эмт, Дэлгэрэх, Өлзийт, Арвайхээр, Ягаантолгой, Дэлгэрэхийндэнж, Рашаант, Бурхи, Ноён, Хүйстолгой, Зүлэгт, Онги гэсэн 13 багтай.	
Төрийн албан хаагчдын тоо		2,864
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	10,089	10,513
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	732	747
Нас баралтын тоо	204	198
Шилжилт хөдөлгөөн	Шилжин ирсэн 1057 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-127 Цуцлалт-43	Гэрлэлт-124 Цуцлалт-45
ЕБС-ийн бүлэг дүүргэлт		
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	Арвайхээр сумын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд төр болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын 6 сургуульд 10,711 суралцагч суралцдаг.	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	202	478
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	993	1,084
Малчдын тоо	1,552	1,713
Малын тоо	237,128	262,608
Хуулийн этгээдийн тоо /2023-I/2024-I улирлаар/	545	612

2.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАРУУНБАЯН-УЛААН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Сайн ноён хан аймгийн Сайн ноёны хошуунд харьяалагдаж байсан. Засаг захиргааны шинэ зохион байгуулалт явагдсан 1931 онд Өвөрхангай аймаг байгуулахад Баян-Улаан, Хөхбүрд гэсэн 2 сумыг нэгтгэн Баруунбаян-Улаан сумыг шинээр байгуулж байсан түүхтэй.	
Газар зүйн байршил	Баруунбаян-Улаан сум нь Өвөрхангай аймгийн нутгийн баруун урд хэсэгт орших ба өөрийн аймгийн Нарийн тээл, Хайрхандулаан, Гучин-Ус, Богд сумд, Баянхонгор аймгийн Богд сумдтай тус тус хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,657	2,496
Нутаг дэвсгэрийн хэмжээ	394111 га	

Сумын төвийн нэр	Баруунбаян-Улаан сум	
Засаг захиргааны хуваарь	Цагаан-Овоо, Хүүхдийн-Ус, Өлзийтхошуу, Хөөвөр гэсэн 5 багтай.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		117
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	704	678
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сумын төв нь төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. 2007 онд баригдсан 10/35/10квт-ийн дэд станцтай.	
Төрөлтийн тоо	59	48
Нас баралтын тоо	17	15
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 161 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-10 Цуцлалт-4	Гэрлэлт-6 Цуцлалт-0
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	20 бүлэгт	
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	432 сурагчтай	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	7	5
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		38
Малчин өрх	535	518
Малчдын тоо	758	678
Малын тоо	126,917	147,761
Хуулийн этгээдийн тоо /2023-1/2024-1 улирлаар/	15	19
Уул уурхай	Тус суманд хайгуулын 2 тусгай зөвшөөрөл олгогдсон.	
Бусад	Сум байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан “Модон жорлонгүй сум” эко аяныг эхлүүлсэн. Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сум Франц Улсын Брусей хоттой хамтран ажиллах гэрээг байгууллаа.	

3.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа	
Товч түүх	Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Сайн ноён хан аймгийн Сайн ноёны хошуу.
Газар зүйн байршил	Хужирт сумтай зүүн талаараа, Уянга сумтай урдуураа, Архангай аймгийн Цэнхэр, Хотонт сумтай хойд, зүүн хойд талаараа, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумтай баруун талаараа хиллэдэг. Газарзүйн онцлог. Ойт хээрийн бүсэд харьяалагддаг. Далайн түвшнээс дээш 1,643-3,099 м өргөгдсөн. Газар нутгийн нийт талбайн 40 орчим хувь нь бэлчээр, ой мод 40%, хад асга 16%, гол горхи 3%-ийг эзэлдэг ба нийт нутгийн 80 орчим хувь Байгалийн цогцолборт газарт хамрагдан тусгай хамгаалалтанд байдаг.

	2022	2023
Хүн амын тоо	7,649	7,580
Нутаг дэвсгэрийн хэмжээ	242.8 мянган га	
Сумын төвийн нэр	Бат-Өлзий сум	
Засаг захиргааны хуваарь	Өвт, Бүрэгтий, Улаан-Ам, Зөрүүлэг, Хүйтэнбулаг, Улиастай гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Байгалийн үзэсгэлэнт Улаан голын хүрхрээ, Хоргой хүрэм, Хангайн цагаан чулуу, Хан баян уул, Үүртийн тохой, Орхоны бага хүрхрээ, Цагаан голын хүрхрээ, Төвхөн хийд, Гүнжийн зам зэрэг газар, Хүний эрүүл мэндэд тустай нь нотлогдсон Хятруун, Могойт, Хамар, Үүрт, Хустын халуун, хүйтэн рашаануудтай, байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх нөөц боломж ихтэй.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		264
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	2,319	2,352
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сум нь Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Суманд улс, орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан нийт 18 дэд станцтай.	
Төрөлтийн тоо	155	137
Нас баралтын тоо	47	44
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 69 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-25 Цуцлалт-4	Гэрлэлт-14 Цуцлалт-3
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	56 бүлэгтэй	
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	125 багш, ажилчид 1,563 суралцагч	
ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт	Дотуур байр-1 Хүүхэд-142	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	34	23
Ажилгүйдлийн түвшин	Бүртгэлтэй ажилгүй иргэд 187 байна. Нийт ажилгүй иргэдийн 71.6 хувийг эмэгтэйчүүд	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх,	131	113
Малчин өрх,	1,494	1,532
Малчдын тоо	2,289	2,295
Малын тоо	278,087	265,775
Хуулийн этгээд, ААН-ын тоо	Сумын хэмжээнд нийт 83 аж ахуйн нэгж байгууллага, 38 жижиг дунд үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж байна.	
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид		
Орон нутгийн төсвийн нийт зарлага	Орон нутгийн төсвийн нийт зардал нь 375,6 сая төгрөг. Нийт зардлын 69 хувь нь цалин, 7 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 19.4 хувийг урсгал шилжүүлэг, 4.6 хувийг нь бусад зардал эзэлж байна.	
Уул уурхай	Тус суманд ашиглалтын 8 тусгай зөвшөөрөл олгогдсон.	

4.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Түшээт хан аймгийн Далай гүний хошуу.	
	2022	2023
Хүн амын тоо	3,495	3,351
Нутаг дэвсгэрийн хэмжээ		
Сумын төвийн нэр	Баян-Өндөр сум	
Засаг захиргааны хуваарь	Бөмбий, Батхаан, Өвөрзүлэгт, Хартойром, Бумбат гэсэн 5 багтай.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		139
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,121	1,095
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	57	68
Нас баралтын тоо	27	17
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 144 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-17 Цуцлалт-1	Гэрлэлт-10 Цуцлалт-2
Бүртгэгдсэн гэмт хэрэг	2	5
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	931	914
Малчдын тоо	1,465	1,433
Малын тоо	309,370	318,940
Хуулийн этгээдийн тоо /2023-л/2024-л улирлаар/	22	26
Уул уурхай	Тус суманд ашиглалтын 1 тусгай зөвшөөрөл олгогдсон.	

5.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өвөрхангай аймгийн Баянгол сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошуу юм.	
Газар зүйн байршил	Дундговь аймгийн Сайхан-Овоо сум болон Зүүнбаян-Улаан, Сант, Төгрөг, Тарагт сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,718	3,506
Нутаг дэвсгэрийн хэмжээ	354,257 га	
Сумын төвийн нэр	Баянгол сум	

Засаг захиргааны хуваарь	Өндөр-Өнц, Эргэндэнж, Цагаанбулан, Нартынхаяа, Цавын-Ихэр, Ширээ гэсэн 6 багтай.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		146
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,084	1,077
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сум нь Төвийн эрчим хүчний сүлжээнд 1999 онд холбогдсон. 35/10 кв-ын дэд станцтай. 10/04 квт-ын дэд станц 2 ширхэг.	
Төрөлтийн тоо	78	67
Нас баралтын тоо	26	22
Шилжилт хөдөлгөөн		
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-15 Цуцлалт-5	Гэрлэлт-11 Цуцлалт-1
ЕБС-ийн бүлэг дүүргэлт		
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	56 багш, ажилтантай	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	19	3
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	855	854
Малчдын тоо	1,480	1,392
Малын тоо	347,389	353,247
Хуулийн этгээдийн тоо /2023-1/2024-1 улирлаар/	18	18
Уул уурхай	Баянгол, Гучин-Ус, Тарагт, Төгрөг сумыг хамарсан хайгуулын 1 тусгай зөвшөөрөлтэй.	
Бусад	Баянгол сумын улсын тэргүүний цэцэрлэг хоёр давхар өргөтгөлийн барилгыг ашиглалтад оруулсан. Тус 50 хүүхдийн багтаамжтай, урлагийн заал, бүлгийн танхим бүхий барилгыг “Сонор бүрд” ХХК улсын төсвийн 564 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар барьж гүйцэтгэсэн байна. Тухайн цэцэрлэгт хамран сургах тойргийн 300 гаруй хүүхэд хамрагдах ёстойгоос өдрийн бүлэгт 125 суралцаж байгаа аж. Цэцэрлэгийг шинэ барилгаар өргөтгөснөөр 180 хүүхэд хамрагдаж, тав тухтай орчин нөхцөлд сурч, хөгжих боломж бүрдлээ.	

**6.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БОГД СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**


Тойм лавлагаа	
Товч түүх	Өвөрхангай аймгийн Богд сум нь 1924 онд байгуулагдсан. Хуучнаар Сайн ноён хан аймгийн Ханхөгшин хошуу.
Газар зүйн байршил	Тус сум нь Өмнөговь аймгийн Булган, Мандал-овоо, Сэврэй, Баянхонгор аймгийн Баянлэг, Богд, өөрийн аймгийн Баруунбаян-Улаан, Төгрөг, Гучин-Ус сумдтай хиллэдэг.

	2022	2023
Хүн амын тоо	5,644	5,409
Нутаг дэвсгэрийн хэмжээ	10,155 км ²	
Сумын төвийн нэр	Богд сум	
Засаг захиргааны хуваарь	Өлзийтхошуу, Хөөвөр, Баянтөхөм, Гүн-Ус, Далан, Ялаатай, Ховд гэсэн 7 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<p>Тэвш уул-сумын төвийн дэргэд зүүн хойд зүгт салбарлан тогтсон хар уулыг тэвш уул гэж нэрлэнэ. Тэвш уулын эргэн тойронд олон төрлийн хадны сүг зураг байхаас гадны булш хиргисүүрүүд ч олон байна</p> <p>Арц богд уул-Арц богд уул нь Бага Богд уулын зүүн хоолойгоор зааглагдаж, баруун үзүүр нь Бага Богд уултай 20 гаруй километр газраар зөрсөн байдаг. Арц Богд ууланд эртний чулуун зэвсгийн доод үед хамаарагдах Дархны газар, Илжгэн чихт хааны мөр хөвийн хоолойн чулуун хана, Сэрвэнгийн арын Гамингийн тойром, Ноён хутагтын хийдийн туурь, Тэвш уулын хадны моринд хөллөсөн дөрвөн дугуйт тэрэгтэй хүмүүсийн сүг зураг бүхий бичигт хад зэрэг түүхэн дурсгалт газрууд олон байдаг.</p>	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		193
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,521	1,486
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сум нь төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон.	
Төрөлтийн тоо	115	123
Нас баралтын тоо	29	25
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 235 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-26 Цуцлалт-6	Гэрлэлт-18 Цуцлалт-2
Бүртгэгдсэн гэмт хэрэг	14	14
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	1,190	1,150
Малчдын тоо	1,987	1,858
Малын тоо	287.461	306.187
Хуулийн этгээдийн тоо /2023-1/2024-1 улирлаар/	23	31
Уул уурхай	Тус суманд ашиглалтын 1, хайгуулын 5 тусгай зөвшөөрөл олгогдсон.	

7.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа	
Товч түүх	<p>ИХ МОНГОЛ УЛСЫН ХААДЫН ҮЕ Ар Юан улсын үед Батмөнх даян хааны үр сад үе улиран захирч байсан Орхон Туулын хоорондох өргөн уудам нутаг юм. Батмөнх даян хан (1464-1517он), Автай сайн хаан (1554-1588 он), Эрхий мэргэн хаан (1578-1610 он), Түшээт хаан Гомбодорж (1594-1655 он)</p> <p>ТҮШЭЭТ ХАН АЙМГИЙН ТҮШЭЭТ ХАНЫ ХОШУУ Халх Монгол Манж чин улсын харуулд 1989 онд орж, 1691 онд Долон нуурт Чин улсыг түших хүртэл Халхын Монгол 8 том хошуу байсны нэг нь Түшээт хан аймгийн Түшээт ханы хошуу юм.</p> <p>ТҮШЭЭТ ХАН АЙМГИЙН ДАЛАЙ ГҮНИЙ ХОШУУ-1691-1924 он. 1691 оны Долоннуурын чуулганы дараа Халхын Монгол 8 том хошууг 34 болгон олшруулахад 1691 онд Халхын түшээт хан аймгийн Далай гүний хошууг Түшээт хан аймгийн Түшээт ханы хошууны нутгаас шинээр байгуулжээ. 1691-1911 он. Манжийн захиргааны үед Түшээт хан аймгийн Далай гүний хошууг Халхын Умард замын Баруун гарын Баруун этгээдийн хошуу гэж тамгын бичээс бичсэн байдаг. 1911-1924 он. Богд хаант Монгол Улсын үед Түшээт хан аймгийн Далай гүнийн хошуу</p> <p>БОГДХАН УУЛЫН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР УУЛЫН ХОШУУ-1924-1931 он 1921 оны ардын хувьсгалын дараа 1923 оны 10 сарын 19 ний өдрийн Засгийн газрын 39-р тогтоолоор Түшээт ханы Далай гүний хошууг Богдхан уулын аймгийн Далай гүний хошуу болгон өөрчилж, улмаар удалгүй 1924 оны 6 сард болсон сумдын хурлаас сонгогдсон төлөөлөгчдийн хурлаар Богдхан уулын Баян-Өндөр уулын хошуу болгон уул усны нэрээр нэрлэн өөрчилжээ.</p> <p>АРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМ-1931-1942 он 1930 оны БНМАУ-ын ИХ Хурлын шийдвэрээр 1930 оны 11 сарын 09 өдрийн Засгийн газрын 37-р хурлаар 13 аймаг шинээр байгуулах болж энэ засаг захиргааны өөрчлөлтийн шийдвэрийг 1931 онд хэрэгжүүлж Архангай аймгийн Бүрд сумыг байгуулжээ.</p> <p>ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БҮРД СУМ-1942- оноос хойш өнөөг хүртэл 1942 оны эхээр Баянхонгор аймаг шинээр байгуулагдахад Өвөрхангай, Архангай, Төв аймгийн зарим сумдыг хооронд нь шилжүүлэх болж Бүрд сум нь 1942 онд Өвөрхангай аймагт шилжжээ.</p>

Газар зүйн байршил	Өвөрхангай аймгийн Есөнзүйл, Хархорин, Баян-Өндөр, Төв аймгийн Эрдэнэсант, Булган аймгийн Рашаант сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,849	2,736
Нутаг дэвсгэрийн хэмжээ	2,581 км ²	
Сумын төвийн нэр	Бүрд сум	
Засаг захиргааны хуваарь	Аржаргалант, Ихборигдой, Донгит, Архөшөөт, Онгон гэсэн 5 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Монгол орны төв хүйс цэг-Монгол орны өнөөгийн газар нутгийн “Хүйс цэг” нь газар зүйн солбилцлын аргаар олсон Х.Ө 46052I, З.У103050I-т орших Өвөрхангай аймгийн Бүрд сумын “Өвөр хөшөөтийн булаг” юм.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		112
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	819	804
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сум нь төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 1985 онд баригдсан 35/10/кВт-ийн дэд станцтай. 2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10/0.4/кВт дэд станцыг нэмж барьсан.	
Төрөлтийн тоо	57	47
Нас баралтын тоо	16	20
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 113 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-12 Цуцлалт-0	Гэрлэлт-9 Цуцлалт-0
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	14 бүлэг	
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	4 удирдлага, 42 багш ажилтантай 332 суралцагч	
ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт	Дотуур байр-1 70 хүүхэд	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	13	6
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	654	649
Малчдын тоо	1,127	1,104
Малын тоо	309,238	301,070
Хуулийн этгээдийн тоо /2023-I/2024-I улирлаар/	17	18



8.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ГУЧИН-УС СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өвөрхангай аймгийн Гучин-ус сум нь 1924 онд байгуулагдсан, хуучнаар Сайн ноён хан аймгийн Эрдэнэ-Үйзэн вангийн хошуу.	
Газар зүйн байршил	Өөрийн аймгийн Богд, Хайрхандулаан, Баруунбаян-Улаан, Тарагт сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,121	2,057
Нутаг дэвсгэрийн хэмжээ	475,250 га	
Сумын төвийн нэр	Гучин-Ус сум	
Засаг захиргааны хуваарь	Хөөвөр, Гучин, Аргалант, Аргуйт гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<p>Булш хиргисүүр – Сумын төвөөс баруун хойш 23 км-т Паалуугаас урагш 1 км-т жижиг толгойн дунд 13 м-ийн диаметртэй битүү чулуун хүрээтэй дөрвөн талаасаа орцтой томоохон хиргисүүрүүд орших бөгөөд үүнийг хүннүгийн үед хамаарах булш гэж үздэг.</p> <p>Их дөрөлж - Сүг зураг бүхий хадтай 1 км орчим үргэлжилсэн сувраа толгод.</p> <p>Паалуугийн дурсгал –Хадны сүг зурагт гэр бүл, хүн ба амьтны зан үйл, харьцаа харуулсан, ан амьтан моринд хөллөсөн сүйх тэрэг зэргийг харуулсан олон төрлийн дүрс байдаг.</p> <p>Уушгийн хөшөө - Хөшөөн хонд гэдэг газар оршдог. Энэ хөшөөнүүдэд маанийн 6 үсэг бусад зураг дүрс байдаг.</p> <p>Дурсгалын хөшөө - Дэлхийн энх тайвныг дэмжигч монголын анхны бүс нутаг болсонд зориулж сумын засаг даргын тамгын газар 2010 онд босгосон.</p> <p>Суварга - Гучин-Ус ,Төгрөг сумдын зааг нутагт Их мөнх уулын зүүн урд Сайн ноён хан аймгийн Сайн ноёны болон Үйзэн вангийн хошууны хилийн тэмдэгт болох суварга.</p>	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		138
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	629	629
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сум нь төвийн эрчим хүчний системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	51	36
Нас баралтын тоо	15	9
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 64 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-12 Цуцлалт-0	Гэрлэлт-7 Цуцлалт-1
Бүртгэгдсэн гэмт хэрэг	4	5
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	454	447
Малчдын тоо	762	745
Малын тоо	134,531	149,934

Хуулийн этгээдийн тоо /2023-1/2024-1 улирлаар/	17	20
Уул уурхай	Тус суманд хайгуулын 1 тусгай зөвшөөрөл олгогдсон. Энэхүү тусгай зөвшөөрөл нь Баянгол, Гучин-Ус, Тарагт, Төгрөг сумын нутаг дэвсгэрийг хамарсан.	
Бусад	<p>Арвайхээр, 2023 оны арваннэгдүгээр сарын 14 /МОНЦАМЭ/. Гучин-Ус, Сант суманд Эрүүл мэндийн төвийн шинэ барилгыг ашиглалтад орууллаа. Гучин-Ус сумын эмнэлэг нь 1953 оны хуучин барилгатай, 2006 онд амбулаторийн өргөтгөл барьсан ч хэвтүүлэн эмчлэх хэсгээ шинэчлэхгүй бол ашиглах боломжгүй гэсэн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагууд гаргаад байсан юм.</p> <p>Иймд Өвөрхангай аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүд 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг улсын төсөвт суулгаснаар 600 м.кв талбай бүхий 15 ортой шинэ барилгыг “Дуутын нуруу” ХХК зургаан сарын хугацаанд барьж, хүлээлгэн өглөө. Ингэснээр сумын 2,100 гаруй иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг стандартын шаардлага хангасан орчин нөхцөлд авах боломж бүрдэж байна.</p>	

9.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЕСӨНЗҮЙЛ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Тус сумыг "Есөнзүйл" гэдэг газрын нэрээр нэрлэжээ. Энэ газар бол Жавзандамба Хутагтын монголд тодорсон анхны дүр Түшээт хан Гомбодоржийн хүү Өндөр гэгээн Их Занабазарын мэндэлсэн Өлгий, Халхчууд эрт дээр үеэс уламжлан тахиж ирсэн нутаг II, III, IV Жавзандамба хутагтууд энд заларч байсан ариун дагшин газар гэдгийг түүх нотолдог. Түшээт хан аймгийн Илдэн бээлийн хошуу нь анх 1705 онд нутаг хошуу хуваарилалтаар Цогт Хун тайж /Номгон/-ы их хүү Сутай-Илдэн ноёнтон байгуулагдаад тэр 13 зэрэг залгажээ. Сүүлд нь энэ хошуу Сайн Ноён Хан аймагт харьяалагдах болсон байна. 1922 онд Бээлийн хошуунд сумд шинээр байгуулагдан Өлзийт, Есөнзүйлийг харьяалсан Дэлгэрэхбулаг гэдэг сум анх үүсэж, бие дааж анх 1924 онд Цэцэрлэг мандал уулын аймгийн Өлзийт уулын хошуунд "Есөнзүйл" нэртэйгээр байгуулагдсан тухай түүхэн баримт бий.	
Газар зүйн байршил	Бүрд, Баян-Өндөр, Сант, Өлзийт, Хужирт сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,731	2,610
Сумын төвийн нэр	Есөнзүйл сум	
Засаг захиргааны хуваарь	Туяа, Арвайнтал, Хүрэмт, Урт, Ихбулаг, Алтан тал гэсэн 6 багтай.	

<p>Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар</p>	<p>ӨНДӨР ГЭГЭЭНИЙ ӨВГӨН СУВАРГА Хуучин Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошуу одоогийн Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын нутаг Зүйлийн хөндий хэмээх газар халхын шарын шашны анхдугаар богд Өндөр гэгээн Занабазар 1639 онд мэндэлжээ. Ийнхүү анхдугаар богд Өндөр гэгээний хүй цөглөсөн газарт 1700-аад оны эхээр гэлэгбаагийн урсгалын нэгэн хурал үүсгэсэн нь Есөнзүйлийн хурал, Зүйлийн суваргын хурал хэмээн халхын шарын шашны түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. Уг хурал нь цогчин, хайлан, дарь эхийн, сахиусны гэсэн 4 дугантай 100-аад ламтай гол сахиус нь улаан сахиус, өдөр тутмын байнгын хурал хурдаг байжээ. Домогт буурлын хөшөө, Бугат дэл, Нарантолгойн хадны сүг зураг, Жонон вангийн хэрмийн туурь, нэн эртний түүхийн дурсгалт чулуун хөшөөнүүд Хүннү, Түрэг, Уйгарын дурсгалт хиргисүүрүүд Сэнгэ цохио, Далай гүний хүрээний туурь, XVII-XVIII зууны үед амьдарч байсан халхын Жонон ван Дэмчиг угшил сайт хурдан хүлгийг алсаас авчирч Манжийн ноёрхлын үеэс эрийн гурван наадмын морины түрүүг авахаар Манж нараас морио нууж уях гэж байгуулсан домог бүхий хэрмийн туурь зэрэг түүх соёлын дурсгалт газрууд бий. Улиаст өндөр, Ногоон тохой, Гацаан хүрэн чулуу, Бумбын хад, Баян-Үйлст, Хаалгын даваа, Сархайрхан, Нурамт, өвтийн сархиа зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай. Эртний домогт Хүүхэн хутагт Буурлын хөшөө сумын нутгийн зүүн урд хэсэгт оршдог.</p>	
<p>Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн</p>		<p>116</p>
<p>Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд</p>		
<p>Өрхийн тоо</p>	<p>864</p>	<p>845</p>
<p>Төрөлтийн тоо</p>	<p>62</p>	<p>41</p>
<p>Нас баралтын тоо</p>	<p>15</p>	<p>20</p>
<p>Шилжилт хөдөлгөөн</p>	<p>Шилжин явсан 121 хүн</p>	
<p>Гэрлэлт/цуцлалтын тоо</p>	<p>Гэрлэлт-12 Цуцлалт-0</p>	<p>Гэрлэлт-7 Цуцлалт-0</p>
<p>Бүртгэгдсэн гэмт хэрэг</p>	<p>4</p>	<p>5</p>
<p>Эдийн засгийн үзүүлэлтүүд</p>		
<p>Мал бүхий өрх</p>		
<p>Малчин өрх</p>	<p>454</p>	<p>447</p>
<p>Малчдын тоо</p>	<p>762</p>	<p>745</p>
<p>Малын тоо</p>	<p>134,531</p>	<p>149,934</p>
<p>Хуулийн этгээдийн тоо /2023-1/2024-1 улирлаар/</p>	<p>17</p>	<p>20</p>

Бусад	<p>Өвөрхангай /МОНЦАМЭ/. Есөнзүйл сумаас “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах зорилтот жил”-ийн хүрээнд дөрвөн баг, таван байгууллага, есөн аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, найман жилийн хугацаанд 200 мянган мод тарихаар ажиллаж байна.</p> <p>Мод тарих өдрүүдээр сумын хэмжээнд 7500 мод бут тарьжээ. “Хөгжил” нэгдлийн ууган гишүүн Ж.Гүндийн нэрэмжит цэцэрлэгт хүрээлэн байгуулан 1500 гаруй мод бут тарьсан.</p>
--------------	--

10.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗҮҮНБАЯН-УЛААН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	<p>Сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошуу (хуучнаар Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошуу бөгөөд манжийн ноёрхлын (1691-1911) үед Халхын умар замын баруун гарын дундад этгээдийн зүүн гарын хошуу гэж нэрлэгдэж байв) хожим Цэцэрлэг мандал уулын аймгийн Арвайхээр хошуу нь 1707 онд Сайн ноён хан Шамбын 2 дугаар отгон хүү Цэрэндашид сайн ноёны хошуунаас нутаг таслан байгуулжээ.</p> <p>Богд хаант Монгол Улсын 1911-1921,1922 онуудад Үйзэн вангийн хошуу хэмээн нэрлэгджээ. Энэ үеийн Засаг захиргааны дотоод хувиар нь Их гол сум, бага гол сум, зүүн сум, баруун сум, хувилгаан бандидад ламын шавь гэж 6 хэсэгт хуваагдаж байжээ.</p> <p>Ардын засгийн жилүүдэд 1923-1931 онд Цэцэрлэг Мандал уулын аймгийн Арвайхээр уулын хошуу гэгдэж байв.</p> <p>Одоогийн Зүүнбаян-Улаан сум нь БНМАУ-ын 6 дугаар Их Хурлын шийдвэрээр 1931 оны 4 дүгээр сард Мөнхбулаг, Шадавбулаг гэдэг 2 жижиг сумыг нэгтгэн Онгийн голын хөвөөнд анх байгуулагджээ.</p>	
Газар зүйн байршил	Сайхан-Овоо сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,737	3,591
Нутаг дэвсгэрийн хэмжээ	270,981 га	
Сумын төвийн нэр	Зүүнбаян-Улаан сум	
Засаг захиргааны хуваарь	Эмгэд, Цахиурт, Цохиот, Баян-Улаан, Хад, Дэвшил гэсэн 6 багтай.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		138
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,234	1,223
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сум нь төвийн эрчим хүчний системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	70	71

Нас баралтын тоо	27	24
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 146 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-11 Цуцлалт-1	Гэрлэлт-11 Цуцлалт-0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	6	4
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх	1,205	1,220
Малчдын тоо	1,744	1,699
Малын тоо	218,785	229,173
Хуулийн этгээдийн тоо /2023-1/2024-1 улирлаар/	24	27
Уул уурхай	Тус суманд ашиглалтын 1, хайгуулын 1 тусгай зөвшөөрөл олгогдсон.	

11.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НАРИЙНТЭЭЛ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Нарийнтээл сум нь 1926 онд БНМАУ-ын нутгийн захиргааны шинэчлэлт хийхэд Хан хөгшин уулын хошуу, Их баруун сум гэж байсныг өөрчилж дээд хэсгийг нь Батширээт сум, Таацын халуун уснаас Таацын цагаан-Овоо хүртэл нутгийг Баян-Өндөр сум, Шаргын гол, Таацын голын сав орчмыг Шарга сум гэж хэд хэдэн хэсэг болгон өөрчилж байжээ. 1931 онд явагдсан орон нутгийн засаг захиргааны өөрчлөлтөөр Баян-Өндөр, Батширээ, Шарга сумдыг нэгтгэж өргөтгөх хурал тухайн онд Өвөр байшинтын амны дэнжид болж сумаа Нарийнтээл хэмээн нэрлэхээр болсон байна.	
Газар зүйн байршил	Нарийнтээл сум нь Өвөрхангай аймгийн хамгийн баруун талын сум бөгөөд баруун талаараа Баянхонгор аймгийн Өлзийт сум, хойд талаараа Өвөрхангай аймгийн Уянга сум, зүүн талаараа Хайрхандулаан сум, өмнөд талаараа Баруунбаян-Улаан сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,532	3,348
Нутаг дэвсгэрийн хэмжээ	270,300 га	
Сумын төвийн нэр	Нарийнтээл сум	
Засаг захиргааны хуваарь	Шарга, Баянтээг, Өндөрхөмөг, Цагаан-Овоо гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Сумын нутаг “Тэмээн чулуун зуслан”, Тахидаг овоо, Ямаан ус, Өшгөгийн нуруу, Ноён хатан цохио, “Шаргын тасархай”, Таацын халуун ус, Цахир, Балин цохио зэрэг байгалийн үзэсгэлэнт газрууд олонтой билээ. Мөн ламын гэгээн Лувсанданзанжанцангийн суварга, номч мэргэн Цэвэлваанчигдоржийн суварга, Мандухай цэцний харуулын шивээ, Тахийн зурагт хөшөө, Цагдуултын хөшөө, Буган хөшөө, Тамгат хөшөө, Чогдов чулуу, Шаргын хүн чулуу, Шивээтийн шивээ, Сондуултын дөрвөлжин булшнууд, Латааны суварга, Өнгөт харын дөрвөлжин булшнууд зэрэг түүх соёлын дурсгалт газартай.	

Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		164
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	940	907
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	63	67
Нас баралтын тоо	19	24
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 184 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-6 Цуцлалт-0	Гэрлэлт-5 Цуцлалт-0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	6	7
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	628	597
Малчдын тоо	1,148	1,100
Малын тоо	174.765	187.086
Хуулийн этгээдийн тоо /2023-1/2024-1 улирлаар/	23	27
Уул уурхай	Тус суманд ашиглалтын 5 лицинз, хайгуулын 9 тусгай зөвшөөрөл олгогдсон.	

12.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН САНТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа	
Товч түүх	Ардын засгийн газраас 1923 оны 1-р сарын 5-нд “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм” гаргаж, 5 сарын 10-ны өдрийн хурлын 39-р тогтоолоор Сайн ноён хан аймгийг Цэцэрлэг мандал уулын аймаг болгож Өлзийт уулын хошууг 13 сумтай байгуулж, Илдэн бэйлийн хүрээг төв болгосон байна. 1927 онд Ардын засгийн газрын шийдвэрээр хошуу тамгын нэрийг өөрчилж, одоогийн Архангай аймгийн Хотонт, Өвөрхангай аймгийн Хужирт, Зүйл, Өлзийт, Сант, сумдыг хамарсан Зүүн-Өлзийт сумыг байгуулжээ. 1929-1930 онуудад Ардын Засгийн газраас нутгийн захиргааны дүрмийг шинэчлэн орон нутгийн засаг захиргааны байршилтад өөрчлөлт хийж, БНМАУ-ын Бага Хурлын тэргүүлэгчийн 1931 оны 2 дугаар сарын 7 ны өдрийн 5 дугаар тогтоолоор Цэцэрлэг мандал уулын аймгийн Өлзийт уулын хошуунаас Сант сумыг байгуулж, “Тагна” хэмээх газар төвлөрүүлэн намын товчоо, захиргаа 1 эсгий гэр, эд хэрэглэгчдийн хоршоо 6 ханатай нэг гэрт байрлан ажил хэргээ явуулж эхэлсэн. Сумын анхны даргаар Баянгол сумын харьяат Малчин эмэгтэй Г.Раахүү, нарийн бичгийн даргаар Сант сумын харьяат Т.Дамдинсүрэн нар ажилласан байна.
Газар зүйн байршил	Сант сум нь өөрийн аймгийн сумдууд Баянгол, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Есөнзүйл, Баян-Өндөр, Дундговь аймгийн Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумдтай хиллэдэг.

	2022	2023
Хүн амын тоо	3,357	3,242
Нутаг дэвсгэрийн хэмжээ	256,406.0 га	
Сумын төвийн нэр	Сант сум	
Засаг захиргааны хуваарь	Туяа, Арвайн тал, Хүрэмт, Урт, Ихбулаг, Алтан тал гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Тус сум Монголын гучин гурван говийн хойт хэсэг Домбон Зээрэн, Шагшургын уужим говиуд, Сант, Шанд, Зодох, Эмээлт /далайн түвшинөөс дээш 1,543 м /, Баян /далайн түвшнээс дээш 1,325 м/, Бургатай /далайн түвшнээс дээш 1633 м/ зэрэг үржил шимт үргэлжилсэн нурууд, Далайн түвшнээс дээш 1,721 өндөр өргөгдсөн Өгцөг уул, Улаан хадны хавчил, агуй, Эрдэнэ овоо зэрэг үзэсгэлэнт байгальтай. Эртний булш, хиргисүүр олонтойгоос гадна Гурван дуган, 100 гаруй лам шавилан суудаг байсан Зээрэнгийн хийдийн туурь, Түрэгийн үеийн хөшөө бичээс түүхэн дурсгалт газруудтай.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		134
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,036	1,003
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Цахилгаан эрчим хүчний төвлөрсөн системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	71	67
Нас баралтын тоо	22	24
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 115 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-10 Цуцлалт-0	Гэрлэлт-8 Цуцлалт-0
Бүртгэгдсэн гэмт хэрэг	6	0
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	913	897
Малчдын тоо	1,294	1,288
Малын тоо	251,365	259,513
Хуулийн этгээдийн тоо /2023-I/2024-I улирлаар/	22	23
Бусад	ХХААХҮЯ, МҮОНРТ-ээс шалгаруулдаг "Алтан төлийн эзэн"-ээр Сант сумын Залаа 4 дүгээр багийн Малчин өрх Бадамсамбуугын Эрдэнэсайханых шалгарсан.	

**13.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТАРАГТ СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Тойм лавлагаа		
Товч түүх	1923-1924 оны заагаар хуучин төрийн байгууллагыг ардчилсан сонгуулийн үндсэн дээр өөрчлөн байгуулахад Сайн ноён хан аймгийн Агь Үйзэн вангийн хошууг Цэцэрлэг мандал уулын аймгийн Арвайхээрийн хошуу гэж нэрлэн тус хошууг Ахар уул, Тарагт гол, Зүүн гол, Орхон гол, Дэлгэрэх булаг, Халуун ус, Марз бүрд, Төгрөг нуур, Халуун ус, Мөнх булаг, Өрхтэй, Хонхор гэсэн 18 сумтай шинэчлэн байгуулсны төвийн сум нь Тарагт сум болж одоогийн Туяа багийн Тарагтын гол дээр байгуулагджээ. 1931 онд засаг захиргааны өөрчлөлтөөр хошуудыг татан буулгахад Арвайхээрийн хошууг Тарагт, Төгрөг, Зүүнбаян-Улаан, Өндөр-Өнц, Гучин-Ус гэдэг 6 сум болгон зохион байгуулсны нэг нь юм.	
Газар зүйн байршил	Тарагт сум нь баруун талаараа Хайрхандулаан сумтай, баруун хойд талаараа Уянга сумтай, хойд зүүн талаараа Зүүнбаян-Улаан сумтай, өмнө талаараа Баянгол, Төгрөг сумтай, баруун урд талаараа Гучин-Ус сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,261	3,099
Нутаг дэвсгэрийн хэмжээ	339,500 га	
Сумын төвийн нэр	Тарагт сум	
Засаг захиргааны хуваарь	Туяа, Арвайн тал, Хүрэмт, Урт, Ихбулаг, Алтантал гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Тарагт сумын нутагт нэн эртний үеэс хүн амьдарч байсан ул мөр болох чулуун ба хүрэл, төмөр зэвсгийн үеийн дурсгалууд, чулуу, хүрэл, зэвсгүүд, хутаг, хадны сүг зураг олон бий. Хүрэмтийн халуун рашаан, Хунтын гармын чулуун хөшөө, Бажийн дөрвөлжин бичээст чулуу, Хадатын гуяын хөшөө, Арвайхээр морины хөшөө, Төрийн зүтгэлтэн П.Гэндэн агсны төрсөн газарт босгосон дурсгалын самбар зэргийг нэрлэж байна. - Хүрэмтийн халуун рашаан - Хангайн овоо - Авзага хайрхан - Домогт бөх борхой бүргэд - Арвай хээрийн тал - Монгол түмний морины их шүтээн	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		142
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1,033	1,028
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Тус сум нь төвийн эрчим хүчний системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	70	67
Нас баралтын тоо	13	20
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 162 хүн	


Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-8 Цуцлалт-2	Гэрлэлт-5 Цуцлалт-2
ЕБС-ийн бүлэг дүүргэлт		
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	50 багш, ажиллагсад 617 суралцагч	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	15	13
Ажилгүйдлын түвшин	2023 оны байдлаар ажилгүй иргэн 873 байна.	
Эдийн засгийн үзүүлэлтүүд⁷⁸		
Малчин өрх	973	999
Малчдын тоо	1,367	1,450
Малын тоо	248,287	278,622
Хуулийн этгээдийн тоо	Төрийн байгууллага 120 Хувийн хэвшил 1366	
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	Хувиараа хөдөлмөр эрхлэгч 51 иргэн	
Орон нутгийн төсвийн нийт зарлага	Орон нутгийн төсвийн нийт зарлага 1,524.4 сая төгрөг.	
Уул уурхай	Тус сум ашиглалтын 2, хайгуулын 7 тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Баянгол, Гучин-Ус, Тарагт, Төгрөг сумыг хамарсан хайгуулын 1 тусгай зөвшөөрөлтэй.	

14.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	1707 онд Сайн ноён Шамбын хоёрдугаар отгон хөвгүүн Цэрэндашид нэгэн хошууны газар нутаг, хүн ам, мал сүрэг таслан өгснөөр Сайн ноён хан аймгийн Үйзэн засгийн хошууг анх байгуулжээ. 1924 онд явагдсан орон нутгийн захиргааны ардчилсан өөрчлөлтөөр Үйзэн вангийн хошууг Арвайхээрийн хошуу хэмээн нэрлэж тус хошууг 18 сумтай шинэчлэн зохион байгуулсны дотор Төгрөг сум орсон юм. Төгрөг сум нь 1924 оны 6-р сард одоогийн Гучин ус сумын ихэнх хэсгийн хамарч байгуулагдсан. Өвөрхангай аймгийн Төгрөг сум нь 1924 онд “Сайн төгрөг” гэдэг газар байгуулагдсан бөгөөд 1939 оны намар “Сайн төгрөг”-өөс нүүж Хоолт гэдэг газар төвлөрөн суурьшсан. Хуучнаар Сайн ноён хан аймгийн Үйзэн вангийн хошуу.	
Газар зүйн байршил	Төгрөг сум нь Өвөрхангай аймгийн нутгийн зүүн урд хэсэгт Богд, Гучин-Ус, Тарагт, Баянгол сумд болон Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,635	2,525
Нутаг дэвсгэрийн хэмжээ	546,688 га	
Сумын төвийн нэр	Төгрөг сум	
Засаг захиргааны хуваарь	Хоолт, Их-Ус, Мазар, Сайнтөгрөг, Баян гэсэн 5 багтай.	

⁷⁸ <https://cdn.greensoft.mn/uploads/users/4539/files/Document%2029.pdf>

Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Төгрөг суманд түүх соёл дурсгалт газрууд болон түүхийн домогт газрууд олон бий. Лам хуврагууд нямба хийж байсан орж гарах гарц бүхий хэд хэдэн агуйг багтаасан туурь буюу Дэмчигийн сүм гэж нэрлэгдсэн газар, Номтын бууцны зураг, Жимгэрийн хөшөө, Эмээлийн хөшөө, Эртний мазар хотын туурь, дарь эхийн жас, Хиргисүүр мөн эрдэнэ хайрхны нүүрст гэдэг газар археологийн ховор дурсгал болох эртний амьтны чулуужсан яс, мод байдаг. Түүхэн домогт газрууд нь Даваашагдарын уяа, Цагаан ботго, Бор ботго, Мазар, Бэлгих, Сайнтөгрөг, Хоолт, Борхойн тээг, Шаа хайрхан, Ахар, Угалз, Долоон толгойт, Дэрсэн хүнт шонхор, Хаяа нуур, Аман ус, Могой гэх мэт 20 гаруй түүхэн домогт газрууд байдаг.	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		124
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	837	807
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Тус сум нь төвийн эрчим хүчний системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	53	49
Нас баралтын тоо	10	12
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 110 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-14 Цуцлалт-0	Гэрлэлт-8 Цуцлалт-0
ЕБС-ийн бүлэг дүүргэлт		
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	50 багш, ажиллагсад 617 суралцагч	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	0	1
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	635	640
Малчдын тоо	988	978
Малын тоо	185,032	182,436
Хуулийн этгээдийн тоо		
Уул уурхай	Тус сум ашиглалтын 1 тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Баянгол, Гучин-Ус, Тарагт, Төгрөг сумыг хамарсан хайгуулын 1 тусгай зөвшөөрөлтэй.	



15.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УЯНГА СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	<p>Тус сум нь 1931 онд байгуулагдсан, хуучнаар Сайн ноён хан аймгийн Ханхөгшиний хошуу. 1953 онд Жаргалантын зам, 1956 онд Өрнөлт, Бадрал нэгдэл байгуулагдан улмаар 1962 онд гурван нэгдлийг нэгтгэн Өрнөлт нэгдэл болгон хөгжүүлжээ.</p> <p>Тус сум нь сарлагаараа улсад тэргүүлдэг сарлагийн сүү тос болон Уянга хийцийн гэрийн эрээн модоороо улсдаа алдартай юм.</p> <p>Уянгачуудын түүхэн он цагийн уртад бүтээсэн бүтээл, хичээл зүтгэл, гавьяат үйлсийг үнэлэн үзэж сум байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын төрийн дээд шагнал "Алтан гадас" одонгоор шагнасан.</p>	
Газар зүйн байршил	Баянхонгор аймгийн Өлзийт болон Өвөрхангай аймгийн Нарийнтээл, Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан, Тарагт, Хайрхандулаан сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	9,363	9,247
Нутаг дэвсгэрийн хэмжээ	313,936.0 га	
Сумын төвийн нэр	Уянга сум	
Засаг захиргааны хуваарь	Жаргалант, Таац, Шивээ-Овоо, Шуранга, Бадрал, Бөөрөлжүүт, Өлт, Онги гэсэн 8 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	<p>Өвөрмөц сонин тогтоцтой хад чулуу, үзэсгэлэнт байгальтай.</p> <p>Онгийн түрэг бичээс, Онъдолтын Хүн булш, Өвөрхангайн түрэг бичээс, Арслан хааны хотын туурь буюу Олон сүмийн хөл зэрэг түүх, соёлын дурсгалтай.</p> <p>Хангайн нурууны Жаргалант, Тооройт, Ив зэрэг далайн түвшнээс дээш 3230 метр өндөр өргөгдсөн уулс, Таац, Онгийн хөндий, Найман нуур, Битүүт, Хятруун. Шурангийн улаан цохио зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай, алт, эрдэнийн чулуу, хүрмэн чулуу зэрэг байгалийн баялагтай.</p>	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		344
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	2,768	2,726
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сумын төв нь 1990 онд, Бадрал, Жаргалант баг нь 2012 онд Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Одоо сумын төвд 10/04 ква-ийн дэд станц 8 ширхэг, 5/04кв-ын дэд станц 2, нийт 10 дэд станц ажиллаж байна.	
Төрөлтийн тоо	189	195
Нас баралтын тоо	64	53
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 116 хүн	

Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-39 Цуцлалт-7	Гэрлэлт-24 Цуцлалт-12
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	18 бүлэг	
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	183 багш, ажиллагсад 1,745 суралцагч ЕБ-ын 12 жилийн 3 дунд сургуультай. 2019 онд улсын төсвийн 951,648.1 мян.төг-ийн хөрөнгө оруулалтаар Жаргалант багт 120 хүүхдийн суудалтай сургууль баригдан ашиглалтад орсон байна. 2017 онд 70 хүүхдийн дотуур байр ашиглалтад орж одоогоор 108 хүүхэд амьдарч байна.	
ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт	Дотуур байр-1 Хүүхэд-108	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	23	28
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх	1,864	1,872
Малчдын тоо	2,923	2,915
Малын тоо	311,552	343,716
Хуулийн этгээдийн тоо	Тус суманд одоогоор төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд, урлаг, соёлын чиглэлээр 9 төсвийн байгууллага, Мал эмнэлэг, банк санхүү, харилцаа холбоо, худалдаа үйлчилгээ, талх нарийн боов, оёдлын үйлдвэрлэл, шатахуун түгээх, алт олборлолтын чиглэлээр 70 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна.	
Уул уурхай	Тус суманд ашиглалтын 8 тусгай зөвшөөрөл олгогдсон.	

16.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАЙРХАНДУЛААН СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Засаг захиргааны шинэ зохион байгуулалт явагдсан 1931 онд Өвөрхангай аймаг байгуулахад 7 сумыг нэгтгэж Хайрхандулаан, Гүннарийн гэсэн 2 сум болгон байгуулсан байна. Гүннарийн сумыг 1961 онд Хайрхандулаан суманд нэгтгэжээ.	
Газар зүйн байршил	Хайрхандулаан сум нь Өвөрхангай аймгийн нутгийн баруун хэсэгт, баруун урд талаараа Нарийнтээл, хойд талаараа Уянга, зүүн талаараа Тарагт, урд талаараа Гучин-ус сумтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	3,465	3,364
Нутаг дэвсгэрийн хэмжээ	413,770.0 га	
Сумын төвийн нэр	Марзат сум	
Засаг захиргааны хуваарь	Бурхант, Нарт, Эмээлт, Дэрсэн хонхор, Аргуйт, Марзат гэсэн 6 багтай.	

Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар ⁷⁹	<ul style="list-style-type: none"> • Бургастын буган хөшөө • Бор ламын агуй • Говийн гурван эрэлчин хөшөө • Гозгорын бэлийн буган хөшөө • Дугана буудал • Мааний үсэгтэй цохио • Манцуйт хөшөө • Ногоон хөвийн уяа • Увшхай хөшөө • Хөгшин тээлийн хөшөөний бичээс • Хувилай хааны цэргийн хотхон
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн	133
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд	
Өрхийн тоо	1,074
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Сум нь Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 2004 онд баригдсан 110/35/10квт-ийн дэд станцтай.
Төрөлтийн тоо	70
Нас баралтын тоо	21
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 101 хүн
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-9 Цуцлалт-1
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	18 бүлэг
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	51 багш, ажиллагсад 470 суралцагч
ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт	Дотуур байр-1 Хүүхэд-51
Бүртгэгдсэн гэмт хэрэг	17
Ажилгүйдлийн түвшин	8
Эдийн засгийн үзүүлэлтүүд	
Малчин өрх	740
Малчдын тоо	1,242
Малын тоо	237,311
Хуулийн этгээдийн тоо	Сумын хэмжээнд нийт 22 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн үйл ажиллагаа явуулж байна.
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, ААН	Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг 1 хоршоо, 1 бүлэг, 41 иргэн, Оёдол, гутал үйлдвэрлэлийн чиглэлээр 1 хоршоо, 4 иргэн, дугуй засвар 2 иргэн, төмөр хийц, гагнуурын чиглэлээр 2 иргэн, эсгий үйлдвэрлэлийн чиглэлээр 2 иргэн, модон эдлэлийн чиглэлээр 2 иргэн, туслах аж ахуй эрхэлдэг 5 иргэн, худалдаа, үйлчилгээний чиглэлээр 2 хоршоо, 17 иргэн тус тус ажиллаж байна.
Орон нутгийн төсвийн нийт зарлага	Орон нутгийн нийт төсвийн зардал нь 288.5 сая төгрөг байна. Нийт зардлын 63% нь цалин, 7% нь нийгмийн даатгалын шимтгэл, 19.4% нь урсгал шилжүүлэг, 10.6% нь бусад зардал эзэлж байна.
Уул уурхай	Тус суманд ашиглалтын 2, хайгуулын 10 тусгай зөвшөөрөл олгогдсон.

⁷⁹ <http://khairkhandulaan.ov.gov.mn/түүхэн-дурсгалт-газар>

**17.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХАРХОРИН СУМЫН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Тойм лавлагаа		
Товч түүх	Монгол Улсын түүх, соёлын өлгий, байгалийн үзэсгэлэнт тогтоц бүхий Орхоны хөндий дэх эртний Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум хотын туурийн залгаа байрлана. Хархорин хот нь анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1956 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 256 дугаар тогтоолоор үр тарианы чиглэлийн “Хархорин” нэртэй сангийн аж ахуй байгуулагдсан. 1957 оны 12 дугаар сард Хархорин сумын АДХГЗ байгуулагдаж, Архангай аймгийн харьяаллаас Өвөрхангай аймгийн харьяалалд шилжүүлсэн байна. УИХ-ын 1994 оны 58 дугаар тогтоолоор аймгийн зэрэглэлтэй хот, 2003 оны 1 дүгээр тогтоолоор Хангайн бүсийн тулгуур төв хот болсон.	
Газар зүйн байршил	Сумын нутаг дэвсгэрийн баруунаар Архангай аймгийн Хотонт, хойд талаараа мөн аймгийн Хашаат, зүүн урдуур өөрийн аймгийн Бүрд, Зүйл, урд талаараа Хужирт сумуудтай тус тус хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	12,170	11,908
Нутаг дэвсгэрийн хэмжээ	224,116 га	
Сумын төвийн нэр	Хархорин сум	
Засаг захиргааны хуваарь	Бангийн-Овоо, Ганган-Орхон, Эрдэнэтолгой, Нарийн хүр, Онгоцон-Ухаа, Жалбаа, Шанх, Орхон гэсэн 8 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Түүх соёлын дурсгалууд - Эрдэнэ зуу музей, хийд -Хархорум хотын туурь - Шанхын хийд - Мойлтын ам - Орхон-7 палеолитийн дурсгал (62.000–20.000 жилийн өмнө) - Гүмбийн дэнж дэх буган хөшөө ба эртний булш оршуулга - Бага Эрээний хүн чулуу - Бумбатын өврийн хүн чулуу - Хархорумын нэгдүгээр монгол бичээс. - Бага арцатын монгол булш - Жаргалантын хиргисүүр - Маамуу толгойн булш	
Төрийн албан хаагчдын тоо, шилжилт хөдөлгөөн		673
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	3,663	3,590
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Төвийн эрчим хүчний системд холбогдсон. 35 кв-ын -27,6 км ЦДАШ, 10 кв-ын ЦДАШ- 27,6 км, 0.22-0.4 кв-ын 57кмЦДАШугамтай. Нэгдсэн цахилгаан шугам сүлжээнд 5 багийн 2468 өрх холбогдсон.	

Төрөлтийн тоо	231	234
Нас баралтын тоо	78	83
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 262 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-60 Цуцлалт-12	Гэрлэлт-55 Цуцлалт-9
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	98 бүлэг	
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	254 багш, ажилчин 2,823 суралцагч	
ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт	Дотуур байр-2 Хүүхэд-232	
Бүртгэгдсэн гэмт хэрэг	61	77
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх,		109
Малчин өрх,	1,101	1,104
Малчдын тоо	1,654	1,704
Малын тоо	307,633	274,557
Хуулийн этгээд, ААН-ын тоо	Сумын хэмжээнд 2023 онд 256 аж ахуйн нэгж байгууллага, 35 үйлдвэрлэл эрхэлж байна.	
Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	103 иргэн худалдаа үйлчилгээний чиглэлээр ажиллаж байна.	
Орон нутгийн төсвийн нийт зарлага	Санхүүгийн дэмжлэгээр 1,125,247.1 мян.төг, ЗДТГ-ын өөрийн орлого 35,900.0 мян.төг, орон нутгийн байгууллагууд 2,057,403 мян.төг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд 1,566,543 мян.төг санхүүжилт тус тус авч, сумын нийт төсвийн гүйцэтгэл 5,161,655.2 мянган төгрөг зарцуулсан.	

18.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХУЖИРТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Хужирт сум нь Илдэн бэйлийн хошууны хэсэг. Автай сайн хааны хүү Бахарай баатар түүний хөвгүүн Цогт хун тайжийн ач Сутай Илдэнгийн албат байжээ. 1725 онд Түшээт хан аймгаас 19 хошуу таслан Сайн ноён хан аймгийг байгуулахад Илдэн бэйлийн хошуу нь Сайн ноён хан аймгийн харьяанд орж Хужирт-Агь сум үүссэн түүхтэй. 1931 онд Халуун-Ус сум нэртэйгээр Архангай аймгийн харьяанд байгуулагдаад 1934 оны 5-р сард Өвөрхангай аймагт шилжин Хужирт сум нэртэй байгуулагдсан.	
Газар зүйн байршил	Архангайн Хотонт, Өвөрхангай аймгийн Хархорин, Есөнзүйл, Өлзийт, Бат өлзий, Зүүнбаян-Улаан сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	6,728	6,568
Нутаг дэвсгэрийн хэмжээ	171,782.0 га	
Сумын төвийн нэр	Хужирт сум	

Засаг захиргааны хуваарь	Өвөрмодот, Уужим, Бэрх, Шивээт, Шунхлай, Дулаан гэсэн 6 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Өндөр Сант, Мойлт, Гуа, Ац, Дулаан, Өвөрмодот, Ханги, Битүүхэй, Мухдаг зэрэг уул нуруу, Орхон, Хужирт, Бургас, Тээл, Харз зэрэг тунгалаг уст голууд, Олон бүрд, Хар бүрд, Бөөрөг зэрэг нуур цөөрмүүд, Үүрт, Шороот, Мойлт, Цувирай, Танхилагт зэрэг халуун рашаан, булгуудтай. Үүртийн тохой, Хүрмэн чулуу, Асгатын энгэр, Хангийн тогоо, Битүүхэй зэрэг байгалийн үзэсгэлэнт сайхан газрууд, Өндөр сант, Дулааны Ёл, Ханги зэрэг сарьдаг өндөрүүдтэй.	
Төрийн албан хаагчдын тоо		263
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	1973	1973
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Төвийн эрчим хүчний системд холбогдсон. Сумын төв дээр 110/35/10 квт-ын 2 дэд станцтай.	
Төрөлтийн тоо	132	113
Нас баралтын тоо	46	52
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 160 хүн	
Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-15 Цуцлалт-4	Гэрлэлт-15 Цуцлалт-5
ЕБС-ийн бүлэг дүүргэлт	42 бүлэг	
ЕБС-ийн сурагч-багшийн тооны харьцаа	98 багш 1,282 суралцагч	
ЕБС-ийн дотуур байрны тоо, дүүргэлт	Дотуур байр-2 Хүүхэд-160	
Бүртгэгдсэн гэмт хэрэг (2021, 2022 он)	21	11
Ажилгүйдлийн түвшин	Суманд бүртгэлтэй ажилгүй 117 иргэн. Нийт ажилгүй иргэдийн 59 хувь нь эмэгтэй. Бүртгэлтэй ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл 21% дээд, 5% тусгай дунд, 49% бүрэн дунд, 19% бүрэн бус дунд, 6% бага буюу боловсролгүй хүмүүс тус тус эзэлж байна. Мөн сумын хэмжээнд албан бусаар хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл 79% нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 3 хувь нь ажил олгогч үлдсэн 18 хувь нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байна.	
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Малчин өрх	1,271	1,270
Малчдын тоо	2,013	2,001
Малын тоо	259,829	247,770
Хуулийн этгээд, ААН-ын тоо 2023-1, 2024-1 улирал	52	59
	Хужирт сумын хэмжээнд нийт үйл ажиллагаа явуулж буй 38 аж ахуй нэгж байгууллага, 6 төсвийн байгууллага, 2 банк, 1 шашны байгууллага, 3 ШТС-тай.	

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	Тус суманд нийт 50 аж ахуй нэгж, байгууллага ажиллаж байгаагаас “Хужирт рашаан сувилал” ХХК, “Жем-Хужирт” ХХК, “Элма-Хужирт” ХХК, зэрэг томоохон аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулж хүрээгээ тэлэн сумын эдийн засгийн бүтцэд томоохон нөлөө үзүүлж байна. Суманд Талх нарийн боовны цех-5, оёдол эсгүүрийн 3, гутал засвар, буриад болон монгол гутал үйлдвэрлэлийн 4, эсгийний үйлдвэрлэлийн 1, гэрийн мод үйлдвэрлэлийн 6, Блок үйлдвэрлэлийн 2, гагнуур төмөр хийц үйлдвэрлэх 3, гэх мэт том жижиг нийлсэн 30 гаруй үйлдвэр цех ажиллаж байна.
Орон нутгийн төсвийн нийт зарлага	Орон нутгийн нийт төсвийн зардал нь 3013.0 сая төгрөг байна. Нийт зардлын 43.2 хувь нь цалин, 4.2 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, 51.4 хувийг урсгал шилжүүлэг, 1.2 хувийг нь бусад зардал эзэлж байна.

19.ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тойм лавлагаа		
Товч түүх	Өлзийт сум нь 1931 онд байгуулагдсан бөгөөд хуучнаар Сайн Ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошууны нутаг. Тус сум нь хангайн нурууны зүүн үргэлжлэл өвөрт тал хээрийн бүсэд оршдог Ханги, Дулаан, Баруун Зүүн Өлзийт хайрхан зэрэг уул нуруудаар тойрсон нутаг. Төхөм, Жороо, Өндөр дэрс, Эхэн, дунд, адгийн цагаан зэрэг уужим тал хөндийтэй Сангийн далай, Зэгстэй, Горхи, Хүйсийн гол, Баруун, зүүн цэгээн, Хойд урд дунд бөөр тойром, Мөрөн, Улаан ам, Их, бага булаг, Яргайтын хайлан, Тахилагт, Асгат зэрэг хүн Малын ундаа болсон нуур тойром, гялтгануур жонш чулуун нүүрс зэрэг ашигт малтмалтай.	
Газар зүйн байршил	Есөн зүйл, Сант, Баян-Өндөр, Зүүнбаян–Улаан, Хужирт зэрэг сумдтай хиллэдэг.	
	2022	2023
Хүн амын тоо	2,252	2,156
Нутаг дэвсгэрийн хэмжээ	196,800 га	
Сумын төвийн нэр	Өлзийт сум	
Засаг захиргааны хуваарь	Борхошуу, Агуйт, Яргайт, Гуулин гэсэн 4 багтай.	
Онцлох байгаль, түүхийн дурсгалт газар	Яргайтын хийд -360 жилийн түүхтэй хийд.	
Төрийн албан хаагчдын тоо		104
Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд		
Өрхийн тоо	728	701
Цахилгааны эх үүсвэртэй өрхийн тоо	Төвийн эрчим хүчний системд холбогдсон.	
Төрөлтийн тоо	31	42
Нас баралтын тоо	15	14
Шилжилт хөдөлгөөн	Шилжин явсан 96 хүн	

Гэрлэлт/цуцлалтын тоо	Гэрлэлт-2 Цуцлалт-2	Гэрлэлт-3 Цуцлалт-0
ЕБС-ийн бүлэг дүүргэлт		
Бүртгэгдсэн гэмт хэрэг (2021, 2022 он)	6	4
Эдийн засгийн үзүүлэлтүүд		
Мал бүхий өрх		
Малчин өрх	650	638
Малчдын тоо	955	897
Малын тоо	188,849	188,301

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Үндэсний статистикийн хороо: <https://www.nso.mn/mn>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://www2.1212.mn>
- Монгол Улсын нийгэм, эдийн засгийн танилцуулга 2019-2023: <https://www.nso.mn/mn/statistic/file-library/view/80622441>
- Архангай аймгийн Статистикийн хэлтэс: <https://arkhangai.nso.mn>
- Баянхонгор аймгийн Статистикийн хэлтэс: <https://bayankhongor.nso.mn>
- Өвөрхангай аймгийн Статистикийн хэлтэс: <https://uvurkhangai.nso.mn>
- Архангай 100: товч түүх, 2023, УБ
- Архангай аймгийн цахим хуудас: <https://arkhangai.gov.mn>
- Баянхонгор аймгийн цахим хуудас: <https://bayanhongor.gov.mn/mn>
- Өвөрхангай аймгийн цахим хуудас: <https://www.uvurkhangai.gov.mn>
- Архангай аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (сар, улирлын бюллетен): https://medee.nso.mn:3005/api/articles/imagesCk/1708591952262-nso-Sariin%20bulleten_12.pdf
- Баянхонгор аймгийн статистикийн бюллетен): <https://medee.nso.mn:3005/api/articles/imagesCk/1705632503285-nso-bulleteni-2023-11.pdf>
- Өвөрхангай аймгийн нийгэм, эдийн засгийн байдал(сар, улирлын бюллетен): [https://medee.nso.mn:3005/api/articles/imagesCk/1705301091603-nso-ST_zagvar_shine%20\(1\).pdf](https://medee.nso.mn:3005/api/articles/imagesCk/1705301091603-nso-ST_zagvar_shine%20(1).pdf)
- Сумдын цахим хуудсууд

БҮЛЭГ II

НИЙГЭМ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ҮНДЭСНИЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР: БУСАД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Г.Алтан-Оч (Ph.D.),
Б.Батцэцэг, Д.Жигваагүнсэл, И.Жаргалзаяабямба,
Р.Оргилмаа, Б.Мөнгөнсүвд*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ОНОЛ, АРГА ЗҮЙ, МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- 1.1. “ЁС ЗҮЙ”-Н ТАЛААРХ ОНОЛ, АРГА ЗҮЙ
- 1.2. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ (“ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР)

ХОЁР. ҮНДЭСНИЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ИРГЭДЭД ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

- 2.1. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС
- 2.2. БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС
- 2.3. ЯПОН УЛС
- 2.4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
- 2.5. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС
- 2.6. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС
- 2.7. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн, УИХ-ын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны даргын захиалгаар “Үндэсний соён гэгээрүүлэх үйл ажиллагаа ба иргэний ёс зүйн хөтөлбөр: бусад орнуудын туршлага” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: Гадаадын зарим орны үндэсний хэмжээний соён гэгээрүүлэх үйл ажиллагаа, иргэний ёс зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, хөтөлбөрүүд болон практик үйл ажиллагааны талаарх туршлагыг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд Сингапур, Эстони, Япон, Солонгос, Казахстан, Энэтхэг, Герман зэрэг улсуудыг хамруулан үндэсний соён гэгээрүүлэх бодлого, тогтолцоо, иргэний ёс зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон холбогдох эрх зүйн зохицуулалт, практик туршлагыг харьцуулан судалсан болно.

Судалгааны бүтэц: Судалгаа нь хураангуй болон үндсэн хоёр хэсэгтэй бөгөөд үндсэн хэсгийн эхний хэсэгт ёс зүйн талаарх онол, арга зүй болон Монгол Улс дахь иргэний ёс зүйн боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар авч үзсэн бол дараагийн хэсэгт үндэсний соён гэгээрүүлэх үйл ажиллагаа ба иргэний ёс зүйн хөтөлбөрийн талаарх бусад орнуудын туршлагыг оруулав.

Түлхүүр үг: Үндэсний соён гэгээрүүлэх хөтөлбөр, иргэний ёс зүйн хөтөлбөр, сургуулийн ёс зүйн хөтөлбөр

Key words: national enlightenment program, citizen ethics program, school ethics curriculum

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Хүний нийгмийн амьдрал нь өөрийн оршихуй болох зан суртахуунаар тодорхойлогддог. Тийм учраас зан суртахууны асуудал нь түүхийн аль ч цаг үед нийгмийн янз бүрийн анги, бүлэг, эрдэмтэн мэргэдийн анхаарлын төвд судлагдан иржээ.

Платоноос эхлээд Карл Маркс хүртэлх олон философичид ёс зүйг сайн сайхан амьдралын үзэл баримтлалын үндэс болгож, хувь хүний эрүүл хөгжлийн онолыг боловсруулж ирсэн. Эдгээр философичдын гол үзэл санаагаар жинхэнэ сайн сайхан амьдралд хүрэх зам нь хүний дотоодод орших, сайтар зохион байгуулагдсан, эрүүл саруул сэтгэхүйг бүрдүүлэх явдал байв. Эдгээр үзэл санааг өнөөдөр ч гэсэн философич, сэтгэл зүйчид судалсаар, хөгжүүлсээр байна.

Судалгаанд авагдсан Сингапур, Эстони, Япон, Солонгос, Казакстан, Энэтхэг, Герман зэрэг улсуудын бүх нийтийг соён гэгээрүүлэх бодлого ба энэ хүрээнд хэрэгжүүлж буй иргэдэд чиглэсэн ёс зүйн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, эрх зүйн орчин болон практик туршлагыг судлан үзэхэд тухайн улс орны түүхэн уламжлал, онцлог байдал, одоогийн хөгжлийн түвшин зэрэгтэй нягт холбоотой, хэрэгжүүлэх арга барил нь дээрхээс хамааран харилцан адилгүй байна.

Нийтлэг байдлаар авч үзвэл, судалгаанд авагдсан орнуудад бүх нийтийг соён гэгээрүүлэх хөтөлбөр болон иргэдэд олгох ёс зүйн боловсролыг бага, балчир наснаас нь буюу бага, дунд боловсролын шатнаас эхлэн системтэйгээр олгож байна. Энэ үйл ажиллагааг тухайн улсын засгийн газар, холбогдох яам, агентлаг, сургалтын байгууллагууд хариуцан хэрэгжүүлж байгаа бөгөөд иргэний нийгмийн байгууллагууд ч мөн энэ үйл хэрэгт хувь нэмрээ оруулан хамтран ажиллаж байна.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

Судалгаанаас үзэхэд, Япон, Энэтхэг зэрэг эртний соёл, иргэншилтэй, өөрийн гэсэн өвөрмөц ёс уламжлалтай орнуудын хувьд тухайн үндэстний өөрсдийн гэсэн ёс зүйн зарчим, шашин, зан заншлын болон эрх зүйн системтэй уялдуулсан бодлоготой байгаа бол Эстони, Сингапур зэрэг улсуудад тухайн улсын иргэнийг төлөвшүүлэх, ёс зүйн чиг баримжаа олгох үйл ажиллагааг сургалтын тусгайлсан хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлдэг байна.

Тухайлбал, Өмнөд Солонгос Улсад иргэний боловсролын асуудлыг нийт 120 гаруй хууль тогтоомжоор зохицуулж байгаа бөгөөд эдгээрээс *Насан туршийн боловсролын тухай хууль*, *Сургуулийн өмнөх боловсролын*

тухай хууль, Бага, дунд сургуулийн боловсролын тухай хууль гэх мэт гол гол хууль тогтоомжоор бүх нийтийн суурь боловсрол, иргэнийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохицуулж байна.

Монгол Улсын хувьд Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр батлагдаж улмаар өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын сургуулийн сурагчид 2019-2020 оны хичээлийн жилээс судалж эхэлсэн байна. **“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр** нь Монгол Улсын “Үндсэн хууль”, “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой бөгөөд Монгол Улсад амар амгалан, хүмүүнлэг нийгмийг бүтээх, сургууль, анги хамт олон, гэр бүлд эелдэг найрсаг уур амьсгал бүрдүүлэх, сурагчдад ёс зүйн боловсрол олгоход чухал ач холбогдолтой гэж үзжээ.

(Судалгааны үр дүнгийн харьцуулалтыг *Хүснэгт 1-ээс үзнэ үү.*)

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын хөтөлбөр ба тогтолцооны талаарх харьцуулсан хүснэгт

Улс	Хөтөлбөр	Тогтолцоо
Сингапур	<p>“Ёс зүй, иргэний боловсрол” (Civics and Moral Education) сургалтын хөтөлбөр нь “Үнэт зүйлийг хэвшүүлэх” (Values in Action) буюу “Нийгэм дэх аас үндэсний хэмжээнд ард иргэдээ соён хувь хүний оролцоо хөтөлбөр” (Community Involvement Programme) болон “Үнэт зүйлийг төлөвшүүлэх” (Values in Practice) зэрэг дэд хөтөлбөрүүдийг багтаадаг байна.</p> <p>Иргэншлийн сургалтын хөтөлбөр (Singapore Citizenship Journey) нь жил бүр зохион байгуулдаг байна. Сургалтаар Сингапурт суурьшихаар зорин ирсэн хүмүүст тус улсын түүх, хөгжлийн гол үе шатууд, Сингапурчуудын нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэн олгохын сацуу тухайн орон нутгийнхаа аж байдалтай танилцах, дасан зохицоход нь тусалдаг байна. Сургалт нь цахим сургалтын модулиуд, туршлага судлах хөтөлбөр, олон нийттэй харилцах гэсэн хэсгүүдээс бүрддэг. Сургалтын төгсгөлд албан ёсны арга хэмжээ зохион байгуулан, сургалтад хамрагдагсдыг Сингапур Улсын иргэн болсныг албан ёсоор мэдэгдэн, Иргэний бүртгэлийн үнэмлэх (National Registration Identity Card)-ийг гардуулдаг байна.</p> <p>“Иргэний боловсрол”-ыг дунд сургуулийн дунд, ахлах ангиудад албан ёсоор заавал судлах хичээлд оруулан тодорхойлж, 1998 онд Насан туршийн боловсролын стратегийг боловсруулан, ёс зүй, иргэний боловсролыг өргөн хүрээнд хүртээмжтэй олгох нөхцөлийг бүрдүүлжээ. Улмаар Насан туршийн боловсролын стратеги нь 2020 онд хэрэгжиж дууссан бөгөөд одоо түүний хэрэгжилтийн үнэлгээнд суурилан боловсруулсан “Боловсролын стратеги 2021-2035”-ийг хэрэгжүүлж байна. Энэ нь бүх түвшний боловсролын хөгжлийг тодорхойлохоос гадна ардчилсан, ёс зүйтэй, Эстони Улсын иргэнийг төлөвшүүлэх бодлогыг агуулсан өргөн хүрээтэй шинэ зорилтыг дэвшүүлсэн байна.</p> <p>Нийгмийн болон иргэний боловсролын үндэсний хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлт</p> <p>Эстони хамгийн анхны сургалтын үндэсний хөтөлбөрт (1996) “Иргэний боловсрол” хичээлээр заах маш өргөн хүрээтэй сэдвүүдийн жагсаалтыг тусгасан байдаг.</p>	<p>Боловсролын яам (Ministry of Education)-аас үндэсний хэмжээнд ард иргэдээ соён гэгээрүүлэх, ёс зүйн боловсрол олгох, хүмүүнлэг, идэвхтэй, оролцоотой иргэн бэлтгэх, үндэсний үнэт зүйлээ өвлүүлэн хадгалуулах зорилгоор “Ёс зүй, иргэний боловсрол хөтөлбөр” (Character and Citizenship programme)-ийг бага наснаас нь Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрөөр олгодог байна. Тус хөтөлбөр нь “Иргэний болон ёс суртахууны боловсрол”, “Үндэсний боловсрол” болон сургуулийн танхимаас гадуур хүүхэд бүрийн заавал хамрагдах боловсролын хөтөлбөрүүдээс бүрдсэн сургалтын цогц хөтөлбөрийг хэлнэ.</p> <p>2001 онд Тарту их сургуулийн философийн факультетын бүрэлдэхүүнд “Ёс зүйн төв”-ийг салбар хоорондын уялдаа холбоог судлах зорилгоор байгуулж, улмаар 2009 онд концерцум болгон өргөжүүлсэн. Тус төв нь эхлээд их дээд сургуулиудын нийгмийн болон иргэний боловсрол, ёс зүйн хичээлүүдийн агуулгыг тодорхойлох, энэ чиглэлээр лекц, гарын авлагыг бэлтгэх зэргээр хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байсан бол 2009 оноос олон нийтэд зориулсан танин мэдэхүйн үйл ажиллагаа, сургалт, салбар мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, ёс зүйн хичээл, сургалтын багш нарыг бэлтгэх ажлыг тус тус явуулдаг болсон.</p>

	<p>Энэхүү сургалтын үндэсний хөтөлбөрийг хичээл хоорондын уялдаа холбоог Ирэгний боловсролд чиглүүлэх, ардчилсан ёсонд суурилсан сургуулийн ач холбогдлыг чухалчлах зорилгоор 2002 онд шинэчлэн боловсруулжээ.</p> <p>Харин 2011 оны хөтөлбөрийн шинэчлэлээр дунд сургуулийн дунд болон ахлах ангиудад заах хичээлийн хөтөлбөрийг тодорхой ялган боловсруулах гэх зэргээр сургалтын хэт их ачааллын асуудлыг шийдвэрлэхийг оролдсон.</p> <p>Улмаар нийгмийн болон иргэний үр чадвар хэмээх хэт ерөнхий үр чадварын сургалтыг практик амьдралын ач холбогдол бүхий агуулгаар солих үүднээс 2014 оны хөтөлбөр шинэчлэлтийг дахин хийсэн байна. Үүнд иргэний үр чадварыг Европын боловсрол, сургалтаар олгох гол түлхүүр үр чадварууд гэх зэргээр Европын Холбооны бодлогын бичиг баримтуудад зааснаар тодорхойлжээ. Ийнхүү урьд өмнөх үндэстэн төвтэй хандлага нь зөөлөрч, дэлхий нийтийн ардчиллын болон Европын үнэ цэнийг эрхэмлэх хандлага нь нэлээд өссөн байна.</p> <p>Японд 1890 онд Эзэн хааны боловсролын тухай гаргасан зарлигаас эхлээд Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Нийгмийн боловсролын тухай хууль зэрэгт ёс зүй, ёс суртахууны талаар нарийвчлан тусгаж өгчээ.</p> <p>Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө 2023 он (Basic Plan for the Promotion of Education) Нийгмийн боловсролд чиглэсэн асуудлаар энэ удаагийн төлөвлөгөөнд:</p> <ul style="list-style-type: none"> • Тогтвортой нийгмийг дэмжих – Ирээдүйн нийгэм бүтээгчдийн санаачлагатай байдал, манлайлал, бүтээлч байдал, асуудлыг зөв шийдвэрлэх чадвар, логик сэтгэлгээ, өөрийгөө илэрхийлэх чадвар, үнэт зүйлсээ тодорхойлох чадварыг сайжруулах тал дээр олон ажлыг эрчимжүүлэх • Өв соёлоо дээдлэн сайн сайхан амьдралын хэв маягийг сайжруулах –Эрүүл мэнд, аюулгүй орчин, насан туршийн боловсролыг нийгмийн боловсролоор дамжуулан түгээх гэсэн 2 зорилт тавин шат шатны байгууллагуудад уг зорилтыг хэрэгжүүлэхийг тусгажээ. <p>Япон Улсын хувьд боловсролд оруулсан хувь хөрөнгө оруулалтыг хувь хүнд бус нийгмийн хөгжлийн үндэс гэж үздэг байна. Тиймээс ирээдүйн симбиотик нийгмийг хөгжүүлэх, шинэ үеийн үнэ цэнийг болгох тал дээр маш их анхаарч байна.</p>	
<p>Орчин үеийн боловсролын тогтолцоо үүссэн цагаас “Ёс зүйн хичээл”-ийн хөтөлбөрийг тогтвортой баримталж, гэр бүл, сургууль, нийгмийн орчинд нэгдмэл байдлаар тусгаж ирсэн.</p> <p>Ерөнхий боловсролын сургуульд ёс суртахууны хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.</p> <ol style="list-style-type: none"> 1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах; 2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга харилцах, хүмүүстэй эелдэг харилцах; 3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх; 4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх. 		

<p>Солонгос</p>	<p>Солонгос Улсад иргэдийн ёс зүй, боловсролын асуудлыг Үндсэн хуулиас гадна нийт 120 гаруй хууль тогтоомжоор зохицуулдаг бөгөөд эдгээрээс дараах хууль тогтоомж болон бусад хуулиар бүх нийтийн суурь боловсрол, иргэдийг соён гэгээрүүлэх арга хэмжээг Насан туршийн боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд сургуулийн боловсролын тухай хууль гэх мэт гол хууль тогтоомжоор зохицуулж байна.</p> <p>БНСУ-ын анхны бие даан баталсан Ёс зүй, ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд цаг үе, нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.</p> <p>2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэсний ондоошил) гэх олголт их орсон байна. 7-10 дугаар ангийн ёс зүйн хичээлийн сурах бичгийн агуулгад дараах 4 хүрээг хамруулсан байна.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хувийн амьдрал; 2. Гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал; 3. Нийгмийн амьдрал; 4. Үндэсний болон хамт олны амьдрал 	<p>Боловсролын тогтолцоо</p> <p>БНСУ-ын боловсролын систем нь бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль, их, дээд сургууль, мэргэжлийн дээд сургууль гэсэн тогтолцоотой байдаг бөгөөд дараах байдлаар суралцах жил, хичээлийн хөтөлбөрийг зохицуулсан байдаг.</p> <ul style="list-style-type: none"> • Бага сургууль – 6 жил • Дунд сургууль – 3 жил • Ахлах сургууль – 3 жил <p>Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10 дугаар анги)-ийн үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12 дугаар анги)-д сурагчид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.</p>
<p>Казахстан</p>	<p>Казахстан Улсын хувьд ёс зүйн үндсийг Аль-Фарабигийн гурвалжингаар тайлбарладаг бөгөөд “үнэнч зан чанар”, “шударга ёс”, “цэвэр сэтгэл” гэх гурван хэсгээс бүрддэг байна. Энэ гурван зүйл хүн бүрд байх ёстой гэж үздэг.</p> <p>Эрдэмтэн Аль-Фарабигийн “Их хотын оршин суугчид” хэмээх зохиолд ёс суртахууны үндэс болсон 12 шинж чанарыг “Оюунлаг үндэстэн-2020” хөтөлбөртэй уялдуулж, оюутан, сурагчдын хөгжлийг төлөвшүүлэх, сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх, үзэл санаатай нийцүүлдэг байна.</p> <p>Казахстан Улсын хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөр хэрэгжүүлдэг.</p> <p>Хөтөлбөрийг Казахстан Улсын боловсролын системд нэвтрүүлснээр “Өөрийгөө танин мэдэх” хичээлийн хөтөлбөрийг бий болгож, 2010 оноос эхлэн хэрэгжүүлсэн.</p> <p>Хөтөлбөрийн зорилго нь хүний дотоод ертөнцийг нээснээр зөв боловсон хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, эрхэм дээд чанарт сургах, амьдрах чадвар болон боломжийг хөгжүүлэхэд оршино. Түүнчлэн бодол санаа, үг яриа, үйл хөдлөлөө зөв уялдуулах, ямар ч асуудлыг өөрийн болон бусдын тусын тулд оновчтой шийдэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хүндэтгэх чадварыг эзэмшүүлэх зорилготой.</p>	<p>Бүгд Найрамдах Казахстан Улсын Боловсролын яам (Ministry of Education of Republic of Kazakhstan) нь төрийн нэгдсэн бодлогоор иргэн бүрийг чанартай боловсрол эзэмших эрхээр хангах бөгөөд Боловсролын тухай хууль (Law of on Education), Улсын боловсролын дагаж мөрдөх стандарт (State Mandatory Standards of Education)-ыг үндэслэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Үндэсний хэмжээнд ёс суртахуун, оюун ухааны боловсролын “Өөрийгөө танин мэдэх” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.</p>

<p>Энэтхэг</p>	<p>Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE)- Энэ хөтөлбөр нь Дээрхийн Гэгэнтэн XIV Далай Ламай айлдсан нийтээр мөрдөх ёс суртахууны үзэл баримтлал дээр үндэслэсэн хөтөлбөр юм. Хөтөлбөрийн хүрээнд байгууллага болон олон нийтийн орчинд хүүхэд, залуучуудад зориулсан ёс зүйн сургалтыг боловсруулан хэрэгжүүлдэг. Хамрах хүрээний хувьд хүүхэд (4-14 насны хүүхдэд), багш, эцэг эх, олон нийтийн байгууллага зэрэг хүрээнд явагддаг.</p> <p>Иргэний дүрэм- Тус дүрэм нь төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, стандартын талаарх үүрэг болон иргэдийн ёс зүй, ёс суртахууны талаарх харилцан ойлголцлын баримт бичиг юм.</p> <p>Гандигийн ёс зүй- Махатма Гандигийн төрсөн өдөр буюу 10 дугаар сарын 02-ны өдрийг Энэтхэгийн ард түмэн үндэсний баяр болгон тэмдэглэж, Гандигийн сургаал, зарчим, номлолыг хойч үедээ дэлгэрүүлэн түгээдэг байна. Гандигийн 11 зарчим өнөөдөр ч Энэтхэг гэлтгүй дэлхий даяар олон сая хүмүүсийг чиглүүлж, урам зориг өгсөөр байна.</p>	<p>Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE) Энэ хөтөлбөр нь 2014 онд боловсруулагдаж эхэлсэн бөгөөд 2017 онд дунд ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бол 2018 онд орон нутгийн сургуулиудад, 2019 онд бага ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна. Энэ хөтөлбөрийг засгийн газраас дэмжиж, хэрэгжүүлдэг.</p> <p>Иргэний дүрэм- Энэхүү дүрмийн үзэл баримтлалын анх Их Британид 1991 онд үндэсний хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн бөгөөд 1997 онд Энэтхэгийн засгийн газар засгийн газрын хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн байна.</p>
<p>Герман</p>	<p>Дотоод сэтгэлийн боловсролыг олгох тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм хэдийгээр байхгүй ч ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт ёс зүй, ёс суртахуун болон зан суртахуун ба иргэний боловсролын хичээлийн агуулгад тусгагдсан гэж үзэж болохоор байна. Дээрх хичээлүүд нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, залуучуудын ёс суртахууны ухамсар, ёс суртахууны зан байдлыг хөгжүүлэхэд чиглэж байна.</p>	



СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ОНОЛ, АРГА ЗҮЙ, МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

1.1. “ЁС ЗҮЙ”-Н ТАЛААРХ ОНОЛ, АРГА ЗҮЙ

Хүний нийгмийн амьдрал нь өөрийн оршихуй болсон зан суртахуунаар тодорхойлогддог. Тийм учраас зан суртахууны асуудал нь түүхийн аль ч цаг үед нийгмийн янз бүрийн анги бүлэг, эрдэмтэн мэргэдийн анхаарлын төвд судлагдан иржээ.

Зан суртахууны тухай мэдлэг эртнээс үүсэж хөгжсөн бөгөөд түүнийг “ёс зүй”-н ухаан судалдаг байна. Ёс зүй нь эртний грекийн “ethos” гэдэг үгнээс гаралтай байна. Энэ нь анх “хамтран амьдрах байр, аж төрөх” гэсэн утгатай байсан бөгөөд сүүлдээ хүмүүсийн амьдралын ямар нэг үзэгдэл, ёс заншил, зан суртахуун, зан төлөв, сэтгэлгээний хэв маяг гэсэн ойлголтыг өгөх болсон билээ.

Ёс зүйн тухай мэдэгдэж байгаар эртний Грек, Ромын сэтгэгчид болох Демократ, Сократ, Платон, Аристотелийн үе (НТӨ V-II зуун)-ээс судлагдаж эхлээд эртний Энэтхэг, Хятадын үзэл, сургаалаар дамжиж дундад зууны үеийн шашны ёс зүйгээр нөхцөлдөж, орчин үеийн ёс зүйн зарчим, онолын арга зүй бүрджээ.

Орчин үеийн ёс зүйн ойлголт

18-р зууны Германы философич И.Кант шинжлэх ухааныг өөрийнхөө протестант хүмүүжлийн зан суртахууны хатуу шаардлагын зарчимтай зохицуулж, зан суртахууны үндсэн зарчмуудыг учир зүйн хувьд үндэслэхийг оролдсон. Философичид ёс зүйн тухай ярихдаа үнэн хэрэгтээ бие биенээсээ огт ондоо гурван асуудлыг гаргаж тавьдаг. Энэ нь:

1. Би өөрийнхөө зан суртахууны зарчмыг үнэн зөв гэдэгт хэрхэн итгэж үнэмших ёстой вэ?
2. Зан суртахууны үүднээс үзэхэд их хүнд хэцүү асуудлыг хэрхэн шийдвэрлэж болох вэ?
3. Хэрхэн сайн сайхан амьдарч болох вэ?

Кант ямар ч нөхцөлд бүх хүний хувьд туйлын бүрэн зөв зарчим болох Категорик императив гэж нэрлэгдсэн зан суртахууны зарчмыг гаргаж хэрэглэсэн. Харин ийм түгээмэл үйлчилдэг зарчим байна гэдгийг ёс зүйн релятивизм болон ёс зүйн скепицизм хоёр үгүйсгэдэг. Хүнд хэцүү тохиолдлыг шийдвэрлэхийн тулд утилитаризмын төлөөлөгчид болох Иеремия Бентам, Жон Стюарт Милль нар хамгийн их олон хүмүүст хамгийн Их Аз Жаргал өгөх зарчмыг гаргаж ирсэн. Утилитаризм бол зан суртахууны ба орчин үеийн философийн хамгийн их маргаантай онолын нэг мөн юм.

Платаноос эхлээд Карл Маркс хүртэлх олон философичид сайн сайхан амьдралын үзэл баримтлалын үндэс болгож хувь хүний эрүүл хөгжлийн онолыг боловсруулж байсан. Эдгээр философичдын гол үзэл санаа бол жинхэнэ сайн сайхан амьдралд хүрэх зам нь хүний дотоодод сайн зохион байгуулагдсан, эрүүл саруул сэтгэцийг бүрдүүлэх явдал байв. Энэ үзэл санаануудыг өнөөдөр ч гэсэн философич, сэтгэл зүйчид судалсаар байна.

1.2. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ (“ИРГЭНИЙ ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР)

Монгол Улсын Засгийн газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр батлагдаж, улмаар 2019-2020 оны хичээлийн жилээс өмчийн хэлбэр үл харгалзан ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчдад хэрэгжиж эхэлсэн байна.

“Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр нь Монгол Улсын “Үндсэн хууль”, “Бага, дунд боловсролын тухай хууль”-ийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах үндсэн зорилготой бөгөөд Монгол Улсад амар амгалан, хүмүүнлэг нийгмийг бүтээх, сургууль, анги хамт олон, гэр бүлд эелдэг найрсаг уур амьсгал бүрдүүлэх, сурагчдад ёс зүйн боловсрол эзэмшүүлэх чухал ач холбогдолтой.

Иргэний ёс зүйн боловсрол хичээлийг бага ангид нийт 320 цаг, дунд ангид нийт 264 цаг, ахлах ангид нийт 198 цаг орохоор сургалтын төлөвлөгөө батлагдан хэрэгжиж байна.⁸⁰

Сургалтын хөтөлбөрийн зарчим, зорилго, зорилт

Зарчим: Сургалтын хөтөлбөрийг бага ангийн сурагч монгол хүн болж төлөвших суурь мэдлэг, чадвар, дадал эзэмших; дунд ангийн сурагч монгол иргэн болж хүмүүжих; ахлах ангийн сурагч эх орныхоо эзэн (монгол хүн) болж төлөвших зарчим баримтлан, сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлж, агуулга, арга зүй, үнэлгээг боловсруулсан байна. Үүнд:

- Монголын уламжлалт өв соёлын мөн чанарыг танин мэдэж, түүнээс суралцах, амьдралдаа хэрэгжүүлэхэд хөтлөх;
- Монгол хүний амьдралын бодит байдлыг судлах;
- Агуулга нь ёс зүй, ёс суртахууны талаарх ухагдахуун, ойлголтоос бүрдэх төдий биш, ёс зүйн боловсрол эзэмших арга ухааныг өөрөө бүтээхэд чиглэх;

⁸⁰ <https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/Curriculum/EBS/iregnii-yos-zui-1-5-angi.pdf> “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, удирдамж

- Сурагчийн нас, сэтгэцийн онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;
- Ихийг гүехэн биш, багыг гүнзгий судлах;
- Анги ахих тусам өргөжин гүнзгийрэх;
- Залгамж холбоог сайтар хангах зэрэг болно.

Зорилго: Сургалтыг хүнлэг энэрэнгүй, цэвэр ариун сэтгэлтэй, билэг оюун төгөлдөр, уламжлалт ёс заншил, ахуйгаа таньж мэдсэн, хүндэлж хамгаалдаг, монгол үндэстнийхээ хэл, соёл, ёс заншлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, бие, хэл, сэтгэлээрээ сайн үйл хийдэг, эх орон, улс үндэстнээ эрхэмлэн дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан, хүмүүнлэг нийгмийг цогцлоон байгуулах ирээдүйн монгол иргэнийг бэлтгэхэд оршино.

Зорилт:

- Сурагч ёс зүйн хэм хэмжээг танин мэдэж, ёс суртахууныг эзэмших
- Уламжлалт сурган хүмүүжүүлэх ухааны арга, аргачлалын учир утгыг танин мэдэж, сурч судлах үйлдээ мөрдөх;
- Өөрийн гэсэн зөв үзэл бодолтой болж, түүндээ тууштай байж, үзэл бодлоо баталж нотолж чаддаг байх;
- Бие, хэл, сэтгэлээр үйлдэх сайн үйлийг зуршил болгож, муу үйлийг цээрлэн жигших;
- Хүмүүнлэг нийгмийг бүтээн байгуулахыг эрмэлзэх, хүн, нийгэм, байгаль орчинтой зөв харилцах, нийгмийн үйл хэрэгт ухаалгаар, идэвхтэй оролцох;
- Бусад хүнийг болон төр улс, эх орон, хүн төрөлхтнийг хүндлэхийн учир утгыг ойлгож, ухааран хүндлэх;
- Амьдралын зорилгоо зөв тодорхойлж, түүнд зөв аргаар хүрэх, бие даан амьдрах арга ухаанд суралцах;
- Сурч судлах, хөдөлмөрлөх, бүтээх үйлд шамдах, чин сэтгэлээсээ хандах;
- Гэр бүл, анги хамт олон, бусад хүний болон нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа сайтар ухамсарлах;
- Асуудлыг ёс суртахууны хувьд зөв, оновчтой шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулах үүргээ ухамсарлаж, зорилго нэгтэй, эв эетэй байж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах, улмаар дэлхийд байр сууриа эзлэх иргэн болж хүмүүжих;
- Айх, ичих ухамсартай, ичгүүр сонжууртай байх;
- Санаа бодлоо нээлттэй илэрхийлж, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
- Хойч үеийнхээ өмнө хүлээх үүрэг, хариуцлагаа гүн тогтсон хэв ёс, заншил, төрийн хууль, дэг журмыг баримталдаг иргэн болж төлөвших.

ХОЁР. ҮНДЭСНИЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ИРГЭДЭД ЁС ЗҮЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

2.1. БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛС

Сингапур Улсын Боловсролын яам (Ministry of Education)-аас үндэсний хэмжээнд ард иргэдээ соён гэгээрүүлэх, ёс зүйн боловсрол олгох, хүмүүнлэг, идэвхтэй, оролцоотой иргэн бэлтгэх, үндэсний үнэт зүйлээ өвлүүлэн хадгалуулах зорилгоор “Ёс зүй, иргэний боловсрол хөтөлбөр” (Character and Citizenship programme)-ийг бага наснаас нь Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрөөр олгодог байна. Тус хөтөлбөр нь “Иргэний болон ёс суртахууны боловсрол”, “Үндэсний боловсрол” болон сургуулийн танхимаас гадуур хүүхэд бүрийн заавал хамрагдах боловсролын хөтөлбөрүүдээс бүрдсэн сургалтын цогц хөтөлбөрийг хэлнэ.⁸¹

Соёл, олон нийт, залуучуудын яам (Ministry of Culture, Community and Youth), Үндэсний нэгдмэл байдлын зөвлөл (National Integration Council), Ард түмний нийгэмлэг (People’s Association) болон Сингапур Улсын цагаачлал, шалган нэвтрүүлэх газар хамтран Сингапур Улс руу цагаачлан ирсэн иргэдийг Сингапур Улсын түүх, соёл, үнэт зүйлс, ёс суртахуун, нийгмийн өмнө хүлээх үүрэг, хариуцлага зэрэг иргэн бүрийн зайлшгүй мэдвэл зохих агуулгыг багтаасан сургалт, хөтөлбөрт тодорхой заасан хугацаагаар заавал хамруулдаг байна.

Сингапур Улс нь үндэснийхээ үнэт зүйлийг хүүхэд багачууддаа өвлүүлэх, хүнлэг, энэрэнгүй, ёс суртахуунтай иргэдийг хүмүүжүүлэх зорилгоор 1950-аад оны сүүл үеэс ёс зүйн албадан боловсролыг иргэний, ёс зүйн, шашны боловсролоор дамжуулан олгож эхэлсэн байна.

“Иргэний болон ёс суртахууны боловсрол” хөтөлбөр

1992 оноос Боловсролын яамнаас “Иргэний болон ёс суртахууны боловсрол” (Civics and Moral Education) ёс зүйн боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг боловсруулан, Ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдад зааж эхэлсэн байна. Тус шинэчлэгдсэн хөтөлбөр нь иргэний боловсролд илүүтэй анхаарч дараах 5 үнэт зүйлийг тодорхойлон, хөтөлбөртөө багтаасан. Үүнд, олон нийтийн аливаа асуудлыг өөрийн асуудлын өмнө тавих, гэр бүлийг нийгмийн үндсэн тулгуур гэж үзэх, хувь хүний эрхийг хүндэтгэн үзэж, олон нийтээс дэмжлэг үзүүлэх, асуудлыг зөрчилдөх бус зөвшилцлийн аргаар шийдвэрлэх, арьс өнгө, шашин шүтлэгээр ялгаварлахгүй байх зэрэг болно.

⁸¹ <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=99663443-930d-418e-b010-4718d0ad7543>

“Үндэсний боловсрол” хөтөлбөр

Сингапурын бусад улс үндэстнээс ялгарах онцлог, тус улсын түүхэн замнал, ололт амжилт болон анхаарах асуудлууд, Сингапур Улсын үнэт зүйлсийн нэгт тооцогддог шатлан дэвших шударга зарчим, үндэстэн ястнуудын таарамж, нийцэл зэргийг хүүхэд, багачуудад зааж сургах, танин мэдүүлэх замаар үндэсний нэгдмэл байдал, түүний ач холбогдлын талаар сургах, төлөвшүүлэх зорилготой “Үндэсний боловсрол” (National Education)⁸² хөтөлбөрийг 1997 оноос эхлүүлсэн байна. Тус хөтөлбөрийг мөн Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгох болжээ. “Үндэсний боловсрол” хөтөлбөр нь сургалтын олон төрлийн үйл ажиллагааг хамарсан, дараах зорилготой:

- Хүүхэд багачуудад Сингапур Улсын түүх, өнөөгийн хүрсэн түвшин, ололт амжилт, бахархал, үндэстний хувьд тулгарч буй сорилыг танин мэдүүлэх, цаашид оршин тогтнох, итгэл үнэмшлийг төлөвшүүлэх, мэдлэгтэй, ур чадвартай иргэн бэлтгэх;
- Өөртөө итгэлтэй, хүсэл эрмэлзэлтэй, нийгмийн талаар мэдрэмжтэй, аливаа асуудлыг олон талаас нь тунгаан бодох, орон нутаг, бүс, дэлхий нийтийн асуудлаар мэдлэг, мэдээлэлтэй иргэдийг хүмүүжүүлэх;
- Хүүхэд, багачуудад Сингапурчуудын үндэсний онцлогийг судлах, танин мэдэх, ойр дотнынхондоо тусалж дэмжих, өөрсдийн амьдарч буй орчин, цаашлаад нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах замаар цаашдын зорилгоо тодорхойлоход нь туслах зэрэг болно.

Сургуулийн танхимаас гадуур хамрагдах хөтөлбөр

Эрүүл чийрэг, спортлог, эх оронч, хүнлэг, тусч, чадвартай иргэн бэлтгэх зорилго бүхий Сургуулийн танхимаас гадуур олгох, заавал хамрагдах боловсролын хөтөлбөр (Co-curricular activities)⁸³ - үүдийг тухайн сургуулийн хүүхдүүдийн хүсэл, сонирхлыг харгалзан клуб, дугуйлан хэлбэрээр зохион байгуулж, хэрэгжүүлдэг байна. Үүнд, урлаг, спорт, дүрслэх урлагийн дугуйлангууд болон дүрэмт хувцас бүхий холбоод (uniformed groups) багтдаг байна. Ерөнхий боловсролын дунд сургуулиудын хэмжээнд 9 томоохон дүрэмт хувцас бүхий холбоод үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Хөвгүүдийн бүлэг, Охидын бүлэг, Охидын хөтөч, Үндэсний цэргийн бэлтгэл сургууль, Үндэсний цагдаагийн бэлтгэл сургууль, Иргэний батлан хамгаалах бэлтгэл сургууль, Өсвөрийн Улаан загалмай, Скаутууд болон Гэгээн Жоны нэрэмжит Түргэн тусламжийн баг зэрэг болно. Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийг дэмжих зөвлөл (Health Promotion Board)-өөс хүүхдүүдийн эрүүл амьдралын хэв маягийг дэмжих зорилгоор

⁸² <https://www.moe.gov.sg/education-in-sg/our-programmes/national-education>

⁸³ <https://www.nib.gov.sg/main/article-detail?cmsuuid=fa092bc5-6339-4c60-beb2-b6355d6027cc>

Эрүүл мэндийг дэмжих клуб (Health Promotion Club)-ыг Канберра дунд сургууль дээр санаачлан, эхлүүлсэн байна.

Сурагчид өөрсдийн сонирхлоор сонгон, нэг буюу түүнээс дээш заавал хамрагдах шаардлагатай эдгээр хөтөлбөрүүдийг 1995 оноос урамшууллын оноо (bonus)-той болгосон бөгөөд Өсвөрийн коллеж (Junior college) болон Политехникийн коллежид элсэн суралцахад тус оноог харгалзан үздэг байна. Түүнчлэн 2003 оноос Сингапур Улсын Үндэсний Их Сургууль (National University of Singapore) болон Нанянг Технологийн Их Сургууль нь тус тус Өсвөрийн коллеж болон Политехникийн коллежид суралцагсад, армид алба хаагчдын дээрх үнэлгээг элсэлтийн шалгууртаа харгалзан үзэхээр шийдвэрлэсэн байна.

Сурагчдын бүх талын хөгжилд тус хөтөлбөрийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, сурагчдын тасралтгүй оролцоо, хүчин чармайлтыг үнэлэн 2003 оноос тус хөтөлбөрийг үнэлгээтэй болгосон байна. Дунд сургуулийн сурагчид манлайлал, сайжруулалт, амжилт, оролцоо, хэрэглээ гэсэн 5 чиглэлээр дүгнүүлэх болсон байна. Ингэснээр сурагчид анги хоорондын, сургуулийн доторх, түүнчлэн сургуулиас гадуур олон төрлийн арга хэмжээнд идэвхтэй хамрагдах болжээ.

Академик хичээлийн хажуугаар олгох эдгээр сургалт хүмүүжлийн хөтөлбөрүүдийг заах дасгалжуулагч багш нарыг 2015 оны 01 дүгээр сараас Боловсролын яаман дээр бүртгэх болсон. Ингэснээр сургуулиуд тодорхой сургалтыг заах, шаардлагатай ур чадвар бүхий багш нарын мэдээллийг олж авах албан ёсны эх сурвалжтай болсон байна.

“Ёс зүй, иргэний боловсрол” хөтөлбөр

“Иргэний болон ёс суртахууны боловсрол”, “Үндэсний боловсрол” болон Сургуулийн танхимаас гадуур олгох боловсролын хөтөлбөрүүдийг нэгтгэн, хувьсан өөрчлөгдөж буй дэлхийд залуу Сингапурчуудыг бэлтгэх зорилго бүхий “Ёс зүй, иргэний боловсрол” цогц хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан байна. Ерөнхий боловсролын сургуулийн бага болон дунд ангид 2014 оноос, ахлах ангийн сурагчдад 2016 оноос тус тус зааж эхэлжээ.

“Ёс зүй, иргэний боловсрол” сургалтын хөтөлбөр нь “Үнэт зүйлийг хэвшүүлэх” (Values in Action) буюу “Нийгэм дэх хувь хүний оролцоо хөтөлбөр” (Community Involvement Programme)⁸⁴ болон “Үнэт зүйлийг төлөвшүүлэх” (Values in Practice) зэрэг дэд хөтөлбөрүүдийг багтаадаг байна.

⁸⁴ <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuiid=c78526c6-decf-4b79-b4ca-421739464884>

“Үнэт зүйлийг хэвшүүлэх” - “Нийгэм дэх хувь хүний оролцоо” хөтөлбөрийг нийгмийн тайван амгалан, нэгдмэл байдал, үүнд иргэн хүний хүлээх үүрэг хариуцлагыг сурагчдад төлөвшүүлэх зорилготой эхлүүлжээ. Хүүхэд багачуудад тухайн газар нутаг, нийгэм, улс орныхоо нэг хэсэг болох, түүнчлэн үүрэг, хариуцлагатай байх зэргийг сургуулийн болон харьяа нутаг дэвсгэрийн нийтийг хамарсан, сайн үйлсийн аянд идэвхтэй оролцуулах, туршлага суулгах арга барилаар олгодог байна. Тус хөтөлбөрт Ерөнхий боловсролын сургуулийн бүх ангийн сурагчид жил бүр 6-аас доошгүй цаг заавал хамрагдах ёстой бөгөөд бага, дунд сургуульд 10 жил суралцахад доод тал нь 60 цагийн сайн үйлсийн аянд хамрагдсан байдаг байна.

Насны бүлгээс хамаарч хүүхдүүд өөр ажлуудад хамрагдах бөгөөд бага ангийн хүүхдүүд бүлэг болон нэг нэгэндээ хичээл заах, мод, цэцэг тарих, ургуулах, сургуулийн орчинд хөнгөн ажил гүйцэтгэх, гар урлал хийж, түүнийгээ борлуулан хуримтлалын санд хандивладаг байна. Дунд ангийн хүүхдүүд нийтийн номын сан, хүүхэд болон ахмад настны асрамжийн газрууд, харилцан туслалцах бүлгүүдэд туслах ажил хийх, цэцэрлэгт хүрээлэн, далайн эргийн наран шарлагын газар зэрэг нийтийн эзэмшлийн газруудыг цэвэрлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна. Ахлах ангийн сурагчид бага, дунд ангийн сурагчдад бүлгээр ажиллах, анги танхимаас гадуурх үйл ажиллагаанд нь туслах, удирдан чиглүүлэх, манлайлах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэдэг байна. 2005 оноос ахлах ангийн сурагчдын сайн үйлсийн аянд заавал хамрагдах цагийг нэмэгдүүлсэн байна. Сурагчид сайн үйлсийн аянд хэрхэн хамрагдсан талаарх үйл явц, үнэлгээний тэмдэглэлийг хөтөлдөг байна.

“Үнэт зүйлийг төлөвшүүлэх”⁸⁵ бага ангийн хүүхдүүдэд зориулсан цахим хөтөлбөрийг 2016 оноос эхлэн хэрэгжүүлсэн бөгөөд хүүхдүүдэд багаас нь эргэн тойрны хүмүүстээ халамж, анхаарал тавих, туслах, талархлаа илэрхийлж байх, хүндлэх, нэгдмэл байх, хариуцлагатай байх зэрэг хүний үнэт зан чанаруудыг ойлгуулах, төлөвшүүлэх зорилготой. Тус хөтөлбөрт Боловсролын яамны зөвшөөрөл бүхий цахим хичээл, тоглоом, хүүхэлдэйн кино, хэвлэн авах боломжтой ном, товхимлыг ашигладаг байна. Эдгээр сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг Англи, Мандарин, Малай, Тамил гэсэн 4 хэл дээр авч, ашиглах боломжтой.

Бага ангийн хүүхдүүдэд хүний эрхэм зан чанарын талаар бяцхан түүхээр дамжуулан ойлгуулах, “хэрэв тэгвэл” гэсэн хувилбаруудаар хэлэлцүүлэх, үлгэр дуурайл авах хүний талаар ярилцах, хүрээлэн буй орчиндоо сайн үйлс хийж байх зэрэг ёс суртахууны хүмүүжлийг олгох, хүний үнэт зан чанарыг багаас нь төлөвшүүлэх тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

⁸⁵ <https://values-in-practice.com/>

Сингапур Улсын иргэншлийн хөтөлбөр⁸⁶

Соёл, олон нийт, залуучуудын яам (Ministry of Culture, Community and Youth), Үндэсний нэгдмэл байдлын зөвлөл (National Integration Council), Ард түмний нийгэмлэг (People’s Association) болон Сингапур Улсын цагаачлал, шалган нэвтрүүлэх газар хамтран Сингапур Улсад амьдрахаар цагаачлан ирсэн иргэдэд зориулан Сингапур Улсын түүх, соёл, үнэт зүйл, иргэн хүний хүлээх үүрэг, хариуцлага зэрэг иргэн бүрийн мэдэж байвал зохих мэдлэг, мэдээллийг багтаасан 2 сарын хугацаатай, заавал хамрагдах Сингапур Улсын иргэншлийн хөтөлбөр (Singapore Citizenship Journey) сургалтыг жил бүр зохион байгуулдаг байна. Сургалтаар Сингапур Улсад суурьшихаар зорин ирсэн хүмүүст тус улсын түүх, хөгжлийн гол үе шатууд, Сингапурчуудын нийгмийн хэм хэмжээ, үнэт зүйлсийн талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэн олгохын сацуу тухайн орон нутгийнхаа аж байдалтай танилцах, дасан зохицоход нь тусалдаг байна. Сургалт нь цахим сургалтын модулиуд, туршлага судлах хөтөлбөр, олон нийттэй харилцах гэсэн хэсгүүдээс бүрддэг. Сургалтын төгсгөлд албан ёсны арга хэмжээ зохион байгуулан, сургалтад хамрагдагсдыг Сингапур Улсын иргэн болсныг албан ёсоор мэдэгдэн, Иргэний бүртгэлийн үнэмлэх (National Registration Identity Card)-ийг гардуулдаг байна.

Жилд ойролцоогоор 13.000-16.000 цагаач иргэд энэхүү хөтөлбөрт хамрагддаг бөгөөд 65% гаруй нь 14-65 насны иргэд, эдгээрээс 60% гаруй нь Зүүн өмнөд Азийн орнуудаас цагаачлан ирэгсэд байна.

2020 онд Сингапур Улсын иргэдийн олон талын төлөөлөл бүхий ажлын хэсгийг байгуулан, юу биднийг Сингапур үндэстэн болгодог, Сингапур улсын иргэн болохоор зорин ирж буй хүмүүс бидний бүтээсэн нийгмийн талаар юуг мэдвэл зохих вэ гэсэн нэгдмэл ойлголтод хүрэхийн тулд 7 сар гаруй хугацаанд судлан, хэлэлцэж, тус хөтөлбөрийн агуулгыг шинэчлэн “Сингапурт тавтай морил” гарын авлагыг боловсруулсан байна. Гарын авлагад шинэ иргэдэд зориулсан анхан шатны буюу амьдрах орон байр, ажил, сургууль, эрүүл мэнд, нийгмийн халамж, банк санхүүгийн үйлчилгээнээс эхлээд Сингапур хүмүүсийн амьдралын хэв маяг, Сингапур улсын түүх, үнэт зүйл, үндэсний бэлгэ тэмдэг, засаг захиргааны зохион байгуулалт, иргэн хүний хүлээх үүрэг буюу улс орноо батлан хамгаалах, олон үндэстний ёс заншлыг хүндэтгэх, нийгэмд хувь нэмрээ оруулах, сонгуульд саналаа өгөх, түүнчлэн Сингапур Улсын ирээдүйн зорилго, урт хугацааны төлөвлөлтийн талаар болон яаралтай тусламжийн газруудтай хэрхэн холбогдох зэрэг зайлшгүй мэдвэл зохих мэдээллийг товч, тодорхой байдлаар багтаасан байна.⁸⁷

⁸⁶ <https://www.sjjourney.gov.sg/>

⁸⁷ <https://www.sjjourney.gov.sg/pdfs/welcome-to-singapore/>

2.2. БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС

Эстони Улсад үндэсний хэмжээнд нийгмийг соён гэгээрүүлэх гэдэг нь боловсролын бүх түвшинд иргэний боловсролыг олгох, нийгмийн ёс зүйг төлөвшүүлэх, үндэсний үнэт зүйлийг таниулан сургах, бие хүнийг төлөвшүүлэх, насан туршийн боловсрол олгох үйл явц юм. Үүнийг сургалтын үндэсний хөтөлбөрүүд, нийгмийн болон иргэний боловсролын үндэсний хөтөлбөр, насан туршийн боловсролын стратеги, боловсролын стратегийн хүрээнд явуулж байна.

*Иргэний боловсрол ба нөхцөл байдал*⁸⁸

Тус улс 1991 онд ЗХУ задарсны дараа тусгаар тогтнолоо сэргээж, тоталитар дэглэмээс ардчилсан тогтолцоо руу шилжих эрс шинэчлэлийг эхлүүлсэн байдаг.

Энэ нь тухайн улсад баримталж ирсэн үнэт зүйлийн тогтолцоо задарч, ард иргэд үнэт зүйлийн баримжаагаа алдсантай холбоотойгоор үндэсний уламжлалт үнэт зүйлсээ олон ургальч, ардчилсан тогтолцоонд нийцүүлэн сэргээж боловсруулах, хөгжүүлэх, улмаар түүнийг олон нийтэд таниулан сургах цогц ажлыг хийх шаардлагатай болсон.

Дээрх нөхцөл байдал нь тухайн үеийн социалист нийгмийн тогтолцооноос ардчилсан нийгмийн тогтолцоо руу шилжиж байсан бүх улс оронд тулгамдсан нийтлэг сорилт, асуудал байсан юм.

Энэ шинэчлэлийн хүрээнд нэн тэргүүнд боловсролын шинэчлэлийг явуулж, үндэсний сургалтын хөтөлбөр, нийгмийн болон иргэний боловсролын хөтөлбөрийг боловсруулсан нь тус улсын зүгээс дээрх сорилтыг даван туулах эхний чухал алхам байжээ. Энэ нь Эстони Улсын орчин үеийн үндэсний боловсролын бодлого, үзэл санааны суурь үндсийг тавьсан гэж үздэг.

Зөвлөлт маягийн “коммунист интернационализмыг глобалчлах” чиг баримжаатай иргэний боловсрол, түүх, соёл, хэлний сургалтын хөтөлбөрийг орчин үеийн үзэл санаа болон эстони үндэсний онцлогт нийцүүлэн боловсруулж 1996 оноос бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлж эхэлсэн. Тухайн цаг үед Эстонид орос хэл, эстони хэлний асуудлаас болж соёлын ялгаа ихээхэн үүсдэг байв.

Сургалтын үндэсний хөтөлбөр нь хүүхэд, залууст нийгмийн үнэт зүйлс, үндэсний хэл, соёл, түүх, иргэний боловсролын мэдлэг олгох, соёлын ялгаатай байдлыг арилгах, соён гэгээрүүлэхэд чухал ач холбогдолтой

⁸⁸ https://link.springer.com/content/pdf/10.1007/978-3-030-71102-3_7.pdf

байжээ. Орон нутгийн сонгуульд санал өгөх иргэдийн насыг 16 болгосон нь хүүхдүүдэд, ялангуяа энэ насны хүүхдүүд суралцдаг 9 дүгээр ангид Иргэний боловсролын хичээлийг нарийвчлан заах, мөн орос хэлтэй хүүхэд, залуусыг эстони хэл соёлд сургах нэг үндсэн шаардлага нөхцөл болсон. Үүнд ёс зүйг иргэний боловсролын агуулгад хамааруулж байв. Уг хөтөлбөрийн үндсэн хэсэгт боловсролын үндсэн үнэ цэн болон сургууль боловсролын шатлалыг, харин дэд хэсэгт нь албан ёсоор заавал судлах хичээл тус бүрийн агуулга хөтөлбөрийг тодорхойлсон байна.

Бага дунд шатны иргэний боловсролын гол зорилго нь нийгмийн анхан шатны мэдлэг, нийгмийн үндсэн ур чадварыг нийгэмд олгох явдал байв. Дунд шатны иргэний боловсролын хөтөлбөр нь улс төрийн институци, түүний үндсэн хуулийн дэг журмын талаарх мэдлэгийг хангахад чиглэгдсэн байдаг бол бүрэн дунд түвшинд эдийн засаг, нийгэм, улс төрийн үйл явцын нь хувьд ертөнцийг харилцан уялдаатай бүхэл бүтэн цогц байдлаар ойлгохыг зорьсон байдаг.

Сургалтын үндэсний хөтөлбөр, нийгмийн болон иргэний боловсролын үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр тус улсын үзэл санааны хандлагад асар их өөрчлөлт орсон ч энэ нь боловсролын байгууллагын хичээл, сургалтад суурилсан уламжлалт бүтцийг хадгалсан хэвээр байгаа нь дэвшүүлж буй үндэсний хэмжээний зорилгыг хэрэгжүүлэхэд хангалтгүй, хязгаарлагдмал шинжтэй байна гэж үзсэн тул “иргэний боловсрол”-ыг дунд сургуулийн дунд, ахлах ангиудад албан ёсоор заавал судлах хичээлд оруулан тодорхойлж, 1998 онд Насан туршийн боловсролын стратегийг боловсруулан, ёс зүй, иргэний боловсролыг өргөн хүрээнд хүртээмжтэй олгох нөхцөлийг бүрдүүлжээ. Улмаар Насан туршийн боловсролын стратеги нь 2020 онд хэрэгжиж дууссан бөгөөд одоо түүний хэрэгжилтийн үнэлгээнд суурилан боловсруулсан “Боловсролын стратеги 2021-2035”-ийг⁸⁹ хэрэгжүүлж байна. Энэ нь бүх түвшний боловсролын хөгжлийг тодорхойлохоос гадна ардчилсан, ёс зүйтэй, Эстони Улсын иргэнийг төлөвшүүлэх бодлогыг агуулсан өргөн хүрээтэй шинэ зорилтийг дэвшүүлсэн байна.⁹⁰

Мөн 2001 онд Тарту их сургуулийн Философийн факультетийн бүрэлдэхүүнд “Ёс зүйн төв”-ийг салбар хоорондын уялдаа холбоог судлах зорилгоор байгуулж, улмаар 2009 онд концерцум болгон өргөжүүлсэн. Тус төв нь эхлээд их дээд сургуулиудын нийгмийн болон иргэний боловсрол, ёс зүйн хичээлүүдийн агуулгыг тодорхойлох, энэ чиглэлээр лекц, гарын авлагыг бэлтгэх зэргээр хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байсан бол 2009 оноос олон нийтэд зориулсан танин мэдэхүйн үйл ажиллагаа, сургалт, салбар мэргэжлийн ёс зүйн дүрмийг боловсруулах, судалгаа, дүн шинжилгээ хийх, ёс зүйн хичээл, сургалтын багш нарыг бэлтгэх ажлыг тус тус явуулдаг болсон.

⁸⁹ https://www.educationestonia.org/wp-content/uploads/2022/12/haridusvaldkonna_arengukava_2035_kinnittaud_vv_eng_0-1.pdf

⁹⁰ <https://www.educationestonia.org/innovation/>

Нийгмийн болон иргэний боловсролын үндэсний хөтөлбөрийн өөрчлөлт, шинэчлэлт⁹¹

Эстоний хамгийн анхны сургалтын үндэсний хөтөлбөрт (1996) “Иргэний боловсрол” хичээлээр заах маш өргөн хүрээтэй сэдвүүдийн жагсаалтыг тусгасан байдаг. Үүнд логик, үндсэн хууль, ардчиллын зарчмууд, нийгмийн бүтэц, эдийн засаг багтсан байна. Энэ нь тогтолцооны өөрчлөлт, шилжилтийн үед иргэний боловсролын олон зорилго, зорилтыг бүрэн хангах үүднээс философи, хууль, эдийн засаг, иргэний мэдлэг боловсролыг нэгтгэн хослуулахыг зорьсон. Гэсэн хэдий ч багш нарт зориулсан заах арга зүйн тодорхой гарын авлага байсангүй. Тиймээс багш нарын ном, сурах бичгийн дутагдалтай байдлыг арилгах үүднээс 1996 оны үндэсний хөтөлбөрийг эш үндэс болгосон хамгийн анхны сурах бичгийг 1997 онд хэвлүүлжээ.

Энэхүү сургалтын үндэсний хөтөлбөрийг хичээл хоорондын уялдаа холбоог Иргэний боловсролд чиглүүлэх, ардчилсан ёсонд суурилсан сургуулийн ач холбогдлыг чухалчлах зорилгоор 2002 онд шинэчлэн боловсруулжээ.

Эцэг эхчүүд, сурагч оюутнууд, багш нарын зүгээс хэтэрхий олон төрлийн хичээлийн улмаас сурагчид хэт их ачаалалтай байна гэсэн санал гомдлыг илэрхийлэх болсон, мөн мэргэжлийн байгууллагуудын зүгээс хичээл хоорондын уялдаа холбоо муу, “бодит амьдрал”-аас хэтэрхий хол, хөндий байна гэх шүүмжлэлүүд гарах болсонтой холбоотойгоор “Үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулах асуудал 2005-2006 оны үед дахин хөндөгдсөн байдаг. Эдгээр шүүмжлэл нь Нийгмийн болон иргэний боловсролын хөтөлбөрт мөн хамааралтай байв. Гэсэн ч тухайн үеийн шинэчлэх оролдлогыг дорвитой сайн өөрчлөлт болгохооргүй байна гэж үзжээ. Учир нь хөтөлбөрийг өөрчлөх хуулийн төсөлд нийгмийн ухааны хичээлүүдийг сэтгэл судлал, эрүүл мэндийн боловсролтой механикаар холбон нэгтгэсэн, хичээлийн зарим чухал сэдвийг учир үндэслэл муутайгаар хассан гэх зэрэг дутагдал их байв.

Харин 2011 оны хөтөлбөрийн шинэчлэлээр дунд сургуулийн дунд болон ахлах ангиудад заах хичээлийн хөтөлбөрийг тодорхой ялган боловсруулах гэх зэргээр сургалтын хэт их ачааллын асуудлыг шийдвэрлэхийг оролдсон. Гол үндэслэл нь дунд ангийн хүүхдэд зориулсан иргэний боловсролын хичээлийн агуулга нь нийгмийн бодит асуудлуудтай нягт холбогдсон, өсвөр үеийнхнийг идэвхтэй иргэн болж төлөвшин хүмүүжихэд нь бэлтгэдэг байх ёстой гэж үзэж байв. 2009 оны ICCS (International Civic and Citizenship Education Study-Олон улсын нийгмийн болон иргэний боловсрол судлал)-ийн нөлөөгөөр “нийгэм судлал”-ын хичээлийн нэрийг “иргэний боловсрол” болгон өөрчилжээ.

⁹¹ https://link.springer.com/content/pdf/10.1007/978-3-030-71102-3_7.pdf

Улмаар нийгмийн болон иргэний ур чадвар хэмээх хэт ерөнхий ур чадварын сургалтыг практик амьдралын ач холбогдол бүхий агуулгаар солих үүднээс 2014 оны хөтөлбөр шинэчлэлтийг дахин хийсэн байна. Үүнд иргэний ур чадварыг Европын боловсрол, сургалтаар олгох гол түлхүүр ур чадварууд гэх зэргээр Европын Холбооны бодлогын бичиг баримтуудад зааснаар тодорхойлжээ. Ийнхүү урьд өмнөх үндэстэн төвтэй хандлага нь зөөлөрч, дэлхий нийтийн ардчиллын болон Европын үнэ цэнийг эрхэмлэх хандлага нь нэлээд өссөн байна.

2014 онд шинэчлэн боловсруулсан хөтөлбөрт сургалтын үр дүнг гурван түвшинд тодорхойлсон. Үүнд: Ерөнхий ур чадвар, нийгмийн ухааны салбар тус бүрийн ур чадварууд, иргэний боловсролын сэдэв тус бүрээс эзэмших ур чадварууд багтжээ.

Ерөнхий түвшинд, суралцагчийн эзэмшвэл зохих нийгмийн болон иргэний ур чадварыг тодорхойлохдоо: “өөрийгөө улс нийгмийнхээ ардчилсан хөгжлийг дэмждэг, мэдээлэл сайтай, үүрэг хариуцлагатай иргэний ёсоор аж төрөгч хүмүүн болгон төлөвшүүлэх ур чадвартай; нийгмийн үнэ цэн болон хэм хэмжээг мэддэг бөгөөд даган мөрддөг, нийгмийн аливаа өөр орчны дүрэм журам, нийгэм, шашин, үндэстэн угсаатаны олон янз байдлыг хүндэтгэдэг; янз бүрийн нөхцөл байдалд бусад хүмүүстай хамтран ажилладаг; хүмүүсийн хоорондын ялгааг хүлээн зөвшөөрч, ойлгодог байх” гэжээ.

Нийгэм судлалын ухааны салбарт, сургалт болон сурах үйл ажиллагааны зорилго нь “нийгмийн аливаа өөрчлөлтийн шалтгаан ба үр дагаврыг ойлгох чадвар; хүний эрх ба ардчиллын талаар мэдлэгтэй байх, тэдгээрийг хүндэтгэдэг байх; иргэний эрх, үүргийн талаар мэдлэгтэй, үүний дагуу өөрийн үйлдлээ хянан зохицуулах чадвартай байх; соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрөх чадвартай байх; биеэ авч явах нийтийн ёс, журмыг даган мөрдөх чадвартай байх; нутаг орон, үндэстэн, төр ба дэлхий нийтээрээ хөгжих явдлыг эрхэмлэдэг байх; өөрийн гэсэн үзэл бодолтой, идэвхтэй бөгөөд хариуцлагатай иргэн байх; нийгмийн талаар судлан үзэхдээ судалгаа шинжилгээний энгийн арга, аргачлалуудыг ашиглах мэдлэг, чадвартай байх; хүрээлэн буй байгаль дэлхийгээ эрхэмлэдэг байх зэрэг нийгмийн ур чадваруудыг суралцагчдын насанд нь тохируулан эзэмшүүлэх”-д оршино гэжээ.

Иргэний боловсролын хичээлийг судалсны үр дүнд сурагчид дараах чадварыг эзэмшинэ. Үүнд: “нийгэмдээ идэвхтэй амьдардаг, хариуцлагатай шийдвэр гаргадаг иргэн болоход шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэ цэн, хандлага зэрэг нийгэмд амьдрах ёс, журмыг танин мэдэж, эзэмшинэ”. Иргэний боловсролын хичээлийг 6 дугаар ангид жилд 35 цаг, 8, 9 дүгээр ангиудад жилд 70 цаг зааж байна.

Ихэнх сургуулиудад иргэний боловсрол хичээлийг 15-16 насны хүүхдүүд суралцдаг 9 дүгээр ангид нь голчлон зааж байна. Учир нь 9 дүгээр анги бол заавал эзэмших боловсрол, сургалтын хамгийн сүүлчийн жил байдаг байна.

Үндэсний өв, соёл, иргэний боловсролыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдал⁹²

Суурь сургуулийн үндэсний хөтөлбөр (*National curriculum for basic schools*)-т үндэсний соёлын өв уламжлал, ёс суртахуун, иргэний боловсролтой холбоотой асуудлыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

2 дугаар зүйлд суурь боловсролын үндсэн үнэт зүйлсийг тодорхойлсон ба 2.3-т Сургалтын хөтөлбөрт чухал гэж тооцсон үнэт зүйлс нь Эстоний Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Европын холбооны суурь баримт бичгүүдэд заасан ёс зүйн зарчмуудаас үүдэлтэй байна.

Хувь хүний нийтлэг үнэт зүйлс (үнэнч, энэрэнгүй байх, шударга ёс, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх) болон нийгмийн үнэт зүйлс (эрх чөлөө, ардчилал, эх хэл, соёлыг хүндэтгэх, эх оронч үзэл, соёлын ялгаатай байдлыг хүндэтгэх, байгаль орчны тогтвортой байдал, хууль дээдлэх ёс, үүрэг хариуцлага болон жендерийн эрх тэгш байдал) нь боловсролын үндсэн үнэт зүйлс байна. Хөтөлбөрийн 2.4-т Эстоний соёлын уламжлал, Европын нийтлэг үнэт зүйлс, дэлхийн соёл, шинжлэх ухааны ололт амжилтыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр өсвөр үе, хүүхэд залуучуудын нийгэмших үйл ажиллагаа явагдана. Чанартай суурь боловсрол эзэмшсэн хүмүүс нийгэмд дасан зохицох чадвартай байж, Эстоний нийгэм, соёл, эдийн засаг, экологийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах болно гэж тус тус заасан байна.

3-р зүйлд Суурь сургуулийн зорилтуудыг тодорхойлсон ба 3.7-д Эстоний сургуулиуд нь Эстони үндэстэн, хэл, соёлыг хамгаалж, хөгжүүлэх үүргийг хүлээсэн учир суурь сургуульд эстони хэлийг судлахад онцгой анхаарна гэж заасан.

4-р зүйлд Сурагчдад ямар чадамж эзэмшүүлэх талаар заасан ба 4.3.1-д соёл, үнэт зүйлсийг үнэлэх чадамж нь хүмүүс хоорондын харилцаа, үйл ажиллагааг нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээний хүрээнд/үүднээс үнэлэх; бусад хүмүүс, нийгэм, байгаль орчин, өөрийн орны болон бусад улсын соёлын өвтэй холбоотой харилцааг мэдэрч, үнэлэх; гоо зүйн мэдрэмжтэй болж, үнэлэх; хүний болон нийгмийн ерөнхий

⁹² Гадаадын зарим орны бага, дунд боловсролын тогтолцоо ба үндэсний өв соёлыг сургалтын агуулга, хөтөлбөрт тусгасан байдлын талаарх харьцуулсан судалгаа (СТ-18/210), УИХТГ-ын ПССХ.

үнэт зүйлсийг үнэлэх, хүн төрөлхтөн, соёл, байгалийн олон янз байдлыг үнэлэх, өөрийн үнэт зүйлийг тодорхойлох зэрэг болно.

11-р зүйлд сургалтын 3 дугаар шатанд (7-9-р анги) эзэмших чадваруудыг тодорхойлсон ба 11.11-д өөрийгөө бүтээлч байдлаар илэрхийлж, урлаг, соёлын өвийг хүндэтгэх гэж заасан.

14-р зүйлд хичээл хоорондын уялдаа холбоог тодорхойлсон ба 14.4-т соёлын ижилсэл нь сурагчийг соёлын талаарх мэдлэгтэй болгож, хүний үзэл бодол, зан байдалд үзүүлэх соёлын нөлөөг ойлгодог, соёлын түүхэн өөрчлөлтүүдийг мэддэг, соёлын олон янз байдал, хүний амьдралын хэв маяг дахь соёл, зан заншлын нөлөөг ойлгож, үндэсний соёл, соёлын олон янз байдлыг хүндэтгэж, соёлын тэвчээртэй байж хамтран ажиллахад бэлэн байхад чиглэгдэнэ гэж тодорхойлсон байна.

Дээрхээс үзвэл, суралцагчдыг багаас нь нийгмийн үнэт зүйл, үндэсний өв соёл, ёс зүй хүмүүжил, иргэний боловсролтой иргэн болгон бэлтгэхэд анхаарч байна.

Ёс зүйн төвийн үйл ажиллагаа

Ёс зүйн төв нь анх 2001 онд Тарту их сургуулийн Философийн факультетийн бүрэлдэхүүнд салбар хоорондын ухаан судлалын нэгж хэлбэрээр байгуулагдаж, улмаар 2009 оноос концерцумын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулах болжээ.

Төвийн үйл ажиллагаанд оролцогч факультетууд нь: урлаг ба хүмүүнлэгийн факультет, нийгмийн шинжлэх ухааны факультет, анагаах ухааны факультет, шинжлэх ухаан, технологийн факультет.

Төвийн удирдах дээд байгууллага нь дээр дурдсан факультетууд болон оюутны төлөөллөөс бүрдсэн гишүүд бүхий удирдах зөвлөл байна. Тус төв нь бас олон улсын хандивлагчдын зөвлөлтэй.

Төвийн зорилго нь:

- Шинжлэх ухаан, нийгэм, эрдэм шинжилгээний ажилтай холбогдох ёс зүйн асуудлуудын талаар салбар хоорондоо судалгааг зохион байгуулах;
- Олон нийтийн лекц яриа, уулзалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар Эстонийн нийгэм дэх хэм хэмжээ, үнэ цэн, шударга ёсны асуудлуудыг гүнзгийрүүлэн судлах;
- Тарту их сургуулийн ёс зүйн сургалтыг удирдан сайжруулж, ёс зүйн чиглэлийн ном зохиол, судалгааны бүтээл туурвих, эмхэтгэх, хэвлэн нийтлүүлэх;

Тус төв нь олон нийтэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг явуулна. Төвийн нэг гол зорилго нь нийгмийн ёс зүйн ухамсарыг дээшлүүлэх, үнэ цэн болон хэм хэмжээний талаарх яриа хэлэцүүлэгт олон нийтийг өргөнөөр оролцуулах явдал байдаг. Төв нь эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах замаар нийгмийн ач холбогдол бүхий олон чухал асуудлыг олон нийтийн хүрээнд хөндөн гаргаж тавьдаг. Тухайлбал, Ёс зүйн төв нь жил бүрийн 12 дугаар сард “Нийтлэг үнэ цэнийн эрэлд” нэрт цуврал эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулдаг байна. Энэ хурлаар өөр бусад улс орны үнэ цэнийн боловсролын туршлагын талаар судлан үздэг ажээ.

Олон нийтэд чиглэсэн үндсэн үйл ажиллагаа:

- “Эстониин нийгэмд үнэ цэнийг хөгжүүлэх нь, 2009-2013” үндэсний хөтөлбөрийг Эстони Улсын боловсрол, эрдэм шинжилгээний яамтай хамтран хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөр нь хоёр удаа шинэчлэгдсэн ба одоогийнх нь 2021-2026 оны хооронд хэрэгжихээр байна.
- Ёс зүйн төвийн санал санаачилга, ЮНЕСКО, Боловсрол, эрдэм шинжилгээний яам, Нийгмийн асуудал хариуцсан яам, Тарту их сургуулийн дэмжлэгтэйгээр интернет сүлжээнд Ethicsweb –“Ёс зүйн цахим хуудас” нээн ажиллуулж байна. Энэ нь ёс зүйн дата өгөгдлийн баазын үүргийг гүйцэтгэдэг. Ёс зүйн энэ цахим хуудсаараа ёс зүйтэй холбогдох ном хэвлэл, хууль журам, сургалт, кэйс судалгаа, ёс зүйн кодууд, ёс зүйн хороод, ёс зүйн сургалт, судалгаа эрхэлдэг байгууллагуудын мэдээллийг цуглуулах боломжтой. Харин форум хэлэлцүүлгээр хүмүүс ёс зүйн асуудал, үнэ цэн, үнэт зүйлийн асуудлыг хөндөн ярилцдаг.
- Ёс зүйн төв нь мөн хууль тогтоох үйл явцад ёс зүйн дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэнэ. Энэ төрлийн хамгийн өндөр төсөвтэй судалгаа нь Эстони Улсын Нийгмийн асуудал хариуцсан яамны захиалгаар хийсэн “Эрүүл мэндийн цахим түүх” төсөл байжээ.
- Төв нь Эстониин Био-ёсзүйн зөвлөл ([Estonian Council on Bioethics](#)), Нийгмийн асуудал хариуцсан яамны дэргэдэх Эрүүл мэндийн мэдээллийн системийн ёс зүйн хороо, Тарту их сургуулийн Хүний асуудлын судалгааны хороо, мөн Тарту их сургуулийн Эмнэлгийн ёс зүйн хороо зэрэг байгууллагуудтай байнгын хамтын ажиллагаатай ажилладаг.
- Төв нь бусад их сургууль, байгууллагуудтай хамтран ёс зүйн судалгаа шинжилгээний ажлын чиглэлээр төрөл бүрийн сургалт, семинарийг зохион байгуулдаг.

Тус төвийн харилцагч нар нь олон нийтийн телевиз, радиогоор яриа, ярилцлагыг тогтмол өгч байна. Мөн төв нь олон нийтэд зориулсан үнэ

цэнэ, үнэт зүйлсийн тухай эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулж, радиогоор нэвтрүүлэхээс гадна олон тооны ном зохиолуудыг уншигч олны гар дээр хүргээд байна.

2.3. ЯПОН УЛС

Япон Улсын хувьд улсаа хөгжүүлнэ гэвэл нийгмийн ёс зүй, хувь хүний ёс суртахууныг сайн дэмжих хэрэгтэй гэж үздэг ард түмэн билээ. Японы хөгжлийн нэг тулгуур болох самурайн ёс зүй, ёс суртахууны системийг дэлхий дахинд Нитобэ Иназо 1900 онд “Бүшидо: Япон Улсын Амин Сүнс” (Bushido: The Soul of Japan) гэх номоороо танилцуулж байжээ.

Япон хүн бүрт байх ёстой 8 цөм ёс суртахуун:

- Зөв байх, зөвийг эрхэмлэх (Righteousness)
- Баатар байх эсвэл зоригтой байх (Heroic Courage)
- Нигүүлсэнгүй байх (Benevolence, Compassion)
- Өөртөө болон өөр хоорондоо хүндэтгэлтэй байх (Respect)
- Зарчмыг баримталдаг, жанжин шугамаасаа хазайхгүй, амласнаа биелүүлдэг байх (Integrity)
- Үндэсний соёл, үнэт зүйлээр бахархах, нэр төрийг нь өндөрт өргөж явах (Honour)
- Үүрэг хариуцлагатай байх, зарчимдаа үнэнч байх (Duty and Loyalty)
- Өөрийн сэтгэлийн хөдлөлөө хянаж чадах (Self-Control)
- Бусад дэд ёс суртахуунууд (хөдөлмөрч, цаг барих зэрэг бидний сайн мэдэх япончуудын зан чанарууд энд багтана)

Хууль эрх зүйн орчин

Япон Улс 1890 онд Эзэн хаан Боловсролын тухай зарлиг гаргасан ба энэхүү зарлигаар зайлшгүй эзэмших шинэ боловсролын тогтолцооны өөрчлөлтөд Японы үнэт зүйлийг гол болгон баримтална гэж тунхагласан байна. Энэ нь үнэнч зүтгэл, ахмадын хүндэл, гэр бүлийн гишүүд, хань ижил, анд нөхөдтэй тогтоосон харилцаа зэрэг ёс суртахууны чанаруудыг чухалчлахыг сануулсан зарлиг байжээ.

Үндсэн хуулийн 26 дугаар зүйлд “Бүх хүн хуульд заасны дагуу өөрийн ур чадварт тохирсон тэгш боловсрол эзэмших эрхтэй. Бүх хүн өөрийн асран хамгаалалтад байгаа хүүхдийг хуульд заасан ерөнхий боловсролтой болгох үүрэгтэй. Заавал эзэмших боловсрол үнэ төлбөргүй байна” гэж заажээ. Үндсэн хуульд заасан энэ бодлогод тулгуурлан 1947 оны 03 дугаар сард Боловсролын суурь хуулийг баталсан бөгөөд тус хуулиар боловсролын салбарт баримтлах дараах дөрвөн зарчмыг дэвшүүлэн тавьсан байна. Үүнд:

- Хүмүүжүүлэх зорилгод тулгуурласан боловсролын бодлого;
- Боловсролын тэнцүү боломж ба хүйсийн тэгш байдал;
- Сургуулийн ардчилсан, үл ялгаварлах тогтолцоо;
- Үнэ төлбөргүй олгох заавал эзэмших боловсролын 6-3 тогтолцоо (6 жилийн бага сургууль, 3 жилийн дунд сургууль).

Мөн хуулиар сургуулийн насны бүх хүүхдэд заавал эзэмших боловсрол буюу 9 жилийн боловсролыг үнэ төлбөргүй олгох, нийгмийн боловсрол, гэр бүлийн боловсрол олгох тухай зохицуулалт, улс төрийн боловсрол, шашны боловсрол олгоход хориглох зарим зохицуулалтыг тус тус тусгасан байна. Мөн үндэсний болон орон нутгийн боловсролыг зүй зохисгүй байдлаар хянахыг хориглосон байна.

Япон Улсын суурь боловсролын тухай хуулиар ёс суртахуун, ёс зүйн боловсролыг заавал эзэмшүүлэх албан боловсрол гэж заасан бөгөөд энэ нь Японы үндэсний өв, соёлтой салшгүй холбоотой юм. Ёс зүйн боловсрол нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх зорилготой юм. Иймд ерөнхий боловсролын сургуульд ёс зүй, ёс суртахууны боловсрол олгоход маш их анхаардаг байна.

Нийгмийн боловсролын тухай хуулийн (Social Education Law)⁹³ зорилт нь төрийн захиргааны болон орон нутгийн захиргааны байгууллагуудын нийгмийн боловсролыг хангах номын сан, музей, олон нийтийн боловсрол олгох танхимаар дамжуулан нийтийг соён гэгээрүүлэх ажлын чиг үүргийг тодорхой болгоход оршино. Тус хуулийн дагуу Kominkan буюу нийгмийн боловсрол олгох байгууллагууд олон нийтийг соён гэгээрүүлэх, ёс зүйн боловсрол олгох төрөл бүрийн үйл ажиллагаа явуулдаг байна. Ойролцоогоор 70,000 гаруй нийгмийн боловсрол олгох байгууллага байна. Тэдгээр байгууллагын төсвийг тухайн орон нутгийн захиргаа төсөв санхүүг хариуцан ажилладаг байна. Тус байгууллагууд ашгийн бус үйл ажиллагаа явуулна.

Номын сан – Номын сангийн тухай хуулиар номын сан нь нийгмийн боловсрол олгох байгууллага мөн гэж заасны дагуу олон нийтийг мэдээллээр хангах томоохон хэрэгсэл болдог.

Музей – Соёлын биет болон биет бус зүйлээр олон нийтийн өв соёлын мэдлэгийг тэлэх, эх оронч үзлийг суулгах, түүх соёлыг түгээн дэлгэрүүлж олон нийтийг соён гэгээрүүлэх үүрэгтэй гэх мэтчилэн чиг үүргийг нь тодорхойлж өгсөн байдаг.

⁹³ Social Education Law <https://www.hurights.or.jp/archives/asiapacific/section1/pdf/Social%20Education%20and%20Kominkan.pdf>

Олон нийтийн боловсрол олгох байгууллага⁹⁴ – Тус байгууллагууд нь боловсролын суурь хуульд зааснаас бусад нийгмийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх олон төрлийн үйл ажиллагаа явуулна.

Боловсролын суурь хуульд хамгийн сүүлд 2006 оны 12 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орсон байх бөгөөд боловсролыг тойрсон асуудал, шинжлэх ухаан, технологийн дэвшил, мэдээллийн дэвшилтэт технологи, хөгширч буй нийгэмд нөлөөлж буй байдал, гэр бүлийн амьдралын хэв маяг, хүүхдийн хүрээлэн буй орчны өөрчлөлт зэрэг олон асуудлууд урган гарснаар зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага тулгарсан байна. Гэхдээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа өмнөх хуулиар тогтоосон нийтлэг зарчим, Японы уламжлал, соёлыг уламжлан үлдээсэн байна. Хуульд заасан боловсролын суурь бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор 2008 оны 07 дугаар сард Засгийн газраас “Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө”-г боловсруулан баталсан. Энэ төлөвлөгөөг 10 жил тутам шинэчлэн боловсруулахаар тогтсон ба уг төлөвлөгөөгөөр дараагийн 10 жилд хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тогтоодог.

Боловсролыг дэмжих үндсэн төлөвлөгөө 2023 он (Basic Plan for the Promotion of Education)⁹⁵

Нийгмийн боловсролд чиглэсэн асуудлаар энэ удаагийн төлөвлөгөөнд:

- Тогтвортой нийгмийг дэмжих – Ирээдүйн нийгэм бүтээгчдийн санаачилгатай байдал, манлайлал, бүтээлч байдал, асуудлыг зөв шийдвэрлэх чадвар, логик сэтгэлгээ, өөрийгөө илэрхийлэх чадвар, үнэт зүйлсээ тодорхойлох чадварыг сайжруулах тал дээр олон ажлыг эрчимжүүлэх;
- Өв соёлоо дээдлэн сайн сайхан амьдралын хэв маягийг сайжруулах – Эрүүл мэнд, аюулгүй орчин, насан туршийн боловсролыг нийгмийн боловсролоор дамжуулан түгээх гэсэн 2 зорилт тавин шат шатны байгууллагуудад уг зорилтыг хэрэгжүүлэхийг тусгажээ.

Япон Улсын хувьд боловсролд оруулсан хувь хөрөнгө оруулалтыг хувь хүнд бус нийгмийн хөгжлийн үндэс гэж үздэг байна. Тиймээс ирээдүйн симбиотик нийгмийг хөгжүүлэх, шинэ үеийн үнэ цэнийг болгох тал дээр маш их анхаардаг.

Бага, дунд боловсролын түвшинд

Бага боловсролыг үндэс суурийг тавихдаа цэцэрлэгийн наснаас эхлэн Япон Улсын иргэн, үнэт зүйлийн мөн чанар, өв соёлыг ойлгуулах

⁹⁴ Educational system practice in Japan https://www.criced.tsukuba.ac.jp/keiei/kyozai_ppe_f3.html#5

⁹⁵ Basic Plan for the Promotion of Education

тал дээр эцэг эхтэй хамтран цогц хөтөлбөрөөр хангаж ажилладаг. Сургуулийн наснаас эхлэн ёс суртахууны хичээлийн мөн цогц хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хичээл орж эхэлнэ.

Ахлах, коллеж, их дээд боловсролын түвшинд

Ёс зүйн хичээлээр “Нийгэмд нээлттэй хөтөлбөр” гэсэн тусгайлсан хөтөлбөрийн хүрээнд ёс суртахууны боловсролыг дэмжин, сурган хүмүүжүүлэх, олон нийтэд тустай соён гэгээрүүлэх төрөл бүрийн ажил хийлгэдэг. Жишээлбэл;

- Амьдралын аюулгүй байдлын боловсрол
- Уламжлал соёлын боловсрол
- Эрүүл мэндийн боловсрол
- Сэтгэлгээ хөгжүүлэх соёл урлагийн боловсрол
- Ёс зүйн боловсрол
- Бие бялдрын хөгжлийн боловсрол гэх мэт олон хөтөлбөрүүд хэрэгждэг байна.

Үүнээс гадна насанд хүрэгчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гадаадын иргэд, цагаач иргэд гэх мэт зорилтот бүлгийн нийгмийн боловсролыг хангах хүрээнд төр болон орон нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд ихээхэн анхаарч ажилладаг.

Боловсролын тогтолцоо

Орчин үеийн боловсролын тогтолцоо үүссэн цагаас “**Ёс зүйн хичээл**”-ийн хөтөлбөрийг тогтвортой баримталж, гэр бүл, сургууль, нийгмийн орчинд нэгдмэл байдлаар тусгаж ирсэн.

Ёс суртахууны хичээлийн үндсэн зорилго нь тухайн сурагч Япон орны үнэт зүйлийг таньж ойлгох, улмаар өөрийн орны соёл, уламжлалыг хадгалах, үнэт зүйлээ өвлүүлэн авч явах иргэнийг төлөвшүүлэх юм. Гэр бүл болон сургууль хоёр хослон нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд оролцдог нь тухайн бүс нутгийн ёс суртахууны боловсролын нэг онцлог болдог байна.

Ерөнхий боловсролын сургуульд **ёс суртахууны** хичээлийг дараах 4 төрлийн агуулгад тулгуурлан заадаг.⁹⁶

1. Өөрийнхөө тухай: Хүн бүр бие даасан байх, өөрсдийн хийж чадах зүйлээ хийх, хэм хэмжээтэй амьдрах;
2. Бусад хүмүүстэй харилцах харилцаа: Хүмүүстэй шударга, эелдэг харилцах;

⁹⁶ Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/educationjapan/pdf/201303MED.pdf>

3. Байгаль, эрхэм дээд зүйлтэй харилцах: Байгалийн гамшиг, байгаль, амьтны ач холбогдлыг мэдрэх;
4. Нийгэм болон бүлгүүдийн тухай: Олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, дүрэм журмаа дагах, амлалтаа биелүүлэх.

Бага ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, амьдрах орчин, хөгжим, зураг, гар урлал, биеийн тамир, гэрийн аж ахуй гэсэн хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** ордог.

Дунд ангийн хичээлийн хөтөлбөрт япон хэл, нийгэм судлал, математик, шинжлэх ухаан, хөгжим, зураг, биеийн тамир, үйлдвэрлэлийн урлаг, гэрийн аж ахуй, **гадаад хэл**, сонгон судлах хичээлүүд багтдаг. Мөн нэмэлтээр **ёс суртахууны хичээл** орно⁹⁷.

Хүснэгт 2. Бага болон дунд ангид судлах хичээлийн цаг

ХИЧЭЭЛИЙН ТӨРӨЛ	АНГИ								
	1	2	3	4	5	6	7	8	9
Япон хэл	272	280	235	235	180	175	140	140	105
Нийгэм судлал	-	-	70	85	90	100	105	105	140
Тоо бодлого	114	155	150	150	150	150	-	-	-
Математик	-	-	-	-	-	-	140	105	140
Шинжлэх ухаан	-	-	70	90	95	95	105	140	140
Амьдрах орчин	102	105	-	-	-	-	-	-	-
Хөгжим	68	70	60	60	50	50	45	35	35
Зураг, гар урлал	68	70	60	60	50	50	-	-	-
Өрхийн эдийн засаг	-	-	-	-	60	55	-	-	-
Биеийн тамир	90	90	90	90	90	90	-	-	-
Уран зураг	-	-	-	-	-	-	45	35	35
Эрүүл мэнд, биеийн тамир	-	-	-	-	-	-	105	105	105
Үйлдвэрлэлийн урлаг, гэрийн урлаг	-	-	-	-	-	-	70	70	35
Гадаад хэл	-	-	-	-	-	-	140	140	140
Ёс суртахуун	34	35	35	35	35	35	35	35	35
Дүгнэлт хичээл	-	-	105	105	110	110	50	70	70
Сонгон судлах хичээл	34	35	35	35	35	35	35	35	35
НИЙТ /ЖИЛД/	782	840	910	945	945	945	1015	1015	1015

2.4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

Бүгд Найрамдах Солонгос Улс нь сургуулийн өмнөх боловсролын бодлого, хөгжлийн өнөөгийн чиг хандлага, хүртээмж, боловсролын салбарын хөгжлөөрөө олон улсад тэргүүлэгч орны нэг юм.

⁹⁷ Japanese educational system <https://www.studyinjapan.go.jp/en/planning/educational-system/>

Ард иргэдийн ёс зүй, соён гэгээрүүлэх үндэсний арга хэмжээнд гэр бүл болон сургууль гол үүрэгтэй байдаг ба энэ хоёр орчин хослон нийтлэг үнэт зүйлсийг төлөвшүүлэх, хөгжүүлэхэд оролцдог нь тухайн бүс нутгийн ёс суртахууны боловсролын нэг онцлог болдог байна.

БНСУ нь бусад улс орноос ялгарах гол ялгаа нь сайн иргэнийг бий болгох төлөвшүүлэхдээ дан ганц сургуулийн боловсролд анхаарах биш гэр бүлийн суурь хүмүүжлээр иргэдээ соён гэгээрүүлж, төлөвшүүлдэг. Иймд сургуульд ёс суртахууны боловсролыг холбогдох хөтөлбөрийн хүрээнд олгосон ч гэр бүлд мөн адил ёс суртахууны ойлголт, ухагдахуун байхгүй, гэр бүл, эцэг эхийн оролцоогүй бол төдийлөн үр дүнд хүрч чаддаггүй гэж үзэх нь элбэг байдаг. Учир нь гэр бүл буюу хүүхдийн ахуй орчин хүний ёс суртахууны төлөвшлийн суурь нь болдог гэж үздэгтэй холбоотой байна. БНСУ нь 51.7 сая хүн амтай⁹⁸ бөгөөд 24-35 насны хүмүүсийн 70 хувь нь дээд боловсролтой байгаа нь тус улсын ерөнхий боловсролын чанарын түвшнийг харуулж байна.

БНСУ нь сургалтын хөтөлбөрийг нийгэмд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдуулан хэрэгцээ, шаардлага болон шинээр гарч ирж буй мэдлэгийн салбар зэрэгтэй уялдуулан шинэчлэн боловсруулах бөгөөд тус улс сургалтын хөтөлбөрөө нийт 7 удаа шинэчилсэн байна. Хамгийн сүүлийн шинэчлэлийг 1997 оны 12 дугаар сарын 31-ний өдөр баталсан байдаг. Тус хөтөлбөрийг даяаршил болон мэдээлэлд суурилсан нийгмийн шаардлагад нийцүүлэхийг зорьсон ба уламжлалт сургалтын арга барил буюу мэдлэг, мэдээллийг олгодгоос гадна бие даан суралцах, сурагч тус бүрийн хэрэгцээ, шаардлагад тохирсон хэлбэрийг нэвтрүүлэх, өргөжүүлэх, хичээлийн ачааллыг бууруулах тал дээр анхаарсан байна.

Хууль, эрх зүйн орчин

БНСУ-ын Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлд⁹⁹

1. Иргэн бүр өөрийн чадамжид тохирсон боловсролыг эрх тэгш эзэмших эрхтэй.
2. Асран хамгаалагч, эцэг эх хүүхдийн заавал эзэмших боловсрол болон хуульд заасан бусад боловсролыг эзэмшихэд хариуцлага хүлээнэ.
3. Төрөөс бүх нийтийн боловсролыг үнэ төлбөргүй олгоно.
4. Боловсролын хараат бус байдал, мэргэжлийн ур чадвар, улс төрийн шударга байдал, дээд боловсролын байгууллагуудын бие даасан байдлыг хуульд заасан нөхцөлөөр баталгаажуулна.
5. Насан туршийн боловсролыг төр хариуцна.

⁹⁸ БНСУ-ын хүн амын тоон мэдээ, <https://www.worldometers.info/world-population/south-korea-population/>

⁹⁹ БНСУ-ын Үндсэн хууль, <https://www.law.go.kr/LSW/eng/engLsSc.do?y=16&x=22&menuId=1&query=education>

6. Боловсролын тогтолцоо, насан туршийн боловсрол, захиргаа, санхүү, багш нарын статус зэрэг боловсролтой холбоотой асуудлыг хуулиар зохицуулна гэж заасан байдаг.

Солонгос улсад иргэдийн боловсролын асуудлыг нийт 120 гаруй хууль тогтоомжоор зохицуулдаг бөгөөд эдгээрээс дараах хууль тогтоомж болон бусад хуулиар бүх нийтийн суурь боловсрол, иргэдийг соён гэгээрүүлэх арга хэмжээг *Насан туршийн боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Бага, дунд сургуулийн боловсролын тухай хууль* гэх мэт гол хууль тогтоомжоор зохицуулж байна.

Сургалтын хөтөлбөр

Шинэ хөтөлбөрийн хүрээнд бага сургуулийн 1 дүгээр ангиас ахлах сургуулийн 1 дүгээр анги (1-10 дугаар анги)-ийн үндсэн хөтөлбөрөөр хичээллэх бол ахлах сургуулийн 2-3 дугаар анги (11-12 дугаар анги)-д сурагчид өөрсдийн ирээдүйн зорилго, зорилтод нийцүүлэн сурах хичээлүүдээ сонгон суралцах юм.

Ёс зүй, ёс суртахууны ухагдахуун нь 1950-иад онд анх сургалтын хөтөлбөрт тусгагдсан бөгөөд цаг үе, нийгмийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагатай уялдан хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна.

БНСУ-ын анхны бие даан баталсан Сургуулийн хөтөлбөрт (1955-1963) ёс зүйн боловсрол нь нийгмийн ухааны хичээлийн агуулгад багтаж байсан. Ёс зүйн хичээлийг Боловсролын яамнаас батлагдсан журмын дагуу зааж эхэлсэн бөгөөд ёс зүйн боловсрол нь иргэний боловсролд чиглэж байсан. 1973 онд ёс суртахууны хичээл нь сургалтын хөтөлбөрт бие даасан хичээл болж орсон бөгөөд улмаар 1974 онд ахлах сургуульд ёс суртахууны хичээлээр үндэсний ёс зүйг судалж эхэлсэн. Тухайн үед ёс зүйн хичээл социализмын нөлөөг эсэргүүцэх, эдийн засгийг сэргээх, үндэсний уламжлалыг сэргээхэд чиглэгдэж байсан.

1973-1982 онд ёс зүйн хичээл бага, дунд сургууль болон дээд сургуульд гэсэн гурван үндсэн чиглэлээр орох болсон. 1982-1988 онд уг хичээл заах арга бүрэн шинэчлэгдсэн бөгөөд хэлэлцүүлэг хэлбэрээр хичээл заагдах болсон. 1989-1994 онд нийгмийн ардчилсан байдал илүү тусгагдах болсон. 1995-1999 онд хүнлэг байдал, итгэл үнэмшил, ёс зүйн хүмүүжлийн үндсэн төлөвшил олгоход чиглэсэн. Энэ үеэс хоёр Солонгосын нэгдлийн тухай, Солонгос улс нэгдсэний дараа гэсэн хоёр үеийн амьдралын зорилгыг тусгайлан заах болсон, мөн *“national identity”* (үндэсний ондоошил, үндэстний ижилсэл, амин чанар)-ын томъёоллыг ёс зүйн хичээлийн агуулгад тусгасан.

Харин 2000 оноос буюу одоо мөрдөгдөж буй 7 дугаар сургалтын хөтөлбөрт “ethnic identity” (үндэсний ондоошил) гэх олголт их орсон байна. 7-10 дугаар ангийн ёс зүйн хичээлийн сурах бичгийн агуулгад дараах 4 хүрээг хамруулсан байна. Үүнд:

1. Хувийн амьдрал;
2. Гэр бүл, хөрш, сургууль дахь амьдрал;
3. Нийгмийн амьдрал;
4. Үндэсний болон хамт олны амьдрал.¹⁰⁰

Дээрх 4 агуулгад үндэсний ондоошил буюу “national identity” гэж тусгайлан томъёолоогүй ч 8, 10 дугаар ангийн сурах бичгийн 4 дэх хэсэг буюу “үндэсний болон хамт олны амьдрал”-д дээрх ойлголтыг тусгасан байна. Тухайлбал, 8 дугаар ангийн ёс зүйн сурах бичгийн “үндэсний болон хамт олны амьдрал” хэсэг нь 4 бүлгээс бүрдэж байна. Үүнд:

1. Солонгосын үндэсний хөгжил ба соёлыг эзэмшихүй (*Korean national development and cultural fluency*);
2. Төрийн болон үндэсний хөгжлийн ач холбогдол (*The importance of the state and national development*);
3. Төр, улс үндэстнийг зөв хайрлах (*Correct love of the state and nation*);
4. Нэгдэл ба Хойд болон Өмнөд Солонгосыг нэгтгэх хүч чармайлт (*Unification and strong will for the reunification of the North and South (Korea)*).

7 дахь сургалтын хөтөлбөрт орсон ёс зүйн хичээлийг ерөнхийд нь үзвэл Солонгос үндэс угсаа, хоёр Солонгосын нэгдэл болон даяаршил гэсэн 3 асуудлыг хөндсөн байна. Хэдийгээр эдгээр асуудлууд нь өмнөх сургалтын хөтөлбөрүүдэд багтаж ирсэн хэдий ч шинэ хөтөлбөр дээрх асуудлуудад харьцангуй их ач холбогдол өгсөн байна.

Боловсролын тогтолцоо

БНСУ-ын боловсролын систем нь бага сургууль, дунд сургууль, ахлах сургууль, их, дээд сургууль, мэргэжлийн дээд сургууль гэсэн тогтолцоотой байдаг бөгөөд дараах байдлаар суралцах жил, хичээлийн хөтөлбөрийг зохицуулсан байдаг.

Бага сургуулийн 6 жил: дунд сургуулийн 3 жилийн сургалт нь албан ёсны сургалт хэмээн тооцогдох бөгөөд үнэ төлбөргүй байдаг. Бага сургуулийн боловсрол нь суралцах дадал, өдөр тутмын амьдралд шаардлагатай анхан шатны чадвар эзэмшүүлэх, амьдралын үндсэн хэвшилд сургах, зөв

¹⁰⁰ Сургалтын хөтөлбөр VII

хүн болж төлөвшүүлэхэд чиглэсэн байдаг. 1 цагийн хичээл нь 40 минут үргэлжилдэг бөгөөд 1-2 дугаар ангид эх хэл, математик, зөв амьдрал, ухаалаг амьдрал, хөгжилтэй амьдрал зэрэг амьдралын үндсэн хэвшил, хэв маягийн хичээл орох бөгөөд 3-6 дугаар ангид эх хэл, нийгэм, ёс зүй, математик, байгалийн шинжлэх ухаан, хэрэглээний шинжлэх ухаан, биеийн тамир, дуу хөгжим, дүрслэх урлаг, англи хэл зэрэг хичээлүүдийг үзнэ.

Дунд сургуулийн сургалт 3 жил: Сурагчийг түүний гэрт хамгийн ойрхон сургуульд хуваарилдаг бөгөөд дунд сургуулийн боловсрол нь бага сургуультай адил заавал эзэмших боловсрол бөгөөд ямар нэгэн шалтгаанаар эцэг эх нь хүүхдээ дунд сургуульд сургахгүй бол хариуцлага хүлээж торгууль төлнө. Дунд сургуулийн сургалт нь бага сургуулийн боловсрол дээр үндэслэн сурагчдын сурах чадвар, амьдралд тустай үндсэн чадварыг хөгжүүлэн, ардчилсан нийгмийн иргэний хувьд мэдэх ёстой зүйлийг заах зорилготой.

Ахлах сургууль нь 3 жил: Дунд сургууль төгссөн болон мэргэжлийн шалгалтуудыг өгч тэнцсэн сурагч ахлах сургуульд орох эрхтэй. Ахлах сургууль нь энгийн ахлах сургууль, тусгай мэргэжлийн ахлах сургууль, мэргэжлийн ахлах сургууль, чөлөөт ахлах сургууль гэсэн 4 төрөлтэй байдаг. Элсэлтийн журам нь хот дүүрэг мөн сургууль тус бүр өөр байдаг. Ахлах сургуульд заавал сурах ёстой биш бөгөөд сургалтын төлбөр болон бусад зардлыг өөрсдөө хариуцдаг бөгөөд сургалтын төлбөр нь бүс нутаг, сургуулиасаа шалтгаалаад ялгаатай байдаг байна. Ахлах сургууль нь дунд сургуулийн боловсролын үр дүнд суурилан сурагчид өөрийн авьяас чадамжинд тохирсон ажил мэргэжил сонгох чадвар, дэлхийн иргэн болоход шаардлагатай чанарыг эзэмшүүлэхэд голлон анхаарна. 1 цагийн хичээл нь 50 минут үргэлжлэх бөгөөд эх хэл, математик, англи хэл, нийгэм, түүх, ёс зүй, байгалийн шинжлэх ухаан, биеийн тамир, урлаг, дуу хөгжим, дүрслэх урлаг, хөдөлмөр, гэр ахуй зэрэг хүмүүжлийн хичээлүүд ордог. Түүнчлэн сурагчид өөрийн хүссэн хичээлийг сонгон суралцах боломжтой. Бүтээлч биечлэн оролцох үйл ажиллагаа нь хичээлээс гадуурх үйл ажиллагаа бөгөөд сурагчид дугуйлан бүлгэм, ажил мэргэжилтэй танилцах хөтөлбөр, сайн дурын үйл ажиллагаа зэргээр дамжуулан бусдад туслах, бусдыг ойлгон хүндлэх зан төлөв суух ба өөрийн авьяас чадвар, нөөц бололцоог хөгжүүлэх чиглэлд илүү анхааран ажилладаг байна.

БНСУ нь дэлхийн иргэн бэлтгэх, ирээдүйн зөв, соёлтой иргэдийг бэлтгэх зорилгоор дараах багц агуулгыг сургалтын хөтөлбөрт тусгасан байдаг.

Хүснэгт 3. Боловсролын агуулга

Хичээлийн нэрс	1-2 дугаар ангийн хичээл	3-6 ангийн хичээл агуулга
Солонгос хэл	Солонгос хэл, математик, зөв амьдрал, у х а л л а м ь д р а л , х ө г ж и л т э й амьдрал	Сонсох, ярих, унших, хэлзүйн дүрэм, уран зохиол;
Нийгэм, ёс зүй		Улс төр, хууль, эдийн засаг, нийгэм соёл, газарзүй, газар нутаг, байгаль орчин, хүн ба амьдрал, тогтвортой ертөнц, ерөнхий түүх, улс төр, соёлын түүх, нийгэм эдийн засгийн түүх, өөрийгөө хүндэтгэх, бусадтай харилцах, нийгэм, хамт олны харилцаа;
Математик		Тоо, тоо бодлого, хэмжих нэгж, тогтмол ухагдахуун;
Байгалийн шинжлэх ухаан, хэрэглээний шинжлэх ухаан		Байгалийн шинжлэх ухааны хичээлээр “хөдөлгөөн ба энерги, бодис, амь нас, дэлхий ертөнц” гэх мэт, Хэрэглээний шинжлэх ухааны хичээлээр “хүний хөгжил, гэр бүл, гэр бүлийн амьдрал, аюулгүй байдал, нөөц баялагийг хянах, бие даах, техник, технологи ашиглах”;
Биеийн тамир		Эрүүл мэндийн боловсрол, сорилтыг даван туулах, аюулгүй байдлыг хангах;
Урлагийн хичээлүүд (дуу хөгжим, дүрслэх ухаан)		Мэдрэмжээ хөгжүүлэх, илэрхийлэх;
Англи хэл		Сонсох, ярих, унших, бичих;

Боловсролын дээрх агуулгаас гадна хүүхдийн бүтээлч байдлыг хөгжүүлэх, танин мэдэхүйн чиглэлээр тодорхой агуулга бүхий хөтөлбөр, үйл ажиллагааг явуулдаг.

Хүснэгт 4. Бүтээлч байдлыг хөгжүүлэх хөтөлбөрийн агуулга


Үйл ажиллагааны ангилал	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааны агуулга
Чөлөөт үйл ажиллагаа	- Шинэ орчинтой дасан зохицох үйл ажиллагаа; - Бүтээлч чадварын хөгжүүлэх үйл ажиллагаа;	Сургуульд элсэхийн өмнөх шинэ орчинтой дасан зохицох үйл ажиллагаа болон шилжилтийн насны өөрчлөлтийг ойлгох, түүнд дасан зохицох үйл ажиллагаа;
Дугуйлан, хичээлээс гадуурх үйл ажиллагаа	- Урлаг, спортын үйл ажиллагаа; - Эрдэм шинжилгээ, соёлын үйл ажиллагаа; - Хүүхэд сурагчдын багаар ажиллах чадварыг хөгжүүлэх үйл ажиллагаа;	Төрөл бүрийн туршлага, соёлын танин мэдэхүйн үйл ажиллагаагаар дамжуулан авьяас чадвараа хөгжүүлэх, шинийг эрэлхийлэх, мэдрэхүйгээ хөгжүүлэх, багаар ажиллах чадвар, туршлага хуримтлуулах, хүмүүстэй харилцах харилцааг хөгжүүлэх;

Сайн дурын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Бусдад туслах; - Байгаль орчин, хүрээлэн буй орчноо хайрлан, хамгаалах; - Олон нийтийн үйл ажиллагаа зохион байгуулж сурах; 	Сайн дурын үйл ажиллагааны утга учрыг ойлгох, бодитоор хэрэгжүүлж сурах;
Ирээдүйн ажил мэргэжилтэй холбоотой үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Өөрийгөө таньж мэдэх; - Ажил мэргэжлээ зөв сонгох, судлах; - Мэргэжлээ төлөвлөх; 	Олон төрлийн мэргэжлийг судалж, оролдож үзэх, ирээдүйд сонгох мэргэжлийнхээ талаар суурь мэдлэгтэй болох;

2.5. БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

Казахстан Улсын хувьд ёс зүйн үндсийг “Аль-Фараби”¹⁰¹-ийн гурвалжингаар тайлбарладаг бөгөөд “үнэнч зан чанар”, “шударга ёс”, “цэвэр сэтгэл” гэж гурван хэсгээс бүрддэг¹⁰² байна.

Зураг 1. Казахстаны ёс зүйн Аль-Фарабигийн гурвалжин



Эх сурвалж: Аль-Фараби гурвалжин
<https://textbook.tou.edu.kz/books/224/6en.html>

Дээрх гурвалжинд “шударга ёс” гэсэн ойлголт нь тухайн хүний дотоод дүр төрх нь цэвэр ариун байх ёстойг харуулж байна. “Үнэнч зан чанар”, “цэвэр сэтгэл” хүн бүрт байх ёстой гэж үздэг.

Ёс зүйн хэм хэмжээ нь амьдрал, нийгмийн салбарт зайлшгүй шаардлагатай нөхцөл бөгөөд ард түмний эв нэгдэлтэй амьдрах чадамжийн үзүүлэлт юм. Ёс зүй нь иргэдийн зан чанарт тавигдах ёс зүйн шаардлагууд гэж үздэг. Нийгэм дэх ёс зүйн үндсэн үүрэг бол хувийн харилцааны ёс суртахууны шаардлагад нийцүүлэн зохицуулах явдал юм.

Энэ утгаараа ёс зүй нь соёлын салшгүй хэсэг юм. Соёл үүсэх явцад хүнлэг зан үйлийн шинж тэмдгүүд нь ёс зүйн шаардлага болж хувирсан. Ёс суртахууны дүрэм, журмыг соёл иргэншлээс сонгодог.

¹⁰¹ Казахстан Эрдэмтэн Аль-Фараби тайлбарласнаар “ёс зүй” гэсэн ойлголт нь бүх зүйлд анхаарал халамж тавих хэрэгцээг илэрхийлдэг гэжээ. Казахстан ард түмэн нь түүх, хэл, соёл, үндэсний онцлог шинж чанараараа ялгаатай байдаг. Агуу гүн ухаантан, эрдэмтэн Абу Насир, Аль-Фараби нь Казахстан ёс зүйг сайн, муу зүйлсийг хамруулан судалдаг шинжлэх ухаан гэж тодорхойлсон байдаг.

¹⁰² Аль-Фараби гурвалжин <https://textbook.tou.edu.kz/books/224/6en.html>

Эрдэмтэн Аль-Фарабигийн “Их хотын оршин суугчид» хэмээх зохиолд ёс суртахууны үндэс болсон 12 шинж чанарыг “Оюунлаг үндэстэн–2020” хөтөлбөртэй уялдуулж, оюутан, сурагчдын хөгжлийг төлөвшүүлэх, сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх, үзэл санаатай нийцүүлдэг байна. Үүнд:

1. Гүнзгий мэдлэг олж авах;
2. Мэргэжлийн ур чадвар;
3. Өндөр чадвар;
4. Үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх;
5. Ард түмний өмнө хүлээсэн үүргийг үзэл баримтлалд тулгуурлах;
6. Сайн үйлсийг урамшуулах;
7. Мэргэжлийн ур чадварт оюун санааны үнэт зүйлсийг ашиглах;
8. Бүтээлч байдал;
9. Орчин үеийн дэвшилтэт технологийг ашиглах;
10. Аж үйлдвэрийн хөгжил цэцэглэлт, мэдээллийн ахиц дэвшил;
11. Философийн шинэ эргэцүүлэл;
12. Ёс суртахуунтай байх, сайн сайхны төлөө тэмүүлэх зэрэг асуудлуудыг хамруулсан.

Дэлхийн өндөр хөгжилтэй 30 оронд эдгээр 12 чанарын индексийн үзүүлэлтүүдийг функциональ бичиг үсгийн эх үүсвэр болгон ашигладаг. Модернизмын орон зайд ёс зүйг чиглүүлдэг функциональ бичиг үсэг нь шинжлэх ухаан, боловсролын салбарын үзэл баримтлал юм. Функциональ бичиг үсэг бол прагматик ур чадвар бөгөөд тухайн мэргэжилтэй холбоотой өөрийн мэдлэгээ харуулах чадвар юм.

Дастаны¹⁰³ (яруу найргийн бүтээл) гол санаа нь: хүн бүр шударга ёс суртахуунтай байх явдал юм. Энэ нь дотоод болон гадаад хэв шинжийг багтаасан бөгөөд **анхны сургаал** гэж үздэг. Дотоод хэв маяг нь айл бүрийн дотоод ёс зүй, харин гадаад хэв маяг нь төрийн ёс зүй гэж үздэг. Эдгээр хоёр хэв маяг нь байнгын зохицол, харилцан үйлчлэлтэй байдаг.

Хоёр дахь сургаал нь: дотоод болон гадаад байдлын сайн сайхан багтана. Хүн бүрийн дотоод сайн сайхан нь дотоод оюуны чадавхын цогц гэж үздэг. Гадаад сайн сайхан нь дотоод байдлын үзүүлэлт болох объектив юм.

Гурав дахь сургаал нь: дотоод мэдлэгээс хуримтлагдсан саруул ухаан юм.

Дөрөв дэх сургаал нь: дотоод болон гадаад байдлын сэтгэл ханамж юм. Дотоод сэтгэл ханамж нь гэр бүлүүд сэтгэл ханамжтай байхыг хэлдэг бөгөөд гадаад сэтгэл ханамж нь нийгмийн улс төр, эдийн засаг, соёл,

¹⁰³ Дастан гэдэг нь түүх, домог гэсэн утгатай. Уран зохиол, яруу найргийн бүтээл юм.

нийгмийн хэрэгцээ шаардлагаас хамаардаг. Энэхүү үндэсний үзэл санаа нь Казахстаны орчин үеийн залуучуудын хүмүүжил, ёс зүйд ихээхэн хувь нэмэр оруулдаг байна.

Казах ёс зүйн онцлог шинж, төрлүүд

Ёс суртахуун нь удамшлын хувьд эцгээс үр хүүхдэд цусаар дамждаггүй. Ёс суртахуун тухайн хүнтэй хамт хөгждөг. Хүн чанар нь нэр төр, хүндэтгэл, агуу чанар зэрэг хувийн шинж чанаруудаар тодорхойлогддог бөгөөд энэ нь ёс зүй юм. Хүний өөрийн амьдралын хэв маяг, амьдралын хэм хэмжээ ёс зүйд үндэслэгдэнэ. Ёс зүй нь тухайн хүний зан чанарыг төлөвшүүлж, нийгэмд тустай, амьдрал нь хүн чанартай холбоотой байдаг бөгөөд хүнлэг байх мэдрэмж ёс зүйгээс эхэлдэг.

Казахстаны ард түмний өвөрмөц дүрэм нь ёс зүйн зарчимд суурилдаг. Казах ёс зүй нь хүн бүрийг удирдан чиглүүлдэг сайхан зан чанар, зарчим, дүрэм журмаар илэрнэ. Казах ард түмний ёс зүйн зарчмуудыг үнэт хэм хэмжээ гэж үздэг. Үүнд:

1. Зүрх сэтгэл, бодол санаа (зорилгын)-ны цэвэр байдал;
2. Харилцаанд өөрийгөө шууд, шударгаар илэрхийлэх чадвар;
3. Ухаалаг, тэнцвэртэй, тэвчээртэй байх;
4. Үндэстэн бүр, нийгмийн түвшин, иргэд хоорондын харилцааг сайн тогтоох;
5. Эелдэг, энэрэнгүй байх;
6. Бусдын баяр баясгалан, зовлонг хуваалцах чадвар;
7. Үнэт зүйлс дээр суурилсан хүмүүжил;
8. Өөрийнхөө муу чанаруудтай тэмцэх чадвар;
9. Даруу байдал, өгөөмөр сэтгэл, зоригтой байх;
10. Уучлах чадвартай байх.

Казах ёс зүйн төрлүүд

Даруухан байх ёс зүй. Казахуудын хийж буй үйлдэл их даруухан байх, харилцаа холбоо, зочдод хандах хандлага зэрэг ёс зүйг ихэд анхаардаг байна. Жишээлбэл: настан буурлууд үр хүүхэд, ач, зээгээ дагуулан олон нийтийн арга хэмжээнд оролцдог бөгөөд энэ нь хэрхэн даруу төлөв байхад сургах, мэргэн зүйр үг, зүйрлэсэн домог, үлгэр сонсгох, түүнээс үлгэр дуурайл хэрхэн авах, зан үйлийг үлгэрлүүлэн сургадаг ажээ.

Мэндлэх, хүндлэх ёс зүй. Энэ ёс зүй нь хэрхэн зөв мэндлэхээс эхлэх бөгөөд хүний оюун санаа, эелдэг байдал зэргийг соёлын үзүүлэлт гэж үздэг. Хүндэтгэсэн настан буурлуудтай залуус нь түрүүлж мэндлэх ёстой. Мэндчилгээний гол нөхцөл бол найрсаг байдал юм. Зөв мэндчилгээ нь

ярианы ёс зүйг төлөвшүүлэхэд ихээхэн тус болдог гэж үздэг. Мөн айл гэрийн эзэгтэй өндөр настантай толгой бөхийж мэндчилж байгаа нь асар их хүндэтгэлийг харуулж буй хэрэг юм.

Зочлох ёс зүй. Казахын ард түмэн зочломтгой зантай, зочдыг найрсаг угтаж, таатай яриа өрнүүлдэг. Казахууд “конак кадэ” гэх бөгөөд энэ нь зочдоос дуу дуулуулах, сонирхолтой зүйлсийг яриулах, домбор хөгжим тоглуулах гэсэн утгыг илэрхийлнэ. Зочломтгой байдал, зочдыг хөгжөөх нь казах соёл, казах зан заншлын гол онцлог юм.

Ирсэн зочдыг дайлах ёс зүй. Ирсэн гийчин, зочдод шинэ малын махыг чанаж өгөх уламжлалтай. Чанасан махыг “табак” гэж нэрлэдэг бөгөөд энэ махаар зөв үйлчлэх нь тэдний ёслол юм. Табак бүр зочдын нас, нийгмийн байдал, цусан төрлийн холбооноос хамаарч хэд хэдэн төрөлд хуваадаг. Табак махны тодорхой хэсгээр (муше) тавьдаг. Хамгийн хүндэтгэлтэй хүнд толгой болон сүүжний махыг тавьж, каз тэргүүлсэн тавгийг тэргүүн ширээнд байрлуулна. Толгойн магнайн хуйхыг хөндлөн зүсээд тавагтай махны дээр нь байрлуулан гол зочид руу харуулна. Сүүж, шаантын барих талыг зочинд харуулж тавих учиртай. Харин хүргэн, бэрийн хувь өвчүү бөгөөд хүүхдийн хувь чих, бөөр, зүрх, шийр, залуу эмэгтэйчүүдийн хувь тагнай, хэл, хоньчны хувь шулуун гэдэс гэхчилэн оноодог байна.

Буян хийх ёс зүй. Бусдад өгөөмөр сэтгэлтэй байх нь ариун сэтгэлийн шинж бөгөөд энэ нь их чухал үнэт зүйл юм. Сайхан сэтгэлтэй хүн мэдрэмжтэй, үнэт зүйл, байгалийн сайхныг биширч, түүнд санаа тавьж, буян үйлддэг ёс бий.

Хүн байх ёс зүй. Хүн төрөлхтөн нь ариун нандин амьдралын хуулиудыг чин сэтгэлээсээ хүндэтгэн биелүүлж байдаг. Гагцхүү хүнээ хайрлах, байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, сайн сайханд итгэх итгэл л хүн чанарын шинж гэж үздэг. Зөв зүйл хийх нь оюун санааны хувьд хөгжсөн хүн гэж үздэг. Биеийн ариун цэвэр болон сэтгэлийн ариун байдлыг хадгалах чадвар нь хувь хүний үнэ цэнэ гэж үздэг. Казахын ёс зүй нь үндэсний соёлын дүр төрх юм. Өсвөр, залуу үеийнхэнд хүмүүнлэг, төлөвшлийг сургахдаа Казах ард түмэн хууль тогтоомж болон уламжлал, ёс заншлаа даган мөрдөх, үүрэг даалгаврыг ягштал биелүүлэхийг заадаг.

Эрүүл амьдралд сургах ёс зүй. Эрүүл мэнд нь хөдөлмөрийн чадварыг тодорхойлох, хувь хүний хөгжлийг хангах бөгөөд хамгийн чухал хэрэгцээ юм. Тиймээс эрүүл амьдралын хэв маягийг ёс зүйтэй холбон авч үздэг.

Эх оронч үзэлтэй байх ёс зүй. Казах ард түмний үндэсний онцлог, уламжлал, соёл нь Казах хүн бүрийн чиглүүлдэг. Үндэстнээ хайрладаг хүн эх хэлээ эрхэмлэдэг, үндэсний бичиг соёлоо хайрладаг. Эх оронч үзэл

нь үндсэрхэг үзэл, өндөр ёс суртахуун, үндэсний бахархал юм. Үндэсний бахархал нь эрэлхэг, энэрэнгүй, бүтээлч, зоригтой, үндэсний нэр төр, хувь хүн бүрийн сэтгэлд зориулагдсан агуу хүч юм.

Ур чадварт сургах ёс зүй. Казахын ард түмэн үндэсний хээ, хувцас оёх, сүлжмэл болон хатгамал урлах, хивс нэхэх, эсгий урлах, дуу дуулах, яруу найраг, үлгэр туурвих, ан агнуур хийх, спорт, бүжиг, хөгжим тоглох гэх мэт урлагийн ур чадвараа хөгжүүлж, чадварлаг байх нь ёс суртахууны шинж гэж үздэг.

Гэр бүлийн харьцаанд сургах ёс зүй нь хүн бүр төрсөн цагаасаа эхлэн гэр бүлд төлөвшдөг учраас хүн төрөлхтний түшиг тулгуур юм. Гэр бүл нь чухал бөгөөд ариун ёс суртахууны алтан сургууль гэж үздэг. Гэр бүлд эцэг эхчүүд харилцан хариуцлагатай үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хүүхдийн хүмүүжлийн чанаруудыг төлөвшүүлж чаддаг. Эцэг эхийн хоорондын харилцан хүндэтгэл, дэмжлэг, хүүхдийнхээ дэргэд тайван байх чадвар нь ёс зүйн гол шаардлагуудын нэг юм.

Үдэж өгөх ёс зүй. Казахын ард түмэн хол, ойрын аялалд гарахаас шалтгаалаад салах ёс зүй өөр өөр байдаг. Салах ёс хийхэд ерөөл хэлэхийг голчлон ашигладаг. Ахан дүүс, найз нөхөд, хөршүүд нь гэр бүл, төрөл төрөгсдөө үдэж өгөхдөө зорьсон газраа саадгүй хүрэхийг хүсэн ерөөж, тэврэн үдэж өгөх уламжлалтай.

Хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаар хэрэгжүүлж буй хөтөлбөр

Казахстан Улсын хувьд хүүхэд, залуучуудын хүмүүжил төлөвшил, ёс суртахууны боловсролын тухай тусдаа хууль байхгүй, харин хөтөлбөр хэрэгжүүлдэг. Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд боловсролын системийн үүргийг тодорхойлсон бөгөөд энд хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаар дараах заалтуудыг тусгасан байна.¹⁰⁴ Үүнд:

- Үндэсний болон хүн төрөлхтний үнэт зүйлд, мөн шинжлэх ухаан, технологийн ололт амжилтад тулгуурлан хувь хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх, мэргэжил дээшлүүлэхэд чиглэсэн чанартай боловсрол олгох нөхцөлийг бүрдүүлэх;
- Хувь хүний бүтээлч чанар, оюуны болон биеийн чадварыг хөгжүүлэх, зөв эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, хувь хүнийг хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэх замаар оюуны чадамжийг хөгжүүлэх;

¹⁰⁴ http://adilet.zan.kz/kaz/docs/Z070000319_ Aguzu billahi minashaitan nirajim bissmillahi rahmani rahim Боловсролын тухай хууль, 11 дүгээр зүйл

- Иргэний болон эх оронч үзэл, Эх орон– Бүгд Найрамдах Казахстан Улсыг хайрлах, төрийн бэлгэ тэмдэг болон төрийн хэлийг эрхэмлэх, үндэсний ёс заншлыг хүндэтгэх, Үндсэн хуульд харшилсан болон нийгмийн эсрэг аливаа үйлдлийг үл тэвчих чанаруудыг төлөвшүүлэх;
- Идэвх санаачилгатай хувь хүнийг төлөвшүүлэх, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын арга хэмжээнд оролцох, хувь хүний эрх ба үүргийн талаарх ухамсартай үзэл бодлыг төлөвшүүлэх;
- Үндэсний болон дэлхийн соёлын ололттой танилцах, Казах үндэсний болон улс дахь бусад үндэстний түүх, зан заншил, ёс журмын талаар судлах, мөн төрийн хэл, орос болон гадаад хэл сурах нөхцөл боломжуудыг бүрдүүлэх юм.

Хөтөлбөрийн зорилго нь: хүний дотоод ертөнцийг нээснээр зөв боловсон хүн болж төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, эрхэм дээд чанарт сургах, амьдрах чадвар болон боломжийг хөгжүүлэхэд оршино. Түүнчлэн бодол санаа, үг яриа, үйл хөдлөлөө зөв уялдуулах, ямар ч асуудлыг өөрийн болон бусдын тусын тулд оновчтой шийдэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, хүний эрхийг хүндэтгэх чадварыг эзэмшүүлэх зорилготой.

“Өөрийгөө танин мэдэх” хөтөлбөрийн гол санаа нь хүүхэд, залуучуудыг ёс суртахуунтай байх, эрхэм чанараа хадгалахад сургахаас гадна, үндэстэн бүрийн, хүн бүрийн хамгийн сайн сайхан, гэгээлэг, ариун чанарыг улам хөгжүүлэхэд оршино.

Хөтөлбөрийг Казахстан Улсын боловсролын системд нэвтрүүлснээр “Өөрийгөө танин мэдэх” хичээлийн хөтөлбөрийг бий болгож, 2010 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Хичээлийн агуулга нь хүний мөн чанарт тулгуурласан бөгөөд өөрийн эрхэм чанарыг мэдрэх, өөрийгөө хүндэтгэх, үзэл бодлоо чөлөөт илэрхийлэх, өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээг ойлгуулан хүмүүжүүлэхийн зэрэгцээ амьдралд зүг чигээ зөв тодорхойлох, шийдвэр гаргах, хариуцлагаа ухамсарлах чадварыг хөгжүүлэхэд оршино. Бүх насны хүүхдүүд, сурагчид болон оюутнууд оролцогсод нийт дүнгээр 37,901 хүн болсон бөгөөд танин мэдэхүйн багш нар 747 хүнийг тус тус¹⁰⁵ хамруулсан байна.

Ёс суртахуун, оюун ухааны сургалт, боловсрол, шинжлэх ухааны портал хуудас «Самопознание.KZ» www.ozin-oz-i-tanu.kz нээж, хүүхэд залуучууд өөрийгөө танин мэдэх, нээх, найз нөхөдтэй болох, үлгэрлэн дуурайл үзүүлэх, бусдад нөлөөлөх, номоос ашиг тус хүртэх, сургаал үгс, үлгэр, түүх, зүйрлэл, цахим номын сан гэх мэтчилэн хэрэгтэй мэдээллүүдийг ашиглахад ойлгомжтой байдлаар байршуулсан байна.¹⁰⁶ Үүний үр дүнд

¹⁰⁵ <http://ozin-oz-i-tanu.kz/p/history>

¹⁰⁶ <http://school.ozin-oz-i-tanu.kz/learn/show/id/110>

сурган хүмүүжүүлэх туршлага хуримтлуулах, туршлага судлах, улмаар хамгийн тохиромжтой туршлагыг сонгож, цаашид хэрэгжүүлэх ач холбогдолтой.

Сургуулийн өмнөх боловсролын түвшинд¹⁰⁷

“Өөрийгөө таних” болон “Бөбек” хөтөлбөрүүдийн хүрээнд 2009 оноос “Өөрийгөө таних” тусгай цэцэрлэгүүд ажиллаж эхэлсэн. Зорилго нь хүүхдийг бүх талаар цогц хөгжүүлэх бөгөөд хүүхдэд зориулсан аливаа үйл ажиллагаанд хүний үнэт зүйлсийн талаарх ойлголтыг ухаж ойлгуулах, хүүхдийн өөрийгөө таних болон өөрийн чадварыг мэдэрч ойлгох чадамжийг идэвхжүүлэн хөгжүүлэхэд оршино.

Уг цэцэрлэг нь хүүхдэд мэдлэг боловсрол олгох, хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах ба чийрэгжүүлэх зэрэг цогц сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулан явуулах боломжоор бүрэн хангагдсан. Цэцэрлэгийн багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эх, хүүхдүүдэд чиглэсэн бүх үйл ажиллагааг “Өөрийгөө таних” хөтөлбөртэй уялдуулж явуулдаг.

Сургуулийн өмнөх насны хүүхдийг сурган хүмүүжүүлэх хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүүхдийн байнгын өдөр тутам хийдэг гол үйлдэл буюу тоглох үйлдлээр дамжуулан мэдлэг боловсрол олгох, төлөвшүүлэн хүмүүжүүлэхэд чиглэсэн.

“Өөрийгөө танин мэдэх” цэцэрлэгт хүүхдийг зөв боловсон сурган хүмүүжүүлэх, төлөвшүүлэх үйл ажиллагаанд эцэг эхийн үүрэг, оролцоо нэн чухал үүрэгтэй. Эцэг эхтэй хамтран ажиллах зорилгоор “Нээлттэй хаалга” буюу эцэг эхэд зориулсан өдөрлөгийг тогтмол зохион байгуулдаг. Уг арга хэмжээ нь хүүхдүүд хайр халамжтай, сайхан сэтгэлтэй байх, мөн бусадтай харилцан ойлголцоход хэрхэн суралцан хүмүүжиж буйг эцэг эхчүүдэд харуулах зорилготой.

“Өөрийгөө таних” хөтөлбөрийг сургуулийн өмнөх боловсролд хэрэгжүүлснээр хүүхдүүд хүнлэг зан чанарын тухай ойлголт авч, сайн сайхан үйл хийж сурахын зэрэгцээ аливаа зүйлд ухамсартай хандаж сурах юм.

Бага, дунд боловсролын түвшинд

Өөрийгөө таних замаар мэдлэг боловсрол олгохын зорилго нь суралцагчийн үнэт зүйл, зөв дадал зуршлыг хөгжүүлэх, өөртөө хандах болон хүрээлэн буй орчинтой, хүн төрөлхтөнтэй харьцах хандлагыг,

¹⁰⁷

улмаар хүнлэг зан чанар, нийгэмд ач тустай хандлагыг хэвшүүлэх, өөрийн сонирхлыг нээх, амьдралын зорилгыг тодорхойлох, хүнлэг сонголт хийх, мөн хэлсэн үг болон үйлдэлдээ хариуцлагатай байхыг төлөвшүүлэхэд оршино.

Хичээлийн агуулгыг хүний үнэт зүйлд үндэслэн боловсруулсан бөгөөд дараах агуулгын хүрээнд боловсрол олгох юм. Үүнд:

- хайр сэтгэл, эрүүл мэнд, эрх чөлөө, аз жаргал, хөдөлмөр, бие болон сэтгэлийн уялдаа холбоо, амьдралын зорилго, хүний үүрэг хариуцлага, мөн санаа бодол, үг яриа, үйл хөдлөлийн уялдаа холбоог бүрэн гүйцэд ойлгуулах замаар өөрийгөө таних;
- гэр бүл, найз нөхөд, хүндэтгэл, эрх тэгш байдал, халуун дотно харьцаа, харилцан ярилцах, харилцан ойлголцох, эв найрамдалтай байхын утга учрыг бүрэн гүйцэд ойлгуулах замаар бусдыг таних;
- байгаль орчин, эх орон, амьдрал болон хүрээлэн буй орчинтойгоо уялдан зохицох, итгэл найдвар зэрэг ойлголтыг бүрэн гүйцэд авснаар дэлхий ертөнцийг таних;
- шударга үнэн, бүтээлч байдал, соёл урлаг, хүн төрөлхтний эв нэгдэл, “хүн төрөлхтөн эх дэлхий хэмээх нэгэн дээвэр дор хамт амьдардаг”-ийг бүрэн гүйцэд ойлгуулах замаар хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлагын талаар таньж мэдэх юм.

Бага дунд боловсролын түвшинд боловсруулсан хичээлийн хөтөлбөр нь хүний үнэт зүйлсийн тухай үндсэн ойлголтуудыг хөгжүүлэхэд тасралтгүй байдлыг хангах буюу дэс дараатай мэдлэг олгоход чиглэсэн.

Хичээлийн хөтөлбөр нь *“өөрийгөө таних”, “нийгэм дэх хүн”, “хүн ба хүрээлэн буй орчин”, “хүн төрөлхтний оюуны бүтээл, мэдлэг туршлага”* гэсэн 4 хэсгээс бүрддэг. Эдгээр сэдвүүд нь улс орнуудын урлаг соёл, түүх, ёс заншлыг хүндэтгэх, хүн төрөлхтний эв нэгдлийн талаар ойлгуулах зорилготой. Жишээ нь агуу хүмүүсийн амьдралыг танилцуулснаар сурагчид хүн, хүрээлэн буй орчинтой хэрхэн зохицох талаарх ойлголтыг эзэмших юм.

Коллеж, их, дээд боловсролын түвшинд

“Өөрийгөө таних” хөтөлбөрийн хүрээнд түүхэнд нэрээ мөнхөлсөн эрдэмтэн мэргэдийн амьдрал, тэдний хэлсэн сургаал үгсийн мөн чанарыг таниулах замаар суралцагчийн дотоод ертөнцийг нээхийг зорьдог. Ингэснээр нийгмийн өмнө хариуцлагаа ухамсарладаг, идэвхтэй, бүтээлч, хүнлэг, хөдөлмөрч хойч үеийг төлөвшүүлэх юм.

Хичээлийн хөтөлбөрийн зорилго:

- Оюутнуудын дотоод ертөнцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Зан чанарыг нь төлөвшүүлэх, өөрөөр хэлбэл, хариуцлага, нэр төр, төлөв даруу зэрэг хүнлэг чанаруудыг төлөвшүүлэх;
- Сурч мэдсэн зүйлийг амьдралд хэрэгжүүлж хэвшүүлэх;
- Хүн болон хүрээлэн буй орчинд сайн үйл хийхийг сургаснаар ирээдүйд ажил мэргэжилдээ дуртай, бүтээлч боловсон хүчнийг бэлтгэх, тэдний мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зэрэг болно.

Хичээлийн хөтөлбөрт буй гол онцлог нь хүмүүжлийн асуудлыг мэдлэг боловсрол олгохоос чухалд тавьсан бөгөөд мэдлэг боловсролыг хүмүүжил дотор багтаасан. Өөрөөр хэлбэл, боловсрол олгох нь хүмүүжлийн нэг асуудал юм. Хичээлийн хөтөлбөрийн агуулга нь хүний үнэт зүйлсийг нээх зорилготой.

Суралцагчийн идэвхийг нэмэгдүүлэх, мэдлэг боловсрол болон хүмүүжил төлөвшлийг хүртээмжтэй олгох үүднээс сургалтын онцлог арга барилуудыг хэрэглэж байна. Үүнд:

- Сайхан сэтгэгдэл төрүүлэх: Хичээл орж эхлэх болон дуусахад сэтгэл ханамжтай байх, сэтгэл санаа тайван байх;
- Хичээлийн эшлэл: Зөв зүйтэй санал бодол, шүүмжлэлийн талаар авч үзэх;
- Яриа хэлэлцүүлэг өрнүүлэх: Хүмүүжлийн ач холбогдолтой сэдвээр яриа хийх;
- Бүтээлч ажил, багаар ажиллах: Ач холбогдолтой тоглоом тоглох, жүжигчилсэн тоглолт хийх, зураг зурах, шүлэг зохиох, зохион бичлэг бичих, дуу зохиох гэх мэт;
- Хөгжимтэй болон нийтээр дуулах: багаар ажиллаж сурах, эв нэгдэлтэй байх зэрэг болно.

“Өөрийгөө таних” хөтөлбөрт тусгасан чухал асуудлын нэг багш нарын үүрэг оролцоо юм. Ёс зүй, хүмүүжил, төлөвшлийн боловсрол олгоход хүний эрхэм чанаруудыг өдөр тутмын амьдралд хэрэгжүүлж хэвшүүлснээр үр дүнд хүрдэг. Үүнд багшийн үүрэг оролцоо чухал ач холбогдолтой. Багшийн хандлага зөв байвал сурагчид нь зөв төлөвших юм.

Төрийн албаны ёс зүй

БНКаз Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 153 дугаар зарлигаар Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталсан. Төрийн алба нь нийгэм, төрийн илэрхийлэл бөгөөд төрийн албан хаагчийн албаны ёс зүйд өндөр шаардлага тавьдаг.

Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм нь төрийн албан хаагчийн албаны ёс зүйн хэм хэмжээг тогтоож, төрийн байгууллагад итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, төрийн албанд харилцааны өндөр соёлыг төлөвшүүлэх, уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэгдэх, итгэл үнэмшил, төрийн албан хаагчийн ёс зүйгүй үйлдлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Төрийн албан хаагчийн ёс зүйд¹⁰⁸ дараах зарчмууд орж байна. Үүнд:

- **итгэл үнэмшил:** төрд хичээнгүйлэн зүтгэх;
- **үнэнч шударга байдал:** ажил үүргээ гүйцэтгэхдээ чин сэтгэлээсээ хандах;
- **шударга ёс:** хувь хүн, хуулийн этгээд, олон нийтийн бүлэг, байгууллагын нөлөөллөөс үл хамааран хууль ёсны шийдвэр гаргах, аливаа нөхцөл байдалд нэг талыг барьсан, субъектив байдлаар ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэх;
- **ил тод, нээлттэй:** олон нийттэй хамтран ажиллах хүсэл эрмэлзэл, үйл ажиллагааны ил тод байдлын баталгаа;
- **зелдэг байдал:** иргэд, хамтран ажиллагсдадаа зөв, хүндэтгэлтэй хандах;
- **ажлын чиглэл:** төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ авах, төрийн үйлчилгээний эрэлт хэрэгцээнд бүрэн анхаарлаа хандуулах, өргөдөл хүлээн авахдаа хүнд суртал гаргахаас урьдчилан сэргийлэх.

Төрийн албан хаагчдад дараах шаардлагуудыг тавина:

- даруу байдал, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахуун, ёс суртахууны хэм хэмжээг дагаж мөрдөх, бодит байдалд нийцэхгүй мэдээллийг түгээхгүй байх;
- улс орны эрх ашиг, иргэдийн эрх ашгийг хохироосон үйлдлээс урьдчилан сэргийлэх;
- хууль эрх зүйг дагаж мөрдөх, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх;
- иргэдтэй харьцахдаа зөв хандах, бүдүүлэг, доромжлох, буруу авир гаргахаас урьдчилан сэргийлэх, үйлдэл;
- хуралдааны протокол, албан ёсны дүрмийг дагаж мөрдөх, төрийн байгууллагын нэр төр, эрх мэдлийг гутаах үйлдлээс урьдчилан сэргийлэх;
- албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой хууль бус амлалт, хууль бус үүрэг хүлээхгүй байх;
- төрийн байгууллага, төрийн албан хаагч болон бусад этгээдийн үйл ажиллагаанд хувийн асуудлаа шийдвэрлэхэд албан

¹⁰⁸Казахстаны Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм https://egov.kz/cms/en/articles/state_service/ethic_code

тушаалаа ашиглахгүй байх, түүнчлэн олон нийт, шашны холбоо, ашгийн бус бусад байгууллагын ашиг сонирхлын үүднээс хандахгүй байх;

- аюулгүй байдлыг хангах, төрийн өмчийг зориулалтын дагуу ашиглах, албан үүргийн гүйцэтгэл, зөвшөөрөгдсөн бусад үйл ажиллагаа;
- албан үүргээ ухамсартай биелүүлэх, саад учруулсан санхүүгийн болон эд хөрөнгийн хууль бус ашиг сонирхлыг хэрэгжүүлэхгүй байх.
- албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотой тохиолдлоос бусад мөрийтэй тоглоомын газарт зочлохгүй байх гэсэн шаардлагуудыг биелүүлдэг байна.

Төрийн албан хаагчийн ажлын байран дэх зан төлөвшилд дараах асуудлуудыг хамруулжээ. Үүнд:

- албан ажилдаа найрсаг харилцаа, бүтээлч хамтын ажиллагааг бий болгох, бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- төрийн болон бусад албан хаагч албаны ёс зүйн хэм хэмжээг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, бусад арга хэмжээ авах;
- хамт олны нэр төр, алдар хүндийг гутаан доромжлохоос зайлсхийх;
- шударга ёс, хувь хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх, үлгэр жишээ болох;
- төрийн албан хаагчийн нэр төр, алдар хүндийн эсрэг ялгаварлан гадуурхалт, зөрчлийг үгүйсгэсэн ёс суртахуун, сэтгэл зүйн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;
- нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээнд нийцээгүй үйлдэл хийхгүй, бусдыг албадахгүй байх;
- хамт ажиллагсдаа үндэслэлгүй буруутгах, бүдүүлэг үг хэлэх, нэр төрийг гутаан доромжлох, эелдэг бус байдал, зохисгүй үйлдэл хийхээс урьдчилан сэргийлэх;
- хамт олонд шашны итгэл үнэмшлийг тулгахгүй байх, харьяа албан хаагчдыг олон нийтийн болон шашны холбоо, ашгийн бус бусад байгууллагын үйл ажиллагаанд оролцуулахгүй байх.

Төрийн албан хаагчид нь: төрийн бодлого, албан ёсны үйл ажиллагааны талаар төрийн бодлогын үндсэн чиглэлд нийцэхгүй, нийтэд мэдээлэхийг хориглосон, төрийн албан тушаалтан, төрийн захиргааны байгууллагад хандсан ёс зүйгүй мэдэгдэл, мэдээллийг нийтэд ил тод илэрхийлэхгүй байхыг энэ дүрэмд тусгасан байна. Төрийн албаны ёс зүйг зөрчихөөс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн албаны эрх бүхий байгууллага хууль тогтоомжийн дагуу зохицуулдаг байна.

Мөн Төрийн албаны тухай хуулийн 49-52 дүгээр зүйлд заасны дагуу **төрийн албан хаагчид ёс зүйн** дараах үүргийг хүлээнэ:

- хууль ёсны зарчмыг удирдлага болгох;
- төрийн албаны нэр хүндийг гутаах үйлдлээс урьдчилан сэргийлэх, төрийн бодлогод үнэнч байж, тууштай хэрэгжүүлэх;
- төрийн алба, төр, түүний байгууллагуудад итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, бэхжүүлэх;
- нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;
- БНКаЗУ-ын төрийн бэлгэдэлд хүндэтгэлтэй хандах хандлагыг үлгэр жишээ болох;
- албан тушаалынхаа бүрэн эрхээс хэтэрсэн тушаалын биелэлтийг харьяа төрийн албан хаагчдаас шаардахгүй байх;
- төрийн албан хаагчийн албан ёсны ёс зүйд заасан бусад ёс зүйн дүрмийг дагаж мөрдөх.

Эдгээрээс гадна төрийн албан хаагчийн ёс зүйн дараах 3 төрлийн зөрчлийг Төрийн албаны тухай хуульд тусгасан байна:

- төрийн албаны нэр хүндэд халдсан сахилгын зөрчил;
- ашиг сонирхлын зөрчил;
- авлигын хэрэг.

Төрийн албан хаагч нь эхний сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жилийн дотор сахилгын зөрчлийг давтан үйлдсэн бол төрийн албанаас халагдана. Мөн албан хаагч нь төрийн байгууллагад учруулсан шууд бодит хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.


2.6. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

Энэтхэг Улс нь ёс зүй, ёс суртахууны талаар маш эртний түүхтэй бөгөөд Буддын шашинтай салшгүй холбоотой явж иржээ. Мөн Энэтхэгийн уламжлалт (Хиндү) амьдралын хэв маягаар хүн бүр өөрийн каст буюу давхаргад амьдарч тохирсон үүргээ биелүүлэх ёстой гэж үздэг. Энэ каст нь 4 давхаргатай (Брахманууд, Кшатри, Вайшья, Шудра) бөгөөд эдгээр давхаргынхан Дарма (Dharma) буюу нийгмийн дэг журам, ёс суртахууны хуульд захирагдах ёстой байдаг.¹⁰⁹ Харин одоогийн байдлаар Энэтхэгт албан ёсны 2 хөтөлбөр, 1 албан бус зан заншил мөрдөгдөн хэрэгжиж байна. Үүнд: Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE), Иргэний дүрэм (Citizen’s Charter – Ethics Notes), Гандигийн ёс зүй-Махатма Гандигийн 11 зарчим (Gandhian Principles) зэргүүд байна.

¹⁰⁹ https://cbseacademic.nic.in/web_material/doc/ktpi/30_kpti%20xii%20-%20indian%20ethics_old.pdf

Бүх нийтийн ёс зүйн боловсрол (Universal Ethics Education-UEE)¹¹⁰

Энэ хөтөлбөр нь Дээрхийн Гэгээнтэн XIV Далай Ламын айлдсан нийтээр мөрдөх ёс суртахууны үзэл баримтлал дээр үндэслэсэн хөтөлбөр юм. Хөтөлбөрийн хүрээнд байгууллага болон олон нийтийн орчинд хүүхэд, залуучуудад зориулсан ёс зүйн сургалтыг боловсруулан хэрэгжүүлдэг. Хамрах хүрээний хувьд хүүхэд (4-14 насны хүүхдэд), багш, эцэг эх, олон нийтийн байгууллага зэрэг хүрээнд явагддаг.



Энэ хөтөлбөр нь 2014 онд боловсруулагдаж эхэлсэн бөгөөд 2017 онд дунд ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бол 2018 онд орон нутгийн сургуулиудад, 2019 онд бага ангийн сурагчдад хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.

Иргэний дүрэм¹¹¹

Энэхүү дүрмийн үзэл баримтлалын анх Их Британид 1991 онд үндэсний хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн бөгөөд 1997 онд Энэтхэгийн засгийн газар засгийн газрын хөтөлбөр болгон хэрэгжүүлсэн байна. Тус хөтөлбөр нь төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, стандартын талаарх үүрэг болон иргэдийн ёс зүй, ёс суртахууны талаарх харилцан ойлголцлын баримт бичиг юм.

Иргэний дүрэмд дараах 6 зарчим баримталдаг байна. Үүнд:

1. Чанар
2. Сонголт
3. Стандартууд
4. Үнэ цэн
5. Хариуцлага
6. Ил тод байдал

¹¹⁰ <https://ayurgyannyas.org/story/> “Бүх нийтийн ёс зүйн боловсрол” хөтөлбөр

¹¹¹ <https://prepp.in/news/e-492-citizens-charter-ethics-notes> Иргэний дүрэм (Энэтхэг)

Өнгөрсөн жилүүдэд Энэтхэгийн эдийн засгийн хөгжлийн салбарт томоохон ахиц дэвшил гарсан. (Сүүлийн 10 жилд 51.63%-65.38% хүртэл) Мөн Энэтхэгийн иргэд эрхийнхээ талаар илүү ухамсартай, соёлтой, мэдлэгтэй болсон. Энэхүү Иргэний дүрмийг зохион байгуулах хариуцах ажлыг Энэтхэгийн засгийн газрын Захиргааны шийтгэл, олон нийтийн гомдолыг шийдвэрлэх газар (DARPG) хариуцдаг байна.

Гандигийн ёс зүй (Махатма Гандигийн 11 зарчим)¹¹²

Энэтхэгийн эрх чөлөөний тэмцлийн нэрт удирдагч Ганди нь хүчирхийлэлгүй байх философи, хайр энэрэл, тэгш байдал, энх тайвны зарчмаараа дэлхий даяар алдартай улс төрч билээ. Түүний төрсөн өдөр буюу 10 дугаар сарын 02-ны өдрийг Энэтхэгийн ард түмэн үндэсний баяр болгон тэмдэглэж, Гандигийн сургааль, зарчим, номлолыг хойч үедээ дэлгэрүүлэн түгээдэг байна. Энэ Гандигийн 11 зарчим өнөөдөр ч гэсэн Энэтхэг гэлтгүй дэлхий даяар олон сая хүмүүсийг чиглүүлж, урам зориг өгсөөр байна. Гандигийн 11 зарчим:

1. **Truth (Satya) – Үнэн байх:** Ганди үнэнийг бусад бүх сайн чанарын үндэс, суурь гэж үздэг. Тэрээр хүн амьдралдаа үнэнийг хэлж, амьдралын бүхий л талаар үнэнийг эрэлхийлж, үнэнч шударга амьдрах ёстой гэж үздэг.
2. **Nonviolence (Ahimsa) – Хүчирхийлэлгүй байх:** Хүчирхийлэлгүй байх нь Гандигийн гүн ухааны гол цөм нь байсан. Энэ нь аливаа амьд биетийг бие махбод, оюун санааны хувьд дарамт, хүчирхийлэлгүй, эвтэй найртай амьдрахын төлөө хичээх явдал юм.
3. **Non-Stealing (Asteya) –Хулгай хийхгүй байх:** Бусдын эд хөрөнгийг хүндэтгэж, шударга байхыг эрхэмлэдэг. Хулгайн явдал, шунахайн сэдлээс зайлсхийж, өөрийн байгаа байдалд сэтгэл хангалуун байхыг хэлнэ.
4. **Chastity (Brahmacharya) – Цэвэр, ариун байх:** Ганди өөрийгөө хянах, амин чухал энергийг хадгалахад итгэдэг байв. Энэ утгаараа ариун явдал гэдэг нь гэр бүлгүй байх, бэлгийн үйл ажиллагааг хийхгүй байх гэж үздэг байв.
5. **Non-Possession (Aparigraha) – Өмчгүй байх:** байдал: Энэ нь хэт эд хөрөнгөөс татгалзаж, сэтгэл хангалуун байх, энгийн буюу минимализмыг дэмждэг.
6. **Control of Diet (Asaucha) – Амтанд шунахгүй байх:** Энэ нь ухаалаг хооллолт, цагаан хоолны дэглэмийн ач холбогдлыг онцолдог. Ганди хоол хүнсний сонголтыг бие махбодын олон оюун санааны цэвэр ариун байдлыг хадгалах хэрэгсэл мөн амьтадын амийг таслах байх сонголт гэж үзсэн.

¹¹² <https://testbook.com/articles/11-principles-of-mahatma-gandhi> Махатма Гандигийн 11 зарчим

7. **Fearlessness (Abhaya) – Айдасгүй байх:** Энэ нь хүмүүсийг зоригтой, тэсвэр хатуужилтай, бэрхшээлийг давах туулах сэдлийг өгдөг.
8. **Equality (Sarvodaya) – Энэ нь ялгаварлан гадуурхалтын эсрэг тэгш бус байдлыг арилгахын төлөө байдаг.**
9. **Bread Labor (Bhoodan) – Биеэр хөдөлмөрлөх:** Хөдөлмөрийн үнэ цэнийг мэдэрч, ялангуяа биеийн хүчний ажил нь ангийн ялгааг багасгадаг.
10. **Swadeshi (Self-Sufficiency) – Хөршийгөө дэмждэг байх:** Үндэсний үйлдвэрлэлийг дэмждэг. Энэ нь улс орны эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх хэрэгсэл гэж үздэг.
11. **Removal of Untouchability (Sarva Dharma Samabhava) – Давхраажлыг арилгах:** Хүмүүсийн нийгмийн уг гарвалаас үл хамааран тэгш байдлыг түгээх, энэтхэг онцлогтой давхраажлыг арилгахыг уриалдаг.

2.7. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Соён гэгээрэл гэдэг ойлголт нь 1700-аад онд үүссэн, дэвшлийг боомилсон бүтцийг даван туулах зорилгоор саруул ухаанаар сэтгэж, үйлдэх хөгжлийг хэлдэг байна. Соён гэгээрлийн хамгийн чухал таних тэмдэг бол “саруул ухаан”¹¹³-д үндэслэн үнэлгээ өгч, шийдвэр гаргах явдал юм. Нийгэм-улс төрийн хувьд, соён гэгээрлийн зорилго нь хувь хүний үйлдэх эрх чөлөө¹¹⁴ (эманзипац), боловсрол, иргэний эрх, ерөнхий хүний эрх, төрийн чиг үүрэг болох нийтийн ач тус (эрх ашиг) гэсэн ойлголтуудад зонхилон чиглэсэн байдаг байна. Соён гэгээрлийн давалгаанууд утга зохиол, гоо сайхны урлаг, 1776 оны америкийн хувьсгал, 1789 оны францын хувьсгал зэргээр улс төрд хүчтэй нөлөө үзүүлж, улмаар улс төр болон нийгмийн байгуулалтад үргэлжилсэн дэвшлийн үйл явц болон тогтсоноор соён гэгээрэл нь орчин үеийн билэг тэмдэг болсон юм. Улмаар соён гэгээрлийн уламжлал нь НҮБ-аас 1948 оны 12 дугаар сард баталсан “Хүний эрхийн ерөнхий тунхаглал”-д тусгалаа олж, тунхаглагдсан юм.¹¹⁵

Дотоод сэтгэлийн боловсролыг олгох тухай тусгайлан зохицуулсан хууль, дүрэм хэдийгээр байхгүй ч ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт ёсзүй, ёс суртахуун болон зан суртахуун ба иргэний боловсролын хичээлийн агуулгад тусгагдсан гэж үзэж болохоор байна. Дээрх хичээлүүд нь суралцагч, өсвөр үе, залуучууд өөрсдийн эрх, эрх чөлөөгөө мэдэж, шийдвэр гаргах үйл явцад оролцох, байр сууриа илэрхийлэх чадвараа хөгжүүлэхэд туслах, оролцоо бүхий нийгмийн хариуцлагатай гишүүн болон төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх, залуучуудын ёс суртахууны ухамсар, ёс суртахууны зан байдлыг хөгжүүлэхэд чиглэж байна.

¹¹³ Vernunft-германаар

¹¹⁴ Emanzipation-германаар

¹¹⁵ Соён гэгээрэл-Aufklärung-германаар <https://de.wikipedia.org/wiki/Aufkl%C3%A4rung>

Дотоод сэтгэлийн боловсрол–нэр томьёоны хувьд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт байхгүй хэдий ч бусдыг энэрэн нигүүлсэх сэтгэл гэж ойлгоно. “Орчин үеийн боловсрол 200 гаруй жил хөгжиж, техник, технологи, материаллаг дэвшилд их анхаарч харин сэтгэлийн боловсролд сайн анхаарсангүй. Хүн хүнээ хайрлах, энэрэх дотоод сэтгэлийн боловсрол олгох хэрэгцээтэй болов.”¹¹⁶ Дотоод сэтгэлийн боловсролыг сүм хийд олгож ирсэн түүхэн уламжлалтай билээ. Азийн орнуудын хувьд, ёс суртахуун, иргэний боловсролын хичээл болон бусад хичээлийн хүрээнд шашны талаарх ойлголтыг өгдөг бол хичээлээс гадуурх хөтөлбөрийн хүрээнд, эсхүл хувийн сургуулиуд нь шашны сургалт явуулах эрхтэй байна. Харин европын хувьд, ерөнхий боловсролын хичээлийн хөтөлбөрт ёс суртахуун, иргэний боловсролын хичээлүүдээс гадна шашин судлалын хичээл орох нь харьцангуй түгээмэл байна. Европын 31 улсад судалгаа явуулахад, 14-т нь ёс суртахуун, зан суртахуунд чиглэсэн бие даасан хичээлийн хүрээнд заадаг бол 17 улс нь бусад хичээлийн судлах сэдвийн хүрээнд багтаасан байна.

Иргэний боловсрол хэмээх ойлголт нь хүүхэд, залуучуудыг нийгмийн идэвхтэй гишүүн болгон бэлтгэн хүмүүжүүлэх боловсролын салбар, харин иргэншлийн боловсрол нь тухайн нийгмийн гишүүд иргэн болон төлөвших үйл явцыг тэмдэглэсэн ойлголт гэж үздэг байна.¹¹⁷

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага (ЮНЕСКО) бүх иргэн, хүн амын бүлэгт хүртээмжтэй хүний эрхийн боловсрол, сургалтын иж бүрэн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатайг гишүүн улс орнуудын анхааралд хүргэх, түүх, иргэний боловсрол зэрэг сургалтын хөтөлбөрт хүний эрхийн агуулгыг тусгаж, зөрчлийг энхийн замаар шийдвэрлэх, хүчирхийллийн бус стратегийг боловсруулах, улмаар тухайн боловсролын хөтөлбөрийн амжилт ололтыг гишүүн орон бүр 5 жил тутамд үнэлж байх талаар зөвлөмжийг 1987 онд гаргажээ.

Иргэний боловсролын талаар 1999 онд хэрэгжүүлсэн олон улсын харьцуулсан судалгаанаас үзэхэд, иргэний боловсролтой холбогдох зорилго, зорилтуудыг янз бүрээр тодорхойлдог хэдий ч дараах зорилтууд нийтлэг байна:

- Хувь хүний чадавх, бололцоог нэмэгдүүлэх;
- Тэгш бололцоог дэмжих;
- Залуу үеийг ажил хөдөлмөрт бэлтгэх;
- Цаашдын буюу дээд боловсрол эзэмших үндэс суурийг тавих;
- Мэдлэг, чадвар, ойлголт бий болгох;

¹¹⁶ О.Пүрэв “Боловсролын хүн судлал ба суралцагчийн хүмүүншил, хөгжил” Боловсролын хүрээлэн <https://humanities.mn/fileman/Uploads/lltgel/2016-2017/hawar/3-purev.pdf>

¹¹⁷ “Иргэний боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг” Судалгааны тайлан, ННФ. УБ. 2011. 68-70 дахь тал

- Иргэншил буюу ардчилал ба нийтлэг хэм хэмжээнд суралцуулах;
- Соёлын өв уламжлалаа хадгалах, эдлэх явдал зэрэг болно.

Иргэний боловсрол нь хүний эрх, ардчилал, улс төр, иргэн-төрийн харилцаа, шийдвэр гаргах үйл явцын талаар мэдлэг эзэмших, чадвар, хандлагаа хөгжүүлэх үйл явцыг багтаасан, олон бүрэлдэхүүн хэсэг бүхий насан туршийн боловсрол юм. Иргэний боловсролын агуулгад мөн плюрализм, олон соёлт орчин, угсаатны ба соёлын өв уламжлал, нийгмийн ялгарал, хүлээцтэй хандах байдал, нийгмийн зүй ёс, үндэсний онцлог, ухаалаг байдал, байгаль орчны ач холбогдлын мэдрэмж зэрэг олон шинэлэг асуудал тусдаг байна. Хүн нийгмийн амьдралын олон талт харилцаанд оролцдог учир тухайн хүнд нийгмийн харилцааны үндэс суурь, зарчмууд, үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдлэг, ойлголт байх шаардлагатай. Тиймээс иргэний боловсролын хичээлийн агуулга нь улс төр, эдийн засаг, нийгэм, ёс суртахуун, соёлын гэсэн 5 үндсэн айн хүрээнд боловсрогдож, эдгээрийн талаар зохих мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэх нь зүйтэй хэмээн судлаачид үздэг байна.

«Иргэний боловсрол»-ын агуулгыг нийгмийн ухаан, нийгэм судлал, дэлхий судлал, хүн ба нийгэм, амьдралын ухаан, мэргэжлээр дэвших, хүний эрхийн боловсрол, ёс зүйн боловсрол, эрх зүйн боловсрол зэрэг олон хичээлийн хүрээнд улс орнууд өөрийн иргэддээ орчин үеийн нийгмийн улс төр, эдийн засаг, соёл, ёс суртахууны харилцааны үндсийг заан сургаж, тэдгээр харилцаанд үр ашигтай оролцох талаар зохих чадвар, хандлагыг төлөвшүүлж иржээ. Түүнээс гадна иргэний боловсрол нь түүх, газар зүй, эдийн засаг, улс төр судлал, байгаль орчин судлал, шашин судлал, төрөлх ба гадаад хэл зэрэг бусад хичээлүүдтэй харилцан холбогдож, иргэдийг нийгмийн харилцаанд бэлтгэхэд дэмжлэг үзүүлдэг байна.¹¹⁸

Герман Улсын ёс зүй, зан суртахууны боловсролын чиг хандлага нь баруун европ буюу бүс нутгийн хэмжээнд олон загвар, хандлага бүрэлдэн тогтсон улсад хамаарна. Муж улсуудын Боловсролын сайд нарын хуралдаанаас 1950 онд ерөнхий боловсролын дунд болон их, дээд сургуулийн иргэний боловсролын хичээлийн үндсэн зарчмыг “иргэний боловсрол нь сурагчдын ёс суртахууны ба нийгмийн хариуцлагатай гишүүний үйл, үйлдлийн ухамсрыг төрүүлэх ёстой” хэмээн тогтоосон байна.

Боловсролын хөтөлбөрийн хүрээнд ёс зүй, ёс суртахуун, зан суртахууны хичээлийн сэдвийг бие даасан хичээл байхаар тогтсон бөгөөд

- ёс зүй;
- амьдрах гүн ухаан - ёс зүй;

¹¹⁸ Д.Халиун нар “Хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаарх бусад орны туршлага” СТ-18/211 Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, УИХТГ 2019

- хүүхэд нас, үнэт зүйл, хэм хэмжээний гүн ухааны хичээлийг заавал судлах буюу заавал судлах/сонгон судлах хэлбэрээр, харин
- шашин судлалын хичээлийн шашны нэг гол урсгалд чиглэсэн хөтөлбөр (хичээлийн агуулга, сургалтын материал боловсруулахад шашны нийгэмлэгүүд голлох үүргийг гүйцэтгэнэ)-ийг заавал судлах буюу заавал судлах/сонгон судлах хэлбэрээр, аль нэг шашны урсгалд чиглээгүй, шашны талаар ерөнхий ойлголт олгох (төр буюу сургууль нь төвийг сахисан байр сууринаас, хүний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хүндэтгэж, сургалтыг явуулна) хөтөлбөрийг нэмэлт хичээлийн хэлбэрээр тус тус зохион байгуулдаг байна.

Герман Улсын дунд сургуулийн нийгмийн ухаан, гүн ухааны хичээлийн хөтөлбөр дэх хэм хэмжээний харьцуулалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5. Ёс суртахууны хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээ ба конвенц (нэгдмэл байдал)¹¹⁹

Төрөл	ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ	ЁС СУРТАХУУНЫ ХЭМ ХЭМЖЭЭ	КОНВЕНЦ (НЭГДМЭЛ БАЙДАЛ)
Е р ө н х и й ойлголт	“Хэм хэмжээ” (латинаар “дүрэм”) гэж харилцан үйлдлийн журмыг хэлнэ. Тэрээр тодорхой үйлдэл хийхийг зөвшөөрөх буюу хориглохыг илэрхийлнэ.		
Тодорхойлолт	(тодорхой нөхцөлд) ямар үйлдлийг хориглох буюу хийвэл зохих, болон зөвшөөрөх эсэхийг хуулиар (тодорхой) тогтоосон дүрэм	(тодорхой нөхцөлд) ямар үйлдэл зохих, хориглох буюу зөвшөөрөх талаарх дүрэм	(тодорхой нөхцөлд) нэгдмэл сонирхолтой хүмүүсийн бүлэгт (тухайлбал, уламжлал, зан заншил, соёл, шашин) мөрдөгдөх дүрэм
Хамрах хүрээ	- Улс төрийн тодорхой газар нутгийн хүрээ (тухайлбал, ХБНГУ, муж улс) - Хүмүүсийн тодорхой бүлэг (тухайлбал, 18 нас хүрсэн Герман Улсын иргэн сонгуулийн эрхтэй) - Бүх хүн (тухайлбал, амьд явах хүний эрх)	- Бүх хүн (тухайлбал, худал хэлэхийг хориглох)	- Тодорхой бүлэг хүмүүс (тухайлбал, тодорхой шашны гишүүн мөргөлчдийн дүрэм; тодорхой соёл дахь мэндлэх дүрэм)

¹¹⁹ Ёс суртахууны хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээ ба конвенц (нэгдмэл байдал)-Moralische Normen, rechtliche Normen und Konventionen-*германаар* <https://www.schule-bw.de/faecher-und-schularten/gesellschaftswissenschaftliche-und-philosophische-faecher/ethik/methodik-didaktik/methodik-ethik/normen-und-konventionen-info.pdf>

<p>Хэм хэмжээг зөрчсөнөөр хүлээх хариуцлага</p>	<ul style="list-style-type: none"> - Гэмт хэргийн бүртгэл - Гэмт хэргийн мөрдлөг - (болзошгүй) Шийтгэл (тухайлбал, мөнгөн торгууль, баривчлах ял, нийгмийн тустай хөдөлмөр) 	<p>Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - Ичих (өөрийн хийсэнд) - Шаналах (өөрийн хийсэнд) - Нийгмийн жигшил - Доромжлох - Үл итгэх 	<p>Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> - Нийгмийн гадуурхал (тухайлбал, хөмсөг зангидах, жаахан ханиах /”хм” гэх/, басамжилж харах) - Загнах
<p>Жишээ</p>	<ul style="list-style-type: none"> - “нийтийн тээвэрт туулайчлах хориотой” - “улаан гэрэл асч байхад гарцаар гарахыг хориглоно” - “зовсон хүнд өөрийн боломжийн хэрээр үл туслах нь гэмт хэрэг мөн” 	<ul style="list-style-type: none"> - “худал ярьж болохгүй” - “шаардлагагүй бол хог гаргахгүй байх хэрэгтэй” - “зөрчлийг эвийн аргаар шийдэх нь зүйтэй” 	<ul style="list-style-type: none"> - “хэрэв чи бэлэг авсан бол гялайснаа илэрхийлэх хэрэгтэй.” - “их дэлгүүрийн кассчинтай мэндлэх нь зохимжтой” - “дарааллын урдуур дайрах нь хүндэтгэлгүй хэрэг”



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Сингапур Улс

- <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=99663443-930d-418e-b010-4718d0ad7543>
- <https://www.moe.gov.sg/education-in-sg/our-programmes/national-education>
- <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=fa092bc5-6339-4c60-beb2-b6355d6027cc>
- <https://www.nlb.gov.sg/main/article-detail?cmsuuid=c78526c6-decf-4b79-b4ca-421739464884>
- <https://values-in-practice.com/>
- <https://www.sgjourney.gov.sg/>
- <https://www.sgjourney.gov.sg/pdfs/welcome-to-singapore/>

Эстони Улс

- https://link.springer.com/content/pdf/10.1007/978-3-030-71102-3_7.pdf
- <https://www.jsse.org/index.php/jsse/article/view/5368>
- <https://eetika.ee/en/content/ethics-estonia>
- <https://eetikakeskus.ut.ee/en/content/about-centre-ethics>
- <https://euroguidance.eu/guidance-system-in-estonia>
- <https://www.educationestonia.org/innovation/>
- https://www.educationestonia.org/wp-content/uploads/2022/12/haridusvaldkonna_arengukava_2035_kinnitaud_vv_eng_0-1.pdf
- https://national-policies.eacea.ec.europa.eu/sites/default/files/2023-04/Estonia_2021.pdf
- <https://valitsus.ee/en/estonia-2035-development-strategy/necessary-changes/sustainability-nation-health-and-social>
- Гадаадын зарим орны бага, дунд боловсролын тогтолцоо ба үндэсний өв, соёлыг сургалтын агуулга, хөтөлбөрт тусгасан байдлын талаарх харьцуулсан судалгаа (СТ-18/210). Д.Халиун, Б.Нандингэрэл, И.Жаргалзаяабямба. УИХТГ-ын ПССХ-ийн Судалгааны алба. 2018 он.

Япон Улс

- Social Education Law <https://www.hurights.or.jp/archives/asiapacific/section1/pdf/Social%20Education%20and%20Kominkan.pdf>
- Basic Plan for the Promotion of Education <https://www.mext.go.jp/en/policy/education/lawandplan/title01/detail01/1373797.htm>
- Moral education in Japan <https://www.nier.go.jp/English/>

- educationjapan/pdf/201303MED.pdf
- Japanese educational system <https://www.studyinjapan.go.jp/en/planning/educational-system/>
- Social Education in Japan https://www.mext.go.jp/component/a_menu/education/detail/
- Japan overview of the education (EAG 2023) <https://gpseducation.oecd.org/CountryProfile?primaryCountry=JPN&treshold=10&topic=EO>
- Social education and social work in Japan <https://journals.uclpress.co.uk/ijsp/article/pubid/IJSP-10-12/>

Солонгос Улс

- БНСУ-ын Боловсролын яам <https://english.moe.go.kr/sub/infoRenewal.do?m=0302&page=0302&s=english>
- 2020 Education in Korea <http://koreaneducentreinuk.org/wp-content/uploads/2021/04/2020EducationinKorea.pdf>
- The National Curriculum for the Primary and Secondary Schools <http://koreaneducentreinuk.org/wp-content/uploads/2021/02/The-National-Curriculum-for-the-Primary-and-Secondary-Schools-2015.pdf>
- global Citizenship Education in South Korea through Civil Society Organizations: Its Status and Limitations <https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/110049/1/4.%20심희정.pdf>
- Civic Education and Political Empowerment Among South Korean Youth <https://stacks.stanford.edu/file/druid:nw989rf6654/Han%20-%20Civic%20Education%20and%20Political%20Empowerment%20Among%20South%20Korean%20Youth.pdf>
- БНСУ-д амьдрах иргэдэд зориулсан гарын авлага www.liveinkorea.kr

Казахстан Улс

- Конституция Республики Казахстан. (принята на республиканском референдуме 30 августа 1995 года) (с изменениями и дополнениями по состоянию на 23.03.2019 г.) <http://online.zakon.kz>
- Закон о государственной службе Республики Казахстан от 23 ноября 2015 года. (с изменениями и дополнениями по состоянию на 11.01.2021 г.) <http://online.zakon.kz>
- “Об утверждении Реестра должностей политических и административных государственных служащих” Указ Президента Республики Казахстан от 29.12.2015 года № 150. <https://adilet.zan.kz/rus/docs/U1500000150>
- “Об утверждении квалификационных требований к отдельным

политическим государственным должностям” Указ Президента Республики Казахстан от 31.12.2020 года № 485. <https://adilet.zan.kz/rus/docs/U2000000485>

- Пралиев С.Ж. Үндэсний хүмүүжил. Сборник лекции. Алматы. КазНПУ имени Абая. Алматы 2011 г.

Энэтхэг Улс

- <https://timesofindia.indiatimes.com/blogs/india-to-bharat/is-the-national-education-policy-focused-on-making-enlightened-and-responsible-citizens/>
- <https://ayurgyannayas.org/story/> “Бүх нийтийн ёс зүйн боловсрол” хөтөлбөр
- <https://prepp.in/news/e-492-citizens-charter-ethics-notes> Иргэний дүрэм (Энэтхэг)
- <https://testbook.com/articles/11-principles-of-mahatma-gandhi> Махатма Гандигийн 11 зарчим
- <https://timesofindia.indiatimes.com/blogs/india-to-bharat/is-the-national-education-policy-focused-on-making-enlightened-and-responsible-citizens/>

Герман Улс

- Соён гэгээрэл-Aufklrung-германаар <https://de.wikipedia.org/wiki/Aufkl%C3%A4rung>
- О.Пүрэв “Боловсролын хүн судлал ба суралцагчийн хүмүүншил, хөгжил” Боловсролын хүрээлэн, 2017 <https://humanities.mn/fileman/Uploads/Iltgel/2016-2017/hawar/3-purev.pdf>
- “Иргэний боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг” Судалгааны тайлан, ННФ 2011. 68-70 дахь тал
- Д.Халиун нар “Хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшил, ёс суртахууны боловсролын талаарх бусад орны туршлага” СТ-18/211 Судалгаа, мэдээлэл, лавлагааны алба, УИХТГ 2019

УИХ МН
СУДАЛГААНЫ САН

**МОНГОЛ УЛС ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ,
ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН НИЙГМИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ ТОЙМ
МЭДЭЭЛЭЛ**

*Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш,
О.Нарантуяа, Б.Батцэцэг*

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ

НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН
ОРЧНЫ ТОЙМ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

- ЭРХ ЗҮЙН ОРЧИН
- ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦ
- ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ
- БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД
- МОНГОЛ УЛСЫН ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

ХОЁР. МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН АСУУДЛУУДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

- ДУНДАЖ НАСЛАЛТ
- ЭРҮҮЛ МЭНД
- БОЛОВСРОЛ
- ГЭМТ ХЭРЭГ
- ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН
- ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХАА	Хөдөө аж ахуй

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн Монгол Улсын хууль тогтоомж
- Хүснэгт 2. Монгол Улсын жендэрийн зөрүүтэй байдлын индекс (2006 оноос хойш)
- Хүснэгт 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан заалт
- Хүснэгт 4. Нас баралт, насны бүлгээр
- Хүснэгт 5. Нас баралт, зонхилох өвчний төрөл
- Хүснэгт 6. Хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг (хүйсээр, хувиар)
- Хүснэгт 7. Хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хот хөдөө (хүйсээр)
- Хүснэгт 8. Хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, бүс аймаг, нийслэл (6 ба түүнээс дээш нас)
- Хүснэгт 9. Гэмт хэрэг үйлдэгдсэд, аймгуудаар (сүүлийн 5 жил)

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

- График 1. Дундаж наслалт, хүйсээр (2015-2022 он)
- График 2. Дундаж наслалтын зөрүү, аймгаар
- График 3. Төрөлт, нас баралт, хүйсээр (дүнд эзлэх хувиар 2022 он)
- График 4. Хүн амын нас баралтын түвшин, бүс нутаг, нийслэлээр (сүүлийн 5 жил)
- График 5. Хөдөлмөр эрхлэх насандаа нас барсан байдал
- График 6. Сургуульд хамрагдалт
- График 7. Хүн амын боловсролын түвшин
- График 8. Хүн амын боловсролын түвшин хот хөдөө
- График 9. Гэмт хэрэг үйлдэгсэд (сүүлийн 5 жил)
- График 10. Ял шийтгүүлэгсэд (сүүлийн 5 жил)
- График 12. Албан бус хөдөлмөр эрхлэлт, ХАА-н салбар орсон байдлаар, (сүүлийн 5 жил)
- График 13. Албан бус хөдөлмөр эрхлэлт, ХАА-н салбарыг хассан байдлаар (сүүлийн 5 жил/)
- График 14. Ажилгүйдлийн түвшин (сүүлийн 5 жил)
- График 15. Өрх толгойлсон эцэг (сүүлийн 5 жил)

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүний захиалгаар “Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдлын тойм” сэдэвт мэдээлэл лавлагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэн (ПССХ)-д гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдлын талаарх тойм судалгаа, мэдээлэл бэлтгэх. Үүний дотор эрэгтэйчүүдийн хүний хөгжил, нийгмийн асуудлуудын талаарх статистик тоон мэдээ бэлтгэх.

Судалгааны хамрах хүрээ:

- Эрх зүйн орчин;
- Монгол Улсын нөхцөл байдлыг тодруулах.

Судалгааны бүтэц:

Судалгаа нь бүтцийн хувьд удиртгал, судалгааны хураангуй, жендэрийн эрх тэгш байдлын талаарх эрх зүйн орчин, эрэгтэйчүүдийн хүний хөгжил, нийгмийн асуудлуудын нөхцөл байдал гэсэн хэсгээс бүрдэнэ.

Судалгаанд Үндэсний статистикийн хорооны статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн тоон мэдээллийг эх сурвалж болгон ашигласан болно.



НЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ ТОЙМ, НӨХЦӨЛ БАЙДАЛ

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиудаар эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхахгүй байх, жендэрийн тэгш байдлыг хангах үзэл санааг баталгаажуулж, бүх шатны сонгогдох болон томилогдох албан тушаалд жендэрийн тэгш байдлыг хангах зэрэг асуудлуудыг зохицуулсан. 2011 онд УИХ-аас баталсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль нь жендэрийн харилцааны асуудлыг тусгайлан зохицуулсан суурь хууль юм. Хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах тогтолцоо бүрдэж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, тайлагнах, хяналт тавих механизмууд бий болсон.

Дээр дурдсан олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргийн дагуу үндэсний эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгоор манай улс дараах хууль тогтоомжийг баталж, хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн Монгол Улсын хууль тогтоомж

Хууль тогтоомжийн нэр	Хууль тогтоомжийн зохицуулалт
Монгол Улсын Үндсэн хууль (1992)	14.2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. 16.11.улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;
Монгол Улсын Засгийн газрын тухай хууль	20 дугаар зүйл.Засгийн газрын бүрэлдэхүүн 4.Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд дараах асуудал хамаарна: -жендэрийн хөгжлийн асуудал;

<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай (2011)</p>	<p>8 дугаар зүйл.Улс төрийн хүрээн дэх жендэрийн эрх тэгш байдлын баталгаа</p> <p>8.1.Улс төрийн нам, үйлдвэрчний эвлэлийн болон олон нийтийн бусад байгууллагад гишүүнээр эвлэлдэн нэгдэх, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, тэгш боломжийг хязгаарлах, ялгаварлан гадуурхахыг хориглоно.</p> <p>8.2.Бүх шатны сонгуульд нэр дэвшигч эрэгтэй, эмэгтэй хүний сонгуулийн сурталчилгаанд зориулан улс төрийн намаас үзүүлэх санхүүгийн дэмжлэг ижил хэмжээтэй байна.</p> <p>8.3.Улс төрийн намын өөрийн төлөөллийн төв болон орон нутгийн байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 25 хувиас доошгүй байна.</p> <p>10 дугаар зүйл.Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгаа</p> <p>10.1.Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараахь бодлого хэрэгжүүлнэ:</p> <p>10.1.1.томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх;</p> <p>10.1.2.төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх;</p> <p>10.1.3.зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх;</p> <p>10.1.4.төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд 40:60 гэсэн харьцааг хангах бодлого, арга хэмжээг тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.</p> <p>10.2.Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс (цаашид "хороо" гэх) зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна.</p> <p>10.3.Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн 40:60 гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх бөгөөд энэ хуулийн 6.5.6-д заасан тохиолдолд энэ заалт үл хамаарна.</p>
--	---

<p>Төрийн албаны тухай хууль (2017)</p>	<p>31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.</p>
<p>Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль (2020)</p>	<p>12.9.Комиссын гишүүнийг томилохдоо жендэрийн тэгш байдлыг харгалзан үзэх бөгөөд энэ хуулийн 12.1-д заасан гишүүний 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийн төлөөлөл байна.</p>
<p>Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)</p>	<p>30.2.Нам, эвслээс нэр дэвшүүлэхэд 2024 оны ээлжит сонгуулиар нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь, 2028 оны ээлжит сонгуулиар 40-өөс доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байна <u>2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө./</u></p>
<p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)</p>	<p>29.2.Нам, эвслээс нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн 20-оос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна.</p>
<p>Улс төрийн намын тухай хууль (2023)</p>	<p>2024.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. 8.1. Нам гишүүдээ намын удирдах байгууллага, албан тушаал, сонгуульд нэр дэвших, сонгох, томилоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байж, тэгш боломж олгоно. 8.2.3.нэр дэвшүүлэхдээ аль нэг хүйсийн төлөөлөл 30 хувиас доошгүй байх. 15.2.Намын дүрэмд дараах нийтлэг зүйлийг тусгана: 15.2.8.төрийн улс төрийн албан тушаалд болон намын удирдах албан тушаалд нэр дэвшигчийг сонгох, томилох, чөлөөлөх, тэдгээрт жендэрийн тэгш байдлыг хангах журам; 17.7.Намын төлөөллийн төв байгууллага, гүйцэтгэх төв байгууллага болон хяналтын байгууллагын бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна.</p>
<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)</p>	<p>6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:</p>
<p>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p>	<p>4.2.7.Бүх нийтэд хүний эрх, жендэрийн боловсрол олгох үндэсний тогтолцоог хөгжүүлж, жендэрийн тэгш байдлыг хангах бодлого баримтална. 4.2.8.Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлж, улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүх хүрээнд эмэгтэйчүүд үр дүнтэй оролцох, манлайлан ажиллах тэгш боломжоор хангана.</p>

<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031) (2022.10.05-ны өдөр ЖҮХ-ны тогтоолоор баталсан)¹²⁰.</p>	<p>Энэхүү стратеги төлөвлөгөө нь нийт 5 үндсэн зорилготой.</p> <ul style="list-style-type: none"> • Зорилго-1.Охид, хөвгүүд, эмэгтэй эрэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох тэгш боломж бүрдүүлнэ. • Зорилго-2.Эдийн засгийн хүрээнд жендэрийн тэгш боломж, тэгш оролцоог дэмжинэ. • Зорилго-3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог хөгжүүлнэ. • Зорилго-4.Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг нэмэгдүүлнэ. • Зорилго-5.Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицоход жендэрийн тэгш оролцоог хангана.
<p>“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол</p>	<p>Зорилт 2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ. <i>1 үе шат (2021-2030):</i>Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе. 2.Иргэн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлэн, тэгш хамруулж, бүх шатны боловсролын залгамж холбоог хангаж, сургалт, үйл ажиллагааны чанарыг дээшлүүлсэн байна. Зорилт 3.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. <i>1 үе шат (2021-2030):</i> Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх үе.</p>
<p>Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоол)</p>	<p>Зорилго 2.Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэх тогтолцоог бэхжүүлж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ. Зорилт 2.1.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ:</p>

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ КОНВЕНЦ

Дээрх олон улсын болон үндэсний хууль тогтоомжоос гадна дэлхий нийтээрээ нэг зорилго болгон хэрэгжүүлэхээр хүчин чармайлт гаргаж буй үүрэг, амлалтууд байна. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2015 онд баталсан 2030 он хүртэлх Дэлхийн Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт “жендэрийн тэгш байдлыг хангах, охид эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн 5 дугаар зорилтыг биелүүлнэ.” гэж, Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Засгийн газар бүр өөрийн бүх бодлого, хөтөлбөрт жендэрийн үзэл баримтлалыг тусгана. Жендэрийн асуудал нь тухайлан нэг салбарын асуудал бус салбар дундын асуудал тул тогтолцоог тасралтгүй бэхжүүлэх.”

¹²⁰ <https://www.ncge.gov.mn/uploads/legal/c926eb06d6c6a482b2b7056100e954d4.pdf>

гэж, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцын хорооны 2016 оны 1382 дугаар хуралдааны зөвлөмжийн 13(а)-д конвенцыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үйл ажиллагааны төвлөрлийг сааруулах зарчмаар явуулахад нь хүний нөөцийн, техникийн болон санхүүгийн хөрөнгө нөөцөөр хангах замаар Жендэрийн үндэсний хороог бэхжүүлэх зэрэг үүрэг, амлалтыг авчээ.

Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрүүдийг 1996 оноос хойш батлан хэрэгжүүлсэн байна. Тухайлбал,

- Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах Үндэсний хөтөлбөр (1996)
- Эмэгтэйчүүдийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2000)
- Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008-2021)
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах Дунд хугацааны стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө (2013-2016)
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх Үндэсний хөтөлбөр (2005-2015)
- Хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгт өртөхөөс сэргийлэх Үндэсний хөтөлбөр (2005-2014)
- Эрүүл мэндийн салбарын Мастер төлөвлөгөө (2005-2015)
- Нөхөн үржихүйн эрүүл мэндийн 3 дахь хөтөлбөр (2007-2011)
- Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах бодлого (2004-2015)
- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах Үндэсний стратеги (2014-2018)
- Ядуурлыг бууруулж, ажил эрхлэлтийг дэмжих бодлого (2010-2014)
- Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого (2011-2015)
- Нийгмийн халамж, хөдөлмөрийн бодлого (2011-2015)
- Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2020-2022)

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ (2021.01.20, ДУГААР 01):

Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай¹²¹ хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь ... 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх ...-т тэтгэмж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.”, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “хүүхдээ асарч байгаа” гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 106.1-д заасан

¹²¹ <https://legalinfo.mn/mn/detail/12756>

хүүхэд асрах чөлөөтэй болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан ажилгүй эх 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгааг;”, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт “Төрүүлсэн 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эх сар бүр хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль ...-ийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... хүйс ...-ээр нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургаадугаар зүйлийн 11 дэх заалтын “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. ...” гэж заасныг тус тус зөрчсөн гэж шийдвэрлэсний дагуу дээрх хуулиудад гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/ гэж өөрчилсөн. Энэхүү шийдвэр нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд нэгэн том туршлага болохуйц шийдвэр юм.

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД

Жендэрийн үндэсний хорооноос Жендэрийн стратеги (2016-2024)-ийг 2016 онд батлан хэрэгжүүлж байна. Энэ стратегийн хүрээнд салбар бүрд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж байна. Тухайлбал,

- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2024) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал
- Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого (2021-2024) Эрүүл мэндийн сайдын тушаал
- Зам тээврийн салбарт жендэрийн талаарх баримтлах бодлого (2021-2026) Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал
- Барилга, хот байгуулалтын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025) Барилга, хот байгуулалтын сайдын тушаал
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт баримтлах жендэрийн тэгш байдлыг хангах бодлого (2017-2024) Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын тушаал
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2018-2025) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаал
- Хууль сахиулах байгууллагуудын жендэрийн нэгдсэн бодлогын баримт бичиг (2018-2021) Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал
- Байгаль орчны салбарын жендэрийн стратеги (2014-2030)

МОНГОЛ УЛСЫН ЖЕНДЭРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



Эх сурвалж: YСХ

Монгол Улс Дэлхийн эдийн засгийн форумгаас эрхлэн гаргадаг Дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын 2023 оны тайлангаар жендэрийн хөгжлийн индексээр 191 улсаас 96 дугаарт, жендэрийн ялгаатай байдлын индексийн үзүүлэлтээр дэлхийн 146 улсаас 70 дугаар, үүнээс эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцооны түвшингээр 26, эмэгтэйчүүдийн боловсролын түвшингээр 63 дугаарт, эмэгтэйчүүдийн улс төрийн эрх мэдэл, оролцооны хувь 113 дугаарт эрэмбэлэгдэж байна. Жендэрийн талаарх зарим үзүүлэлтийг авч үзвэл,

Хүснэгт 2. Монгол Улсын жендэрийн зөрүүтэй байдлын индекс 2006 оноос хойш

Жендэрийн зөрүүтэй байдлын индекс (Он)	Нийт		Эдийн засгийн оролцоо		Боловсрол эзэмших байдал		Эрүүл мэнд ба амьдрах чадвар		Улс төрийн эрх мэдэл	
	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо
2006 он (115 орноос)	42	0.682	21	0.704	20	0.999	1	0.980	101	0.046
2007 он (128 орноос)	62	0.673	47	0.668	23	0.999	1	0.980	113	0.046
2008 он (130 орноос)	40	0.705	10	0.756	1	1.000	1	0.980	95	0.084
2009 он (134 орноос)	22	0.722	1	0.833	1	1.000	1	0.980	100	0.075
2010 он (134 орноос)	27	0.719	2	0.875	59	0.992	1	0.980	124	0.032

2011 он (135 орноос)	36	0.714	3	0.850	47	0.995	1	0.980	125	0.032
2012 он (135 орноос)	44	0.711	1	0.839	50	0.994	1	0.980	127	0.032
2013 он (136 орноос)	33	0.720	2	0.833	49	0.994	1	0.979	108	0.073
2014 (142 орноос)	42	0.721	10	0.808	69	0.993	1	0.979	103	0.103
2015 (145 орноос)	56	0.709	22	0.783	73	0.992	1	0.980	117	0.084
2016 (144 орноос)	58	0.705	23	0.766	66	0.993	1	0.980	119	0.084
2017 (144 орноос)	53	0.713	20	0.776	65	0.993	1	0.980	107	0.102
2018 (149)	58	0.714	20	0.780	70	0.993	1	0.980	109	0.102
2020 (153)	79	0.706	29	0.751	71	0.993	1	0.980	120	0.102
2021 (156)	69	0.716	23	0.769	73	0.998	1	0.980	116	0.122
2022 (146)	70	0.715	26	0.765	63	0.994	1	0.980	113	0.121
2023 (146)	80	0.704	33	0.745	67	0.994	1	0.980	121	0.099

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд зааснаар аль нэг хүйсийн төлөөллийн хувийг дараах байдлаар зохицуулжээ. Тухайлбал,

Хүснэгт 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан заалт

	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.1	МУИХ-ын сонгуулийн тухай хууль 30.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хууль 29.2
УИХ	-	20 хувиас доошгүй	
Засгийн газар, аймаг, нийслэлд	15 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй
Дүүрэгт	20 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй
Суманд	25 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй
Хороонд	30 хувиас доошгүй	-	20 хувиас доошгүй

Харин төрийн албаны хувьд, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланд дурдсанаар нийт 225.205 төрийн албан хаагч ажиллаж байгаагийн 145554 буюу 64.6 хувийг эмэгтэй албан хаагч, 79,651 буюу 35.4 хувь нь эрэгтэй албан хаагчид эзэлж байна. Үүнийг ангилан авч үзвэл,

- | | |
|--|-----------------------|
| - Төрийн улс төрийн албан хаагч | 3759 буюу 1.7% |
| - Төрийн захиргааны албан хаагч | 22023 буюу 9.8% |
| - Төрийн тусгай албан хаагч | 47158 буюу 20.9% |
| - Төрийн үйлчилгээний албан хаагч эмэгтэйчүүд эзэлж байна. | 152265 буюу 67.6%-ийг |

Харин төрийн албан тушаалын төрлөөр авч үзвэл,

- Удирдах ажилтан 16,847
 - эмэгтэй 7275 буюу 43%
 - эрэгтэй 9572 буюу 57%
- гүйцэтгэх ажилтан 149,450
 - эмэгтэй 106,107 буюу 71%
 - эрэгтэй 43,343 буюу 29%
- Туслах ажилтан 58,908
 - Эмэгтэй 32,172 буюу 55%
 - Эрэгтэй 26,736 буюу 45% байна.

ХОЁР. МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН АСУУДЛУУДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ


ДУНДАЖ НАСЛАЛТ

Хүн амын дундаж наслалт гэдэг нь тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, түүний үр нөлөөг илэрхийлдэг Хүний Хөгжлийн индексийн үзүүлэлтүүдийн нэг юм. Дундаж наслалт нь шинэ төрсөн хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг илэрхийлнэ. Дундаж наслалтыг тухайн насны хүн ам, тэдгээрийн нас баралтыг харьцуулан нас баралтын коэффициентийг бодож, одоогийн наснаас дараагийн насанд шилжин амьдрах магадлалаар тооцдог. Тиймээс дундаж наслалтыг судлахдаа нас баралтыг насны бүлэг, хүйсээр авч үзэх нь зайлшгүй юм. Монгол Улс анх 1992 оноос эхлэн дундаж наслалтыг тооцож эхэлсэн.

Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 2022 оны байдлаар 9,4 жил байгаа нь дэлхийн дунджаас хоёр дахин их байна. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын 2016 оны статистикаас харахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү хамгийн өндөр улсуудаас 12-рт, Ази, Номхон далайн бүсийн хувьд 2-рт жагсаж байна.


2022 оны байдлаар эмэгтэй хүний дундаж наслалт 76.7 бол эрэгтэй хүний дундаж наслалт 67.3 жил байна.

График 1. Дундаж наслалт, хүйсээр (2015-2022 он)



Эх сурвалж: <https://www2.1212.mn/tables.aspx>

График 2. Дундаж наслалтын зөрүү (аймгаар)




Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдлыг аймагуудын хувьд харахад Орхон аймаг хамгийн их зөрүүтэй буюу 11.7 байгаа ба Сэлэнгэ, Дорноговь, Дархан-Уул, Сүхбаатар аймагууд зөрүү 10 буюу улсын дунджаас их байна. Говь-сүмбэр аймаг зөрүү хамгийн бага буюу 3.7 байна.

ЭРҮҮЛ МЭНД

Монгол Улсын хэмжээнд 2022 оны байдлаар төрөлт 66,910, нас баралт 19,301 байна.

График 3. Төрөлт, нас баралт, хүйсээр, (дүнд эзлэх хувиар, 2022 он)



Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар нийт 110,622 хүн нас барсан байна.

Хүснэгт 4. Нас баралт, насны бүлгээр

Он	Хүйс	Насны бүлэг															Totals
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+	
2014	Эмэгтэй	378	27	36	58	90	86	98	173	216	289	429	413	397	409	1,677	4,776
	Эрэгтэй	500	68	69	111	163	238	295	399	513	660	787	774	633	532	1,446	7,188
2015	Эмэгтэй	380	38	31	52	67	101	90	151	185	293	405	446	419	398	1,598	4,654
	Эрэгтэй	494	68	64	118	162	203	275	378	513	604	729	790	648	548	1,445	7,039
2016	Эмэгтэй	443	38	37	54	63	105	110	155	212	277	381	422	372	473	1,596	4,738
	Эрэгтэй	575	63	68	102	138	200	264	344	447	591	720	842	634	545	1,372	6,905
2017	Эмэгтэй	390	39	32	51	64	85	115	133	166	257	371	440	443	444	1,642	4,672
	Эрэгтэй	448	78	51	104	126	179	265	359	514	619	802	833	717	547	1,456	7,098
2018	Эмэгтэй	380	45	31	54	58	93	127	154	222	323	388	494	479	461	1,857	5,166
	Эрэгтэй	488	58	52	105	117	176	274	371	475	686	810	908	816	657	1,539	7,532
2019	Эмэгтэй	362	41	29	44	64	69	103	157	211	299	368	495	491	461	1,783	4,977
	Эрэгтэй	452	61	58	71	129	191	257	363	512	676	815	946	851	672	1,581	7,635
2020	Эмэгтэй	330	38	38	59	43	61	104	127	187	251	337	415	460	450	1,713	4,613
	Эрэгтэй	374	53	63	83	93	173	248	340	447	602	672	817	829	628	1,474	6,896
2021	Эмэгтэй	302	30	38	50	79	69	130	170	231	308	391	492	559	566	1,990	5,405
	Эрэгтэй	365	58	75	77	121	156	283	387	502	684	799	955	1,027	796	1,731	8,016
2022	Эмэгтэй	287	36	29	50	43	60	116	173	177	245	365	465	560	544	1,888	5,038
	Эрэгтэй	407	67	64	85	113	165	283	409	516	742	874	1,002	1,022	855	1,670	8,274
Totals		7,355	906	865	1,328	1,733	2,410	3,437	4,743	6,246	8,406	10,443	11,949	11,357	9,986	29,458	110,622

График 4. Хүн амын нас баралтын түвшин, бүс нутаг, нийслэлээр (сүүлийн 5 жил)





График 5. Хөдөлмөр эрхлэх насандаа нас барсан байдал

**НАСНЫ
БҮЛГИЙН
ХУВЬД**

**Хөдөлмөр эрхлэх насандаа
нас барсан**



Эрэгтэйчүүдийн нас баралт 15 наснаас эхлэн эмэгтэйчүүдээс их болж, 45 наснаас огцом нэмэгджээ. Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйгээс 3.3 дахин илүү байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү ихэсч, эрчүүд богино насалж байгаагийн хамгийн том шалтгаан нь “халдварт бус” өвчин байна. Халдварт бус өвчлөл болох зүрх судасны тогтолцооны өвчин, хавдар гэсэн 2 өвчлөл 1995 оноос хойш нас баралтын зонхилох шалтгаан болж байна.

Хүснэгт 5. Нас баралт, зонхилох өвчний төрөл

Статистик үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Нас баралт	17,331	17,205	15,922	19,931	17,981
Зүрх судасны тогтолцооны өвчин	5,963	5,531	5,221	6,213	5,843
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад эмгэгээр	2,923	2,827	2,736	3,029	3,360
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	1,187	1,173	1,076	1,155	1,237
Амьсгалын тогтолцооны өвчин	752	803	594	965	891
Хавдар	4,308	4,582	4,159	4,251	4,302
Бусад	2,198	2,289	2,136	4,318	2,348

Эх сурвалж: <https://www.2.1212.mn/>

Манай улсын хүн амын нас баралтыг зонхилох шалтгаанаар авч үзвэл, 1990 онд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлж байсан бол 1992 оноос одоог хүртэл зүрх судасны тогтолцооны өвчин тэргүүлэх шалтгаан болж байна. Бүх өвчний төрөлд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их байгаа бөгөөд гэмтэл хордлого ба гадны шалтгаант бусад эмгэг болон амьсгалын тогтолцооны өвчнөөр эрэгтэйчүүдийн нас баралтын түвшин эмэгтэйчүүдийнхээс 2-4 дахин их байна. Нас баралтад нөлөөлж буй хамгийн том хүчин зүйлс нь эрүүл мэндийн асуудал болох өвчлөл 83.1% байна. Бусад осол, гэмтэл, амиа хорлолтын шалтгаанууд 16.9% эзэлж байна.

БОЛОВСРОЛ¹²²

Бичиг үсгийн мэдлэг

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр 15, түүнээс дээш насны хүн амын бичиг үсгийн мэдлэгийн түвшин 98.7 хувь байгаа нь 2010 оныхоос 0.4 пунктээр өссөний дотор эрэгтэйчүүдийнх мөн 0.4 пунктээр, эмэгтэйчүүдийнх 0.6 пунктээр нэмэгджээ.

Хүснэгт 6. Хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг (хүйсээр, хувиар)

Бичиг үсгийн мэдлэг	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бичиг үсэг мэддэг	98.3	98.2	98.3	98.7	98.7	98.9
Бичиг үсэг мэддэггүй	1.7	1.8	1.7	1.3	1.3	1.1

¹²² Жендэрийн тэгш бус байдал 2020 <https://www.ncge.gov.mn/research>

Бичиг үсэг эзэмшсэн хүн амыг хот, хөдөөгөөр харьцуулж харахад 15, түүнээс дээш насанд хотын хүн амын 99.3 хувь нь бичиг үсэг мэддэг бөгөөд хүйсээр харахад ойролцоо байна. Харин хөдөөгийн хүн амын 97.6 хувь нь бичиг үсэг мэдэж байгаа бол 2.4 хувь нь бичиг үсэг мэдэхгүй байна.

Хүснэгт 7. Хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, хот хөдөө (хүйсээр)

Байршил	Бичиг үсэг мэддэг			Бичиг үсэг мэддэггүй		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
БҮГД	98.7	98.6	98.9	1.3	1.4	1.1
Хот	99.3	99.2	99.4	0.7	0.8	0.6
Хөдөө	97.6	97.3	97.9	2.4	2.7	2.1

Хүснэгт 8. Хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг бүс аймаг, нийслэл (6 ба түүнээс дээш нас)

Аймаг, нийслэл	Бичиг үсэг мэддэг			Хүйсийн харьцаа	Бичиг үсэг мэддэггүй			Хүйсийн харьцаа
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	
БҮГД	98.2	98.0	98.3	91.6	1.8	2.0	1.7	109.7
БАРУУН БҮС	97.4	97.3	97.5	97.5	2.6	2.7	2.5	105.9
Баян-Өлгий	97.3	97.5	97.2	99.6	2.7	2.5	2.8	88.8
Говь-Алтай	97.9	97.8	98.0	92.4	2.1	2.2	2.0	105.3
Завхан	97.3	97.1	97.5	96.0	2.7	2.9	2.5	111.1
Увс	97.0	96.3	97.6	98.5	3.0	3.7	2.4	154.0
Ховд	97.6	97.8	97.4	99.2	2.4	2.2	2.6	84.0
ХАНГАЙН БҮС	97.9	97.6	98.1	93.9	2.1	2.4	1.9	116.3
Архангай	97.8	97.5	98.1	95.1	2.2	2.5	1.9	125.6
Баянхонгор	97.6	97.5	97.8	94.4	2.4	2.5	2.2	108.3
Булган	98.4	98.5	98.3	96.1	1.6	1.5	1.7	84.6
Орхон	99.0	98.8	99.2	89.6	1.0	1.2	0.8	142.1
Өвөрхангай	97.1	96.9	97.3	93.8	2.9	3.1	2.7	107.3
Хөвсгөл	97.5	97.1	97.9	95.2	2.5	2.9	2.1	130.7
ТӨВИЙН БҮС	98.2	97.9	98.5	91.8	1.8	2.1	1.5	124.8
Говьсүмбэр	98.2	97.5	98.8	88.0	1.8	2.5	1.2	190.9
Дархан-Уул	98.8	98.6	99.0	88.8	1.2	1.4	1.0	124.0
Дорноговь	97.6	97.1	98.0	90.3	2.4	2.9	2.0	135.3
Дундговь	97.6	97.2	97.9	90.4	2.4	2.8	2.1	123.1
Өмнөговь	98.7	98.5	98.8	87.8	1.3	1.5	1.2	109.1
Сэлэнгэ	98.3	97.9	98.6	94.7	1.7	2.1	1.4	136.5
Төв	97.9	97.8	98.0	97.7	2.1	2.2	2.0	109.4
ЗҮҮН БҮС	96.9	96.6	97.1	95.4	3.1	3.4	2.9	112.4
Дорнод	97.7	97.5	97.9	95.4	2.3	2.5	2.1	115.6
Сүхбаатар	96.0	95.8	96.2	97.3	4.0	4.2	3.8	108.8
Хэнтий	96.6	96.3	96.9	94.0	3.4	3.7	3.1	113.4
УЛААНБААТАР	98.7	98.7	98.8	88.5	1.3	1.3	1.2	99.3


Эх сурвалж: Жендэрийн Үндэсний хороо

6 ба түүнээс дээш насны хүн амд бичиг үсэг мэддэггүй хүний эзлэх хувь аймаг болгонд өөр байхын зэрэгцээ хүйсээр харахад Баян-Өлгий, Булган аймаг болон Улаанбаатар хотод бичиг үсэг мэддэггүй эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ их байна. Бусад аймагт бичиг үсэг мэддэггүй 100 эмэгтэйд 5-90 эрэгтэй илүү ногдож байна. Харин бичиг үсэг мэддэг хүн амын хүйсийн харьцааг харахад бүх аймагт бичиг үсэг мэддэг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээсээ их байна.

Хүн амын сургуульд хамрагдалт

Сургуульд хамрагдалтыг өмнөх тооллогуудын дүнтэй харьцуулахад тогтмол өссөөр иржээ. 2020 оны тооллогоор 6-29 насны хүн амын 72.6 хувь нь сургуульд хамрагдаж байгаа бөгөөд 2010 оны тооллогын дүнтэй харьцуулахад 14.5 пунктээр нэмэгдсэн байна. Ялангуяа 6-17 насны буюу ЕБС-ийн насны хүүхдийн 98.0 хувь нь сургуульд хамрагдаж байна. Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээр 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалтыг судлахад энэ насны хүн амын тал хүрэхгүй (47.8 хувь) хувь, 2010 оны тооллогоор 56.9 хувь нь сургуульд суралцаж байсан бол 2020 онд 72.6 хувь болж нэмэгдсээр байна.

График 6. Сургуульд хамрагдалт




Дээрх үзүүлэлтийг хүйсээр ангилахад эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтын хувь эрэгтэйчүүдийнхээс 2.2 пунктээр бага байна. Энэ нь 2010 онд 5.1 пункт байснаас харахад эрэгтэйчүүдийн сургуульд хамрагдалт сайжирч байгаа нь харагдаж байна. Эмэгтэйчүүдийн сургуульд хамрагдалтын хувь 2 тооллогын хооронд 14.4 пунктээр, эрэгтэйчүүдийнх 17.2 пунктээр өсжээ. Сургуульд хамрагдалтад гарсан томоохон өөрчлөлт бол сургуульд хамрагдагчдын хувьд хүйс болон хот, хөдөөгөөр ялгаварлахгүй бүх ангилалд нэлээд нэмэгджээ. Тухайлбал, хөдөөгийн хүн амын сургуульд хамрагдалт өмнөх тооллогоос 18.4 пунктээр, тэр дундаа эрэгтэйчүүдийнх 18.8 пункт, эмэгтэйчүүдийнх 17.8 пунктээр нэмэгдсэн явдал юм.

Боловсролын түвшин

2020 онд 10, түүнээс дээш настай нийт хүн амын 13.7 хувь нь бага, 17.1 хувь нь суурь, 29.2 хувь нь бүрэн дунд, 8.6 хувь нь техникийн болон тусгай

мэргэжлийн (техникийн 3.9 хувь, тусгай мэргэжлийн 4.7 хувь), 24.2 хувь нь дипломын болон бакалаврын дээд (дипломын 1.1 хувь, бакалаврын 23.1 хувь), 2.1 хувь нь магистр, 0.1 хувь нь докторын түвшний боловсролтой байна.


График 7. Хүн амын боловсролын түвшин



Эх сурвалж: Боловсролын салбарын статистикийн мэдээлэл 2021-2022 он

Хүн амын боловсролын түвшинг байршлаар үзвэл мөн л суурь, бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын эзлэх хувь давамгайлж байна. Тооллогын дүнгээс харахад дээд боловсролтой хүн амын хувийн жин хотод хөдөөгөөс 2.5 дахин өндөр, харин бага боловсролтой хүн амын хувийн жин хөдөөд, хотоос 2.1 дахин, суурь боловсролтой хүн амынх 2.6 дахин илүү байна. Үүнээс үзэхэд хөдөөд бага болон суурь боловсролтой хүн амын хувийн жин хотоос нэлээд илүү, харин бүрэн дунд болон дээд боловсролтой хүн амын хувийн жин эсрэгээр хотод нэлээд илүүг харуулж байна.

График 8. Хүн амын боловсролын түвшин хот, хөдөө



Эх сурвалж: Боловсрол бичиг үсгийн мэдлэг тайлан 2021 он


2010 оны тооллогын дүнгээр бүрэн дунд боловсролтой хотын хүн амын хувийн жин хөдөөгөөс 18.0 пунктээр илүү байсан бол 2020 онд 9.4 пункт болж зөрүү багассан байна. Мөн 2010 оны тооллогоор хотын дээд боловсролтой хүн амын хувийн жин хөдөөгөөс 16.4 пунктээр илүү байсан бол 2020 онд зөрүү 20.1 пункт болж нэмэгдсэн байна.

ГЭМТ ХЭРЭГ

Бүртгэгдсэн гэмт хэрэг

Гэмт хэрэг, зөрчлийн бүртгэлийн мэдээллийг ЦЕГ-аас хөтөлж, гаргадаг. 2023 оны бүтэн жилийн байдлаар нийт 35574 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 24134 хүн холбогдож, 19113 нь эрэгтэй байна.

График 9. Гэмт хэрэг үйлдээсэд (сүүлийн 5 жил)



Эрэгтэйчүүд гэмт хэрэгт холбогдсон байдлыг сүүлийн 5 жилээр авч үзвэл 2019 оноос хойш 28,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн аймгуудаар харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 9. Гэмт хэрэг үйлдээсэд, аймгуудаар (сүүлийн 5 жил)


№	Аймаг, нийслэл	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Баян-Өлгий	259	334	175	237	337
2	Говь-Алтай	146	142	193	199	225
3	Завхан	182	207	308	305	242
4	Увс	237	169	190	254	267
5	Ховд	369	373	322	336	408
6	Архангай	339	334	331	420	342
7	Баянхонгор	398	363	346	347	268
8	Булган	279	231	310	291	265
9	Орхон	424	334	351	469	541
10	Өвөрхангай	391	304	371	475	363
11	Хөвсгөл	411	432	611	693	453

12	Говьсүмбэр	89	112	91	103	103
13	Дархан-Уул	509	406	342	436	587
14	Дорноговь	328	227	315	414	384
15	Дундговь	119	137	212	178	174
16	Өмнөговь	334	333	281	322	376
17	Сэлэнгэ	487	373	440	437	540
18	Төв	499	614	464	510	463
19	Дорнод	375	380	437	447	389
20	Сүхбаатар	328	311	222	368	298
21	Хэнтий	576	415	430	513	459
22	Нийслэл	7739	7224	8408	11437	11623
23	Бусад	5	5	1	4	6
	Нийт	14823	13760	15151	19195	19113

Шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэрэг

Монгол Улсын нийт шүүхээр 2023 оны бүтэн жилийн байдлаар нийт 14192 хүн ял шийтгүүлснээс 1702 эмэгтэй, 12490 нь эрэгтэй байна. Ял шийтгүүлсэн эрэгтэйчүүдийг сүүлийн 5 жилээр авч үзвэл 2019 оноос хойш 11568-аас 12490 болж 8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

График 10. Ял шийтгүүлэгсэд (сүүлийн 5 жил)



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН


Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

Хөдөлмөр эрхлэлтийн түвшинг “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”¹²³-ын дагуу тооцож байна. 2023 оны IV улирлын байдлаар Монгол Улсын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.4 хувь байна. Хүйсээр ялгаж харвал, эрэгтэйчүүд 63.2 хувь, эмэгтэйчүүд 48.6 хувь байна. Сүүлийн 5 жилээр харьцуулж үзвэл хөдөлмөр эрхлэлтийн түвшин төдийлөн ялгаатай биш 1.3 хувийн үзүүлэлтээр буурсан үзүүлэлттэй байна.

¹²³https://tuv.nso.mn/uploads/users/87/files/1_%20%D0%90%D1%80%D0%B3%D0%B0%D1%87%D0%BB%D0%B0%D0%BB_%D1%85%D3%A9%D0%B4%D3%A9%D0%BB%D0%BC%D3%A9%D1%80.pdf

Үүнд:

График 11. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (сүүлийн 5 жил)




Албан бус хөдөлмөр эрхлэлт

Албан бус хөдөлмөр эрхлэгч гэж албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчид дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

1. Тухайн хугацаанд хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, орлогын албан татвар, өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч;
2. Албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч;
3. Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч;
4. Хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүд орно.

Хамгийн сүүлийн байдлаар 2022 оны бүтэн жилийн байдлаар албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо 500,304 хүрсэн бөгөөд 292,360 нь эрэгтэй байна. Эрэгтэйчүүдийн албан бус хөдөлмөр эрхлэлтийг сүүлийн 5 жилээр харьцуулж үзвэл, 2019 оны бүтэн жилд 270,817 байсан бол 2022 онд 7.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

График 12. Албан бус хөдөлмөр эрхлэлт, ХАА-н салбар орсон байдлаар, (сүүлийн 5 жил)



Дээрх үзүүлэлт, дүн нь албан бус хөдөлмөр эрхлэлтэд ХАА-н салбар орсон дүн бөгөөд ХАА-н салбарын дүн хасаж тооцвол, 2022 онд нийт 215,378 хүн албан бус хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд үүнээс 128,199 нь эрэгтэйчүүд байна.

График 13. Албан бус хөдөлмөр эрхлэлт, ХАА-н салбарыг хассан байдлаар (сүүлийн 5 жил)




Ажилгүйдлийн түвшин

Ажилгүйдлийн түвшин нь ажиллах хүчний хэдэн хувийг ажилгүйчүүд эзэлж байгааг харуулдаг бөгөөд 2023 оны IV улирлын байдлаар Монгол Улсын ажилгүйдлийн түвшин 3.9 хувь байна. Хүйсээр ялгаж харвал, эрэгтэйчүүд 4.7 хувь, эмэгтэйчүүд 3 хувь байна. Сүүлийн 5 жилээр харьцуулж үзвэл ажилгүйдлийн түвшин 2019 оны IV улирлын байдлаас 2.1 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Үүнд:


График 14. Ажилгүйдлийн түвшин (сүүлийн 5 жил)



ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭЦЭГ

“Өрх толгойлсон эх,эцэг (хүн)” гэж нөхөр, эхнэрийн аль нэг нь нас барсан, эсвэл сураггүй алга болсон нь шүүхээр тогтоогдсон, гэрлэлтээ цуцлуулсан, эцэг, эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан бол тухайн шийдвэр хүчин төгөлдөр байх хугацаанд, гэрлэж байгаагүй боловч төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэдтэй ганц бие эх /эцэг/-ийг ойлгоно. Хамгийн сүүлийн байдлаар 2022 оны бүтэн жилийн байдлаар улсын хэмжээнд 15089 өрх толгойлсон эцэг байна. Сүүлийн 5 жилээр харьцуулж үзвэл, 2019 оны бүтэн жилд 17628 байсан бол 2022 онд 12.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

График 15. Өрх толгойлсон эцэг (сүүлийн 5 жил)



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, ЖҮХ, UNFPA, ММСГ, 2021
- Төрийн албаны зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан
- Улс төрийн хүрээн дэх жендэрийн тэгш байдал, МУ-ын ХЭҮК, КОЙКА, UNDP, УБ
- Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, Швейцарын хөгжлийн агентлаг, IRIM судалгааны хүрээлэн, УБ, 2015 он
- “Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны талаарх олон нийтийн төсөөлөл” судалгааны тайлан, SPDR1, KOICA, UNDP, GENDER EQUALITY, 2022
- Хүний эрх, жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээнд зориулсан гарын авлага, УИХТГ, 2023 он
- Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 01 дүгээр дүгнэлт
- Монгол Улсын эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлс <https://www.ncge.gov.mn/research/>
- Жендэрийн тэгш бус байдал 2020 <https://www.ncge.gov.mn/research>
- 1212 <https://www2.1212.mn/tables.aspx>
- Жендэрийн Үндэсний хороо <https://www.ncge.gov.mn/research>
- Боловсролын бичиг үсгийн мэдлэг тайлан 2021 он <https://cdn.greensoft.mn/uploads/users/2649/files/PDF%20files/CBR-MN-compressed.pdf>
- Боловсролын салбарын статистикийн мэдээлэл 2021-2022 он <https://cdn.greensoft.mn/>



**ТӨРИЙН АЛБА БОЛОН ПАРЛАМЕНТЫН АЖЛЫН АЛБАНЫ
МЭРГЭШСЭН АХМАД АЖИЛТНУУДЫН ТАЛААРХ ХҮНИЙ НӨӨЦИЙН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА БА
МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ**

(Төлөвлөгөөт судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Д.Аюуш, Б.Батцэцэг,
Д.Жигваагүнсэл, Р.Оргилмаа,
Б.Ууганжаргал, Б.Мөнгөнсувд*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ОНОЛ, АРГА ЗҮЙ

ХОЁР. ОЛОН УЛСЫН ЖИШИГ, ЗӨВЛӨМЖ

ГУРАВ. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

- ЯПОН УЛС
- ӨМНӨД СОЛОНГОС УЛС (БНСУ)
- ЭСТОНИ УЛС
- ФИНЛАНД УЛС
- АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний 3.1.4-т “Төрийн байгууллага болон бусад салбарт олон жил хүчин зүтгэсэн ахмад үеийнхний туршлагаас суралцах, санал, зөвлөгөөг сонсох, төлөөллийн оролцоог хангах” гэж, 5.1.2-т “Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэл бүхий нотолгоонд суурилсан судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангаж дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний хүрээлэн байгуулах асуудлыг шийдвэрлэх” гэж заасан.

Мөн Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний 3.3.2-т “Тамгын газрын ахмад үеийнхний туршлагаас суралцах, санал, зөвлөгөөг сонсох, шаардлагатай тохиолдолд гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоо бүрдүүлэх” гэж заасан.

Дээрх стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх болон Монгол Улсын Их Хурлын багц хуулийн төслүүдийг боловсруулж, хэлэлцүүлэх үйл явцад судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд “Төрийн алба болон парламентын ажлын албаны мэргэшсэн ахмад ажилтнуудын талаарх хүний нөөцийн бодлого, зохицуулалт: олон улсын туршлага ба Монгол Улсын нөхцөл байдал” сэдэвт төлөвлөгөөт судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгааны зорилго

Төрийн алба болон парламентын ажлын албанд олон жил ажилласан, тодорхой чиглэлээр мэргэшсэн ахмад ажилтнуудыг ажилд татан оролцуулах хүний нөөцийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн онол арга зүй, олон улсын жишиг, сайн туршлага, бусад улсын эрх зүйн зохицуулалтыг судлахын зэрэгцээ Монгол Улсын нөхцөл байдлыг тодруулан гаргах.

Судалгааны хамрах хүрээ

- Хөдөлмөрийн зах зээл дэх ажиллах хүчний бодлогын хүрээн дэх насжилтад суурилсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих онол, арга зүйн үндэслэл, олон улсын жишиг;
- Парламент болон төрийн байгууллагад олон жил ажилласан ахмад туршлагатай ажилтнуудыг татан ажиллуулах хүний нөөцийн бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, олон улсын жишиг ба зохицуулалтын зөвлөмж;

- Гадаадын зарим орны парламент болон төрийн байгууллагад олон жил ажилласан ахмад туршлагатай ажилтнуудыг татан ажиллуулах бодлого, эрх зүйн орчин ба практик туршлага;
- Монгол Улсын төрийн алба болон УИХ-ын Тамгын газарт олон жил ажилласан, мэргэшсэн туршлагатай ахмад ажилтнуудыг татан ажиллуулах хүний нөөцийн хэрэгцээ шаардлага, эрх зүйн орчин ба өнөөгийн байдал.

Судалгааны бүтэц

Судалгаа нь хураангуй болон үндсэн хэсэгтэй. Судалгааны үндсэн хэсэг нь гурван бүлэгтэй:

- *Нэгдүгээр бүлэгт*, насжилтад суурилсан хүний нөөцийн бодлого, менежмент: онол, арга зүйн үндэслэл, олон улсын чиг хандлага;
- *Хоёрдугаар бүлэгт*, Төрийн алба болон парламентын ажлын албанд мэргэшсэн ахмад ажилтнуудыг ажиллуулах хүний нөөцийн бодлого, хөтөлбөр: олон улсын жишиг, зөвлөмж, эрх зүйн зохицуулалтын суурь зарчмууд;
- *Гуравдугаар бүлэгт*, Гадаадын зарим орны төрийн алба болон парламентын ажлын албанд мэргэшсэн ахмад ажилтнуудыг ажиллуулах талаар баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр: эрх зүйн зохицуулалт ба практик туршлага;
- *Дөрөвдүгээр бүлэгт*, Монгол Улсын төрийн алба болон парламентын ажлын албанд мэргэшсэн ахмад ажилтнуудыг ажиллуулах хүний нөөцийн бодлого, эрх зүйн орчин ба өнөөгийн нөхцөл байдал.

Түлхүүр үг: *Тэтгэврийн нас*

Key words: Retirement ages



СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Онол, арга зүйн хувьд:

Толь бичигт өндөр настан гэдэг ахмад настны тодорхой нэг бүлэг буюу 80-аас дээш насныхныг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуульд “өндөр насны тэтгэвэр” (3.1.1 дэх заалт) гэж тэтгэврийн насанд гарах эрх бүхий “бүх хүн”-ийг хамааруулах боловч хуулийн зүйл заалтын хэрэглээг харвал ажил мэргэжлийн онцлог (5.1.7 дахь заалт)-оос хамаарч доод тал нь 35 наснаас тэтгэвэрт гарах эрх үүсэх боломжтой байхаар байна.

Монгол Улсын Засгийн газраас 2013 онд “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” тогтоол¹²⁴ баталсны дагуу Геронтологийн үндэсний төв хүн ам зүй, нийгмийн эрүүл мэндийн, эдийн засагчид г.м. мэргэжилтнүүд хамтран настан эмэгтэй 55-84, эрэгтэй 60-84 гэж ерөнхий ангиллын дотор хөгшрөх нас (эмэгтэй 45-54, эрэгтэй 50-59), хижээл (эмэгтэй 55-64, эрэгтэй 60-64), ахимаг (эмэгтэй, эрэгтэй 65-74), ахмад нас (эмэгтэй, эрэгтэй 75-84), өтөл нас (85-аас дээш) гэсэн ангиллыг санал болгожээ.

Зарчмын хувьд улс орны бодлого, хөгжлийн түвшин, хүн амын дундаж наслалтаас хамаарч ахмадууд 1) хугацаа заахгүйгээр үргэлжлүүлэн ажиллах, 2) насны дээд хязгаарыг нэмэх, 3) насны хязгаарыг бууруулж, багасгах, 4) хатуу шугам тогтоож өөрчлөхгүйгээр мөрдөх гэсэн хэлбэрүүд байх боломжтой байна.

Олон улсын зөвлөмжийн хувьд:

Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлттэй холбоотойгоор НҮБ болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-аас гаргасан зөвлөмж, гарын авлага, баримт бичгүүд гарсан байдаг байна.

Олон Улсын Ахмад настны эрхийн тухай конвенц (UNCROP) нь НҮБ-аас баталсан хүний эрхийн дараагийн томоохон гэрээ билээ. Уг гэрээ нь Ахмад настнуудын хүний эрхийн хуваагдмал бүтцийг засахыг эрэлхийлдэг ба ахмад настнуудын анхаарал татсан чухал хүний эрхийг баталгаажуулахад чиглэдэг. Олон Улсын ахмад настнуудын гэрээний гол зүйл нь хүн амын хөгшрөлтийн улмаас дэлхий даяар өсөн нэмэгдэж буй хүн ам зүйн 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Харин ОУХБ-ын Удирдах зөвлөлөөс найман Конвенцыг “суурь конвенц” хэмээн тогтоосон ба эдгээр нь хөдөлмөр эрхлэхтэй холбоотой үндсэн зарчмуудыг багтаасан. Үүнд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, албадан

¹²⁴ “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр. МУЗГ-ын тогтоол. №416. УБ., 2013.12.14.

хөдөлмөрийн бүх хэлбэрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, хөдөлмөр эрхлэлт дэх бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг зогсоох тухай конвенцууд болно.

Судалгаанд авагдсан орнуудын туршлагыг тоймлон авч үзвэл:

Япон

Япон Улс 2024 оны байдлаар 122.7 сая хүн амтай бөгөөд сүүлийн 10 жилд хүн амын тоо нь ойролцоогоор 3 саяар буурсан үзүүлэлттэй байна. Хүн амын төрөлт буурч, хөгшрөлт хурдацтай явагдаж байгаа нь тус улсын хөдөлмөрийн насны хүн амын тоог бууруулж дотоодын нийт бүтээгдэхүүн буурахад ихээхэн нөлөөлж байна. Тиймээс тэтгэвэрт гарах насыг уртасгах, ахмад ажилчдын тоог нэмэгдүүлэх тал дээр ихээхэн анхаарч 2020 онд төрийн албан хаагчийн хууль болон орон нутгийн төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, хөгшрөлт хурдацтай явагдаж, ажиллах хүчний хомстолд орж байгаатай холбоотойгоор төрийн албаны тэтгэврийн насыг 60 байсныг 61 болгон нэмэгдүүлж өөрчилсөн. Цаашдаа 2031 он гэхэд 65 нас хүргэхийн тулд хоёр жил тутамд нэг жилээр нэмэгдүүлнэ. Тус хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тэтгэврийн насыг 61 болгосон хэдий ч төрийн албаны удирдах албан тушаалтныг 60 наснаас нь албан журмын тэтгэврийг тогтоох тогтолцоо үйлчилдэг. Энэ нь дараагийн залуу үеийн зэрэг дэв, ажлын байрны шат ахих боломжийг бүрдүүлэх зорилготой байна.

Япон Улсын Засгийн газраас албан журмаар тэтгэвэр тогтоолгосон ахмад настны цаашдын хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг дэмжихийг “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-ийн хүрээнд зохицуулж байна. Тус хуульд зааснаар засгийн газар, орон нутгийн засаг захиргаа болон хувийн хэвшлийн байгууллагууд нягт уялдаатай хамтран ажиллаж, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлж, хэрэгжилтэд засгийн газар хяналт тавин ажиллана. Албан журмаар тэтгэвэрт гарсан ахмад ажилтныг болон бусад өндөр насны тэтгэвэр авдаг иргэдийг түр зуурын болон хөнгөн ажлын байраар хангах боломжийг бүрдүүлэх зорилгоор Ахмад настны хөдөлмөрийг дэмжих хүний нөөцийн төв болон холбоодыг томилж, төрөөс бүх талын тусламж дэмжлэг үзүүлэн ажилладаг байна.

Өмнөд Солонгос

Өмнөд Солонгос Улс нь хурдацтай хөгширч буй улсуудын нэг болж байна. Энэ үзүүлэлтээрээ ЭЗХАХБ-ын гишүүн орнуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй нь байна. Тус улсын хувьд цалинг боловсролын түвшин, ажилласан жилээр нь тодорхойлдог. Энэ нь бодлогын хүчтэй хариу арга

хэмжээ байхгүй тохиолдолд эдийн засгийн өсөлтийг бууруулж, тэгш бус байдлыг нэмэгдүүлж, сайн сайхан байдлыг сулруулж, эдийн засгийн тогтвортой байдал болон нийгмийн халамж сорилттой тулгарч байна. Өмнөд Солонгос Улсын ахмад настнуудын ажлын байр бий болгох бодлого нь зөвхөн өндөр настай, бага орлоготой ахмад настанд төдийгүй өндөр бүтээмжтэй, тэтгэвэрт гарах бэлтгэлгүй залуу ахмадуудад мөн чиглэгдэж байна. Тус улс нь төрөлт буурсантай холбоотойгоор бусад улсуудын адилаар тэтгэвэрт гаргах насыг 2016 оноос хойш үе шаттайгаар нэмэгдүүлсэн байна.

Өмнөд Солонгос Улс нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтэд зориулсан тусдаа хуультай орон бөгөөд, үүнийг “Ахмад настны хөдөлмөр эрхлэхэд насаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-аар 2013 оноос зохицуулж байсан бол энэхүү хуулийг 2023 оны 10 дугаар сарын 31-нд “Ахмад настны ажлын байр, нийгмийн үйл ажиллагааг дэмжих хууль” болгон өөрчлөн баталсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан байна.

Мөн дээрх хуульд зааснаар Өмнөд Солонгос Улс “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн цогц төлөвлөгөө”-г засгийн газрын холбогдох яам батлахаар тусгасан бөгөөд анх 2013 онд баталж байжээ. Одоогийн цогц төлөвлөгөө нь 2023-2027 оны хооронд хэрэгжихээр байна.

Тус төлөвлөгөө нь ахмад настны ажлын байрыг 2027 он гэхэд нийт ахмад настны 10 хувьд хүргэх, хөдөлмөр эрхлэлтэд эмзэг бүлгийн бага орлоготой ахмад настнуудыг түлхүү хамруулах, нийгмийн эмзэг бүлгийнхэнд нийгмийн үйлчилгээ үзүүлэх, ажлын байраар хангах зорилтыг дэвшүүлсэн байна. Энэхүү хоёр зорилтыг хэрэгжүүлэх 4 нарийвчилсан төлөвлөгөөг баталсан.

Мөн “**Өмнөд Солонгосын ахмад ажилтны хөгжлийн институт**” гэсэн байгууллага Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яаманд харьяалагдаж, ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн үйл ажиллагаанд оролцох үүрэг бүхий төрийн өмчит компани хэлбэрээр ажилладаг байна.

Эстони

Эстони Улс нь сүүлийн жилүүдэд дундаж наслалт харьцангуй өссөн хэдий ч 65-аас дээш насны ахмадуудын эрүүл, чанартай наслалт хангалтгүй байна гэж үздэг байна. Тус улсад 2021 оноос тэтгэврийн зарим шинэчлэлийг хийж эхэлснээр ахмад настнуудын ажил хөдөлмөр эрхлэх урам зоригийг дээшлүүлэх, тэгш боломж, таатай нөхцөл бүрджээ.

Эстони Улсын хувьд ахмад настнуудад зориулсан тусгай хууль байдаггүй бөгөөд Үндсэн хууль болон бусад хүний эрхийн, нийгмийн хамгааллын хуулиудаараа зохицуулсан байдаг байна. Харин Эстони Улсын Засгийн газраас 2013 оноос эхлэн “Ахмад настнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх анхны цогц төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна. Энэ төлөвлөгөө нь Засгийн газрын 2016-2023 онд хэрэгжүүлсэн Нийгмийн халамжийн хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд одоо 2023-2030 он хүртэлх төлөвлөгөө хэрэгжиж байна. Тус төлөвлөгөөнд ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, сайн дурын ажилд дэмжлэг үзүүлэх бодлого, ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх бодлого, ахмад настны мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа, төрийн болон олон нийтийн байгууллагын оролцоо зэрэг асуудлуудыг авч үзсэн байна.

Финланд

Финланд Улсад ахмад, өндөр настай иргэдийн ялгамжтай байдлыг ойлгох, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, тэдний гаргасан шийдвэрийг хүндлэх гэх мэт ахмад болон өндөр настай иргэдэд хандах хандлага, тэдэнд ээлтэй орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа эрчимтэй нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд тус улс нь насжилтын үзүүлэлтээр дэлхийд тэргүүлж байна.

Тус улс хөдөлмөрийн харилцааг хэд хэдэн хууль (Хөдөлмөрийн гэрээний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, Сургалтын чөлөөний тухай хууль, Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлын тухай хууль)-уудаар зохицуулдаг.

Ахмад настнуудад ээлтэй орчинг бүрдүүлэх, тэдэнд зориулсан ажлын байр төлөвлөх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хангахаар ажилладаг. Засгийн газраас ахмад иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангахаар тодорхой бодлогоор дэмжин ажиллаж байсан түүхтэй. Харин сүүлийн жилүүдэд ахмад настнуудад зориулсан төрийн үйлчилгээ, нийгмийн халамжийг илүү сайжруулах зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

АНУ

АНУ-д тэтгэврийн дундаж нас эрэгтэй 65, эмэгтэй 62 байна. 2023 оны байдлаар 65-аас дээш насны 58 сая иргэн байгаагаас 11 сая нь хөдөлмөр эрхэлж байна. Дундаж наслалт нэмэгдэж байгаа, иргэд тэтгэврийн хуримтлал үүсгээгүй, иргэдийн хувийн хуримтлал багассан, нийгмийн даатгалаас бүтэн тэтгэвэр авах нас нь болоогүй болон тус тэтгэвэр нь амьжиргааны зардалд хүрэлцээгүй зэрэг олон шалтгааны улмаас ахмад настнууд тэтгэврийн насанд хүрсэн хэдий ч цааш үргэлжлүүлэн ажиллах шаардлага үүсдэг байна.

АНУ-д ахмад, тэтгэврийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах төрийн бодлогуудыг хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд “Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль” (The Age Discrimination in Employment Act 1967)¹²⁵, Нийгмийн хамгааллын тухай хууль (The Social Security Act) болон холбогдох бусад хууль тогтоомжоор ахмад настнуудын хөдөлмөр эрхлэх эрхийг хамгаалж байна.

Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс албадан тэтгэвэрт гаргах байдлыг халж, “Ахмад настнуудын олон нийтэд тустай ажил, үйлчилгээ эрхлэхийг дэмжих хөтөлбөр” (The Senior Community Service Employment Program)¹²⁶ зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Төрийн албаны ахмад ажилтнуудын хувьд “Үе шаттайгаар тэтгэвэрт гарах хөтөлбөр” (The Phased Federal Retirement Program)-т хамрагдах боломжтой бөгөөд ингэснээр ахмад ажилтнууд хагас цагаар ажиллан, шинэ залуу ажилтнуудыг дагалдуулан ажиллаж, өөрийн мэдлэг чадвар, туршлагаасаа зааж, сургах боломжийг олгосон байна.

Судалгааны дэлгэрэнгүйг судалгааны хэсгээс үзнэ үү.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

¹²⁵ <https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2011-title29/html/USCODE-2011-title29-chap14.htm>

¹²⁶ <https://www.dol.gov/agencies/eta/seniors>

Хүснэгт 1. Судалгаанд авагдсан орнуудын харьцуулсан товч мэдээлэл

Улс	Тусдаа хуульгай эсэх	Хууль, эрх зүйн орчин	Хөтөлбөр, төлөвлөгөө
Япон	Тийм	<ul style="list-style-type: none"> - Япон улсын ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль - Ахмад настныг хөдөлмөр эрхлэхэд насаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 	<p>Засгийн газрын “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах арга хэмжээний үндсэн бодлого”</p> <p>Засгийн газрын “Ахмад настны ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 3 дахь цогц төлөвлөгөө (2023-2027)”</p>
Солонгос	Тийм	<ul style="list-style-type: none"> - Улсын тэтгэврийн даатгалын тухай хууль - Нийгмийн хамгааллын тухай хууль - Тэгш байдлын тухай хууль - Хөдөлмөрийн эрхлэлтийн үйлчилгээ, тэтгэмжийн тухай хууль - Хөдөлмөрийн гэрээний тухай хууль - Эрүүл мэндийн даатгалын тухай хууль - Төрийн албаны тухай хууль - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг. 	<p>“Ахмад настуудын идэвхтэй амьдралын хөгжлийн төлөвлөгөө” 2013-2020 онд хэрэгжүүлсэн. Одоогоор Нийгмийн асуудал эрхэлсэн яамнаас 2023-2030 он хүртэлх нийгмийн халамжийн хөгжлийн шинэ төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд үүнд ахмад настуудын сайн сайхан амьдралын нөхцөл, тэгш боломжийн асуудлыг анх удаа тусдаа дэд зорилтын хүрээнд авч үзэж байна.</p>
Эстони	Үгүй		
Финланд	Үгүй	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөрийн гэрээний тухай хууль - Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль - Ээлжийн амралтын тухай хууль - Ажлын цагийн тухай хууль - Сургалтын чөлөөний тухай хууль - Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлын тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулдаг. 	<p>“Ахмад насны хөдөлмөр эрхлэгчдийн Финландын үндэсний хөтөлбөр” нь үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр Засгийн газраас танилцуулсан.</p>
Америк	Тийм	<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль 	<p>“Ахмад настуудын олон нийтэд үйлчилгээ үзүүлэх ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь ахмад настуудад зориулсан олон нийтэд туслах ажлын байран дээр дадлагажуулах хөтөлбөр юм.</p>

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГ. ОНОЛ, АРГА ЗҮЙ

Толь бичигт “өндөр настан” гэдэг ахмад настны тодорхой нэг бүлэг буюу 80-аас дээш насныхныг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай” хуульд “өндөр насны тэтгэвэр” (3.1.1 дэх заалт) гэж тэтгэврийн насанд гарах эрх бүхий “бүх хүн”-ийг хамааруулах боловч хуулийн зүйл заалтын хэрэглээг харвал ажил мэргэжлийн онцлог (5.1.7 дахь заалт)-оос хамаарч доод тал нь 35 наснаас тэтгэвэрт гарах эрх үүсэх боломжтой байхаар байна.

Насжилт, түүнтэй холбоотой нийгмийн асуудлуудыг судлах явцад албан болон албан бус хэрэглээн дэх ойлголтын хүрээ, агуулга, хуулийн зүйл заалт, тэдгээрийн хэрэглээ зохицуулалттай холбоотой зөрчил төөрөгдөл, хэрэглээний замбараагүй байдал үүсэж буй тул ойлголт, томъёоллоос эхлээд засварлаж, өөрчлөх шаардлагатай зүйлс цөөнгүй илэрч байна. Шинжлэх ухааны талаас насжилтыг хронологийн (хуанлийн), үүргийн (functional), сэтгэл зүйн (psychology), зохион байгуулалт (organizational age)-ын амьдралын мөчлөг (life span)-өөр тодорхойлдог.¹²⁷ Отто вон Бисмарк 1989 онд тэтгэврийн насны доод хязгаарыг 65 нас гэж тогтоосон нь урт удаан хугацаанд жишиг байдлаар ашиглагдаж байна.¹²⁸

Монгол Улсын Засгийн газраас 2013 онд “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” тогтоол¹²⁹ баталсны дагуу Геронтологийн үндэсний төв хүн ам зүй, нийгмийн эрүүл мэндийн, эдийн засагчид г.м. мэргэжилтнүүд хамтран настан эмэгтэй 55-84, эрэгтэй 60-84 гэж ерөнхий ангиллын дотор хөгшрөх нас (эмэгтэй 45-54, эрэгтэй 50-59), хижээл (эмэгтэй 55-64, эрэгтэй 60-64), ахимаг (эмэгтэй, эрэгтэй 65-74), ахмад нас (эмэгтэй, эрэгтэй 75-84), өтөл нас (85-аас дээш) гэсэн ангиллыг санал болгожээ.¹³⁰

Зарчмын хувьд улс орны бодлого, хөгжлийн түвшин, хүн амын дундаж наслалтаас хамаарч ахмадууд 1) хугацаа заахгүйгээр үргэлжлүүлэн ажиллах, 2) насны дээд хязгаарыг нэмэх, 3) насны хязгаарыг бууруулж, багасгах, 4) хатуу хязгаар тогтоож өөрчлөхгүйгээр мөрдөх гэсэн хэлбэрүүд байх боломжтой.¹³¹

Аливаа байгууллагын хувьд удирдлагын тогтолцоо нь санхүүгийн, хүний нөөцийн, үйлдвэрлэлийн, маркетингийн гэх мэт тодорхой чиглэлүүдтэй байдаг.

¹²⁷ Dorien Kooij, Annet de Lange, Paul Jansen, Josje Dijkers. Older worker's motivation to continue to work: five meanings of age: A conceptual review // Journal of Managerial Psychology. Vol23.2007. p365-366.

¹²⁸ Jo Thijssen, Tonette Rocco. Development of older workers: revisiting policies // “Working and ageing” survey report. Printed in the European Union. Luxembourg. 2010. p14.

¹²⁹ “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр. МУЗГ-ын тогтоол. №416. УБ., 2013.12.14.

¹³⁰ <https://gerontology.mohs.gov.mn/?p=2798> Насны ангилал. Геронтологийн үндэсний төв.

¹³¹ А.Гидденс. Социологи. Адмон принт ХХК. УБ., 2006. 204 дэх тал.

Өндөр үр бүтээлтэй ажиллахын тулд аливаа байгууллага хүний нөөцийн оновчтой уян хатан бодлого явуулах нь чухал. Өөрөөр хэлбэл, хүний нөөцийг удирдах хэлтэс хэдий чинээ сайн ажиллана байгууллагын амжилт түүнээс шууд шалтгаалдаг. Тийм учраас аливаа байгууллагын хамгийн чухал нөөц бол хүн гэдэг нь зайлшгүй юм. Иймд байгууллагын ажилчдын мэдлэг чадвар, хөгжил болон тогтвор суурьшил зэрэг нь тухайн байгууллагын амжилтын үндэс болдог. Үүний тулд хүмүүсийг зөв удирдан хөгжүүлж чадвал тэд үр ашигтай ажиллаж, түүнийхээ хэрээр хөгжиж, сэтгэж, бүтээлч сэтгэлгээтэй болдог байна.

Хүний нөөцийн удирдлагын хөгжлийн үндэс нь Их Британиас үүсэлтэй гэж үздэг бөгөөд боловсон хүчний менежменттэй салшгүй холбоотой. Хүмүүс анх хамтран хөдөлмөрлөж эхэлсэн үеэс боловсон хүчний менежмент албан бусаар үүссэн. Англи хэлээр “Human resource” орос хэлээр “Человеческие ресурсы” гэдэг үгийн монгол утга нь “Хүний нөөц” гэж орчуулагддаг.

Хүний нөөцийн тухай олон тодорхойлолт, ухагдахуунууд байдаг. Гэвч эдгээрийг Монгол хэл дээрх хүний нөөцийн менежментийн чиглэлийн сурах бичгүүдэд хомсхон тайлбарласан байдаг. Өөрөөр хэлбэл, хүний нөөцийн талаар нарийн тайлбарлаж бичсэн зүйлс манай оронд хэвлэгдсэн нийт сурах бичгүүдэд ховорхон бөгөөд, их алсуур байдалтай тойм төдий бичсэн байна. Хүний нөөц гэдэг ойлголтыг хэрхэн тодорхойлж тайлбарласныг дурдвал:

“Хүний нөөц бол бусад нөөцүүдтэй харьцуулахад хамгийн шавхагдашгүй, арвин баялаг юм. Учир нь хэрвээ хүмүүсийг зөв удирдаж, хүмүүжүүлж чадвал тэд үр ашигтай хөдөлмөрлөхийн зэрэгцээ хөгжихийн хэрээр сэтгэж, шинийг эрэлхийлэх бүтээлч сэтгэлгээтэй болдог.

ХОЁР. ОЛОН УЛСЫН ЖИШИГ, ЗӨВЛӨМЖ

Олон Улсын Ахмад настны эрхийн тухай конвенц (UNCROP) нь НҮБ-аас баталсан хүний эрхийн дараагийн томоохон гэрээ билээ. Уг гэрээ нь Ахмад настнуудын хүний эрхийн хуваагдмал бүтцийг засахыг эрэлхийлдэг ба ахмад настнуудын анхаарал татсан чухал хүний эрхийг баталгаажуулахад чиглэдэг. Энэхүү гэрээг 1989 оноос хойш дэлхий даяар бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн бөгөөд НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц амжилттай хэрэгжсэний үр дүнд үндэслэн гарсан.

НҮБ-ын тайланд дурдсанаар, ахмад настнуудын эрхийн асуудал, нийгмийн халамжийн асуудал улам эмзэг болж, ихэнх улс орны хүний эрхийн хуулиуд тусгагдсан хэдий ч хууль нь хэрэгжихгүй байгаа тал дээр зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна.

Хүн амын хөгшрөлтийн хэрээр ахмад настнуудын хүний эрхийн асуудал улам бүр чухал асуудал болж байгаатай холбогдуулан дэлхий даяар өндөр настнуудын эрхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагаас үүдэн байгуулагдсан Ахмад настны эрхийн холбоо (GAROP) дахь конвенцыг сурталчлан таниулах, бусад улс орнуудыг уриалан дуудах ажилд дэлхийн өнцөг булан бүрээс сайн дурын мэргэшсэн зөвлөхүүд болон Төрийн бус байгууллага (ТББ) манлайлан оролцож байна.¹³²

Дэлхийн хүн амын хөгшрөлт өндөр байгаатай холбоотойгоор ахмад настны хөдөлмөр эрхлэлт нь улс орны эдийн засгийн нэг хөдөлгүүр тул улс орнууд хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид бага зэрэг өөрчлөлт оруулахыг уриалж байна. Жишээ нь: тэтгэврийн насны дээд хязгаар дэлхийн ихэнх улс орнуудад адил байх бөгөөд үүнтэй холбоотойгоор гарц гаргалгаа эрэн хайж байна.

Версалийн гэрээнд гарын үсэг зурсан улс орнуудын хөдөлмөрийн нөхцөл нь шударга бус, хүндрэл бэрхшээлтэй байгаа зэрэг асуудлыг шийдвэрлэхийн тулд ОУХБ нь гишүүн орнуудын Засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийн оролцоотойгоор хөдөлмөрийн хэм хэмжээг тодорхойлсон конвенц, зөвлөмж боловсруулах шаардлагатай болсон.

ОУХБ-ын Удирдах зөвлөлөөс найман конвенцыг “суурь конвенц” хэмээн тогтоосон ба эдгээр нь хөдөлмөр эрхлэхтэй холбоотой үндсэн зарчмуудыг багтаасан. Үүнд, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, албадан хөдөлмөрийн бүх хэлбэрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах, хөдөлмөр эрхлэлт дэх бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг зогсоох тухай конвенцууд болно. Эдгээр зарчмууд нь ОУХБ-ын 1998 оны “Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, эрхийн тухай” тунхаглалд

¹³² <https://www.ilo.org/resource/g20-labour-recommendations-english>

тусгагдсан байдаг. Суурь конвенцуудыг одоогийн байдлаар 1357 удаа соёрхон баталж 91,7 хувийг хүчин төгөлдөр мөрдөж байна. Суурь найман конвенц:

- Эвлэлдэн нэгдэх ба зохион байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны 87 дугаар конвенц
- Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай 1949 оны 98 дугаар конвенц
- Албадан хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр конвенц
- Албадан хөдөлмөрийг устгах тухай 1957 оны 105 дугаар конвенц
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай 1973 оны 138 дугаар конвенц
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай 1999 оны 182 дугаар конвенц
- Тэгш шан хөлс олгох тухай 1951 оны 100 дугаар конвенц
- Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 1958 оны 111 дүгээр конвенц

Засаглалын дөрвөн конвенц: /Удирдамжийн шинжтэй/ ОУХБ-ын Удирдах зөвлөлөөс дараах дөрвөн конвенцыг тэргүүлэх шинжтэй баримт бичгээр тодорхойлсон. Эдгээр конвенц нь соёрхон баталсан гишүүн орнуудад олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний тогтолцооны чиг үүргийг боловсронгуй болгох ач холбогдолтой. ОУХБ-ын “Шударга даяарчлалын төлөөх нийгмийн шударга ёсны тухай” тунхаглал, дагалдах баримт бичигт Засаглалын конвенцуудын үзэл санааг ач холбогдол өгч, цохон тэмдэглэсэн байдаг.

- Хөдөлмөрийн хяналтын тухай 1947 оны 81 дүгээр конвенц
- Хөдөлмөрийн хяналтын тухай (Хөдөө аж ахуйн салбар) 1969 оны 129 дүгээр конвенц
- Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний хэрэгжилтийг дэмжих гурван талт зөвшилцлийн тухай 1976 оны 144 дүгээр конвенц
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай 1964 оны 122 дугаар конвенц

Олон Улсын хөдөлмөрийн байгууллага болон бусад олон улсын ТББ-ууд НҮБ-аас хүргүүлсэн зөвлөмжийг удиртгал болгон түгээн дэлгэрүүлж байна. Дэлхий даяар тулгарч буй өндөр настнуудын хүний эрхийн асуудлын нэг нь ахмад настуудын эрх зүйн чадамж, бие даасан байдал, хөдөлмөр эрхлэлт, бие даан амьдрахад нь ялгаварлан гадуурхалт, гадуурхагдах, эрх нь хязгаарлагдахад хүргэдэг нийгмээрээ хөгшрөлтийг гадуурхах хандлага юм.

Ахмад настны эрхийг хамгаалах конвенцыг ахмад настнуудын хүний эрхийн норматив стандартын олон улсын эрх зүйн хүчин төгөлдөр баримт бичиг гэдгийг дэлхийн даяар хүлээн зөвшөөрүүлэх зорилготой бөгөөд ахмад настнуудын хүний эрхийг хэрэгжүүлэх, хамгаалахад чиглэгддэг. Ахмад настнуудад тохиолдож буй хүний эрхийн олон зөрчлийн үндсэн нийтлэг хүчин зүйл болох хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны дарамт шахалт хаа сайгүй далд хэлбэртэй оршиж байна.

Хөдөлмөр эрхлэх үйл явцад хувь хүний харилцаа нь албан байгууллага болон улс орны хэмжээнд нийгэмд зөв хандлага бий болгох ба хувь хүмүүсийн хоорондын харилцааны ёс зүй, хандлага дээр тулгуурладаг. НҮБ болон Ахмад настны эрхийн холбоо (GAROP), ОУХБ-аас гаргасан конвенцын ахмад настнуудын эрүүл мэнд, хоол тэжээл, орон байр ба байгаль орчин, гэр бүл, нийгмийн халамж, орлого, аюулгүй байдал, хөдөлмөр эрхлэлт, боловсрол зэрэг ахмад настны эрхэд хамаарах хэд хэдэн дэд сэдвүүдийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрсөн байна.

Тиймээс эдгээр асуудлыг шийдвэрлэх бодлогын зөвлөмжийг улс орнуудад хүргүүлсэн бөгөөд үүнд, төрийн албанд насны бүлгүүдийн тэнцвэргүй байдлаас зайлсхийх, тэтгэврийн насны хязгаарыг дахин судлах шаардлагатай байна. Нэмж дурдахад ахмад настнуудын эрүүл мэнд, тэтгэвэрт гарах санхүүгийн баталгааг хангахад чиглэсэн идэвхтэй бодлого боловсруулахыг зөвлөж байна.

Ахмад настны хувьд НҮБ нь хөгшрөлтийн талаарх зөвлөмж, гишүүн орнуудын дотоод бодлогыг тодорхойлж, ахмад настны тухай бодлого тодорхойлох, шийдвэр гаргах түвшинд авч хэрэгжүүлэхэд дөхөм болох үүднээс зөвлөмжөө хүргүүлсэн байна.

ГУРАВ. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

ЯПОН УЛС

Япон Улс хүн амын тоогоор дэлхийн улс орнуудаас 12-рт жагсаж байна.¹³³ 2024 оны байдлаар 122.7 сая хүн амтай тус улс нь сүүлийн 10 жилд хүн амын тоо нь ойролцоогоор 3 саяар буурсан үзүүлэлттэй байна. Хүн амын төрөлт буурч, хөгшрөлт хурдацтай явагдаж байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын тоо буурч, дотоодын нийт бүтээгдэхүүн буурахад нөлөөлөөд байна. Тиймээс тэтгэвэрт гарах насыг уртасгах, ахмад ажилчдын тоог нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоог нэмэгдүүлэх талаар ихээхэн анхаарч ажиллаж байна. 2022 оны байдлаар 65 ба түүнээс дээш насны нийт ажил эрхэлж буй хүмүүсийн тоо 6,39 сая болж, хөдөлмөрийн насны хүн амын 10.6%-ийг эзэлж байна.

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны мэдээлснээр 2022 он хүртэл 70 ба түүнээс дээш насны хүмүүсийг ажиллуулах хөтөлбөртэй компаниудын эзлэх хувь сүүлийн 10 жилийн хугацаанд хоёр дахин нэмэгдэж, 39 хувьд хүрээд байна. 65 ба түүнээс дээш насны ажилтнуудыг албан журмын дагуу тэтгэвэр тогтоолгосон ч үргэлжлүүлэн ажиллуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн харьцаа мөн хугацаанд 12 пунктээр нэмэгдэж, 25%-д хүрчээ.

Хууль эрх зүйн орчин

Япон Улсад 10-аас доошгүй жил шимтгэл төлсөн тохиолдолд улсын хэмжээнд өндөр насны тэтгэврийг 65 насаар тогтоодог байна.¹³⁴ 65-75 нас хүртэл тэтгэвэрт гарахаа хойшлуулж болох бөгөөд хойшлуулсан тэтгэврийн хэмжээг сард 0.7%, жилд 8.4%-аар нэмэгдүүлнэ.

Япон улсын төрийн албан хаагчийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд зааснаар төрийн ордон болон түүнтэй адилтгах байгууллагад ажилладаг албан тушаалтнууд 60 насандаа тэтгэвэрт гарна гэж заасан байна.

2020 оны төрийн албан хаагчийн хууль болон орон нутгийн төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хөгшрөлт хурдацтай явагдаж, ажиллах хүчний хомстолд орж байгаатай холбоотойгоор төрийн албаны тэтгэврийн насыг 60 байсныг 61 болгон нэмэгдүүлж өөрчилсөн. Цаашдаа 2031 он гэхэд 65 нас хүргэхийн тулд хоёр жил тутамд нэг жилээр нэмэгдүүлнэ.

Япон улсын ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (Act on Stabilization of Employment of Elderly Persons)¹³⁵

¹³³ Japan population <https://www.worldometers.info/world-population/japan-population/>

¹³⁴ Pensions at a Glance 2023 <https://www.oecd.org/els/public-pensions/PAG2023-country-profile-Japan.pdf>

¹³⁵ Act on Stabilization of Employment of Elderly Persons <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2621/en>

Тус хуулийн зорилго нь эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг авах замаар нийгмийн халамжийг дэмжихэд оршино.

“Ахмад настан” гэсэн ангилалд Эрүүл мэнд нийгмийн хамгааллын яамны тушаалаар тогтоосон насанд хүрсэн буюу түүнээс дээш насны хүнийг хэлнэ гэж заажээ.

Засгийн газар, орон нутгийн засаг захиргааны хариуцлага

- Засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа нь ажил олгогч, ажилчид болон бусад холбогдох хүмүүсийн сайн дурын хүчин чармайлтыг зохих ёсоор анхаарч үзэхийн зэрэгцээ эдгээр ажил олгогчид, ажилчид болон бусад холбогдох хүмүүст нөхцөл байдлын дагуу шаардлагатай дэмжлэг үзүүлэх;
- Ахмад настнуудын хүсэл, чадамжид нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэх болон бусад төрөл бүрийн хөдөлмөр эрхлэх боломжийг хангахад шаардлагатай арга хэмжээг цогц, үр дүнтэй сурталчлах;
- Ахмад настныг дахин ажлын байраар хангахад шаардлагатай мэргэжлийн сургалт зохион байгуулах.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах үндсэн бодлого

Эрүүл мэнд, хөдөлмөр, хамгааллын сайд нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах зэрэг арга хэмжээний үндэс болгон “Тогтворжуулах арга хэмжээний үндсэн бодлого”-ыг боловсруулна. Үүнд:

- Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүрдүүлэх;
- Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгыг тодорхойлох;
- Ажил олгогчоос ажилчдын чадавхыг хөгжүүлэх, сайжруулах, ажлын байрыг сайжруулахад чиглэсэн зохистой арга хэмжээг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын удирдамжийг батлах;
- Бусад бүх төрлийн нөхцөлийг сайжруулах, дахин ажилд ороход дэмжлэг үзүүлэх;
- Ажил олгогчоос өндөр настны ажлын төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх, арга хэмжээ авах;

- Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг хангах арга хэмжээг саадгүй хэрэгжүүлэх;
- Авах арга хэмжээний үндэс суурь болохуйц тодорхой мэдээллийг цуглуулах;
- Ахмад настныг дахин ажлын байраар хангах арга хэмжээг хөнгөвчлөх үндсэн бодлогод байх ёстой мэдээллийг бүрдүүлэх;
- Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулахын тулд авах арга хэмжээний үндсэн бодлого болох бусад мэдээллийг бүрдүүлж тусгана.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах арга хэмжээний үндсэн бодлогыг боловсруулахаас өмнө Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд холбогдох захиргааны байгууллагын дарга нартай зөвшилцөж, тэдний санал бодлыг сонсож үйл ажиллагааг хэрэгжүүлэх Бодлогын зөвлөлийг байгуулна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах арга хэмжээний үндсэн бодлогыг боловсруулсны дараа Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нэн даруй түүний тоймыг олон нийтэд зарлана.

Ажилд орох, ажилд авах үндэслэл

- 65 наснаас дээш насныхныг зайлшгүй ажилд авах, ажиллуулах тохиолдолд шалтгааныг тайлбарлах;
- Ажил олгогчийн гаргасан тайлбар шалтгааныг үндэслэн Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тайлбар зөвлөмж өгнө.

Ажилд орох өргөдлийн халаасны дэвтэр (Pocketbook)

Хөдөлмөр эрхлэлт, аюулгүй байдлын албанаас ажилгүй дунд болон ахмад настанд ажилд орох өргөдлийн халаасны дэвтрийг өгдөг. Тус дэвтэрт ажилд орохыг хүссэн өргөдөл, мөн ажил хайх үйл ажиллагаанд албадан бус, өөрийн хүсэл сонирхлоор оролцохыг хүлээн зөвшөөрсөн өргөдлийг бичнэ. Тус дэвтрийн хугацааг Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас тогтооно. Энэхүү дэвтрийг үндэслэн тухайн ажил хайж байгаа хүнд мэргэжлийн чиг баримжааг олж өгөх, хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэшүүлэх сургалтад хамруулах, шинээр орсон ажлын байранд дадлагажуулах, тогтвортой ажиллуулах зэрэг арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлт, аюулгүй байдлын алба хариуцан ажиллана.

Бусад байгууллагын чиг үүрэг

Хөдөлмөр эрхлэлт, аюулгүй байдлын агентлагууд, орон нутгийн засаг захиргаа, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

хөдөлмөр эрхлэлтийн байгууллага нь хуульд заасны дагуу ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд нягт уялдаатай хамтран ажиллах чиг үүрэгтэй байна.

Албан журмаар тэтгэвэрт гарсан хүмүүсийн дахин хөдөлмөр эрхлэх боломжийг хангах

Төрийн удирдах албан тушаалтныг 60-аас дээш насанд албан тушаалыг бууруулж, заавал албадан тэтгэвэр тогтоолгох тогтолцоог хэрэгжүүлнэ. Энэхүү тогтолцоо нь залуу ажилтны ажлын байрны зэрэг дэвийг нэмэгдүүлэх зорилготой байна.

Япон Улсын ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн V бүлэгт албан журмаар тэтгэвэрт гарсан хүмүүсийн дахин хөдөлмөр эрхлэх боломжийг хангах гэсэн бүлгээр тэтгэвэрт гарсан ахмад ажилтныг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлэх боломжийг зохицуулжээ.

Засгийн газраас албан журмаар тэтгэвэр тогтоолгосон ахмад настны цаашдын хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах, нийгмийн халамжийг сайжруулах, амьдралын сайн сайхан байдлыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг дэмжих зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж, засгийн газар болон орон нутгийн засаг захиргаа зөвлөгөө дэмжлэг үзүүлэн мөн хяналт тавин ажилладаг байна.

Албан журмаар тэтгэвэрт гарсан ахмад ажилтныг болон бусад өндөр насны тэтгэвэр авдаг иргэдийг түр зуурын болон хөнгөн ажлын байраар хангах боломжийг бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Ахмад настны хөдөлмөрийг дэмжих хүний нөөцийн төвүүдийг томилон ажиллана.

Хүний нөөцийн төвийн чиг үүрэг:

- Түр зуурын ажил болон бусад хөнгөн ажлын байраар хангах, ажилд орох хүсэлтэй өндөр настан, тэтгэвэрт гарсан хүмүүсийг системтэйгээр ажиллуулах;
- Түр зуурын ажил болон бусад хөнгөн ажилд орох хүсэлтэй өндөр настан тэтгэвэр авагчдыг ажилд зуучлах үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх;
- Өндөр настан тэтгэвэр авагчдад түр зуурын ажил болон бусад хөнгөн ажил эрхлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгоход чиглэсэн сургалт явуулах;
- Өмнөх гурван зүйлд зааснаас гадна өндөр настан, тэтгэвэр авагчдад түр зуур ажил эрхлэхэд шаардлагатай бусад бүх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн

хамгааллын яамны тушаалын дагуу үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан тооцоог санхүүгийн жил дууссаны дараа мужийн засаг даргад ирүүлнэ.

Хүний нөөцийн төвийн холбооны чиг үүрэг:

Эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар нэгдсэн холбоо, нэгдсэн санг муж бүрд томилж, ахмад настнуудын нийгмийн халамжийг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор, албан журмаар тэтгэвэрт гарсан хүмүүсийн ур чадварыг практикт ашиглахыг идэвхтэй сурталчилна. Төвийн чиг үүрэг:

- Хүний нөөцийн төв, хүний нөөцийн холбооны үйл ажиллагааны талаар олон нийтэд сурталчлах ажлыг хэрэгжүүлэх;
- Хүний нөөцийн төв, хүний нөөцийн холбооны үйл ажиллагаа эрхэлж буй хүмүүст сургалт явуулах;
- Хүний нөөцийн төвүүд болон хүний нөөцийн холбооны үйл ажиллагааг уялдуулж, чиглүүлэх, бусад тусалцаа дэмжлэг үзүүлэх;
- Хүний нөөцийн төв, хүний нөөцийн холбооны үйл ажиллагааны талаарх мэдээлэл, материал цуглуулж, бусад холбогдох этгээдэд өгөх;
- Хүний нөөцийн төв, хүний нөөцийн холбоог цаашид тогтвортой хөгжүүлэх, өндөр настны тэтгэвэрт гарсан хүмүүсийн ур чадварыг практикт идэвхтэй ашиглах, дэмжих шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулах чиг үүрэгтэй байна.

Засгийн газрын дэмжлэг

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах, нийгмийн халамжийг цаашид сайжруулах зорилгоор засгийн газар “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг тогтворжуулах арга хэмжээний үндсэн бодлого”-ын дагуу ажил олгогч, ажилчид болон бусад холбогдох этгээдэд туслах зорилгоор дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд:

- Ахмад настны хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой ажил олгогч байгууллагад улсаас тэтгэмж олгох;
- Албан журмын тэтгэврийн насыг наашлуулах, тасралтгүй хөдөлмөр эрхлэлтийн тогтолцоог нэвтрүүлэх, дахин ажилд орохыг дэмжих зэрэг арга хэмжээ авах;
- Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийн талаарх техникийн асуудлаар ажил олгогч болон бусад холбогдох талуудад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

- Тэтгэвэрт гарсны дараах амьдралаа төлөвлөхөд нь туслах шаардлагатай зөвлөгөө, зааварчилгааг өгөх;
- Засгийн газар өндөр настныг ажилд зуучлах үйл ажиллагааг үр дүнтэй хангахад шаардлагатай тоног төхөөрөмж, бусад бэлтгэл ажлыг сайжруулах;
- Орон нутгийн засаг захиргаа болон бусад холбогдох байгууллагууд ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ авч, тухайлбал, ахмад настнуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг үүсгэн байгуулсан тохиолдолд засгийн газраас шаардлагатай хөрөнгө төсвийн дэмжлэг үзүүлж болно.

ӨМНӨД СОЛОНГОС УЛС (БНСУ)

Өмнөд Солонгос улсын хувьд хүн ам нь хурдацтай хөгширч буй улсын нэг бөгөөд 65 ба түүнээс дээш насны хүмүүсийн тоо 2060 онд хөдөлмөрийн насны хүн амын 80%-ийг давах төлөвтэй байгаа нь ЭЗХАХБ-ын гишүүн орнуудаас хамгийн өндөр үзүүлэлттэй улс болж байна.¹³⁶

Сүүлийн хорин жилийн хугацаанд хөдөлмөрийн насны хүн амын (15-64) дунд ахмад настнуудын (50-64) эзлэх хувь 2000 онд 18.8% байсан бол 2020 онд 37.5% болж нэмэгджээ. Төрөлтийн түвшин бага, дундаж наслалт өндөр байгаагаас шалтгаалан ажиллах хүчний насжилт бүр ч хурдацтай нэмэгдэх төлөвтэй байна. Ахмад ажилтнууд өндөр албан тушаал хашиж, өндөр цалин авах магадлалтай тул ахмад ажилчид хөдөлмөрийн өндөр зардал үүсгэж болзошгүй байна. Тус улсын хувьд цалинг боловсролын түвшин, ажилласан жилээр нь тодорхойлдог. Энэ нь бодлогын хүчтэй хариу арга хэмжээ байхгүй тохиолдолд эдийн засгийн өсөлтийг бууруулж, тэгш бус байдлыг нэмэгдүүлж, сайн сайхан байдлыг сулруулж, эдийн засгийн тогтвортой байдал болон нийгмийн халамж сорилттой тулгарч байна.

Ахмад настнуудын ажлын байр бий болгох бодлого нь зөвхөн өндөр настай, бага орлоготой ахмад настанд төдийгүй өндөр бүтээмжтэй, тэтгэвэрт гарах бэлтгэлгүй залуу ахмадуудад зайлшгүй шаардлагатай. Ахмадуудын ажлын байр бий болгох нь зөвхөн тэтгэвэрт гарах орлогоо баталгаажуулаад зогсохгүй, дунджаас доогуур орлоготой ахмад настнуудыг дэмжин үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Тус улсын хувьд төрөлт буурсантай холбоотойгоор 2030 он гэхэд хөдөлмөрийн насны залуучуудын тоо нэг саяар цөөрнө гэсэн судалгаа гаргажээ.

¹³⁶ <https://www.oecd-ilibrary.org/sites/374630b6-en/index.html?itemId=/content/component/374630b6-en>

Тиймээс төрөөс тэтгэврийн насыг хойшлуулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх шаардлага үүссэн. 2016 оноос хойш үе шаттайгаар хэрэгжиж эхэлсэн заавал тэтгэвэрт гарах насыг 60 нас болгосон нь ахмад ажилчдын (55-60 насны) хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн бол, харин хувийн компаниудад ажилладаг залуучуудын (15-29 насны) тоо буурахад нөлөөлжээ.

Өмнөд Солонгосын Статистикийн байгууллагаас гаргасан “Ахмад настны нэмэлт судалгааны дүн” тайланд дурдсанаар, 2024 оны 05 дугаар сарын байдлаар өндөр настан 15.481.000 байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.098.000-аас 384.000 (2.5%)-аар өссөн нь түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд 10 жилийн өмнөх үеэс 10.845.000-аас 4.253.000 буюу 39.2%-аар өсчээ.¹³⁷ Тус судалгааны тайланд дурдсанаар, ахмад настнуудын 10.602 сая буюу 68.5% нь цаашид ажиллах хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн бөгөөд ажил хөдөлмөр эрхлэх шалтгаануудад нэгт, амьжиргааны зардалд туслах (55.8%), хоёрт, ажиллах таатай нөхцөл (35.6%) орсон байна. Цаашид ажиллах хүсэлтэй өндөр настнууд дунджаар 73 нас хүртлээ ажиллах хүсэлтэй гэж хариулсан бөгөөд сарын дундаж цалин 2-2,5 сая вон (19.8%) байвал тохиромжтой гэж хариулжээ.

2023 оны 06 дугаар сард Өмнөд Солонгосын Хөдөлмөр эрхлэлтийн талаарх сэтгүүлд нийтлэгдсэн “65 ба түүнээс дээш насны ахмадуудын хөдөлмөр эрхлэлтийн байдал, шалтгаан, үр дагавар” тайланд¹³⁸ дурдсанаар 2018-2022 оны хооронд эдийн засгийн идэвхтэй хүн ам, ажил эрхлэлтийн өсөлтийн дийлэнх хувийг 65 ба түүнээс дээш насны ахмадууд эзэлж байна. Энэ хугацаанд эдийн засгийн идэвхтэй 65 ба түүнээс дээш насны иргэдийн тоо, хөдөлмөр эрхэлж буй иргэдийн тоо жилд дунджаар 9 гаруй хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өмнөд Солонгосын статистикийн байгууллагаас гаргасан “2023 оны эдийн засгийн идэвхтэй хүн амын судалгаа-ахмад настны нэмэлт судалгаа”-нд дурдсанаар өндөр настан буюу 55-79 насны хүн амын эдийн засгийн идэвхжилийн оролцоо 60.2%-тай гарсан¹³⁹ нь өндөр настнууд ажиллах хүчрүү орж байгааг харуулж байна. Тухайлбал, эдийн засгийн идэвхтэй өндөр настан хүн ам 9.3 саяд хүрч, өнгөрсөн оноос 349,0 мянгаар нэмэгдсэн байна. Ажил эрхлэлтийн түвшин 58.9%-тай байна.

Бодлого, эрх зүйн орчин

Өмнөд Солонгос улс 2025 он гэхэд хэт хөгширсөн нийгэм болох магадлалтайгаас гадна өндөр настнуудын ядуурлын түвшин өндөр байгаа нь анхаарал татсан асуудал болж байна. Тиймээс тэтгэвэрт гарсан

¹³⁷ <https://www.newspost.kr/news/articleView.html?idxno=11027> “Ахмад настны эдийн засгийн үйл ажиллагааны статистик” болон “Хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийн тайлан”-н талаар

¹³⁸ <https://www.newspost.kr/news/articleView.html?idxno=110270>

¹³⁹ <https://www.newspost.kr/news/articleView.html?idxno=112399>

ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох асуудал нь тулгамдсан асуудал юм. Энэхүү асуудлыг шийдвэрлэхэд бодлого, эрх зүйн орчин чухал бөгөөд асуудлыг шийдвэрлэх зорилгоор ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн хууль тогтоомжийг баталж, үе шаттай хэрэгжүүлж байна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой дараах хууль тогтоомж хэрэгжиж байна.

Ахмад настныг хөдөлмөр эрхлэхэд насаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2022.06.10) (고용상 연령차별금지 및고령자고용촉진에 관한 법률)¹⁴⁰

Ахмад настныг хөдөлмөр эрхлэхэд насаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 19 дүгээр зүйлд ажилтны тэтгэвэрт гарах насыг 60 ба түүнээс дээш байхаар тогтоосон. Хэрэв бусад хууль тогтоомжоор тэтгэвэрт гарах насыг 60 ба түүнээс дээш байхаар тогтоогоогүй тохиолдолд тэтгэвэрт гарах хамгийн доод нас 60 байна. Энэхүү зохицуулалт нь 2013 оноос хэрэгжиж байгаа бөгөөд тэтгэвэрт гарах насыг сунгасан аж ахуйн нэгж, ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний тогтолцоог шинэчлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой бөгөөд шаардлагатай тохиолдолд төрөөс татаас олгох замаар дэмжлэг үзүүлэхээр заасан.

Түүнчлэн тэтгэвэрт гарсан хүн дахин ажилд орох хүсэлтэй бол ажил олгогч тухайн хүнийг хөдөлмөрийн чадварт нь тохирсон ажилд эгүүлэн ажиллуулах боломжтой бөгөөд цалингийн хэмжээг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу талууд тохиролцохоор зохицуулсан байна. Тэтгэвэрт гарсан хүнийг дахин ажилд ороход төрөөс болон ажил олгогчоос үзүүлэх дэмжлэгийн талаар зохицуулсан.

60-аас дээш насанд тэтгэвэрт гарах тогтолцоог нэвтрүүлэх нь ахмад ажилчдыг нас харгалзахгүйгээр чадвараас нь хамааруулан ажиллах хугацааг уртасгах боломжийг олгоход оршино. Өөрөөр хэлбэл, ажилтан, ажил олгогч зөвшилцөн тэтгэвэрт гарах насыг 60-аас дээш тогтоох боломжтой юм. Гэхдээ энэхүү зохицуулалт нь төрийн албан хаагчдад хамаарахгүй.

Энэхүү хуулийг 2023 оны 10 дугаар сарын 31-нд Ахмад настны ажлын байр, нийгмийн үйл ажиллагааг дэмжих хууль¹⁴¹ (노인 일자리 및 사회활동 지원에 관한 법률) болгож шинэчлэн баталсан бөгөөд 2024 оны 11 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх юм.

¹⁴⁰ <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsId=000121&ancYnChk=0#0000>

¹⁴¹ <https://www.law.go.kr/IsInfoP.do?IsSeq=255807&viewCls=IsRvsDocInfoR#>

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн цогц төлөвлөгөө

Ахмад настныг хөдөлмөр эрхлэхэд насаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 4-3 дугаар зүйлд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндсэн төлөвлөгөөг Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн сайд таван жил тутам холбогдох байгууллагуудын дарга нартай зөвшилцөн тогтоохоор заасан. Ийнхүү заасны дагуу Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яамнаас “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн цогц төлөвлөгөө (2013-2017)”¹⁴²-г анх 2013 онд баталсан бөгөөд эдийн засгийн бие даасан байдал, тэтгэвэрт гарсан ахмадуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх алсын харааг тодорхойлсон байдаг. Энэхүү төлөвлөгөөний зорилго нь ахмад настны санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийг өргөжүүлэх, сайжруулах, бизнес эрхэлж, хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлт, аж ахуй эрхлэлтийг идэвхжүүлэх зорилготой байсан.

Харин 2018 онд “Ахмадуудын ажлын байр, нийгмийн арга хэмжээний 2 дугаар цогц төлөвлөгөө (2018-2022)”-г баталсан бөгөөд энэ нь ахмад настны ажлын байр, нийгмийн халамжийн үйл ажиллагааг хослуулан хэрэгжүүлсэн.

“Ахмад настны ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 3 дахь цогц төлөвлөгөө (2023-2027)”¹⁴³-г 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр баталсан. Тус төлөвлөгөө нь ахмад настны ажлын байрыг 2027 он гэхэд нийт ахмад настны 10 хувийг хамруулах, хөдөлмөр эрхлэлтэд эмзэг бүлгийн бага орлоготой ахмад настнуудыг түлхүү хамруулах, нийгмийн эмзэг бүлгийнхэнд халамжийн үйлчилгээ үзүүлэх, ажлын байраар хангах зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү хоёр зорилтыг хэрэгжүүлэх 4 нарийвчилсан төлөвлөгөөг баталсан. Үүнд:

- Олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн ажлын байрыг сайжруулна.
 - Төрийн үйлчилгээтэй холбоотой ажлын байрыг нэмэгдүүлэх;
 - Нийтийн ашиг сонирхолд нийцсэн ажлын байрны чанарыг сайжруулах;
 - Нийтийн эрх ашгийг хамгаалах ажлын тогтолцоог боловсронгуй болгох;
- Нийгмийн үйлчилгээний төрлийн ажлын байрыг нэмэгдүүлнэ.
 - Нийгмийн үйлчилгээ үзүүлэх ажлын байрны тоог нэмэгдүүлэх;
 - Төрийн байгууллага, хувийн хэвшлийн компаниудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх замаар нийгмийн үйлчилгээний тэргүүлэх загварыг идэвхжүүлэх;

¹⁴² <https://www.newspost.kr/news/articleView.html?idxno=110441>

¹⁴³ https://www.mohw.go.kr/gallery.es?mid=a10505000000&bid=0003&tag=&act=view&list_no=377501

- Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлнэ.
 - Хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх;
 - Гарааны ажлын байрны дэмжлэгийг нэмэгдүүлэх;
 - Хувийн хэвшлийн ажлын байрыг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох;
- Ахмад настнуудад тогтвортой ажлын байр бий болгох тогтолцоог сайжруулна.
 - Хууль, эрх зүйн тогтолцоог бэхжүүлэх;
 - Уламжлалт тогтолцоог сайжруулах;
 - Бодлогын үр нөлөөг статистик мэдээлэлд үндэслэн шинжлэх;
 - Нийгмийн ойлголтыг өөрчлөх;
 - Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, тэр дундаа аж ахуйн нэгжийн нийгмийн оролцоог идэвхжүүлэх;
- Байгууллагын тогтвортой суурийг бий болгож, мэдлэгийг дээшлүүлнэ.
 - Ахмад настны ажлын байртай холбоотой хуулиудыг батлан гаргаж, төрөл бүрийн статистик мэдээ гаргаж, бодлогод тусгах.

Энэхүү хөтөлбөрт гурван төрлийн ажлын байрны боломжийг багтаасан. Үүнд:

1. Төрийн үйлчилгээний ажлын байр: Орон нутгийн засаг захиргаа нь өндөр настан, ахмад настны асрамж, нийтийн байгууламжийн засвар, үйлчилгээ, метроны хөтөч, нийтийн болон бага сургуулийн номын санч, түүхэн дурсгалт газрын хамгаалагч зэрэг орон нутгийн хэрэгцээнд нийцүүлэн орлого багатай, боловсролтой хүмүүсийг голчлон ажилд авдаг. Цалингийн хувьд сард 30 цаг ажилладаг бөгөөд 270,000 вон байдаг.
2. Хувийн хэвшлийн ажлын байр: Орон нутгийн засаг захиргаа хөтөлбөрт оролцогчдыг ажилд авсан хувийн хэвшлийнхэнд татаас олгодог. Цалин нь ажлын цаг, ажлын төрлөөс хамааран 365.000-1.961.000 вонын хооронд хэлбэлздэг.
3. Нийгмийн халамж үйлчилгээний ажлын байр: 2019 онд Засгийн газар нийгийн халамжийн хэрэгцээ нэмэгдэж байгаатай холбогдуулан гурав дахь удаагаа нийгмийн халамж үйлчилгээний ажлын хөтөлбөрийг бий болгосон. Оролцогчид сард ойролцоогоор 60 цаг ажилладаг бөгөөд дунджаар 713.000 вонын цалин авдаг.

Дээр дурдсан ажлын байруудад 65-аас дээш насны (зарим тохиолдолд 60-аас дээш насны) иргэд ажилд орох боломжтой бөгөөд орлогын тодорхой босгоос доогуур орлоготой 65 ба түүнээс дээш насны хүмүүсийг зөвхөн төрийн үйлчилгээний ажлын байраар хангадаг.

Өмнөд Солонгосын ахмад ажилтны хөгжлийн институт (Korea Older Worker Development Insititute).¹⁴⁴ Тус институт нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яаманд харьяалагддаг, ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн үйл ажиллагаанд оролцох үүрэг бүхий хагас төрийн байгууллага юм. Ахмад настны халамжийн тухай хуулийн 23-2 дугаар зүйлд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн тусгай агентлагууд байгуулж, ажиллуулах гэж заасны дагуу 2005 онд байгуулагдсан. Бүтэц, зохион байгуулалтын хувьд, дарга, захирлуудын зөвлөл, хянан шалгагч, ёс зүйн хяналт шалгалтын хэлтэс, стратеги төлөвлөлтийн хэлтэс, төрийн байгууллагын ажлын байрны хэлтэс, хувийн байгууллагын ажлын байрны хэлтэс, бизнесийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх алба болон төрийн бодлогод дэмжлэг үзүүлэх албатай бөгөөд 12 хотод үйл ажиллагаа явуулдаг.

Төрийн албанаас тэтгэвэрт гарсан иргэдийн хувьд, Төрийн албан хаагч тэтгэвэрт гарахтай холбоотой харилцааг Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн тэтгэврийн тухай хууль болон төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэх тухай тогтоолоор зохицуулж байна.

Төрийн албаны тухай хууль¹⁴⁵: Төрийн албаны тухай хуулийн 74 дүгээр зүйлд зааснаар төрийн албан хаагч нь бусад хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд тэтгэвэрт гарах нас 60 нас байна. Төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарах нас нь 01-06 дугаар сарын хооронд байвал 06 дугаар сарын 30-нд, 07-12 сарын хооронд байвал 12 дугаар сарын 31-нд гардаг.

Зарим хууль тогтоомжоор зарим төрийн албан хаагчийн тэтгэвэрт гарах насыг өөрөөр зохицуулсан байна. Тухайлбал:

Нас	Хууль тогтоомжийн зохицуулалт
70 нас:	<ul style="list-style-type: none"> Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч (Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 45.4 дэх хэсэг) Үндсэн хуулийн цэцийн Ерөнхий шүүгч, Үндсэн хуулийн цэцийн шүүгч (Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 7.2 дахь хэсэг)
65 нас:	<ul style="list-style-type: none"> Шүүгч (Шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн 45.4 дэх хэсэг) Улсын ерөнхий прокурор (Прокурорын байгууллагын тухай хуулийн 41.1 дэх хэсэг) Дээд боловсролын сургалтын байгууллагад багш (Боловсролын төрийн албан хаагчийн тухай хуулийн 47.1 дэх хэсэг) Тусгай байцаагч (Тусгай байцаагчийн тухай хуулийн 12.2 дахь хэсэг)
63 нас:	Ерөнхий прокуророос бусад прокурор (Прокурорын байгууллагын тухай хуулийн 41.2 дахь хэсэг)
62 нас:	Боловсролын чиглэлээр ажилладаг төрийн албан хаагч (дээд боловсролын байгууллагын багш нараас бусад)

¹⁴⁴ <https://kordi.or.kr/content.do?cmsId=153> https://kordi.or.kr/upload/attach/08/357308_202004161121559150.pdf

¹⁴⁵ <https://www.law.go.kr/LSW/InfoP.do?isId=001719&ancYnChk=0#0000> Төрийн албаны тухай хууль

Улс төрийн албан хаагчдын хувьд Ерөнхийлөгчийн шийдвэрээр томилогдож, чөлөөлөгддөг төрийн захиргааны байгууллагуудын газрын дарга нар, дэд сайдуудын тэтгэвэрт гарах насыг заагаагүй. Харин Хяналт шалгалтын тухай хууль (감사원법)-д улсын хяналт шалгалтын байгууллагын дарга 70 нас, хяналт шалгалтын байгууллагын гишүүд 65 настай тэтгэвэрт гарахаар заасан байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль¹⁴⁶ (공직자윤리법) Энэхүү хууль нь 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр болсон.

Тус хуулийн 4 дүгээр бүлэгт тэтгэвэрт гасан төрийн албан хаагчийн хөдөлмөр эрхлэлт, үйл ажиллагааны хязгаарлалтын талаар зохицуулсан. Энэхүү хуулийн 3.1.1-12 дугаар хэсэгт заасан албан тушаалтнууд болох төрийн улс төрийн албан тушаалтан, төрийн өндөр болон түүнтэй адилтгах албан тушаалтан, төрийн албаны 4 ба түүнээс дээш зэрэгтэй төрийн албан хаагчид, төрийн тусгай албан хаагч, боловсролын болон төрийн үйлчилгээний байгууллагын удирдах болон түүнтэй адилтгах албан тушаалтнууд нь тэтгэвэрт гарсан өдрөөс хойш гурван жилийн хугацаанд тус хуульд заасан байгууллагын аль нэгэнд ажилд орохыг хориглосон.

Тухайлбал,

- өөрийн хөрөнгө, жилийн гадаад гүйлгээний дүн тодорхой түвшнээс дээш гарсан ашгийн төлөөх компани;
- өмгөөллийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан хуулийн фирм
- Мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан жилийн гадаад гүйлгээний дүн нь тодорхой түвшнээс дээш гарсан нягтлан бодох бүртгэлийн компани;
- Гадаадын хуулийн зөвлөхийн тухай хуульд заасан гадаадын хуулийн зөвлөх фирм, жилийн гадаад гүйлгээний дүн нь тодорхой түвшнээс дээш гарсан хамтарсан хуулийн фирм;
- Төрийн байгууллагын удирдлагын тухай хуульд заасан зах зээлийн төрлийн нийтийн аж ахуйн нэгж;
- Аюулгүй ажиллагааны хяналтын ажил, лиценз/зөвшөөрөл олгох, худалдан авах ажил хариуцсан төрийн үйлчилгээний байгууллагууд
- Бага, дунд боловсрол болон дээд боловсролын тухай хуульд заасан сургууль байгуулж, удирдан зохион байгуулдаг боловсролын байгууллага;
- Эмнэлгийн үйлчилгээний тухай хуульд заасан нэгдсэн эмнэлэг болон холбогдох аж ахуйн нэгж;

¹⁴⁶ <https://www.law.go.kr/LSW//lsLinkProc.do?lsNm=%EA%B3%B5%EC%A7%81%EC%9E%90%EC%9C%A4%EB%A6%AC%EB%B2%95&chrClsCd=&mode=20&ancYnChk=0#>

- Нийгмийн халамжийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн байгууллага болон нийгмийн халамжийн байгууламжийг ажиллуулдаг бусад ашгийн бус байгууллага;
- Батлан хамгаалах салбар, хүнсний бүтээгдэхүүн зэрэг олон нийтийн аюулгүй байдалтой холбоотой баталгаажуулалт, хяналт шалгалт зэрэг ажлыг гүйцэтгэдэг ашгийн төлөөх компани, корпорац.

Тухайн байгууллагын төрийн албаны ёс зүйн хорооноос тухайн хүний тэтгэвэрт гарахаас өмнө 5 жилийн хугацаанд харьяалагдаж байсан байгууллага, нэгж болон ажилд орох байгууллага хооронд ямар нэг хамаарал байхгүй гэсэн дүгнэлт гарч, ажилд орохыг зөвшөөрсөн тохиолдолд хүн ажилд авч болно. Ийнхүү ажилд орсон тохиолдолд 2 жилийн хугацаанд ажлын тайлангаа зөвшөөрөл өгсөн байгууллагын ёс зүйн хороонд ирүүлнэ.

ЭСТОНИ УЛС

Эстони Улс нь 2021 оны байдлаар 1.33 сая хүн амтай бөгөөд энэ нь 2050 он гэхэд 1.28 сая болж буурах ба харин ахмад (65-аас дээш) настнуудын хүн амд эзлэх хувь 27.9 хувь болж өсөх тооцоо гарчээ.

Тус улсад дундаж наслалт ийнхүү өссөн хэдий ч 65-аас дээш насны ахмад настнуудын эрүүл чанартай наслалт төдийлөн хангалтгүй байна гэж үздэг байна. Энэ нь сүүлийн жилүүдэд тус улсын нийгмийн дотоодод “Тэтгэврийн систем ирээдүйд ямар байвал зохистой вэ” хэмээх хэлэлцүүлэг, мэтгэлцээн өрнөх нэг үндсэн нөхцөл болжээ. Үүний үр дүнд 2021 оноос тэтгэврийн зарим шинэчлэлийг хийж эхэлсний нэг нь ахмад настнуудын ажил хөдөлмөр эрхлэх урам зоригийг дээшлүүлэх, тэгш боломж, таатай нөхцөлөөр хангах явдал юм.

Улсын тэтгэврийн даатгалын тухай хуульд оруулсан 2010 оны нэмэлт, өөрчлөлтөөр тэтгэврийн насыг хүйс харгалзахгүй 63 байсныг 65 болгон нэмэгдүүлсэн. Харин 2021 оны тэтгэврийн шинэчлэлээр тэтгэврийн насыг 2027 оноос эхлэн хүн амын дундаж наслалттай уялдуулан тогтоож байхаар болжээ. 2024 оны байдлаар тус улсын тэтгэврийн насны хязгаар 64 байна. Мөн иргэд тэтгэвэрт гарах тохиромжтой цагаа өөрөө сонгох, тэтгэврээ хэсэгчлэн авч эхлэх, эсхүл тэтгэвэр авч эхлэх хугацаагаа түр хойшлуулах зэрэг боломжуудаар хангагдсан байна. Төрийн алба болон хувийн хэвшилд ажиллаж буй ажилтнууд Улсын тэтгэврийн даатгалын тухай хуульд заасан зохицуулалтад адил тэгш хамрагдана.

Одоо үйлчилж буй тэтгэврийн хууль, журмын зохицуулалтаар тэтгэвэр тогтоохдоо ажилласан жил хугацааны шалгуур тавих, зарим ажил

мэргэжлийн хүмүүст бусдаас эрт, таатай нөхцөлөөр тэтгэвэр тогтоодог зэрэг явдлуудыг орчин үеийн хөдөлмөрийн орчин нөхцөлд хоцрогдсон, шударга бус гэж үзэх хандлагатай болжээ.

Тиймээс наснаас эрт болон таатай нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгодог явдлыг 2021 оноос эхлэн аажмаар бууруулж, улмаар 2026 оноос бүр мөсөн зогсоож, оронд нь иргэд тэтгэврийн насанд хүрэхээс таван жилийн өмнөөс эхлэн тэтгэврийн уян хатан нөхцөлийг сонгон ажил, амьдралаа зохицуулах боломжтой гэж үзэж байна.

Ийнхүү тэтгэврийн тогтолцоог шинэчилснээр иргэд олон таатай нөхцөл боломжоор хангагдахаас гадна тэтгэвэрт гарахдаа уян хатан байдлаар буюу хүсвэл тэтгэвэр авах болон хөдөлмөр эрхлэлтийг хослуулах боломж бүрдэж байгаа юм.

Энэ мэт шат дараалсан олон шинэчлэлт өөрчлөлтүүдийг тусгасан бодлогын төлөвлөлт зохицуулалтыг тус улсын Нийгмийн асуудал эрхэлсэн яамнаас боловсруулан ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийг 2030-2036 оноос эхлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хууль эрх зүйн орчин

Эстони Улсад ахмад настнуудад зориулсан тусгай хууль байдаггүй. Гэвч хүний эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн, тэгш хэрэгжүүлэх тухай Бүгд Найрамдах Эстони Улсын Үндсэн хуульд тусгасан байдаг.

Харин нийгмийн эрхийг:

- Улсын тэтгэврийн даатгалын тухай хууль
- Нийгмийн хамгааллын тухай хууль
- Тэгш байдлын тухай хууль
- Хөдөлмөрийн эрхлэлтийн үйлчилгээ, тэтгэмжийн тухай хууль
- Хөдөлмөрийн гэрээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай хууль зэрэг хуулиудаар тус тусад нь зохицуулдаг байна.

Ахмад настнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх анхны цогц төлөвлөгөөг 2013 онд Нийгмийн асуудал эрхэлсэн яамнаас Мадридын олон улсын ахмад настнуудын үйл ажиллагааны төлөвлөгөө (Madrid International Plan of Action on Ageing)-нд нийцүүлэн баталсан. Гишүүн орнууд нь 4 жил тутамд тус олон улсын төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнадаг байна.

Эстони Улсын “Ахмад настнуудын идэвхтэй амьдралын хөгжлийн төлөвлөгөө”(2013-2020) нь ахмад настанд ээлтэй нийгмийг дэмжих, ахмад настнуудын амьдралын чанар, тэгш боломжийг хангах зорилготой юм. Энэхүү төлөвлөгөөг дараа нь Засгийн газраас баталсан хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, халамж, жендерийн эрх тэгш байдал, тэгш боломжийн стратегийн хүрээнд батлагдсан 2016-2023 оны Нийгмийн халамжийн хөгжлийн цогц төлөвлөгөөнд тусгасан.

Нийгмийн асуудал эрхэлсэн яамнаас одоо 2023-2030 он хүртэлх нийгмийн халамжийн хөгжлийн шинэ төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд үүнд ахмад настнуудын сайн сайхан амьдралын нөхцөл, тэгш боломжийн асуудлыг анх удаа тусдаа дэд зорилтын хүрээнд авч үзэхээр болжээ.

Мөн 2021-2023 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, стратегийн баримт бичгүүдэд тусгагдсан ахмад настны идэвхтэй, эрүүл амьдралыг дэмжих, ялгаварлан гадуурхахтай тэмцэх, ахмад настны эрхийг хамгаалан баталгаажуулахын төлөө ажиллаж байна.

Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого

Эстонийн нийгмийн бодлогод “хөдөлмөр эрхлэлт нь ядуурлын эсрэг хамгийн сайн хамгаалалт” гэсэн зарчмыг баримталдаг. Тиймээс хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын тогтвортой тогтолцоог бүрдүүлж, нийгмийн өөрчлөлтийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг шинэчлэх болсон. Үүний үр дүнд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний нийгмийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх “Ахмад настнуудын идэвхтэй амьдралын хөгжлийн төлөвлөгөө” (2013-2020) болон бусад бодлогын баримт бичгүүдийн хүрээнд ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн олон бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлсэн байна.

2010 оноос тэтгэврийн насыг 65 болгон нэмэгдүүлж, 2021 оноос тэтгэврийн насыг дундаж наслалттай уялдуулан уян хатан байдлаар тогтоох болсон нь ахмад настнуудыг урт хугацаанд ажил хөдөлмөр эрхлэх, нийгэмд идэвхтэй амьдрах боломжийг бүрдүүлжээ.

Эстонийн ажилгүйдлийн даатгалын сангаас ахмад настнуудад ур чадвараа дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлд тохирох хөтөлбөрийг олох боломжийг олгох үүднээс тэтгэвэр авагчдад хөдөлмөрийн зах зээлийн бүх үйлчилгээг санал болгодог. Тухайлбал: Тэтгэвэрт гарах насны ажил хайгч нь хөдөлмөрийн зах зээлийн сургалтад хамрагдах, мэргэжил дээшлүүлэх, ажилд зуучлуулах, бизнес эрхлэхэд дэмжлэг авах, ажлын байр, ажлын тоног төхөөрөмж, ажил гүйцэтгэхэд шаардлагатай туслах хэрэгслийг урьдчилгаагүй зээлээр (үнэгүй) авах боломжтой.

2019 онд дунд насныханд (55 ба түүнээс дээш) хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээг үр дүнд суурилсан шинэ хэлбэрээр үзүүлэх төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төсөл нь хөдөлмөрийн зах зээлд ахицааг насны хүмүүсийг түлхүү хамруулж тэднийг давтан сургах, зөвлөгөө өгөх зэргээр ур чадвар, ажил хөдөлмөрт бэлэн байдлыг дээшлүүлэх, тохирох ажлын байранд зуучилж, тогтвортой ажиллуулах шинэлэг шийдлүүдийг санал болгожээ.

Аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, боловсролын байгууллага, төрийн болон орон нутгийн захиргааны агентлагууд ахмад настнуудыг ажилд ороход нь туслах зорилгоор уг төсөлд хүсэлт гарган дэмжлэг авах боломж нээлттэй байдаг байна.

Мөн Олон янз байдлын хэлэлцээрийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь төрийн болон төрийн бус байгууллага, компани нь хүмүүсийн олон талт байдлыг хүндэтгэж, ажилтнууд, түншүүд, үйлчлүүлэгчдэдээ тэгш хандах зарчмыг эрхэмлэдэг гэдгээ баталгаажуулсан сайн дурын гэрээ юм. Гэрээнд нэгдэн орсон байгууллагууд өөрсдийн байгууллага болон нийгэмд харилцан туршлага солилцох, тэгш байдлыг хангах зорилгоор хамтын нийгэмлэгийг бүрдүүлэх, тэр дундаа ажилд авахдаа илүү тэгш боломжийг бүрдүүлж буйгаа илэрхийлдэг байна.

Нийгмийн асуудал эрхэлсэн яамны ахмад настны өмгөөллийн стратегийн түншүүд нь ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, 50-аас дээш насны хүмүүсийг хөдөлмөрийн зах зээлд дахин нэвтрүүлэхэд бэлтгэх, тэдний дижитал чадамжийг дээшлүүлэх хөдөлмөр эрхлэлтийн зөвлөгчийг бэлтгэх үүрэгтэй бөгөөд энэ чиглэлийн сургалтыг тогтмол зохион байгуулдаг болжээ. Мөн ажлын байр, цаг хугацааны хувьд хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөлийг улам сайжруулах арга хэмжээг боловсруулж байна.

Эдгээр өөрчлөлтүүдийн үр дүнд илүү уян хатан, бага цагаар ажиллах, эсвэл алсын зайнаас онлайн ажиллахыг илүүд үздэг хүмүүсийг хөдөлмөрийн зах зээлд гаргах боломж илүү нэмэгдсэн нь бүх нийтийн цагийн ажлыг дэмжихэд, тэр дотроо ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд тустай, таатай зохицуулалт, нөхцөлүүд болжээ.

Сайн дурын ажилд дэмжлэг үзүүлэх

Сайн дурын ажилтнууд болон нийгмийн ажилтнуудын ухамсартай хамтын ажиллагаа нь хүмүүсийн ганцаардлыг арилгах, ахмад настнуудын нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, тусламж хэрэгтэй байгаа хүмүүс болон орон нутгийн засаг захиргааны санхүүгийн асуудлыг хэмнэх зэрэгт чухал ач холбогдолтой юм.

Тусгай хэрэгцээт хүмүүс болон ахмад настанд туслах үйлсэд сайн дурынхныг татан оролцуулах зорилгоор 2018 оноос халамжийн тогтолцоонд сайн дурын үйл ажиллагааг турших туршилтын төслийг эхлүүлсэн.

Төсөлд хамрагдсан сайн дурынхны дийлэнх хувийг дунд болон түүнээс дээш насныхан эзэлж байна: 51% нь 55 ба түүнээс дээш насныхан, 28% нь 65 ба түүнээс дээш насныхан байжээ. Төсөл нь тусламж хэрэгтэй хүмүүст шаардлагатай үйлчилгээ, эсвэл гэрээсээ гадуурх нийгмийн үйл ажиллагаанд оролцоход нь туслалцаа үзүүлэх хүртэл хэд хэдэн аргаар дэмжлэг үзүүлж чадсан байна.

Төслийг 2023 оны II хагасаас үе шаттайгаар орон нутгийн засаг захиргаанд шилжүүлсэн бөгөөд одоогоор байнгын ажлынхаа хажуугаар сайн дурын ажил хийдэг ахмадуудын тоо нэмэгдсээр байна.

Тиймээс орон нутгийн аж амьдралыг дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулж, идэвхтэй ажилласан, нийгмийн хөгжилд эерэг үүрэг гүйцэтгэсэн ахмадуудыг Нийгмийн асуудал эрхэлсэн яамны сайд хүлээн авч урамшуулах арга хэмжээг зохион байгуулдаг уламжлал тогтсон байна. Тухайлбал, 2020 онд Ковид-19-тэй тэмцэхэд олон ахмадууд сайн дурын ажилтны хэлбэрээр оролцон зохих хувь нэмрээ оруулжээ.

Ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх

Хөдөлмөрийн зах зээлд насны ялгаварлан гадуурхалтыг бууруулахын тулд ажил олгогчдын мэдлэг, бэлэн байдал, ур чадварыг дээшлүүлэхэд төрөөс ихээхэн анхаардаг байна.

Тэтгэврийн насныхны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс ажил олгогчдод цалингийн хөнгөлөлт үзүүлэх, тэдэнд зориулсан сургалтын зардал, ажилд зуучлах, ажилд дасган зохицуулах зэрэгт зарцуулсан зардлуудыг нь нөхөн олгох гэх мэт арга хэмжээг авах, ажил олгогчдод татварын хөнгөлөлт үзүүлэх зэргээр дэмжлэг үзүүлдэг.

Ахмад настнуудын цагийн ажлыг дэмжих зорилгоор тэдний нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчдоос авахдаа, жишээлбэл, журам ёсоор бол ажил олгогчид хагас цагаар ажилладаг ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг багадаа сард тогтоосон доод хэмжээгээр төлөх ёстой ч тэтгэврийн насны ажилтны шимтгэлийг тухайн тогтоосон шимтгэлээс доогуур байсан ч зөвхөн бодитоор төлсөн цалингаас нь тооцох зохицуулалтыг хийж өгчээ.

Ахмад настны мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа

Тэгш боломжийн комиссар болон түүний ажлын алба нь хөдөлмөр эрхлэх, үйлчилгээ авах, боловсрол эзэмших болон бусад нөхцөл байдалд өөрийгөө ялгаварлан гадуурхаж байна гэж үзсэн ахмад настнуудад зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг.

Комиссар нь ахмад настны эрхийг хамгаалах, ахмад настны талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр идэвхтэй ажилладаг. Тухайлбал, ахмадуудад зориулсан тусгай вэб хуудас ажиллуулж, тэтгэвэр, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, хүчирхийлэл, эд хөрөнгө, мэдээллийн технологийн хэрэглээ, амьдралын өөрчлөлтөд хэрхэн дасан зохицох талаар мэдээлэл өгөх, танин мэдэхүйн нийтлэлүүдийг бичих зэрэг ажлуудыг хийж байна.

Мөн Иргэдийн нийгмийн ухамсрыг дээшлүүлэх зорилгоор Ням гараг бүр Эстони олон нийтийн телевизээр 112000 гаруй үзэгчтэй ахмадуудад зориулсан тусгай нэвтрүүлгийг тогтмол явуулдаг.

2010 оноос хойш олон улсын ахмадын өдрийг тэмдэглэж “60+ фестиваль”-ийг Эстони даяар зохион байгуулдаг болсон. Уг наадамд 5000 гаруй ахмад настан оролцож лекц сонсох, мэдээлэл солилцох, бусад соёлын арга хэмжээнд оролцдог ажээ.

Мөн онд Тартугийн Их сургуулиас Насан туршийн боловсролын зарчимд суурилсан ахмад настнуудад (60 ба түүнээс дээш насны, зарим тохиолдолд 50 ба түүнээс дээш насны) зориулсан үнэ төлбөргүй тусгай сургалтын хөтөлбөрийг эхлүүлж, ахмад настнуудыг нийгэмд гарч буй өөрчлөлтөд уян хатан хандахад тусалж байна. Хөтөлбөрт 4300 гаруй ахмад насны оюутнууд хамрагдсан бөгөөд уг үйл ажиллагаа нь “Оны шилдэг боловсролын үйл ажиллагаа” цол тэмдгээр шагнуулжээ.

Төрийн болон олон нийтийн байгууллагын оролцоо

Төрөөс ахмад насны хөдөлмөр эрхлэлт, тэдний нийгмийн асуудлын тэгш болон хууль ёсны байдлыг хангахын тулд аливаа шийдвэр гаргах, боловсруулахдаа оролцогч талууд болон олон нийтийг хамруулах нь түгээмэл байдаг.

Хамгийн том оролцогч тал болох Эстони олон нийтийн 28000 гаруй тэтгэвэр авагчдыг төлөөлсөн Эстони олон нийтийн тэтгэвэр авагчдын нийгэмлэгийн холбоо нь Эстони олон нийтийн бүх бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.

Эстони олон нийтийн бусад ахмадын байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ч тэдний хоорондын хамтын ажиллагаа сул, бодлого боловсруулах, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд ахмадуудын дуу хоолой тийм ч

хүчтэй биш байсан тул 2019 онд Нийгмийн асуудал эрхэлсэн яамнаас ахмад настны өмгөөллийн байгууллагуудтай хоёр жилийн стратегийн түншлэл байгуулах санаачилга гаргасан. Улмаар 2022 оноос шинэ түншлэл эхлүүлсэн бөгөөд эдгээр түншүүд нь ахмад настны эрх ашгийг хамгаалах байгууллагын хамтын ажиллагаа, харилцаа холбоо, бодлого боловсруулах, нөлөөлөл, хэвлэл мэдээлэлтэй харилцах чиглэлээр ур чадвараа дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэг ажлыг хийжээ.

Ахмад настны бодлогын хороо нь 1997 оноос Нийгмийн асуудал эрхэлсэн яамны зөвлөх байгууллагын үүргийг гүйцэтгэж ирсэн. Ахмад настны өмгөөллийн байгууллага, үйлчилгээ эрхлэгчид, мэргэжилтнүүд, эрдэмтэн судлаачид, улс төрчдөөс бүрдсэн тус хороо нь Нийгмийн асуудал эрхэлсэн яам, төрийн бусад байгууллага, Эстонийн хотуудын холбоо, Хотын захиргаанаас ахмад настнуудтай холбоотой асуудлаар хууль тогтоомж, хөгжлийн төлөвлөгөө болон бусад стратегийн баримт бичгүүдийг боловсруулахад оролцдог. 2022 оноос тус Хорооны үйл ажиллагааны зохион байгуулалтыг шинэчилж, бүс нутгийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нутгийн засаг захиргааны ахмадын зөвлөлийг тэдэнд зөвлөх байгууллага болгон оролцуулахаар болсон байна.

Хууль тогтоомж, хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй байдалд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг заавал хийх ёстой. Нөлөөллийн үнэлгээний асуулга нь ахмад настны эрх, бэрхшээл, амьдралын чанарт гарсан өөрчлөлтийг хэрхэн үнэлэх, ажил олох боломж, нийгэмд хамруулах талаар байдаг ажээ.

ФИНЛАНД УЛС

Сүүлийн 15 жилийн хугацаанд дэлхий даяар ахмад, өндөр настай иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх шаардлага дэлхийн бүх улс оронд тулгарч байна. Ахмад, өндөр настай иргэдийн ялгамжтай байдлыг ойлгох, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх, тэдний гаргасан шийдвэрийг хүндлэх гэх мэт ахмад болон өндөр настай иргэдэд хандах хандлага, тэдэнд ээлтэй орчныг бүрдүүлэх үйл ажиллагаа эрчимтэй нэмэгдэж байна.

Финланд Улс нь дэлхийн хамгийн өндөр насжилттай улс орны жагсаалтыг сүүлийн жилүүдэд тэргүүлж байгаа бөгөөд 2023 оны байдлаар нийт хүн амын тоо ойролцоогоор 5.6 сая байна. Нийт хүн амын насжилтыг насны бүлгүүдээр ангилбал 20-39 настай иргэд 1.4 сая, 40-59 настай иргэд 1.39 сая буюу хүн амын талаас илүү хувийг эзэлж байна. Харин 60-аас дээш насны иргэд 2023 оны сүүлээр 1.6 саяд хүрсэн. Хүн амын насжилт нэмэгдэж байгаа нь эрүүл мэндийн үйлчилгээ, амьдралын орчин сайжирсантай холбоотой гэж дүгнэж байна.

Тус улс хөдөлмөрийн харилцааг хэд хэдэн хууль (Хөдөлмөрийн гэрээний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, Сургалтын чөлөөний тухай хууль, Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлын тухай хууль)-уудаар зохицуулдаг.

Ахмад настнуудад ээлтэй орчинг бүрдүүлэх, тэдэнд зориулсан ажлын байр төлөвлөх, нийгмийн амьдралд оролцох оролцоог хангахаар ажилладаг. Засгийн газраас ахмад иргэдийг хөдөлмөр эрхлэх боломжоор хангахаар тодорхой бодлогоор дэмжин ажиллаж байсан түүхтэй. Харин сүүлийн жилүүдэд ахмад настнуудад зориулсан төрийн үйлчилгээ, нийгмийн халамжийг илүү сайжруулах зорилгоор тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Хууль, эрх зүйн орчин

Финланд Улсад хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн гэрээний тухай хууль (The Employment Contracts Act)-аар зохицуулдаг. Энэхүү хууль нь хөдөлмөрийн харилцааг зохицуулах анхдагч хууль бөгөөд 1922 онд батлагдсан.

Хөдөлмөрийн гэрээний тухай хуульд хөдөлмөрийн гэрээний тодорхойлолт, гэрээ байгуулах, гэрээ дуусгавар болгох, хөдөлмөр хамгааллын дүрэм, талуудын хэд хэдэн үндсэн эрх, үүргийг тусгасан байдаг. Түүнчлэн уг хуульд ажил олгогчийн дагаж мөрдөх нийтлэг эрх, үүрэг, хамтын гэрээгээр тэгш эрх олгох, чөлөө олгох, цалин хөлсийн хэмжээ гэх мэт зохицуулалтыг тусгасан бөгөөд уг хуулийг 2000 оны эхэнд хүчингүй болгосон.

Үүнээс хойш хөдөлмөрийн харилцааны асуудлуудыг Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль (The Labour Safety Act 1958), Ээлжийн амралтын тухай хууль (The Annual Holidays Act 1973), Ажлын цагийн тухай хууль (The Hours of Work Act 1996), Сургалтын чөлөөний тухай хууль (The Study Leave Act 1979), Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш байдлын тухай хууль (The Act on Equality between Men and Women 1986) зэрэг тусдаа хуулиар зохицуулдаг.¹⁴⁷

Тэтгэврийн нас

Европын холбооны гишүүн улс орнуудад тэтгэврийн насыг 65 насаар тогтоосон байдаг боловч олон улс орнууд 2020- 2030 он хүртэл тэтгэврийн насыг 67 нас болгож нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд Финланд Улсын Хөдөлмөрийн гэрээний тухай хуульд “Ажил олгогч болон ажилтан хөдөлмөрийн харилцааг үргэлжлүүлэхээр тохиролцоогүй тохиолдолд тухайн ажилтан тэтгэврийн насанд хүрсэн үед ажилтанд мэдэгдэх ажиллагаа хийлгүйгээр тэтгэвэрт гаргаж болно” гэж заасан байдаг.¹⁴⁸

¹⁴⁷ National Labour Law Profile: Republic of Finland

¹⁴⁸ Retirement Ages: <https://www.etk.fi/en/work-and-pensions-abroad/international-comparisons/retirement-ages/>

Финланд, Кипр, Дани, Словак, Грек, Итали, Нидерланд, Португал зэрэг орнууд тэтгэврийн насыг хүний дундаж насжилттай уялдуулах бодлого баримталж байна. Зарим улс оронд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэтгэврийн насыг ялгамжтай байдлаар тодорхойлсон байдаг. Түүнчлэн зарим улс орнуудад нийгмийн даатгал төлсөн хугацаа нь урт тохиолдолд тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэрт гарах боломжтой бөгөөд энэ тохиолдолд тэтгэврийн хэмжээ буурдаггүй.

Ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ

Ахмад насны хөдөлмөр эрхлэгчдийн хороо нь ахмад насны хөдөлмөр эрхлэгчдийн Финландын үндэсний хөтөлбөрийг танилцуулсан. Энэхүү хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхээр Засгийн газраас танилцуулсан бөгөөд уг хөтөлбөрийг Засгийн газрын гол гурван яам болох Хөдөлмөрийн яам¹⁴⁹, Боловсролын яам¹⁵⁰ болон Нийгэм хамгаалал, эрүүл мэндийн яам¹⁵¹ хэрэгжүүлж байсан.

Энэхүү хөтөлбөрийг 45-64 насны иргэдийн технологийн өөрчлөлт, ажлын байрны эрэлт хэрэгцээнд нийцэж ажиллахад нь дэмжлэг үзүүлэх, ур чадвар олгох, хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах боломж олгох, ахмад насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгэм, соёлын хөгжил дэвшлээс хоцрохгүй байх, гадуурхалтад өртөхөөс сэргийлэх, хугацаанаас өмнө тэтгэвэрт гарах эрсдэлээс сэргийлэх зорилгоор 1998-2002 он хүртэл 4 жилийн хугацаанд хэрэгжүүлсэн.

Түүнчлэн хөтөлбөрийн хүрээнд зургаан зорилгыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон. Үүнд:

- Ахмад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх;
- Тэтгэврийн дундаж насыг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээнд ахмад настны хувь хэмжээг нэмэгдүүлэх;
- Ахмад ажилтнуудын хөдөлмөрийн чадварыг хадгалах, хөдөлмөрийн чадварыг нь нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Хагас цагийн тэтгэвэр (part-time pension) болон уян хатан цагийн системийг бүрдүүлэх загварыг туршиж, хэрэгжүүлэх;
- Хүнийг насаар ялгаварлан гадуурхах үзлийг бууруулж, ахмад настай ажилчдад илүү таатай хандах хандлагыг нэмэгдүүлэх.

Ахмад насны хөдөлмөр эрхлэгчдийн Финландын үндэсний хөтөлбөр нь 4 жилийн хугацаанд хэрэгжиж дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

¹⁴⁹ The Ministry of Labour

¹⁵⁰ The Ministry of Education

¹⁵¹ The Ministry for Social Affairs and Health

- Тэтгэврийн нас өссөн;
- Хөдөлмөрийн зах зээл дээрх ахмад ажилчдын оролцоо нэмэгдсэн;
- Хагас цагийн тэтгэвэр авах иргэдийн сонирхол нэмэгдсэн;
- Ахмад ажилчдыг дэмжих хөтөлбөрийн талаарх мэдээлэл иргэдэд нээлттэй болсон;
- Тэтгэврийн нас нэмэгдсэнээр хөдөлмөрийн зах зээл дээрх ажилчдын тоо 1998 онд 2.522.402 байсан бол 2002 онд 2.623.421 болж өссөн;
- 55 наснаас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин нэмэгдсэн.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

АНУ-д тэтгэврийн дундаж нас эрэгтэй 65, эмэгтэй 62 байна. 2023 оны байдлаар 65-аас дээш насны 58 сая иргэн байгаагаас 11 сая нь хөдөлмөр эрхэлж байна. Үүний 62% нь бүтэн цагаар (долоо хоногийн 35 болон түүнээс илүү цаг) ажилладаг байна. 50.15 сая өндөр настан Нийгмийн даатгалаас тэтгэвэр авч байна. 2060 он гэхэд тус улсын 65-аас дээш насны иргэд 95 саяд хүрнэ гэсэн тооцоолол хийгджээ.¹⁵²

Дундаж наслалт нэмэгдэж байгаа, иргэд тэтгэврийн хуримтлал үүсгээгүй, иргэдийн хувийн хуримтлал багассан, нийгмийн даатгалаас бүтэн тэтгэвэр авах нас нь болоогүй болон тус тэтгэвэр нь амьжиргааны зардалд хүрэлцээгүй зэрэг олон шалтгааны улмаас ахмад настнууд тэтгэврийн насанд хүрсэн хэдий ч цааш үргэлжлүүлэн ажиллах шаардлага үүсдэг байна. 1980 онд дундаж наслалт 73.7 байсан бол 2022 оны байдлаар 77.5 болж өссөн. Үүнтэй зэрэгцээд тэтгэвэр тогтоолгон, нийгмийн даатгалаас бүтэн тэтгэвэр авах нас мөн нэмэгджээ. 1943-1954 оны хооронд төрсөн иргэд 66 насандаа тэтгэврээ тогтоолгох боломжтой бол 1960 оноос хойш төрсөн иргэд 67 насандаа тэтгэврээ тогтоолгох эрх үүсэхээр болжээ. Ахмад ажилтан өөрөө хүсвэл 62 нас хүрээд тэтгэврээ тогтоолгох эрхтэй хэдий ч нийгмийн даатгалаас хүртэх тэтгэврийн хэмжээ багаар тооцогдоно.¹⁵³

АНУ-д ахмад, тэтгэврийн насны иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах төрийн бодлогуудыг хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд “Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль” (The Age Discrimination in Employment Act 1967)¹⁵⁴, Нийгмийн хамгааллын тухай хууль (The Social Security Act) болон холбогдох бусад хууль тогтоомжоор ахмад настнуудын хөдөлмөр эрхлэх эрхийг хамгаалж байна.

¹⁵² <https://www.census.gov/library/stories/2018/03/graying-america.html>

¹⁵³ <https://www.ssa.gov/pubs/EN-05-10035.pdf>

¹⁵⁴ <https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2011-title29/html/USCODE-2011-title29-chap14.htm>

Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үүднээс албадан тэтгэвэрт гаргах байдлыг халж, “Ахмад настнуудын олон нийтэд тустай ажил, үйлчилгээ эрхлэхийг дэмжих хөтөлбөр” (The Senior Community Service Employment Program)¹⁵⁵ зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Төрийн албаны ахмад ажилтнуудын хувьд “Үе шаттайгаар тэтгэвэрт гарах хөтөлбөр” (The Phased Federal Retirement Program)-т хамрагдах боломжтой бөгөөд ингэснээр ахмад ажилтнууд хагас цагаар ажиллан, шинэ залуу ажилтнуудыг дагалдуулан ажиллаж, өөрийн мэдлэг чадвар, туршлагаасаа зааж, сургах боломжийг олгосон байна.

“Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль”

Нэгдсэн Улсын код Дугаар 29-Хөдөлмөр, Бүлэг 14 - Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль (621-634 хэсэг)-ийг 1967 онд баталсан байна. Тус хуулиар 40-өөс дээш насны иргэдийн хөдөлмөрлөх бүхий л нөхцөлд буюу ажилд авах, ажлаас халах, тушаал дэвших, ажлаас халагдсаны нөхөн олговор олгох, тэтгэмж олгох, даалгавар гүйцэтгүүлэх, сургалтад хамруулах зэргээс тухайн ажилтныг насны байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно гэж заажээ. Мөн настай холбоотой зар сурталчилгааг хориглодог байна.

Ахмад ажилтанг насны байдлаар нь гадуурхахыг хориглосон байна. Гадуурхалд, хүний настай холбоотой үг хэллэгээр дайрч доромжлох зэрэг үйлдлүүдийг багтааж үзнэ. Ажилтанг байнга доромжлох, хүнд байдалд оруулах, ажлын дайсагнасан, таагүй орчинг бий болгох, ахмад ажилтанг үндэслэлгүйгээр албан тушаал бууруулах, ажлаас халах зэрэг шийдвэр гаргах нь хууль бус юм. Гадуурхан дарамталж буй этгээд нь хохирогчийн удирдах ажилтан, хамтран ажиллагч, эсхүл үйлчлүүлэгч байх боломжтой. Тухайн байгууллагаас баримталж буй хөдөлмөр эрхлэлтийн бодлого нь 40 ба түүнээс дээш насны ажилтан болон ажилд орохоор хүсэлт гаргагчдад тухайн хүний наснаас хамааран ямар нэгэн үндэслэлгүйгээр сөрөг нөлөө үзүүлэхээр бол хууль бус гэж үзнэ.

Аливаа хүн өөрийн наснаас хамааран хөдөлмөр эрхлэхтэй холбоотой ямар нэг гадуурхалд өртсөн тохиолдолд гомдол гаргах эрхтэй бөгөөд Хөдөлмөрийн яамны харьяа Тэгш хөдөлмөр эрхлэлтийн комисс (Equal Employment Opportunity Commission)¹⁵⁶ нь асуудлыг шударгаар шийдвэрлэхэд хяналт тавьж ажиллана.

Ажил олгогч, Хөдөлмөрийн агентлаг болон Хөдөлмөрийн байгууллагуудад насаар ялгаварлан гадуурхах явдлыг дараах байдлаар хоригложээ.

¹⁵⁵ <https://www.dol.gov/agencies/eta/seniors>

¹⁵⁶ <https://www.eeoc.gov/overview>

623-р хэсэг. Насаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай**(а) Ажил олгогчийн хувьд**

Дараах тохиолдлыг хууль бус гэж үзнэ:

1. наснаас нь хамааран аливаа хүнийг ажилд авахаас татгалзах, эсхүл ажлаас халах, нөхөн олговор болон ажиллах нөхцөлөөр ялгаварлан гадуурхах;
2. наснаас нь хамааран аливаа хүний хөдөлмөр эрхлэх боломжийг нь хязгаарлах, тусгаарлах, ангилах, ажилтныг нь хувьд түүний байр суурьт сөргөөр нөлөөлөх;
3. наснаас нь хамааран аливаа ажилтны цалингийн хэмжээг бууруулах.

(б) Хөдөлмөрийн агентлагийн хувьд

Хөдөлмөрийн агентлаг нь аливаа хүнийг насаар нь ялгаварлан гадуурхах, ажилд зуучлахаас татгалзах, эсхүл насаар нь ангилан ажил санал болгох нь хууль бус юм.

(с) Хөдөлмөрийн байгууллагын хувьд

Дараах тохиолдлыг хууль бус гэж үзнэ:

1. аливаа хүнийг наснаас нь хамааран гишүүнчлэлд бүртгэхээс татгалзах, эсхүл гишүүнчлэлээс хасах;
2. наснаас нь хамааран гишүүдээ хязгаарлах, тусгаарлах, ангилах болон аливаа хүний наснаас хамааран ажилд зуучлахаас татгалзах, ямар нэгэн байдлаар хөдөлмөр эрхлэх боломжийг нь хаах, эсхүл наснаас нь хамааран ажилтны болон ажил эрэлхийлэгчийн нэр хүндэд халдах, сөргөөр нөлөөлөх зэргийг багтаажээ.

Албадан тэтгэврийг халсан тухай

Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлсээр ирсний дотор 1986 онд (тодорхой, шаардлагатай мэргэжлийг эс тооцон) албадан тэтгэвэр тогтоох байдлыг халсан байна. Ингэснээр 65-аас дээш насны иргэдийн хөдөлмөр эрхлэлт дорвитой хэмжээгээр өсчээ. 1960-1970 оны үед 65 нас хүрсэн иргэдийг албадан тэтгэвэрт гаргаж байсан бол “Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахыг хориглох тухай хууль”-д 1978, 1986 онд нэмэлт, өөрчлөлт оруулснаар 70 наснаас өмнө албадан тэтгэвэрт гаргахыг хориглож, дараа

нь албадан тэтгэвэрт гаргах байдлыг хоригложээ. Одоогийн байдлаар тодорхой насанд хүрснээр тухайн мэргэжлээрээ ажиллан, ажил үүргээ гүйцэтгэхэд бие болон оюуны чадамжийн хувьд хүндрэлтэй тул дараах мэргэжилд тэтгэврийн нас заадаг байна. Үүнд, холбооны хууль сахиулах ажилтнууд, байгаль хамгаалагчид, гал сөнөөгчид 57 насандаа, нисгэгчид 65 наснаас өмнө (өмнө нь 60 байсан), агаарын замын хөдөлгөөний хянагч болон тодорхой төрийн албаны ажилтнууд, тухайлбал, хуульч, шүүгч 56 насандаа тус тус тэтгэвэрт гардаг байна.

Холбооны хэмжээнд ахмад настнуудыг ажлын байраар хангах хөтөлбөр

АНУ-ын Хөдөлмөрийн яамны Хөдөлмөр эрхлэлт, сургалтын захиргаанаас хэрэгжүүлдэг “Ахмад настнуудын олон нийтэд үйлчилгээ үзүүлэх ажил эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” нь ахмад настнуудад зориулсан олон нийтэд туслах ажлын байран дээр дадлагажуулах хөтөлбөр юм. “Ахмад настан Америк иргэдийн тухай хууль”-аар зөвшөөрсний дагуу тус хөтөлбөр нь орлого багатай, ажилгүй ахмад настнуудыг сургалтанд хамруулдаг байна. Хөтөлбөрт хамрагдсан ахмад настнууд Америкийн Хөдөлмөрийн төвүүдээр дамжуулан ажилд орох боломжтой байна. Хөтөлбөрт хамрагдагсад нь сургууль, эмнэлэг, өдөр өнжүүлэх төв болон ахмад настнуудыг асрах төв зэрэг ашгийн бус олон нийтийн байгууллагуудад үйлчилгээний олон төрлийн үйл ажиллагаанд ажлын байран дээр дадлагажин, туршлага хуримтлуулдаг байна. Хөтөлбөрөөр 40 гаруй сая нийтэд туслах үйлчилгээний ажлын цагийг төрийн, ашгийн бус байгууллагуудад шаардлагатай ажил, үйлчилгээ үзүүлэхэд зориулан Засгийн газраас санхүүжүүлдэг ажээ. Оролцогчид долоо хоногт дунджаар 20 цаг ажилладаг бөгөөд холбооны болон муж, орон нутгийн хөдөлмөрийн хөлсний хамгийн доод ангиллын дээд шатлалаар цалинжуулдаг байна. Оролцогчид нь 55 нас хүрсэн, ажилгүй, өрхийн орлого нь холбооны ядуурлын түвшингийн 125%-аас ихгүй байх шаардлага тавигддаг байна. Хөтөлбөрт ахмад дайчид, тэдгээрийн эхнэр, нөхөр, түүнчлэн 65-аас дээш настай болон хөгжлийн бэрхшээлтэй, бичиг үсэггүй, эсхүл Англи хэлний мэдлэг тааруу, хөдөө орон нутагт оршин суудаг, орон гэргүй болон орон гэргүй болох эрсдэлтэй, ажилд орох магадлал багатай болон Америкийн Хөдөлмөрийн төвүүдээр дамжуулан ажил хайсан ч орж чадаагүй иргэдийг нэн тэргүүнд сонгон, сургаж дадлагажуулдаг байна. Холбооны агентлагууд болон үндэсний, ашгийн бус 19 байгууллага улсын төсвөөс татаас аван ахмад настнуудыг дадлагажуулан ажиллуулж байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр нийгмийн эмзэг бүлгийн нэг хэсэг болсон ахмад настнуудыг эдийн засгийн хувьд дэмжихийн сацуу нийгмийн харилцаанд эргэн оруулснаар тэдгээрийн эрүүл мэндийн хувьд ч нааштай үр дүн гарсан байна. Хөтөлбөрийн үндсэн зорилго нь ахмад настнуудыг улсын төсвөөс санхүүжилт авдаггүй байгууллагуудад зуучлан ажилд оруулах явдал юм.

Үе шаттайгаар тэтгэвэрт гарах хөтөлбөр

Ахмад ажилтнууд тэтгэврийн нас дөхөхөөр илүү чөлөөтэй, уян хатан нөхцөлтэйгөөр, хагас цагаар буюу долоо хоногт 35-аас доош цаг ажиллах сонирхолтой байдаг байна. Зарим хувийн байгууллагад ажилтантайгаа гэрээ байгуулсны үндсэн дээр энэ нь хэрэгждэг бол Холбооны (төрийн албаны-federal employees) ахмадажилтан, албанхаагчдыг тухайнажилтны хүсэлтээр үе шаттайгаар тэтгэвэрт гаргах буюу тодорхой хугацаанд хагас цагаар ажиллуулахтай холбоотой асуудлыг Нэгдсэн Улсын код Дугаар 5 - Төрийн байгууллага болон ажилтнууд, Бүлэг 83 – Тэтгэвэр, 8336а – Үе шаттайгаар тэтгэвэрт гарах хэсгээр зохицуулж байна. Нэг талаар ахмад ажилтнуудыг тэтгэврийн амьдралд дасгах, нөгөө талаар тэдний туршлага, мэдлэг чадварыг шинэ, залуу ажилтнуудад өвлүүлэх, дагалдуулан сургах, дадлагажуулах зорилготой үе шаттайгаар тэтгэвэрт гаргах үйл ажиллагааг 2014 оноос төрийн байгууллагын ахмад ажилтнуудад хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ нь ажилтны хүсэлтээр, байгууллага болон ажилтны хамтын зөвшилцөл дээр хэрэгжих боломжтой. Ингэхдээ ажилтан тухайн албан байгууллагадаа 3-аас доошгүй жилийн хугацаанд тогтвор суурьшилтай ажилласан байх шаардлагатай.

Үе шаттайгаар тэтгэвэрт гарах гэдэг нь ахмад ажилтан өөрийн албан тушаалын зарим чиг үүргээс чөлөөлөгдөж, тухайн албан тушаалынхаа дараагийн хүнийг бэлтгэх, тэдэнд зөвлөгөө өгөх, мэдлэг, туршлагаасаа хуваалцах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Ингэхдээ ахмад ажилтнууд ажлын цагийн 20%-ийг зөвлөх, дадлагажуулах үйл ажиллагаанд зориулах үүрэгтэй. Энэ хугацаандаа хагас цагийн цалингаа тооцуулж авахын сацуу, тэтгэврээ хэсэгчлэн авдаг байна. Бүрэн тэтгэврээ тогтоолгоход тухайн ажилтныг бүтэн цагаар ажилласанд тооцож, тэтгэврийг тогтооно. Ахмад ажилтан өөрийн хүсэлтээр хагас цагаар ажиллахаа больж, бүтэн цагаар ажиллах боломжтой бөгөөд энэ тохиолдолд дахин Үе шаттайгаар тэтгэвэрт гарах хөтөлбөрт хамрагдах боломжгүй.

Тэтгэвэрт гарах нас заасан тодорхой мэргэжлийн ажилтнууд, хөгжлийн бэрхшээлтэй ахмад ажилтнууд, тэтгэврээ тогтоолгосон ч дахин ажиллаж буй ажилтнууд, тус хөтөлбөрт хамрагдаж байгаад буцаад бүтэн цагаар ажиллаж байгаа ажилтнууд нь Үе шаттайгаар тэтгэвэрт гарах хөтөлбөрт хамрагдах боломжгүй байна.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсад 2023 ны байдлаар 353.2 мянган хүн өндөр насны тэтгэвэр, 19.7 мянган хүн цэргийн тэтгэвэр авч байна.

Хууль эрх зүйн орчин

Ахмад настны хөдөлмөрийн харилцааны асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд¹⁵⁷ зааснаас эхлэн авч үзэх шаардлагатай болно. Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 16.4-т “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй”, 16.5-д “өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй”...гэсэн нь Үндсэн хуулиас салбарлан гарсан хуулиудад ахмад настны талаар баримтлах суурь зарчмууд болж ирсэн.

Ахмад настны тухай¹⁵⁸

Энэ хуулийн зорилт нь ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, нийгмийн үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үүргийг тодорхойлж, тэдгээрийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино. Ахмад настны хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ. Мөн энэхүү хуулиар ахмад настны эрх, ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, ахмад настны амьжиргааг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулахад төрөөс үзүүлэх дэмжлэг зэргийг нарийвчлан зааж өгсөн.

Ахмад настны тухай хуульд заасан хэрэгждэггүй, зөрчилтэй байгаа заалт нь ахмадын сангийн тухай асуудал байна. Учир нь төрийн байгууллага ямарваа нэг сан байгуулахыг төсвийн тухай хуулиар зөвшөөрөхгүй бөгөөд, захиран зарцуулах эрх байгууллагын удирдлагад олгогддоггүй.

Ахмад настны тухай хуулийн 3.1-т эрэгтэй 60, эмэгтэй 55 настай хүмүүсийг ахмад настан гээд хөдөлмөр эрхлэх эрхийг холбогдох хуулиар зохицуулсан байна. Тэдний хөдөлмөр эрхлэх эрхийг Хөдөлмөрийн тухай хуулиар баталгаажуулжээ.

¹⁵⁷ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367> Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

¹⁵⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12453> Ахмад настны тухай, 2017 он.

Хөдөлмөрийн тухай хууль¹⁵⁹

Үндсэн хуулиас салбарлан ахмад настантай холбогдох хамгийн гол хууль нь Хөдөлмөрийн тухай хууль юм. Учир нь ахмад настан хэмээх ойлголт нь хүн хөдөлмөрлөх, хуульд заасан насанд хүрсний дараа хөдөлмөрлөх хугацаандаа төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ, хугацаанаас хамааран нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авахтай холбоотой нийт процесстой шууд уялддаг юм. Хөдөлмөрийн эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актууд энэ хуулийн 2.5-д зааснаас бусад тохиолдолд дараах эрэмбээр үйлчилж байна. Үүнд:

- энэ хууль;
- Монгол Улсын бусад хууль;
- захиргааны хэм хэмжээний акт;
- салбар, салбар дундын хамтын хэлэлцээр;
- хамтын гэрээ;
- хөдөлмөрийн гэрээ;
- аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ.

Үүнээс гадна тус хуулийн 145 дугаар зүйлд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн тухай заалтуудыг оруулж өгсөн байдаг. Үүнд:

- 145.1. Ахмад настан, тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж болно;
- 145.2. Ажилтан өндөр насны тэтгэвэр авч байгаа нь түүний цалин хөлсийг бууруулах болон энэ хуульд заасан бусад эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй;
- 145.3. Ажил олгогч ахмад настны хүсэлтээр ажлын цагийг богиносгож, бүтэн бус цагаар ажиллуулж, эрүүл мэндэд нь харшлахгүй өөр ажилд шилжүүлэх асуудлыг хөдөлмөрийн дотоод журмаар зохицуулна хэмээн заажээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль¹⁶⁰

Энэ хууль нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгч, нийгмийн даатгалын байгууллага болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээдэд хамаарч байгаа бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн зардлын төлбөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал олгох, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх харилцааг зохицуулж байна.

¹⁵⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751> Хөдөлмөрийн тухай хууль, 2021 он.

¹⁶⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148379551> Нийгмийн даатгалын ерөнхий хууль, 2023 он.

Тус хуулийн 18 дугаар зүйлд зааснаар нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг заасан бөгөөд ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ 10.5-12.5 хувь, даатгуулагчийн төлөх шимтгэлийн хэмжээ 9.5 хувь байна.

Хүснэгт. Ажил олгогч болон даатгуулагчийн нийгмийн даатгал төлөх хувь хэмжээ

№	Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/	Даатгуулагчийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/
1	Тэтгэврийн даатгал	8.5	8.5
2	Тэтгэмжийн даатгал	1	0.8
3	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал	0.5, 1.5, 2.5	-
4	Ажилгүйдлийн даатгал	0.5	0.2
	Шимтгэлийн дүн	10.5, 11.5, 12.5	9.5

Мөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай¹⁶¹, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай¹⁶², Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай¹⁶³ зэрэг хуулиуд тус хуулийг дагаж үйлчилж байна.

Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай¹⁶⁴

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Ардын болон Гавьяат цолтон, Төрийн шагналт, Төрийн соёрхолт, Ахмад дайчин, Улсын ударник, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Монгол Улсын Үндсэн хуулийг хэлэлцэж, баталсан /1990-1992 он/ Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай¹⁶⁵

¹⁶¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148505951> Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, 2023 он.

¹⁶² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148705641> Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, 2023 он.

¹⁶³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148638921> Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, 2023 он.

¹⁶⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12462> Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хууль, 2017 он.

¹⁶⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=576> Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, 1994 он.

Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаанд цэргийн жинхэнэ алба болон тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаасан нийт албан хаагчдад хамаардаг. Энэ хуулиар 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй, 20-оос доошгүй жил алба хаасан эмэгтэй цэргийн алба хаагчийн иргэний байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан нэг жилийг зургаан сараар бодон цэргийн байгууллагад ажилласан хугацаанд оруулан тооцож Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоодог.

Цэргийн алба хаагч нь нас харгалзахгүйгээр ажилласан жилээс хамааран тэтгэвэр тогтоолгож байгаагаас үүдэлтэйгээр 40 орчим насны тэтгэвэр авагчид олон байна.

Нийгмийн халамжийн тухай¹⁶⁶

Нийгмийн халамжийн тэтгэврийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно. Үүнд: Эрэгтэй 60, эмэгтэй 55 болон түүнээс дээш настай иргэн, тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэд багтдаг. Үүнээс гадна “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” байдаг бөгөөд үүнд мөн ахмад настнууд хамрагдана.

УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд **“Алсын хараа-2050”** Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийг баталсан. Энэ урт хугацааны бодлогын баримт бичигт ахмад настны асуудлыг, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн талаар дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

“Амьдралын чанар ба дундаж давхарга” гэсэн 3-р бүлгийн Зорилт 3.1-т “Амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлж, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог бэхжүүлнэ” гэсний хүрээнд: II үе шат (2031-2040)-ны 5-д “Ахмад настанд урт хугацааны тусламж, үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулах”... гэсэн асуудлыг тусгасан байна.

Мөн **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа**”-нд ахмад настны талаар илүү дэлгэрүүлж тусгасан байна. Үүнд:

¹⁶⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=393> Нийгмийн халамжийн тухай хууль, 2012 он.

2.3.3. Монгол хүний хөгжлийн цогц судалгаанд үндэслэн төрөөс хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөдөлмөрийн болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг тэгш хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын бодлого зохицуулалтыг сайжруулна.

2.6.16. Хүн амын бүлгүүд, тухайлбал эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.

3.1.3. Бүх ахмад настанд суурь тэтгэвэр олгоно.

3.1.13. Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.

3.1.18. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.

7.3.11. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.

7.4.5. Яаралтай тусламжийн дуудлага, мэдээллийг хүлээн авах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад иргэнд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй болгож, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, эмнэлгийн түргэн тусламжийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагааны шуурхай байдлыг хангана.

9.1.7. Насан туршийн боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж насанд хүрэгчид, ахмад настанд зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн түншлэлийг бэхжүүлнэ... гэсэн үйл ажиллагаануудыг тусгасан байна.

Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр¹⁶⁷

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс 2021 онд “**Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр**”-ийг баталсан. Хөтөлбөрийн зорилго нь ахмад мэргэжилтнүүдийн хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, мэдээллийн сан үүсгэн, тэдний мэдлэг, ажлын туршлагыг хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж, орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх явдал юм.

Энэхүү хөтөлбөр хэрэгжүүлэгч субъект нь Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн хэлтсүүдээр дамжуулан гүйцэтгэж байна. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст гаргасан мэдээллийн санд бүртгүүлсэн тэтгэврийн насны ахлах мэргэжилтнүүд

¹⁶⁷ <https://mlsp.gov.mn/eng/content/detail/1312> Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, 2021 он.

хамрагддаг. Үүнээс гадна ахмадын төрийн бус байгууллага нь зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр ажиллаж болно. Ахмад мэргэжилтний зөвлөн туслах үйл ажиллагаа шаардлагатай байгаа төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэнд болон хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд зөвлөх үйлчилгээ авах хэрэгцээ, шаардлага, ажлын цар хүрээг тодорхойлсон төслийг аймаг, дүүргийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэст ирүүлдэг. Үүний дагуу төсөлд хамрагдан, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ахмадад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын баталсан жишиг хэмжээгээр ажилласан цагийн урамшууллыг тооцож олгох бөгөөд, нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар журамласан байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Япон Улс

- Japan population <https://www.worldometers.info/world-population/japan-population/>
- Pensions at a Glance 2023 <https://www.oecd.org/els/public-pensions/PAG2023-country-profile-Japan.pdf>
- Act on Stabilization of Employment of Eldery Persons <https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/2621/en>
- Civil Service Pension Arrangements in Japan <https://cis.ier.hit-u.ac.jp/Japanese/society/conference1101/sakamoto-paper.pdf>
- Pensions at a Glance 2023 <https://www.oecd.org/els/public-pensions/PAG2023-country-profile-Japan.pdf>
- Re-Employment after retirement age <https://arqis.jp/knowledge/arqis-newsletter-re-employment-after-retirement-age-march-2021/>

Өмнөд Солонгос Улс

- The Life and Work in the Aged Society, Korean labor Force Development Institute for the aged, 2024 Spring https://www.kordi.or.kr/upload/attach/10/501610_202403291319028710.pdf
- Ажиллах ёстой ахмадууд-Ахмад настнуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлого нь тэднийг тэтгэвэрт гарахад нь хөнгөвчлөх үү? Нийтлэл <https://www.newspost.kr/news/articleView.html?idxno=110441>
- Хэчнээн солонгос хүн тэтгэвэртээ гарахаар бэлтгэж байна вэ? Нийтлэл <https://www.newspost.kr/news/articleView.html?idxno=112399>
- “Ахмад настны эдийн засгийн үйл ажиллагааны статистик” болон “Хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийн тайлан”-ийн талаар <https://www.newspost.kr/news/articleView.html?idxno=110270>
- Өмнөд Солонгосын ахмад настны хүний нөөцийн хөгжлийн институт-Korean labor force development institute for the aged https://kordi.or.kr/upload/attach/08/357308_202004161121559150.pdf
- Өмнөд Солонгосын ахмад настны хүний нөөцийн хөгжлийн институтийн үйл ажиллагааны танилцуулга https://www.kordi.or.kr/upload/attach/74/437374_202205301349031710.pdf
- Raising employment and enhancing job quality in the face of rapid ageing, OECD, 2020 <https://www.oecd-ilibrary.org/sites/374630b6-en/index.html?itemId=/content/component/374630b6-en>
- South Korea’s senior employment program for those over the age of 65 years, 2023 <https://www.sdg16.plus/policies/south-koreas-senior-employment-program-for-those-over-the-age-of-65-years/>
- Ахмад настныг хөдөлмөр эрхлэхэд насаар нь ялгаварлан

гадуурхахыг хориглох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
<https://www.law.go.kr/lsInfoP.do?lsId=000121&ancYnChk=0#0000>

- Ахмад настнуудын ажлын байр, нийгмийн үйл ажиллагааг дэмжих 3-р цогц төлөвлөгөө <https://www.mohw.go.kr/>
- Төрийн албаны тухай хууль <https://www.law.go.kr/LSW/lsInfoP.do?lsId=001719&ancYnChk=0#0000>
- Төрийн албан хаагчийн тэтгэврийн тухай хууль <https://www.law.go.kr/>
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль <https://www.law.go.kr/%>

Эстони Улс

- <https://www.h2020-pillars.eu/sites/default/files/toolkit/Estonia%20-%20Case%20Study.pdf>
- https://population-europe.eu/files/documents/dp9_webversion.pdf
- <https://raulpage.org/koolitus/elderly.html>
- https://www.europarl.europa.eu/RegData/etudes/STUD/2017/602036/IPOL_STU%282017%29602036_EN.pdf

Финланд Улс

- <https://ageing-better.org.uk/finland-national-programme-ageing-workers>
- <https://extranet.who.int/agefriendlyworld/network/vaasa/>
- <https://www.oecd-ilibrary.org/>
- Финланд Улсын Үндсэн хууль The Constitution of Finland https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990731_20180817.pdf
- Хөдөлмөрийн гэрээний тухай хууль The Employment Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2001/en20010055_20180597.pdf
- Retirement Ages <https://www.etk.fi/en/work-and-pensions-abroad/international-comparisons/retirement-ages/>
- Хөдөлмөрийн цагийн тухай хууль: The Working Time Act https://www.finlex.fi/en/laki/kaannokset/2019/en20190872_20191405.pdf
- Discussion Paper: Ageing Workforce, Social Cohesion and Sustainable Development: Political Challenges within the Baltic Sea Region

Америкийн Нэгдсэн Улс

- The growth of the older workforce
- <https://www.pewresearch.org/social-trends/2023/12/14/the-growth-of-the-older-workforce/>
- Understanding the Aging Workforce <https://www.ncbi.nlm.nih.gov/books/NBK588541/>
- The phased retirement programm

- <https://www.federalregister.gov/documents/2014/08/08/2014-18681/phased-retirement>
- What is the Social Security Retirement Age?
- <https://www.nasi.org/learn/social-security/retirement-age/>
- US code Title 5-Government organization and employees
- <https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2012-title5/html/USCODE-2012-title5.htm>
- U.S. Equal Employment Opportunity Commission <https://www.eeoc.gov/overview>
- Age Discrimination in Employment Act <https://www.govinfo.gov/content/pkg/USCODE-2011-title29/html/USCODE-2011-title29-chap14.htm>
- The Average Age of Retirement in the US <https://www.forbes.com/advisor/retirement/average-retirement-age/>

БҮЛЭГ III

ЭРХ ЗҮЙ, ТӨРИЙН БАЙГУУЛАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧИЙН ЭРХИЙГ ХАНГАХ НӨХӨН ТӨЛБӨР
ОЛГОХ ОЛОН УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, Ц.Ариунаа, Э.Дашзэвэ,
П.Уранчимэг, Э.Билгүүн*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

1.НҮБ-ын Үндсэн зарчим, удирдамжийн тойм

- 1.1.Олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн хууль тогтоомж
- 1.2.Үндсэн зарчим, удирдамжийн хамрах хүрээ: ноцтой зөрчил ба түүний хохирогчид
- 1.3.Хохирогчдын эрх
- 1.4.Улс орнуудын үүрэг

2.Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах, тэдэнд нөхөн төлбөр олгох гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

- 2.1.Канад Улс
- 2.2.Өмнөд Солонгос Улс
- 2.3.Филиппин Улс
- 2.4.Энэтхэг Улс

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын дэд даргын захиалгаар “Гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, хамгаалах олон улсын болон үндэсний тогтолцоо, механизм” сэдэвт судалгааг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

- НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2005 оны 60/147 дугаар тогтоолоор батлагдсан “Олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ноцтой зөрчлийн улмаас хохирогчийн хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах эрхийн талаарх үндсэн зарчим, удирдамж”-ийн талаар тойм мэдээлэл бэлтгэх;
- гадаадын зарим орны гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, хамгаалах үндэсний тогтолцоо, механизм, түүний эрх зүйн орчныг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд захиалагчийн хүсэлтийн дагуу НҮБ-ын “Олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ноцтой зөрчлийн улмаас хохирогчийн хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах эрхийн талаарх үндсэн зарчим, удирдамж”, түүнийг хэрэгжүүлэх талаарх Канад, Өмнөд Солонгос, Филиппин, Энэтхэг зэрэг улсуудын гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, хамгаалах үндэсний тогтолцоо, механизм, эрх зүйн зохицуулалтын мэдээллийг тэдгээр орнуудын хууль, эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судалсан болно.

Судалгааны бүтэц:

Судалгаа нь хураангуй болон дэлгэрэнгүй хэсэгтэй. Судалгааны дэлгэрэнгүй хэсэг нь хоёр бүлэгтэй: *Нэгдүгээр бүлэгт*, НҮБ-ын “Олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ноцтой зөрчлийн улмаас хохирогчийн хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр авах эрхийн талаарх үндсэн зарчим, удирдамж”-ийн хүрээнд хүний эрх, хүмүүнлэгийн эсрэг гэмт хэрэг, хохирогч, тэдгээрийн эрх, эрхийг хангах, хамгаалах арга механизмын талаар; *Хоёрдугаар бүлэгт*, гадаадын зарим орны гэмт хэргийн хохирогчийн эрхийг хангах, хамгаалах үндэсний тогтолцоо, механизм, түүний эрх зүйн орчны талаарх мэдээллийг тус тус судалсан болно.

Түлхүүр үг: *гэмт хэрэг, хохирогч, хохирогчийн эрх, хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр авах эрх;*

Key words: *offence, victim, victims’ rights, right to a remedy and reparation, international human rights law, human rights protection system, international humanitarian law, Basic Principles and Guidelines, right to legal protection, remedies, victims of human rights violation, reparation, restitution, compensation, rehabilitation, satisfaction, guarantees of non-repetition.*

Ключевые слова: *международное право прав человека, система защиты прав человека, международное гуманитарное право, Основные принципы и руководящие положения, право на правовую защиту, средства правовой защиты, возмещение ущерба, жертвы нарушения прав человека, реституция, компенсация, реабилитация, сатисфакция, гарантии неповторения случившегося.*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейгаас 2005 оны 12 дугаар сарын 16-ны өдөр **“Олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ноцтой зөрчлийн хохирогчдын хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх эрхийн үндсэн зарчим, удирдамж”** (цаашид “Үндсэн зарчим, удирдамж”)-ийг баталсан. Үүнийг баталсан гол зорилго бол олон улсын хүний эрхийн болон олон улсын хүмүүнлэгийн баримт бичгүүдэд өөр өөрөөр тусгасан байдаг гэм хорыг арилгах, нөхөн сэргээх эрхийн талаарх ойлголтыг нэгтгэх байсан.

Үндсэн зарчим, удирдамж нь дараах зорилготой:

- хохирогчийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг болон “нөхөн олговор” авах эрхийг тууштай хэрэгжүүлэх боломж олгох;
- холбогдох нэр томъёог тодорхой болгох;
- бүх улс орнуудад хэрэглэхэд нээлттэй стандартуудыг тусгах;
- хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ нь учруулсан хохирлын хэмжээтэй шууд хамааралтай байх зэрэг болно.

Үндсэн зарчим, удирдамж нь “олон улсын болон дотоодын эрх зүйн шинэ үүрэг хариуцлага үүсгэдэггүй, харин одоо байгаа эрх зүйн үүргийг хэрэгжүүлэх механизм, хэлбэр, журам, арга замыг тодорхойлдог” гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.

Олон улсын хүний эрхийн хууль тогтоомж нь ямар ч үед, өөрөөр хэлбэл, энх тайвны үед ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч үйлчилдэг, харин **олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж** нь гагцхүү зэвсэгт мөргөлдөөний үед л үйлчилдэг. Гэвч энэхүү хоёр нь бие биеэ нөхөж, зарим талаараа давхцаж, харилцан бататгасан байдлаар хэрэгжих ёстой байдаг. Тухайлбал, геноцид буюу төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг зэрэг **ноцтой зөрчлүүдийг** Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нарийвчлан тодорхойлсон.

Үндсэн зарчим, удирдамжийн дагуу **хохирогч** гэдэгт «бие махбодын болон оюун санааны гэмтэл, сэтгэл санааны хохирол, эдийн засгийн хохирол, үндсэн эрх нь ихээхэн хэмжээгээр хохирсон хүмүүс дангаараа буюу хамтдаа хохирсон ... мөн хохирогчийн ойрын гэр бүл, асран хамгаалагчид болон гамшигт нэрвэгдсэн хохирогчдод туслахад, хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд хөндлөнгөөс оролцож хохирол амссан хүмүүс багтана.”

Хохирогч нь олон улсын хууль тогтоомжид заасан үр дүнтэй арга хэмжээг тэгш хүртэх эрхтэй. Мөн хохирогчдын хохирлыг нөхөн төлөх ба энэ нь “зөрчил, учирсан хохирлын хүнд, хөнгөн байдалд тохирсон” байх ёстой бөгөөд “хангалттай, үр дүнтэй, шуурхай нөхөн төлбөр авах” эрхтэй. Бүрэн бөгөөд үр дүнтэйгээр хохирлыг барагдуулахын тулд Үндсэн зарчим, удирдамжид нөхөн сэргээх, нөхөн олговор, сэргээн засах, сэтгэл ханамжтай байх, дахин давтагдахгүй байх баталгаа зэргийг тусгасан байна. Тохиолдол бүрд хувь хүний нөхцөл байдлыг үргэлж харгалзан үзнэ.

Судалгаанд хамрагдсан улс орнуудын хохирогчийн эрхийг хамгаалах, хохирлыг нөхөн төлөхтэй холбоотой зарим онцлог асуудал болон зохицуулалтын талаар тоймлон дурдвал:

Канад Улс 2007 онд гэмт хэргийн хохирогчийн талаар олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах Холбооны Омбудсмений газрыг байгуулжээ. Энэ газар нь шууд хохирогчдод чиглэсэн үйлчилгээ үзүүлэхээс гадна бодлого боловсруулагчид болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчдод хохирогчийн эрэлт хэрэгцээ, сэтгэл зүйн зовнилыг судлах мэдлэг, дадлага эзэмшүүлэх, хохирогчдод сөргөөр нөлөөлж болзошгүй хандлага, тулгамдсан асуудлуудыг тогтоох, тодорхойлох чиглэлээр ажилладаг бөгөөд шаардлагатай гэж үзвэл Омбудсмен нь Холбооны Засгийн газарт зөвлөмж хүргүүлдэг байна. Мөн 2015 онд Хохирогчийн эрхийн тухай хуулийг баталж, энэ хуульд Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэргийн тухай хуульд заасан гэмт хэргийн хохирогчийг хамааруулсан байдаг. Хохирогчийн 4 төрлийн эрхийг хамгаалахаар хуульчилсны нэг нь “хохирлоо барагдуулах” эрх юм.

Хохирогч хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр гаргуулах талаар шүүхийн шийдвэр гаргуулах, мөн иргэний шүүхээр дамжуулан төлөгдөөгүй хохирлыг албадан барагдуулах тухай шүүгчийн захирамж гаргуулах үндсэн эрхтэй. Хохирогчдод хохирлоо нэхэмжлэхэд нь туслах стандарт маягт бөглөх ба хохирогч шүүхэд хохирлын нөлөөллийн мэдэгдэл гаргадаг. Шүүх бүх гэмт хэргийг хянан хэлэлцэхдээ хохирлыг барагдуулах асуудлыг зайлшгүй авч үзсэн байх үүрэгтэй.

Өмнөд Солонгос Улс 2005 оноос хохирогчдын эрхийг хангах, хамгаалах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд хохирогчийг хамгаалах, тэдэнд үзүүлэх тусламжийг өргөжүүлэн ажиллаж байна. Улсын хэмжээнд бүх шатны прокурорын газруудын дэргэд гэмт хэргийн хохирогчийг хамгаалах 58 төв ажиллаж байна. Энэ төвд хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр мэргэшсэн, прокурорын байгууллагад ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүд хохирогчдод болон тэдний

гэр бүлийн гишүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зөвлөгөө өгдөг.

Тус улсад тодорхой төрлийн гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгодог. Нөхөн төлбөр нь гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн төлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй болсон хохирогчид олгох (хөдөлмөрийн чадвар алдалт) нөхөн төлбөр гэсэн 2 төрөлтэй. Мөн хохирогч, эсхүл түүний гэр бүлийн гишүүд нөхөн төлбөр авах тухай өргөдлөө харьяалагдах Гэмт хэргийн хохирлыг барагдуулах хороонд гаргадаг.

Филиппин Улсын Хууль зүйн яамны дэргэд хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон хохирогчдын хохирлыг барагдуулах, нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх зорилгоор 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Нэхэмжлэлийн зөвлөл ажилладаг. Хилс хэргээр хорих ял эдлээд цагаатгагдсан, хууль бусаар хоригдоод суллагдсан, шүүхийн шийдвэрийн дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар баривчлагдсан, эсхүл хүчирхийлэлд өртсөн хохирогчид нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг гаргана. Нэхэмжлэлийн зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хохирогчдод төрийн байгууллагуудаас эрүүл мэнд, боловсролын чиглэлээр мөнгөн бус нөхөн төлбөр олгох боломжтой.

Энэтхэг Улсад хохирогчид нөхөн төлбөр авах эрхтэй, ялангуяа, хүчирхийллийн гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох нь төрийн бодлогоор зохицуулагддаг. Хохирогчид амьдарч байгаа, эсхүл тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн мужийн нөхөн төлбөрийн хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаснаар хохирогч, эсхүл түүний гэр бүлийн гишүүд нь нөхөн төлбөр авах боломжтой болдог. Гэмт хэрэгтэн үйлдэл дээрээ баригдаагүй, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй ч хохирогчдод нөхөн төлбөр төлж болно. Нөхөн төлбөр авах тодорхой нөхцөл, шалгуур байдаг. Тухайлбал, хүчирхийллийн гэмт хэргийн шууд хохирогч, эсхүл түүний амьд үлдсэн гэр бүлийн гишүүн л хохирлын нөхөн төлбөр авах хүсэлт гаргах эрхтэй. Хохирогч шүүхээс зөвлөгөө авах зардлаа нөхөн төлүүлэхийг хүсэж болно. Хохирогч хохирлоо барагдуулахын тулд хэргийн талаар мэдээлж, мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажилласан байх ёстой. Шүүхээс нөхөн төлбөр олгох шийдвэр гарсан тохиолдолд тухайн муж, дүүргийн Хууль зүйн үйлчилгээний газар нөхөн төлбөрийн хэмжээг тогтооно. Уг газар шаардлагатай баримтыг бүрдүүлэн 2 сарын дотор нөхөн төлбөрийг олгодог. Тухайн муж, дүүргийн Хууль зүйн үйлчилгээний газар нь хохирогчийн асуудлыг хөнгөвчлөхийн тулд цагдаагийн байгууллагын яаралтай тусламж, эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээг үзүүлэх захиалга өгч болно.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

ХОХИРОГЧИЙН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ, НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ НЬ: НҮБ-ЫН НӨХӨН ТӨЛБӨР АВАХ ЭРХИЙН ҮНДСЭН ЗАРЧИМ, УДИРДАМЖ БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

1.НҮБ-ын Үндсэн зарчим, удирдамжийн тойм

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейгаас 2005 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “Олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ноцтой зөрчлийн хохирогчдын хохирлыг барагдуулах, нөхөн төлүүлэх эрхийн үндсэн зарчим, удирдамж” (цаашид “Үндсэн зарчим, удирдамж”)-ийг 60/147 тоот тогтоолоор баталсан.¹⁶⁸

Үндсэн зарчим, удирдамжийг баталсан гол зорилго бол олон улсын хүний эрхийн болон олон улсын хүмүүнлэгийн баримт бичгүүдэд өөр өөрөөр тусгасан байдаг гэм хорыг арилгах, нөхөн сэргээх эрхийн талаарх ойлголтыг нэгтгэх явдал байсан.

Үндсэн зарчим, удирдамж нь дараах зорилготой:

- хохирогчийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг болон “нөхөн олговор” авах эрхийг тууштай хэрэгжүүлэх боломж олгох;
- холбогдох нэр томъёог тодорхой болгох;
- бүх улс орнуудад хэрэглэхэд нээлттэй стандартуудыг тусгах;
- хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ нь учруулсан хохирлын хэмжээтэй шууд хамааралтай байх зэрэг болно.

Хохирлыг барагдуулах нь хохирогчийн хохирлыг барагдуулахаас гадна тухайн гэмт этгээдэд хариуцлага тооцох, цаашид төсөөтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх замаар нийтийн ашиг сонирхолд үйлчилдэг. Энэ нь нийгмийн бүх түвшинд хууль дээдлэх ёсыг сахиулдаг шударга ёсны чухал элемент юм.

Уг баримт бичгийн төслийг 1993 оноос хойш 16 жилийн турш хүний эрхийн бие даасан шинжээчид боловсруулсан бөгөөд боловсруулах явцад төсөлд улс орнууд, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагуудын саналыг тусгах боломжийг олгосон урт хугацааны, олон нийтийн оролцоотой зөвлөлдөх үйл явцыг хангаж ажилласан байна. Тиймдээ ч НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Үндсэн зарчим, удирдамжийг батлахдаа

¹⁶⁸ Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation for Victims of Gross Violations of International Human Rights Law and Serious Violations of International Humanitarian Law (Basic Principles and Guidelines). UN General Assembly resolution 60/147 of 16 December 2005.
<https://documents.un.org/doc/undoc/gen/n05/496/42/pdf/n0549642.pdf?token=LZcAWpT43QSo6ixSuq&fe=true>

түүнийг аль болох өргөн хүрээнд түгээх шаардлагатайг онцолсон байна. Олон улсын хүний эрхийн болон олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийг хүндэтгэн хэрэгжүүлэх НҮБ-ын гишүүн бүх улсуудын үүргийг тодорхойлсон 27 зүйл буюу зарчим бүхий энэхүү баримт бичиг нь хүний эрхийн зөрчлийн хохирогчдын хохирлыг барагдуулах, гэм хорыг арилгах, дотоодын хууль эрх зүйн тогтолцоонд шударга ёсонд хүрэх эрхийг анх удаа кодчилсон байна.

Үндсэн зарчим, удирдамж нь “олон улсын болон дотоодын эрх зүйн шинэ үүрэг хариуцлага үүсгэдэггүй, харин одоо байгаа эрх зүйн үүргийг хэрэгжүүлэх механизм, хэлбэр, журам, арга замыг тодорхойлдог” гэдгийг онцлон тэмдэглэсэн байна.

1.1.Олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн хууль тогтоомж¹⁶⁹

Олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн хууль тогтоомж нь түүхэн болон үзэл баримтлалын өөр өөр үндэстэй, хамрах хэм хэмжээний хувьд ялгаатай байдаг боловч хоёулаа бүх хүнийг хамгаалах зорилготой бөгөөд хүн бүрийн амь нас, сайн сайхан, нэр төрийг хүндэтгэх зарчимд суурилдаг. Эрх зүйн үүднээс авч үзвэл, олон улсын хүний эрхийн болон олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж нь олон улсын заншлын эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон олон улсын гэрээнүүд байдаг.

Олон улсын хүний эрхийн хууль тогтоомж нь ямар ч үед, өөрөөр хэлбэл, энх тайвны үед ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч үйлчилдэг, харин олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж нь гагцхүү зэвсэгт мөргөлдөөний үед л үйлчилдэг.

Энх тайван цагт ард түмэндээ хандах хандлагыг зохицуулдаг олон улсын хүний эрхийн хууль тогтоомж нь зэвсэгт мөргөлдөөний үед төрийн үйл ажиллагааг зохицуулдаг олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжоос ялгаатай гэж үздэг ч энэхүү хоёр нь бие биеэ нөхөж, зарим талаараа давхцаж, харилцан бататгасан байдлаар хэрэгжих ёстой байдаг.¹⁷⁰

Олон улсын хүний эрхийн хууль тогтоомж (International human right law)

Төр нь хүний эрхийг хүндэтгэх төдийгүй хүний эрхийг зөрчихөд хүргэж болзошгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх үүрэгтэй. Цаашлаад ямар нэг байдлаар эрх нь зөрчигдсөн хүмүүс эрхээ сэргээх, хохирлоо барагдуулахыг шаардах эрхээр хангах нь төрийн үүрэг болдог.

¹⁶⁹ Международно-правовая защита прав человека в вооруженных конфликтах. Управление Верховного комиссара ООН по правам человека. Нью-Йорк и Женева, 2011 год. www.ohchr.org

¹⁷⁰ IHL and human rights law (29 October 2010). What is the difference between IHL and human rights law? (22 January 2015). International Committee of the Red Cross. www.icrc.org

Иймд хүн бүрийг хараат бус, үр дүнтэй, шударга шүүхээр шийдвэрлүүлэх, хүний эрхийн зөрчлийн баримтыг төрөөс хүлээн зөвшөөрөх, үнэн мөнийг эрэн хайх, зөрчигчдийг хуулийн хариуцлагад татах, хохирогчдод учруулсан хохирлыг барагдуулах зэргээр хангах шаардлагатай.

Хүний эрхийг хангах, хамгаалах хүчин чармайлт нь олон улсын конвенц, гэрээг сахин хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Олон улсын баримт бичгүүдэд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах зэрэг асуудлуудыг шууд тусгах, эсхүл өргөн хүрээнд тайлбарлах замаар тусгагдсан байдаг. Арга хэмжээ авах эрхийг олон улсын хүний эрхийн дараах баримт бичгүүдэд тусгасан байдаг:¹⁷¹

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал (§8) (1948 он)¹⁷²;
- Эдийн засаг, нийгэм, соёлын олон улсын пакт (1966 он)¹⁷³, түүний нэмэлт протокол;
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (§2.3) (1966 он)¹⁷⁴, түүний нэмэлт хоёр протокол.

Нөхөн төлбөр авах эрхийг хүний эрхийн олон улсын дараах конвенцод тусгасан байдаг:¹⁷⁵

- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (§6) (1965 он)¹⁷⁶ (Монгол Улс 1966.05.03-ны өдөр гарын үсэг зурж, 1969.03.31-ний өдөр соёрхон баталсан);
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (§14) (1984 он)¹⁷⁷, түүний нэмэлт протокол;
- Бүх цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенц (§15, 16.9, 18.6, 22.5) (1990 он)¹⁷⁸;
- Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц (§24) (2006 он)¹⁷⁹;
- хүний эрхийн талаарх бүс нутгийн баримт бичгүүд, тухайлбал:

¹⁷¹ Keburiya K.O., Solntsev A.M. The Significance of the 2005 UN Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation. *Moscow Journal of International Law*. 2021;(2):78-98. <https://doi.org/10.24833/0869-0049-2021-2-87-98>

¹⁷² 1948 Universal Declaration of Human Rights (Art. 8). <https://legalinfo.mn/mn/detail/1271>

¹⁷³ 1966 International Covenant on Economic, Social and Cultural Rights.

¹⁷⁴ 1966 International Covenant on Civil and Political Rights (para. 3 of Art. 2).

¹⁷⁵ Keburiya K.O., Solntsev A.M. The Significance of the 2005 UN Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation. *Moscow Journal of International Law*. 2021;(2):78-98. <https://doi.org/10.24833/0869-0049-2021-2-87-98>

¹⁷⁶ Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 6 дугаар зүйл. <https://legalinfo.mn/mn/detail/1242>

¹⁷⁷ 1984 Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment (Art. 14).

¹⁷⁸ 1990 International Convention on the Protection of the Rights of All Migrant Workers and Members of their Families (Art. 15, para. 9 of Art. 16, para. 6 of Art. 18, para. 5 of Art. 22)в

¹⁷⁹ 2006 International Convention for the Protection of All Persons from Enforced Disappearance (Art. 24).

- Хүний эрхийн тухай Европын конвенц (§13, 41) (1950 он)¹⁸⁰;
- Хүний эрхийн тухай Америкийн конвенц (§10, 25) (1969 он)¹⁸¹;
- Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн дүрэм (§21.2) (1981 он)¹⁸² зэрэг болно.

Түүнчлэн Ерөнхий Ассамблей, Аюулгүйн Зөвлөл, Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан тогтоолууд, тодорхой тохиолдлын талаарх шийдвэр, хүний эрхийн тусгай журмын талаарх тайлан, тунхаглал, удирдамж болон бусад эрх зүйн баримт бичгүүд нь хууль тогтоомжийг батлах, тодорхой болгох, боловсронгуй болгоход хувь нэмэр оруулдаг.

Хэдийгээр янз бүрийн цаг хугацаанд батлагдсан хүний эрхийн олон улсын гэрээнд хүний эрхийн зөрчлийн хохирогчдод үр дүнтэй арга хэмжээ авах талаар янз бүрээр тусгагдсан байдаг. 1948 онд батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй.” хэмээн заасан байдаг.¹⁸³ Гэсэн хэдий ч эрх нь зөрчигдсөн хохирогчдод үр дүнтэй арга хэмжээ авах нь зөвхөн шүүхэд хандах эрх төдийгүй тэдний хохирлыг барагдуулахыг хамт авч үзэх явдал юм.

Мөн Хүний эрхийн тухай Европын конвенц (European Convention on Human Rights)-д шударга шүүхээр шүүлгэх эрх (§6), үр дүнтэй гэм хорыг арилгах эрх (§13) болон шударга нөхөн олговор (§41) зэрэг хохирлыг барагдуулах арга хэмжээний талаар тусгасан байдаг.

Олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж (International humanitarian law)

Олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж нь зэвсэгт мөргөлдөөний байдлыг зохицуулах баримт бичгийн цогц бөгөөд энэ нь зэвсэгт мөргөлдөөний ард иргэд, тэр дундаа энгийн иргэд, мөргөлдөөнд оролцоогүй (эсхүл цаашид оролцохгүй), зэвсэгт мөргөлдөөнд оролцогч хэвээр байгаа, тухайлбал байлдагчдад үзүүлэх нөлөөг хязгаарлахад чиглэгдсэн байдаг. Үүний тулд олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж нь хүнийг хамгаалах, дайны арга хэрэгсэл, арга барилыг хязгаарлах гэсэн хоёр чиглэлийг хамардаг.

Олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомж нь олон улсын гэрээ, олон улсын заншил юм. Олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжид хэд хэдэн конвенц, протокол хамрагддаг. Дараах баримт бичиг нь орчин үеийн олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийн суурь болдог:

¹⁸⁰ 1950 European Convention for the Protection of Human Rights and Fundamental Freedoms (Articles 13 and 41).

¹⁸¹ 1969 American Convention on Human Rights (Articles 10 and 25).

¹⁸² 1981 African Charter on Human and Peoples' Rights (para. 2 of Art. 21).

¹⁸³ Хүний эрхийн түгээмэл тунхаглал. <https://legalinfo.mn/mn/detail/1271>

- Газрын дайны хууль, ёс заншлын тухай Гаагийн дүрэм;
- Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархадсан болон өвчтэй хүмүүсийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенц (I);
- Тэнгисийн зэвсэгт хүчний шархтан, өвчтөн болон хөлөг онгоцны сүйрэлд өртөгсдийн нөхцөл байдлыг сайжруулах тухай Женевийн конвенц (II);
- Дайнд олзлогдогсодтой харьцах тухай Женевийн конвенц (III);
- Дайны үед энгийн иргэдийг хамгаалах тухай Женевийн конвенц (IV);
- Олон улсын зэвсэгт мөргөлдөөний хохирогчдыг хамгаалах тухай Женевийн конвенцын нэмэлт протокол (Протокол I);
- Олон улсын бус зэвсэгт мөргөлдөөний хохирогчдыг хамгаалахтай холбоотой Женевийн конвенцын нэмэлт протокол (Протокол II).

Гаагийн дүрэм нь бүх улс тэдний зөвшөөрлөөс үл хамааран заавал дагаж мөрдөх олон улсын заншлын эрх зүй гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрдөг. Харин Женевийн конвенцуудыг улс орнууд соёрхон батална. Женевийн конвенцууд, тэдгээрийн протоколд тусгагдсан олон заалтууд нь олон улсын заншлын эрх зүйн нэг хэсэг гэж тооцогддог бөгөөд бүх зэвсэгт мөргөлдөөнд хамаардаг.

Зарим төрлийн зэвсгийг үйлдвэрлэх, ашиглах, нөөцлөхтэй холбоотой олон улсын гэрээ хамаарах бөгөөд энэ нь байлдааны ажиллагааг зохицуулах, тодорхой төрлийн зэвсгийг ашиглахад хязгаарлалт тавьдаг бөгөөд олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжид хамаардаг. Тухайлбал:

- Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай гэрээ;
- Явган цэргийн эсрэг мина ашиглах, нөөцлөх, үйлдвэрлэх, шилжүүлэхийг хориглох, устгах тухай конвенц;
- Бактериологийн (биологийн) болон хорт зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх, ашиглахыг хориглох, устгах тухай конвенц;
- Химийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөх, ашиглахыг хориглох, устгах тухай конвенц зэрэг байна.

1.2. Үндсэн зарчим, удирдамжийн хамрах хүрээ: ноцтой зөрчил ба түүний хохирогчид¹⁸⁴

Үндсэн зарчим, удирдамж нь хохирогч төвтэй бөгөөд олон улсын хүний эрхийн болон олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийг зөрчиж, хувь хүн, эсхүл бүлэгт хохирол учруулсан тохиолдолд ижил үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, энх тайвны үед ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч хэрэгжих ёстой.

¹⁸⁴ Implementing Victims' Rights: A Handbook on the Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation. The Redress Trust. March 2006. <https://redress.org/wp-content/uploads/2018/01/MAR-Reparation-Principles.pdf>

Ноцтой зөрчил

Олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн хууль тогтоомжийг бүдүүлэг, ноцтой зөрчсөний хууль зүйн үр дагавар нь маш тодорхой байдаг. Тухайлбал, шүүхээр хамгаалуулах эрх, олон улсын хууль тогтоомж, хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй байх гэх мэт. Эдгээр нь Үндсэн зарчим, удирдамжид кодлогдон тусгагдсан стандартууд юм.

Үндсэн зарчим, удирдамж нь олон улсын хууль тогтоомжийн дагуу гэмт хэрэг гэж тооцогдох зөрчлөөс үүсэх эрх зүйн үр дагаврыг хамардаг.

Өмнө нь дурдсанчлан олон улсын хууль тогтоомжууд нь бие биеэ нөхөж байдаг. Тухайлбал, геноцид буюу төрлөөр устгах, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг зэрэг ноцтой зөрчлүүдийн талаар Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм (цаашид “Ромын дүрэм”)¹⁸⁵-д нарийвчлан тодорхойлсон байдаг.

Ромын дүрмийн 6 дугаар зүйлд “Энэхүү дүрмийн зорилгоор **“төрлөөр устгах”** гэмт хэрэг гэж аль нэгэн үндэстэн, угсаатан, арьсны өнгө болон шашин шүтлэг нэгтэйн хувьд тийм бүлэг хүнийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах зорилгоор үйлдсэн дараах үйлдлийн аль нэг мөн:

- (a) тийм бүлгийн гишүүдийг алах;
- (b) тийм бүлгийн гишүүдийн бие махбодод ноцтой гэмтэл учруулах буюу ухаан санааг сарниулах;
- (c) тийм бүлгийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь устгахад чиглэсэн амьдралын нөхцөлийг санаатайгаар зориуд бий болгох;
- (d) тийм бүлгийн дунд төрөлтийг зогсооход чиглэсэн арга хэмжээ авах;
- (e) хүүхдийг нэг бүлгээс нөгөөд хүчээр шилжүүлэх.” гэж заасан байна.

Ромын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Энэхүү Дүрмийн зорилгоор **“хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг”** нь энгийн аливаа хүмүүст өргөн хүрээтэй буюу байнга халдах байдлаар санаатай үйлдэж байгаа дараах үйлдлийн аль нэг болно:

- (a) алах,
- (b) устгах;
- (c) боолчлох;
- (d) хүн амыг албадан гаргах буюу хүчээр нүүлгэн шилжүүлэх;
- (e) шоронд хорих буюу бусад байдлаар олон улсын эрх зүйн үндсэн хэм хэмжээг зөрчих замаар хүний бие махбодын эрх чөлөөг харгис, хэрцгийгээр хасах;

¹⁸⁵ Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрэм. Монгол Улсын Олон улсын гэрээ. 1998 оны 07 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2002 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон. <https://legalinfo.mn/mn/detail/1217>

- (f) эрүүдэн шүүх;
- (g) хүчиндэх, бэлгийн боолчлолд оруулах, биеэ үнэлэхэд тулган хавчих, албадан жирэмслүүлэх, хүчээр засаж хөнгөлөх буюу адилтган үзэж болох бусад хүнд хэлбэрийн бэлгийн аливаа хүчирхийлэл;
- (h) аливаа тодорхой бүлэг буюу нэгдлийг 3 дахь хэсэгт тодорхойлсон улс төр, арьсны өнгө, үндэс, угсаа, соёл, шашин, хүйсийн болон олон улсын эрх зүйн дагуу тэвчиж үл болох хэмээн хүлээн зөвшөөрсөн бусад үндэслэлээр энэ хэсэгт дурдсан аливаа үйлдэл буюу Шүүхийн шүүн шийдвэрлэх харьяалалд хамаарах аливаа гэмт хэрэгтэй холбоотойгоор мөрдөн мөшгөх;
- (i) хүмүүсийг хүчээр сураггүй алга болгох;
- (j) арьсны өнгөөр алагчлах гэмт хэрэг;
- (k) хүчтэй зовуурь шаналгаа учруулах буюу бие махбодод нь ноцтой гэмтэл учруулах, эсхүл санаа сэтгэлийн буюу бие махбодын эрүүл мэндийн хувьд ноцтой хохирол санаатай учруулсан шинж чанартай хүмүүнлэг бус бусад үйлдэл.” гэж заасан байна.

Ромын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт зааснаар “дайны гэмт хэрэг” гэж дор дурдсан зөрчлийг ойлгоно:

- (a) Женевийн 1949 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн конвенцын ноцтой зөрчил...;
- (b) олон улсын эрх зүйгээр тогтсон олон улсын зэвсэгт мөргөлдөөнд хэрэглэх хууль болон заншлыг өөрөөр ноцтой зөрчсөн;
- (c) Женевийн 1949 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн дөрвөн конвенцын хувьд нийтлэг 3 дугаар зүйлийг олон улсын шинж чанаргүй зэвсэгт мөргөлдөөний үед ноцтой зөрчих, ялангуяа зэвсгээ хураалгасан цэргийн албан хаагч болон өвчтөн, шархтан, албадан саатуулагдсан болон аливаа бусад шалтгааны улмаас цэргийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцоогүй хүмүүсийн хувьд үйлдсэн...

Ромын дүрэмд санаатай алах, эрүүдэн шүүх, хүнлэг бусаар харьцах, санаатайгаар их хэмжээний хохирол учруулах, бие, эрүүл мэндэд нь ноцтой гэмтэл учруулах, хууль бусаар албадан гаргах, шилжүүлэх, хууль бусаар хорих, барьцаалах, энгийн иргэдийг бамбай болгон ашиглах зэрэг үйлдлүүдийн жагсаалтыг Ромын дүрэмд тусгасан байна.

Ноцтой зөрчлийн хохирогчид

Үндсэн зарчим, удирдамжид хүний эрхийн баримт бичиг, хууль зүйн шинжлэх ухаанд байдаг тодорхойлолтуудыг нэгтгэн “хохирогч”-ийн тухай тодорхойлолтыг өгсөн байна.

Үндсэн зарчим, удирдамжийн 8 дугаар зарчимд зааснаар **хохилогч** гэдэгт «бие махбодын болон оюун санааны гэмтэл, сэтгэл санааны хохирол, эдийн засгийн хохирол, үндсэн эрх нь ихээхэн хэмжээгээр хохирсон хүмүүс дангаараа буюу хамтдаа хохирсон ... мөн хохирогчийн ойрын гэр бүл, асран хамгаалагчид болон гамшигт нэрвэгдсэн хохирогчдод туслахад, хохирогч болохоос урьдчилан сэргийлэхэд хөндлөнгөөс оролцож хохирол амссан хүмүүс багтана.”

Үндсэн зарчим, удирдамжаас харахад, хохирогч гэсэн ойлголт нь дараах элементүүдийг агуулж байна:

- гэмт этгээд нь тогтоогдсон, хохирогчтой тодорхой харилцаатай эсэхээс үл хамааран тухайн хүн хохирсон бол хохирогч мөн;
- янз бүрийн хохирол учирч болох бөгөөд эдгээр нь эерэг үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотой байж болно;
- хохирогч нь шууд болон шууд бус хохирогч байж болох ба шууд бус хохирогч ч хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй;
- хүмүүс ганцаараа болон нийтээрээ зовж шаналж болно.

Үндсэн зарчим, удирдамжид гэмт хэрэг үйлдэгчээс илүү хохирогчдод анхаарлаа хандуулж байгаа нь олон улсын эрх зүйн хүрээнд хувь хүнд оногдуулсан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээн зөвшөөрөх олон улсын эрүүгийн эрх зүйд өргөн хүрээтэй өөрчлөлтүүдийн нэг болжээ. Энэ нь олон улсын эрх зүй дэх төрийн бус оролцогчдын оролцоог хүлээн зөвшөөрөх ерөнхий чиг хандлагатай нийцэж байгаа аж.

Өмнө нь хүний эрхийн хууль тогтоомжоор гэмт хэрэгтнүүдэд хариуцлага тооцохыг чухалчилж, хохирогчдыг орхигдуулдаг байв. Сүүлийн хэдэн арван жилд олон улсын эрүүгийн шүүхүүд байгуулагдаж, хүний эрхийн хууль тогтоомжуудын тоо нэмэгдсээр байгаа нь хохирогчдыг олон улсын эрх зүйн хүрээнд илүү ихээр хүлээн зөвшөөрөх болсон байна. Тухайлбал, 1998 онд Ромын дүрмийн дагуу Олон улсын эрүүгийн шүүх байгуулагдсан нь хохирогчдын асуудалд анхаарал хандуулах болсон. Олон улсын хэмжээнд төрлөөр устгах гэмт хэрэг, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, дайны гэмт хэрэг, түрэмгийллийн гэмт хэрэгт олон улсын эрүүгийн харьяалал тогтоосноор олон улсын байцаан шийтгэх ажиллагаанд хохирогчдыг тодорхой хүлээн зөвшөөрч, тэдний хохирлыг барагдуулах эрхийг тодорхойлсон.

1.3.Хохирогчдын эрх¹⁸⁶

Зөрчигдсэн эрхийг үр дүнтэй сэргээн тогтоох замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш эрхтэй оролцох

Үндсэн зарчим, удирдамжид тусгагдсан ноцтой зөрчил гарсан тохиолдолд түүнийг арилгах арга нь хууль ёсны байхыг шаарддаг.

Үндсэн зарчим, удирдамжийн 12 дугаар зарчим (зүйл)-д зааснаар олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ноцтой зөрчлийн хохирогч нь олон улсын хууль тогтоомжид заасан үр дүнтэй арга хэмжээг тэгш авах эрхтэй. Улс орнууд нь хохирогчийн шүүхэд хандах эрхийг нь хангах, шүүх хуралдааныг шударгаар явуулах олон улсын хууль тогтоомжид заасан үүргийг дотоодын хууль тогтоомжид тусгах үүрэгтэй.

Өөрөөр хэлбэл, ноцтой зөрчил гаргасан тохиолдолд захиргааны болон бусад шүүхийн бус арга хэмжээ нь олон улсын хууль тогтоомжийн хүрээнд улс орнуудын хүлээсэн үүргээ биелүүлэхэд хангалтгүй гэж үздэг. Хохирогч нь захиргааны журмаар хохирлоо барагдуулахаар хөөцөлдөж байсан ч тухайн иргэн болон төрийн эсрэг иргэний нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй байх ёстой гэсэн үг. Үүний нэгэн адил баривчлагдсан хүн цагдан хоригдсон эсэхээ шүүхийн байгууллагад эсэргүүцэх, шаардлагатай бол үндэслэлгүйгээр баривчлах тухай иргэний нэхэмжлэл гаргах эрхтэй.

Үндсэн зарчим, удирдамжийн 13 дугаар зарчим (зүйл)-д зааснаар шүүх нь хувь хүнд хүртээмжтэй байхаас гадна улс орнууд хохирогчдын бүлгүүдэд хохирлоо барагдуулах тухай нэхэмжлэл гаргах, зохих тохиолдолд нөхөн төлбөр авах боломжийг олгох журам боловсруулахыг хичээх ёстойг сануулсан байна.

Хохирлыг нөхөн төлүүлэх хэлбэрүүд

Үндсэн зарчим, удирдамжид зааснаар хохирогчдын хохирлыг нөхөн төлөх байдал нь “зөрчил, учирсан хохирлын хүнд байдалд тохирсон” байх ёстой бөгөөд “хангалттай, үр дүнтэй, шуурхай нөхөн төлбөр авах” эрхтэй гэдгийг онцлон тэмдэглэсэн байдаг.

Бүрэн бөгөөд үр дүнтэй хохирлыг барагдуулахын тулд Үндсэн зарчим, удирдамжид нөхөн сэргээх, нөхөн олговор, сэргээн засах, сэтгэл ханамжтай байх, дахин давтагдахгүй байх баталгаа зэргийг тусгасан байна. Тохиолдол бүрд хувь хүний нөхцөл байдлыг үргэлж харгалзан үзнэ.

¹⁸⁶ Implementing Victims' Rights: A Handbook on the Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation. The Redress Trust. March 2006. <https://redress.org/wp-content/uploads/2018/01/MAR-Reparation-Principles.pdf>

Нөхөн сэргээх (Restitution)

Үндсэн зарчим, удирдамжийн 19 дүгээр зүйлд “Боломжтой бол хохирогчийг олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнөх анхны байдалд нь зохих ёсоор нөхөн сэргээх ёстой. Зохих ёсоор эрх чөлөөг нөхөн сэргээх, хүний эрх, хувь хүн, гэр бүлийн амьдрал, иргэний харьяаллаа хэрэгжүүлэх, оршин суугаа газартаа буцаах, ажил хөдөлмөрөө сэргээх, эд хөрөнгөө буцаан авах зэрэг орно.” хэмээн заасан.

Нөхөн олговор (Compensation)

Үндсэн зарчим, удирдамжийн 20 дугаар зүйлд “Олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийн ноцтой зөрчсөн үйлдлээс үүдэн гарсан зөрчлийн хүнд байдал, тухайн тохиолдол бүрийн нөхцөл байдалд тохирсон, зохистой харьцаатай, эдийн засгийн хувьд үнэлж болох аливаа хохирлыг нөхөн төлүүлэх ёстой, тухайлбал:

- (a) бие махбодын болон оюун санааны хохирол;
- (b) ажил хөдөлмөр, боловсрол, нийгмийн халамж зэрэг боломжоо алдах;
- (c) эд хөрөнгийн хохирол, орлогын алдагдал, түүний дотор боломжит орлогын алдагдал;
- (d) ёс суртахууны хохирол;
- (e) хууль зүйн болон шинжээчийн туслалцаа, эм, эмнэлгийн үйлчилгээ, сэтгэлзүйн болон нийгмийн үйлчилгээний зардал.” хэмээн заасан.

Сэргээн засах (Rehabilitation)

Үндсэн зарчим, удирдамжийн 21 дүгээр зүйлд “Сэргээн засах нь эмнэлгийн болон сэтгэл зүйн тусламж, түүнчлэн хууль зүйн болон нийгмийн үйлчилгээг багтаасан байх ёстой.” хэмээн заасан.

Сэтгэл ханамжтай байх (Satisfaction)

Үндсэн зарчим, удирдамжийн 22 дугаар зүйлд “Сэтгэл ханамжид шаардлагатай тохиолдолд дор дурдсанаас аль нэгийг, эсхүл бүгдийг нь хамруулна:

- (a) үргэлжилж буй зөрчлийг таслан зогсооход чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ;

- (b) хохирогч, түүний төрөл төрөгсөд, гэрч, хохирогчид туслах, цаашид зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөндлөнгөөс оролцсон хүмүүсийн аюулгүй байдал, ашиг сонирхолд цаашид хохирол учруулахгүй, заналхийлэхгүй байх үүднээс баримтыг шалгаж, үнэнийг бүрэн, олон нийтэд ил болгох;
- (c) алга болсон хүмүүсийн байгаа газар, хулгайлагдсан хүүхдүүдийн биеийн байдал, амь үрэгдэгсдийн цогцсыг хайх, мөн хохирогчдын илэрхийлсэн буюу хүлээн зөвшөөрөгдсөн хүсэл, гэр бүл, хамт олны соёлын зан үйлийн дагуу цогцсыг сэргээх, таних, дахин оршуулахад туслалцаа үзүүлэх;
- (d) хохирогч болон хохирогчтой ойр холбоотой хүмүүсийн нэр төр, нэр хүнд, эрхийг сэргээсэн албан ёсны мэдэгдэл хийх, шийдвэр гаргах;
- (e) баримтыг хүлээн зөвшөөрөх, хариуцлага хүлээх зэрэг олон нийтээс уучлал гуйх;
- (f) зөрчил гаргасан этгээдэд шүүх болон захиргааны хариуцлага хүлээлгэх;
- (g) хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, хүндэтгэл үзүүлэх;
- (h) олон улсын хүний эрхийн хууль, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн сургалтын хөтөлбөрүүд болон бүх түвшний сургалтын хэрэглэгдэхүүнд гарсан зөрчлийн үнэн зөв тайланг багтаах.” хэмээн заасан.

Дахин давтагдахгүй байх баталгаа (Guarantees)

Үндсэн зарчим, удирдамжийн 23 дугаар зүйлд “Дахин давтагдахгүй байх баталгаа нь шаардлагатай тохиолдолд урьдчилан сэргийлэхэд хувь нэмрээ оруулах дараах арга хэмжээний аль нэгийг буюу бүгдийг багтаасан байна:

- (a) цэрэг, аюулгүй байдлын хүчний иргэний үр дүнтэй хяналтыг хангах;
- (b) иргэний болон цэргийн бүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны олон улсын стандарт, шударга, шударга ёсны дагуу явагдахыг баталгаажуулах;
- (c) шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх;
- (d) хууль эрх зүй, эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн салбарынхан, хэвлэл мэдээлэл болон бусад холбогдох мэргэжлийн хүмүүс, хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах;
- (e) нийгмийн бүх салбарт хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн чиглэлээр боловсрол олгох, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, түүнчлэн цэрэг, аюулгүй байдлын хүчнийг бэлтгэх;
- (f) төрийн албан хаагчид, тэр дундаа хууль сахиулах, хорих анги, хэвлэл мэдээлэл, эмнэлгийн, сэтгэл зүй, нийгмийн үйлчилгээ,

- цэргийн алба хаагчид, түүнчлэн эдийн засгийн аж ахуйн нэгжүүдэд ёс зүйн дүрэм, ёс зүйн хэм хэмжээ, ялангуяа олон улсын стандартыг дагаж мөрдөхийг дэмжих;
- (g) нийгмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хянах, түүнийг шийдвэрлэх механизмыг дэмжих;
- (h) олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчих, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйг ноцтой зөрчихийг дэмжсэн, эсхүл идэвхжүүлсэн хуулиудыг хянаж, шинэчлэх.” гэж заасан.

1.4. Улс орнуудын үүрэг

Үндсэн зарчим, удирдамжид зааснаар олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийг бүдүүлгээр зөрчсөн, олон улсын хүмүүнлэгийн хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд улс орнуудын үүргийг заасан байна. Тухайлбал:

- ноцтой зөрчил гарсан тохиолдолд түүнийг мөрдөн шалгах;
- хангалттай нотлох баримт байгаа бол эдгээр зөрчилд буруутай гэх этгээдийг шүүхэд өгч, гэм буруутай нь тогтоогдвол шийтгэх;
- олон улсын хууль тогтоомжийн дагуу өөр хоорондоо хамтран ажиллаж, эдгээр зөрчлийг мөрдөн шалгах, яллах эрх бүхий олон улсын шүүхийн байгууллагуудад туслалцаа үзүүлэх;
- дотоодын хууль тогтоомждоо зохих заалтуудыг тусгах;
- олон улсын хууль тогтоомж болон бусад үүргээр шаардсан тохиолдолд улс орнууд гэмт хэрэгтнийг бусад улс, олон улсын холбогдох шүүхийн байгууллагад шилжүүлэн өгөх, шилжүүлэхэд тус дөхөм үзүүлэх;
- олон улсын шударга ёсыг хэрэгжүүлэхэд шүүхийн туслалцаа, хамтын ажиллагааны бусад хэлбэрээр туслалцаа үзүүлэх (түүний дотор олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу, эрүүдэн шүүх болон бусад хэлбэрийн харгис хэрцгий, хүнлэг бус, нэр төрийг гутаасан харьцах, шийтгэхийг хориглохтой холбоотой олон улсын эрх зүйн шаардлагыг харгалзан хохирогч, гэрчүүдэд туслалцаа үзүүлэх, хамгаалах зэрэг) зэрэг болно.

2. Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах, тэдэнд нөхөн төлбөр олгох гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт

2.1. Канад Улс

Канад Улсад гэмт хэргийн хохирогчийн эрхтэй холбоотой харилцааг Хохирогчийн эрхийн тухай хууль (*Victims Bill of Rights Act, 2015*)¹⁸⁷-аар зохицуулдаг. Энэ хууль нь 2015 оны 07 сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 4 бүлэг, 29 зүйлтэй.

¹⁸⁷ <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-23.7/page-1.html>

Хохирогчийн эрх

Хохирогч гэдэг нь тус улсын Эрүүгийн хууль (Criminal Code), Насанд хүрээгүй этгээдийн эрүүгийн хариуцлагын тухай хууль (Youth Criminal Justice Act), Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг болон дайны гэмт хэргийн тухай хууль (Crimes Against Humanity and War Crimes Act), Хар тамхи, мансууруулах бодисын хяналтын тухай хууль (Controlled Drugs and Substances Act), Каннабисын тухай хууль (Cannabis Act) болон Цагаач, дүрвэгсдийг хамгаалах (Immigration and Refugee Protection Act) зэрэг хуулиудад заасан гэмт хэргийн улмаас бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгө, эдийн засгийн хохирол учирсан этгээдийг хэлнэ.¹⁸⁸

Хохирогчийн эрхийн тухай хуулиар гэмт хэргийн хохирогчийн дараах 4 төрлийн эрхийг хамгаалдаг.¹⁸⁹ Үүнд:

- 1) мэдээллээр хангагдах эрх;
- 2) хамгаалуулах эрх;
- 3) оролцооны эрх;
- 4) хохирлоо барагдуулах эрх.

Хохирогч нас барсан, эсхүл өөрийн эрхээ бие даан хэрэгжүүлэх чадваргүй болсон тохиолдолд дараах этгээдүүдийн аль нэг нь хуулийн дагуу хохирогчийн эрхийг эдэлж болно. Үүнд:

- хохирогчийн эхнэр, нөхөр;
- хохирогчтой гэр бүлийн харилцаатай байсан, нэг жилээс доошгүй хугацаанд хамтран амьдарсан этгээд;
- хохирогчийн хамаатан садан, эсхүл түүнээс шууд хараат байсан этгээд;
- хохирогчийн хууль ёсны болон бодит асран хамгаалагч, харгалзан дэмжигч байсан этгээд;
- хохирогчоос хараат этгээдийн хууль ёсны болон бодит асран хамгаалагч, харгалзан дэмжигч байсан этгээд.

1) Мэдээллээр хангагдах эрх

Хохирогч нь Канад Улсын хууль, шүүхийн тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа болон холбогдох дүрэм, журмын талаар мэдээлэл авах эрхтэй. Түүнчлэн тухайн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцын талаар буюу тухайлбал, өөрийг нь хохироосон гэмт этгээдийг мөрдөх, яллах болон түүнд оногдуулах ял шийтгэлийн тухай зэрэг тодорхой мэдээлэл авч болдог. Энэ хүрээнд хохирогч дараах мэдээллийг гаргуулахаар хүсэлт гаргаж болдог.¹⁹⁰ Үүнд:

¹⁸⁸ Канад Улсын Хохирогчийн эрхийн тухай хуулийн 2 дугаар зүйл.

¹⁸⁹ <https://www.victimsfirst.gc.ca/serv/vrc-dvc.html>

¹⁹⁰ Канад Улсын Хохирогчийн эрхийн тухай хуулийн 6-8 дугаар зүйл.

- **ерөнхий мэдээлэл:**

- эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь хохирогчийн эрх, үүрэг;
- хохирогчид үзүүлэх боломжтой үйлчилгээ, тусгай хөтөлбөрүүд, түүн дотор хохирогчийн эрхийг сэргээн тогтоох шударга ёсны хөтөлбөрүүд;
- хохирогчийн эрхийг эдлүүлээгүй, зөрчсөн тохиолдолд гомдол гаргах нөхцөл, журам;

- **тухайн хэрэг болон гэмт этгээдийн талаар:**

- тухайн хэргийн мөрдөн шалгалтын явц, үр дүн;
- гэмт этгээдийг цагдан хорьсон, эсхүл тэнсэн харгалзсан эсэх болон хэрэв сулласан бол хугацаа, нөхцөлийн талаарх мэдээлэл;
- гэмт этгээдийг батлан даалтад гаргасан, болзолт шийтгэл оногдуулсан, эсхүл тэнсэн харгалзсан тухай шийдвэрийн хуулбар;
- мөрдөн шалгах ажиллагааны явцад сэтгэцийн эмгэгийн улмаас яллагдагчаар татагдах буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй нь тогтоогдсон яллагдагчийн тухай мэдээлэл.

- **тухайн гэмт хэрэгт ял эдэлж буй хоригдлын талаар (Засан хүмүүжүүлэх алба (Correctional Service) болон Өршөөлийн зөвлөл (Parole Board)-д бүртгэлтэй хохирогчийн хувьд):**

- хоригдлын эрх зүйн байдал, түүний хүмүүжил, засралын ахиц, өөрчлөлт;
- олон нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөс бусад тохиолдолд хоригдлын суллагдсан огноо, очих газар, нөхцөл;
- хохирогч ба гэмт этгээдийн хооронд зуучлах үйлчилгээ.

2) Хамгаалуулах эрх

Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд өөрийн аюулгүй байдал, хувийн нууцлалыг хамгаалах, өш хонзонгийн сэдлээр айлган сүрдүүлэлт, заналхийлэлд өртөх бодит аюул занал учрах хангалттай үндэслэл, шаардлага гарсан тохиолдолд хамгаалалтад орох эрхтэй.

Мөн хохирогч шүүх хуралд дараах гэрчийн мэдүүлэг авахуулахаар хүсэлт гаргах эрхтэй.¹⁹¹

¹⁹¹ Канад Улсын Хохирогчийн эрхийн тухай хуулийн 9-13 дугаар зүйл.

- тэдний аюулгүй байдал, хувийн нууцлалыг эрүүгийн шүүхийн албан хаагчид хариуцах;
- айлган сүрдүүлэх, заналхийлэх, өс хонзон авахаас хамгаалагдсан байх;
- хувийн зарим мэдээллээ олон нийтэд мэдээлэхгүй байхыг шүүхээс хүсэх зэрэг эрхтэй.

Хохирогч шүүхэд мэдүүлэг өгөхдөө мэдүүлгийн тусламж (testimonial aids) хүсэх эрхтэй бөгөөд энэхүү эрхийг шүүхээс хангуулдаг. Шүүх хохирогчоос хяналтын камерын цаанаас, зориулалтын хаалтын ардаас, эсхүл ойрын туслах хүнтэйгээр мэдүүлэг авах эсэх асуудлыг шийдэхдээ гэрчийн аюулгүй байдал, харуул хамгаалалтын найдвартай байдал зэрэг хэд хэдэн хүчин зүйлсийг харгалзан үзэж шийдвэрлэдэг.

Хэрэв 18-аас доош насны хохирогч хүсэлт гаргасан бол тухайн хэргийн талаар хэвлэн нийтлэхийг хориглодог.

Тус улсын Өршөөлийн зөвлөлд мэдүүлэг өгсөн хохирогчийн эрхийг хамгаалах үүднээс тус зөвлөл нь урт хугацааны хяналтад байгаа гэмт этгээдэд хохирогчтой холбоо тогтоохгүй байх, эсхүл газар зүйн хориг тогтоох зэрэг шаардлагатай боломжит хязгаарлалт тавьж болно. Зөвлөл нь гэмт этгээдэд тавигдсан хязгаарлалт арилсан, өөрчлөгдсөн талаар хохирогчид тухай бүр мэдэгдэх үүрэгтэй. Засан хүмүүжүүлэх алба олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулахааргүй бол гэмт этгээд (хоригдол)-ийг суллагдахаас өмнө түүний одоогийн гэрэл зургийг үзэх боломжоор хохирогчийг хангах үүрэгтэй.

3) Оролцооны эрх

Хохирогч хохирлын нөлөөллийн мэдэгдэл (victim impact statements) гаргаж, шүүхээр хэлэлцүүлэх эрхтэй. Мөн хохирогч, түүний эрхийг зөрчсөн шийдвэрийн талаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй.¹⁹²

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийн оролцоог илүү ач холбогдолтой байдлаар хангасан байдаг. Үүнд:

- батлан даалтад гаргах ажиллагааны тэмдэглэлд хохирогчийн аюулгүй, хамгаалагдсан байдлыг харгалзан үзэх талаар тусгахыг шүүгчээс хүсэх;
- Эрүүгийн хуульд зааснаар хохирогч болон олон нийтэд учруулсан хохирлыг хүлээн зөвшөөрөхийг ялын зорилго болгон нэмж оруулах;
- хохирогч шүүхэд хохирлын нөлөөллийн мэдэгдэл гаргахдаа мэдүүлгийн тусламж (testimonial aid) авахыг зөвшөөрөх;

¹⁹² Канад Улсын Хохирогчийн эрхийн тухай хуулийн 14-17 дугаар зүйл.

- хохирогч хохирлын нөлөөллийн мэдэгдэл гаргахдаа хохирлын фото зургийг шүүхэд гаргахыг зөвшөөрөх;
- хохирогч гэмт хэргийн улмаас өөрт учирсан бие махбод, сэтгэл санаа, эд хөрөнгө, санхүүгийн хохирлыг шүүхэд тайлбарлахад энгийн, ойлгомжтой байлгахын тулд хохирогч болон нийгэмд үзүүлэх нөлөөллийн мэдэгдлийн стандарт маягтыг хэрэглэх;
- хэрэв хохирогчид тухайн гэмт хэргийн хор нөлөөллийг илүү сайн илэрхийлэхэд тустай бол хохирлын нөлөөллийн мэдэгдэлдээ фото зураг, дүрслэл оруулахыг зөвшөөрөх.

Хяналтын зөвлөл хохирлын нөлөөллийн мэдэгдлийн стандарт маягтыг сэтгэцийн эмгэгийн улмаас эрүүгийн хариуцлага хүлээхгүй гэж үзсэн яллагдагчийн талаар шийдвэр гаргахдаа мөн ашиглаж болно.

Түүнчлэн гэмт этгээдийг өршөөх, хугацаанаас өмнө тэнсэн суллах, болзолтойгоор суллах үйл ажиллагаанд хохирогчийн оролцоог дараах байдлаар хангасан. Үүнд:

- хохирогч тухайн гэмт этгээдийн тэнсэн харгалзах шүүх хуралд оролцох боломжгүй бол шүүх хурлын аудио бичлэгийг сонсох боломж олгох;
- хохирогчийн өмнөөс мэдээлэл хүлээн авах, түүнийг төлөөлөх этгээдийг томилох;
- хохирогч Засан хүмүүжүүлэх алба болон Өршөөлийн зөвлөлийн холбогдох гэмт хэрэгтний талаарх мэдээлэлд хандах эрхээсээ татгалзах эрхтэй.

4) Хохирлоо барагдуулах эрх

Хохирогч хохирлоо барагдуулах, нөхөн төлбөр гаргуулах талаар шүүхийн шийдвэр гаргуулах, мөн иргэний шүүхээр дамжуулан төлөгдөөгүй хохирлыг албадан барагдуулах тухай шүүгчийн захирамж гаргуулах эрхтэй.

Эрүүгийн хуулиар:

- хохирогч шүүх ажиллагааны явцад өөрийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо тайлбарлахыг зөвшөөрнө;
- хохирогчдод хохирлоо нэхэмжлэхэд нь туслах стандарт маягт байна;
 - хохирогчийн нэхэмжилсэн мөнгөн дүн нь тооцоолоход хялбар бөгөөд санхүүгийн бодит алдагдлын зарчимд үндэслэсэн байхыг шаардах бөгөөд энэхүү мөнгөн дүнд зөвхөн гэмт хэрэгтэнд шийтгэл оногдуулах хүртэлх хугацааны хохирлыг багтааж болно (ирээдүйд гарах хохирлыг тооцох боломжгүй);

- шүүх бүх гэмт хэргийг хянан хэлэлцэхдээ хохирлыг барагдуулах асуудлыг зайлшгүй авч үзсэн байх шаардлагатай;
- гэмт этгээдийн төлбөрийн чадвар нь шүүхээс хохирол барагдуулах, нөхөн төлбөр гаргуулах шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйл байх ёсгүй;
- шүүх шийдвэртээ нөхөн төлбөрийн хуваарийг оруулж болно.

Шүүгч дараах санхүүгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж болно:

- гэмт хэргийн улмаас гэмтсэн, үрэгдүүлсэн эд хөрөнгө;
- гэмт хэргийн улмаас бие махбодод учруулсан гэмтэл, сэтгэл санааны хохирол;
- гэмт этгээдийг баривчлах, баривчлахыг завдах үед бие махбодод учруулах гэмтэл;
- гэмт хэргийн улмаас нүүсэн, байрласан түр хоргодох орон байр, хоол хүнс, хүүхэд асрах, тээврийн зардал;
- хувийн мэдээллээ алдсан хүмүүсийн хувийн мэдээллийг сэргээх, зээлийн түүх, зээлжих зэрэглэлээ засах зардал.

Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах Холбооны Омбудсмений газар

Холбооны Засгийн газар нь гэмт хэргийн хохирогчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах Холбооны Омбудсмений газар (Office of the Federal Ombudsperson for Victims of Crime)-ыг 2007 онд байгуулсан.

Хохирогч Холбооны хуулиар олгогдсон эрхийнхээ талаар болон тэдэнд үзүүлж буй үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахаар тус газарт хандах эрхтэй бөгөөд түүнчлэн гэмт хэргийн хохирогчтой холбоотой аливаа холбооны агентлагийн үйл ажиллагаа, эсхүл холбооны хууль тогтоомжийн талаар холбогдох байгууллагад гомдол гаргаж болно.¹⁹³

Тус алба нь шууд хохирогчтой харилцаж, тэдэнд хандсан үйлчилгээ үзүүлэхээс гадна бодлого боловсруулагчид болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч ажилтнуудад хохирогчдын эрэлт хэрэгцээ, санаа зовнилыг судлах мэдлэг, дадлага эзэмшүүлэх, хохирогчдод сөргөөр нөлөөлж болзошгүй чиг хандлага, тулгамдсан асуудлуудыг тогтоох, тодорхойлох чиглэлээр ажилладаг. Омбудсмен шаардлагатай тохиолдолд Холбооны Засгийн газарт зөвлөмж хүргүүлдэг байна.

¹⁹³ Канад Улсын Хохирогчийн эрхийн тухай хуулийн 25-26 дугаар зүйл.

Тус газраас гэмт хэргийн хохирогчдод дараах үйлчилгээ үзүүлдэг.¹⁹⁴ Үүнд:

- хохирогчийн эрхийн талаарх асуултуудад хариулах;
- Холбооны Засгийн газраас хохирогчид үзүүлэх үйлчилгээ, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгөх;
- Холбооны Засгийн газрын хэлтэс, агентлаг, хууль тогтоомж, бодлогын талаарх гомдлыг хүлээн авч хянан үзэх;
- хохирогчид туслалцаа үзүүлж болох хот, муж дахь хөтөлбөр, үйлчилгээнд хандах;
- Холбооны Засгийн газарт хохирогчдын эрэлт хэрэгцээ, тулгамдсан асуудалд нийцсэн бодлого боловсруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар зөвлөмж хүргүүлж, тэдгээр зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар олон нийтэд мэдээлэх.

Эдгээр үйлчилгээ үнэ төлбөргүй байдаг агаад харин хохирогчдын өмнөөс өмгөөлөл хийх, хуулийн зөвлөгөө өгөх үйлчилгээг тус байгууллага үзүүлдэггүй байна.

2.2.Өмнөд Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос Улс) хохирогчдын эрхийг хангах, хамгаалах талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ хүрээнд хохирогчийг хамгаалах, тэдэнд үзүүлэх тусламжийг өргөжүүлэн ажиллаж байна.

Гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг Эрүүгийн хууль (Criminal act, 2020), Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай (Crime victim protection act, 2017), Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны тухай (Enforcement decree of the crime victim protection act, 2018), Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сангийн тухай (Crime victim protection fund act, 2010), Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сангийн үйл ажиллагааны тухай (Enforcement decree of the crime victim protection fund act, 2014), Төрөөс нөхөн төлбөр олгох тухай (State compensation act, 2017) хуулиар зохицуулж байна.

Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар **хохирогч** гэж Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн улмаас бие, сэтгэл, эдийн засгийн хохирол амссан этгээдийг хэлнэ.

Хохирогчид олгох нөхөн төлбөр

Гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бөгөөд гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тодорхойгүй, эсхүл гэмт хэргийн

¹⁹⁴ <https://www.victimfirstst.gc.ca/abt-apd/hwhv-cnav.html>

улмаас учруулсан хохирлоо бүрэн буюу хэсэгчлэн нөхөн төлөх санхүүгийн чадамжгүй бол хохирогч болон түүний гэр бүлийн гишүүн нь төрөөс нөхөн төлбөр олгодог.¹⁹⁵

Хуульд зааснаар дараах гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгоно:¹⁹⁶

- дээрэмдэх;
- хулгайлах;
- хүчирхийлэл үйлдэх;
- хүчиндэх;
- бэлгийн харьцаанд албадан орох;
- сүрдүүлэх (blackmail);
- залилах;
- бусдын эд хөрөнгийг шамшигдуулах;
- итгэл эвдэх;
- бусдын эд хөрөнгөд хохирол учруулах.

Дээр дурдсан гэмт хэргийн хохирогч, эсхүл түүний гэр бүлийн гишүүн нөхөн төлбөр авах тухай өргөдлөө гаргах эрхтэй бөгөөд өргөдөл гаргагч нь хоёр дахь шатны шүүх хуралдаанаас өмнө гэмт хэрэгтний яллагдагчаар татагдсан шүүхэд бичгээр, эсхүл шүүх хуралд гэрчээр оролцох үедээ амаар гаргаж болдог байна.

Нөхөн төлбөр олгох тухай шүүхийн шийдвэр нь иргэний хэргийн шүүхийн шийдвэртэй адил хүчинтэй бөгөөд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлж болно.

Мөн хохирогч нь нөхөн төлбөр авах тухай өргөдлөө өөрийн оршин суугаа, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газарт харьяалагдах Гэмт хэргийн хохирлыг барагдуулах хороонд (Crime Damage Relief Review Committee) гаргаж болно.¹⁹⁷ Энэ тохиолдолд хохирогч нь хохирол тодорхой болсон өдрөөс хойш 2 жилийн дотор, эсхүл хохирол бий болсноос хойш 5 жилийн дотор өргөдлөө гаргах бөгөөд хэрэв энэхүү хугацаа өнгөрсөн бол нөхөн төлбөр олгохгүй ажээ.

Нөхөн төлбөрийн төрөл, хэмжээ

Нөхөн төлбөр нь дараах төрөлтэй:

- 1) гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн төлбөр (үүнд, гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн эхнэр,

¹⁹⁵ <https://fgn.kics.go.kr/en/jsp/cva/crimeVictimAssistance02.jsp>

¹⁹⁶ <https://fgn.kics.go.kr/en/jsp/cva/crimeVictimAssistance03.js>

¹⁹⁷ Өмнөд Солонгос Улсын Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйл.

- нөхөр, хүүхэд, эцэг эх, ач зээ, өвөө эмээ, ах дүүс хамаарна);
 2) хөгжлийн бэрхшээлтэй болсон хохирогчид олгох нөхөн төлбөр (I-VI зэрэгтэй хөдөлмөрийн чадвар алдсан хохирогчид хамаарна).

Хүснэгт. Нөхөн төлбөрийн хэмжээ

	Нөхөн төлбөрийн төрөл	Нөхөн төлбөрийн хэмжээ
	гэмт хэргийн улмаас нас барсан этгээдийн гэр бүлд олгох нөхөн төлбөр	30-15 сая вон
	хөгжлийн бэрхшээлтэй болсон хохирогчид олгох нөхөн төлбөр	
	- хөдөлмөрийн чадвар алдсаны I зэрэг	30 мянган вон
	- хөдөлмөрийн чадвар алдсаны II зэрэг	25 мянган вон
	- хөдөлмөрийн чадвар алдсаны III зэрэг	20 мянган вон
	- хөдөлмөрийн чадвар алдсаны IV зэрэг	15 мянган вон
	- хөдөлмөрийн чадвар алдсаны V зэрэг	10 мянган вон
	- хөдөлмөрийн чадвар алдсаны VI зэрэг	6 мянган вон

Хууран мэхлэх зэрэг хууль бус аргаар нөхөн төлбөр авсан этгээдийг 5 жилээс дээш хугацаагаар хорих, эсхүл 20 сая хүртэлх воноор торгоно.

Хохирогчийг хамгаалах төв

Өмнөд Солонгос Улсын хэмжээнд бүх шатны прокурорын газруудын дэргэд нийт 58 гэмт хэргийн хохирогчийг хамгаалах төв ажиллаж байна.¹⁹⁸ Эдгээр төвүүдэд хэрэг хянан шийдвэрлэх чиглэлээр мэргэшсэн, прокурорын байгууллагад ажиллаж байсан туршлагатай мэргэжилтнүүд хохирогчдод болон тэдний гэр бүлийн гишүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зөвлөгөө өгдөг.

Хохирогчийг хамгаалах төв нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг:

- холбогдох хэргийн шүүх хурлын талаар, гарсан шийдвэр, гэмт хэрэгтний хоригдож дуусах хугацаа зэрэг мэдээллийг хохирогчид өгөх¹⁹⁹;
- гэмт хэргийн улмаас амь насаа алдсан хохирогчийн гэр бүл, гэмт хэргийн улмаас хүнд гэмтэл авсан хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эсэх, хэрхэн авах талаар зөвлөх (иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүйгээр бусад арга замаар гэмт хэргийн хохирогч болон тэдний гэр бүлийн гишүүдэд нөхөн төлбөр олгох);
- шүүхэд гэрчээр дуудагдсан иргэнд хууль зүйн зөвлөгөө өгөх, шүүх хурлын үйл ажиллагаанд туслах;

¹⁹⁸ www.spo.go.kr/site/eng/02/10201000000002018120606.jsp

¹⁹⁹ Өмнөд Солонгос Улсын Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйл.

- Хохирогчийг хамгаалах төвийн хариуцах асуудалд хамаарахгүй бол тухайн хохирогчийг иргэний хохирогчийг дэмжих төв (civil victim support center) болон холбогдох бусад байгууллагатай холбож өгөх.²⁰⁰

2.3. Филиппин Улс

Бүгд Найрамдах Филиппин Улс (Филиппин Улс) нь гэмт хэргийн хохирогчдын үндсэн эрхийг хангах, хохирлыг арилгахад туслах, тэдэнд нөхөн төлбөр олгох харилцааг Үндсэн хууль, Хохирогч, гэрчийг хамгаалах тухай болон Хохирогчдын эрхийг хангах Нэхэмжлэлийн зөвлөл байгуулах тухай хуулиар зохицуулж байна.

Эрх зүйн орчин

Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт төр нь хүн бүрийн нэр төр, хүний эрхийг эрхэмлэн дээдлэх баталгааг хангана хэмээн тунхаглажээ. Үүний дагуу Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт хохирогчтой холбоотой дараах заалтууд байдаг:

- гэмт хэрэгт шалгагдаж байгаа сэжигтэн дуугүй байх, хууль зүйн зөвлөгөө өгөх өмгөөлөгчөө өөрөө сонгох эрхтэй. Хэрэв тухайн этгээд төлбөрийн чадамжгүй бол үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх;
- сэжигтний эсрэг эрүү шүүлт тулгах, хүчирхийлэх, заналхийх, айлган сүрдүүлэх зэрэг аргыг ашиглахыг хориглоно. Мөн нууцаар, ганцаарчлан болон бусад төстэй аргаар хорихыг хориглоно;
- эдгээр заалтыг зөрчсөн бол эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээлгэх, түүнчлэн эрүү шүүлт тулгах, түүнтэй адилтгах гэмт хэргийн хохирогч болон түүний гэр бүлд нөхөн төлбөр олгох, цагаатгах арга хэмжээг авах.

Үндсэн хуулийн 13 дугаар зүйлийн 18 дахь хэсэгт зааснаар тус улсын Хүний эрхийн комиссын бүрэн эрх, чиг үүрэгт “Хүний эрхийг хамгаалах, эрх нь зөрчигдсөн хохирогч болон тэдний гэр бүлд нөхөн төлбөр олгох талаар үр дүнтэй арга хэмжээ авахыг Конгресст санал болгоно” гэж заасан байдаг.²⁰¹

Мөн Филиппин Улс нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчмуудыг тус улсын хуулийн нэг хэсэг болгон баталсан. Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүний эрхийн олон улсын хууль тогтоомж, конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэргийг дагаж мөрдөж байна.

²⁰⁰ <https://fgn.kics.go.kr/en/jsp/cva/crimeVictimAssistance01.jsp>

²⁰¹ https://www.constituteproject.org/constitution/Philippines_1987?lang=en

Хохирогч, гэрчийг хамгаалах тухай хуульд дараах зүйлсийг тусгасан байна:

- Филиппин Улсын шүүх нь хохирогчийн аюулгүй байдал, бие махбодын болон сэтгэл санааны тогтвортой байдал, нэр төр болон хувийн нууцыг хамгаална;
- шүүх хурлын нийтлэг зарчмыг үл харгалзан хохирогч, гэрч, яллагдагчийг хамгаалах үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль нэг хэсгийг хаалттай, эсхүл цахимаар болон бусад тусгай хэрэгсэл ашиглан явуулж болно;
- нотлох баримт, мэдээлэл задруулах нь хохирогч, гэрч болон түүний гэр бүлийн аюулгүй байдалд ноцтой аюул учруулж болзошгүй бол шүүх аливаа баримт, мэдээллийг нууцлах, эсхүл хураангуй болон хэсэгчилсэн байдлаар танилцуулж болно;
- шүүх хохирогчдод учирсан хохирлыг барагдуулах, нөхөн төлбөр олгохтой холбоотой аливаа хохирлын цар хүрээ, хэмжээг тодорхойлно.

Нэхэмжлэлийн зөвлөл

Хохирогчдын эрхийг хангах Нэхэмжлэлийн зөвлөл байгуулах тухай хуулийн дагуу хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон хохирогчдын хохирлыг барагдуулах, нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэх зорилгоор Хууль зүйн яамны дэргэд Нэхэмжлэлийн зөвлөл байгуулжээ.

Нэхэмжлэлийн зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд гишүүд нь хууль зүйн салбарт 10-аас доошгүй жил ажилласан, хүний эрхийн талаар мэргэшсэн байна. Филиппин Улсын Ерөнхийлөгч тус зөвлөлийн дарга, гишүүдийг томилно. Нэхэмжлэлийн зөвлөлийн дарга, гишүүд нь давж заалдах шатны шүүхийн дарга, дэд шүүгч нартай дүйцэх зэрэг дэв, цалин урамшуулалтай.

Тус зөвлөлийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхэд туслах зорилготой Ажлын алба байх бөгөөд тус алба нь 5 хуульч, 3 туслах хуульч, 3 захиргааны ажилтны бүрэлдэхүүнтэй. Шаардлагатай тохиолдолд зөвлөх, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, олон нийтийн боловсролын мэргэжилтнүүдтэй гэрээгээр хамтран ажилладаг.

Нэхэмжлэлийн зөвлөл нь дараах чиг үүрэгтэй:

- хуулийн дагуу Нэхэмжлэлийн зөвлөлд ирүүлсэн өргөдлийг хүлээн авч судлах;
- захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан явуулах, нэхэмжлэлтэй холбоотой маргааныг шийдвэрлэх;

- чиг үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;
- үйл ажиллагаагаа олон нийтэд танилцуулах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах;
- шаардлагатай бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нөхөн төлбөр олгох

Нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг дараах этгээдүүд гаргана:

- хилс хэргээр хорих ял эдлээд цагаатгагдсан хохирогч;
- хууль бусаар хоригдоод суллагдсан хохирогч;
- шүүхийн шийдвэрийн дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар баривчлагдсан хохирогч;
- хүчирхийлэлд өртсөн хохирогч (амиа алдах, бие махбодын болон сэтгэл санааны хүнд гэмтэл авах, хөгжлийн бэрхшээлтэй болох, үр хөндүүлэх, эрүүдэн шүүх зэрэг).

Хууль бусаар баривчлагдсан, хоригдсон хохирогчдод нөхөн төлбөр олгохдоо цагдан хоригдсон хугацааг тооцно. Нөхөн төлбөрийн хэмжээ нь нэг сарын 1.000-3.000 песо байна. Бусад гэмт хэргийн хохирогчийн нөхөн төлбөр нь 10.000.00-50.000 песо байна.

Нэхэмжлэлийн зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу хохирогчдод төрийн байгууллагуудаас эрүүл мэнд, боловсролын чиглэлээр мөнгөн бус нөхөн төлбөр олгох боломжтой.

Нэхэмжлэл гаргах хугацаа: Хуулийн дагуу нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд хорихоос суллагдсанаас хойш, эсхүл хохирогч хохирол, гэмтэл учирсан өдрөөс хойш 6 сарын дотор Нэхэмжлэлийн зөвлөлд нөхөн төлбөр авах тухай нэхэмжлэл гаргана. Энэ хугацаанд нэхэмжлэл гаргаагүй бол хохиролгүй болсонд тооцно.

Хохирогчийн өв залгамжлагч нэхэмжлэл гаргах: Хуулийн дагуу нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд нас барсан, хөдөлмөрийн чадвараа алдсан бол түүний өв залгамжлагч эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн, эцэг, эх, ах эгч, дүү нар нь энэхүү дарааллаар нэхэмжлэл гаргаж болно.

Нэхэмжлэлийг шийдвэрлэх хугацаа: Нэхэмжлэлийн зөвлөлд өргөдөл гаргасан өдрөөс хойш ажлын 30 хоногт уг асуудлыг шийдвэрлэнэ. Хэрэв хохирогч Нэхэмжлэлийн зөвлөлөөс гаргасан тогтоолын шийдвэртэй санал нийлэхгүй бол уг тогтоолыг хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор Хууль зүйн яаманд гомдол гаргах эрхтэй.

2.4. Энэтхэг Улс

Энэтхэг Улсад хохирогч нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд мэдээлэл авах, байлцах, сонсгол хийх зэрэг хууль ёсны эрхтэй. Тус улсын төрийн бодлого нь гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох төдийгүй тэдэнд цогц дэмжлэг үзүүлэхэд хүчин чармайлт гарган ажилладаг.

Тус улсад хохирогч болон түүний эрхийг хангах, хамгаалах, хохирлыг нь барагдуулах тухай асуудлыг дараах хуулиудаар зохицуулдаг. Үүнд:

- Үндсэн хууль (Constitution, 1950)²⁰²;
- Эрүүгийн хууль (Penal Code, 1860)²⁰³;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Code of Criminal Procedure, 1973)²⁰⁴;
- Эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хууль (Protection of Women from Domestic Violence Act, 2005)²⁰⁵;
- Хуваарьт каст ба хуваарьт овог аймгуудын (харгис хэрцгий байдлаас урьдчилан сэргийлэх) хууль (Scheduled Castes and the Scheduled Tribes (Prevention of Atrocities) Act, 1989)²⁰⁶;
- Эцэг эх, ахмад настны халамж, тусламж үйлчилгээний тухай хууль (Maintenance and Welfare of Parents and Senior Citizens Act, 2007)²⁰⁷.

Энэтхэг Улсын Үндсэн хуульд хохирогчийн эрх, түүний хамгаалалт, хохирогчид нөхөн төлбөр олгох тухай зарим заалтыг тусгасан байна. Тухайлбал:

- тус улсын нутаг дэвсгэрт хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх, эрх зүйн тэгш хамгаалалттай байх тухай (14 дүгээр зүйл);
- гэмт хэргийн хохирогчдын хохирлыг төрөөс барагдуулахыг шаардах замаар амь нас, эрх чөлөөг нь шударга бусаар хасуулахгүй, хамгаалах тухай (21 дүгээр зүйл);
- төрөөс эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлж, тэгш боломжийн үндсэн дээр шударга ёсыг дэмжих тухай (39А дүгээр зүйл);
- төр нь эдийн засгийн чадавхынхаа хүрээнд хөдөлмөрийн чадвараа алдсан, зүй бусаар гачигдах, бусад шаардлагатай тохиолдолд олон нийтийн дэмжлэг, тусламжийг авах эрхтэй (41 дүгээр зүйл) зэргийг баталгаажуулсан байна.

²⁰² Indian Constitution of 1950, <https://legislative.gov.in/constitution-of-india/>

²⁰³ The Indian Penal Code, 1860, <https://www.indiacode.nic.in/bitstream/123456789/2263/1/aA1860-45.pdf>

²⁰⁴ The Code of Criminal Procedure, 1973 https://www.indiacode.nic.in/handle/123456789/16225?view_type=search&col=123456789/1362

²⁰⁵ Protection of Women from Domestic Violence Act, 2005, <https://www.indiacode.nic.in/handle/123456789/2021>

²⁰⁶ Scheduled Castes and the Scheduled Tribes (Prevention of Atrocities) Act, 1989, <https://www.indiacode.nic.in/handle/123456789/1920>

²⁰⁷ Maintenance and Welfare of Parents and Senior Citizens Act, 2007 <https://www.indiacode.nic.in/handle/123456789/2033>

Эрүүгийн шүүх дэх хохирогчийн эрх²⁰⁸

Энэтхэг Улсын хуулиудад хохирогч гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байна:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд **хохирогч** гэж яллагдагчийг буруутгаж байгаа үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан аливаа хохирол, хохирол амссан хувь хүн; мөн хохирогчийн асран хамгаалагч, хууль ёсны өв залгамжлагчийг хэлнэ гэж;
- Эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хуульд **хохирогч** гэж гэмт этгээдтэй (respondent) гэр бүлийн харилцаатай байсан, эсхүл харилцаатай байгаа хүнээс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэж мэдэгдэж буй аливаа эмэгтэйг хэлнэ гэж;
- Хуваарьт каст ба хуваарьт овог аймгуудын тухай (харгис хэрцгий байдлаас урьдчилан сэргийлэх) хуульд **хохирогч** гэж энэ хуульд заасан аливаа гэмт хэрэг үйлдсэний улмаас сэтгэл санааны болон эд хөрөнгийн хохирол учирсан, бие махбод, сэтгэл зүйн хувьд зовж шаналсан аливаа хүн, түүний хууль ёсны асран хамгаалагч, өв залгамжлагчийг хэлнэ гэж.

Тус улсын хуулиар хохирогчид тодорхой эрх олгосон байдаг. Тухайлбал, хүнд болон хөнгөн гэмт хэрэг үйлдсэн эсэхээс үл хамааран аливаа хүчирхийлэлд өртсөн хохирогч, мөн амь насаа алдсан хохирогчийн гэр бүлийн гишүүд, насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн, эцэг эх, асран хамгаалагч, бусад төрөл төрөгсөд, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, эсхүл хохирогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч зэрэг хүмүүс хохирогчийн өмнөөс эрхийг нь эдэлж болно.

Энэтхэг Улсад тусгай хэрэгцээт хохирогч гэж байх ба ийм хохирогчдод тусгай эрхийг зайлшгүй олгодог. Тусгай хэрэгцээт хохирогч гэдэгт бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч, өндөр настан, бага насны хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамаардаг байна.

Хохирогч нь дараах үндсэн эрхтэй. Үүнд:

- 1) эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх (сонсголд оролцох эрх);
- 2) нөхөн төлбөр нэхэмжлэх, авах эрх (төрөөс болон гэмт этгээдээс);
- 3) мэдээлэл авах эрх;
- 4) дарамт, айлган сүрдүүлгээс ангид байх эрх;
- 5) нотлох баримт болгон хураан авсан хувийн эд хөрөнгөө нэн даруй эргүүлэн авах эрх;
- 6) шүүх хурлаар шуурхай шийдвэрлүүлэх эрх.

²⁰⁸ <https://www.legalserviceindia.com/legal/article-9643-protection-of-rights-of-victims-in-criminal-justice-system.html>

Хохирогчийн дээр дурдсан үндсэн эрхүүдийг авч үзвэл:

1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх (сонсголд оролцох эрх):

Хохирогч болон тэдний гэр бүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй. Гэр бүл нь шүүх хуралд оролцох, хурлын үйл ажиллагаа, тодруулбал, хохирогч болон гэмт этгээдийн өмгөөлөгчийн тайлбар, гэрчийн мэдүүлэг, шүүгчийн байр суурийг сонсох, гэрчлэх нь маш чухал байдаг.

Мөн хохирогчийн хамгийн чухал эрхийн нэг бол түүний эрх ашгийг хөндсөн шүүхийн сонсголыг сонсох, үг хэлэх эрх юм. Хохирогчоос ял оногдуулах шүүх хуралд мэдүүлэг өгөх, энэ гэмт хэрэг өөрт нь болон тэдний гэр бүлд үзүүлэх нөлөөллийн талаар мэдүүлэг өгөхийг зөвшөөрсөн бол шүүх гэмт хэргийн хувийн шинж чанар, учирсан хохирлыг хүлээн зөвшөөрдөг.

Гэмт хэргийн хохирогчийн өөр нэг эрх бол тухай хэргийн талаар прокурортой ярилцах юм. Шүүхийн эцсийн шийдвэр гарахаас өмнө прокурор хохирогчийн саналыг сонссон байна.

2) Нөхөн төлбөр нэхэмжлэх, авах эрх (төрөөс болон гэмт этгээдээс):

Хохирогч нь нөхөн төлбөр төрөөс болон гэмт этгээдээс нэхэмжилж авах эрхтэй байна.

2.1. Төрөөс нөхөн төлбөр нэхэмжлэх эрх

Хүчирхийлэлд өртсөн хохирогчид нөхөн төлбөр олгох асуудлыг төрийн бодлогоор зохицуулдаг. Хохирогч амьдарч байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэгдсэн муж улсын нөхөн төлбөрийн хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаснаар хохирогч, эсхүл түүний гэр бүлийн гишүүн нөхөн төлбөр авч болно. Мөн гэмт хэрэгтэн нь үйлдэл дээрээ баригдаагүй, эрүүгийн хариуцлага хүлээгээгүй ч хохирогчид нөхөн төлбөр олгож болно.

Нөхөн төлбөр авахад тодорхой шаардлагыг хангасан байна. Тухайлбал, хүчирхийллийн гэмт хэргийн шууд хохирогч, эсхүл түүний амьд үлдсэн гэр бүлийн гишүүн нь нөхөн төлбөр нэхэмжлэх эрхтэй. Мөн хохирогч шүүхээс зөвлөгөө авах зардлаа нөхөн төлүүлэх хүсэлт гаргаж болно. Хохирогчийн хувьд хохирлоо барагдуулахын тулд хэргийн талаар мэдээлж, мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажилласан байхыг шаарддаг. Гэвч зарим тохиолдолд хохирогчийн өөрийнх нь буруутай үйлдлээс болж хохирол учирсан бол нөхөн төлбөр авах боломжгүй байдаг. Хохирогчид эмнэлгийн, зөвлөгөө авсны төлбөр, алдсан орлого, оршуулгын зардал зэрэг нөхөн төлж болох зардлыг нөхөн төлбөрийн хөтөлбөрийн дагуу олгоно.

2.2. Гэмт этгээдээс нөхөн төлбөр авах эрх

“Нөхөн төлбөр” гэсэн нэр томъёо нь гэмт этгээдийн учруулсан хохирлыг барагдуулах, ингэхдээ ихэвчлэн мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг ойлгоно. Мөн гэмт хэргийн явцад хулгайлагдсан, эвдэрч гэмтсэн эд хөрөнгийг буцаан өгөх, засварлах, нөхөн сэргээж төлүүлэхийг ойлгоно.

“Хохирлыг нөхөн төлүүлэх зардал” нь эмчилгээний, эмийн зардал, өвчтэй байсан хугацааны цалин, хуулийн зөвлөгөө авах зардал, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохтой холбоотой зардал (замын зардал, хүүхэд асрах зардал гэх мэт), алдагдсан, гэмтсэн эд хөрөнгө, даатгалын хөнгөлөлт, гэмт хэргийн улмаас гарсан бусад зардал зэрэг орно.

Нөхөн төлбөр нь сэтгэл зүйн түгшүүр, дарамтыг арилгаж чадахгүй ч цаашид гарах эмчилгээ, зөвлөгөө авах зардал гэх мэт ирээдүйд учрах бодит хохирлыг нөхөж болно. Шүүх хохирлыг нөхөн тооцохдоо хохирогчид учирсан хохирлыг харгалзан үздэг.

3) Мэдээлэл авах эрх:

Хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, өөрийн эрх, хамгаалалтын арга, бусад боломжит үйлчилгээний талаар мэдээлэл авах эрхтэй. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны тогтолцоо нь хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулж, хууль ёсны эрх, хамгааллын арга, хүртээмжтэй үйлчилгээний талаар мэдээлэлтэй байх боломжийг олгодог.

Хохирогчдын мэдээлэл авах эрхэд,

- шүүх хуралд оролцох буюу хохирогчийн мэдүүлэг өгөх;
- гэмт этгээдээс нөхөн төлбөр авахаар Иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах;
- хохирогч болон түүний гэр бүл, хамаарал бүхий этгээдийг гэмт хэрэг үйлдэгчээс хамгаалах тухай шүүхийн шийдвэр гаргуулах зэрэг эрхүүд хамаарна.

Шүүхээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаарх мэдээллийг хохирогчид өгөх үүрэгтэй. Тухайлбал, шүүх хурлын тов, цаг, яллагдагчийг баривчлах, батлан даалтад гаргах, ялыг хэрэгсэхгүй болгох зэрэг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатны талаар хохирогчдод мэдэгдэх үүрэгтэй.

4) Дарамт, айлган сүрдүүлгээс ангид байх эрх:

Хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дарамт, айлган сүрдүүлгээс хамгаалагдах эрхтэй. Энэ эрх нь нийтээр тодорхойлсон хамгаалах үндсэн эрх, эсхүл тусгай хамгаалалтын арга хэмжээний цогц хэлбэрээр илэрч болно.

Гэмт хэргийн хохирогчийг дарамт, айлган сүрдүүлгээс урьдчилан сэргийлж хамгаалах хэд хэдэн арга хэмжээ байдаг:

- цагдаа, шүүх рүү дагалдан явах/буцах;
- шүүх хурлын явцад яллагдагч, түүний гэр бүл, гэрч, найз нөхдөөс тусдаа хүлээлгийн бүсийг аюулгүй байлгах;
- гэрчийг хамгаалах хөтөлбөрт хамруулах;
- оршин суугаа газрыг нүүлгэн шилжүүлэх;
- олон нийтэд аюул учруулах, эсхүл хохирогч болон гэрчүүдийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс шүүгдэгчийг батлан даалтад гаргахаас татгалзах, батлан даалтад гаргах бол тодорхой нөхцөлүүд тавьж гаргах зэрэг байна.

5) Нотлох баримт болгон хураагдсан хувийн эд хөрөнгөө нэн даруй эргүүлэн авах эрх:

Хохирогч нь хулгайн гэмт хэрэгт эд хөрөнгөө алдах, эсхүл хуулийн байгууллагаас эд хөрөнгийг нь нотлох баримт болгон хураан авах гэсэн хоёр хэлбэрээр хохирч болно. Иймээс хохирогч нотлох баримт болгон хураагдсан хувийн эд хөрөнгөө цаг тухайд нь эргүүлэн авах эрхтэй.

6) Шүүх хурлаар шуурхай шийдвэрлүүлэх эрх:

Гэмт хэргийн хохирогчид шуурхай шүүхээр асуудлаа шийдвэрлүүлэх буюу хэргийг цаг алдалгүй шийдвэрлүүлэх эрхтэй бөгөөд энэ нь шүүхийн шийдвэрээр шийдвэрлэгддэг ажээ. Шүүх талуудын хүсэлтийг үндэслэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах тухай шийдвэр гаргахдаа хохирогчид үзүүлэх аливаа нөлөөллийг харгалзан үзэх шаардлагатай.

Хохирогчид нөхөн төлбөр олгох

Хохирол барагдуулахтай холбоотой өнөөгийн хууль эрх зүйн тогтолцоо нь 1973 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Дээд шүүхийн шийдвэрт тусгагдсан байдаг. Мөн Хүний амь нас хохирсон гамшигт ослын тухай хууль (Fatal Accidents Act, 1855), Авто тээврийн хэрэгслийн тухай хууль (Motor Vehicles Act, 1988), Хүний эрхийн зөрчлийг арилгах тухай Үндсэн хуулийн арга хэрэгслүүд (Constitutional Remedies for Human Rights Violation), Гэмт хэрэгтнийг тэнсэн харгалзах тухай (Probation of Offenders Act, 1958) зэрэг хуулиудад гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай асуудал тусгагдсан байна.²⁰⁹

²⁰⁹ Compensatory Jurisprudence, https://www.legalservicesindia.com/article/1888/Compensatory-Jurisprudence.html#google_vignette

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 357-359 дугаар зүйлд нөхөн төлбөр олгох тухай асуудлыг зохицуулдаг. Шүүхээс торгох ял болон бусад ялыг (цаазын ялыг оролцуулан) оногдуулсан бол шүүх уг шийдвэрийг гаргахдаа нөхөн төлбөрийн хэмжээг тусгах бөгөөд төлөлтийг бүхэлд нь буюу хэсэгчлэн төлөхөөр шийдвэрлэнэ.

Дараах тохиолдолд хохирлыг нөхөн төлүүлнэ:

- хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг;
- хохирлын нөхөн төлбөрийг шүүхийн шийдвэрээр тухайн этгээд Иргэний шүүхээр нөхөн төлөх боломжтой бол;
- бусдын амь хохироосон, эсхүл ийм гэмт хэрэг үйлдэхэд өдөөн хатгасны улмаас хохирогч нас барсан бол;
- хүн хулгайлах, бусдын эд хөрөнгийг завших, итгэл алдах, залилах, шударга бусаар хөрөнгө өөртөө авах, хадгалах, эсхүл хулгайлсан эд хөрөнгийг захиран зарцуулах, захиран зарцуулахад нь туслах зэргийг үйлдсэн бол.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 357А-д хохирогчийн нөхөн төлбөр олгох тогтолцооны талаар зохицуулжээ. Шүүхээс нөхөн төлбөр олгох шийдвэр гарсан тохиолдолд тухайн муж улс, дүүргийн Хууль зүйн үйлчилгээний газар (Legal Service Authority) нөхөн төлбөрийн хэмжээг тогтоодог байна.

Хохирогчийг тогтоосон боловч гэмт этгээдийг тогтоогоогүй, шүүх хурал болоогүй тохиолдолд хохирогч (буюу түүний асрамжид байдаг хүн)-д нөхөн төлбөр олгох хүсэлтийг муж улс, дүүргийн Хууль зүйн үйлчилгээний газарт гаргана. Тус газар нь шаардлагатай баримтыг бүрдүүлэн 2 сарын дотор нөхөн олговрыг олгоно. Тухайн муж улс, дүүргийн Хууль зүйн үйлчилгээний газар нь хохирогчид чирэгдэл учруулахгүйн тулд түүнд цагдаагийн байгууллагын яаралтай тусламж, эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээг үзүүлэх захиалга өгч болно. Үүний дагуу цагдаагийн байгууллага болон тусламж үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага түр хугацааны тусламж үйлчилгээг үзүүлнэ.

Дээрх хуулийн 357С-д хохирогчийг эмчлэх тухай зохицуулсан байна. Төрийн болон хувийн хэвшлийн бүх эмнэлэг, төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд нь хохирогчид нэн даруй үнэ төлбөргүй эмнэлгийн анхны тусламж үзүүлэх үүрэгтэй.

Энэтхэг Улсын муж улсуудад гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч болон түүний асрамжид байгаа хүнд нөхөн төлбөр олгоход дор дурдсаныг баримтална. Үүнд:

- 1) хохирогчид мөнгөн тусламж үзүүлэх;
- 2) хохирогчийн хэрэгцээ шаардлагаас хамааран хамгаалах байр, зөвлөгөө, эмнэлгийн тусламж, хууль зүйн туслалцаа, боловсрол, мэргэжлийн сургалт зэрэг дэмжлэг үзүүлэх.

Хохирогчийг хамгаалах²¹⁰

Хохирогчийг хамгаалах нь төрийн үндсэн үүрэг бөгөөд хохирогчийн нэр төр, эрхийг хуулиар хамгаалах нь шударга ёсыг тогтооход тусалдаг. Хохирогчид өөрийн нэр төрийнхөө төлөө гэмт хэргийг нуун дарагдуулж, зарим үед хохирогч өөрийнх нь эсрэг гэмт хэрэг үйлдэж байгааг мэдэхгүй байх тохиолдол байдаг.

Хохирогч бол эрүүгийн хэргийн анхан шатны гэрч тул түүний аюулгүй байдлыг хамгаалах нь хянан шийдвэрлэх ажиллагааг шударга явуулахад хамгийн чухал хүчин зүйл юм.

Хохирогчийг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг Эрүүгийн хуулийн 228А дугаар зүйлд тусгаж, хохирогчид тодорхой эрхийг өгдөг. Тухайлбал, бэлгийн хүчирхийллийн хохирогчийн хувийн мэдээллийг хэвлэн нийтлэхийг хориглодог, харин хохирогч өөрөө зөвшөөрсөн бол хэвлэн нийтэлж болно. Хохирогчийн хувийн мэдээллийг ил болгох нь хохирогч цаашдаа нийгмийн амьдралд оролцоход олон хүндрэлтэй асуудал тулгардаг тул энэ хуулийн заалт нь хохирогчийг болон хохирогчийн гэр бүлийг хамгаалахад тусалдаг ажээ. Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр хохирогчийн хувийн мэдээллийг нийтэлсэн буюу задруулсан бол гэм буруутай этгээдийг 2 хүртэлх жилээр хорино.

Энэтхэг Улсын Дээд шүүх нь хохирогчийг хамгаалах, нуух, түүний хувийн мэдээллийг задруулахгүй байхтай холбоотой олон арга хэмжээ авдаг. Тухайлбал, шүүх нь эхнэр-нөхөр, эмч-өвчтөн, өмгөөлөгч-үйлчлүүлэгчийн харилцаа холбоог задруулахаас хамгаалдаг.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

²¹⁰ Protection of Victims. <https://www.legalserviceindia.com/legal/article-9628-protection-of-victims.html>

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation for Victims of Gross Violations of International Human Rights Law and Serious Violations of International Humanitarian Law (Basic Principles and Guidelines). UN General Assembly resolution 60/147 of 16 December 2005.
- <https://documents.un.org/doc/undoc/gen/n05/496/42/pdf/n0549642.pdf?token=LZcAWpT43QSo6ixSUq&fe=true>
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц. <https://legalinfo.mn/mn/detail/1242>
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал. <https://legalinfo.mn/mn/detail/1271>
- Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрэм. <https://legalinfo.mn/mn/detail/1217>
- Международно-правовая защита прав человека в вооруженных конфликтах. Управление Верховного комиссара ООН по правам человека. Нью-Йорк и Женева, 2011 год. www.ohchr.org
- IHL and human rights law (29 October 2010). What is the difference between IHL and human rights law? (22 January 2015). International Committee of the Red Cross. www.icrc.org
- Keburiya K.O., Solntsev A.M. The Significance of the 2005 UN Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation. Moscow Journal of International Law. 2021;(2):78-98. <https://doi.org/10.24833/0869-0049-2021-2-87-98>
- Implementing Victims' Rights: A Handbook on the Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation. The Redress Trust. March 2006. <https://redress.org/wp-content/uploads/2018/01/MAR-Reparation-Principles.pdf>

Канад Улс

- Гэмт хэргийн хохирогчдын эрхийг хамгаалах Холбооны Омбудсмений газар: www.victimfirst.gc.ca/index.html
- www.victimfirst.gc.ca/abt-apd/hwhv-cnav.html
- www.victimfirst.gc.ca/serv/vrc-dvc.html
- Хохирогчийн эрхийг хамгаалах хууль: laws-lois.justice.gc.ca/eng/acts/c-23.7/page-1.html

Өмнөд Солонгос Улс

- Эрүүгийн хууль
- Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах тухай хууль
- Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны тухай хууль

- Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сангийн тухай хууль
- Гэмт хэргийн хохирогчийг хамгаалах сангийн үйл ажиллагааны тухай хууль
- Төрөөс нөхөн төлбөр олгох тухай хууль
- fgn.kics.go.kr/en/jsp/cva/crimeVictimAssistance01.jsp
- www.spo.go.kr/site/eng/02/10201000000002018120606.jsp

Филиппин Улс

- Үндсэн хууль: <http://hrlibrary.umn.edu/research/Philippines/PHILIPPINE%20CONSTITUTION.pdf>
- Хохирогч, гэрчийг хамгаалах тухай хууль: <https://cjad.nottingham.ac.uk/en/legislation/411/keyword/321/>
- Хохирогчдын эрхийг хангах Нэхэмжлэлийн зөвлөл байгуулах тухай хууль: <https://legacy.senate.gov.ph/lisdata/2428620887!.pdf>

Энэтхэг Улс:

- Constitution of 1950: <https://legislative.gov.in/constitution-of-india/>
- Penal Code, 1860: www.indiacode.nic.in/bitstream/123456789/2263/1/aA1860-45.pdf
- Code of Criminal Procedure, 1973: www.indiacode.nic.in/handle/123456789/16225?view_type=search&col=123456789/1362
- Protection of Women from Domestic Violence Act, 2005: www.indiacode.nic.in/handle/123456789/2021
- Scheduled Castes and the Scheduled Tribes (Prevention of Atrocities) Act, 1989: www.indiacode.nic.in/handle/123456789/1920
- Maintenance and Welfare of Parents and Senior Citizens Act, 2007: www.indiacode.nic.in/handle/123456789/2033
- Protection Of Rights Of Victims In Criminal Justice System: www.legalserviceindia.com/legal/article-9643-protection-of-rights-of-victims-in-criminal-justice-system.html
- Protection of Victims: www.legalserviceindia.com/legal/article-9628-protection-of-victims.html
- A Critical Study On Victim Compensation Under Various Laws Of India: www.legalserviceindia.com/legal/article-6103-a-critical-study-on-victim-compensation-under-various-laws-of-india.html
- Compensatory Jurisprudence: www.legalservicesindia.com/article/1888/Compensatory-Jurisprudence.html#google_vignette

**ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧИН:
ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА МОНГОЛ УЛСЫН
БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэ, Г.Билгээ, Д.Халиун,
Ц.Ариунаа, Э.Билгүүн, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл,
П.Уранчимэг, Т.Эрдэнэчимэг, Х.Очир*

АГУУЛГА

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ


СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. АРДЧИЛСАН ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧИН: ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

- 1.1.Нэр томъёоны тодорхойлолт
- 1.2.Сөрөг хүчин буюу хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх асуудал
- 1.3.Сөрөг хүчний тэргүүний парламент дахь байр суурь
- 1.4.Сөрөг хүчний тэргүүнийг томилох асуудал
- 1.5.Сөрөг хүчний эрх, үүрэг
 - 1.5.1.Засгийн газарт хяналт тавих
 - 1.5.2.Төрийн байгууллагуудын томилгоотой холбоотой эрх
 - 1.5.3.Сөрөг хүчний тэргүүний бусад эрх, үүрэг
- 1.6.Цөөнхийн хориг тавих болон зөвшилцөх эрх

ХОЁР. ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 2.1.Австрали Улс
- 2.2.Герман Улс
- 2.3.Нидерланд Улс
- 2.4.Өмнөд Солонгос Улс
- 2.5.Финланд Улс
- 2.6.Франц Улс



ГУРАВ. УИХ ДАХЬ ОЛОН НАМЫН ОРОЛЦОО БА УИХ ДАХЬ ЦӨӨНХИЙН
БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1.УИХ дахь олон намын оролцоо (1990-2020 он)

3.2.УИХ дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн талаарх эрх зүйн
орчин

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ. УИХ-ын тухай хуулиудад намын бүлэг, цөөнхтэй холбоотой
үндсэн зохицуулалт тусгагдаж ирсэн талаарх харьцуулалт



УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний 1.1.3-т “Улсын Их Хурал нь цөөнхийг хүндэтгэж, түүний үйл ажиллагаанд хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлж, Улсын Их Хурлын гишүүд, ажлын албаны ажилтнуудын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах талаар анхаарч ажиллах” гэж, 5.1.2-т “Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэл бүхий нотолгоонд суурилсан судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангаж дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний хүрээлэн байгуулах асуудлыг шийдвэрлэх” гэж заасан.

Мөн Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний 3.6.1-т “Улсын Их Хурал шийдвэрээ шинжлэх ухааны үндэслэлтэй, дүн шинжилгээ бүхий судалгаа шинжилгээ, баримт нотолгоонд тулгуурлан гаргахад дэмжлэг үзүүлэх үр нөлөөтэй механизм бүрдүүлэх” гэж заасан.

Дээрх стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх болон Монгол Улсын Их Хурлын багц хуулийн төслүүдийг боловсруулж, хэлэлцүүлэх үйл явцад судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд “Парламент дахь цөөнхийн бүлэг буюу сөрөг хүчин: онол арга зүй, олон улсын чиг хандлага, Монгол Улсын болон гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт” сэдэвт төлөвлөгөөт судалгааны ажлыг гүйцэтгэв.

Судалгааны зорилго

- 1) парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, үйл ажиллагааны онол арга зүйн үндэс, олон улсын жишиг, сайн туршлага, эрх зүйн зохицуулалтын суурь зарчмуудыг судлах;
- 2) гадаадын зарим улсын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын талаарх туршлагыг харьцуулан судлах;
- 3) Монгол Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт шинэчлэлтийн товчоон болон өнөөгийн нөхцөл байдлыг судлах.

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгаанд ардчилсан парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагааны онол, арга зүйн үндэслэл, эрх, үүрэг, олон

улсын жишиг болон сайн туршлагыг Олон Улсын Парламентын Холбоо (IPU), Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)-ээс гаргасан зөвлөмж, судалгааны тайлан, дүгнэлт, мөн Монгол Улсын болон дор дурдсан (Австрали, Герман, Нидерланд, Өмнөд Солонгос, Финланд, Франц) улс орнуудын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагааны эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судалсан болно.

Судалгааны бүтэц

Судалгаа нь хураангуй болон үндсэн хэсэгтэй. Судалгааны үндсэн хэсэг нь гурван бүлэгтэй:

- *нэгдүгээр бүлэгт*, ардчилсан парламентад цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үүрэг роль: цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн статус, эрх, үүрэг, үйл ажиллагааны онол, арга зүйн үндэслэл, олон улсын жишиг, сайн туршлага, эрх зүйн зохицуулалтын суурь зарчмууд;
- *хоёрдугаар бүлэгт*, гадаадын зарим улсын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын талаарх туршлага;
- *гуравдугаар бүлэгт*, Монгол Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх, үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт шинэчлэлтийн товчоон болон өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг тус тус судалсан болно.

Түлхүүр үг: парламент, парламентын бүлэг, парламент дахь сөрөг хүчин, сөрөг хүчний нам, сөрөг хүчний тэргүүн, хууль тогтоох цөөнх, парламент дахь цөөнх.

Key words: parliament, parliamentary group, opposition in parliament, opposition party, leader of the opposition, legislative minorities, minorities in parliament.



СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Ардчилсан парламент дахь цөөнхийн бүлэг буюу сөрөг хүчин: онол арга зүй, олон улсын чиг хандлагын талаар

Орчин үед ардчилал гэдгийг зөвхөн олонхын засаглал төдий биш, өргөн хүрээндээ хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалыг хүний үндсэн эрх, хууль дээдлэх ёс, төрийн эрх мэдлийн хяналт-тэнцэл, шударгаар захирах ёс, иргэдийн оролцоо, нээлттэй хэлэлцүүлэг зэрэг арга хэрэгслүүдтэй хосолсон улс төрийн тогтолцоо хэмээн тодорхойлж байна. Тиймээс ардчилсан улсууд парламент дахь сөрөг хүчин, эсхүл цөөнхийн эрх, үүрэг, хариуцлагыг албан ёсоор үндсэн хууль болон бусад хуулиараа хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байдаг. Хэлбэрийн хувьд зарим улсын үндсэн хуульд сөрөг хүчин, эсхүл цөөнх, тэдгээрийн эрх, үүргийн талаар зөвхөн ерөнхий байдлаар тусгаж ихэнх нарийвчилсан зохицуулалтыг парламентын болон дэгийн хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлж байна. Энэтхэг зэрэг цөөн улсууд үндсэн хуулиараа нарийвчлан зохицуулсан байдаг.

“Сөрөг хүчин”, “парламент дахь цөөнх”-ийн тухай ойлголт, тэдгээртэй холбоотой зохицуулалтууд нь засаглалын хэлбэр, төрийн байгууламж, эрх зүйн бүл зэргээс хамаарч зарим тохиолдолд ижил төстэй, зарим тохиолдолд өөр өөр утга агуулгаар томъёологдсон байх төдийгүй үндсэн зохицуулалтуудын хувьд ч харилцан ялгаатай талуудтай байна. Иймд парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн орчныг дараах байдлаар ангилж үзэж болохоор байна. Үүнд:

Эрх зүйн бүлээс хамаарч:

- *Вестминстерийн загвар бүхий ардчилсан парламент (Далайн буюу Англо-Америкийн эрх зүйн бүл) дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* Парламент дахь сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, парламентын дотор болон гадна тодорхой эрх дарх олгодог. Сөрөг хүчний тэргүүн нь өөрийн “Сүүдрийн Засгийн газар” байгуулж, харгалзах сайд нарыг сөрөг хүчний гишүүдээс томилон ажиллуулдаг. Өөрөөр хэлбэл, сөрөг хүчнийг алтернатив засгийн газар буюу хүлээгдэж буй засгийн газрын түвшинд авч үздэг бөгөөд өнөөдрийн сөрөг хүчний тэргүүн, хэрэв дараагийн сонгуульд нам нь ялбал, маргаашийн ерөнхий сайд болох магадлалтай гэсэн үг;
- *олон намын төлөөлөлтэй ардчилсан парламент (Эх газрын буюу Ром-Германы эрх бүл) дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* Парламент дахь цөөнхийн буюу сөрөг хүчний бүлгүүд

гэдэг ойлголтыг авч үздэг. Сөрөг хүчний үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд цөөнхийн хойшлуулах журам, үндсэн хуулийн шүүхэд хандах, парламентын мөрдөн шалгах хороо байгуулах, улс төрийн намуудыг пропорционал харьцаагаар парламент доторх болон гаднах томилгоонд оролцуулах эрхийг хангах гэх мэт арга хэлбэрүүдийг ашигладаг.

Засаглалын хэлбэр, төрийн байгууламжаас хамаарч:

- *нэг танхимтай парламентын тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин);*
- *хоёр танхимтай парламентын тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* хоёр танхимтай парламентад сөрөг хүчний тэргүүн нь ихэвчлэн доод танхимын гишүүн байдаг;
- *дэд түвшний засаглалтай (subnational governments) буюу холбооны улсын тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* сөрөг хүчин янз бүрийн түвшинд зэрэгцэн оршдог;
- *ерөнхийлөгчийн засаглалтай болон холимог тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* засгийн эрх баригч буюу ерөнхийлөгчийн сонгогдсон нам парламентад олонхыг бүрдүүлээгүй байж болно. Тиймээс ерөнхийлөгчийн засаглалд сөрөг хүчний тэргүүн нь хууль тогтоох цөөнхөөс биш, олонхоос ч сонгогдож болдог. Өөрөөр хэлбэл, парламентын олонх нь сөрөг хүчний үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Олон улсын практикт сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг албан ёсоор хүлээн зөвшөөрч баталгаажуулах нь төрийн эрх мэдлийг хуваалцаж байгаа хэрэг биш харин юуны түрүүнд улс төрийн яриа хэлэлцээ хийх, мэтгэлцээн өрнүүлэх, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх, харилцан буулт хийж зөвшилцөх явдлыг дэмжих зорилготой хэмээн үзэж байна.

Сөрөг хүчин (цөөнхийн хүчин) нийтлэг байдлаар дараах эрх, үүрэг хэрэгжүүлдэг. Үүнд:

- хяналт шалгалт явуулах чиглэлээр:
 - асуулга, асуулт тавих;
 - засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг парламентаар хэлэлцүүлэх;
 - парламентын хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах;
 - комисс, мөрдөн шалгах түр хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах;
 - сөрөг хүчний өдрүүд зохион байгуулах.
- төрийн томилгоонд оролцох чиглэлээр:
 - шүүх засаглал болон 4 дэх засаглалтай холбоотой томилгоо;

- ерөнхийлөгчийг томилох (парламентын засаглалтай улсын хувьд);
- сөрөг хүчний сенаторуудыг томилох.
- хориг тавих эрхээ хэрэгжүүлэх болон зөвшилцөх чиглэлээр:
 - хэт олонх буюу цөөнхийн хоригийн зарчим;
 - цөөнх нь хуулийн хэрэгжилтийг хойшлуулах механизм;
 - цөөнхийн хүсэлтээр санал асуулга явуулах;
 - цөөнхийн үндсэн хуулийн шүүхэд хандах эрх зэрэг эрх, үүргийг тус тус хэрэгжүүлдэг. Эдгээр эрх, үүргийн талаарх тодорхой мэдээллийг судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.

Судалгаанд авагдсан орнуудын туршлага

Энэхүү судалгаанд парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн бүл, дээр дурдсан засаглалын хэлбэр, төрийн байгууламжийн ангиллуудыг харгалзан төлөөллийг хангах үүднээс Австрали, Герман, Нидерланд, Өмнөд Солонгос, Финланд, Франц зэрэг улсуудыг сонгон авч хамруулсан болно.

Судалгаанд хамрагдсан улсуудын зарим онцлох асуудал, зохицуулалтуудыг тоймлон дурдвал:

Австрали Улсын парламентын тогтолцоо Вестминстерийн загварт суурилдаг тул Төлөөлөгчдийн Танхимд суудалтай хоёр дахь том нам, эвсэл албан ёсны сөрөг хүчин (opposition) болдог бөгөөд сөрөг хүчний тэргүүний эрх, үүрэг, статусыг чухалчилж үздэг. Сөрөг хүчний тэргүүн сүүдрийн Засгийн газрыг байгуулж тэргүүлэн сөрөг хүчний гишүүдээс сүүдрийн сайд нарыг томилон ажиллуулдаг.

Герман Улсын Бундестагийг сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдүүлдэг. Сонгогч бүр тойрогт нэр дэвшигчид болон намд санал өгөх эрхтэй. Сонгуулийн мажоритар системийн дагуу сонгуулийн тойрог бүрд анхны санал хураалтаас хамгийн их санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ. Парламентын үлдсэн суудлыг пропорционал төлөөллөөр хуваарилна. Пропорционал санал хураалтаар 5 хувиас доошгүй санал авсан, эсхүл мажоритар тогтолцооны дагуу гурваас доошгүй парламентын суудал авсан нам пропорционал төлөөллийн тогтолцооны дагуу парламентад суудал авах эрхтэй. Герман Улсын сонгуулийн систем нь аль нэг нам дангаараа засгийн газар байгуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг тул олон жижиг намууд нийлж олонхыг бүрдүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилготой “таван хувийн хориг” (the five percent hurdle) гэж нэрлэгддэг босготой байна. Энэ нь Бундестагт таваас доош хувийн төлөөлөлтэй нам намын бүлэг байгуулах боломжгүй ба бусад намтай эвсэх боломжгүй гэсэн үг юм.

Нидерланд Улсын Парламентын доод танхим буюу Төлөөлөгчдийн Танхим (Tweede Kamer) 150 гишүүнтэй. Тус танхимын гишүүдийг бүх ард түмнээс сонгуулийн пропорционал тогтолцоогоор шууд сонгодог. Нэг нам, эвслийн жагсаалтаас сонгогдсон гишүүдийг парламент дахь нэг бүлэг гэж үздэг бөгөөд нэг гишүүн сонгогдсон байсан ч тухайн гишүүнийг дангаараа парламент дахь бүлэг гэж тооцдог байна.

Өмнөд Солонгос Улс нь ерөнхийлөгчийн засаглалтай, нэг танхимтай парламенттай. Парламент буюу Үндэсний Ассамблейн нэг намын 20-оос дээш гишүүн, эсхүл өөр өөр намын мөн тооны гишүүд нэгдэн нийлж намын бүлэг байгуулж болдог бөгөөд бүлгийн гишүүд нам болон бүлгийн харьяаллаа солих, шилжих бүрэн чөлөөтэй байдаг ажээ. Үндэсний Ассамблей дахь бүлэг бүр өөрийн төлөөлөх этгээд (Representative Member)-ээ сонгох бөгөөд тухайн сонгогдсон гишүүн нь улс төрийн намын дарга буюу, эсхүл улс төрийн намын төлөөлөгчөөс ялгаатай юм. Бүлэг төлөөлөх этгээд нь шууд Төрийн байгуулалт (House Steering Committee)-ын болон Тагнуул (Intelligence Committee)-ын хорооны гишүүн болдог байна.

Финланд Улс парламентын засаглалтай. Парламент нэг танхимтай, 200 гишүүнтэй. Гишүүдийг олон мандат бүхий 12 тойргоос хувь тэнцүүлэх буюу нээлттэй нэрийн жагсаалт бүхий пропорционал тогтолцоогоор сонгодог. Парламентын бүлэг хамгийн багадаа 3 гишүүнтэйгээр байгуулагдах боломжтой боловч гишүүн бүр заавал бүлэгт харьяалагдах үүрэггүй байдаг. Намын бүлгийн гишүүдийн тоо нь зарим тохиолдолд чухал ач холбогдолтой байдаг. Тухайлбал, 20-оос доошгүй гишүүнтэй бүлэг л Засгийн газар, сайдуудын эрхлэх асуудлын хүрээнд тэдгээрт асуулт, асуулга тавих эрхтэй байдаг.

Франц Улс нь хагас ерөнхийлөгчийн засаглалтай, 2 танхим бүхий парламенттай. Доод танхим буюу Үндэсний Ассамблей нь 577 депутаттай. Бүрэн эрхийн хугацаа нь 5 жил байх бөгөөд бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар сонгогддог. Нэг мандаттай тойргийн зарчмаар санал хураалтын хоёр шаттай мажоритар системээр сонгодог. Парламент дахь сөрөг хүчин (opposition groups) болон цөөнхийн бүлгийн (minority groups) албан ёсны статусыг Үндсэн хуулиараа баталгаажуулан хуульчилсан байдаг бөгөөд парламент дахь сөрөг хүчин болон цөөнхийн бүлгийн асуудлыг ялгаж заагласан. Парламент дахь бүлгүүдээс өөрсдийгөө “сөрөг хүчин”-ээр зарлаж улс төрийн мэдэгдэл гарган Улсын Ерөнхийлөгчид уламжилснаар тухайн бүлгийг албан ёсны сөрөг хүчин гэж үздэг. Энэхүү мэдэгдлийг хэдийд ч гаргаж болохоос гадна мөн эгүүлэн татаж болдог. Харин парламент дахь хамгийн олон гишүүнтэй бүлгээс бусад өөрсдийгөө сөрөг хүчнийх гэж зарлаагүй бүлгийг цөөнхийн бүлэг гэж үздэг. Цөөнх болон сөрөг хүчний бүлгийн статус ерөнхийдөө ойролцоо боловч сөрөг

хүчинд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцох эрх илүү олгогдсон байдаг ажээ.

Эдгээр улсуудын албан ёсны цөөнхийн бүлэг (сөрөг хүч)-ийн гишүүдийн тооны доод хязгаарыг авч үзэхэд харилцан адилгүй янз бүр байна. Жишээлбэл: огт тоо заагаагүй (Австрали), 1 (Нидерланд), 3 (Финланд), 8 (Монгол), 15 (Франц), 20 (Өмнөд Солонгос), нийт суудлын 5 хувь буюу 37 (Герман) зэрэг байна. Түүнчлэн парламентын цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн гишүүдийн намын харьяалал, шилжих хөдөлгөөний хувьд ч харьцангуй чөлөөтэй (БНСУ, Финланд), эсхүл хатуу хязгаарлалттай (Герман, Нидерланд) зохицуулалттай байна. Судалгаанд хамрагдсан улсуудын харьцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1-ээс үзнэ үү.

Монгол Улс парламентын засаглалтай, нэгдмэл төрийн байгууламжтай, үндэсний эрх зүйн тогтолцоо нь Ром-Германы бүлд харьяалагддаг учраас манай энэхүү өвөрмөц онцлогт илүү тохирсон эрх зүйн зохицуулалт бүхий улсууд нь Герман, Финланд байна.

Монгол Улсын Их Хурлын цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн талаар

1990 оноос өмнөх үед Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Ардын Их Хурал (АИХ) нь тухайн үеийн Үндсэн хуулиар хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага байсан боловч нэг нам, нэг үзэл суртлын авторитар тогтолцоотой байсан учраас парламентын бүлэг, цөөнхийн талаарх ойлголт байхгүй байсан.

Монгол Улсад 1990 оны 07 дугаар сард анх удаа олон намын оролцоотой анхны чөлөөт, ардчилсан сонгууль болж АИХ-ыг шинэчлэн байгуулж байсан. Энэхүү АИХ “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль батлан гаргаж, хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын Бага Хурал (УБХ)-ыг байгуулсан. БНМАУ-ын АИХ-ын 430 депутатаас сонгогдсон 50 гишүүнтэй УБХ нь 1990-1992 онд бүрэн эрхээ хэрэгжүүлж, Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн байгууллыг шинэтгэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. УБХ нь Монгол Улсын байнгын ажиллагаатай анхны парламент юм.

1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хуулийн дагуу нэг танхимтай парламентын тогтолцоонд шилжсэнээс хойш эдүгээ 8 дахь парламентын бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд Монгол Улсын Их Хурлын тухай хууль (МУИХтХ) 1992, 1997, 2001, 2006, 2020 онуудад 5 удаа, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (МУИХЧХДтХ) 1997, 2007, 2020 онуудад 3 удаа тус тус шинэчлэгдэн

батлагдаж байсан. Эдгээр хуулиудад Улсын Их Хурал (УИХ) дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой гол ойлголт, нэр томъёонууд болон зохицуулалтууд агуулга, цар хүрээний хувьд өргөжин төгөлдөрших байдлаар тусгагдаж ирсэн байна.

Тухайлбал:

- **1992 оны МУИХтХ-д:** Намын бүлэг гэдгийг “Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал бүхий нам бүлэг байгуулж болно.” гэж томъёолж, намын бүлгийн эрх, үүргийг тодорхойлсон, мөн “Улсын Их Хурлын дарга Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар намуудын бүлгийн ахлагч нартай зөвшилцсөнөөр Улсын Их Хурал өөрийн гишүүдээс сонгон Байнгын хороог байгуулна.” гэсэн зохицуулалт оруулсан;
- **1997 оны МУИХтХ-д:** Энэ хуульд анх УИХ дахь “Олонх”, “Цөөнх”-ийн ойлголт, тэдгээрийн харилцааг зохицуулж эхэлсэн. Түүнчлэн “Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэгт ордог Улсын Их Хурлын гишүүдээс сонгоно.” заалт оруулсан;
- **2001 оны МУИХтХ-д:** 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “...Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.” гэсэн зохицуулалт орсонтой холбоотойгоор энэхүү асуудлыг нарийвчлан тусгаж ирсэн;
- **2006 оны МУИХтХ-д:** УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл, бүлгийн ажлын албаны зохицуулалтыг дараах байдлаар тусгасан. Үүнд: “Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.”; “Бүлэг нь бодлогоо боловсруулах, зохион байгуулалтын тусалцаа авах чиг үүрэг бүхий ажлын албатай байна.”;
- **2020 оны МУИХтХ-д:** 2019 онд Үндсэн хуульд “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэсэн нэмэлт орсон. Үүнтэй холбоотойгоор

2020 оны УИХтХ-д “...хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор хойшлуулахгүйгээр байгуулна.”

Ийнхүү парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-тэй холбоотой “намын бүлэг”, “намын бүлгийн эрх, үүрэг”, “цөөнх”, “нам, эвслийн бүлэг тус бүрээс УИХ-ын дэд даргыг сонгох”, “байнгын хорооны бүрэлдэхүүнийг нам, эвслийн бүлэгт хуваарилах”, “Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг цөөнхийн бүлгээс сонгох”, “Хянан шалгах түр хороо байгуулахдаа цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулах”, “нам, эвслийн бүлэг ажлын албатай байх, “УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөлийн бүрэлдэхүүнд нам, эвслийн бүлгийн дарга орох” зэрэг ойлголт, зохицуулалтууд тухайн цаг үеийн шаардлага болон олон улсын нийтлэг жишгээс үүдэлтэйгээр тухай бүр МУИХтХ-даа тусгагдаж иржээ.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан улсуудын парламент дахь намын бүлэг, цөөнхийн зохицуулалтын харьцуулалт

Улс, Парламент	Эрх зүйн орчин	Парламент дахь бүлэг	Бүлгийн зорилго	Бүлгийн удирдлага ба ажлын алба
Австрали Улс (Төлөөлөгчдийн Танхим)	-Үндсэн хууль; -Үндсэн хуулийн конвенц; -Төлөөлөгчдийн Танхимын практик; -Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэг.	Парламентад хамгийн олон суудал авсан улс төрийн нам олонхын бүлгийг байгуулж Засгийн газраа байгуулна. Харин парламентад суудалтай хоёр дахь том нам (намуудын эвсэл) сөрөг хүчний бүлэг байгуулна.	Бүлгийн зорилго нь хууль тогтоомжийн төсөл болон улс төрийн ач холбогдолтой асуудлыг хэлэлцэхэд туслахад чиглэнэ. Бүлэг нь тухайн улс төрийн намаас сонгогдсон гишүүд, сенаторуудаас бүрддэг ба төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх эрх мэдэлтэй.	Сөрөг хүчний бүлгийн удирдагч нь төрийн өндөр албан тушаалтны жагсаалтын 10 дугаарт бичигддэг бөгөөд сөрөг хүчний үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Тэрээр сүүдрийн Засгийн газрыг тэргүүлэх, сөрөг хүчний гишүүдээс сүүдрийн Засгийн газрын сайд нарыг сонгох, бүлгийг хуралдуулж төрийн бодлого, хуулийн төслүүдийг санаачлан хэлэлцэх, урьдчилан мэдэгдэлгүйгээр Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд асуулт асуух зэрэг эрх мэдэлтэй.
Герман Улс (Бундестаг)	- Үндсэн хууль; - Улс төрийн н;амын тухай хууль; - Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль; - Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хууль.	Бундестагийн нийт суудал (735)-ын хамгийн багадаа 5 хувиас доошгүй суудал (36-37 орчим) авсан улс төрийн нам бүлэг байгуулна. Мөн улс төрийн үзэл баримтлал, зорилгоороо нэгдмэл, аль ч мужид хоорондоо өрсөлддөггүй намын харьяалалтай гишүүд нийлж Бундестагт хамтарсан нэг намын бүлэг байгуулж болно.	Парламентын засаглалтай ардчилсан улсад намын бүлэг нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын талаар мэтгэлцээн өрнүүлэх, Бундестагийн гишүүдийн өргөн барьсан хуулийн төслүүдэд санал өгөх зэрэг нь үндсэн зорилго болдог.	Бундестаг дахь намын бүлэг бүр гишүүдийнхээ дундаас бүлгийн даргыг сонгох бөгөөд намын бүлэг байгуулсан тухай, түүний албан ёсны нэр, намын бүлгийн даргын нэр, гишүүдийн нэрс зэргийг Бундестагийн ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

<p>Нидерланд Улс (Төлөөлөгчдийн Танхим)</p>	<p>-Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн журам.</p>	<p>Пропорционал сонгуулийн системээр намын нэг жагсаалтаас сонгогдсон гишүүдийг парламент дахь нэг бүлэг гэж үзнэ. Жагсаалтаас нэг гишүүн сонгогдсон байсан ч тухайн гишүүнийг дангаараа Парламент дахь бүлэг гэж тооцдог.</p>	<p>Сөрөг хүчний намууд ихэвчлэн парламентын хороод дахь төлөөллөөрөө дамжуулан хууль тогтоомж, засгийн газрын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн намын бүлгүүд хууль тогтоох үйл явцад хувь нэмрээ оруулж, Засгийн газарт хариуцлага тооцох, хяналт тавих боломжийг олгодог.</p>	<p>Парламентын бүлгийн дарга нар Тагнуул, Аюулгүй байдлын хорооны гишүүд байна. Парламент дахь бүлэг бүр гүйцэтгэх хорооныхоо бүрэлдэхүүний талаар Парламентын даргад мэдээлнэ. Намын бүлгүүд нарийн бичиг, шинжээч, хэвлэл мэдээллийн ажилтан гэх мэт бүлгийн ажилтнуудын цалинд зарцуулагддаг төсөвтэй байдаг.</p>
<p>Өмнөд Солонгос Улс (Үндэсний Ассамблей)</p>	<p>-Үндсэн хууль; -Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act); -Улс төрийн намын тухай хууль (Political Parties Act).</p>	<p>Үндэсний Ассамблейд 20-оос дээш гишүүнтэй улс төрийн нам бүлэг (negotiating party) байгуулна. Аль нэг бүлэгт харьяалалгүй 20 болон түүнээс дээш тооны гишүүд нэгдэн нийлж тусдаа бүлэг байгуулж болно.</p>	<p>Бүлгийн зохион байгуулалтын үндсэн зорилго нь улс төрийн нам, эвсэл, тэдгээрийн бүлгийн гишүүдийн дунд үр дүнтэй яриа хэлэлцээ хийх, мэдээлэл шуурхай түгээх, дамжуулах болон солилцох нээлттэй суваг бий болгох, ингэснээрээ парламентын хууль тогтоох үйл ажиллагааг илүү хялбар, үр дүнтэй болгоход чиглэгддэг.</p>	<p>Үндэсний Ассамблей дахь бүлэг бүр өөрийн төлөөлөх этгээдийг сонгох бөгөөд тухайн этгээд нь улс төрийн намын дарга буюу, эсхүл намын төлөөлөгчөөс ялгаатай. Бүлэг төлөөлөх этгээд шууд Төрийн байгуулалтын болон Тагнуулын хорооны гишүүн болдог. Бүлэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлэг тус бүрд бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтныг томилон ажиллуулдаг. Тус ажилтныг бүлэг төлөөлөх этгээдийн санал болгосноор Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.</p>

<p>Финланд Улс (Парламент)</p>	<p>-Үндсэн хууль; -Парламентын дэгийн тухай дүрэм.</p>	<p>Парламентын бүрэн эрхийн хугацаанд парламентын бүлэг хамгийн багадаа 3 гишүүнтэйгээр байгуулагдана.</p>	<p>Парламентын бүлэг нь практик түвшинд парламентын үйл ажиллагаанд хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг. Парламентаар хэлэлцэгдэж буй аливаа асуудлыг гишүүд бүлгийн хуралдаанаараа хэлэлцэж, тухайн асуудалд бүлэг ямар байр суурь баримтлахаа шийддэг.</p>	<p>Парламентын бүлгүүд нь дарга, дэд даргатай байх бөгөөд бүлгийн даргын үүрэг нь бүлгийнхээ байр суурийг парламентын бусад бүлгүүдээр хүлээн зөвшөөрүүлэх, харилцан зөвшилцөж, хамтран ажиллах явдал юм.</p>
<p>Франц Улс (Үндэсний Ассамблей)</p>	<p>-Үндсэн хууль; -Үндэсний Ассамблейн Хуралдааны дэгийн тухай хууль.</p>	<p>Үндэсний Ассамблейн гишүүд өөрсдийн улс төрийн адил төстэй байдлыг харгалзан бүлэг байгуулж болно. Бүлэг байгуулахад хамгийн багадаа 15 гишүүнтэй байна.</p>	<p>Засгийн газарт сөрөг хүчний үзүүлэх нөлөө нь парламентын хяналтыг хэрэгжүүлэх оролцоогоор хангагддаг бөгөөд энэ нь эрх мэдлийг хуваарилах тогтолцооны хяналт, тэнцвэрийн механизм төдийгүй олонх, цөөнхийн хоорондын мэтгэлцээний арга хэлбэр болдог.</p>	<p>Бүлэг нь өөрсдийн томилсон дотоод алба, захиргааны хэрэг эрхлэх газартай байж болно. Тэдгээрийн дүрэм, байр, тоног төхөөрөмж, албан хаагчдынх нь Үндэсний Ассамблейд танхимд нэвтрэх асуудлыг бүлгийн дарга, Квесторын санал болгосны дагуу Үндэсний Ассамблейн Тамгын газар тогтооно.</p>
<p>Монгол Улс (Улсын Их Хурал)</p>	<p>-Монгол Улсын Үндсэн хууль; -Монгол Улсын Их Хурлын тухай хууль; - Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль.</p>	<p>Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд наймаас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулж болно. Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.</p>	<p>Нам, эвслийн бүлэг (цөөнх) нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж шийдвэрлэх зарчмыг хангуулах зорилготой.</p>	<p>Нам, эвслийн бүлэг даргаа дотроосоо сонгоно. Бүлгийн дарга нь Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн гишүүн байна. Бүлэгт бодлого боловсруулахад нь туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын алба байна. Бүлгийн ажлын албаны ажилтны тоо тухайн бүлгийн гишүүдийн тооны 1/2-тай тэнцүү байх бөгөөд хэрэв бүлгийн гишүүдийн тоо 23-аас доош бол 12 хүртэл байна.</p>

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. АРДЧИЛСАН ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧИН: ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА²¹¹

Орчин үед ардчиллыг зөвхөн олонхын засаглал төдий зүйл биш, хууль тогтоох (парламент) болон гүйцэтгэх засаглал (засгийн газар)-ыг үндсэн эрх, хууль дээдлэх ёс, хяналт, тэнцвэрт байдал, шударгаар захирах ёс, иргэдийн оролцоо, нээлттэй хэлэлцүүлгийн арга хэрэгсэлтэй хослуулсан улс төрийн тогтолцоо хэмээн тодорхойлж байна.

Ардчилсан нийгэмд сөрөг хүчний намуудын эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мөн шүүх болон төрийн албаны хараат бус байдлыг дэмжих гэх мэт үйл ажиллагаа явуулах эрхийг үндсэн хуулиар зөвшөөрч хамгаалсан байдаг. Энэ нь тэдэнд засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандахад тэгш эрх эдлэх, энэхүү хандлага нь гэмт хэрэгт тооцогдохгүй, дарамт шахалтад өртөхгүй бөгөөд хохирохгүй байх баталгаа болдог.

Тиймээс ихэнх улсууд үндсэн хуулиараа сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ нь улс төрийн олон ургалч үзлийн зарчмыг баримтлах (эрх мэдлийг аль нэг нам дангаар эзэмшиж болохгүй), ардчилсан яриа хэлэлцээ, мэтгэлцээн хийхийг тууштай дэмжих буюу өөрөөр хэлбэл шийдвэр гаргахдаа бусад намуудын дуу хоолойг сонсох боломжийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Үндсэн хуульт ардчилсан улсуудын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийг хүлээн зөвшөөрч, тэдний эрх, үүргийн талаарх асуудлыг үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд авч үздэг.

1.1. Нэр томъёоны тодорхойлолт

Юуны түрүүнд “сөрөг хүчин” болон “парламент дахь цөөнх” (хууль тогтоох цөөнх) гэсэн нэр томъёоны талаар авч үзье. Эдгээр нь засаглалын хэлбэрээс хамаарч зарим тохиолдолд ижил, зарим тохиолдолд өөр тусдаа ойлголтууд байдаг.

Ихэнх тохиолдолд, ялангуяа парламентын засаглалын тогтолцоонд ижил ойлголтыг илэрхийлдэг. Учир нь энэ тогтолцооны хувьд ерөнхий сайд нь парламентад олонх болсон нам, эвслээс сонгогдох ба парламент дахь цөөнхийн нам, эвсэл нь засгийн газар буюу гүйцэтгэх засаглалыг

²¹¹ Opposition and Legislative Minorities: Constitutional Roles, Rights and Recognition. International IDEA. <https://www.idea.int/sites/default/files/publications/opposition-and-legislative-minorities-constitutional-roles-rights-recognition.pdf>

шүүмжилж эсрэг байр суурь илэрхийлэгч болдог. Өөрөөр хэлбэл парламентад тодорхой тооны суудал авсан нам, эвслүүд албан ёсоор парламентын бүлэг байгуулах бөгөөд олонхыг бүрдүүлсэн нам, эвслийн бүлэг нь эрх баригч хүчин буюу олонх, бусад нам, эвслийн бүлэг нь сөрөг хүчин буюу цөөнх болдог байна.

Харин ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглалын тогтолцоонд төрийн тэргүүн нь парламент дахь цөөнхийн нам, эвслээс нэр дэвшин томилогдсон, эсхүл сонгогдсон тохиолдолд парламент дахь бусад нам нь сөрөг хүчин болдог. Өөрөөр хэлбэл, парламент дахь цөөнх бус, харин олонх нь ерөнхийлөгчийн эсрэг байр сууриа илэрхийлж сөрөг хүчний үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс энэ тогтолцооны хувьд “хууль тогтоох цөөнх” гэдэг нэр томъёо тохирохгүй, харин “сөрөг хүчин” гэх нэр томъёог хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, “хууль тогтоох цөөнх” (парламент дахь цөөнх) болон “сөрөг хүчин” гэсэн нэр томъёонууд өөр өөр ойлголтыг илэрхийлнэ.

Сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг улсуудад “сөрөг хүчин” гэж сөрөг хүчний тэргүүнийг сонгосон парламент дахь хамгийн том буюу гол сөрөг хүчний намыг хэлдэг бөгөөд түүнийг албан ёсоор сөрөг хүчинд тооцдог.

Мөн дээрх албан ёсны сөрөг хүчний намаас гадна “сөрөг хүчний нам”-д парламентад суудал авсан бөгөөд засгийн газрын эсрэг байр суурь илэрхийлдэг бусад намуудыг хамруулдаг.

Зарим тохиолдолд засгийн эрх баригч болон албан ёсны сөрөг хүчний намуудын дараа орох сөрөг хүчний хоёр дахь том намыг “гуравдагч сөрөг хүчний нам” гэж нэрлэдэг. Харин парламент дахь суудлын тоогоор эдгээрээс бага байх бусад сөрөг хүчний намуудыг “бага сөрөг хүчний нам” (minor opposition parties)-ууд гэж нэрлэх жишиг байдаг.

Түүнчлэн олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний нам гэсэн ойлголтод хууль тогтоох байгууллага буюу парламентад төлөөлөлгүй намуудыг ч багтаах хандлага байдаг. (the extra-legislative opposition буюу хууль тогтоох эрхгүй сөрөг хүчин).

1.2.Сөрөг хүчин буюу хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх асуудал

Ардчилсан улсуудад сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх нь цөөнхийн эрх, үүрэг, үйл ажиллагааны талаарх ойлголт нь тухайн тогтолцооны онцлогоос хамаарч ялгаатай байдаг. Тухайлбал, парламентын болон ерөнхийлөгчийн засаглалд сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн тэргүүн ижил байр суурьтай байдаггүй.

Хэдийгээр заримдаа өөр байх боловч, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний тэргүүний тухай ойлголт нь парламентын засаглал, мажоритар тогтолцоо, Их Британийн түүхэн уламжлалт улс төрийн тогтолцоотой нягт холбоотой гэж үздэг.

Бусад институцийн хувьд буюу ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглал, пропорционал төлөөллийн тогтолцоо бүхий парламентын засаглалд хууль тогтоох цөөнхийг чадавхжуулах бусад арга хэрэгсэл ашиглах нь илүү түгээмэл байдаг. Гэхдээ ерөнхийлөгчийн тогтолцоотой цөөн тооны улсад сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрч, түүнд томоохон эрх мэдлийг олгодог байна.

Хэлбэрийн хувьд зарим улсын үндсэн хуульд сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх болон тэдгээрийн эрх, үүргийн талаар зөвхөн ерөнхий байдлаар тусгаж, парламентын дэгийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд нарийвчилсан асуудлыг тодорхойлдог бол зарим улсын үндсэн хуульд нарийвчлан заасан байдаг.

Ардчилсан улсуудад сөрөг хүчнийг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй улс төрийн тогтолцооны амин чухал элемент гэж үнэлдэг. Сөрөг хүчний намууд нь бодлогын хөтөлбөрт шинэ асуудлуудыг оруулах, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, засгийн газарт хариуцлага тооцох, сонгогчдод мэдээлэл өгөх, идэвхжүүлэх болон сонголтоо хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Үр дүнтэй сөрөг хүчин нь засгийн газарт алдаа гаргахаас зайлсхийх, эсхүл алдаагаа хурдан засаж залруулахад тус дөхөм болдог бөгөөд ингэснээр засаглалын үр дүн сайжирна гэж үздэг.

Түүнчлэн олон улсын туршлагад, бодлого боловсруулах ажилд хувь нэмрээ оруулах чадамжтай хууль тогтоох цөөнх нь бодлогыг илүү хүртээмжтэй, илүү хариу үйлдэлтэй болгож чадна гэж үздэг. Учир нь чадварлаг бөгөөд эрх мэдэлтэй сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхтэй байж ардчилсан зарчмаар хэлэлцүүлэг, мэтгэлцээн хийх боломж бүрддэг. Аливаа шийдвэрийг эрх баригч олонх гаргадаг боловч сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхтэй байх нь тэднийг сонсох, олон нийтэд санал бодлоо илэрхийлэх, гаргасан шийдвэрийг нягтлах боломж өгдөг байна.

Олон улсын практикт сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх нь эрх мэдлийг хуваах явдал биш гэж үздэг бөгөөд энэ нь юуны түрүүнд улс төрийн яриа хэлэлцээ, мэтгэлцээн, хяналт, хариуцлага, харилцан буултыг дэмжих зорилготой байна.

1.3.Сөрөг хүчний тэргүүний парламент дахь байр суурь

Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний тэргүүнийг томилох процедур болон түүний парламент дахь байр суурь засаглалын хэлбэрээс хамаарч харилцан адилгүй байна.

Вестминстерийн загвар бүхий ардчилсан парламентад

Энэхүү тогтолцооны хувьд парламентын доод танхимд олонхын суудалтай нам, эвслийн тэргүүн гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийг ерөнхий сайдаар ахлуулсан сайд нарын танхимд төвлөрүүлдэг. Тиймээс ерөнхий сайд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх бүх үйл ажиллагааг удирдаж байдаг. Ерөнхий сайд болон сайд нарын танхим нь засгийн газрын бодлого, үйл ажиллагааг парламентын доод танхимын өмнө хариуцдаг боловч албан үүргээ гүйцэтгэх хугацаанд доод танхимын олонхын дэмжлэгт найддаг байна.

Вестминстерийн загвар бүхий ардчилсан улсуудын үндсэн хуульд, ялангуяа 1950-аад оноос хойш батлагдсан үндсэн хуулиудад сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрч, түүний парламент доторх болон гаднах эрх мэдлийн талаар тусгасан байх нь түгээмэл ажиглагддаг. Мажоритар тогтолцоонд сөрөг хүчин шаардлагатай хяналт, тэнцвэрийг хангаж, ерөнхий сайдын удирдлагыг автократ болохоос сэргийлнэ гэж үздэг. Энэ тогтолцооны хувьд сөрөг хүчний гүйцэтгэдэг чухал үүрэг бол улс төрд эрх мэдлийг зохицуулах болон эрх мэдлийн төлөө өрсөлдөх гэсэн хоёрдмол үүрэг юм.

Сөрөг хүчин нь зохицуулагч хүчний хувьд засгийн газрын бодлогод нөлөөлж, засгийн газраас сөрөг хүчний ашиг сонирхлыг харгалзан үзэхийг шаардах эрхтэй бөгөөд энэ нь илүү сайн, илүү хүртээмжтэй, илүү өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн бодлогын шийдвэр гаргахад нөлөөлдөг байна.

Харин өрсөлдөгч хүчний хувьд сөрөг хүчин нь засгийн газарт хяналт тавьж, алдаа дутагдлыг нь олон нийтэд ил тод болгоход анхаарахын зэрэгцээ алдаа гаргасан тохиолдолд засгийн газарт хариуцлага хүлээлгэх боломжтой. Түүнээс гадна Вестминстерийн загвартай улсуудад сөрөг хүчнийг алтернатив засгийн газар, эсхүл хүлээгдэж буй засгийн газрын түвшинд авч үздэг. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн Сөрөг хүчний тэргүүн, хэрэв дараагийн сонгуульд нам нь ялбал, маргаашийн ерөнхий сайд болох магадлалтай гэсэн үг.

Ихэнх Вестминстерийн загвар бүхий ардчилсан улсад “сүүдрийн засгийн газар”-ыг байгуулдаг уламжлалтай. Ерөнхий сайдын зэрэгцээ Сөрөг хүчний тэргүүнтэй байхаас гадна сөрөг хүчин өөрийн бодлогоо Засгийн газрын тодорхой бүтэц, нэгжтэй уялдуулан илэрхийлэх үүрэг бүхий сөрөг хүчний парламентын гишүүдээс бүрдсэн хороо ажиллуулдаг байна. Тухайлбал, Засгийн газрын Гадаад хэргийн сайдтай зэрэгцээд Сөрөг хүчний гадаад хэргийн сайд ажилладаг. Канадад ийм үүрэг бүхий сөрөг

хүчний гишүүдийг “шүүмжлэгчид” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь тэдний үүргийн нэг хэсэг болох засгийн газрын үйл ажиллагааг шүүмжилж, хянах ажлыг удирдан чиглүүлдэг байна. Гэхдээ шүүмжлэх нь “Сүүдрийн засгийн газар”-ын цорын ганц үүрэг биш бөгөөд энэ нь сөрөг хүчинд хүлээгдэж буй засгийн газрын алтернатив үүргийг гүйцэтгэх боломжийг олгож байдаг.

Гэсэн хэдий ч дараагийн сонгуульд сөрөг хүчний тэргүүн ерөнхий сайдаар томилогдвол “Сүүдрийн засгийн газар”-ын гишүүдийг жинхэнэ Засгийн газрын бүрэлдэхүүнд томилох үүрэг хүлээдэггүй байна.

Олон нам бүхий ардчилсан парламентад

Парламентын тогтолцоо, ялангуяа эх газрын Европын уламжлалт парламентын тогтолцоотой улсуудын хувьд парламент нь нийгмийн янз бүрийн бүлгүүдийн үзэл бодол, эрх ашгийг илэрхийлэгч олон намын төлөөллөөс бүрддэг. Ийм нөхцөлд ганц сөрөг хүчний тэргүүн гэхээс илүү сөрөг хүчний намуудын тэргүүнүүд гэж авч үздэг. Энэ тохиолдолд сөрөг хүчний намуудын тэргүүнүүд намынхаа илтгэгч, засгийн газрыг шүүмжлэгч, эвслийн хэлэлцээний төлөөлөгчийн хувьд янз бүрийн үүрэг гүйцэтгэж болох ч тэд Вестминстерийн загвар дахь сөрөг хүчний тэргүүнтэй ижил статустай байдаггүй, мөн дараагийн сонгуулиар ерөнхий сайд болох ч албагүй.

Энэ тогтолцооны хувьд сонгуулийн систем нь пропорционал, эсхүл мажоритар байж болно. Түүхийн хувьд авч үзвэл, энэ тогтолцоонд эерэг, сөрөг талын аль аль нь ажиглагддаг. Тухайлбал, Францын Гурав дахь Бүгд Найрамдах Улсын үед парламентыг бүрдүүлэхдээ сонгуулийн мажоритар системийг ашигласан. Тухайн үед олон намтай улс төр эмзэг, эвслийн Засгийн газартай байсан бөгөөд сөрөг хүчний тэргүүн нь тодорхойгүй байжээ. Үүний эсрэг жишээ нь, Шинэ Зеланд, Фижи зэрэг улсууд сонгуулийн пропорционал системтэй (одоо ч хэрэглэж байгаа) боловч хамгийн том сөрөг хүчний намын даргыг сөрөг хүчний тэргүүнээр томилж, ирээдүйд ерөнхий сайд болно гэсэн хүлээлт хадгалагдсаар байна.

Олон нам бүхий парламентын тогтолцоонд улс төрийн сөрөг хүчний эрх хэмжээг өөр арга хэлбэрээр зохицуулсан байдаг. Тухайлбал, цөөнхийн хойшлуулах журам, үндсэн хуулийн шүүхэд хандах, парламентын мөрдөн шалгах хороо байгуулах, улс төрийн намуудыг пропорционал харьцаагаар парламент доторх болон гаднах томилгоонд оролцуулах эрхийг хангах арга хэлбэрийг ашиглаж байна.

Ерөнхийлөгчийн болон засаглалын холимог тогтолцооны үед

Ерөнхийлөгчийн засаглалтай буюу эсхүл холимог тогтолцоонд сөрөг хүчний тэргүүний эрх зүйн байдал, эрх, үүргийг парламентын

тогтолцооныхоос ялгах хоёр чухал шинж байдаг гэж үздэг. Нэгдүгээрт, засгийн эрх баригч буюу ерөнхийлөгчийн нам нь парламентад олонхыг бүрдүүлээгүй байж болно. Тиймээс ерөнхийлөгчийн засаглалд сөрөг хүчний тэргүүн нь хууль тогтоох цөөнхөөс биш, олонхоос ч сонгогдож болдог. Өөрөөр хэлбэл, парламентын олонх нь сөрөг хүчний үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Хоёрдугаарт, сөрөг хүчний тэргүүн нь дараагийн сонгуулиар заавал ерөнхийлөгчид өрсөлдөх албагүй. Учир нь ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах тусгай журамтай байдаг тул нэр дэвших хүмүүс нь парламентын гишүүн бус этгээд ч байж болно.

Ийм тогтолцоотой зарим улсад үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний тэргүүн нь гүйцэтгэх засаглалыг тэргүүлдэг ерөнхийлөгч (шууд сонгогдсон)-тэй зэрэгцэн ажиллах тохиолдол бас байдаг. Үүнд, Буркина Фасо, Мадагаскар, Нигер, Сенегал, Сейшелийн арлууд, Шри-Ланка, Уганда, Замби, Зимбабве зэрэг улсууд багтана.

Ерөнхийлөгчийн засаглалтай зарим улсад парламент дахь цөөнхийн тэргүүний байр суурийг хуулийн хүрээнд албан ёсоор хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, Кенийн Үндсэн хуулийн 108 дугаар зүйлд “Цөөнхийн намын дарга нь Үндэсний Ассамблейн хоёр дахь том нам, эвслийн удирдагч байна.” гэж заасан байдаг. Эндээс харахад, дээр өгүүлсэн сөрөг хүчний тэргүүнээс ялгаатай нь Үндэсний Ассамблейд авсан суудлын тооноос хамаарч байна.

1.4.Сөрөг хүчний тэргүүнийг томилох асуудал

Вестминстерийн загвар бүхий улсуудад (жишээ нь, Австрали, Канад, Энэтхэг, Малайз) сөрөг хүчний тэргүүн нь эртнээс уламжлан ирсэн улс төрийн албан тушаал бөгөөд хууль тогтоомж, эсхүл парламентын шийдвэрээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг боловч түүний эрх, үүргийг парламентын эрх ямба, эсхүл уламжлалт ёс заншлын асуудал гэж үздэг байв. Харин 1950-аад оноос хойш батлагдсан шинэ үндсэн хуулиудад сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, томилох журам, бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг заадаг болсон.

Сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн тэргүүний талаар АНУ-ын адил хуучны үндсэн хуулиудад тусгаагүй байдаг бол Кени, Сенегал, Сейшелийн арлууд зэрэг улсуудын шинэчлэгдсэн үндсэн хуулиудад тусгасан байдаг.

Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний тэргүүнийг томилох асуудал засаглалын хэлбэрээс хамаарч өөр өөр байна.

Парламентын засаглалтай улсуудад

Парламентын засаглал бүхий ардчилсан улсуудад сөрөг хүчний тэргүүнийг сонгох журам янз бүр байдаг ч ерөнхийдөө парламентын доод танхим дахь хамгийн том сөрөг хүчний намыг тэргүүлдэг парламентын гишүүнийг томилдог зарчимтай. Тухайлбал, Мальтын Үндсэн хуулийн 90 дүгээр зүйлд²¹² зааснаар тус улсын Ерөнхийлөгч нь сөрөг хүчний тэргүүнээр Төлөөлөгчдийн Танхим дахь тооны хувьд бусад сөрөг хүчний намуудаас хамгийн олон суудалтай намын дарга бүхий гишүүнийг томилно. Хэрэв сөрөг хүчин байхгүй, эсхүл хоёр ба түүнээс дээш тооны сөрөг хүчний намууд тэнцүү тооны суудал авсан бол засгийн газрын эсрэг байр суурьтай гишүүдийн бүлэг дотроос хамгийн олон дэмжлэг авсан гишүүнийг Ерөнхийлөгч сөрөг хүчний тэргүүнээр томилно.

Үүнээс үзэхэд, сөрөг хүчний тэргүүнийг томилоход сонголт багатай бөгөөд парламентад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн том сөрөг хүчний намтай тохиолдолд тус намын дарга бөгөөд парламентын гишүүнийг шууд томилдог.

Сөрөг хүчний тэргүүнээр томилогдсон гишүүн парламент (2 танхимтай бол доод танхим) дахь хамгийн том сөрөг хүчний намын даргын албан тушаалыг давхар хашдаг. Өөрөөр хэлбэл, намын даргын албан тушаалаасаа буусан, эсхүл парламентын гишүүний бүрэн эрх нь дуусгавар болсон бол сөрөг хүчний тэргүүний эрх, үүрэг мөн дуусгавар болно.

Ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглалтай улсуудад

Ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглалтай улсуудад сөрөг хүчний тэргүүн (Ерөнхийлөгчийн эсрэг байр суурьтай) ба парламент дахь цөөнхийн бүлгийн дарга (парламент дахь олонхоос бусад) хоёрын ялгааг ойлгох нь чухал байдаг.

Ерөнхийлөгчийн засаглалд хууль тогтоох цөөнх болон сөрөг хүчин гэсэн ойлголтууд нь үргэлж ижилхэн байдаггүй. Учир нь ерөнхийлөгчийг дэвшүүлэн гаргасан нам нь парламент дахь цөөнх байх боломжтой. Тийм учраас сөрөг хүчний тэргүүнийг томилох, ажиллуулах тухай журмыг боловсруулахдаа энэ ялгааг анхаарах хэрэгтэй байдаг. Гүйцэтгэх засаглалын тэргүүнээр ерөнхийлөгч ажиллаж байгаа тохиолдолд сөрөг хүчний тэргүүнээр өөр намаас сонгох нь зохистой ба ингэснээр гүйцэтгэх засаглалд хяналт тавих боломжтой. Тухайлбал:

- Сейшлийн Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд зааснаар сөрөг хүчний тэргүүнийг Үндэсний Ассамблейн гишүүдийн дундаас

²¹² Constitution of Malta. <https://legislation.mt/eli/const/eng>

сонгох бөгөөд ингэхдээ зөвхөн Ерөнхийлөгчийн намаас бусад намын харьяалалтай гишүүд л сонгогдох болон санал өгөх эрхтэй.

- Мадагаскарын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар парламент дахь сөрөг хүчний бүлгүүд хоорондоо тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хамгийн олон санал авсан сөрөг хүчний бүлгийн даргыг албан ёсны сөрөг хүчний тэргүүнд тооцно. Энэхүү “сөрөг хүчин” гэсэн нэр томъёо нь Ерөнхийлөгчийн эсрэг байр сууриа илэрхийлдэг гишүүд (Өөрөөр хэлбэл, парламент дахь Ерөнхийлөгчийг дэвшүүлэн гаргасан намаас бусад намуудын төлөөллүүд) хамаардаг.

Дээрх зохицуулалтуудаас гадна тухайн цаг үе, нөхцөл байдлын улмаас бий болсон зарим “стандарт бус” зохицуулалтууд байдаг. Тухайлбал:

- **Урвахын эсрэг заалт (anti-defection clause):** Доминикийн Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд зааснаар Парламентын гишүүн нь гишүүнээр дахин сонгогдсон тохиолдолд сөрөг хүчний тэргүүнд нэр дэвших эрхтэй байдаг. Энэ нь засгийн эрх баригч намын гишүүн нь намаасаа гарч, улмаар сөрөг хүчний тэргүүн болохоос зайлсхийх арга болдог (Учир нь 2018 онд Барбадост ийм тохиолдол гарч байсан). Энэ нь Доминикийн улс төрийн тогтвортой байдал, намын сахилга бат, парламентын тогтолцооны бүрэн бүтэн байдлыг дэмжих зорилготой ажээ.
- **Парламентаас гадуурх сөрөг хүчин:** 2016 онд Гренадын Парламентад сөрөг хүчингүй, дан нэг намын төлөөлөл сонгогджээ. Үүнээс үүдэн парламентын гаднаас сөрөг хүчний тэргүүнийг томилох тухай өөрчлөлтийг Үндсэн хуульдаа оруулах санал гарсан боловч бүх нийтийн санал асуулгаар дэмжигдээгүй ажээ. Хэрэв энэ санал дэмжигдсэн бол хамгийн олон санал авсан сөрөг хүчний намын дарга нь сөрөг хүчний тэргүүнээр томилогдож, улмаар Парламентын гишүүн болох байв.
- **Сөрөг хүчний гишүүдийн тооны доод хэмжээ (Minimum size of the opposition):** Энэтхэгийн Парламент дахь сөрөг хүчний тэргүүний цалин, тэтгэмжийн тухай хуульд (1977 он) заасны дагуу сөрөг хүчний тэргүүнээр парламентын хоёр танхим дахь хамгийн том сөрөг хүчний намын дарга ажиллана. Гэхдээ парламентын доод танхим болох Лок Сабха (Ардын Танхим)-гийн даргын шийдвэрээр тухайн нам нь хамгийн багадаа танхимын гишүүдийн 10 хувийг бүрдүүлсэн байхыг шаардсан. Хэрэв сөрөг хүчний нам энэ шаардлагыг хангаагүй бол сөрөг

хүчний тэргүүний суудлыг сул үлдээдэг байв. Гэвч 1985 онд энэхүү шийдвэрийг хууль бус гэж үзээд Үндсэн хуулийн 52 дахь удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болгожээ. Тухайн үед албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний тэргүүн маш их хэрэгтэй байсан боловч сөрөг хүчний гишүүдийн тоо заасан хэмжээнд хүрэхгүй байсны улмаас ардчилсан зарчмаар яриа хэлэлцээ, мэтгэлцээн явуулах боломжгүй нөхцөл байдал үүсчээ. Өөрөөр хэлбэл, энэ нь Үндсэн хуулийн хоёрдмол утгатай, эсхүл учир дутагдалтай зохицуулалтууд сөрөг хүчнийг “байхгүй мэт болгоход” хүргэж болдгийн жишээ юм. Ийм нөхцөл байдал дахин үүсэхээс сэргийлэхийн тулд Үндсэн хуульд сөрөг хүчний тэргүүнийг дэмжих гишүүдийн доод хэмжээг зааж болохгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Хоёр танхим бүхий парламенттай улсуудад

Хоёр танхимтай парламентад сөрөг хүчний тэргүүн нь ихэвчлэн парламентын доод танхимын гишүүн байдаг (Өөрөөр хэлбэл, ард түмнээс сонгогдсон гишүүн). Түүхэн талаас нь авч үзвэл, сөрөг хүчний тэргүүн нь дээд танхимын гишүүн байж болох ч Вестминстерийн загварын ихэнх ардчилсан улсуудад ерөнхий сайдыг доод танхимаасаа сонгодог тул сөрөг хүчний тэргүүнийг мөн доод танхимаас сонгодог байна. Зарим хоёр танхимт парламентад сөрөг хүчний тэргүүн нь парламентын хоёр танхимд зэрэгцэн ажиллах тохиолдол байдаг. Жишээлбэл, Энэтхэгт Парламент дахь сөрөг хүчний тэргүүний цалин, тэтгэмжийн тухай хуулийн дагуу Лок Сабха (Ардын Танхим, доод танхим) болон Ража Сабха (Төрийн Зөвлөл, дээд танхим) нь тус тусдаа сөрөг хүчний тэргүүнтэй. Австралид мөн үүнтэй адил Төлөөлөгчдийн Танхим (доод танхим) болон Сенат (дээд танхим) дахь сөрөг хүчний тэргүүн нар тусдаа байдаг.

Парламентад хоёр танхимд тусдаа сөрөг хүчний тэргүүнтэй ч гагцхүү доод танхимын сөрөг хүчний тэргүүн л албан ёсны байх бөгөөд бүрэн хэмжээний эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх давуу эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл, доод танхим дахь сөрөг хүчний тэргүүн нь албан ёсоор парламентын дотор болон гадна талд сөрөг хүчнийг удирддаг бол дээд танхим дахь сөрөг хүчний тэргүүн нь тус танхим дахь сөрөг хүчний ерөнхий төлөөлөгч, эсхүл сөрөг хүчний үйл ажиллагааны менежер байна. Зарим тохиолдолд Зимбабвегийн Парламенттай адил парламентын хоёр танхим дахь сөрөг хүчний тэргүүн нарын эрх, үүрэг, хариуцлага адил байдаг.

Гуравдагч болон жижиг намуудыг, бие даагчдыг хүлээн зөвшөөрөх асуудал

Сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрдөг ихэнх ардчилсан улсуудын хувьд парламентад хамгийн их суудалтай хоёр намаас гадна гуравдагч болон бусад жижиг намуудын төлөөлөл байдаг. Тийм учир албан ёсны сөрөг хүчний тэргүүнээс гадна парламентад суудалтай бусад намуудын дарга нарыг хүлээн зөвшөөрөх асуудал үүсдэг.

Олон улсын туршлагаас үзэхэд, албан ёсны сөрөг хүчний эрх ашгийг дэмжих зарим арга хэлбэрийг бусад сөрөг хүчний намууд бас хэрэгжүүлэх боломжтой байна. Тухайлбал, парламентын хороодын албан тушаалын хуваарилалт, сөрөг хүчний өдрүүд, парламентын болон намын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг сөрөг хүчний намуудад хуваарилах зэрэг зохицуулалтыг парламент дахь бусад сөрөг хүчний намууд мөн адил хэрэгжүүлдэг байна. Их Британид сөрөг хүчний хоёр дахь том намын дарга нь ихэвчлэн Privy council зөвлөлийн гишүүний хувьд тангараг өргөдөг. Соломоны арлуудын Үндсэн хуульд (66 дугаар хэсэг) Сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрөхөөс гадна бие даасан гишүүдийн тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг. Иймээс бие даасан гишүүдийн тэргүүнийг хүлээн зөвшөөрч чадвал бусад сөрөг хүчний намын тэргүүн ч мөн адил хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж үздэг байна.

Сөрөг хүчний тэргүүнийг шинээр томилох

Парламентын тухайн бүрэн эрхийн хугацаанд сөрөг хүчний намын дарга нас барсан, огцорсон, чөлөөлөгдсөн бол сөрөг хүчний тэргүүнээр ажиллах хугацаа мөн дуусгавар болох тул намын дараагийн дарга нь сөрөг хүчний тэргүүнээр ажилладаг. Ихэнх улсын, тухайлбал, Белиз, Доминик, Сент Люсия зэрэг улсуудын Үндсэн хуульд уг асуудлыг бас тусгасан байдаг.

Дэд түвшний засаглал (subnational governments)

Олон улсын туршлагаас харахад сөрөг хүчин гэх ойлголт нь хүчирхэг орон нутгийн засаг захиргаа, бүс нутгийн эрх мэдэл, холбооны систем гэх мэт дэд түвшний буюу орон нутгийн засаглалд ч зэрэгцэн оршиж байдаг. Энэ тохиолдолд улс үндэсний түвшнээс гадна орон нутгийн түвшинд сөрөг хүчний тэргүүний эрх, үүргийг хүлээн зөвшөөрөх эсэх асуулт урган гарч ирдэг байна. Тиймээс улс орнууд уг асуудлыг Үндсэн хууль болон орон нутгийн түвшний хууль тогтоомжуудад зэрэг тусгасан байдаг. Жишээлбэл, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 116.2-т мужийн түвшний хууль тогтоох байгууллагын хууль тогтоомжоор “хамгийн том сөрөг хүчний намын тэргүүн”-ийг сөрөг хүчний тэргүүний талаар зохицуулахыг хуульчилсан байна.

1.5.Сөрөг хүчний эрх, үүрэг

Ардчилсан улсууд үндсэн хуульдаа сөрөг хүчин болон сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, томилох асуудлыг зохицуулахаас гадна түүний эрх, үүрэг болон хариуцлагын талаар мөн зохицуулсан байдаг.

1.5.1.Засгийн газарт хяналт тавих

Ерөнхий сайдын асуулгын цагаар мэтгэлцэх эрх

Парламент дахь сөрөг хүчний тэргүүний хамгийн наад захын, олон нийтэд харагдахуйц үүрэг нь ерөнхий сайдын асуулгын цагаар асуулт асуух юм. Ерөнхий сайдын асуулга нь ихэвчлэн парламентын чуулганы хугацаанд долоо хоног бүр болдог бөгөөд парламентын гишүүд ерөнхий сайдаас цаг үеийн асуудлаар асуулт асууж, олон нийтийн анхаарлын төвд байгаа асуудлыг тодруулах, харин ерөнхий сайдын хувьд парламентад үйл ажиллагаагаа зөвтгөх, тайлбарлах боломжийг олгодог.

Ерөнхий сайдын асуулгын цагаар сөрөг хүчний тэргүүн нь эхэлж асуулт асуух давуу эрхтэй бөгөөд түүний дараа бусад сөрөг хүчний намын дарга нар асуулт асуудаг. Тэдний дараа л парламентын жирийн гишүүд (backbenchers – Засгийн газрын гишүүн бус, мөн сөрөг хүчний Сүүдрийн засгийн газрын гишүүн бус) асуулт асуух журамтай. Тиймээс сөрөг хүчний тэргүүн нь тухайн асуулгын өнгө аяс, чиглэлийг тогтоож, хэлэлцэх асуудалд нөлөөлөх боломжтой гэж үздэг. Мөн энэхүү мэтгэлцээний үйл явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулдаг тул мөн олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой байдаг.

Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар мэтгэлцэх эрх

Мөн засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаарх мэтгэлцээний эхэнд ихэвчлэн сөрөг хүчний тэргүүн эхэлж үг хэлэх давуу эрхтэй байдаг. Тухайлбал, Вестминстерийн загвар бүхий улсуудад сөрөг хүчний тэргүүн нь ийм мэтгэлцээний үеэр эхэлж үгээ хэлдэг. Парламентаар хэлэлцэх засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэл, хууль тогтоох хөтөлбөрийг тодорхойлсон энэхүү илтгэлийг парламентын чуулганы нээлтийн үеэр төрийн тэргүүн, эсхүл амбан захирагч тавьдаг уламжлалтай. Үүний дараа засгийн газрын бодлогын талаарх мэтгэлцээн өрнөж, улмаар засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явагддаг журамтай.

Тиймээс энэхүү мэтгэлцээн нь сөрөг хүчний тэргүүнд засгийн газрын хөтөлбөр болон гүйцэтгэлд бүхэлд нь эргэлзэх, итгэл хүлээлгэж болох эсэхийг засгийн газраас нотлохыг шаардах боломжийг тогтмол (жил бүр) олгодог.

Парламентын хороон дахь сөрөг хүчний оролцоо

Парламентын ихэнх ажлыг, ялангуяа хууль тогтоох, хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэх зэрэг ажлыг парламентын хороод гүйцэтгэдэг. Парламентын хороодыг бүрдүүлэхдээ парламентад суудалтай намуудыг өргөн хүрээнд хамруулдаг байна. Өөрөөр хэлбэл, хороодын албан тушаалыг олонх болон сөрөг хүчний намуудад парламентад авсан суудлын дагуу хувь тэнцүүлэн хуваарилах нь түгээмэл жишиг юм. Хороодын бүрэлдэхүүнийг ихэвчлэн үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эсхүл парламентын шийдвэрээр тогтоодог. Зарим улсын үндсэн хуульд засгийн газар, сөрөг хүчин хоорондын тэнцвэрийг хангах ерөнхий дүрмийг заадаг. Тухайлбал, Мальтын Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд Парламентын хороод нь нийгмийн ач холбогдол бүхий асуудлыг хянаж шалгадаг тул хороодыг бүрдүүлэхдээ Парламентын гишүүдийн хуваарилалтыг шударгаар хийхийг заасан байдаг. Үүний нэгэн адил Тунисын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд Хороодыг пропорционал төлөөллийн аргаар бүрдүүлэхээр хуульчилсан бол Сьерра-Леоны Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд Хороодын бүрэлдэхүүнд парламент дахь улс төрийн намууд болон бие даагч гишүүдийг хамруулахаар заасан байна.

Парламентын хороодын даргын албан тушаалыг засгийн эрх баригч болон сөрөг хүчний намуудад пропорционал хуваарилах хандлагатай байдаг. Тухайлбал, Шинэ Зеландад Парламентын нийт хороодын тал орчим хувийг нь сөрөг хүчний гишүүд даргалдаг (албан ёсны сөрөг хүчин, эсхүл сөрөг хүчний намуудын аль нэг) бол Австралид ихэвчлэн хорооны даргаар засгийн эрх баригч намаас, дэд даргаар сөрөг хүчний намаас сонгогддог. Гадаад улсуудын туршлагаас үзэхэд, уг асуудлыг үндсэн хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрч зохицуулсан байна. Тухайлбал, Мадагаскарын Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд хороодын 1/3-ээс доошгүйг нь сөрөг хүчний гишүүд даргалахаар хуульчилсан байна.

Мөн зарим улсын үндсэн хуульд парламентын хорооны даргатай холбоотой тусгай зохицуулалтуудыг тусгасан байна. Энэ нь ихэвчлэн санхүү, төсөвт хяналт тавих хороодод үйлчилнэ. Вестминстерийн загвар бүхий парламентад санхүүгийн хороог сөрөг хүчний гишүүн даргалах нь түгээмэл байдаг. Тухайлбал, Тринидад Тобагогийн Үндсэн хуулийн 119 дүгээр зүйлд “Улсын төсвийн хорооны дарга нь Төлөөлөгчдийн Танхим дахь сөрөг хүчний гишүүн байна” гэж, Тунисын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлд Санхүүгийн хорооны дарга, Гадаад харилцааны хорооны илтгэгчээр сөрөг хүчний гишүүнийг томилохоор заасан байна.

Мөрдөн шалгах хороон дахь сөрөг хүчний давуу эрх

Зарим улсын үндсэн хуульд парламентын цөөнх, эсхүл тодорхой тооны гишүүдийн хүсэлт, шаардлагаар парламентын мөрдөн шалгах хороо

байгуулахыг зөвшөөрдөг. Энэ нь сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн гарт байгаа хүчирхэг хэрэгсэл болж, бодлогын шийдвэрээ сайтар хянаж шалгах боломжийг олгодог. Тухайлбал:

- Португалд Парламентын гишүүн бүр чуулганы хугацаанд нэг удаа мөрдөн шалгах хороо байгуулах санал гаргаж болох ба хэрэв гишүүдийн 1/5 нь уг саналыг дэмжсэн бол мөрдөн шалгах хороо байгуулна. (Үндсэн хуулийн 178 дугаар зүйл);
- Мозамбикт Парламент дахь бүлэг болгон мөрдөн шалгах хороо байгуулах санал гаргаж болно (Үндсэн хуулийн 197 дугаар зүйл);
- Тунист Парламент дахь сөрөг хүчин нь жил бүр мөрдөн шалгах хороо байгуулж, түүнийг удирдах эрхтэй (Үндсэн хуулийн 61 дүгээр зүйл);
- Гүржид Парламентын гишүүдийн 1/5 нь хүсэлт гаргаж, 1/3 нь зөвшөөрснөөр мөрдөн шалгах хороо байгуулна. (Үндсэн хуулийн 42 дугаар зүйл). Үүний дагуу сөрөг хүч нь парламентын мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх мэдэлтэй болдог. Гүржийн Парламент дахь бүх бүлгүүдээс хамгийн багадаа нэг гишүүн нь мөрдөн шалгах хороонд ажиллах бөгөөд энэ нь сөрөг хүчний бүлгүүдэд олонх байх баталгаа болдог.

Сөрөг хүчний үйл ажиллагаанд зориулсан тусгай өдөр

Зарим улсад парламентын хуралдааны тодорхой өдрүүдийг бусад үйл ажиллагаанд тусгайлан хуваарилдаг. Тухайлбал, сөрөг хүчинд мөрийн хөтөлбөрөө тодорхойлох боломж олгодог “Сөрөг хүчний өдөр” нь Вестминстерийн загвар бүхий зарим улсад олон жилийн турш хэрэгжиж байна. Их Британид жил бүр Парламентын чуулганы 20 орчим өдрийг “Сөрөг хүчний өдөр”-т зориулдаг. Үүнээс дийлэнх өдрүүд нь албан ёсны сөрөг хүчинд (хамгийн том сөрөг хүчин), бусад өдрүүд нь бусад сөрөг хүчинд хуваарилагддаг байна.

2009 оноос хойш Парламентын жирийн гишүүдэд (Засгийн газрын гишүүн бус, мөн сөрөг хүчний Сүүдрийн засгийн газрын гишүүн бус) зориулж нам дамнасан хорооноос²¹³ санал болгосон асуудалтай холбоотой нэмэлт өдрүүдийг (backbench business day) хуваарилдаг болжээ. Түүнээс гадна хувь гишүүнд зориулж тусад нь Парламентын цаг гаргаж болох бөгөөд энэ нь гишүүдэд хууль санаачлах ажлыг илүү үр дүнтэй хийх боломж олгох зорилготой.

Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний намуудад парламентын хуралдааны цагийн тодорхой хэсгийг ийнхүү тусгайлан зориулдаг зарчмыг үндсэн хуулиар зохицуулж байна. Тухайлбал, Мароккогийн

²¹³ Нам дамнасан бүлэг нь хоёр ба түүнээс дээш улс төрийн намын гишүүдээс бүрдэнэ.

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд сөрөг хүчний “хууль тогтоох үйл ажиллагаанд үр дүнтэй оролцох, ялангуяа парламентын хоёр танхимын хэлэлцэх асуудлын дараалалд хуулийн төслийг оруулах замаар”, өөрөөр хэлбэл, парламентын цагийн хуваарьт сөрөг хүчний өргөн мэдүүлсэн болон дэмжсэн хуулийн төслүүдээ оруулах эрхийг баталгаажуулжээ. Сейшлийн арлуудад Үндэсний Ассамблейн дарга нь хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоохын өмнө сөрөг хүчний тэргүүнтэй заавал зөвлөлдөх ёстой байдаг.

1.5.2. Төрийн байгууллагуудын томилгоотой холбоотой эрх

Үндсэн хуулиар зохицуулж болох өөр нэг чухал асуудал бол төрийн байгууллагуудын томилгооны асуудал юм. Үүнд, шүүх, сонгуулийн хороо, хилийн комисс, төрийн албаны комисс зэрэг байгууллагын томилгоо орно.

Шүүх засаглал болон дөрөв дэх засаглалын томилгоо (judicial and fourth-branch institutions)

Энэ нь засгийн газар, төрийн болон нам бус байгууллагуудын хоорондын зааг хязгаарыг тодорхой байлгах, тэдгээрийг дан ганц засгийн газрын хяналтад байхаас сэргийлэх зарчим юм. Олон улсын практикт, парламентын олонхын засгийн газарт бодлогоо тодорхойлох, хөтөлбөрөө хэрэгжүүлэх эрх, боломж олгодог хэдий ч улс төрийн тогтолцоог бүхэлд нь хяналтдаа байлгаж, дангаар ноёрхохоос сэргийлж байх зарчмыг хэрэгжүүлдэг. Ялангуяа шүүхийн хараат бус байдал, засаг захиргааны төвийг сахисан байдал, сонгуулийн үйл явцын шударга байдлыг хангах ёстой ба эдгээртэй холбоотой томилгооны асуудалд сөрөг хүчин үүргээ хэрэгжүүлэх хэд хэдэн жишиг аргууд байдаг.

- **Зөвлөлдөх (consultative procedure):** Ихэнх тохиолдолд сөрөг хүчний тэргүүн томилгоонд зөвхөн зөвлөлдөх үүрэгтэй байдаг. Тухайлбал, Ямайкад Ерөнхий сайд нь Ерөнхий шүүгч, Давж заалдах шатны шүүхийн дарга, Төрийн албаны болон Цагдаагийн албаны комиссын гишүүд, Шүүх, хууль зүйн албаны комисст нэр дэвшүүлсэн 3 гишүүнийг томилохын өмнө сөрөг хүчний тэргүүнтэй заавал зөвлөлдөнө. Ерөнхий сайд Үндсэн хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу томилгоо хийхээс өмнө сөрөг хүчний тэргүүнтэй зөвлөлдөх ба зөвшөөрсөн тохиолдолд Ерөнхий амбан захирагч (Хааны нэрийн өмнөөс) уг томилгоог хийдэг. Хэрэв Сөрөг хүчний тэргүүн зөвшөөрөөгүй бол Ерөнхий амбан захирагч Ерөнхий сайдаас эргэн харахыг хүсэх ёстой. Гэсэн ч эцсийн шийдвэрийг Ерөнхий сайд гаргах бөгөөд сөрөг хүчний тэргүүн хориг тавих эрхгүй. Зөвлөлдөх процедурын үр нөлөө нь олон хүчин зүйлээс, тухайлбал, Ерөнхий сайд, сөрөг

хүчний тэргүүн нарын хувийн болон улс төрийн харилцаа, хоёр намын хамтын ажиллагааны улс төрийн зөвшлийн бэхжилт зэргээс хамаарна гэж үздэг.

- **Харилцан тохиролцох (concurrent procedure):** Энэ тохиолдолд ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүн томилгоо хийхдээ харилцан тохиролцох ёстой бөгөөд энэ нь сөрөг хүчний тэргүүнд хориг тавих боломж олгодог. Өөрөөр хэлбэл, томилогдохоор нэр дэвшсэн хүн нь хоёр талд хүлээн зөвшөөрөгдөх ёстой гэсэн үг. Энэ нь зөвлөлдөх процедуртай харьцуулахад түгээмэл бус байдаг. Гэсэн ч зөвлөлдөх аргаар үр дүнд хүрээгүй, эсхүл үр дүнд хүрэх магадлал багатай нөхцөлд харилцан тохиролцох нь илүү үр дүнтэйд тооцогддог.
- **Төлөөлөх (representative procedure):** Энэ нь Ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүний аль алинд нь тодорхой тооны томилгоо хийх боломжийг олгодог. Тухайлбал, Антигуа ба Барбудагийн Үндсэн хуулийн 63 дугаар зүйлд Хилийн тойргийн комиссын нийт 4 гишүүнээс нэг гишүүнийг сөрөг хүчний тэргүүн, хоёр гишүүнийг Ерөнхий сайд нэр дэвшүүлэх бөгөөд үлдсэн нэг гишүүнийг тус комиссын даргын санал болгосноор томилдог.
- **Хувь тэнцүүлэх (proportional procedure):** Энэ нь олон намтай нөхцөлд болон олон гишүүнтэй томилгоонд тохирсон төлөөлөх процедурын нэг төрөл юм. Энэ аргын зарчим нь томилгоо хийх үед намууд парламент дахь суудлын хувь хэмжээгээр пропорционал хувилбараар сонгодог, эсхүл томилдог. Тухайлбал, Австрид Омбудсмэний чиг үүргийг парламентын доод танхим болох Үндэсний Зөвлөлөөс сонгогддог гурван гишүүн бүхий зөвлөл гүйцэтгэдэг. Тус улсын Үндсэн хуульд зааснаар Үндэсний Зөвлөлд хамгийн олон мандаттай гурван нам тус бүр нэг гишүүнийг нэр дэвшүүлэх эрхтэй.
- **Томилгооны комисс байгуулах (appointments commission procedure):** Фижи, Балба, Сейшелийн арлууд, Шри-Ланка зэрэг улсад төрийн байгууллагуудын томилгооны асуудлыг авч хэлэлцэх үүрэг бүхий Томилгооны комисс байгуулж, бүрэлдэхүүнд нь сөрөг хүчний тэргүүнийг оруулдаг. Тухайлбал, Фижид ийм комисс нь Хүний эрхийн хороо, Ялгаварлан гадуурхалтын эсрэг хороо, Сонгуулийн хороо, Төрийн албаны комисс зэрэг байгууллагын гишүүнд болон Цагдаагийн комиссар, Ерөнхий аудитор зэрэг албан тушаалд нэр дэвшүүлэх үүрэгтэй. Комисс нь 6 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнд: Ерөнхий сайд, сөрөг хүчний тэргүүн, Ерөнхий прокурор, мөн Ерөнхий сайдын санал

болгосон хоёр хүн, сөрөг хүчний тэргүүний санал болгосон нэг хүн байна. Комиссын бүрэлдэхүүнд орж буй Ерөнхий прокурор нь Ерөнхий сайдын оролцоотой томилогддог албан тушаалтан тул энэ улсын хувьд комиссын 6 гишүүний 4-ийг нь засгийн эрх баригч талаас, 2-ийг нь сөрөг хүчнээс бүрдүүлж байна. Энэ тохиолдолд сөрөг хүчний зүгээс томилгоог хүлээн зөвшөөрөөгүй бол хориг тавих боломжгүй (дээр дурдсан зөвлөлдөх аргатай илүү төстэй). Харин Сейшлийн арлуудад Томилгооны комисст Ерөнхийлөгч болон сөрөг хүчний тэргүүн тус бүр хоёр гишүүнийг томилдог. Өөрөөр хэлбэл эрх баригч болон сөрөг хүчин тэнцүү төлөөлөлтэй байна. Сейшлийн арлуудын энэхүү зохицуулалт Фижигээс ялгаатай нь томилгоо хийхдээ сөрөг хүчнийг хяналт шалгалт хийх боломжоор хангадаг байна.

- **Сөрөг хүчинд олгох онцгой эрх (exclusive opposition appointments):** Зарим тохиолдолд, сөрөг хүчин томилгоо хийхэд зөвхөн оролцоод зогсохгүй томилох эрхтэй байна. Тухайлбал, Аргентинд Ерөнхий аудиторыг Үндэсний Конгресс дахь хамгийн том сөрөг хүчний намын саналаар томилдог.
- **Супер олонхын томилгоо (supermajority appointment procedure):** Сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхөд нэг гишүүнтэй байгууллагын томилгоонд санал өгөх боломжийг олгодог. Тухайлбал, Болгарт Шүүхийн дээд зөвлөлийн гишүүдийн тэн хагасыг Үндэсний Ассамблейн гишүүдийн 2/3-ын олонхын саналаар сонгодог (Үндсэн хууль, 130 дугаар зүйл). Португалд Үндсэн хуулийн шүүхийн 10 гишүүн, Омбудсмэн, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн ерөнхийлөгч, Шүүхийн дээд зөвлөлийн 7 гишүүн, хэвлэл мэдээллийн зохицуулах байгууллагын гишүүдийг сонгохдоо парламентын нийт гишүүдийн 2/3-ын олонхын саналаар шийдвэрлэнэ. (Үндсэн хууль, 163 дугаар зүйл).

Гүйцэтгэх засаглалыг тэргүүлдээгүй ерөнхийлөгчийг томилох (Appointment of ceremonial presidents)

Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалыг тэргүүлдэггүй бөгөөд нам бус төрийн тэргүүн байдаг парламентын бүгд найрамдах улсуудад ерөнхийлөгчийг томилохдоо сөрөг хүчний оролцоог хангадаг. Тухайлбал, Доминикт Ерөнхийлөгчийг Ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүн хамтран томилж болдог (Үндсэн хууль, 19 дүгээр зүйл) ба тэд нэг нэр дэвшигчид санал нийлсэн бол тухайн нэр дэвшигч шууд томилогдоно. Харин санал нийлээгүй бол Ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүний дэвшүүлсэн нэр дэвшигчдийн аль нэгийг сонгохын тулд Парламентад санал хураалт явуулна. Гэхдээ санал хураалтын үр дүнд Ерөнхий сайдаас нэр дэвшүүлсэн хүнийг сонгох магадлал өндөр гэж үздэг.

Сөрөг хүчний сенаторуудыг томилох

Карибын тэнгисийн хамтын нөхөрлөлийн ихэнх улсад сөрөг хүчний тэргүүний нэмэлт үүрэг нь тодорхой тооны сенаторуудыг томилох байдаг. Томилогдсон сенаторууд мэтгэлцээн явуулах, асуулт асуух, хорооны үйл ажиллагаанд оролцоходоо дээд танхимд сөрөг хүчний оролцоог баталгаажуулдаг. Сенаторын тооны хувьд улс орнууд харилцан адилгүй байна. Тухайлбал, Барбадосын Үндсэн хуулийн 36 дугаар зүйлд зааснаар нийт 21 сенаторын 2-ыг сөрөг хүчний тэргүүн, 12-ыг Ерөнхий сайд, 7 бие даагчийг Амбан захирагч томилдог. Тринидад ба Тобагод нийт 31 сенаторын 6-г нь сөрөг хүчний тэргүүн, 16-г нь Ерөнхий сайд, 9-ийг (намаас бус, нийгэм эдийн засгийн салбарт ажилладаг хүмүүсээс) нь Ерөнхийлөгч сонгодог. Энэ зарчимаар, нэг талаасаа засгийн эрх баригч талын сенаторууд хууль батлахад олонх байх, нөгөө талаасаа сөрөг хүчний сенаторууд нь бие даагч сенаторуудын хамт Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад хориг тавьж чадах боломж бүрддэг. Энэ нь Үндсэн хуулийн өөрчлөлтийг, наад зах нь хуулийн тодорхой заалтуудыг батлахын тулд заавал сөрөг хүчин болон бие даагчидтай зөвшилцөх ёстой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, засгийн газар бодлогоо тодорхойлж болох ч Үндсэн хуулийн өөрчлөлтийг дангаараа хийх боломжгүй байна.

1.5.3. Сөрөг хүчний тэргүүний бусад эрх, үүрэг

“Privy Council” зөвлөлдөх эрх

Их Британид сөрөг хүчний тэргүүн нь “Privy Council”-ийн гишүүний хувиар тангараг өргөдөг. Энэ зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах нь ховор бөгөөд зөвлөлийн чиг үүргийг зөвхөн сайд нар гүйцэтгэдэг. Гэсэн ч зөвлөлийн дүрмийн дагуу сөрөг хүчний тэргүүн нь хүлээн авсан мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй. Үүнтэй төстэй чиг үүргийг Канадын Хааны нууц зөвлөл хэрэгжүүлдэг. Зарим улсад үндсэн хуулиар байгуулагдаагүй, эсхүл Ямайкийн нэгэн адил тодорхой чиг үүргийг гүйцэтгэх, тухайлбал, өршөөл үзүүлэх талаар зөвлөгөө өгөх.

Сөрөг хүчний тэргүүн нь үндэсний аюулгүй байдал, цэргийн байршил, гадаад харилцааны асуудал зэрэг нам, улс төрийн бус мэдээллийг тогтмол авдаг. Энэ нь улс орны ач холбогдолтой асуудлаар зөвшилцөлд хүрэх, сонгуулийн мөчлөгөөр бодлогын тогтвортой байдлыг хангахад засгийн газар болон сөрөг хүчин хоорондын харилцааны ашигтай суваг болж чадна гэж үздэг.

Санхүүжилт болон бусад хангамжаар хангагдах эрх

Ихэнх улсад сөрөг хүчний тэргүүнд түүний үндсэн эрхээс гадна санхүүгийн болон бусад давуу эрхийг олгодог. Эдгээр нь сөрөг хүчний тэргүүний

байр суурь, нөхцөл байдал, олон нийтэд харагдах байдлыг дээшлүүлж, удирдагчийн үүргээ биелүүлэх чадварыг нэмэгдүүлнэ гэж үздэг.

Олон улсын практикт, сөрөг хүчний тэргүүний цалингийн хэмжээ нь Ерөнхий сайдынхаас бага байх боловч засгийн газрын сайдын цалинтай тэнцүү байдаг. Тухайлбал, Сейшлийн арлуудын Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд энэ зарчмыг тусгасан байна: “Сөрөг хүчний тэргүүний цалин, хангамж, тэтгэмж, тэтгэврийн хэмжээ нь сайдад төлөх ёстой хэмжээнээс багагүй байх бөгөөд төсвийг нь Нэгдсэн санд тусгана.”

Үүнээс гадна сонгуулийн санхүүжилт, албан өрөө, ажлын алба, томилолт, автомашин, мэдээлэл технологи, харилцаа холбоо, тоног төхөөрөмж, номын сангийн үйлчилгээ болон судалгаа хийлгэх зэргээр хангагдаж болно. Их Британийн Парламент доод танхимынхаа сөрөг хүчний намуудад 1975 оноос хойш төрийн сангаас “Short money” гэж нэрлэгдэх санхүүжилт олгодог болсон. Зөвхөн сөрөг хүчний тэргүүнд албан үйл ажиллагаанд нь зориулж тогтмол санхүүжилт олгогддог. Түүнчлэн зөвхөн албан ёсны сөрөг хүчин гэлтгүй сөрөг хүчний бүх намд парламентын үйл ажиллагаа, томилолтын зардалд зориулж санхүүжилт олгодог. Санхүүжилтийн хэмжээг намуудын Парламентад авсан суудлыг харгалзан тооцдог. Марокко нь Үндсэн хуулиараа сөрөг хүчний намын статус, санхүүжилт болон хангамжийн асуудлыг хамгийн өргөн хүрээнд зохицуулсан улсуудын нэг юм. Тус улсын Үндсэн хуульд (10 дугаар зүйл) Сөрөг хүчний намуудын санхүүжилт төдийгүй олон нийтийн өргөн нэвтрүүлгийн эфирийн цагийн хуваарийг хүртэл тусгаж баталгаажуулсан байдаг. Гэхдээ сөрөг хүчний намуудын эдгээр болон бусад эрх, давуу эрх практикт хэрхэн хэрэгжих талаарх нарийвчилсан асуудлыг органик хуулиар зохицуулдаг байна.

Парламентын дотоод удирдлага, зохион байгуулалтад оролцох эрх (Parliamentary leadership and administration)

Сөрөг хүчин парламентын удирдлага, дотоод зохион байгуулалтын асуудалд оролцож болох ба зарим улсад үүнийг хуулийн хүрээнд зохицуулсан байдаг. Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчин зөвхөн парламентын үйл ажиллагааны зохион байгуулалт, дэг журамд хяналт тавихаас гадна түүний биет хөрөнгө болох барилга байгууламж, албан өрөө, номын сан, архив, түүгээр зогсохгүй автомашины зогсоол зэрэгт хяналт тавьдаг. Ийм асуудалд сөрөг хүчний дуу хоолой байх нь парламент бүхэлдээ гишүүдийнхээ эрх ашгийн төлөө ажиллаж, засгийн газар, сөрөг хүчин хоорондын институцийн зохистой тэнцвэрт байдлыг хангахад амин чухал гэж үздэг. Тухайлбал:

- 1985 оны Канадын Парламентын хуулийн 50 дугаар зүйлийн дагуу Нийтийн Танхимын байр, үйлчилгээ, ажилтнуудын

санхүүгийн асуудлыг удирдах зорилгоор Дотоод эдийн засгийн зөвлөл байгуулагджээ. Сөрөг хүчний тэргүүн өөрөө, эсхүл түүний нэр дэвшүүлсэн хүн энэ зөвлөлийн гишүүн байх эрхтэй (Засгийн эрх баригч талаас нэр дэвшүүлсэн хүмүүсийн хамт). Нийтийн Танхим хамгийн багадаа 12 гишүүнтэй хоёр ба түүнээс дээш сөрөг хүчний намтай тохиолдолд тус бүр нэг гишүүнийг тус зөвлөлийн гишүүнээр томилно.

- Армений Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлд зааснаар Парламентын дотоод удирдлагыг Парламентын дарга нь гурван гишүүний хамт удирддаг бөгөөд тэдний нэг нь сөрөг хүчнээс сонгогдоно.
- Зимбабвед “Парламентын удирдлагыг хянах” үүрэгтэй Парламентын байнгын хороо ажилладаг бөгөөд түүнд хоёр танхимын сөрөг хүчний тэргүүнийг оруулахаар Үндсэн хуулийн 151 дүгээр зүйлд заажээ.
- Германд Парламентад суудалтай бүх намын төлөөллийг багтаасан Ахмадын зөвлөл байгуулдаг ба хамгийн том намаас Зөвлөлийн даргыг (Бундестаг буюу доод танхимын дарга), бусад нам тус бүрээс дэд дарга нарыг сонгодог байна.
- Гүржийн Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд “Парламентын ажлыг зохион байгуулах зорилгоор Парламентын товчоо байгуулж болох ба энэ нь Парламентын дарга, дэд дарга, хороодын болон Парламентын бүлгийн дарга нараас бүрдэнэ” гэж заасан байдаг.

1.6.Цөөнхийн хориг тавих болон зөвшилцөх эрх

Хэт олонх буюу цөөнхийн хоригийн зарчмууд

Парламентын хэт олонх хүссэн хуулийн төслөө хүч түрэн батлахыг хязгаарлах боломж олгох үүднээс хэт олонхын шалгууртай (2/3-ын саналаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гэх мэт) хамт цөөнхийн хориг тавих эрхийн шалгуурыг бас тодорхойлох боломжтой. Хоригийн үр дүн нь тухай хоригийг хэрэгжүүлж буй цөөнхийн хэмжээ болон хоригийн үйлчлэх хүрээнээс (хоригийн далайц, үргэлжлэх хугацаа, цуцлах нөхцөл гэх мэт) хамаарна.

Цөөнхийн хоригийн зарчим нь олонхын шийдвэр гаргах эрхийг булаах бус, харин цөөнх нь олонхын шийдвэртэй холбоотой эсрэг байр сууриа илэрхийлэх, тухайн шийдвэрийг өргөн хүрээнд хэлэлцүүлэх, олон нийтийг дайчлах боломж олгоход чиглэгдэж байдаг.

Судалгаанд дараах хоёр төрлийн механизмыг авч үзнэ:

- хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулах механизм (зөвхөн хуулийн хэрэгжилтийг хойшлуулна);

- санал асуулга явуулах эрх (цөөнх олон нийтийн дэмжлэгтэйгээр хуулийг хүчингүй болгох).

Хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулах механизм

Зарим улсын үндсэн хуулиар парламентын цөөнхөд хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулах эрх олгодог. Тухайлбал, Шведийн Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд зааснаар үндсэн эрхийг хөндсөн хуулийн төслийг хэлэлцэн батлахыг парламентын хамгийн багадаа 10 гишүүний шаардлагаар нэг жилийн хугацаатай хойшлуулж болох ба гишүүдийн 5/6-ийн буюу 83 хувийн саналаар уг шаардлагыг хүлээн авахгүй байж болно. Хэрэв тухайн цөөнхийг бүрдүүлж буй намын бүлэг нь парламентын 1/6-ийг бүрдүүлж буй бол хойшлуулах эрхийг хэрэгжүүлэх боломжтой. Гэхдээ хойшлуулах механизм нь хуулийг цуцална гэсэн үг биш бөгөөд эцсийн дүндээ ердийн олонхоор хуулийн төслийг батална.

Парламент дахь цөөнх нь хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулснаар нэг жилийн хугацаанд олон нийт, хэвлэл мэдээллээр хэлэлцүүлэх боломжтой. Эсрэгээрээ олонх нь олон нийтийн дэмжлэг авахын тулд хуулийн төслийн ач холбогдлыг ухуулан таниулах шаардлага үүсдэг.

Хойшлуулах эрхийг цөөнхөд олгосноор (цөөнх энэ эрхээ хэрэгжүүлээгүй байсан ч) олонх хууль батлахдаа илүү уян хатан ханддаг. Засгийн газар аливаа хуулийг парламентаар батлуулахдаа цөөнхийн эсэргүүцэлтэй тулгарч, хойшлуулах механизмыг хэрэгжүүлэхээс сэргийлэн эхлээд цөөнхтэй зөвшилцөн санал бодлыг нь тусгахыг эрмэлздэг.

Мөн яарсан буюу дутуу боловруулагдсан хуулийн төслийг олонхын зүгээс хүч түрэн батлахаас сэргийлдэг. Өөрөөр хэлбэл, хэрэв тухайн хуулийн төсөл нь жилийн хугацаагаар хойшлогдох магадлалтай бол засгийн газар, олонх нь яаран батлахын оронд илүү нухацтай хандан олон талын санал бодлыг тусгахыг эрмэлздэг.

Тухайлбал, Данийн Үндсэн хуулийн 41.3-т зааснаар Парламентын гишүүдийн 2/5-ийн шаардлагаар аливаа хуулийн төслийг 12 хоногийн хугацаатай хойшлуулж болох бол Шведэд хойшлуулах эрх нь зөвхөн үндсэн эрхийг хөндсөн хуулийн төсөлд хамаарна. Өөрөөр хэлбэл, Шведтэй харьцуулахад Данийн хойшлуулах эрх нь өндөр босготой ч илүү өргөн хүрээг хамаардаг. Гэхдээ Данийн хойшлуулах эрх нь төсөв мөнгө, иргэншил, онцгой үеийн хуулийн төсөлд хамаарахгүй.

Хэдийгээр 12 хоногийн хугацаагаар хойшлуулах нь чамлалттай боловч олонх хуулийн төслийг цөөнхөөр хэлэлцүүлэхгүйгээр яаран батлахаас

сэргийлж чаддаг төдийгүй богино хугацаанд ч тухайн хуулийн төслийг олон нийт, хэвлэл мэдээллээр хэлэлцүүлэх, тухайн хуульд олон нийтийн анхаарлыг хандуулах боломжийг олгодог.

Санал асуулга явуулах эрх

Данийн Үндсэн хуульд дээр дурдсан хойшлуулах механизмаас гадна цөөнхийн хүсэлтээр санал асуулга явуулах боломжийг мөн тусгажээ. Энэ нь Парламентаар батлагдсан хуулийг Хаан батламжлахаас өмнө гишүүдийн 1/3-ийн саналаар, олон нийтийн санал асуулга явуулах хүртэл тухайн хуулийн хэрэгжилтийг түдгэлзүүлж болдог. Парламентын гишүүдийн 1/3 нь гарын үсэг зурсан шаардлагыг хууль батлагдсанаас хойш 3 хоногийн дотор Парламентын даргад хүргүүлэх бөгөөд санал асуулгыг тухайн хуулийг олон нийтэд танилцуулснаас хойш ажлын 12 хоногийн дараа, ажлын 18 хоногоос хэтрүүлэлгүйгээр (хэт богино хугацаатай) зохион байгуулна. Хэрэв засгийн газар болон олонх нь санал асуулгын дүнгээр олон нийтийн дэмжлэг авч чадахгүй бол хуулиа эргүүлэн татаж болно. Харин санал асуулга явагдаж санал өгсөн иргэдийн олонх нь, мөн нийт сонгогчдын 30 хувь нь хуулийн эсрэг санал өгсөн бол Хаан тухайн хуулийг батламжлахгүй. Зарим тохиолдолд яаралтай горимоор Хааны батламжилсан хуулийн эсрэг олон нийт санал өгсөн бол тухайн хуулийг хүчингүйд тооцно. Гэхдээ цөөнхийн хүсэлтээр санал явуулах эрх олгосон заалтыг төсөв мөнгө, иргэншилтэй холбоотой хууль, олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлсэн хууль, Хааны угсаа замгалжлалын хуульд хэрэглэдэггүй.

Цөөнхийн хүсэлтээр санал асуулга явуулах механизм нь засгийн газрын үйл ажиллагааг гацааж, хууль батлах явцыг хүндрэлтэй болгож байгаа (цөөнх хүссэн асуудлаар санал асуулга явуулахыг шаардаж болно) мэт боловч бодит байдалд энэ нь тийм биш юм. Энэ заалт 1953 онд батлагдсанаас хойш 2 удаа л санал асуулга явуулжээ. Энэ механизмын гол ач холбогдол нь олонхын хууль батлах үйл явцыг илүү уян хатан болгоно гэж үздэг. Үүнд, нэгдүгээрт, эрх баригч олонх нь цөөнхийг санал асуулга явуулах эрхээ хэрэгжүүлэхгүй байлгахын тулд цөөнхтэй зөвшилцөхийг оролддог. Хоёрдугаарт, энэ нь хориг тавих үнэмлэхүй эрх биш бөгөөд цөөнхийн хувьд асуудлыг хамтын шийдэлд хүргэж байгаа арга хэлбэр юм. Эцэст нь шийдвэрийг парламентын олонхоор баталдаг. Хэрэв цөөнх санал асуулга явуулах эрхээ хэт их ашиглавал улс төрийн хувьд төлөвшөөгүй улс төрийн хүчин болж харагддаг ажээ.

Латвийн Үндсэн хуулийн дагуу Ерөнхийлөгчийн хүсэлтээр, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-ийн шаардлагаар хууль батлагдсанаас хойш 10 хоногт багтаан хуулийн хэрэгжилтийг хоёр сарын хугацаагаар түдгэлзүүлж болно. Энэ хугацаанд нийт сонгогчдын 10 хувийн гарын үсгийг

цуглуулсан бол олон нийтийн санал асуулга явуулна. Энэхүү 10 хувийн босго нь өндөр босго бөгөөд ялангуяа том нутаг дэвсгэртэй, олон хүн амтай улсын хувьд хоёр сарын хугацаанд гарын үсэг цуглуулах нь өндөр зардалтай, нүсэр зохион байгуулалт шаарддаг тул бараг боломжгүй гэж үздэг. Харин Латви шиг жижиг улсын хувьд санал асуулга нь боломжтой бөгөөд санал асуулгыг 4 удаа (1998, 1999, 2007, 2010 онд) явуулсан.

Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх

Зарим улсад парламент дахь цөөнхийн зүгээс тухайн хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар үндсэн хуулийн шүүхэд хандаж болдог. Тухайлбал, Францын Үндсэн хуулийн дагуу Үндэсний Ассамблей, эсхүл Сенатын 60 гишүүн (мөн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Парламентын хоёр танхимын дарга нар) тухайн хуулийг хянуулахаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй. Гэхдээ тухайн хууль батлагдсаны дараа, гэхдээ ёсчлон батлахаас өмнө Үндсэн хуулийн шүүхэд хандах шаардлагатай. Үүнтэй ижил заалтууд нь франц хэлтэй Африкийн улсуудад түгээмэл байдаг. Жишээ нь, Тунисын Үндсэн хуулиар Парламентын 30 гишүүний саналаар тухайн хуулийг баталснаас хойш 30 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой байдаг.

Ийм зохицуулалт нь тухайн хуульд зөвхөн хориг тавих эрх төдий биш харин үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянахад чиглэгдсэн эрх зүйн үйл явц юм. Энэ нь цөөнхийн хувьд тухайн хуулийг цуцлуулах нэг арга зам юм. Цөөнх тухайн асуудлаар үндсэн хуулийн шүүхэд хандаад амжилт олохгүй байсан ч энэ үйлдлээрээ олон нийтийн анхаарлыг мөнхүү хуулийн алдаатай, сул талд хандуулж, олон түмний хэлэлцүүлгийн төвд аваачсанаар эрх баригчид асуудлыг эргэн харахаас аргагүйд хүрч болзошгүй билээ.

ХОЁР. ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Австрали Улс

Австралийн Холбооны Улс (Австрали Улс) нь Вестминстерийн загварт суурилдаг хоёр танхимт парламенттай, доод танхим болох Төлөөлөгчдийн Танхимын 151 гишүүнийг бүх нийтийн шууд санал хураалтаар²¹⁴ 3 жилийн хугацаатай сонгодог, харин дээд танхим болох Сенатын 76 гишүүнийг 6 жилийн хугацаатай²¹⁵ сонгодог.

Парламент дахь намын бүлэг

²¹⁴ Australian Constitution. Art. 24. <https://www.aph.gov.au/constitution>

²¹⁵ Australian Constitution. Art. 6.

Парламентад суудалтай намууд нь хууль тогтоомжийн төсөл болон улс төрийн ач холбогдолтой асуудлыг хэлэлцэх бүлгүүдийг байгуулан ажилладаг. Тэдгээр бүлгүүд нь тухайн улс төрийн намаас сонгогдсон гишүүдээс бүрддэг ба төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөхийг оролддог. Парламент дахь бүх намын бүлэг долоо хоногт нэг удаа буюу танхимын хуралдаангүй өдөр хуралддаг бөгөөд хуралдаан хаалттай явагдах ба түүний явцыг олон нийтэд мэдээлдэггүй. Намын бүлгийн хуралдаан нь намын бодлого, парламентын үйл ажиллагаа, парламентын тактик, намын болон бүлгийн дотоод маргааныг шийдвэрлэх, албан тушаалтныг сонгох, томилох зэрэг асуудлыг дотроо хэлэлцэх, эрх баригчдад шахалт үзүүлэх, шаардлага хүргүүлэх арга хэрэгсэл болдог.

Парламентад олонхын суудал авсан намын бүлгээс дээд, доод танхимын даргыг, хоёр дахь том намын бүлэг буюу сөрөг хүчнээс тэдгээр танхимын дэд даргыг тус тус сонгодог байна.

Цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн орчин

Төлөөлөгчдийн Танхимд суудалтай хоёр дахь том нам, эвслийг сөрөг хүчин (opposition) гэнэ. Сөрөг хүчин нь Төлөөлөгчдийн Танхимын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.²¹⁶ Сөрөг хүчин нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг нь шүүмжилж, засгийн газрыг огцруулах оролдлого хийдэг учир зарим тохиолдолд “хүлээж буй засгийн газар” (government in waiting) гэж үздэг. Австрали Улсын Парламентын түүхэнд Төлөөлөгчдийн Танхимд 2024 оныг хүртэлх хугацаанд сөрөг хүчний нийт 35 тэргүүн ажиллаж байсны 19 нь Ерөнхий сайдаар ажиллаж байжээ.²¹⁷

Сөрөг хүчний үйл ажиллагааг Үндсэн хуулийн конвенц²¹⁸ (Их Британийн Үндсэн хуулиас эхтэй Хамтын Нөхөрлөлийн улсуудын дагаж мөрддөг бичмэл бус уламжлал, зөвлөмж), Төлөөлөгчдийн Танхимын практик²¹⁹, Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэг²²⁰ болон бусад эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Вестминстерийн загвартай улсуудад сөрөг хүчнийг “Сүүдрийн засгийн газар” гэж нэрлэх нь түгээмэл байдаг. Төлөөлөгчдийн Танхимын нэгдсэн хуралдааны танхимд сөрөг хүчний гишүүд засгийн газрын гишүүд (олонхын бүлэг)-ийн эсрэг талд суудаг бөгөөд эрх барьж буй засгийн газар огцорвол өөрсдийн засгийн газрыг байгуулдаг.²²¹ Төлөөлөгчдийн Танхим болон Сенатад аль алинд нь сөрөг хүчний гишүүд байдаг.

²¹⁶ Parliament of Australia. www.aph.gov.au

²¹⁷ The Politics of Australia. Jaensch, Dean.


²¹⁸ Introduction to the Study of the Law of the Constitution. AV Dicey. p 23-24.

²¹⁹ House of Representatives Practice (7th edition). www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7

²²⁰ House of Representatives Standing and Sessional Orders. www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_and_Sessional_Orders

²²¹ <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-and-its-people/opposition>

Зураг 1. Төлөөлөгчдийн Танхимын суудал хуваарилалт



Эх сурвалж: peo.gov.au.

Сөрөг хүчний тэргүүн ба түүний чиг үүрэг

Төлөөлөгчдийн Танхим дахь сөрөг хүчний тэргүүн (leader of the opposition) нь тус танхимын сөрөг хүчний гишүүдээс сонгогдоно.²²² Сөрөг хүчний тэргүүн бол улс төрийн томоохон лидер бөгөөд хэрэв Засгийн газар огцорвол дараагийн Ерөнхий сайд болох өндөр магадлалтай байдаг. Тэрээр Хамтын Нөхөрлөлийн улсуудын төрийн өндөр албан тушаалтнуудын жагсаалтын 10 дугаарт бичигддэг²²³ бөгөөд жирийн гишүүдээс өндөр цалин хөлс авдаг байна.

Сөрөг хүчний тэргүүн нь Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны үеэр Ерөнхий, сайд нараас асуулт асуух, үг хэлэх зэргээр парламент дахь сөрөг хүчний үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Ерөнхий сайд танхимд үг хэлсэл бол сөрөг хүчний тэргүүн нь түүнтэй адил хугацаатай хариу үг хэлдэг.²²⁴

Сөрөг хүчний тэргүүн нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- парламент дахь сөрөг хүчний гол төлөөлөгчөөр ажиллах;
- Төлөөлөгчдийн Танхимын гишүүдээс сүүдрийн сайд нарыг томилох;
- Сүүдрийн засгийн газрын болон намын бүлгийн хуралдааныг хуралдуулж, төрийн бодлого, хуулийн төслүүдийг санаачлан хэлэлцэх;

²²² <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-and-its-people/people-in-parliament/leader-of-the-opposition>

²²³ Commonwealth Table of Precedence. Special Gazette No. S206 of 5 October 1982.

²²⁴ https://aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/00_-_Infosheets/Infosheet_19_-_The_House_government_and_opposition

- холбооны сонгуулийн компаниг ажлыг удирдан зохион байгуулах;
- урьдчилан мэдэгдэхгүйгээр асуулт асуух;
- Сүүдрийн засгийн газрыг тэргүүлэх зэрэг өргөн хүрээтэй эрх, үүрэгтэй. Сүүдрийн засгийн газар бол сөрөг хүчний бодлого, шийдвэр боловсруулдаг, гаргадаг гол механизм юм.

Сөрөг хүчний чиг үүрэг

Парламент дахь сөрөг хүчний үндсэн үүрэг бол засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих юм. Үүнээс гадна сөрөг хүчин дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Засгийн газрыг огцруулах – сөрөг хүчин нь засгийг газрыг огцруулж, өөрсдийн засгийн газрыг байгуулахыг эрмэлздэг;
- хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сайжруулах санал гаргах;
- улсын төсөв, түүний зарцуулалтад хяналт шалгалт хийх;
- засгийн газрын бодлогын талаар мэдээлэл, тодруулга авах, асуулт, асуулга тавих;
- төрийн захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих, шүүмжлэх, үнэлгээ, дүгнэлт өгөх;
- өргөдөл, гомдол шалгах;
- эрх шилжүүлсэн хууль тогтоомжид хяналт шалгалт хийх.

Хэдийгээр Парламентын гишүүн бүр өргөдөл, гомдол барагдуулах, асуулт, асуулга тавих, аль нэг хороонд харьяалагдан ажиллах боловч дээр дурдсан чиг үүргийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх нь сөрөг хүчнээс ихээхэн хамаардаг. Парламент дахь олонхын бүлгийн гишүүд Парламентын эдгээр үйл ажиллагаанд үр дүнтэй оролцох боломжтой боловч практик дээр гагцхүү сөрөг хүчин энэ үүргийг илүү сайн гүйцэтгэдэг байна.

Төлөөлөгчдийн Танхимаар хэлэлцэх асуудлуудад засгийн газрын буюу Парламент дахь олонхын бүлгийн санаачлан өргөн барьсан хууль тогтоомжийн төслүүд давамгайлж байдаг тул сөрөг хүчин хэлэлцэж буй бүх асуудлаар саналаа илэрхийлэх боломжтой. Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд засгийн газрын болон сөрөг хүчний гишүүдийн мэтгэлцээнд үг хэлэх хугацаа тэнцүү байх бөгөөд дарааллын хувьд ээлжилж үг хэлэх боломжийг олгодог.

Мөн сөрөг хүчин өөрсдийн дэвшүүлсэн асуудлаар болон олон нийтийн анхаарлыг татаж буй сэдвээр Төлөөлөгчдийн танхимын хуралдааны үеэр хэлэлцүүлэг явуулах бүрэн боломжтой байдаг. Сөрөг хүчний гишүүд Төлөөлөгчдийн Танхимын бүх хороонд орж ажиллах бөгөөд саналуудыг нь хорооны тайланд тусгадаг.²²⁵

²²⁵[www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter2/The_\(official\)_Opposition](http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter2/The_(official)_Opposition)

Цөөнхийн бүлэг Парламентын хороодод ажиллах

Парламентын хороо нь Парламентын нэрийн өмнөөс тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхээр Парламентын нэг буюу хоёр танхимаас томилогдсон гишүүдийн зохион байгуулалтын бүтэц (хамтарсан хороодын хувьд хоёулаа) бөгөөд Төлөөлөгчдийн Танхимаас Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих нэг механизм болдог.²²⁶

Хороодын гишүүдийн тоо харилцан адилгүй бөгөөд гол төлөв 8-32 гишүүнтэй байна. Хороод эрх баригч болон сөрөг хүчний гишүүдээс бүрддэг бөгөөд энэ нь Төлөөлөгчдийн Танхим дахь бүх намын бүлгийн гишүүдийн тоотой хамааралтай байдаг ч ерөнхийдөө эрх барих хүчний гишүүд хороо бүрд олонх болдог.

Ихэнх хороодыг эрх баригч хүчний гишүүн даргалж, дэд даргаар нь сөрөг хүчний гишүүн ажилладаг. Хороодод орох гишүүдийг намын бүлэг дотроос сонгож, дараа нь тухайн намын удирдагч нэр дэвшүүлдэг. Үүний дараа хороонд орохоор нэр дэвшсэн гишүүдийг танхимын тогтоолоор албан ёсоор томилдог.²²⁷

2024 оны байдлаар 45 дахь Төлөөлөгчдийн Танхим 15 хороотой ажиллаж байна.²²⁸ (Хүснэгт 2.)

Хүснэгт 2. Төлөөлөгчдийн Танхимын хороодын гишүүнчлэл

	Хорооны нэр	Олонхын бүлгийн гишүүн	Цөөнхийн бүлгийн гишүүн	Эвсэлд үл нэгдсэн гишүүн	Нийт гишүүд
1	Эдийн засгийн байнгын хороо	6	3	1	10
2	Хөдөлмөр эрхлэлт, боловсрол, сургалтын байнгын хороо	6	3	1	10
3	Бүс нутгийн хөгжил, дэд бүтэц, тээвэрлэлтийн байнгын хороо	6	3	1	10
4	Гишүүний халдашгүй эрх ба ашиг сонирхлын хороо	6	5	-	11
5	Өргөдлийн байнгын хороо	5	3	-	8
6	Дэг журмын байнгын хороо	4	3	-	7
7	Сонгон шалгаруулах хороо	6	4	1	11
8	Төсөв болон захиргааны асуудал хариуцсан хороо	5	4		9
9	Бусад хороод	5	3	1	9

²²⁶ www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House

²²⁷ www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/00_-_Infosheets/Infosheet_4_-_Committees

²²⁸ www.aph.gov.au/parliamentary_business/committees

2.2.Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман Улс)-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд тус улс нь ардчилсан, холбооны улс бөгөөд төрийн бүх эрх мэдлийг ард түмэн сонгуулийн болон бусад арга замаар бүрдүүлсэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлнэ хэмээн заасан байдаг.

Герман Улсын Бундестаг нь холимог тогтолцоог ашиглан гишүүд нь шууд сонгуулиар сонгогддог. Сонгогч бүр тойрогт нэр дэвшигчид өгөх нэг санал болон намд өгөх нэг санал гэсэн 2 санал өгөх эрхтэй. Сонгуулийн мажоритар системийн дагуу сонгуулийн тойрог бүрд анхны санал хураалтаас хамгийн их санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ. Парламентын үлдсэн суудлыг пропорционал төлөөллөөр хуваарилна. Пропорционал санал хураалтаар 5 хувиас доошгүй санал авсан, эсхүл мажоритар тогтолцооны дагуу гурваас доошгүй парламентын суудал авсан нам пропорционал төлөөллийн тогтолцооны дагуу парламентад суудал авах эрхтэй. Пропорционал төлөөллийн тогтолцооны үр дүнгээр санал авах эрхтэй байвал үүнийг нэмэлт суудал (overhang seats) гэж хадгална. Улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан парламентад сул суудал гарвал дараа нь эрэмбэлэгдсэн тухайн намын нэр дэвшигчээс нөхөн гүйцээнэ.

Герман Улс шиг парламентын засаглалтай ардчилсан улсад засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын талаар мэтгэлцээн өрнүүлэх, Бундестагийн гишүүдийн өргөн барьсан хуулийн төслүүдэд санал өгөх зэрэг нь сөрөг хүчний үндсэн үүрэг болдог уламжлалтай.

Бундестаг дахь намын бүлэгтэй холбоотой харилцааг дараах хуулиудаар зохицуулдаг:

- Үндсэн хууль;
- Улс төрийн намын тухай хууль;
- Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль;
- Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хууль.

Бундестаг дахь намын бүлгийн эрх зүйн байдал

Бундестагийн хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт зааснаар намын бүлэг нь Бундестагийн гишүүдийн хамгийн багадаа 5 хувиас бүрдсэн нэг намын харьяалалтай гишүүдийн холбоо гэж заасан байдаг. Мөн улс төрийн ижил зорилгоороо нэгдмэл, аль ч мужид хоорондоо өрсөлддөггүй намуудын харьяалалтай гишүүд нийлж Бундестагт

хамтарсан нэг намын бүлэг байгуулж болно. Эдгээр нөхцөл болзлыг хангаагүй ч намын бүлэг байгуулах тухай хүсэлтийг гишүүдээс гаргасан бол тус намын бүлгийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг Бундестагийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг байна.

Герман Улсын сонгуулийн систем нь аль нэг нам дангаараа засгийн газар байгуулахад хүндрэлтэй байх бөгөөд олон жижиг намууд нийлж олонхыг бүрдүүлэхээс урьдчилан сэргийлсэн “таван хувийн хориг” (five percent hurdle) гэж нэрлэгддэг босготой. Энэ нь Бундестагт 5-аас доош хувийн төлөөлөлтэй нам нь намын бүлэг байгуулах боломжгүй гэсэн үг юм.²²⁹

Парламентад намын бүлэг байгуулахад:

- намын бүлэг байгуулсан тухай, түүний албан ёсны нэр, намын бүлгийн даргын нэр, намын бүлгийн гишүүдийн нэрс зэргийг Бундестагийн ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ;
- намын бүлэгт гишүүдийн зэрэгцээ зочид байж болно. Зочдын тоог намын бүлгийн хэмжээг тодорхойлоход оруулж тооцохгүй боловч харин намын бүлгүүдэд хуваарилагдсан албан тушаалд томилж, сонгоход зочдыг харгалзан үзэж болно;
- намын бүлэг байгуулах эрмэлзэлтэй хэдий ч гишүүдийн тоо хүрэлцэхгүй бол үзэл бодлоороо нэгдэхийг хүссэн Бундестагийн гишүүд хамтран бүлгэм байгуулахыг зөвшөөрч болно;
- намын бүлгүүд дундаа болон нийлж хамтран байгуулсан ажлын хэсгүүд нь уг намын бүлгүүдийн гишүүдийн тоо хэмжээнд болон хуваарилагдах албан тушаалын квотод ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.²³⁰

Намын бүлгүүдийн эрэмбэлсэн дарааллыг гишүүдийнх нь тоонд үндэслэн тогтооно. Гишүүдийн тоо нь тэнцүү намын бүлгүүдийн хувьд тэдний дарааллыг Бундестагийн ерөнхийлөгч нэгдсэн чуулганы нэг хуралдаан дээр шодож шийднэ. Гишүүнийх нь суудал эзгүйрсэн ч шинэ гишүүн нөхөн сонгогдох хүртэл хугацаанд тухайн намын бүлгийн гишүүдийн тоог өөрчлөгдөөгүйд тооцно.

Намын бүлгүүдэд хуваарилах албан тушаалын квотын хувьд, Ахмадын зөвлөлийг болон байнгын хороог тус тус бүрдүүлэх, Байнгын хорооны даргыг томилох зэрэг асуудлыг шийдвэрлэхэд намын бүлгийн гишүүдийн тоог харгалзсан квотын харьцааг баримтлан намын бүлгүүдэд эрх хуваарилна. Бундестагийн хүрээнд хийгдэх бусад томилгоо буюу сонгуульд дээрх зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

²²⁹ <https://www.deutschland.de/en/topic/politics/the-german-parliament-and-the-parties>

²³⁰ Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль. Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

Бундестагийн хуралдааны дэгийн тухай хуульд намын бүлгийн талаар зохицуулсан байдал

- Бундестагийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарыг сонгохдоо намын бүлэг тус бүрээс доод тал нь нэг Бундестагийн дэд ерөнхийлөгчийг нэр дэвшүүлж сонгоно;
- хуралдааны тэмдэглэл хөтлөгчдийг сонгохдоо намын бүлэг тус бүрээс ирүүлсэн саналыг үндэслэн сонгоно;
- чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний хүрээнд хуралдаан даргалагч нь ирц бүрдээгүйн улмаас амжилтгүй болсон санал хураалтыг дахин явуулах товыг зарлах, эсхүл уг асуудлыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс хасах эрхтэй. Гэхдээ түүний энэ шийдвэрийг аль нэг намын бүлэг, эсхүл нэгдсэн хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувиас доошгүй нь эсэргүүцсэн бол хуралдаан даргалагчийн шийдвэр хүчингүй болно;
- Бундестаг нь хуралдааныг хойшлуулах бол зөвхөн хуралдаан даргалагчийн санал болгосны дагуу, эсхүл аль нэг намын бүлгийн хүсэлтийн дагуу, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гаргана;
- Бундестагийн гишүүний өргөн барьсан асуудлаар хэлэлцүүлэг эхэлсэн бол үг хэлэх эхний гишүүн нь төсөл санаачлагчийн намын бүлэгт харьяалагддаггүй гишүүн байна;
- хуралдааны дэгтэй холбоотой горимын санал гаргаж буй гишүүнд хамгийн эхэнд үг хэлэх эрхийг хуралдаан даргалагч олгоно. Горимын саналыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай бол зөвхөн санал гаргагч гишүүнд үг хэлэх эрх олгоно. Дэгтэй холбоотой өөр горимын санал гарсан бол намын бүлгүүд тус бүрээс нэг төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл олгож хязгаарлалт хийнэ;
- хэлэлцүүлэгт үг хэлэх хугацааг Ахмадын зөвлөлийн саналыг үндэслэн Бундестаг тогтоох бөгөөд гишүүд 15 минутаас илүүгүй хугацаанд үг хэлнэ. Харин намын бүлгийн шаардсанаар тус намын бүлгийг төлөөлсөн илтгэгч 45 минут хүртэл хугацаагаар үг хэлж болно;
- Засгийн газрын гишүүн, Холбооны Зөвлөлийн гишүүн, эсхүл эдгээр байгууллагын төлөөлөгч 20 минутаас илүү хугацаагаар үг хэлж байвал өөр байр суурьтай байгаа намын бүлэг өөрийнхөө илтгэгчид ижил хугацааны үг хэлэх эрхийг шаардаж болно;
- хэлэлцүүлгийн явцад Засгийн газрын гишүүн, эсхүл Холбооны Зөвлөлийн гишүүн, эсхүл тэдгээрийн төлөөлөгч уг асуудал дээр үг хэлэх зөвшөөрөл авч дахин үг хэлсэн бол байр сууриа илэрхийлж дууссан намын бүлгүүдэд үг хэлэх нэмэлт цаг олгоно;
- Засгийн газрын гишүүн, эсхүл Холбооны Зөвлөлийн гишүүн, тэдний төлөөлөгч хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс гадуур

- үг хэлбэл аль нэг намыг бүлэг болон хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь нь шаардсанаар хэлэлцүүлэг явуулна. Энэ хэлэлцүүлгийн үед шийдвэрийн төсөл хэлэлцэхгүй;
- санал хураахаас өмнө аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь нь нэрсийн жагсаалтаар санал хураахыг шаардаж болно;
 - Бундестагийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулсан баримт бичгийг Бундестагийн гишүүн өргөн барьсан тохиолдолд түүний энэ санаачилгыг нэг намын бүлэг дэмжсэн, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь гарын үсэг зурж дэмжсэн байх ёстой;
 - өргөдөл саналыг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхгүйгээр Байнгын хороонд шилжүүлж болно. Нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд ирсэн Бундестагийн гишүүдийн 5 хувь нь эсэргүүцээгүй тохиолдолд өргөдөл, саналыг урьдчилан тараахгүйгээр шууд санал хурааж шийдвэрлэж болно;
 - Ахмадын зөвлөл урьдчилан тохирсон бол зарим асуудлын хэлэлцүүлгийн оронд хэлэх үгийг бичгээр авч хуралдааны протоколд тэмдэглүүлж хавсаргана. Ийм горимыг тохирсон бол хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тухайн асуудлыг бусдаас ялгагдахаар бичнэ. Өмнөх өдрийн 18:00 цагаас өмнө намын бүлэг, эсхүл нийт гишүүдийн 5 хувь нь хэлэлцүүлэг хийхийг шаардвал хэлэлцүүлгийг заавал хийнэ. Хэлэлцүүлгийн хүрээнд намын бүлэг бүрд нэг удаа үг хэлэх боломж олгох бөгөөд хэлэлцүүлгийг 30 минут үргэлжлэхээр тооцож энэ хугацаанд намын бүлгийн гишүүдийн тоог харгалзан хуваарилна;
 - Европын Холбооны тодорхой баримт бичгийг Бундестагт ирүүлэх үүргээс Засгийн газрыг чөлөөлж болно. Аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь үүнийг дэмжээгүй бол тодорхой баримт бичгийг Бундестагт ирүүлэх Засгийн газрын үүрэг хүчинтэй хэвээр үлдэнэ;
 - Европын Холбооны баримт бичиг болон Европын Холбооны Парламентын тогтоол шийдвэрийг зарчмын хувьд Байнгын хороонд шилжүүлнэ. Шилжүүлэх шийдвэрийг боловсруулахдаа намын бүлгүүдтэй зөвшилцөж, ач холбогдлыг нь үнэлнэ. Байнгын хороонд шилжүүлэх шаардлагагүй, Европын Холбооны бусад баримт бичгийн хувьд Бундестагийн гишүүдэд танилцах боломжийг бүрдүүлнэ. Аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувийн хүсэлтээр Европын Холбооны бусад баримт бичгийг Байнгын хороонд шилжүүлж болно;
 - Европын Холбооны баримт бичгүүдийг шилжүүлэх саналыг Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлнэ. Бундестагийн ерөнхийлөгч намын бүлгүүдтэй зөвшилцөн Асуудлыг голлон хариуцах Байнгын хороонд болон хамтрагч Байнгын хороонд даруй шилжүүлнэ. Шилжүүлсэн, эсхүл шилжүүлэхээр

- төлөвлөснийг аль нэг Байнгын хороо, эсхүл намын бүлэг эсэргүүцсэн бол Ахмадын зөвлөл үүнийг шийдвэрлэнэ;
- Холбооны канцлерт итгэл үзүүлэхээс татгалзах тухай тогтоол батлахдаа Бундестагийн гишүүдийн дөрөвний нэг, эсхүл хамгийн багадаа Бундестагийн гишүүдийн дөрөвний нэгтэй тэнцэх тооны гишүүнтэй намын бүлэг санал гаргана;
 - Бундестагийн ерөнхийлөгч Засгийн газарт тавьсан асуулгыг Засгийн газарт мэдэгдэж, хариу өгөх эсэх хариуны товыг тодорхойлохыг шаардана. Хариу ирүүлсний дараа асуулгыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулна. Аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь шаардсан бол хэлэлцүүлэг явуулна;
 - Засгийн газар асуулгад хариу өгөхөөс бүрмөсөн, эсхүл ойрын 3 долоо хоногийн хугацаанд татгалзсан бол Бундестаг асуулгыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж болно. Нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь шаардсан бол хэлэлцүүлгийг заавал явуулна;
 - аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулахыг шаардаагүй тохиолдолд Бундестагийн Зэвсэгт хүчний асуудал эрхэлсэн илтгэгчийн тайлан мэдээллийг Бундестагийн ерөнхийлөгч Батлан хамгаалахын байнгын хороонд шилжүүлнэ;
 - аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь шаардсан бол Бундестагийн Зэвсэгт хүчний асуудал эрхэлсэн илтгэгчид түүний тайлан илтгэлийг хэлэлцэх үед Бундестагийн ерөнхийлөгч түүнд үг хэлэх эрх олгоно;
 - мөн аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь шаардсан бол Бундестагийн хуралдаанд Бундестагийн Зэвсэгт хүчний асуудал эрхэлсэн илтгэгчийг дуудаж оролцуулна.

Намын бүлэг байнгын болон бусад хороодод ажиллах

- ажлаа бэлтгэхийн тулд аливаа Байнгын хороо өөрсдийн гишүүдийн дундаас нэг дэд хороог тодорхой үүрэг даалгавартайгаар байгуулж болно. Чингэхдээ Байнгын хорооны гишүүдийн 1/3 нь татгалзвал дэд хороог байгуулахгүй. Онцгой тохиолдолд намын бүлгүүд нь тухайн Байнгын хорооны гишүүн бус хүнийг дэд хорооны гишүүнээр томилж болно;
- байнгын хороонд төлөөлөлтэй намын бүлэг бүр нь дэд хороонд доод тал нь 1 гишүүнээ оруулах эрхтэй;
- намын бүлгүүд байнгын хороодод орох өөрийн гишүүдийг болон тэдний орлогч нарыг томилно. Бундестагийн ерөнхийлөгч намын бүлгийн харьяалалгүй гишүүдийг Байнгын хороодод зөвлөх эрхтэй гишүүнээр томилно;

- байнгын хорооны гишүүдийн ажлыг дэмжих зорилгоор намын бүлэг бүрээс намын бүлгийн 1 ажилтан байнгын хорооны хуралдаанд байлцах эрхтэй;
- бусад хууль тогтоомжоор хязгаарлалт тогтоогоогүй бол намын бүлгийн дарга нар бүх байнгын хороодын болон бусад хороодын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцож болно. Бүлгийн дарга өөрийн намын бүлгийн гишүүнийг өөрийн өмнөөс хуралдаанд оролцуулж болно;
- байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлгийг дуусгах талаар горимын санал гаргасан бол намын бүлгийн төлөөлөл бүр байр сууриа илэрхийлсний дараа, намын бүлгүүдийн байр сууринаас зөрүүтэй саналууд яригдсаны дараа л санал хураалт явуулахыг зөвшөөрнө;
- нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь санал гаргаж чуулганы хуралдаанд оролцож буй гишүүдийн 2/3 нь энэ саналыг дэмжсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд шилжүүлэхгүйгээр шууд 2 дахь хэлэлцүүлэгт оруулж болно;
- төсөл санаачлагч нь эсэргүүцээгүй тохиолдолд л Бундестагийн шийдвэрийн төслийн талаар гаргасан саналыг нь Байнгын хороо руу шилжүүлж болно. Намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй Бундестагийн гишүүдийн 5 хувь нь хүсэлт гаргасан бол санал хураалтыг хуралдааны дараагийн өдөр хүртэл хойшлуулна;
- намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь санал гаргасан бол Холбооны Зөвлөлийн зөвшөөрөл шаардах хуулиудын хувьд Зуучлах хороо байгуулах тухай тогтоолыг Бундестаг гаргаж болно;
- Европын Холбооны асуудал хариуцсан байнгын хорооноос Засгийн газарт Европын Холбооны баримт бичгийн талаар илэрхийлсэн байр суурийн агуулга, үндэслэлийн талаар Байнгын хороо санал, дүгнэлт бэлтгэж, түүнийг Бундестагийн хэвлэмэл материал хэлбэрээр тараасны дараа гурван долоо хоногийн дотор хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулна. Гэхдээ энэ асуудлын хэлэлцүүлгийг зөвхөн аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь нь хүсэлт гаргасан тохиолдолд л явуулна;
- Европын Холбооны асуудал хариуцсан байнгын хорооны хуралдаанд Европын парламентын тодорхой герман гишүүд оролцох эрхтэй; Европын парламентын бусад герман гишүүд орлогчийн хувьд Байнгын хорооны хуралдаанд оролцох эрхтэй. Хамтран ажиллах эрхтэй Европын парламентын гишүүдийг Бундестаг дахь намын бүлгүүдийн саналаар Бундестагийн ерөнхийлөгч томилно;
- байнгын хорооны дарга аль нэг намын бүлгийн шаардлага, эсхүл байнгын хорооны гишүүдийн 1/3-ийн хүсэлтийн дагуу болон

Бундестагийн ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр байнгын хорооны ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна;

- Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Бундестагт тараасны дараа чуулганы хуралдаанаар шийдвэрлүүлэхээр 3 долоо хоногийн дотор хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж, Байнгын хорооны илтгэгч нь амаар нэмэлт оруулах боломжтой. Аль нэг намын бүлэг, эсхүл хуралд оролцож буй гишүүдийн 5 хувь нь шаардсан тохиолдолд л өргөдлийн талаар чуулган дээр хэлэлцүүлэг явуулна.

Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуульд намын бүлгийн талаарх зохицуулалт

Парламент хууль баталж, баталсан хуулиудыг Засгийн газар хэрэгжүүлж шүүх маргаантай асуудлуудыг шийдвэрлэнэ. Хэдийгээр эрх мэдлийг ардчилсан байдлаар хуваарилсан байсан ч хяналтгүй бол тухайн эрх мэдлийг хэтрүүлэн хэрэглэх, буруугаар ашиглах, дарангуйлал тогтох магадлалтай байдаг байна. Иймд хянан шалгах түр хороо нь эрх мэдлийн хуваарилалтыг хангаж байдаг парламентын хяналтын үр өгөөжтэй арга хэрэгсэл юм.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг парламентын олонх, цөөнхийн буюу хүчний харьцааны дагуу тогтооно. Парламентын хянан шалгах түр хороо байгуулах тухай хууль ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтуудаар хянан шалгах түр хорооны ажиллах дэгийг тогтоодог байна.

Герман Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд Бундестагийн гишүүдийн 1/4-ийн санаачилгаар хянан шалгах түр хороо байгуулж болно гэсэн заалт байдаг бөгөөд энэхүү заалтаар Бундестагийн гишүүдийн цөөнхийн санаачилгаар хянан шалгах түр хороог байгуулах баталгааг хангасан юм. Ингэснээр Парламентаас байгуулдаг хянан шалгах түр хороо нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих сөрөг хүчний эрх мэдлийг нэмэгдүүлж байдаг. Хянан шалгах түр хороо нь олон нийтэд нээлттэй болон хаалттай хуралдаануудаар нотлох баримтуудыг авч хэлэлцэж салбарын шинжээчид болон гэрчүүдийн үгийг сонсдог. Үүгээрээ хянан шалгах түр хорооны ажиллах дэг нь шүүхтэй төстэй байдаг.

Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Бундестаг түр хороог байгуулахдаа түүний жинхэнэ болон ижил тооны орлогч гишүүдийн тоог тогтооно. Гишүүдийн тоо тогтоохдоо Бундестаг дахь олонх, цөөнхийн харьцааны зэрэгцээ тавигдсан үүрэг, даалгавар болон хянан шалгах хорооны ажлын чадамжийг харгалзан үзнэ. Түр хороонд намуудын бүлэг бүрийн

төлөөллийг оролцуулна. Намын бүлэг бүрд ногдох гишүүдийн тоог математик пропорцын зарчмаар (St. Laue/Schepers) тогтооно.

Мөн хуулийн 5 дугаар зүйлд түр хорооны жинхэнэ болон орлогч гишүүдийг намын бүлгүүд томилох ба эгүүлэн татна. Түр хорооны даргыг сонгохдоо намын бүлгүүдийн гишүүдийн тоог харгалзан үзнэ.

Хянан шалгах түр хороо нь Ахмадын зөвлөл дэх зөвшилцөөний дагуу түр хорооны нэг гишүүнийг орлогч даргаар томилох бөгөөд орлогч дарга нь тухайн түр хорооны даргаас өөр намын бүлгийн харьяалалтай байх ёстой.²³¹

Хянан шалгах түр хороо намын бүлгүүдийн тодорхой ажилтнуудад хуралдаанд оролцох зөвшөөрөл олгож болно.²³²

2.3. Нидерланд Улс

Нидерландын Хаант Улс (Нидерланд Улс)-ын Парламент (Staten-Generaal) нь хоёр танхимтай: дээд танхим буюу Сенат (Eerste Kamer) 75 гишүүнтэй, доод танхим буюу Төлөөлөгчдийн Танхим (Tweede Kamer) 150 гишүүнтэй. Сенатын гишүүдийг мужийн зөвлөлийн гишүүдээс 4 жилийн хугацаагаар, сонгуулийн пропорционал тогтолцоогоор сонгодог бол Төлөөлөгчдийн Танхимын гишүүдийг бүх ард түмнээс сонгуулийн пропорционал тогтолцоогоор шууд сонгодог.

Нидерланд Улсад Засгийн газрын танхимд ороогүй намуудыг сөрөг хүчин гэж үздэг.²³³ Одоогийн байдлаар Парламент дахь намын бүлэг, сөрөг хүчний эрх зүйн байдлыг тогтоосон, үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй. Парламент дахь бүлгүүдийн үйл ажиллагааг Төлөөлөгчдийн Танхимын дэгээр зохицуулдаг.

Парламент дахь бүлгийн эрх зүйн байдал

Пропорционал сонгуулийн намын нэг жагсаалтаас сонгогдсон гишүүдийг Парламент дахь нэг бүлэг гэж үзнэ. Жагсаалтаас нэг гишүүн сонгогдсон байсан ч тухайн гишүүнийг дангаараа Парламент дахь бүлэг гэж тооцдог. Парламент дахь бүлгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн Парламент дахь бүлэг нь Парламентын Ерөнхийлөгчид мэдэгдэнэ. Парламент дахь бүлэг бүр гүйцэтгэх хорооныхоо бүрэлдэхүүний талаар Парламентын Ерөнхийлөгчид мэдэгдэнэ.

²³¹ Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл.

²³² Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл

²³³ <https://www.houseofrepresentatives.nl/how-parliament-works/democracy-netherlands/coalition-vs-opposition>

Сөрөг хүчний намууд ихэвчлэн парламентын хороодод төлөөлөлтэй байдаг бөгөөд энэ нь хууль тогтоомж, Засгийн газрын бодлогын хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ингэснээрээ намын бүлгүүд хууль тогтоох үйл явцад хувь нэмрээ оруулж, Засгийн газарт хариуцлага тооцох, хяналт тавих боломжийг сөрөг хүчинд олгодог. Парламентын холбогдох хороодын сөрөг хүчний гишүүд Парламентын чуулганы хуралдааны үеэр Засгийн газрын сайд нарт асуулт, асуулга тавьж, тэдгээрийн хийсэн үйлдэл, шийдвэрийнх нь төлөө хариуцлага тооцохыг шаардах эрхтэй. Нидерланд Улсад Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг оруулах босго нь 150 гишүүний 30 нь байдаг.

Парламент дахь бүлгүүдийн зарим онцлог зохицуулалтын талаар Төлөөлөгчдийн Танхимын дэгээс тодруулбал:

- Парламент дахь бүлэгт санхүү хуваарилах, санхүүгийн хяналт тавих журмыг танхим батална.
- Парламент дахь бүлэг хуваагдаж, нэг буюу хэд хэдэн шинэ бүлэг байгуулсан тохиолдолд Парламент дахь анхны бүлгийн төсвийг хуваагдалд оролцсон бүх улс төрийн бүлэгт гишүүдийн тоотой хувь тэнцүүлэн хуваарилна.
- Хоёр ба түүнээс дээш улс төрийн бүлэг нэгдэж Парламент дахь шинэ бүлэг байгуулсан бол шинээр байгуулагдах Парламент дахь бүлгийн төсөв нь ижил тооны гишүүдтэй Парламент дахь бүлгийн төсвөөс хэтэрч болохгүй.
- Парламент дахь анхны бүлгийн ажилтнуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Парламентын Ерөнхийлөгчийн ажлын алба нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийг үл харгалзан түр хугацааны зохицуулалт хийж болно.
- Парламент дахь бүлгийн дарга нар нь Тагнуул, Аюулгүй байдлын хорооны гишүүд болно.
- Төсвийн хорооны хэлэлцүүлгийн төгсгөлд Парламентын чуулганы нэгдсэн хуралдаанд улс төрийн бүлэг тус бүрээр үг хэлэх дээд хугацааг Парламент тогтооно.
- Парламент дахь бүлэг тус бүрийн үг хэлэх дээд хугацаа хоёр минут байх бөгөөд энэ хугацаанд санал гаргах ёстой.
- Чуулганы хуралдааны танхимд гишүүн бүрд суудал хуваарилна. Мөн Парламентын Ерөнхийлөгчийн ажлын алба нь Парламент дахь бүлэг тус бүрд тодорхой бүлэг суудал хуваарилна.
- Парламент нь Парламент дахь бүлгийн тодорхой сэдвийн талаар үг хэлэх дээд хугацааг болон сайд нарын үг хэлэх дээд хугацааг хязгаарлаж болно. Мөн хэлэлцүүлгийг зөвхөн нэг үе шаттайгаар явуулахаар шийдвэрлэж болно.
- Асуулт, асуулгын үеэр асуугч этгээдийн яриаг таслахыг хориглоно. Мөн Парламент дахь нэг бүлгийн гишүүд хоёроос илүүгүй асуулт асуух эрхтэй.

Төлөөлөгчдийн Танхимын одоогийн бүрэлдэхүүн

Нидерланд Улсын Төлөөлөгчдийн Танхим нь 100 суудалтай байсан бөгөөд 1956 онд энэ тоо 150 болж нэмэгдсэн нь өнөөг хүртэл хэвээр байна.

Өнөөгийн Хамтарсан Засгийн газар нь түр Засгийн газар бөгөөд Эрх чөлөө, ардчиллын төлөөх ардын нам [Volkspartij voor Vrijheid en Democratie] (24 суудал), Христийн ардчилсан холбоо [Christen-Democratisch Appil] (5 суудал), Ардчилсан 66 [Democraten 66] (9 суудал), Христийн нэгдэл [ChristenUnie] (3 суудал) намуудын хоорондын хэлэлцээрийн үр дүнд 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр үүсгэн байгуулагдсан.

Төлөөлөгчдийн Танхим дахь сөрөг хүчин нь: Эрх чөлөөний төлөө нам [Partij voor de Vrijheid] (37 суудал), Ногоон зүүн-Хөдөлмөрийн нам [GroenLinks–PvdA] (25 суудал), Нийгмийн шинэ гэрээ [Nieuw Sociaal Contract] (20 суудал), Тариаланч иргэдийн хөдөлгөөн [BoerBurgerBeweging] (7 суудал), Социалист нам [Socialistische Partij] (5 суудал), ДЕНК [DENK] (3 суудал), Амьтдын төлөө нам [Partij voor de Dieren] (3 суудал), Ардчиллын төлөөх форум [Forum voor Democratie] (3 суудал), Калвинист улс төрийн нам [Staatkundig Gereformeerde Partij] (3 суудал), Вольт [Volt Nederland] (2 суудал), Зөв хариулт 2021 [Juiste Antwoord 2021] (1 суудал) байна.

2023 оны Нидерланд Улсын бүх нийтийн сонгуульд Эрх чөлөөний төлөө нам ялалт байгуулсан. Эрх чөлөөний төлөө нам нь бусад гурван намтай (либерал-консерватив Эрх чөлөө, ардчиллын төлөөх ардын нам, тариаланчдын эрхийн төлөө Тариаланч иргэдийн хөдөлгөөн, баруун-төвийн үзэл баримтлалтай Нийгмийн шинэ гэрээ) хамтарч олонхын Засгийн газар байгуулахаар хэлэлцээр хийж байна.

Гэсэн ч Эрх чөлөөний төлөө намаас Лалын сүм хийд, Исламын сургууль, Коран судрыг хориглох тухай хуулийн төслийг санал болгохоор төлөвлөж байсан тул хэлэлцээр тасалдсан. Үүнээс гадна Нийгмийн шинэ гэрээ намын дарга Питер Омцигт мэдэгдэл хийхдээ Засгийн газрын санхүүгийн байдалд цочирдсон бөгөөд одоогоор хэлэлцээрийг түр зогсоохоор төлөвлөж байна гэж мэдэгджээ. Тэрээр Эрх чөлөөний төлөө намын дарга болох Вилдерсийн хэлэлцээрийг хянахаар сонгосон Хөдөлмөрийн намын Засгийн газрын сайд асан Рональд Пластеркийг хоёр долоо хоногийн өмнө хүлээн авсан санхүүгийн мэдээллийг энэ долоо хоногт л нийтэлсэн гэж шүүмжилжээ.

2024 оны 03-р сарын байдлаар Эрх чөлөөний төлөө намын дарга Хиэрт Вилдерс өөрийгөө Ерөнхий сайд болох боломжгүй гэдгээ хүлээн зөвшөөрсний дараа эвслийн хэлэлцээр нь илүү тодорхой зорилготой болсон. Хэлэлцээрт оролцож буй дөрвөн нам нь голчлон технократ

Засгийн газар байгуулах зорилготой байна. Намуудын хооронд үүссэн санал зөрөлдөөнтэй холбоотойгоор Эрх чөлөөний төлөө нам тэргүүтэй Парламентад олонх болсон эвсэл, эсхүл Парламентын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулах цөөнхийн Засгийн газар байгуулах боломжгүй гэсэн дүгнэлтийг эвслийн хэлэлцээрт оролцож буй зуучлагчийн зүгээс гаргасан юм.

2.4.Өмнөд Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос Улс) нь ерөнхийлөгчийн засаглалтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм. Улс төрийн түүхийн үүднээс 1948 оноос өнөөг хүртэл нийт 6 удаа Бүгд найрамдах улс тунхагласан гэж үздэг. 1948 оны 07 дугаар сарын 17-ны өдөр анхдугаар Үндсэн хуулиа баталсан бөгөөд түүнээс хойш 5 удаа шинэчлэн найруулсан.

Үндсэн хуульд Үндэсний Ассамблейн “...гишүүдийн тоог хуулиар тогтоох бөгөөд 200-аас доошгүй байна.” гэж заасан²³⁴ боловч Үндэсний Ассамблейн 2020 оны сонгуулиар байгуулагдсан өнөөгийн парламент 300 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байдаг.²³⁵ Үндэсний Ассамблейг холимог сонгуулийн тогтолцоогоор бүрдүүлдэг. 253 гишүүнийг нэг мандаттай тойргуудаас мажоритар аргаар, үлдэх 47 гишүүнийг пропорционал тогтолцоогоор тус тус сонгодог. Эдүгээ улс төрийн долоон нам Үндэсний Ассамблейд суудалтай байна.

Хүснэгт 3. Үндэсний Ассамблейн түүхэн товчоон²³⁶

Бүгд найрамдах улс	Улс төрийн дэглэм	Засаглалын хэлбэр	Үндэсний Ассамблей	Хугацаа
Нэгдүгээр	Авторитар	Ерөнхийлөгчийн	I-IV	1948-1960
Хоёрдугаар	Ардчилсан	Парламентын	V	1960-1961
Гуравдугаар	Авторитар	Ерөнхийлөгчийн	VI-VIII	1963-1972
Дөрөвдүгээр	Авторитар	Ерөнхийлөгчийн	IX-X	1973-1980
Тавдугаар	Авторитар	Ерөнхийлөгчийн	XI-XII	1981-1988
Зургадугаар	Ардчилсан	Ерөнхийлөгчийн	XIII-XVI	1988-

Үндэсний Ассамблей дахь намын бүлэгтэй холбоотой харилцааг дараах хуулиудаар зохицуулна:

- Үндсэн хууль (Constitution, 1987);
- Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act, 2012);
- Улс төрийн намын тухай хууль (Political Parties Act, 2022).

²³⁴ Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

²³⁵ Үндсэн хуулийн 42 дугаар зүйл

²³⁶ https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/70195/1/kjps_15_1_25-42.pdf

Бүлгийн эрх зүйн байдал

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Үндэсний Ассамблейд 20-оос дээш гишүүнтэй улс төрийн нам бүлэг (negotiating party) байгуулна.” Мөн аль нэг бүлэгт харьяалалгүй 20 болон түүнээс дээш тооны гишүүд нэгдэн нийлж тусдаа бүлэг байгуулж болдог. Тухайн бүлгийг төлөөлөх этгээд нь бүлгийн нийт гишүүдийн гарын үсэг зурж, тамга дарсан бүртгэлийн хуудсыг Үндэсний Ассамблейн даргад өргөн барьснаар бүлэг албан ёсоор байгуулагдсанд тооцогдоно. Бүлгийн харьяалах гишүүд, эсхүл намд өөрчлөлт орсон тохиолдолд тэр тухайгаа Үндэсний Ассамблейн даргад нэн даруй мэдэгдэх ёстой. Ямар нэгэн бүлэгт харьяалагддаггүй гишүүн намын харьяалалд орох, эсхүл намын харьяаллаа өөрчлөх бол мөн энэ тухайгаа нэн даруй Үндэсний Ассамблейн даргад мэдэгддэг.²³⁷

Нам, эвслийн бүлэг (бүлэг)-ийн зохион байгуулалтын үндсэн зорилго²³⁸ нь улс төрийн нам, эвсэл, тэдгээрийн бүлгийн гишүүдийн дунд үр дүнтэй яриа хэлэлцээ хийх, мэдээлэл шуурхай түгээх, дамжуулах болон солилцох нээлттэй суваг бий болгох явдал юм. Ингэснээрээ улс төрийн нам, эвслийн бүлгийн гишүүдийн зүгээс хэлэлцэх асуудлын талаар урьдчилан мэдээлэл цуглуулах, тухайн асуудлыг шийдвэрлэх, боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах, гаргах боломжийг хангаж парламентын хууль тогтоох үйл ажиллагааг улам хөнгөвчилж, илүү үр дүнтэй болгоход чиглэгддэг.

Бүлгийн нийт гишүүдийн тооны харьцаа нь чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүний тоог тогтоох, байнгын хороо, тусгай хорооны гишүүдийн тоог тодорхойлох, тэдгээрийг томилоход гол чухал үндэслэл болдог.

Үндэсний Ассамблей дахь бүлэг бүр өөрийн төлөөлөх этгээд (Representative Member)-ээ сонгох бөгөөд тухайн сонгогдсон гишүүн нь улс төрийн намын дарга буюу, эсхүл улс төрийн намын төлөөлөгчөөс ялгаатай юм. Бүлэг төлөөлөх этгээд нь шууд Төрийн байгуулалт (House Steering Committee)-ын болон Тагнуул (Intelligence Committee)-ын хорооны гишүүн болдог.

Бүлгийн гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлэг тус бүр өөрийн бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтныг томилон ажиллуулдаг. Бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтныг Бүлэг төлөөлөх этгээдийн санал болгосноор Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө. Бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтан нь төрийн албаны тусгай албан хаагч байх бөгөөд ажилтны тоо, түүнд тавигдах шаардлага, зэрэг дэв, томилох, чөлөөлөх зэрэг харилцааг Үндэсний Ассамблейн дүрмээр зохицуулдаг байна.

²³⁷ Үндэсний Ассамблейн тухай хуулийн 33 дугаар зүйл

²³⁸ <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/contents.do?menuNo=1500025>

Чуулганы хуралдаантай холбоотой бүлэгт хамаарах зохицуулалт

- Үндэсний Ассамблейн гишүүдийн хуралдааны танхимд суух суудлын хуваарийг Үндэсний Ассамблейн дарга, бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж тогтооно. Нэгдсэн саналд хүрээгүй тохиолдолд суудлын хуваарийг Үндэсний Ассамблейн дарга тогтооно;
- Үндэсний Ассамблейн дарга Үндэсний Ассамблей дахь бүлгийн төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж жилийн ажлын үндсэн төлөвлөгөөг (үүнд төрийн захиргааны хяналт шалгалтыг багтаана) жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор батална;
- нэгдсэн хуралдааныг үдээс хойш 14 цагт нээдэг (Бямба гаригийн үдээс өмнө 10 цагт) боловч гагцхүү Үндэсний Ассамблейн дарга, бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хуралдааныг нээх цагийг өөрчилж болдог;
- нэгдсэн хуралдааныг олон нийтэд нээлттэй явуулдаг. Гагцхүү Үндэсний Ассамблейн даргын санал болгосноор, эсхүл 10 болон түүнээс дээш гишүүд гарын үсэг зурж, горимын санал гаргаснаар, эсхүл Үндэсний Ассамблейн дарга үндэсний аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзэн бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөнөөр нэгдсэн хуралдааныг хаалттай явуулж болдог;
- 20 ба түүнээс дээш тооны гишүүд гарын үсэг зурж горимын санал гаргаснаар, эсхүл Үндэсний Ассамблейн дарга шаардлагатай гэж үзэн бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөн тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга ээлжит чуулганы товыг хэсэгчилж өөрчлөх, эсхүл тухайн өдрийн нэгдсэн хуралдааны товд хэлэлцэх асуудлыг нэмж оруулах болон дараалал өөрчилж болно;
- нэн яаралтай горимоор асуудал шийдвэрлэх болсон үед Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн тохиолдолд хуульд заасан зарим зохицуулалтыг дагаж мөрдөхгүй байж болно;
- Төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхэд жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төсвийн болон бусад дагалдах хуулийн төсөлд байнгын хороо бүр санал, дүгнэлтээ гаргасан байх ёстой бөгөөд энэ хугацаанд санал, дүгнэлтээ гаргаагүй бол гаргасанд тооцож тухайн хуулийн төслүүдийг дараах өдөр нэгдсэн хуралдаанд шилжүүлдэг зохицуулалттай боловч Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн тохиолдолд энэхүү заалтыг үйлчлэхгүй байхаар тогтож болдог байна;

Бүлэг үг хэлэх, асуулт, асуулга тавихтай холбоотой зохицуулалт

- Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж тухайн хэлэлцэх асуудлаар үг хэлэх нийт хугацааг бүлэг бүрийн гишүүний тоонд хуваан тогтоож хуваарилна. Энэ тохиолдолд бүлэг төлөөлөх этгээд нь ногдсон цагт үг хэлэх гишүүдийн тоо болон бүлгийн үг хэлэх гишүүдийн хугацааг тогтоож Үндэсний Ассамблейн дарга урьдчилж мэдэгдэнэ. Нэгдсэн хуралдаан нээгдмэгц Үндэсний Ассамблейн дарга 1 цагаас илүүгүй хугацаагаар гишүүдэд Үндэсний Ассамблейн хэлэлцэж буй хуулийн төсөл, санал хүсэлт зэрэг бусад Үндэсний Ассамблейд хамаарах асуудлаар 5 минут хүртэл хугацаанд үг хэлэх зөвшөөрөл олгож болно. 5 минут чөлөөтэй үг хэлэхийг хүссэн гишүүн хуралдаан эхлэхээс багадаа 4 цагийн өмнө үг хэлэх саналаа хэлэх үгийн товч агуулгын хамтаар Үндэсний Ассамблейн даргад танилцуулж бүртгүүлнэ. 5 минутын чөлөөтэй үг хэлэх гишүүний тоо, дарааллыг бүлэг бүрийн гишүүний тооны харьцааг харгалзан үзэж Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж тогтооно;
- хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон асуудлаар Үндэсний Ассамблейн гишүүн эсрэг, эсхүл дэмжиж буй байр сууриа илэрхийлж мэтгэлцэх хүсэлтээ Үндэсний Ассамблейн даргад урьдчилан мэдэгдэнэ. Үндэсний Ассамблейн дарга энэ мэдэгдлийг хүлээж авсан дараалал болон тухайн байр сууриа илэрхийлэх гишүүний харьяалагдаж буй бүлгийг харгалзан үзэж эсрэг байр суурьтай болон дэмжиж байгаа гишүүнийг ээлжлэн үг хэлүүлэх ба хамгийн багадаа нэг эсрэг байр суурьтай гишүүний үгийг сонсоно;
- санал хураалт явуулахдаа Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн тохиолдолд нээлттэй, эсхүл нууц санал хураалтыг цахим төхөөрөмжийг ашиглан явуулж болно;
- хуралдааны тэмдэглэлийг гишүүд болон олон нийтэд тараана. Үндэсний Ассамблейн дарга нууцад хамаарах, эсхүл үндэсний аюулгүй байдалд холбогдолтой гэж үзсэн хэсгийн тухайд үг хэлсэн гишүүн, эсхүл түүний харьяалах намын бүлгийг төлөөлөх этгээдтэй зөвлөлдөж тухайн хэсгийг нийтлэхгүй байж болно;
- нэгдсэн хуралдааны тогтоолоор Ерөнхий сайд, Засгийн газрын төлөөлөгч, эсхүл Засгийн газрын гишүүнийг хуралдаанд оролцуулах тухай хүсэлтийг гаргаж болно. Энэ тохиолдолд тухайн хүсэлтийг 20-оос доошгүй гишүүн бичгээр гаргана. Хүсэлтийг хүлээн авсан Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүн Үндэсний Ассамблейн даргын, эсхүл хорооны даргын зөвшөөрлийг авсан тохиолдолд Ерөнхий сайдын өмнөөс Засгийн

газрын гишүүн, Засгийн газрын гишүүний өмнөөс Засгийн газрын төлөөлөгчийг оролцуулж асуултад хариулж болно. Энэ тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй, эсхүл хорооны дарга нь гүйцэтгэх нарийн бичигтэй тус тус зөвлөлдөнө;

- Засгийн газарт асуулга тавихад асуулгын сэдэв бүрд асуулт тавих гишүүдийн тоог Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөний дараа тогтооно. Үндэсний Ассамблейн дарга асуулт тавих гишүүдийн тоог бүлгийн гишүүдийн тоо, хувь хэмжээний дагуу хуваарилна. Бүлэгт харьяалагдаагүй гишүүдийн асуулт тавих гишүүний тоог Үндэсний Ассамблейн дарга бүлгийн төлөөлөгч гишүүдтэй зөвлөлдөж тогтооно.

Бүлэг хороодод ажиллахтай холбоотой зохицуулалт

- бүлэг төлөөлөх этгээдүүд нь Үндэсний Ассамблейн Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн байна;
- Төсөв, данс тооцооны тусгай хороо нь 50 гишүүнтэй байна. Тус хорооны гишүүдийг бүлэг болон байнгын хорооны гишүүний тооны харьцааг харгалзан үзэж бүлэг тус бүрийг төлөөлөх этгээдийн хүсэлтийг үндэслэн Үндэсний Ассамблейн дарга томилно;
- Ёс зүйн хяналтын зөвлөх хороо нь хорооны даргыг оролцуулан 8 зөвлөхтэй байх ба зөвлөхүүдийг хорооны дарга бүлэг тус бүрийг төлөөлөх этгээдийн санал болгосноор томилно. Бүлэг тус бүрийг төлөөлөх гишүүдийн санал болгох зөвлөхийн тоо нь тухайн бүлгийн гишүүний тооны харьцаанаас хамаарна. Энэ тохиолдолд хамгийн олон гишүүнтэй бүлгийг төлөөлөх этгээдийн санал болгосон Зөвлөх хорооны гишүүний тоо нь бусад бүлгийг төлөөлөх гишүүний санал болгосон Зөвлөх хорооны гишүүний тоотой адил байх ёстой;
- Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөнөөр өргөн мэдүүлсэн сонгуулийн тухай хууль тогтоомжийн төсөл зэргийг хянан үзэх зорилгоор Сонсголын тусгай хороо байгуулж болно. Ерөнхийлөгчөөр сонгогдсон этгээд Ерөнхий сайдад нэр дэвшигчийн талаар сонгол явуулах хүсэлт гаргасан тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга Үндэсний Ассамблей дахь бүлэг тус бүрийг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцөн Сонсголын тусгай хороогоор сонгол явуулна;
- Тагнуулын байнгын хорооны гишүүнийг бүлэг төлөөлөх этгээдүүдээс санал болгосон нэр дэвшигч дундаас Үндэсний Ассамблейн дэд дарга болон бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөнөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө;

- хороодын гишүүний томилгоог хийсний дараа бүлгийн гишүүний тоонд өөрчлөлт орсон тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга бүлэг бүрд ногдох тоог өөрчилж хорооны гишүүдийг дахин томилж болно;
- бүлэг бүр Хорооны гүйцэтгэх нарийн бичгийн даргыг томилно;
- нэгдсэн хуралдааны шийдвэр гарсан, эсхүл Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцөж шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд хороог нэгдсэн хуралдааны үеэр хуралдуулдаггүй;
- хороод нь бүртгэлтэй гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүдийн хүсэлтээр хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор хэлэлцэх асуудлын дарааллыг зохицуулах зорилгоор хэлэлцэх асуудлын жагсаалтыг зохицуулах хороог байгуулж болно. Зохицуулах хороо нь зохицуулах хорооны даргыг оролцуулан нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зохицуулах хороог бүрдүүлэхдээ Үндэсний Ассамблей дахь бүлгийн тооны харьцааг үндэслэнэ.
- Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн хороонд хариуцуулсан асуудлаар хорооны санал, дүгнэлт гаргах хугацааг тогтоож болно.

Хүснэгт 4. Үндэсний Ассамблейд суудалтай намууд, тэдгээрийн бүлэг²³⁹

Нам, эвслийн бүлэг		Тойргоос сонгогдсон гишүүд	Намын жагсаалтаар сонгогдсон гишүүд	Тоо	Хувь	
1	Олонх	Солонгосын Ардчилсан нам (Democratic Party of Korea)	147	16	163	54.8
2	Цөөнх	Ард түмний хүч нам (People Power Party)	90	23	113	38.5
3	Бүлэггүй	Ногоон шударга ёс нам (Green Justice Party)	1	5	6	2.02
4		Шинэчлэлийн нам (Reform Party)	3	1	4	1.35
5		Жинбо нам (Jinbo Party)	1	0	1	0.34
6		Шинэ ирээдүй нам (New Future Party)	1	0	1	0.34
7		Шинэ дэвшилт холбоо (New Progressive Party)	0	1	1	0.34
8		Бие даагч	7	1	8	2.7

²³⁹ <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/contents.do?menuNo=1500025>

2.5. Финланд Улс

Эрх зүйн орчин

Бүгд Найрамдах Финланд Улс (Финланд Улс) нь парламентын засаглалтай Бүгд найрамдах улс юм. Тус улсын Парламент (Eduskunta) нь нэг танхимтай, 4 жилээр сонгогддог 200 гишүүнтэй. Парламентын 199 гишүүнийг олон мандат бүхий 12 тойргоос сонгуулийн пропорционал тогтолцоогоор, үлдсэн нэг гишүүнийг Аланд автономит бүсийн нэг мандаттай тойргоос сонгодог.²⁴⁰

Гишүүд нь Парламентад суудалтай улс төрийн намынхаа харьяаллын дагуу бүлэгт хуваагддаг ба одоогийн Парламентад намын 9 бүлэг байна.²⁴¹

Бүлгийн үйл ажиллагааг зохицуулдаг гол эрх зүйн баримт бичгүүдэд:

- Үндсэн хууль (Constitution²⁴²);
- Парламентын тухай хууль (Parliament Act of 1928²⁴³);
- Парламентын дэг (Parliament's rules of procedure²⁴⁴) хамаардаг.

Парламентын бүлгүүд нь Парламент шинээр байгуулагдсан үеэс эхлэн идэвхтэй ажиллаж ирсэн ч 2000 онд Үндсэн хуулиар тэдний үйл ажиллагааг хуульчилж хүлээн зөвшөөрчээ.²⁴⁵

Парламентын дэгийн 51 дүгээр зүйлд зааснаар тухайн Парламентын бүрэн эрхийн хугацаанд Парламент дахь бүлэг хамгийн багадаа 3 гишүүнтэй байгуулагдана.²⁴⁶ Гишүүн бүр бүлэгт заавал орох үүрэг байхгүй ч ихэнх гишүүд өөрийн намын бүлэгт харьяалагддаг.

Парламентын бүлэг нь дарга, дэд даргатай байх бөгөөд бүлгийн дарга нь бүлгийнхээ байр суурийг илэрхийлэх, бусад бүлэгтэй харилцан зөвшилцөж, хамтран ажиллах явдал юм. Парламентын дарга, дэд дарга санал, санаачилга гаргасан бүлгийн байр суурийг Парламентын бусад бүлгүүдэд танилцуулах, тэдэнтэй зөвшилцөх үүрэгтэй.

Бүлэг нь практик дээр Парламентын үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, Парламентаар хэлэлцэгдэж буй цаг үеийн аливаа асуудлыг гишүүд бүлгийн хуралдаанаараа хэлэлцэж, тухайн асуудалд бүлэг ямар байр суурь баримтлахаа шийддэг.

²⁴⁰ Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

²⁴¹ <https://www.eduskunta.fi/EN/kansanedustajat/eduskuntaryhm%c3%a4t/Pages/default.aspx>

²⁴² The Constitution of Finland. https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990731_20180817.pdf

²⁴³ Parliament Act of 1928. <https://www.refworld.org/legal/legislation/natlegbod/1928/en/95894>

²⁴⁴ Parliament's rules of procedure https://www.eduskunta.fi/EN/naineduskuntatoimii/Documents/RulesofProcedure_20150416.pdf

²⁴⁵ Stronger position for the parliamentary groups

<https://www.eduskunta.fi/EN/kansanedustajat/eduskuntaryhm%c3%a4t/Pages/default.aspx>

²⁴⁶ БНФУ-ын Парламентын хуралдааны дэг (Гарын авлага). “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх”. УБ., 2019 он.

Бүлэг ихэвчлэн Пүрэв гарагт хуралдах бөгөөд хэлэлцэгдэж буй асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол санал хураалт явуулж болно. Гэсэн хэдий ч аливаа бүлэг зөвшилцөлд хүрэхийг хичээдэг.

Үндсэн хууль дахь Парламентын бүлгийн талаарх зохицуулалт

Финланд Улсын Үндсэн хуульд Парламентын бүлгүүдийн оролцоо, эрх, үүргийн талаар хэрхэн заасан тухай үзвэл:

- Парламентын ээлжит бус сонгууль (огцруулах)-ийн тухай. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын үндэслэл бүхий саналын дагуу, *парламентын бүлгүүдийн саналыг сонссоны дараа* Чуулганы хуралдааны үеэр ээлжит бус сонгууль явуулах тухай зарлиг гаргаж болно. (Үндсэн хуулийн 26 дугаар зүйл);
- *хориос доошгүй гишүүнтэй бүлэг* Засгийн газар, сайдуудын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар, сайдуудад асуулт, асуулга гаргаж болно. Санал асуулгын хариуг Засгийн газарт хүргүүлсэн өдрөөс хойш арван тав хоногийн дотор Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Санал асуулгыг хэлэлцсэний эцэст Засгийн газар, сайдад итгэл үзүүлэхгүй байх тухай санал гаргасан тохиолдолд парламентаас итгэл үзүүлэх эсэх асуудлыг авч хэлэлцэнэ. (Үндсэн хуулийн 43 дугаар зүйл);
- Ерөнхий сайдыг томилох тухай. Ерөнхий сайдыг Парламентаас сонгож, Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайдын гаргасан саналын дагуу Ерөнхийлөгч бусад сайдуудыг томилно. Парламентаас Ерөнхий сайдыг сонгохоос өмнө *парламентын бүлгүүд* Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүний асуудлаар хэлэлцдэг. Ерөнхийлөгч эдгээр хэлэлцээрийн үр дүн, парламентын дарга болон *бүлгүүдийн саналыг сонссоны дараа* Ерөнхий сайдад нэр дэвшүүлж буй хүнийг Парламентад танилцуулна. Парламент нээлттэй санал хураалт явуулж, нийт гишүүдийн талаас илүү хувь нь дэмжсэн тохиолдолд нэр дэвшигч Ерөнхий сайдаар сонгогдоно. (Үндсэн хуулийн 61 дүгээр зүйл).

Үг хэлэхтэй холбоотой парламентын бүлгийн зохицуулалт

Парламентын дэгийн 51 дүгээр зүйлд Парламентын бүлгийн үг хэлэх асуудлыг дараах байдлаар зохицуулжээ²⁴⁷:

- 1) Парламентын даргын зөвлөл өөрөөр шийдээгүй бол улсын төсөв, Засгийн газрын мэдэгдэл, тайлан, асуулгыг хэлэлцэх үед үг хэлэх зөвшөөрөл бүлэгт өгнө. Хэлэлцэж буй бусад асуудлаар

²⁴⁷ Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

- бүлэгт үг хэлэх зөвшөөрөл өгөх шийдвэрийг Парламентын даргын зөвлөл гаргана. Бүлэгт үг хэлэх зөвшөөрөл өгөхөд энэ дэгийн 50(2,3) дугаар зүйл²⁴⁸ үйлчилнэ;
- 2) бүлгийн үг хэлэх дараалал нь сонгуулийн дараа бүрдсэн парламентын бүлгийн хэмжээтэй уялдах бөгөөд хамгийн олон төлөөлөгчтэйгээс хамгийн цөөн төлөөлөгчтэй бүлэг гэсэн дарааллаар явагдана. Төлөөлөгчдийн тоо тэнцүү бүлгүүдийн үг хэлэх дарааллыг шодсоны үндсэн дээр Парламентын даргын зөвлөл тогтооно;
 - 3) Парламентын бүрэн эрхийн хугацаанд Парламентын бүлэг хамгийн багадаа гурван төлөөлөгчтэйгээр байгуулагдсан, эсхүл дарааллыг өөрчлөх бодитой шалтгаан байгаа тохиолдолд Парламентын даргын зөвлөл бүлгийн үг хэлэх дарааллыг өөрчилж болно;
 - 4) чуулган хуралдаж дуусахаас өмнө 2 дахь хэсэгт хамаарах бүлгүүд үг хэлсний дараа дахин үг хэлэх хүсэлт гаргавал Парламентын даргын зөвлөл шийдвэрлэнэ;
 - 5) Парламентын даргын зөвлөл дээр дурдсаныг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан удирдамж гаргаж болно.

Хороодтой холбоотой бүлгийн зохицуулалт

Парламент нь 17 байнгын хороотой, тэдгээрийн нэг нь Европын Холбооны асуудал хариуцсан байнгын хороо юм. Парламентын гишүүн хоёр байнгын хороонд харьяалагдаж болно. Байнгын хороод 17 гишүүн, 9 орон тооны бус гишүүнтэй, Үндсэн хороо 25 гишүүн, 13 орон тооны бус гишүүнтэй байна.

Хорооны гишүүдийг 4 жилийн хугацаатай томилно. Хорооны бүрэлдэхүүнд Парламентын бүлгүүдийн тооны харьцааг тусгасан байх ёстой бөгөөд бүлгүүд нь гишүүдээ томилдог.

Хорооны хуралдаан нь гишүүдийн 2/3-оос доошгүй нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааны ирц бүрдсэн гэж үзнэ.²⁴⁹

Хорооноос гаргасан баримт бичигтэй танилцах бүлгийн эрх

Аливаа асуудлыг хэлэлцэх бэлтгэлтэй холбоотой баримт бичгийг тухайн асуудал Хороогоор шийдвэрлэгдсэний дараа нийтэд нээлттэй болгоно.

²⁴⁸ 50.2.Төлөөлөгчдөд үг хэлэх зөвшөөрөл өгөхөөс өмнө Хороог төлөөлж үг хэлэх төлөөлөгчид, парламентын саналын талаар танилцуулах хэлэлцүүлэг явуулах үед саналын эхэнд гарын үсэг зурсан төлөөлөгчид, парламентаас томилогдсон байгууллагын тайланг тавих даргад, эсхүл тухайн байгууллагаас томилогдсон төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл өгнө. Спикер Хорооны дүгнэлтийг танилцуулах төлөөлөгчид зөвшөөрөл өгч болох бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад танилцуулга дууссаны дараа зарчмын зөрүүтэй саналын эхэнд гарын үсэг зурсан төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл өгч болно. Асуулгын хариуг өгсний дараа асуулгын эхэнд гарын үсэг зурсан төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл өгнө. (10/2016)

50.3.Спикер төлөөлөгчдөд хүсэлт гаргасан дарааллын дагуу үг хэлэх зөвшөөрөл өгөхөөс өмнө сайд, Засгийн газрын хууль зүйн канцлер, парламентын омбудсменд үг хэлэх зөвшөөрөл өгч болно.

²⁴⁹ Eduskunta Riksdagen page. <https://www.eduskunta.fi/EN/valiokunnat/Pages/default.aspx>

Хэрэв нууцын зэрэглэлтэй биш бол Хороонд болон Хорооны ажлын хэсэгт төлөөлөлгүй парламентын бүлэг шийдвэрлэгдэж буй асуудалтай холбоотой баримт бичгийн хуулбарыг авах эрхтэй байна. (Парламентын дэгийн 43а.1 дүгээр зүйл).

Үндсэн хуулийн 50.3 дугаар зүйлд заасны дагуу Хороо баримт бичгийг нууцын зэрэглэлтэй гэж зарласан бол баримт бичгийг нууцална.

2.6. Франц Улс

Бүгд Найрамдах Франц Улс (Франц Улс) нь хагас ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглалтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм. Үндсэн хуулиа 1958 оны 10 дугаар сарын 04-ний өдөр бүх нийтийн санал асуулгаар баталсан бөгөөд Тав дахь Үндсэн хууль гэж нэрлэдэг. Түүнээс хойш Үндсэн хуульд 24 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Франц Улсын Парламент нь дээд танхим болох Сенат, доод танхим болох Үндэсний Ассамблей гэсэн хоёр танхимтай. Сенат нь 348 гишүүнтэй, тус улсын орон нутгийн зөвлөлийн гишүүд болон гадаадад амьдарч буй Франц иргэдийн төлөөллөөс бүрдэнэ. Бүрэн эрхийн хугацаа 6 жил байх бөгөөд гишүүдийн тал хувь нь 3 жил тутамд шинэчлэн сонгогддог. Сенатын хувьд хууль тогтоох эрх мэдэл нь хязгаарлагдмал байна.

Үндэсний Ассамблей нь 577 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд бүх нийтийн шууд, нууц санал хураалтаар сонгогддог. Нэг мандаттай тойргийн зарчмаар санал хураалтын хоёр шаттай мажоритар системээр сонгодог. Одоогийн Үндэсний Ассамблей 16 дахь хууль тогтоох байгууллага бөгөөд Парламентын 10 бүлэгтэй, аль ч бүлэгт хамаарахгүй, гишүүдийг нэгтгэсэн 1 бүлэгтэй бөгөөд 5 бүлэг нь сөрөг хүчин болдог.²⁵⁰

Хүснэгт 5. Нам, эвслийн бүлгүүдийн гишүүнчлэл

	<i>Нам, эвслийн бүлэг</i>	<i>Тойргоос сонгогдсон гишүүд</i>	<i>Холбогдох гишүүд</i>	<i>Нийт</i>
1	Сэргэн мандалтын бүлэг (Renaissance)	159	10	169
2	Үндэсний цуглааны бүлэг (Rassemblement National)	88	0	88
3	Шинэ экологи, нийгмийн бүлэг (La France insoumise - Nouvelle Union Populaire écologique et sociale)	74	1	75
4	Бүгд Найрамдахчуудын бүлэг (Les Républicains)	58	4	62

²⁵⁰ Les groupes politiques actuels. <https://www.assemblee-nationale.fr/dyn/les-groupes-politiques>

5	Ардчилсан хөдөлгөөний бүлэг (Démocrate (MoDem et Indépendants))	50	0	50
6	Социалист нам (Socialistes et apparentés)	27	4	31
7	Horizons бүлэг (Horizons et apparentés)	29	1	30
8	Экологичид бүлэг (Écologiste – NUPES)	22	0	22
9	Ардчилсан БН зүүн (Gauche démocrate et républicaine – NUPES)	22	0	22
10	Хилийн чанад дахь бие даасан иргэд, эрх чөлөө (Libertés, Indépendants, Outre-mer et Territoires)	22	0	22
	Бүлгийн нийт гишүүд	551	20	571
	Бүртгэлгүй гишүүд (Non inscrit)	6	0	6
	Нийт суудал дүүрсэн	557		577
	Дүүрээгүй суудал	0		0
	Нийт суудал			577

Эх сурвалж: Үндэсний Ассамблейн цахим хуудас
https://www2.assemblee-nationale.fr/instances/liste/groupes_politiques/effectif

Хууль, эрх зүйн орчин

Үндэсний Ассамблей дахь намын бүлэгтэй холбоотой харилцааг Үндсэн хууль²⁵¹, Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулж байна.

Үндсэн хуульд 2008 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Танхим бүрийн хуралдааны дэгээр тэдгээрийн дотор байгуулагдсан Парламентын бүлгүүдийн эрхийг тодорхойлно. Тухайн танхим дахь сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдийн онцгой эрхийг хүлээн зөвшөөрнө.”²⁵² хэмээн Парламент дахь сөрөг хүчний (opposition groups) болон цөөнхийн бүлгүүд (minority groups) албан ёсны статусыг баталгаажуулан хуульчилсан.

Үндэсний Ассамблейн сөрөг хүчин болон цөөнхийн бүлгүүд нь Үндсэн хуулиар эрх зүйн хувьд баталгаажсан институт юм. Үндсэн хуулийн 48 дугаар зүйлд “Сард нэг удаа Парламент дахь сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдийн санаачилсан хэлэлцэх асуудлаар чуулган хуралдана.” гэж заасан байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн 51.1 дэх зүйлд зааснаар Үндэсний Ассамблейн сөрөг хүчин болон цөөнхийн бүлгүүд нь Парламентын бүлгүүдийн эрхийг тодорхойлж, давуу байдал, тусгай эрх олгохыг зөвшөөрдөг байна.

²⁵¹ Constitution of October 4, 1958. <https://www2.assemblee-nationale.fr/langues/welcome-to-the-english-website-of-the-french-national-assembly#chap5>

²⁵² Constitution of October 4, 1958, Art.51-1.

Бүлгийн эрх зүйн байдал

Үндэсний Ассамблей дахь сөрөг хүчний эрх зүйн байдал нь олон намын тогтолцоотой болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сөрөг хүчний эрх чөлөөг хангахыг зохицуулсан байна.

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуульд Парламентын олонхын бүлгээс бусад бүлгүүдийн албан ёсны статусыг Парламент дахь сөрөг хүчний (*opposition groups*) болон цөөнхийн бүлгүүд (*minority groups*) гэж ялгаж заагласан байна.

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 19.1-т Парламентын бүлэг байгуулах тухай тусгасан байна. Үүнд:

- гишүүд өөрсдийн улс төрийн адил төстэй байдлыг харгалзан бүлэг байгуулж болно. Бүлэг байгуулахад хамгийн багадаа 15 гишүүнтэй байна²⁵³;
- бүлэг нь харьяалагдах гишүүдийн гарын үсэгтэй мэдэгдэл, холбогдох гишүүдийн нэрсийн жагсаалт, бүлгийн даргын нэрийг хавсаргасан улс төрийн мэдэгдлийг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгчид уламжилснаар бүлэг байгуулсанд тооцно. Энэ мэдэгдэлд бүлгээ “сөрөг хүчин” гэж тодорхойлж, албан ёсны сэтгүүлд нийтэлнэ;
- хамгийн олон гишүүнтэй бүлгээс бусад нь өөрсдийгөө “сөрөг хүчин” гэж зарлаагүй бүлгийг **цөөнхийн бүлэг** гэж үзнэ. Цөөнхийн болон сөрөг хүчний бүлгүүдийн статус ижил боловч сөрөг хүчинд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцох эрх нь илүү олгогдсон байна;
- Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдэд хамаарах тодорхой бүрэн эрхийг Үндэсний Ассамблейн анхдугаар чуулганы эхэнд, дараа нь жил бүрийн ээлжит чуулганы эхэнд тодорхойлно;
- Үндэсний Ассамблейн гишүүн зөвхөн нэг бүлэгт харьяалагдана;
- аль нэг бүлэгт харьяалалгүй гишүүн өөрсдийн сонгосон бүлэгт тухайн бүлгийн зөвшөөрлөөр орж болно.

Бүлэг байгуулагдсаны дараа Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч нь бүлгүүдтэй тохиролцож, бүлгүүдийн гишүүдийн болон бүлэгт ороогүй гишүүдийн чуулганы нэгдсэн хуралдааны танхим дахь суух суудлыг хуваарилна.

²⁵³ БНФУ-ын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг (Гарын авлага). “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх”. УБ. 2019 он.

Бүлгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон бол Үндэсний Ассамблейн ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэх бөгөөд мөн энэ талаар албан ёсны сэтгүүлд нийтэлнэ.

Бүлгийн **хориглох зүйлийг** Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлд тусгасан. Үүнд:

- Үндэсний Ассамблейд хуралдааны дэгийн 19 дүгээр зүйлд заасан, эсхүл бусад хэлбэрээр хувийн, орон нутгийн, эсхүл албан тушаалын ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор өөрсдийн гишүүдийг захирамжлах, эрхийг хааж боогдуулах ямар ч бүлгийг байгуулахгүй;
- дээрх ашиг сонирхлыг илэрхийлэх зорилготой ямар ч төрлийн байнгын бүлэг ордонд хуралдахыг хориглоно.

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан бүлэг нь өөрсдийн томилсон ажлын алба, хэрэг эрхлэх газартай байж болно.

Чуулганы хуралдаантай холбоотой бүлгийн зохицуулалт

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлд Үндэсний Ассамблейн ерөнхийлөгчийн зөвлөл (цаашид “Ерөнхийлөгчийн зөвлөл”)-тэй холбоотой асуудалд **бүлэгтэй холбоотой зохицуулалтыг** тусгажээ:

- Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнд Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, байнгын хорооны дарга, Санхүү эдийн засаг, төсвийн хяналтын хорооны ерөнхий дарга, Европын ажил хэрэг эрхэлсэн хорооны дарга, бүлгийн дарга нараас бүрдэнэ;
- Ерөнхийлөгчийн зөвлөл нь шаардлагатай бол 7 хоног тутам хуралдах бөгөөд товыг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч тогтооно. Тэрээр мөн Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бүлгийн даргын хүсэлтээр Ерөнхийлөгчийн зөвлөлийг зарлан хуралдуулж болно;
- Ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд гишүүдээс гаргасан саналаар санал хураалт явуулах бөгөөд санал хураалтад тус зөвлөлийн бусад гишүүдийн саналыг хассаны дараа бүлгийн дарга нарт тухайн бүлгийн гишүүдийн тоотой тэнцэх хэмжээний саналын эрх олгоно;
- Түр хороодын дарга нарыг 80 дугаар зүйлд заасны дагуу хүсэлт гаргасан тохиолдолд Ерөнхийлөгчийн зөвлөлд урьж болно;

- Сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдийн дарга нар Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу долоо хоногийн хэлэлцэх асуудлын жагсаалтыг гаргаж, Ерөнхийлөгчийн зөвлөл хуралдахын өмнөх өдөр танилцуулна. Хурлыг ээлжит чуулган бүрийн эхэнд сөрөг хүчний бүлэг, цөөнхийн бүлгүүдийн тооны харьцааг харгалзсан бүрэлдэхүүнтэй хуралдуулна. Бүлэг тус бүр ээлжит чуулганы хугацаанд 3-аас доошгүй удаа хуралдана;
- Батлагдсан хэлэлцэх асуудлын жагсаалтыг Засгийн газар, бүлгүүдийн болон хороодын дарга нарт хүргүүлнэ. Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч нь зөвлөлийн хурлын дараа Засгийн газраас Үндэсний Ассамблейд оруулсан асуудлаас бусад саналыг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ. Үндэсний Ассамблей саналыг бүхэлд нь шийдвэрлэнэ. Тус хуралдаанд зөвхөн Засгийн газрын төлөөлөл илтгэл тавьж болох бөгөөд хуралд оролцож буй хороодын дарга нар, эсхүл Ерөнхийлөгчийн зөвлөлд оролцсон төлөөлөгчид саналын талаар 2 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж болно. Нэг бүлгээс нэг илтгэгч үг хэлнэ;
- Ерөнхийлөгчийн зөвлөл хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу хэлэлцүүлэг явуулах хугацааг тогтооно. Энэ хугацааг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч хэлэлцүүлгийн хугацаанаас хамаарч бүлэг тус бүрд тэнцүү хугацааг олгоно. Аль ч бүлэгт харьяалалгүй гишүүдэд тэнцүү хугацааны үг хэлэх боломж олгоно. Үлдсэн хугацааг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч бүлгүүдэд тэдний гишүүдийн тооны харьцаанд тохируулан хуваарилна;
- Сөрөг хүчний бүлгүүдэд бусад бүлгүүдэд олгосон хугацаанаас илүү хугацаа олгоно. Нэмэлт хугацааны 60 хувь нь сөрөг хүчний бүлгүүдэд хуваарилагдах бөгөөд үүнийг тэдгээрийн гишүүдийн тооны харьцаанд тохируулан хуваарилна. Үлдсэн нэмэлт хугацааг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч бүлгийн гишүүдийн тооны харьцаанд тохируулан хуваарилна. Бүлэгт ороогүй гишүүдэд тэдний тоонд нь харьцуулан үг хэлэх нийт хугацааг хуваарилна;
- Гишүүд нэг бүлгээс нөгөөд чөлөөтэй шилжих, бүлгүүд статусаа чөлөөтэй өөрчлөх эрх²⁵⁴ нь асуудалд байр сууриа илэрхийлэх боломжийг бүлгүүдэд тэгш олгодог. Эдгээр байр сууриуд давхцах магадлал багатай тул парламент үргэлж сөрөг хүчинтэй байх бөгөөд энэ нь хоёр намын тогтолцооноос илүүтэйгээр өөр өөр үзэл бодлын бодит тэнцвэрийг тусгадаг байна.

²⁵⁴ Мөн тэнд. Art.19-3, 21.

Сөрөг хүчний эрх зүйн байдал

Сөрөг хүчний бүлгүүд нь парламентын үйл ажиллагаанд оролцох давуу эрхээр хангагдаж байгаа эсэхээс ихээхэн хамаарах ба Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулиар сөрөг хүчин болон цөөнхийн бүлгүүдэд хэд хэдэн эрхийг олгосон.

Засгийн газарт сөрөг хүчний бүлгүүдийн үзүүлэх нөлөө нь парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцох оролцооноос ихээхэн хамаардаг бөгөөд энэ засаглал хоорондын хяналт, тэнцвэрийг хангах төдийгүй олонх, цөөнхийн хоорондын харилцааны арга хэрэгсэл юм.

Долоо хоног бүрийн Засгийн газрын цагаар чуулганы хуралдаанд товлосон асуултын талаас доошгүй хувийг нь сөрөг хүчний гишүүд асуух зохицуулалтыг Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд тусгасан байна.²⁵⁵

Франц Улсад Парламентын хяналтын хүрээнд сөрөг хүчин нь олонхтой адил тэгш боломжоор хангагдаад зогсохгүй, зарим талаар давуу байдал, тусгай эрх эдлэх боломжийг мөн хуулиар зохицуулжээ.

Үндэсний Ассамблейд сөрөг хүчний гишүүдийг удирдах албан тушаалд томилох замаар давуу байдал, тусгай эрхийг баталгаажуулсан. Тухайлбал, Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулиар Мөрдөн шалгах хорооны дарга нь сөрөг хүчний бүлгийн гишүүн байна²⁵⁶, Тус хорооны ажлын алба нь дарга, 4 дэд дарга, 4 нарийн бичгийн даргаас бүрдэх ба Үндэсний Ассамблейн улс төрийн төлөөлөл, бүтцийг бүрэн тусгасан байдлаар дээрх томилгоог хийдэг байна.²⁵⁷

Санхүү, эдийн засаг, төсвийн хяналтын хорооны даргаар сөрөг хүчний гишүүнийг сонгоно.²⁵⁸ Мөн Төрийн бодлогын үнэлгээ, хяналтын хорооны дэд дарга нарын нэг нь²⁵⁹, хорооноос томилогдсон хоёр илтгэгчийн нэг нь сөрөг хүчний гишүүн байна.²⁶⁰

Дээрх зохицуулалтууд нь төсвийн бүрдүүлэлт, гүйцэтгэлийн гол асуудал болох Засгийн газрын үйл ажиллагаанд парламентын хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий чухал хороодын удирдах албан тушаалд сөрөг хүчний төлөөллийг томилохоор заасан нь парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд сөрөг хүчний оролцоог нэмэгдүүлэх, хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд ихээхэн анхаардгийг илэрхийлж байна.

²⁵⁵ Règlement de l'Assemblée Nationale. Art.133. https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte_reference/02_reglement_assemblee_nationale#

²⁵⁶ Мөн тэнд. Art.143-2.

²⁵⁷ Мөн тэнд. Art.143-1.

²⁵⁸ Мөн тэнд. Art.39-3.

²⁵⁹ Мөн тэнд. Art.146-2-4.

²⁶⁰ Мөн тэнд. Art.146-3-3.

Үндэсний Ассамблейд олонхын бүлэг нь нэг, сөрөг хүчний бүлэг хэд хэд байх боломжтой учраас сөрөг хүчнүүд парламентын хяналтын хөшүүргийг илүү үр дүнтэй ашиглах боломж, бололцоогоор хангагддаг байна.

Үндэсний Ассамблей дахь нийт бүлгүүдэд парламентын бүхий л үйл ажиллагаанд тэгш оролцох эрх олгосон байдаг. Тухайлбал, Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 28, 47-1, 10-3 дугаар зүйлд гишүүдийг Үндэсний Ассамблейн аль нэг албан тушаалд томилох, 146 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт төсвийн илтгэгчдийг томилоход Үндэсний Ассамблей дахь бүлгүүдийн төлөөллийг бүрэн хамарсан байхаар зохицуулсан байна.

ГУРАВ. УИХ ДАХЬ ОЛОН НАМЫН ОРОЛЦОО БА УИХ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1. УИХ дахь олон намын оролцоо (1990-2020 он)

Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын анхдугаар Үндсэн хууль 1924 онд батлагдаж, улмаар 1940, 1960 онд шинэчлэгдэж байсан бөгөөд 1990 онд батлагдсан 1960 оны Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиудаар улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн бүхий л харилцааны эх үндсийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тогтоож байв.

1990 оноос өмнө БНМАУ-ын Ардын Их Хурал (АИХ) хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага байв. Нэг намын авторитар тогтолцоотой байсан тухайн үед бүх нийтийн санал хураалтаар АИХ-ын депутатуудыг аймаг, нийслэл, сум, дүүргээс нэг мандаттай, зөвхөн санал болгосон хүнийг дугуйлах замаар сонгож байсан. Тиймээс БНМАУ-ын АИХ-ын үед парламент дахь намын бүлэг, цөөнхийн талаарх ойлголт байхгүй байсан. 1990 оны 07 дугаар сард Монгол Улсад анх удаа олон намын оролцоотой анхны чөлөөт, ардчилсан сонгууль болж АИХ-ыг шинэчлэн байгуулж байсан. Энэхүү АИХ нь “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийг батлан гаргаж, уг хуулийн дагуу хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын Бага Хурал (УБХ)-ыг байгуулсан. АИХ-ын 430 депутатаас сонгогдсон 50 гишүүнтэй УБХ нь 1990-1992 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн. УБХ бол Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн байгууллыг шинэтгэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн анхны байнгын үйл ажиллагаатай парламент юм. Тухайлбал, улс төрийн харилцааны хувьд олон намын тогтолцоог баталгаажуулсан ардчилсан дэглэмд шилжсэн, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, баталгааг хангах үндсэн үүргийг төр хариуцах болсон.

Өөрөөр хэлбэл, олон ургалч үзлийг нийгмийн оюун санааны эш үндэс болгосон. Энэ бол ардчиллын чухал үнэт зүйлсийн нэг юм. Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн Цэцийн тухай болон БНМАУ-ын шүүхийн байгууламжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталж, төрийн байгууллын шинэ тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Эдийн засгийн харилцааны хувьд нийтийн өмчид суурилсан аж ахуйн социалист тогтолцоо дангаар ноёрхож байсныг халж, олон хэвшилт эдийн засагтай болох харилцааг хуульчлан баталгаажуулсан. Шударга өрсөлдөөнд үндэслэсэн зах зээлийн эдийн засгийн харилцааг тогтоож, түүнд төрийн оролцоог хязгаарлаж өгсөн. Хувийн ба нийтийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, төрийн өмчийг задлан хувьчлах, иргэд хувийн аж ахуй эрхлэх эрх зүйн үндсийг тогтоож, банк, гааль, албан татварын зэрэг хуулиудыг шинэчлэн баталжээ.

УБХ-аас боловсруулж АИХ-ын чуулганд хэлэлцүүлсэн Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хууль 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсанаар нийгмийн бүх хүрээнд ардчилсан зарчмыг тууштай хэрэгжүүлэх эрх зүйн харилцааны тулгуур эхлэл тавигдсан юм.

Ийнхүү 1992 оны 07 дугаар сарын 29-ний өдөр УБХ Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн дагуу сонгогдон Монгол Улсын Их Хурал (УИХ)-д эрхээ шилжүүлэн өгснөөр үйл ажиллагаа нь дуусгавар болсон.²⁶¹

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”²⁶² хэмээн баталгаажуулж, нэг танхимтай парламентын тогтолцоонд шилжсэнээс хойш эдүгээ 8 дахь парламентын бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж байна.

1992 онд анхны УИХ хууль тогтоох үйл ажиллагаагаа эхлүүлж, парламентын 76 гишүүн, 4 жилийн хугацаатай чөлөөт ардчилсан сонгуулиар сонгогдож ирсэн. 1992 оноос УИХ-ын гишүүдийг сонгох сонгуулийг томсгосон болон жижиг тойрог бүхий мажоритар тогтолцоогоор зохион байгуулж ирсэн бол 2012 оны УИХ-ын сонгуулийг анх удаа холимог тогтолцоогоор явуулж байв.

²⁶¹ УИХ-ын цахим хуудас. <https://www.parliament.mn/nn/2348/>

²⁶² Монгол Улсын Үндсэн хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

Хүснэгт 6. УИХ-ын сонгуулийн товчоон (1992-2020 он)

Сонгуулийн он цагийн дараалал	Сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч	УИХ дахь нам, эвслийн харьцаа
1990-1992 (УБХ)	УБХ-ын 50 гишүүнийг сонгогчдын 5, түүнээс дээш хувийн санал авсан намд УБХ-ын мандат буюу суудал хувь тэнцүүлэн хуваарилж (5 хувьд 1 мандат), намууд сонгуулиар авсан мандатынхаа тоогоор нэр дэвшүүлж АИХ-аас сонгосон.	МАХН 33, Монголын ардчилсан нам 13, Монголын Социал-демократ нам 4, Монголын Үндэсний дэвшлийн нам 3 суудал авсан.
1992-1996	Нам, эвсэл: 8 нам, 2 эвсэл Нийт нэр дэвшигч: 293 Нам, эвслээс нэр дэвшигч: 275 Бие даан нэр дэвшигч: 18	Нийт сонгогчдын 57.1 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 70 суудалтай, харин 31.1 хувийн санал авсан Ардчилсан нам 5 суудал авсан.
1996-2000	Нам, эвсэл: 5 нам, 2 эвсэл Нийт нэр дэвшигч: 302 Нам, эвслээс нэр дэвшигч: 267 Бие даан нэр дэвшигч: 35	Сонгогчдын 45.7 хувийн саналыг авсан Ардчилсан нам УИХ-д 50 суудалтай, харин 39.9 хувийн санал авсан МАХН 25 суудал авсан.
2000-2004	Нам, эвсэл: 13 нам, 3 эвсэл Нийт нэр дэвшигч: 602 Нам, эвслээс нэр дэвшигч: 575 Бие даан нэр дэвшигч: 27	Сонгогчдын 51.5 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 72 суудалтай, харин 24.1 хувийн санал авсан Ардчилсан нам 1 суудал авсан.
2004-2008	Нам, эвсэл: 7 нам, 1 эвсэл Нийт нэр дэвшигч: 244 Нам, эвслээс нэр дэвшигч: 229 Бие даан нэр дэвшигч: 15	Сонгогчдын 48.8 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 36 суудалтай, харин 44.8 хувийн санал авсан Ардчилсан нам 36 суудал авсан.
2008-2012	Нам, эвсэл: 12 нам, 1 эвсэл Нийт нэр дэвшигч: 356 Нам, эвслээс нэр дэвшигч: 311 Бие даан нэр дэвшигч: 45	Сонгогчдын 43 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 45 суудалтай, харин 39.2 хувийн санал авсан Ардчилсан нам 28 суудал авсан.
2012-2016	Нам, эвсэл: 11 нам, 2 эвсэл Нийт нэр дэвшигч: 544 Нам, эвслээс нэр дэвшигч: 518 Бие даан нэр дэвшигч: 26	Томсгосон мажоритар 26 тойргоос 48 нэр дэвшигч сонгох сонгуульд сонгогчдын 33.5 хувийн саналыг авсан МАН 17 суудал авсан бол 34.2 хувийн саналыг авсан АН 25 суудал, 17.9 хувийн санал авсан МАХН 3 суудал авсан. Харин намын жагсаалтаар сонгогдох 28 нэр дэвшигчийг намууд авсан саналын хэмжээтэй дүйцэхүйц хэмжээгээр хувааж авчээ.

<p>2016-2020</p>	<p><i>Нам, эвсэл:</i> 12 нам, 3 эвсэл <i>Нийт нэр дэвшигч:</i> 498 <i>Нам, эвслээс нэр дэвшигч:</i> 429 <i>Бие даан нэр дэвшигч:</i> 69</p>	<p>Сонгогчдын 46.5 хувийн саналыг авсан МАН УИХ-д 65 суудалтай, харин 34.2 хувийн санал авсан Ардчилсан нам 9 суудалтай болжээ.</p>
<p>2020-2024</p>	<p><i>Нам, эвсэл:</i> 13 нам, 4 эвсэл <i>Нийт нэр дэвшигч:</i> 606 <i>Нам, эвслээс нэр дэвшигч:</i> 485 <i>Бие даан нэр дэвшигч:</i> 121</p>	<p>АН-11 Бие даагч-1 Зөв хүн электрот хөдөлгөөн-1 Та бидний эвсэл-1</p>

Харин 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулиар Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд орсон өөрчлөлтийн дагуу 126 гишүүнтэй парламент бүрдэнэ. Энэ удаагийн УИХ-ын сонгууль нь сонгуулийн холимог тогтолцоогоор явагдана. Ингэхдээ 78 гишүүнийг томсгосон мажоритар, 48 гишүүнийг нэг тойргийн хаалттай жагсаалт бүхий пропорциональ тогтолцоогоор сонгоно.

3.2. УИХ дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн орчны өөрчлөлт

Монгол Улсын байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан цагаасаа хойш УИХ-ын тухай болон УИХ-ын хуралдааны дэгээ хэд хэдэн удаа шинэчлэн баталсан.

Хүснэгт 7. УИХ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн жагсаалт

	УИХ-ын бүрэн эрхийн хугацаа	УИХ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж
1	1990-1992 (УБХ)	- БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль (1990.05.10)
2	1992-1996 (УИХ)	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (1992.01.06)
3	1996-2000	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (1997.02.07) - Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг (1997.02.06)
4	2000-2004	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2001.06.21) - Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг (УИХ-ын тогтоол, 2001, №61)
5	2004-2008	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2006.01.26)
6	2008-2012	- Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг (УИХ-ын тогтоол, 2006, №14)
7	2012-2016	- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007.10.11)
8	2016-2020	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2020.05.07)
9	2020-2024	- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2020.05.13)

Эх сурвалж:

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он (Эх сурвалж, харьцуулсан судалгаа). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/additional/?lawid=356>

1992 оны парламентаас хойш Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага, УИХ-д сөрөг хүчин буюу цөөнхийн бүлгийн асуудлыг хуулиар зохицуулах шаардлага үүссэн. УИХ дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой гол ойлголт, нэр томъёонууд түүхэн хөгжлийн үүднээс агуулга, хүрээний хувьд өргөжиж, тухай тухайн үеийнхээ Монгол Улсын Их Хурлын тухай хууль (МУИХТХ) болон холбогдох хуулиуддаа тусгагдаж ирсэн.

Хүснэгт 8. Улсын Их Хурлын тухай хуулиар УИХ дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой асуудлыг зохицуулсан байдал

	Асуудал	УИХ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж
1	Намын бүлэг	1992 оны МУИХТХ-ийн 17.1-т “Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал бүхий нам бүлэг байгуулж болно.” гэж томъёолж байсан бол 2006 оны МУИХТХ-аас “Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулж болно.” гэж өөрчлөн найруулсан. Тооны хувьд 8 суудал байх гэсэн шалгуур тогтвортой мөрдөгдөж иржээ.
2	Намын бүлгийн эрх, үүрэг	1992 оны МУИХТХ-аас намын бүлгийн эрх, үүргийг 6 байхаар томъёолж байсан. Дараа дараагийн хуулиудад хүрээ, зохицуулалт өргөжсөөр 2020 оны УИХТХ-д 9 болсон байна. Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу.
3	Цөөнх	1992 оны хуулиас “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны ажиллагаа ... цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.” гэж орсон. 1997 оны МУИХТХ-аар “Улсын Их Хурлын нийт гишүүний 39-өөс доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнхөд тооцно.” гэж анх томъёолсон. Түүнээс хойших МУИХТХ-уудад нарийвчлан тусгагдаж ирсэн.
4	УИХ-ын дэд дарга	2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “...Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно. “ гэсэн зохицуулалт орсон. 2001 оны МУИХТХ-д энэ асуудлыг нарийвчлан тусгаж, улмаар 2006, 2020 оны хуулиудад дэд дарга нарын томилгоо, эрх, үүрэг, чөлөөлөх, огцруулах зэрэг нарийвчилсан зохицуулалтууд орсон байна.
5	Бүлгийн ажлын алба	1992 оны МУИХТХ-д “Улсын Их Хурал дахь намын бүлэг орон тооны ажилтантай байж болно.” гэсэн заалт байсан бол 2006 оны МУИХТХ-аас “Бүлэг нь бодлогоо боловсруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий ажлын албатай байх” зохицуулалт орсон.

6	УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөл	2006 оны МУИХТХ-аас “Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.” гэсэн заалт орсон.
7	Байнгын хороод, дэд хороод	1992 оны МУИХТХ-аас “Улсын Их Хурлын дарга Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар намуудын бүлгийн ахлагч нартай зөвшилцсөнөөр Улсын Их Хурал өөрийн гишүүдээс сонгон Байнгын хороог байгуулна.” 1997 оны МУИХТХ-иас “Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэгт ордог Улсын Их Хурлын гишүүдээс сонгоно.” гэсэн зохицуулалт, 2019 онд Үндсэн хуульд “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэсэн нэмэлт орсон. Үүнтэй холбоотойгоор 2020 оны МУИХТХ-д “...хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор хойшлуулахгүйгээр байгуулна.”
8	Дэгийн тухай хууль	1997 онд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль анх батлагдсан, тус хуулийг 2007, 2020 онд тус тус шинэчлэн найруулсан. Энэхүү хуульд намын бүлэг, цөөнхийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтуудыг тусгасан.

Дэлгэрэнгүйг хавсралт хүснэгтээс харна уу.



АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Opposition and Legislative Minorities: Constitutional Roles, Rights and Recognition. International IDEA. <https://www.idea.int/sites/default/files/publications/opposition-and-legislative-minorities-constitutional-roles-rights-recognition.pdf>
- Guidelines on the rights and duties of the opposition in parliament: <http://archive.ipu.org/dem-e/opposition.pdf>
- Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

Австрали Улс

- Australian Constitution. <https://www.aph.gov.au/constitution>
- House of Representatives Practice (7th edition). www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7
- House of Representatives Standing and Sessional Orders. www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_and_Sessional_Orders
- Parliament of Australia. <https://www.aph.gov.au/>
- Parliamentary Education Office. <https://peo.gov.au/>
- The Politics of Australia. Jaensch, Dean.
- Introduction to the Study of the Law of the Constitution. AV Dicey.
- Commonwealth Table of Precedence. Special Gazette No. S206 of 5 October 1982.

Герман Улс

- <https://www.deutschland.de/en/topic/politics/the-german-parliament-and-the-parties>
- Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль.
- Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хууль.

Нидерланд Улс

- Хуулиар дамжуулан ардчиллыг бататгахын төлөө Европын комисс, Ардчилсан парламентад сөрөг хүчний үүрэг оролцооны тухай. [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2010\)025-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2010)025-e)
- Хуулиар дамжуулан ардчиллыг бататгахын төлөө Европын комисс, Ардчилсан нийгэм дэх парламентын олонх ба сөрөг хүчний хоорондын харилцааны параметрууд: Хяналтын

хуудас. [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2019\)015-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2019)015-e)

- Хуулиар дамжуулан ардчиллыг бататгахын төлөөх Европын комисс, Ардчилсан парламент дахь сөрөг хүчний эрх, үүргийн талаарх процедурын удирдамж. <https://assembly.coe.int/nw/xml/XRef/Xref-XML2HTML-en.asp?fileid=11792&lang=en>

БНСУ

- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=25732&lang=ENG
- https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=60320&lang=ENG
- <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/main.do#section1>
- https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/70195/1/kjps_15_1_25-42.pdf
- <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/contents.do?menuNo=1500025>
- [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2022/733582/EPRS_BRI\(2022\)733582_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2022/733582/EPRS_BRI(2022)733582_EN.pdf)

Финланд Улс

- The Constitution of Finland. https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990731_20180817.pdf
- Parliament's rules of procedure https://www.eduskunta.fi/EN/naineduskuntatoimii/Documents/RulesofProcedure_20150416.pdf
- Eduskunta Riksdagen page. <https://www.eduskunta.fi/EN/valiokunnat/Pages/default.aspx>
- БНФУ-ын Парламентын хуралдааны дэг (Гарын авлага). “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх”. УБ., 2019 он

Франц Улс

- Constitution of October 4, 1958: <https://www2.assemblee-nationale.fr/langues/welcome-to-the-english-website-of-the-french-national-assembly#chap5>
- Règlement de l'assemblée nationale. https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte_reference/02_reglement_assemblee_nationale#
- Rights and responsibilities of the opposition in the parliament. http://www.assembly.coe.int/LifeRay/APCE/pdf/ConfPres/2010Limassol/Droitsetresponsabilitesparlement_E.pdf

- Report on the role of the opposition in a democratic Parliament, adopted by the Venice Commission, at its 84th Plenary Session (Venice 15-16 October 2010).
- [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?ref=cdl-ad\(2010\)025&lang=EN](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?ref=cdl-ad(2010)025&lang=EN)
- Thomas Kucig. Government dominance and the role of opposition in parliamentary democracies. <https://ejpr.onlinelibrary.wiley.com/doi/10.1111/1475-6765.12525>
- В.В.Маклаков. Парламент Франции. <https://cyberleninka.ru/article/n/parlament-frantsii-perevod-zakonodatelnyh-aktov/viewer>
- БНФУ-ын талаарх мэдвэл зохих баримтууд, Б.Туул,2023 : <https://montsame.mn/en/read/319540>
- <https://www.assemblee-nationale.fr/dyn/les-groupes-politiques>
- https://www2.assemblee-nationale.fr/instances/liste/groupes_politiques/effectif
- <https://www2.assemblee-nationale.fr/deputes/liste/groupe-politique>

ХАВСРАЛТ. УИХ-ын тухай хууль дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын түүхчилсэн лавлагаа (1992-2020 он)

Нэр томъёо	1992.01.06	1997.02.07	2007.06.21	2006.01.26	2020.05.07
<p>Намын бүлэг</p>	<p>5.3.Улсын Их Хурлын нийт гишүүний ердийн олонх буюу 39-өөс доошгүйн бүрэн эрх хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нам, эсхүл эвслийг Улсын Их Хурал дахь олонхын суудал авсан нам буюу эвсэлд тооцно.</p> <p>17.1.Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал бүхий нам бүлэг /цаашид “намын бүлэг” гэх/ байгуулж болно. Улсын Их Хурлын гишүүн зөвхөн өөрийнх нь нэр дэвшүүлсэн намын бүлэгт харьяалагдана.</p>	<p>17.1.Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам/эвсэл/бүлэг /цаашид “нам, эвслийн бүлэг” гэх/ байгуулж болно. Нам, эвслийн бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэрийг нь дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд орно.</p> <p>Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал эзэлбэл Монгол Улсын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар эвслийн нэг бүлэг байгуулна.</p>	<p>21.1.Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам/эвсэл/бүлэг /цаашид “нам, эвслийн бүлэг” гэх/ байгуулж болно. Нам, эвслийн бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэрийг нь дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд орно. Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал эзэлбэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар эвслийн нэг бүлэг байгуулна.</p>	<p>26.1.Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг /цаашид “бүлэг” гэх/ байгуулж болно.</p> <p>26.2.Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэр нь албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.</p> <p>26.3.Сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан бол эвслийн нэг бүлэг байгуулна.</p>	<p>33.1.Бүлэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>33.1.1.хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн дотоод, гадаад бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх;</p>

<p>Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулан оролцсон намууд 8-аас доошгүй суудал эзэлсэн Их Хурлын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар Улсын Их Хуралд нам (эвсэл)-ын нэг бүлэгтэй байна.</p>	<p>17.2. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэдэн намыг төлөөлж буй гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулж болохгүй. Харин тэдгээр нь аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох бөгөөд хэрэв нам, эвслийн бүлэгт нэгдсэн шилжих бол тухай бүр Улсын Их Хурлын даргад мэдэгдэнэ.</p>	<p>21.2. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэд хэдэн намыг төлөөлж байгаа гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулж болохгүй. Харин тэдгээр нь аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэх бол тухайн нам, эвслийн бүлэгт нэгдэн орох хүсэлтээ тавина. Хүсэлтийг хүлээн авсан бол энэ тухай шийдвэрээ нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уг баримт бичгийг үндэслэн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд албан ёсоор мэдээлнэ.</p>	<p>26.4. Улсын Их Хуралд 8-аас дээш суудал авсан нам татан буугдсан, эвсэл тарсан бол бүлгийг татан буугдсанд тооцох ба түүний бүрэлдэхүүнд байсан гишүүд дахин бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>26.5. Нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад бичгээр өргөн мэдүүлэх бөгөөд ийнхүү өргөн мэдүүлснээр бүлэг эрх, үүргээ хэрэгжүүлнэ.</p>	<p>33.1.2. ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын даргад саналаа илэрхийлэх;</p> <p>33.1.3. нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;</p> <p>33.1.4. нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах;</p>
<p>Бие даан нэр дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд аль нэг намын бүлэгт нэгдэн ажиллах боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй. Улсын Их Хуралд 8 хүрэхгүй суудал бүхий хэд хэдэн намын гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулахыг хориглоно. Харин тэдгээр нь аль нэг намын бүлэгт эвсэн нэгдэж болно.</p>	<p>17.3. Аль нэг нам, эвслийн бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харьяаллаас татгалзсан тохиолдолд эвслийн бүлгээс албан ёсоор гарч болно. Ийнхүү нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарах тухайгаа тухайн нам, эвслийн бүлгийн ахлагчид урьдчилан мэдэгдсэн байна.</p> <p>21.4. Нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй.</p>	<p>21.3. Аль нэг нам, эвслийн бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харьяаллаас татгалзсан тохиолдолд нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарч өөр бүлэгт нэгдэн орж болно. Ийнхүү нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарах тухайгаа тухайн нам, эвслийн бүлгийн ахлагчид урьдчилан мэдэгдсэн байна.</p> <p>21.4. Нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй.</p>	<p>26.6. Бүлэг даргаа гишүүдийнхээ дотроос сонгож, энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад албан ёсоор мэдээлнэ.</p>	<p>33.1.5. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргад зөвшилцөж;</p>

<p>17.5.Намын бүлэгт Улсын Их Хурлын бүтцийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагад шууд хариуцахгүй.</p>	<p>17.4.Нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй.</p> <p>17.5.Нам, эвслийн бүлэг ахлагчаа гишүүдийнхээ дотроос сонгож энэ тухайгаа Улсын Их Хуралд албан ёсоор мэдэгдэнэ.</p> <p>17.6.Нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгогдсоноос хойш 24 цагийн дотор нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.</p> <p>21.7.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлгээс өргөн мэдүүлсэн баримт бичгийг үндэслэн нам, эвслийн бүлгийг бүртгэж, энэ тухай Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор зарлана. Шинээр нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нэгдвэл түүнийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч бүлэгтээ бүртгэн авч, энэ тухай шийдвэрээ гаргаж Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уг шийдвэрийг нэгдсэн хуралдаанд албан ёсоор мэдүүлнэ.</p>	<p>21.5.Нам, эвслийн бүлэг ахлагчаа гишүүдийнхээ дотроос сонгож, энэ тухайгаа Улсын Их Хуралд албан ёсоор мэдэгдэнэ.</p> <p>21.6.Нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгогдсоноос хойш 24 цагийн дотор нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.</p> <p>21.7.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлгээс өргөн мэдүүлсэн баримт бичгийг үндэслэн нам, эвслийн бүлгийг бүртгэж, энэ тухай Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор зарлана. Шинээр нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нэгдвэл түүнийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч бүлэгтээ бүртгэн авч, энэ тухай шийдвэрээ гаргаж Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уг шийдвэрийг нэгдсэн хуралдаанд албан ёсоор мэдүүлнэ.</p>	<p>26.7.Бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор мэдүүлнэ.</p> <p>26.8.Шинээр нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдвэл тухайн бүлгийн дарга Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд тус тус албан ёсоор мэдүүлнэ.</p> <p>/Энэ хэсгийг 2012.12.21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p> <p>26.9.Бие даан нэр дэвшиж сонгогдсон болон ээлжит сонгуулиар 8-аас доош суудал авсан өөр нам, эвслийн төлөөлөл бүхий гишүүд нийлж нэг бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>26.10.Энэ хуулийн 26.9-т заасан гишүүд аль нэг бүлэгт нэгдэж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг энэ хуулийн 26.8-д заасны дагуу мэдүүлнэ.</p>	<p>31.1.Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд наймаас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг /цаашид “бүлэг” гэх/ байгуулж болно.</p> <p>31.2.Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.</p> <p>31.3.Бүлэг даргаа гишүүдийнхээ дотроос сонгож, энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад бичгээр мэдүүлнэ.</p> <p>31.4.Нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлгийн эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.</p> <p>31.5.Бие даан нэр дэвшиж сонгогдсон болон ээлжит сонгуулиар наймаас доош суудал авсан өөр өөр нам, эвслийн төлөөлөл бүхий гишүүд нийлж нэг бүлэг байгуулахыг хориглоно.</p>
--	---	---	--	---



<p>31.6.Гишүүн бүлгээс гарсан бол өөр бүлэгт нэгдэн орохыг хориглоно.</p> <p>31.7.Бүлгээс гарсан гишүүд нэгдэж бие даан бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>31.8.Нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдсэн бол тухайн бүлгийн дарга нь, гишүүн аль нэг бүлгээс гарсан бол энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад бичгээр тус тус ирүүлснийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонстоно.</p> <p>31.9.Улсын Их Хуралд бүлэг байгуулсан нам татан буугдсан, эвсэл тарсан бол бүлгийг татан буугдсанд тооцох ба түүний бүрэлдэхүүнд байсан гишүүд нэгдэн дахин бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>31.10.Энэ хуулийн 31.9-д заасан гишүүн аль нэг бүлэгт нэгдэн орсон бол энэ хуулийн 31.8-д заасны дагуу мэдээлнэ.</p>	<p>26.11.Гишүүд нэг бүлгээс гарч нөгөө бүлэгт нэгдэн орж болгох боловч ийнхүү бүлгээс гарсан гишүүд нэгдэж бие даан бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>26.12.Энэ хуулийн 26.11-т заасны дагуу гишүүн аль нэг бүлгээс гарсан, нөгөө бүлэгт нэгдэн орсон бол тухайн бүлгийн дарга, Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд тус тус албан ёсоор мэдээлнэ.</p> <p><i>/Энэ хэсгийг 2012.12.21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</i></p>	<p>21.8.Улсын Их Хуралд суудал бүхий аль нэг нам тарах буюу намууд эвслээ цуцалбал тухайн нам, эвслийн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно. Нам тарсан буюу намууд эвслээ цуцалсан тухай шийдвэрийг, ийнхүү шийдвэр гарснаас хойш хуралдах эхний нэгдсэн хуралдаанд, чуулганы завсарлагааны үед уг шийдвэр гарвал ээлжит чуулганы эхний нэгдсэн хуралдаанд тус тус мэдээлнэ.</p> <p>21.9.Нам, эвслийн бүлгийн хуралдааныг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн даваа гаригт зохион байгуулж байна.</p>	<p>17.7.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлгээс өргөн мэдүүлсэн баримт бичгийг үндэслэн нам, эвслийн бүлгийг бүртгэж, энэ тухай Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр албан ёсоор зарлана. Шинээр нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт эвсэн нэгдвэл, түүнийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч бүлэгтээ бүртгэн авч, энэ тухай шийдвэр гаргана. Уг шийдвэрийг гишүүний өргөдлийн хамт гишүүний бүрэн эрх нь эхэлснээс хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр албан ёсоор мэдээлнэ.</p>	
--	--	--	--	--

<p>Намын бүлгийн эрх, үүрэг</p>	<p>18.1.Улсын Их Хурал дахь бүлэг дараах эрх, үүрэгтэй:</p> <p>1/Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үндэслэл, тус тусын санал, дүгнэлт гаргах;</p> <p>2/чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;</p> <p>3/Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үед завсарлага авах;</p>	<p>17.8.Улсын Их Хуралд суудал бүхий аль нэг нам тарах буюу намууд эвслээ цуцалбал тухайн нам, эвслийн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно. Нам тарсан буюу намууд эвслээ цуцалсан тухай шийдвэрийг, энэхүү шийдвэр гарснаас хойш 72 цагийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр, чуулган хуралдаагүй үед энэхүү шийдвэр гарвал ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 72 цагийн дотор чуулганы хуралдаан дээр тус тус мэдэгдэнэ.</p> <p>18.1.Нам, эвслийн бүлэг дараах эрх, үүрэгтэй:</p> <p>1/Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үндэслэл, бодлогын талаар тус тусын санал, дүгнэлт гаргах;</p> <p>2/чуулган, Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг татан оролцуулж, хуралдааны дэгийг чанд сахиулах;</p> <p>3/чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;</p>	<p>22.1.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг дараах эрх, үүрэгтэй:</p> <p>22.1.1.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үндэслэл, бодлогын төслийн талаар тус тусын санал, дүгнэлт гаргаж, тухайн асуудал хариуцсан Байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн хуралдаанд оруулах;</p> <p>22.1.2. чуулган, Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг татан оролцуулж, хуралдааны дэгийг чанд сахиулах;</p>	<p>27.1.Бүлгийн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>27.1.1.хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн гадаад, дотоод бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх;</p> <p>27.1.2.ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын даргад саналаа илэрхийлэх;</p>	<p>31.11.Улсын Их Хурлын гишүүд хамтран Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгээс өөр зохион байгуулалтын аливаа хэлбэр үүсгэхийг хориглоно.</p> <p>31.12.Бүлгийн даргыг чөлөөлөх, огцруулах, шинээр томилох асуудлыг бүлгийн нийт гишүүдийн олонхын саналаар шийдэж, шийдвэрээ Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлнэ. Улсын Их Хурлын дарга уг шийдвэрийг нэгдсэн хуралдаанд уншиж сонсоно.</p>
					<p>33.1.6.бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>33.1.7. нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах;</p> <p>33.1.8.хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;</p> <p>33.1.9.бүлгийн ажлын албаны ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.</p>

	<p>27.1.3.нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;</p> <p>27.1.4.нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах;</p> <p>27.1.5.Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>27.1.6./Энэ заалтыг 2010.12.30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p> <p>27.1.7.бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>27.1.8.нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах;</p> <p>27.1.9.хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;</p> <p>27.1.10.бүлгийн ажлын албаны ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.</p>		<p>22.1.3. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;</p> <p>22.1.4. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;</p> <p>27.1.5. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>27.1.6./Энэ заалтыг 2010.12.30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p> <p>27.1.7. бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>27.1.8. нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах;</p> <p>27.1.9. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;</p> <p>27.1.10. бүлгийн ажлын албаны ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.</p>	<p>4/Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;</p> <p>5/бүлгийн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>6/Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>7/Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах;</p> <p>8/чуулганаар хэлэлцэж буй асуудлаар нам, эвслийн бүлгийн байр суурийг боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллуулах.</p> <p>18.2. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн бусад эрх, үүргийг Улсын Их Хурал хуулиар тогтоож болно.</p> <p>18.3. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн нам, эвслийг төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүн дараах эрх, үүрэгтэй:</p> <p>1/Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааны дэгийг сахиж;</p>		

		<p>2/Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох тухай асуудлаа Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>3/Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, харьяалагдах Байнгын хороонд оруулах.</p>	<p>28.1. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны /цаашид “хуралдаан” гэх/ ажиллагаа хууль дээдлэх, дэгээ чанд сахиж, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.</p>	<p>23.1. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи буюу 39 ба түүнээс дээш суудал авсан нам буюу эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид “олонхи”/-д тооцно.</p> <p>23.2. Улсын Их Хурлын нийт гишүүний 38-аас доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх /цаашид “цөөнх”/-д тооцно.</p>	<p>3.2. Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь хараат бус, нээлттэй, ил тод, хариуцлагатай, иргэдэд хүртээмжтэй байх бөгөөд асуудлыг тал бүрээс нь хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана.</p> <p>/Энэ хэсгийг 2010.12.30-ны өдрийн хуулиар нэмсэн/</p> <p>8.1. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийг Улсын Их Хурал дахь олонхи (цаашид “олонхи” гэх) гэнэ.</p> <p>/Энэ хэсэгт 2010.12.30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p> <p>8.2. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 38 ба түүнээс доош суудал авсан нам, эвсэл, гишүүнийг цөөнх (цаашид “цөөнх” гэх) гэнэ.</p>	<p>3.4. Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчимд нийцсэн, бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.</p> <p>11.1. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийг Улсын Их Хурал дахь олонх /цаашид “олонх” гэх/ гэнэ.</p> <p>11.2. Аль ч нам, эвсэл олонх болоогүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн, ийнхүү зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу олонхыг бүрдүүлнэ.</p>
--	--	---	--	---	--	--



<p>УИХ-ын дэд дарга</p>	<p>-</p>	<p>-</p>	<p>27.1. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн үр дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.</p> <p>27.3. Улсын Их Хурлын дэд дарга нар дараахь нийтлэг чиг үүрэгтэй:</p> <p>27.3.1. Улсын Их Хурлын Байнгын болон бусад хороод, нам, эвслийн бүлэг, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;</p>	<p>/Энэ хэсэгт 2010.12.30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p> <p>8.3. Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн авсан суудлыг зөвхөн тухайн нам, эвслээс нэр дэвшин сонгогдсон гишүүдийн тоогоор тодорхойлох бөгөөд үүнд бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүнийг оруулж тооцохгүй.</p> <p>12.1. Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.</p> <p>12.3. Энэ хуулийн 26.4-т зааснаар нам, эвслийн бүлэг тарсан бол тухайн бүлгээс сонгогдсон дэд даргыг чөлөөлөгдсөнд тооцож, энэ тухай тогтоол батлагдсанд тооцно.</p> <p>/Энэ хэсэгт 2010.12.30, 2012.12.21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p> <p>12.4. Улсын Их Хурлын дэд дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.4.1. Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;</p>	<p>11.3. Энэ хуулийн 11.1, 11.2-т зааснаас бусад Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх цаашид “цөөнх” гэх/ гэнэ.</p> <p>15.1. Улсын Их Хурлын дэд даргыг Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, илээр санал хурааж сонгоно. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.</p> <p>15.2. Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн, 10 дугаар зүйлд заасны дагуу гишүүний бүрэн эрх нь дуусгавар болсноос гадна өөрийнх нь хүсэлтээр, эсхүл нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгийн хүсэлтээр Улсын Их Хурлын дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, огцруулна.</p> <p>15.3. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг тарсан бол тухайн бүлгээс нэр дэвшүүлж сонгосон дэд даргыг чөлөөлсөн тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.</p>
-------------------------	----------	----------	--	--	---



<p>15.4. Улсын Их Хурлын дэд дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.4.1. Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;</p> <p>15.4.2. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны ирц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>15.4.3. Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>15.4.4. Улсын Их Хурлын даргаас хуваарилсан болон даалгасан чиг үүрэг;</p> <p>15.4.5. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.</p> <p>15.5. Улсын Их Хурлын даргын түр эзгүйд түүний даалгаснаар дэд дарга үүргийг нь хэрэгжүүлнэ.</p>	<p>12.4.2. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны ирц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>12.4.3. Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>12.4.4. Улсын Их Хурлын даргаас даалгасан бусад чиг үүрэг;</p> <p>12.4.5. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.</p> <p>12.5. Улсын Их Хурлын даргын түр эзгүйд түүний даалгаснаар дэд дарга үүргийг нь хэрэгжүүлнэ.</p>				
---	--	--	--	--	--



<p>УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөл</p>	<p>14¹.1. Улсын Их Хурлын даргын дэргэд дор дурдсан бүрэлдэхүүнтэй Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана:</p> <p>14¹.1.1. Улсын Их Хурлын дэд дарга;</p> <p>14¹.1.2. Байнгын хорооны дарга;</p> <p>14¹.1.3. нам, эвслийн бүлгийн ахлагч.</p> <p>14¹.2. Зөвлөл дараах чиг үүрэгтэй:</p> <p>14¹.2.1. Улсын Их Хурлын чуулганаар долоо хоногийн хэлэлцэх асуудлыг зөвшилцөх;</p> <p>14¹.2.2. шаардлагатай тохилдолд нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьг өдрөөс бусад ажлын өдөр хуралдах Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны хуваарийг тогтоох;</p> <p>14¹.2.3. Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдааны хуваарь тогтоох;</p> <p>14¹.2.4. Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудал.</p> <p>14¹.3. Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно.</p>	<p>14¹.3. Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал, Улсын Их Хурлын төсөв батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.</p>	<p>14.3. Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хургалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.</p>	<p>14.3. Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал, Улсын Их Хурлын төсөв батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.</p> <p>14.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын дарга, дэд дарга, нам, эвслийн бүлгийн дарга, Байнгын хороодын дарга, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэх/ орно. Шаардлагатай бол Зөвлөлийн хурлыг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй хийж болно.</p> <p>14.5. Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга батална.</p>
---	---	---	---	---



	/Энэ хэсэгт 2012.12.21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/				
14.6.Зөвлөлийн хуралдаанаар зөвшилцсөн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг дагаж мөрдөх үүрэгтэй.	11.5.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга батална.				
	11.6.Зөвлөлөөс баталсан чуулганы хуралдааны тов, хэлэлцэх асуудлын чиглэл, дарааллыг нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг дагаж мөрдөх үүрэгтэй.				
	/Энэ хэсэгт 2010.12.30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/				



<p>Бүлгийн ажлын алба</p>	<p>17.4. Улсын Их Хурал дахь намын бүлэг орон тооны ажилтантай байж болно. Намын бүлэг тухайн бүлгийн 2 гишүүнд нэг ажилтан байхаар тооцсон орон тооны ажилтантай байж болно. Намын бүлгийн гишүүдийн тоог харгалзан унаа, албан томилолт, бичиг хэргийн зардал, ажилтны цалингийн санг Улсын Их Хурлын төсөвт тусгана. Намын бүлэг батлагдсан төсвөө Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зарцуулна.</p>	<p>17.9. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг 2 гишүүнд орон тооны нэг ажилтан байхаар тооцож тогтоосон ажлын албатай байж болно. Ажилтнууд нь тухайн нам, эвслийн бүлгийн ажлын албанд харьяалагдана.</p>	<p>21.10. Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг 2 гишүүнд орон тооны нэг ажилтан байхаар тооцож тогтоосон ажлын албатай байж болно. Ажлын албаны дотоод зохион байгуулалтын асуудлыг дүрмээр зохицуулна.</p>	<p>27.2. Бүлэг нь бодлого боловруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий ажлын албатай байх бөгөөд түүний гүйцэтгэх үүргийг нь бүлгийн дүрмээр зохицуулна. Бүлгийн ажлын албаны ажилтны тоо тухайн бүлгийн гишүүдийн тооны хоёрны нэгтэй тэнцүү байх бөгөөд хэрэв бүлгийн гишүүдийн тоо 23 сондгой байгаа тохиолдолд дараагийн бүхэл тэгш тооноос тооцно.</p>	<p>33.2. Бүлэг нь бодлого боловруулахад нь зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байх бөгөөд түүний гүйцэтгэх үүргийг нь бүлгийн дүрмээр зохицуулна. Бүлгийн ажлын албаны ажилтны тоо тухайн бүлгийн гишүүдийн тооны хоёрны нэгтэй тэнцүү байх бөгөөд хэрэв бүлгийн гишүүдийн тоо 23 ба түүнээс доош бол тухайн бүлгийн ажлын албаны ажилтны тоо 12 хүртэл байна.</p>
	<p>21.11. Нам, эвслийн бүлэг батлагдсан төсвөө зохих журмын дагуу зарцуулах бөгөөд түүнд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.</p>	<p>21.12. Нам, эвслийн бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.</p>	<p>21.13. Нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагын өмнө шууд хариуцахгүй.</p>	<p>27.3. Бүлгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцах ба ажлын албаны цалин, унаа, албан томилолт, холбоо, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</p>	<p>33.3. Бүлгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг Тамгын газар хариуцах ба ажлын албаны цалин, унаа, албан томилолт, холбоо, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</p>
	<p>17.10. Нам, эвслийн бүлэг батлагдсан төсвөө зохих журмын дагуу зарцуулах бөгөөд түүнд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.</p>	<p>17.11. Нам, эвслийн бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.</p>	<p>17.12. Аль ч нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй Улсын Их Хурлын гишүүнд Тамгын газрын хавсарган томилсон ажилтан туслалцаа үзүүлнэ.</p>	<p>27.4. Бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хувьд эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хариуцахгүй.</p>	<p>33.4. Бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хувьд эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хариуцахгүй.</p>
	<p>17.13. Нам, эвслийн бүлэг хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагын өмнө шууд хариуцахгүй.</p>			<p>27.5. Бүлгийн төсвийн зарцуулалтад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.</p>	<p>33.5. Бүлгийн төсвийн зарцуулалтад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.</p>

**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЗӨВЛӨЛТЭЙ ХОЛБООТОЙ
ЗАРИМ АСУУДАЛ БОЛОН АЙМГИЙН ТӨВИЙН ХҮН АМ БА
СОНГОГДОХ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТООНЫ ХАРЬЦААНЫ ТАЛААРХ
ЛАВЛАГАА**

*Г.Билгээ, Э.Дашзэгвэ, Ц.Ариунаа,
Э.Билгүүн, П.Уранчимэ*

АГУУЛГА

УДИРТГАЛ

Нэг. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлтэй холбоотой зарим заалтын хэрэгжилт

Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын зардлын тооцоо

Гурав. Баг, хорооны ИНХ-ын дарга нарт олгох урамшууллын зардлын тооцоо

Дөрөв. Аймгийн төвийн хүн ам ба аймгийн төвөөс сонгогдох Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн тооны харьцаа

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



УДИРТГАЛ

Судалгааны захиалгын дагуу “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлтэй холбоотой зарим асуудал болон аймгийн төвийн хүн ам ба сонгогдох төлөөлөгчийн тооны харьцааны талаарх лавлагаа”-г Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны захиалгын даалгавар:

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхийг татан буулгаснаар хэлэлцэх асуудал бүрээр иргэдийн хурлыг цуглуулж хуралдуулах зэргээр учирч байгаа хүндрэл бэрхшээл, санал, гомдлыг тоймлож хийсэн дүгнэлт;

2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийг хурлын чөлөөт цагаар бие даасан шийдвэр гаргаж, түүнийгээ хуралдаанд танилцуулдаг байхаар тэдэнд Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор олгож байсан урамшуулал олгоход улсын хэмжээгээр улс, орон нутгийн төсвөөс гарах зардлын хэмжээ;

3.Багийн иргэдийн Нийтийн Хурлын даргыг 4 жилийн хугацаагаар сонгож дээрх Засгийн газрын тогтоолын дагуу урамшууллыг олгоход улс болон орон нутгийн төсвөөс гарах зардлын хэмжээ;

4.Аймгийн төвийн хүн амаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төлөөлөгч сонгох зохистой хувь хэмжээ.



Нэг. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлтэй холбоотой зарим заалтын хэрэгжилт

Өмнөх туршлага:

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө тус хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) болон иргэдийн Нийтийн Хурал (ИНХ)-ын хуралдааны чөлөө цагт нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг түүний Тэргүүлэгчид гүйцэтгэнэ” хэмээн заасан байсан.

2006 онд батлагдсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (ЗЗНДНТУТХ) (2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс хүчингүй болсон)-ийн 9 дүгээр зүйлд зааснаар Хурлын Тэргүүлэгчид нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцооны нэг хэсэг байх бөгөөд Хурлын хуралдааны чөлөө цагт бүрэн эрхийг нь Тэргүүлэгчид хэрэгжүүлдэг байсан. Энэ нь жилд 1-2 удаа болдог хуралдааны завсар хооронд Хурлын тасралтгүй үйл ажиллагааг хангахад чиглэгдсэн байна. Гэхдээ Үндсэн хууль, ЗЗНДНТУТХ-ийн аль алинд нь Тэргүүлэгчийг сонгох шалгуурыг тодорхойлоогүй. ЗЗНДНТУТХ-ийн 20 дугаар зүйлээр Хурлын Тэргүүлэгчийн бүрэн эрхийг тусгайлан заасны дээр өмч, газар эзэмших, ашиглах, үнэ, тариф тогтоох, Хурлын шийдвэрийг хүчингүй болгох гэх мэт Хурлын өөрийнх нь олон чухал эрх мэдлийг Тэргүүлэгчдэд шилжүүлжээ. Хурлын Тэргүүлэгчдийн тоо нийслэл, аймагт 7-11, сум, дүүрэгт 5-7, баг, хороонд 3-5 байсан. Энэ нь цөөн тооны эрх мэдэл бүхий хүмүүс Хурлын өмнөөс шийдвэр гаргах бололцоог олгож байв. Тухайлбал, баг байгуулах, түүний нутаг дэвсгэрийн заагийг тогтоох, ашигт малтмал хайх, олборлохтой холбоотой асуудал шийдвэрлэх зэрэг нутгийн өөрөө удирдах байгууллагын амин чухал асуудлыг ИТХ-ын Тэргүүлэгчид шийдэх болсон байна (Сэлэнгэ, Булган, Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн шийдвэрүүдийг судалж үзэхэд). Мөн түүнчлэн иргэд сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан орон нутгийнхаа үйл хэрэгт оролцох, төлөөллөө хэрэгжүүлэх зарчим алдагдахад хүрч байсан.²⁶³

Өнөөгийн байдал:

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр энэхүү “Тэргүүлэгчид” гэсэн бүтцээс татгалзсан. 2020 онд батлагдсан МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгаар ИТХ-ын Зөвлөлийг бий болгосон.

²⁶³ ЗНДНТУТХ-ийн хэрэгжилтийн байдал хийсэн дүн шинжилгээ, 2019 он.

Шинэчилсэн найруулгын 51 дүгээр зүйлд зааснаар “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг бүхий 5-7 хүртэл төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл байгуулна. Зөвлөлийг Хурлын дарга тэргүүлнэ.” Шинэчилсэн найруулгын 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт зааснаар ИТХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

ИТХ-ын Зөвлөлүүд үйл ажиллагаагаа МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгад заасны дагуу хэвийн явуулж байгаа хэдий ч энэхүү шинэ бүтэц нь тодорхой шийдвэр гаргах эрх мэдэлгүй учраас Хурлын хороодоос төдийлөн ялгарахгүй, давхардсан бүтэц болж байгаа талаар орон нутгаас тавьж буй шүүмжлэл нь бодит үндэслэлтэй гэж үзэж байна. УИХ-аас Зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталсан ба орон нутагт дагаж мөрдөж байна.²⁶⁴

Тулгамдсан асуудал:

2023 онд хийгдсэн шинэчилсэн найруулгын зарим зүйл, заалтын хэрэгжилтийн судалгаанд ИТХ-ын Зөвлөлийн талаарх зохицуулалтыг сайжруулах шаардлага үүсээд байгааг онцлон дурдаад ИТХ-аас зарим бүрэн эрхээ Зөвлөлд шилжүүлдэг байх боломжийг хуулиар нээж өгөх хувилбарыг судалсан байна.

Тус судалгаанд дурдсанаар ИТХ-ын Зөвлөлийн талаар хамгийн олон давтагдан гарсан санал, шүүмжлэлээс чухлыг нь тоймловол:

- Зөвлөл шийдвэр гаргах эрх мэдэлгүй байна;
- Зөвлөл Хурлын хороодоор нэгэнт хэлэлцсэн асуудлыг давхардуулан хэлэлцэх нь цаг дэмий үрж, Хурлын ажлын албанд илүү ачаалал үүсгэж, үр ашиг багатай байна;
- Зөвлөл шийдвэр гаргадаггүй учраас төлөөлөгчид Зөвлөлд орж ажиллах сонирхолгүй, орсон ч яваандаа залхаж байна;
- шинэчилсэн найруулгад заасан “хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах, хуралдааны бэлтгэл хангах, хуралдаан хоорондын хугацаанд Хурлын хороо, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах” чиг үүргээ хэрэгжүүлэхэд Зөвлөл хүчгүйдэж байна;
- Зөвлөл өмнө нь байсан “тэргүүлэгчид” шиг ажиллахгүй учраас Хурлын хуралдаанаар том, жижиг нийлсэн маш олон асуудал хэлэлцэх болдог, үүнээс болж хуралдааны чанар суларч байна.

²⁶⁴ ЗНДНТУТХ-ийн зарим зүйл, заалтын хэрэгжилт, 2023 он.

Уг нь хуралдаанд оролцож байгаа төлөөлөгчдийн үнэтэй цагийг стратегийн шинжтэй гол гол асуудлаа тал бүрээс нь хэлэлцэхэд зориулбал Хурлын ач холбогдол дээшилнэ;

- “Тэргүүлэгчид” байхгүй учраас хуулийн хугацаатай олон асуудал шийдэгдэхгүй хүлээгдэх, мөн Хурлын байгууллага “ажилгүй” сул зогсож байгаа мэт сэтгэгдэл иргэдэд төрж байна.

“Тэргүүлэгчид” байхгүй болсон нь дан ганц сөрөг үр дагавар авчирсан гэвэл бас өрөөсгөл болно. Хууль тогтоогчийн зүгээс “төлөөлөгч бүр бүрэн эрхээ хариуцлагатай хэрэгжүүлж, Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болно” гэсэн хүлээлт эхний үр дүнгээ өгч байгааг орон нутгийн төлөөллүүд онцолж байсан. Хурлын хороодын үйл ажиллагаа идэвхжиж, төлөөлөгчид өөрсдийгөө орон нутгийн чухал шийдвэр гаргагч нар гэдгээ ойлгож эхэлж байна. Зөвлөлд эрх шилжүүлдэг зохицуулалтыг бий болгосноор, нэг талаас Хурлын байгууллагын тасралтгүй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх боловч нөгөө талаас, Хурал бүрэн эрхээ “цөөхөн хэдэн хүнд” даатган орхидог хуучин практик сэргэж болзошгүй юм. Иймд Хурал эрх шилжүүлэхдээ энэ хоёр хүчин зүйлийн тэнцвэрийг олж ажиллах шаардлага үүснэ.

Гадаад улс орнуудын туршлагыг үзэхэд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага эрх мэдлээ шилжүүлэх нь ердийн үзэгдэл байдаг. Харин дараах хэд хэдэн хязгаарлалтыг тавьдаг байна.²⁶⁵ Өөрөөр хэлбэл, дараах бүрэн эрхээ шилжүүлэхийг хориглодог:

- хувь хэмжээ тогтоох;
- хэм хэмжээ тогтоосон акт батлах;
- мөнгө зээлэх, эсхүл урт хугацааны бодлогод тусгагдаагүй хөрөнгө худалдан авах, захиран зарцуулах;
- урт хугацааны бодлого, жилийн төлөвлөгөө, жилийн тайлан батлах;
- Засаг даргыг томилох, чөлөөлөх;
- цалин, урамшуулал тогтоох.

Энд санал болгож буй “Зөвлөлд Хурлын зарим эрхийг шилжүүлдэг болох зохицуулалт хийх” шийдлийн талаар асуумжийн аргаар аймаг, сумдын иргэдийн төлөөлөгчдийн байр суурийг судлахад 2000 гаруй төлөөлөгч хариулт өгсөн байна. Тодруулбал;

“Хороодын үйл ажиллагаа болон Зөвлөлийн үйл ажиллагаа нь хоорондоо давхцаж байна гэж та үзэж байна уу?” гэсэн асуултад 2,003 оролцогч хариулснаас 54,7% нь “Үгүй”, 45,3 хувь нь “Тийм” гэж хариулжээ.

²⁶⁵ Governance manual - Delegation of decision-making functions and powers. aucklandcouncil.govt.nz

Дээрх асуултын хариултыг бататгах зорилгоор **“ИТХ хуульд заасан зарим бүрэн эрхээ хуралдааны чөлөөт цагт өөр этгээдэд шилжүүлэх замаар хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт шаардлагатай юу?”** гэж өөрөөр томъёолж асуусан байна. Асуултад 2,011 оролцогч хариулснаас 57,0% нь “Үгүй”, 43,0 хувь нь “Тийм” гэж хариулжээ.

Эндээс харахад, судлаачийн санал болгож буй шийдэл төлөөлөгчдийн 43-45 хувийн дэмжлэгийг авсан байна. Санал ийнхүү хуваагдсан байдал нь, нэг талаас, Хурлын бүрэн эрхийг бусад этгээдэд шилжүүлэх хувилбар төдийлөн сайн дэмжлэг авахгүй байгааг харуулж байгаа ч, нөгөө талаас, эсрэг санал өгсөн төлөөлөгчид Хурлын эрх мэдлийг өөр этгээдэд алдахгүй гэсэн байр суурьтай байгааг илтгэж байгаа үр дүн юм. Энэ бол мөн чухал эерэг үр дүн юм. Төлөөлөгчид өмнө нь “тэргүүлэгчид”-д эрх мэдлээ даатган орхидог байсан хуучин практикийг аль болох дахин сэргээхгүй байх сонирхолтой байна гэж ойлгож болно. Харин дэмжиж санал өгсөн төлөөлөгчид Хурлын тасралтгүй үйл ажиллагааг чухалчилсан гэж тайлбарлаж болно.

Дээрх хоёр асуулттай холбоотойгоор дараах асуултыг оролцогчдоос асуусан: **“Дээрх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон тохиолдолд Хурал зарим бүрэн эрхээ аль этгээдэд шилжүүлэх боломжтой гэж үзэж байна вэ?”** гэсэн асуултад 1,799 оролцогч хариулснаас 44.6% нь Хурлын Зөвлөлд, 24.7% нь Хурлын хороодод, 20.8% нь Хурлын даргад гэж хариулжээ. Эндээс үзэхэд, эрх шилжүүлэхийг дэмжигчдийн хувьд энэ гурван нийлбэр гэж үзвэл 96.1%-д хүрч байна. Зөвхөн хэнд буюу ямар субъектэд гэдгээрээ хуваагдаж байгаа боловч бүгд дэмжиж байгаа хэрэг юм.

1996 онд батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.4 дэх хэсэгт “Хурлын хуралдааны чөлөөт цагт Хурлын дарга нь шийдвэрлэх” зохицуулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 22-ны хуулиар өөрчлөлт оруулсан байна. Энэ бол “тэргүүлэгчид” байхгүй болсонтой холбоотойгоор асуудлыг цаг алдахгүй, түргэн шуурхай шийдэж байх үүднээс Хурлын даргад эрх мэдэл олгосон хэрэг ажээ. Хурлын Зөвлөлд эрх шилжүүлэх зохицуулалт бий болсон тохиолдолд энэ нэмэлт, өөрчлөлтийг эргэж харах нь зүйтэй болно.

2023 онд хийгдсэн шинэчилсэн найруулгын зарим зүйл, заалтын хэрэгжилтийн судалгаанд дурдсанаар Хурлын дарга, Хурлын хороодод эрх шилжүүлэхийг одоохондоо түдгэлзэх нь зүйтэй бөгөөд эхлээд Зөвлөлд эрх шилжүүлэх зохицуулалтыг тодорхой хугацаанд туршиж, зүгшрүүлэх хэрэгтэй гэж үзсэн байна.

Дурдагдсан судалгаанд МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулга нь Монгол Улсын бусад хуульд тогтоомжид харшлах зүйл, заалт бий эсэхийг судалсан байна. Захиргааны Ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно.” гэж заасан байдаг. Эндээс үзэхэд, шинэ хуульд болон бусад хууль тогтоомжид заасан Хурлын бүрэн эрхийг шилжүүлж болох эсэхийг тухай бүр зөвшөөрсөн заалт тусгаж өгөх шаардлагатай. Зөвшөөрөөгүй бол хориглосон гэж үзнэ.

Санал:

2023 онд хийгдсэн шинэчилсэн найруулгын зарим зүйл, заалтын хэрэгжилтийн судалгаанд МУЗЗНДНТУТХ-ийн шинэчилсэн найруулгын 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэгт дараах байдлаар өөрчлөн найруулах саналыг өгсөн байна:

“51.2.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөл нь Хурлаас эрх шилжүүлснээс бусад тохиолдолд Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар бие даан шийдвэр гаргахгүй.”

Хоёр. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын зардлын тооцоо

ИТХ-аас Зөвлөлдөө эрх шилжүүлэх замаар хуралдааны чөлөө цагт Хурлын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх боломжтой болсон тохиолдолд Хурлын Зөвлөлийн гишүүдийн ажиллах хэвийн нөхцөлөөр хангах, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээнд тодорхой зардал гаргах шаардлагатай болно. Иймд Монгол Улсын нийслэл, 21 аймаг, 9 дүүрэг, 330 сумын ИТХ-ын Зөвлөлийн гишүүдэд олгох урамшууллын нэг жилийн зардлын тооцоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1.

№	Засаг захиргааны нэгж	Нэгжийн нийт тоо	Зардлын жишиг (жилээр) (Засгийн газрын 2021 оны 402-р тогтоол)	Хурлын зөвлөлийн гишүүдийн тоо (дээд хязгаараар)	Дүн (сая ₮-өөр)
1.	Нийслэл	1	15.0	7	105.0
2.	Дүүрэг	9	3.0	7	189.0
3.	Аймаг	21	5.0	7	735.0
4.	Сум	330	1.0	7	2 310.0
Нийт дүн					3 339.0

Тайлбар: зардлын тооцоог гаргахдаа Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2022-д дурдсан тоо баримтыг үндэслэн Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын хавсралт “Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг”-ийг удирдлага болгов.

Гурав. Баг, хорооны ИНХ-ын дарга нарт олгох урамшууллын зардлын тооцоо

Баг, хорооны ИНХ-ын даргыг 4 жилийн хугацаагаар сонгож ажиллуулсан тохиолдолд гарах нэг жилийн урамшууллын зардлыг дээр дурдсан зардлын нийтлэг жишгийг баримтлан тооцлоо. Ингэхдээ багийн ИНХ-ын даргын урамшууллыг сумын төлөөлөгчийн, хорооны ИНХ-ын даргын урамшууллыг дүүргийн төлөөлөгчийн зардлын жишгээр тус тус тооцсон болно.

Хүснэгт 2.

№	Засаг захиргааны нэгж	Нэгжийн нийт тоо	Зардлын жишиг (жилээр) (Засгийн газрын 2021 оны 402-р тогтоол)	Хурлын зөвлөлийн гишүүдийн тоо (дээд хягзаараар)	Дүн (сая ₮-өөр)
1.	Хороо	204	3.0	7	4 284.0
2.	Баг	1645	1.0	7	11 515.0
Нийт дүн					15 799.0

Дөрөв. Аймгийн төвийн хүн ам ба аймгийн төвөөс сонгогдох ИТХ-ын төлөөлөгчийн тооны харьцаа

Аймгийн төвийн хүн ам ба аймгийн төвөөс сонгогдох ИТХ-ын төлөөлөгчийн тооны харьцааны статистик мэдээг дараах эх сурвалжийн хүрээнд бэлтгэв. Үүнд:

- Хүн амын тоог Үндэсний статистикийн хорооны 2023 оны тайлан мэдээ (аймгийн нийт хүн амын тоог Жилийн дундаж хүн амын тоо, аймгийн төвийн хүн амын тоог Монгол Улсад оршин суугаа жилийн дундаж хүн амын тоо);
- сонгогчдын тоог Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын 2023 оны статистик мэдээ;
- төлөөлөгчдийн тоог Сонгуулийн Ерөнхий Хорооны ИТХ-ын сонгуулийн 2016-2020 оны дүнгээс тус тус авч ашиглалаа.

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 3.

№	Аймгийн нэр	Аймгийн төвийн сумын нэр	Хүн амын тоо (2023 оны байдлаар ҮСХ)		Сонгогчдын тоо		Төлөөлөгчдийн тоо		
			Аймаг (жилийн дундаж хүн амын тоо)	Аймгийн төв (МУ-д оршин суугаа жилийн дундаж хүн амын тоо)	Аймаг (УБЕГ 2023)	Аймгийн төв (УБЕГ 2023)	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн тоо (2016-2020)	Аймгийн төвийн сумаас сонгогдсон АИТХ-ын төлөөлөгчийн тоо (2016- 2020)	Аймгийн төвийн сумын ИТХ-ын төлөөлөгчийн тоо (2020 он, ҮСХ)
1	Архангай	Эрдэнэбулган	92,746	21,595	60,971	13,967	39	10	31
2	Баян-Өлгий	Өлгий	115,696	40,764	69,241	26,431	39	13	31
3	Баянхонгор	Баянхонгор	88,282	32,750	56,393	20,497	41	16	31
4	Булган	Булган	60,848	12,664	40,759	8,613	33	6	31
5	Говь-Алтай	Есөнбулаг	56,925	18,955	37,447	12,142	41	16	31
6	Говьсүмбэр	Сүмбэр	18,024	13,218	11,058	8,168	17	13	31
7	Дархан-Уул	Дархан	108,584	87,509	70,224	59,193	33	27	31
8	Дорноговь	Сайншанд	71,323	28,146	45,553	17,596	31	14	31
9	Дорнод	Хэрлэн	83,879	47,394	52,914	29,377	35	22	21
10	Дундговь	Сайнцагаан	46,239	16,829	30,466	10,573	35	11	31
11	Завхан	Улиастай	71,462	16,332	46,839	10,718	41	12	31
12	Орхон	Баян-Өндөр	109,783	102,395	71,262	68,786	35	31	31
13	Өвөрхангай	Арвайхээр	114,796	36,254	74,950	22,753	41	12	31

14	Өмнөговь	Даланзадгад	74,067	30,623	47,799	19,778	33	12	31
15	Сүхбаатар	Баруун-Урт	65,455	24,135	41,679	14,790	33	15	31
16	Сэлэнгэ	Сүхбаатар	107,016	21,716	71,335	15,256	37	8	31
17	Төв	Зуунмод	91,745	17,215	62,531	11,965	41	6	31
18	Увс	Улаангом	83,939	33,474	52,503	20,724	41	16	31
19	Ховд	Жаргалант	91,264	33,172	56,652	21,063	41	17	31
20	Хөвсгөл	Мөрөн	136,739	42,883	88,381	27,478	41	14	31
21	Хэнтий	Хэрлэн	79,026	24,394	51,419	15,549	39	16	21

Аймгийн төвийн хүн ам ба аймгийн төвөөс сонгогдох ИТХ-ын төлөөлөгчийн тооны харьцааны хувьд, нийт улсын хэмжээнд нэг төлөөлөгчид дунджаар 2221 хүн ногдож байна.

Хамгийн өндөр нь Орхон аймгийн нэг төлөөлөгчид 3303 хүн, хамгийн бага нь Говьсүмбэр аймгийн нэг төлөөлөгчид 1185 хүн тус тус ногдож байна.



Хүснэгт 4.

№	Аймгийн нэр	Аймгийн төвийн сумын нэр	Аймгийн төвийн хүн ам ба төлөөлөгчийн тооны харьцаа
1	Орхон	Баян-Өндөр	3303
2	Дархан-Уул	Дархан	3241
3	Баян-Өлгий	Өлгий	3136
4	Хөвсгөл	Мөрөн	3063
5	Өвөрхангай	Арвайхээр	3021
6	Төв	Зуунмод	2869
7	Сэлэнгэ	Сүхбаатар	2715
8	Өмнөговь	Даланзадгад	2552
9	Архангай	Эрдэнэбулган	2160
10	Дорнод	Хэрлэн	2154
11	Булган	Булган	2111
12	Увс	Улаангом	2092
13	Баянхонгор	Баянхонгор	2047
14	Дорноговь	Сайншанд	2010
15	Ховд	Жаргалант	1951
16	Сүхбаатар	Баруун-Урт	1609
17	Дундговь	Сайнцагаан	1530
18	Хэнтий	Хэрлэн	1525
19	Завхан	Улиастай	1361
20	Говь-Алтай	Есөнбулаг	1185
21	Говьсүмбэр	Сүмбэр	1017

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Монгол Улсын Үндсэн хууль (1992 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2006 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (Шинэчилсэн найруулга) (2020 он).
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилт. Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт техникийн туслалцаа үзүүлэх зорилгоор Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын институцийн чадавхыг бэхжүүлэх нь” төсөл. 2023 он.
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УИХ-ын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Монгол Улсад төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төсөл. 2019 он.
- Монгол Улсын статистикийн эмхэтгэл - 2022. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо.
- Governance manual - Delegation of decision-making functions and powers. aucklandcouncil.govt.nz
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн цахим хуудас. <http://khural.mn/dashboard/tuluulugch>
- Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо. <https://m-election.mn>
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www.1212.mn/mn>
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

БҮЛЭГ IV

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

**МАЛ АЖ АХУЙН ХОЛБОО, ТӨРӨӨС МАЛЧИД РУУ ЧИГЛЭСЭН
ДЭМЖЛЭГ, ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

*Ц.Норовдондог (Ph.D.), О.Билгүүтэй,
Р.Оргилмаа, Р.Нургүүл*

АГУУЛГА

УДИРТГАЛ

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

- БНСУ-ын Засгийн газраас мал аж ахуй эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг, бодлого
- Хөдөө Аж Ахуйн Үндэсний Нэгдсэн Холбоо (National Agricultural Cooperative Federation)
- Хөдөө аж ахуйн холдинг компани

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

- Мал аж ахуйн бодлого
- Засгийн газраас хөдөө орон нутгийн иргэдэд үзүүлж буй дэмжлэг: “Ауыл аманат” төсөл
- Төслийн хүрээнд үзүүлэх дэмжлэг

ШВЕЙЦАРЫН ХОЛБООНЫ УЛС

- ХАА-д чиглэсэн бодлого, үйл ажиллагаа

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ



УДИРТГАЛ

“Мал аж ахуйн холбоо, төрөөс малчид руу чиглэсэн дэмжлэг, гадаадын зарим орны туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд гүйцэтгэлээ.

Сэдвийн хүрээнд БНСУ, БНКау, Швейцарын Холбооны улсын туршлагыг тус тус судалсан бөгөөд улс орнуудын засгийн газраас малчид руу чиглэсэн дэмжлэг, бодлого хөтөлбөр, мөн ХАА-н холбоодын үйл ажиллагааны талаарх мэдээллийг тоймлон бэлтгэлээ.

Түлхүүр үг: ХАА-н Холбоо, ХАА-н бодлого, Ухаалаг ХАА, Мал ах ахуй

Keyword: Agriculture cooperation, Agriculture policy, Smart Agriculture, Livestock

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС

БНСУ-ын Засгийн газраас мал аж ахуй эрхлэгчдэд үзүүлж буй дэмжлэг, бодлого

Хүнс хөдөө аж ахуйн яамны (Ministry of Agriculture, Food and Rural Affairs) 2023-2027 он хүртэлх таван жилийн төлөвлөгөөнд танилцуулсан арга хэмжээнд БНСУ-ын Засгийн газар малчид, фермер эрхлэгчдийн насжилт өндөр байгаатай холбогдуулан 2040 он гэхэд 40 хүртэлх насны малчид фермерийн тоог нийт фермерчдийн 10 хувьд хүргэх урт хугацааны төлөвлөгөөний хүрээнд 2027 он гэхэд 30.000 залуу фермерийг дэмжиж ажиллана хэмээн мэдэгдсэн.²⁶⁶

2023 онд хөдөө орон нутагт байнга суурьших хүсэлтэй 4000 залуу малчид фермерүүдэд 1.1 сая воны (785 евро) татаасыг гурван жилийн хугацаанд сар бүр олгож байна. Тэднийг орон сууцжуулах, амьдрах нөхцөлийг сайжруулах, санхүүгийн дэмжлэг таатай орчныг бүрдүүлэх зорилгоор нийт 100 тэрбум воны хөгжүүлэх хөрөнгө оруулалтын сан байгуулсан.

Хүнс хөдөө аж ахуйн яамнаас залуу малчид, фермерүүдэд олгох зээлийн дээд хязгаарыг нэмэгдүүлж мөн дээр нь зээлийн хүүг бууруулсан байна. Зээлийн эргэн төлөлтийн хугацааг 25 жил болгон сунгаж, 15 жилээс 10 жилээр уртасна. Ингэснээр үндсэн зээл болон хүүгийн эргэн төлөлтийн дарамт жилд 45 хувиар буурсан байна.

Засгийн газар малчид фермерүүдийн нөхцөл байдал, түвшинд тохирсон боловсролын хөтөлбөрүүдийг өргөжүүлж, асуудлыг газар дээр нь шийдвэрлэхэд зөвлөгөө өгөх боломжийг олгосон байна. Мөн үйлдвэрлэлийн үр ашиг, нийт бүтээмжид дэвшилтэт технологийг ашиглах судалгааны ажилд их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байна.

Эдгээр нь Хүнс хөдөө аж ахуйн яамны (Ministry of Agriculture, Food and Rural Affairs) 2023-2027 он хүртэлх таван жилийн төлөвлөгөөнд танилцуулсан арга хэмжээний нэг бөгөөд уламжлалт хөдөлмөр их шаарддаг мал аж ахуй, аж үйлдвэрийг дэвшилтэт технологийн тусламжтайгаар хөгжүүлэх зорилготой юм.²⁶⁷

БНСУ, Нидерланд Улсын ЭСЯ, Хөдөө аж ахуйн хэлтэстэй хамтран залуу малчид фермерүүдийг сургах чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүнд БНСУ, Нидерландад сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, залуу тариаланчдад зориулсан түрээсийн фермүүд байгуулах, демо фермүүдтэй сургалтын төвүүдийг байгуулах зэрэг үйл ажиллагаанууд багтсан байна.

²⁶⁶ South Korean Government encouraging young farmers and smart agriculture <https://www.agroberichtenbuitenland.nl/actueel/nieuws/2022/10/19/south-korean-government-encouraging-young-farmers-and-smart-agriculture>

²⁶⁷ <https://www.mafra.go.kr/english/index..do>

УХААЛАГ МАЛ АЖ АХУЙ

Сүүлийн жилүүдэд Өмнөд Солонгос, Нидерланд улстай хөдөө аж ахуйн олон дэвшилтэт технологи нэвтрүүлэх тал дээр хамтран ажиллаж байна. Хэдийгээр БНСУ мал аж ахуйг ухаалаг, дэвшилтэт технологи ашиглан хөгжүүлэх бодлого хөтөлбөр баримталж ажиллаж байгаа ч олон сорилтуудтай тулгарч байна.²⁶⁸

БНСУ-ын Засгийн газар ухаалаг мал аж ахуйн салбарыг дэмжиж эдийн засгийн тэргүүлэх салбаруудын нэг болгохоор ажиллаж байна. Үүний тулд “ухаалаг мал аж ахуй”-д шинэ боломжуудыг нээж big data платформ байгуулж, инновацын технологийг ашиглаж байна.

Ухаалаг мал аж ахуйг хэрэгжүүлэхэд ажиллах хүч, технологийн хөгжлийг нэвтрүүлэх шаардлагатай ба одоогоор БНСУ-д 6485 га талбайд болон 4743 өрхийн мал аж ахуйд ухаалаг хөдөө аж ахуйн дэвшилтэт технологи нэвтрүүлсэн байна.

БНСУ-ын ХАА салбарт тулгараад байгаа том асуудлуудын нэг бол мал аж ахуй эрхлэх ажиллах хүч ба одоогоор насжилтын хувьд 50-60 насны хүмүүс мал аж ахуй эрхэлж байгаа ба залуус уг салбарт ажиллах нь бага байна.

Ухаалаг хөдөө аж ахуйг хөгжүүлэх замаар залуучуудын гарааны экосистемийг бий болгох шаардлагатай ба 40-өөс доош насны залуу МАА эрхлэгчид анхны хөрөнгө оруулалтын зардал, мэргэжил боловсрол, газар ашиглалт зэрэг практикт ихээхэн бэрхшээлтэй тулгардаг байна. Тиймээс ухаалаг мал аж ахуй нь санхүүгийн хувьд илүү тогтвортой, ялангуяа 50-60 насны фермүүдийн дунд өргөн тархсан. Ухаалаг мал аж ахуйг дараах фермүүдэд түлхүү ашиглаж байна.

МАЛ АЖ АХУЙН УХААЛАГ ТЕХНОЛОГИ

Ухаалаг мал аж ахуйн технологийг нэвтрүүлснээр бүтээгдэхүүний гарц нэмэгдэж зардал буурсан байна. Мөн дараах дэвшилтэд өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Хүрээлэн буй орчны хувьд: Температур, чийгшил, салхины чиглэл, хур тунадас, гэрэлтүүлэг, агааржуулалт;

Мал аж ахуйн хувьд: Дулааныг тохируулах, тэжээл бэлтгэх, хог хаягдлыг багасгах, ялгах, сүү бэлтгэх;

²⁶⁸ <https://www.agroberichtenbuitenland.nl/actueel/nieuws/2022/08/16/how-smart-is-south-koreas-smart-agriculture-time-for-an-upgrade>

Мэдээллийн хувьд: Зардлын менежмент, маркетинг, халдварт өвчний тархалтын мэдээлэл зэрэг асуудлуудыг тус тус шийддэг байна.

Үнээний фермүүдэд сүү болон махны чиглэлээр дэвшилтэт технологийг түлхүү ашигласан байна. Малын байрны агааржуулалт, сэнс, автомат саалтуур, биометрийн мэдээллийг хянах төрөл бүрийн төхөөрөмжүүдийг ашигласан байна. Мөн малын байрны температурыг гар утаснаас удирдаж, хянах боломжтой хяналтын системийг үүсгэсэн байна. Түүнчлэн май аж ахуйтай холбоотой дата сан үүсгэж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын жин, хээлийн мэдээллийг бүрэн хянах боломжтой болсон байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ХОЛБОО (NATIONAL AGRICULTURAL COOPERATIVE FEDERATION)

1961 онд Засгийн газраас ХАА-н бүтээмжийг нэмэгдүүлэх, ХАА-н фермерүүдийн оролцоотойгоор нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах зорилгоор холбооны тогтолцоог бий болгож, Үндэсний ХАА-н холбоо /NACF/ буюу Хөдөө аж ахуйн холбоог байгуулжээ. ХАА-н холбоо нь Өмнөд Солонгосын 2.1 сая гаруй малчин, фермерүүдийг төлөөлсөн 1117 анхан шатны гишүүдийн дээд байгууллага юм.


Энэхүү холбооны гишүүд нь ардчилсан хяналттай, бие даасан бүлгүүд бөгөөд Засгийн газрын санхүүжилтээс илүүтэйгээр гишүүдийн хураамж, дэмжлэгээр санхүүждэг. Тэд эргээд байгууллагын захиалгаар дамжуулан NACF-ийг санхүүжүүлэхийн тулд хөрөнгөө босгодог. NACF-ыг ардчилсан шударга зарчмаар мэдлэг туршлага бүхий шууд сонгогдсон ерөнхийлөгч удирддаг байна.

Сүүлийн тавин жилийн хугацаанд NACF-ийн санхүүгийн үйл ажиллагаа (банк, даатгал, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө) ихээхэн өсөлттэй байгаа нь түүнийг БНСУ-ын хамгийн том санхүүгийн байгууллагуудын нэг болгоход хүргэсэн. 2012 оны 03 дугаар сарын 02-нд NACF үйл ажиллагаагаа өргөтгөж, Үндэсний Хөдөө Аж Ахуйн Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолын дагуу санхүүгийн холдинг компани НонХюп Санхүүгийн Нэгдэл (NongHyup Financial Group) болон Хөдөө Аж Ахуйн Холдинг компани (NongHyup Agribusiness Group) гэсэн хоёр холдинг компанийг байгуулжээ.



NACF-ын NongHyup Financial Group (‘NHFG’) болон NongHyup Agribusiness Group (‘NHAG’) нь БНСУ-ын дээд түвшний толгой компани юм. NHFG нь 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар салбар компаниудаараа дамжуулан үйлчлүүлэгчдэдээ санхүүгийн өргөн хүрээний үйлчилгээ үзүүлдэг нийт хөрөнгийн үнэлгээгээр Өмнөд Солонгос улсын гурав дахь том санхүүгийн групп болсон юм.


НонХюп Санхүүгийн Нэгдэл (NongHyup Financial Group)



NHFG болон NHAG нь 2012 оны 03 дугаар сарын 02-нд санхүүгийн бизнес эрхэлдэг компаниудыг хянах, удирдах, санхүүжилтийг дэмжих зорилгоор байгуулагдсан.

NHFG-ийн охин компаниудад NongHyup Bank, NongHyup Life Insurance, NongHyup Property & Casualty Insurance, NH Investment & Securities, NH-Amundi Asset Management, NH Capital, NH Futures, NH Savings Bank, NH Venture Investment багтдаг.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХОЛДИНГ КОМПАНИ



ННАГ нь газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалт, нийлүүлэлттэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг 14 охин компанийн толгой компани юм. 14 охин компанийн дунд Nong Woo Bio, NongHyup Feed, NH Trading зэрэг АНУ-д салбар компаниуд үйл ажиллагаа явуулдаг байна.

Үндэсний ХАА-н холбоонд 800 гаруй банкны салбар, борлуулалт, боловсруулалтын 600 гаруй аж ахуйн төвүүд, түүнчлэн олон төрлийн аж ахуйн нэгж нэгдэн үйл ажиллагаа явуулдаг. Эдгээрийн үйл ажиллагаа нь гишүүдийнхээ аж ахуй, борлуулалт, өргөн хэрэглээний бараа, зээл, банк, даатгал, агуулах, тээвэр, нийгэм, соёлын бусад үйл ажиллагааг дэмжихэд чиглэнэ.

Хамтран ажиллах тогтолцоог бий болгосноор Засгийн газраас ХАА-н салбарын үйл ажиллагааг дэмжих, ХАА-н хөрөнгө, хангамжийг нэмэгдүүлэх, ХАА-н бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, ургац хураалт, аж ахуйн технологийн шинэчлэлийн хөтөлбөрийн хэрэгжилт зэрэгт ихээхэн нэгдмэл бодлоготой болж, салбарын үйл ажиллагаа шуурхай, шударга, цогц хэлбэрээр явагдах нөхцөл бүрдсэн гэж үздэг.

БНСУ-д Үндэсний Хөдөө аж ахуйн холбоо (NACF) хөдөө аж ахуйн борлуулалтын үйл ажиллагааг илүү үр ашигтай байдлаар хүнсний түгээх төвүүдээр дамжуулан нэгдсэн байдлаар зохион байгуулдаг. Үндэсний ХАА-н холбооны хүнсний түгээлтийн төвүүд нь ХАА-н бөөний борлуулалтын захаасаа илүү сайн үйл ажиллагаатай байдаг байна.

Энэхүү ХАА-ын нэгдсэн борлуулалтын тогтолцоо нь фермерүүд болон хэрэглэгчдийн хоорондох маш сайн харилцаа холбоо болохоос гадна хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, борлуулалтыг түргэн шуурхай болгоход чухал үүрэгтэй юм.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН, ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ БҮРДЭЛТ

ХАА-н хүнс борлуулах системийн үр бүтээмжийг тооцохдоо борлуулалтын хувь хэмжээг хэрэглэгчийн үнэтэй харьцуулан бодож үнэлдэг бол борлуулалтын хувь хэмжээг хэрэглэгчийн үнэтэй харьцуулж бодоход дараахь томъёог хэрэглэдэг байна. Борлуулалтын хэмжээ нь ХАА-н бүтээгдэхүүнийг борлуулахад гарсан өртөг ба ашгаас бүрдэнэ. Тухайлбал,

$$\text{Маркетингийн ашгийн харьцаа} = \frac{\text{хэрэглэгчийн үнэ} - \text{үйлдвэрлэгчийн үнэ}}{\text{хэрэглэгчийн үнэ}}$$

Өмнөд Солонгосын хөдөө аж ахуй, загасчлалын худалдааны корпорац (KAFTC) жил тутам ХАА-н гол нэрийн бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээнд анализ хийж үр дүнг хэвлэн нийтлүүлдэг. Энэхүү дүгнэлт мэдээнээс үзэхэд:

- ХАА-н 48 бүтээгдэхүүний борлуулалтын дундаж хувь хэмжээ 43.9%, байгаагаас 14.1% нь шууд өртөг, 14.9% нь шууд бус өртөг буюу цэвэр ашиг байна.
- ХАА-хүнс борлуулалтын төвийн сүлжээ борлуулалтын хувь хэмжээ дунджаар бөөний худалдаа борлуулалтын сүлжээнээс илүү үзүүлэлттэй гарсан байна.

ХАА-н бүтээгдэхүүний үнийг ХАА-н холбооноос хянан зохицуулдаг. Ингэхдээ үнэ тогтоох үр бүтээмжийг сайжруулах, борлуулалтын үнийг тогтвортой байлгах бодлого баримтлах, үнийн өрсөлдөхүйц байдлыг хангах зэрэгт ихээхэн анхаарч ажилладаг.

БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛС

МАЛ АЖ АХУЙН БОДЛОГО

Казахстан Улсын хувьд мал аж ахуй нь хөдөө аж ахуйн хамгийн чухал салбаруудын нэг бөгөөд хөдөө аж ахуйн салбарын гол чиглэл гэж тооцогддог. Хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 45 орчим хувийг энэ салбар үйлдвэрлэдэг. Мал аж ахуй нь хөдөөгийн хүн амын хувьд ажил эрхлэлт, орлогын эх үүсвэр болдог тул энэ салбар эдийн засгийн чухал хөшүүрэг юм. Мал аж ахуй нь хүн амыг мах, сүү, өндөг, цөцгийн тос, бяслаг, айраг, хиам, утсан мах гэх мэт чухал хэрэгцээтэй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж байдаг.

Казахстан Улсын газар нутаг, байгаль, цаг уурын нөхцөл мал аж ахуйд таатай тул энэ салбарыг хөгжүүлэх асар их боломжтой. Мал аж ахуйн төрлийг бүс нутгаар нь авч үзвэл, хойд бүс нутагт гахай, сүүний чиглэлийн үхэр, өмнөд бүс нутагт махны чиглэлийн үхэр, хонь, адуу, тэмээ, баруун болон зүүн бүс нутагт махны чиглэлийн үхэр болон адууны аж ахуй зонхилж байна. Шувууны аж ахуйн хөгжил улс орны бүх бүс нутагт бараг жигд тархсан байна. Цөл, хагас цөлийн бүсийн хувьд мал аж ахуйн үндсэн төрлүүд нь хонь, адуу, тэмээний аж ахуй юм. Хонины аж ахуйг нарийн ноос, хагас нарийн ноос, мах-өөх, смушковое гэсэн дөрвөн үндсэн чиглэлээр хөгжүүлдэг.

Тус улсын шинжээчдийн үзэж байгаагаар Казахстанас Хятадад үхэр, гахайн мах, мөн Ойрх Дорнодын орнуудад хонь, хурганы мах экспортлох асар их нөөц боломж бий. Мөн Казахстаны үйлдвэрлэгчид, жилдээ 265 гаруй мянган тонн гахайн мах хэрэглэдэг Орос, 2 сая гаруй тонн гахайн махны хэрэгцээтэй Хятадын зах зээлд гахайн бүтээгдэхүүн экспортлох боломжтой.

Үүний зэрэгцээ шувууны аж ахуй ч эрчимтэй хөгжиж байна. Энэ салбарын дотоодын үйлдвэрлэгчид дотоодын хэрэглэгчдийг шувууны гаралтай бүтээгдэхүүнээр бүрэн хангадаг. Түүнчлэн гадаад зах зээлд шувууны өндөг нийлүүлж байна. Тухайлбал, статистикийн мэдээгээр, зөвхөн Афганистан Улсад жилд 400 сая хүртэл өндөг худалдаалдаг байна.

2018 онд гахайн аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөрийг шувууны аж ахуй, сүүний фермийн төслүүдтэй хамт баталсан. Энэ гурван санаачилгыг нэгтгэж, мал аж ахуйн салбарыг эрчимтэй хөгжүүлэх төрийн ерөнхий хөтөлбөрт тусгасан байна.

Засгийн газар хөдөө аж ахуйн, түүний дотор мал аж ахуй, түүний ашиглагдаагүй ихээхэн нөөц бололцоог ашиглан нэмүү өртөг бий болгох, экспортыг дэмжих, ажлын байр бий болгох, хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангах зорилт тавин ажиллаж байна. Казахстан Улсын мал аж ахуйгаа хөгжүүлэх стратегийн гол чиглэл нь хүн амыг дотоодын үйлдвэрлэлээр дамжуулан өндөр чанартай хүнсний бүтээгдэхүүнээр хангах, хүнсний бие даасан байдлыг бий болгох нийгэм, эдийн засгийн хамгийн чухал зорилтыг шийдвэрлэхэд оршино.

Төрөөс мал аж ахуйг дэмжих чиглэлээр урт, дунд хугацааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Салбарын урт хугацааны бодлогын баримт бичиг нь “Бүгд Найрамдах Казахстан Улсын агро аж үйлдвэрийн цогцолборыг 2021-2030 он хүртэл хөгжүүлэх үзэл баримтлал”²⁶⁹ юм.

²⁶⁹ Об утверждении Концепции развития агропромышленного комплекса Республики Казахстан на 2021 – 2030 годы, <https://adilet.zan.kz/rus/docs/P2100000960#z142>

Засгийн газраас мал аж ахуйн салбарын урт хугацааны бодлогын хэрэгжилтийг дэмжих хүрээнд дунд хугацааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг бөгөөд энд “**Казахстаны үр дүнд чиглэсэн мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөр**”²⁷⁰-ийн талаар тоймлон авч үзье.

Казахстан Улсын Засгийн газрын хүсэлтээр Дэлхийн банкны групп, тус улсын Хөдөө аж ахуйн яамтай хамтран мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд 2021-2025 онуудад 5 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банкнаас 500 сая ам.долларын зээлийн санхүүжилт олгох бөгөөд Засгийн газартай тохиролцсоны дагуу хөтөлбөр тодорхой, хэмжигдэхүйц үр дүнд хүрсний дараа олгохоор болсон байна.

Энэхүү хөтөлбөрийг Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаевын 2019 оны 09-р сарын 02-ны өдөр ард түмэндээ хандаж хэлсэн үгэндээ дэвшүүлсэн дараах тэргүүлэх зорилтуудад нийцүүлж боловсруулснаас гадна тэдгээр зорилтуудыг давхар хэрэгжүүлэх юм. Энэ нь нэгдүгээрт, Казахстаны ашигт малтмал, газрын тосноос хамааралтай экспортыг төрөлжүүлэхийг дэмжих; хоёрдугаарт, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх, хөдөө орон нутагт нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх; гуравдугаарт, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг дэмжих, Казахстаны бэлчээрийн асар их нөөц бололцооны ашиглалтыг сайжруулах зорилтууд болно.

Энэ хөтөлбөрийн хөгжлийн зорилго (PDG) нь **байгаль орчинд ээлтэй, хүртээмжтэй, өрсөлдөх чадвартай** үхрийн махны үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Байгаль орчинд ээлтэй - Орчин үеийн экспортын баримжаатай махны өртгийн сүлжээг хөгжүүлэхэд байгаль орчны тогтвортой байдал чухал. Үхрийн махны үйлдвэрлэл нь ихэвчлэн хүлэмжийн хийн ялгаруулалт өндөр, газрын доройтол үүсгэх болон бусад сөрөг нөлөөтэй байдаг. Тиймээс тус хөтөлбөрт эдгээр асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхаарсан байна. Дэлхийн практикт мал аж ахуйн салбартаа цаг уурын ухаалаг системийг дэмжсэн улс орнууд (жишээ нь Уругвай) дэлхийн өндөр үнэ цэнэтэй зах зээлд нэвтрэх боломжтой болсон. Энэхүү хөтөлбөр нь Парисын хэлэлцээрийн зарчимтай нийцэж байгаа бөгөөд уг хэлэлцээрт Казахстан Улс 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгарлыг 1990 оны түвшинтэй харьцуулахад 15-25%-иар бууруулах зорилт дэвшүүлсэн байна. Хөтөлбөрт Засгийн газрын дэмжлэг (татаас) болон хүлэмжийн хийн ялгаруулалтыг хянах механизмыг бий болгох замаар байгаль орчны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн байна.

²⁷⁰ Программа устойчивого развития животноводства в Казахстане, ориентированная на результат: Часто задаваемые вопросы, <https://www.vsemirnyjbank.org/ru/news/factsheet/2021/05/14/faqs-kazakhstan-sustainable-livestock-development-program>

Хүртээмжтэй байдал – Хөдөө орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэл, нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ. Хөтөлбөрт жижиг, дунд тариаланчдыг нэмүү өртөг өндөртэй махны экспортод чиглэсэн өртгийн сүлжээтэй холбоход дэмжлэг үзүүлэх фермер төвтэй загварыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд зөвхөн тодорхой шалгуурыг хангаж сонгогдсон фермер, тариаланчид хамрагдах боломжтой бөгөөд орчин үеийн 20.000 жижиг, дунд фермийн аж ахуйг шинээр бий болгож, хамгийн багадаа 100.000 жижиг, дунд фермийн аж ахуйд хөдөө аж ахуйн сайн туршлагыг хэрэгжүүлэх зорилготой байна.

Өрсөлдөх чадвар - мал аж ахуйн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах таатай орчныг бүрдүүлэхэд төрийн үйлчилгээ, бодлогоор дэмжих, тэр дундаа жижиг, дунд мал аж ахуй эрхлэгчдэд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх ажлыг сайжруулахад чиглэнэ. Олон улсын малын эрүүл мэндийг хамгаалах байгууллагын үнэлгээгээр Казахстан Улсын мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулахад ахиц дэвшил гарсан гэж дүгнэсэн. Гэсэн хэдий ч малын ашиг шимийг сайжруулах, ялангуяа жижиг, дунд мал аж ахуй эрхлэгчдэд чанартай мал эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг хангахын тулд, түүнчлэн Казахстаны мал хянах системийг олон улсын шилдэг туршлагад нийцүүлэхийн тулд цаашид сайжруулахад анхаарч байна.

Хөтөлбөрөөс хэрэгжүүлэх гол арга хэмжээ

Бэлчээрийн тогтвортой менежмент, мал аж ахуйн тогтвортой хөгжил, мал эмнэлгийн тогтолцоог бэхжүүлэх болон дэмжих, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм. Мөн хөтөлбөрт мал аж ахуйн салбарын өсөлтийн улмаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах, хүлэмжийн хийн ялгарлыг нэмэгдүүлэхгүй байхыг онцгойлон анхаарч байна.

Хөтөлбөрөөс хэн ашиг хүртэх вэ?

Хөтөлбөрийн үр шимийг хүртэгчид нь бүртгэлтэй хувиараа хөдөлмөр эрхлэгч 10-500 толгой үхэртэй фермерүүд байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд хамгийн багадаа 100.000 жижиг дунд фермерүүд (тариачин) хөдөө аж ахуйгаа өргөжүүлэх, мэдлэг туршлагаа сайжруулах, зөвлөх үйлчилгээ авах боломж нэмэгдэнэ. Түүнчлэн, хамгийн багадаа 20.000 шинэ ферм бий болгох бөгөөд тэдэнд аж ахуйгаа явуулахад төрөл бүрийн дэмжих арга хэмжээ үзүүлнэ. Хөтөлбөрийн хүрээнд мал эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад дэмжлэг үзүүлэх бөгөөд үүний үр дүнд олон фермерүүдэд ашигтай нөхцөл бүрдэнэ. Мөн 2-5 толгой үхэр сүрэгтэй (бүртгэлгүй) фермерүүдэд үзүүлэх мал эмнэлгийн тусламж үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөсөн.

Хөтөлбөр хэрэгжүүлснээр олон тооны жижиг аж ахуйчид тариачин, фермерийн аж ахуй эрхлэгчээр бүртгүүлэх төлөвтэй байгаа нь тэдний эрх зүйн статусыг сайжруулж, төрийн үйлчилгээ, санхүүжилтийн хөтөлбөрүүд болон зах зээлийн уялдаа холбоог сайжруулах боломжийг олгоно. Энэ бүхний үр дүнд ашиг хүртэгч эдгээр фермерүүд үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, амьдрах чадварт өндөртэй үхрийн аж ахуй эрхлэгч болно гэсэн хүлээлттэй байна.

Салбарын өсөлттэй холбоотой хүлэмжийн хийн ялгаруулалтыг хэрхэн хянах вэ?

Үүний тулд хөтөлбөрт саармагжуулах гурван арга замыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Мал аж ахуйн менежментийг сайжруулах замаар (тэжээлийн менежмент ба өвлийн тэжээл, удамшлын болон малын эрүүл мэндийг сайжруулах) бүтээмжийг нэмэгдүүлж, нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах;
- Бэлчээрийн менежментийн туршлагыг сайжруулах замаар хөрсний нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэх (эвдэрсэн газрыг нөхөн сэргээх гэх мэт);
- Чулуужсан түлшний эрчим хүчний хэрэглээг бууруулах, орлуулах зорилгоор эрчим хүчний хэмнэлттэй төхөөрөмж болон сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл (нар, салхи) нэвтрүүлэх. Энэхүү хөтөлбөр нь байгаль орчин, байгалийн нөөцийн хяналтын улсын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгоход тусална.

Дэлхийн банкнаас Казахстан Улсын мал аж ахуйн байдалд өгсөн үнэлгээ, зөвлөмж

Дэлхийн банкнаас 2004 онд Казахстан Улсын мал аж ахуйн салбарын талаар илтгэл бэлтгэж, тус салбарыг хөгжүүлэх зарим чухал асуудлыг онцолж байсан ба түүнээс хойш Казахстан Улс мал эмнэлгийн тогтолцоогоо эрс сайжруулсан байна. Түүнчлэн малын эрүүл мэндийн байдал 15 жилийн өмнөхөөс илүү сайжирсан бөгөөд Төв Азийн бусад орнуудтай харьцуулахад илүү сайн түвшинд байна гэж Дэлхийн банкнаас 2019 онд дээрх хөтөлбөрийг бэлтгэх үеэр дүгнэсэн байна. Казахстан Улс мал аж ахуйн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг ихээр татаж, үхэр, хонины үүлдэр угсааг сайжруулах тал дээр ахиц дэвшил гаргасан. Салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд, тэжээлийн үйлдвэрлэл, хадгалалтыг сайжруулах, сайн чанарын үхэр, хонины үйлдвэрлэлийн тогтвортой тогтолцоог сайжруулах, жижиг, дунд фермерүүдийг экспортын баримжаатай өртгийн сүлжээнд оруулах, орлого нэмэгдүүлэх, ажлын

байр бий болгох, нийлүүлэлтийн сүлжээг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг өргөтгөх, фермерүүдэд зориулсан сургалт зэрэг багтана. Өнөөдөр Казахстан Улс шинэ зах зээл, экспортын боломжийг идэвхтэй эрэлхийлж, мал аж ахуйн тогтвортой бүтээгдэхүүний зах зээлийг нээхийн тулд экспортын түншүүдтэй хамтран ажиллаж байна. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд амаргүй сорилтуудтай тулгардаг боловч янз бүрийн санаачлага гарган шийдвэрлэхийг зорьж байна. Дээрх хөтөлбөр нь эдгээр санаачлагыг дэмжиж, ахиц дэвшлийг хэмжих, шилдэг туршлагыг хэрэгжүүлэх арга хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх юм.

ЗАСГИЙН ГАЗРААС ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ: “АУЫЛ АМАНАТ” ТӨСӨЛ

2023 оны байдлаар Казахстан Улсын хөдөө орон нутагт 7.7 сая хүн буюу хүн амын 41 хувь амьдарч байна. Хөдөө орон нутагт дэд бүтэц хөгжөөгүй, иргэдийн орлого бага гэх мэт шалтгааны улмаас хот руу нүүдэллэн шилждэг байна. 2022 оны байдлаар Казахстан Улсад хот, хөдөөгийн иргэдийн мөнгөн орлогын зөрүү 38 хувьтай гарсан. Мөн хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааны эх үүсвэр голдуу газар тариалан, мал аж ахуй байх бөгөөд иргэдийн бизнесээ нээх, хөгжүүлэх, өргөжүүлэх санаачилга, төлөвлөгөө нь ихэнх тохиолдолд биелэх боломжгүй байдаг байна.

Хөдөө орон нутагт тулгарч буй эдгээр асуудлуудыг шийдэхийн тулд Засгийн газар «Ауыл Аманат» төслийг 2023 оноос Казахстан даяар хэрэгжүүлж эхэлсэн.

Төслийг хэрэгжүүлснээр хөдөө орон нутгийн иргэдийн орлого, сайн сайхан байдал, амьдралын чанарыг дээшлүүлэх, тулгамдсан асуудлыг хурдан шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзжээ.

Энэ төслийг 2019 онд Казахстаны Жамбыл мужид туршилтын журмаар хэрэгжүүлж амжилттай үр дүнд хүрсэн байна. Үүнд хамрагдсан Жамбыл мужийн 11 ауыл (засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн доод түвшний нэгж)-ын хувьд сарын дундаж орлого 1.7 дахин өсөж, нийгмийн тусламж үйлчилгээ авагчдын тоо 3 дахин, ажилгүйдлийн түвшин 36%-аар буурсан байна. Мөн туршилтын төслийн хүрээнд олгосон зээлийн эргэн төлөлт хугацаандаа сайн төлөгдсөн бөгөөд 60 хоногоос дээш хугацаа хэтрэлт гараагүй байна.

Ерөнхийлөгч Касым Жомарт Токаев туршилтын төслийн талаар Казахстаны ард түмэнд хандаж хэлсэн үгэндээ, “Бид ийм туршилтын төслийг хэрэгжүүлснээр, үүнд оролцсон хөдөө аж ахуйн хоршоод 2 дахин их тариа, ногоо хурааж, малын тоо 25 орчим хувиар өссөн байна. Бүс нутаг бүрийн онцлогийг харгалзан сайн туршлагыг үе шаттайгаар орон

даяар хэрэгжүүлэх шаардлагатай байна” гэдгийг онцолжээ. Туршилтын төсөл амжилттай хэрэгжсэн тул улс даяар хэрэгжүүлэхээр болсон байна.

Төслийн зорилго

Төсөл нь хөдөө орон нутгийн иргэдэд бизнесийн санаа, төслөө хэрэгжүүлэхэд туслах зорилготой бөгөөд газар тариалан, мал аж ахуй, шувууны аж ахуйд дэмжлэг үзүүлэх, хүн суурьшаагүй газар нутгийн нөөцийг ашиглах, хоршоо байгуулах, үйлдвэрлэл болон боловсруулах чиглэлийн хувийн аж ахуйг хөгжүүлэх, улмаар Казахстаны хөдөө орон нутгийг хөгжүүлэх, дотоодын агро аж үйлдвэрийн цогцолборыг дэмжихэд чиглэж байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ

Засгийн газраас төслийг хэрэгжүүлэхэд 2023 онд 52.4 тэрбум тенге (11 мянга гаруй бичил зээл олгоход) төсөвлөсөн. Төсөл 2023-2025 онуудад хэрэгжинэ. Энэ төслийн хүрээнд олгох бичил зээлийн хугацаа 5 жил, харин мал аж ахуйн чиглэлээрх санаачилгад 7 жил байхаар төлөвлөсөн байна. Зээлийн хэмжээ нь 2500 - 8000 сарын тооцооллын индексстэй тэнцэх мөнгөн дүнтэй²⁷¹ (8.6 сая – 27.6 сая тэнге), нэрлэсэн хүү жилийн 2.5%, эхний жил зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй байна.

Төсөлд хэн хамрагдах вэ

Төслийн хүрээнд олгогдох хөнгөлөлттэй нөхцөл бүхий бичил зээлд дараах хүмүүс хамрагдана:

- Шинээр бизнесээ эхлүүлж байгаа болон үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчид;
- Тэтгэврийн насанд хүрээгүй боловч орон тооны цомхотголд орсон ажилчид;
- Аж ахуйн нэгжийн бүртгэлгүйгээр бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох үйл ажиллагааг бие даан эрхэлдэг хүмүүс (үүнд идэвхгүй аж ахуйн нэгжүүд орно);
- Өрхийн бизнест цалин хөлсгүйгээр ажилладаг хүмүүс;
- Орлого нь амьжиргааны доод түвшнээс доогуур хувийн туслах аж ахуйн гишүүд;
- Орлого нь амьжиргааны доод түвшнээс доогуур үйлдвэрлэлийн хоршооны гишүүд.

²⁷¹ Сарын тооцооллын индексийг Казахстан Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамж үйлчилгээний бусад төлбөр, түүнчлэн торгууль, татвар болон бусад төлбөрийг тооцохдоо хэрэглэдэг бөгөөд 2023 оны байдлаар 3450 тэнгетэй тэнцүү байна. <https://www.gov.kz/memleket/entities/kgd-zhetysu/press/news/details/479860?lang=kk>, 2023 оны 12 сарын 11-ний өдрийн Монголбанкны ханшаар, Казахстан тэнге 7.48 төг, <https://www.mongolbank.mn/mn/currency-rate>

Төслийг хэрэгжүүлж буй туршлагаас

Энэ төслийг Казахстаны Актөбе мужид анх хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд төсөл хэрэгжсэнээр тус бүс нутагт Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн хөдөө орон нутгийг хөгжүүлэх зорилтыг биелүүлэх боломж бас бүрдэнэ. Бүс нутгийн захиргаанаас төсөл хэрэгжүүлэхийн өмнө судалгаа явуулж ауыл бүрд ажилгүй болон өөрөө өөрийгөө ажлаар хангагч иргэдийн тоо, өрх бүрийн орлогыг бодитоор тогтоосон байна. Мөн хүн амыг чанартай, хүртээмжтэй хоол хүнсээр хангахад ямар үйлдвэрлэлийг илүүтэй хөгжүүлэх шаардлага байгааг тодорхойлжээ. Төслийн хүрээнд энэ бүс нутагт 3 тэрбум тэнгэ төсөвлөгдсөн бөгөөд эхний ээлжид бүс нутгийн 24 ауылд 2700 гаруй санаачилгыг хэрэгжүүлэхээр болсон байна. Төслийг хэрэгжүүлэхдээ хөдөөгийн иргэдэд мөнгөн болон эд, хөрөнгө хэлбэрээр зээл олгох юм. Тухайлбал, 27 том аж ахуй эрхлэгч фермээс иргэдэд 6000 толгой мал зээлээр өгөх ба малынхаа төлөөр нь эргэн төлүүлэхээр зохицуулсан байна. (2023 оны 01 сарын байдлаар 42 хувийн туслах аж ахуйд 650 толгой үхэр өгсөн).

Төслийн хэрэгжилтээс хүлээгдэж буй үр дүн

Төсөл нь хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах бодитой алхам болно гэж үзсэн бөгөөд төслийн хүрээнд олгогдох бичил зээл нь хөдөөгийн олон оршин суугчдад хувийн бизнесээ эхлүүлэх, одоо эрхэлж байгаа бизнесээ өргөжүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг болно гэсэн хүлээлттэй байна.

Өнөөдөр Казахстан Улсад ямар ч санхүүгийн байгууллага жилийн 2.5%-ийн маш бага хүүтэй, эхний жил зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх, мөн хөдөө орон нутгийн үл хөдлөх хөрөнгийн баталгаатай тааламжтай нөхцөл бүхий зээл олгодоггүй байна. Тиймээс энэ төслийг хөдөө нутгийн иргэд талархалтай хүлээн авч байгааг төслийн зүгээс онцолсон байна.

ШВЕЙЦАР

Швейцарын Холбооны Улс нь 7 бүс, 26 кантон буюу муж улс, 2136 коммун (орон нутгийн засаг захиргааны нэгж)-д хуваагддаг байна. Нийт газар нутгийн 2/3 нь эгц өндөр уулс, ой хээрийн бүс эзэлдэг тул хөдөө аж ахуйд тохиромжтой газар нутаг нь нийт газар нутгийн тун бага хэмжээг эзэлдэг байна. Хөдөө аж ахуйн газар нутгийн 1/3 орчим хувийг уулын бэлчээр газар эзэлдэг бөгөөд зуны улиралд эдгээр өндөрлөг газруудад 6000 гаруй түрээсийн бэлчээрт мал сүргээ бэлчээдэг байна. 2022 оны байдлаар тус улсын хэмжээнд 48.344 фермд 149.578 фермерийн ажилтнууд бүртгэгдсэн байна.

Швейцарын Холбооны Улсын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлээр Хөдөө Аж ахуйн салбарын асуудлыг зохицуулсан байна. Хөдөө аж ахуйн салбарт тогтвортой, зах зээлд чиглэсэн бүтээгдэхүүний бодлого хэрэгжүүлснээр:

- a. Хүн амыг эрүүл, баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангах;
- b. байгалийн баялаг болон хөдөөгийн унаган төрхийг хадгалах, хамгаалах;
- c. хүн амын төвлөрсөн бус суурьшлыг дэмжихэд тус тус хувь нэмэр оруулна гэжээ.²⁷²

Хүн амыг эрүүл, найдвартай хүнсээр хангахдаа ирээдүй, хойч үедээ үржил шимтэй хөрс, цэвэр ундны ус үлдээх бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аргыг ашиглана. Энэ нь экологийн стандарт нь хөдөө аж ахуйн бодлогын чухал зорилт болохыг илэрхийлж байна. Түүнчлэн газар нутгийг арчилж хамгаалах нь мөн хөдөө аж ахуйн салбарын онцгой үүрэг болохыг тодорхойлсон байна. ХАА-н бодлого нь хөдөө орон нутгийг хөгжүүлэхэд онцгой үүрэгтэй бөгөөд үүнийг бүс нутгийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх, түүнчлэн хөдөө аж ахуйн салбарт зориулсан болон бусад ерөнхий хөрөнгө, санхүүжилтийг олгохыг заасан байна.

ХАА-д чиглэсэн бодлого, үйл ажиллагаа

ХАА-д чиглэсэн олон үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаагийн дотор,

- санхүүгийн урамшуулал, татаас олгох (direct payment)
- дэлхийн худалдааны байгууллагын зөвшөөрлөөр ХАА-н бүтээгдэхүүний импортыг хязгаарлах зэрэг багтаж байна.

Хүрээлэн буй орчин болон мал аж ахуйд ээлтэй, байгальд ойр, эдийн засгийн үр өгөөжтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн аргыг ашигласнаар засгийн газраас хөдөө аж ахуйг дэмжих санхүүгийн урамшуулал, татаас, нөхөн олговор (direct payments) зэрэгт хамрагдах боломжтой байна.

Хөдөө аж ахуй, түүн дотроо мал аж ахуйн салбарт үзүүлж буй санхүүгийн дэмжлэгүүд нь дараах төрөлтэй байна.²⁷³ Үүнд:

- **Газар нутаг, бэлчээр ашиглалтын татаас**
 - Газар нутгийг хэт ойжихоос сэргийлэн, зуны улиралд бэлчээрийн зорилгоор ашиглах;
 - Хүнд нөхцөлийн нөхөн олговор олгох;
 - Мал сүргийг зуны улиралд бэлчээрлүүлэхэд урамшуулал олгох.

²⁷² <https://www.fedlex.admin.ch/eli/cc/1999/404/en#a104>

²⁷³ <https://www.blw.admin.ch/blw/en/home/das-blw.html>

- **Биологийн олон төрөл зүйлийн мал, амьтныг өсгөхөд олгох татаас**
 - Үржил шим бүхий мал амьтны төрөл зүйл болон амьдрах орчны олон янз байдлыг хамгаалахад татаас олгох.
- **Бүтээгдэхүүн боловсруулах тогтолцоог дэмжих татаас**
 - Хүрээлэн буй орчин болон мал аж ахуйд ээлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд татаас олгох зэрэг болно.

ХӨДӨӨ АЖ АХУЙД БАРИМТЛАХ БОДЛОГО

Холбооны засгийн газраас “2022 оноос хойш хөдөө аж ахуйд баримтлах бодлого” (Dispatch on the development of agricultural policy after 2022)-ыг баталсан бөгөөд тус улсын хөдөө аж ахуйн салбар нь цаашид бүтээгдэхүүнийхээ нэмүү өртөгт анхаарлаа хандуулах боломж бүхий тогтолцоог бүрдүүлсэн байна. Түүнчлэн тус бодлого нь фермийн үр ашгийг нэмэгдүүлж, байгаль орчинд үзүүлэх нөлөө болон нөхөн сэргээгдэхгүй нөөц баялгийн хэрэглээг бууруулахад чиглэсэн байна.

ХАА-н бодлого нь хөдөө орон нутгийг хөгжүүлэх онцгой үүрэгтэй тул санхүүгийн дэмжлэгээр хөдөөгийн нийгмийн бүтцийг (social structure in rural areas) хадгалах бодлогыг хэрэгжүүлж байна. Үүнд:

- залуу малчид, фермерүүдэд гарааны бизнес эрхлэхэд нь тусалж хүүгүй зээл олгох;
- уулархаг нутаг дэвсгэрт фермийн аж ахуй эрхэлж буй малчид, фермерүүдэд нэмэлт санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Эдийн засаг, боловсрол, судалгааны яам (Federal Department of Economic Affairs, Education and Research)-ны харьяа Холбооны хөдөө аж ахуйн газар (Federal Office for Agriculture)²⁷⁴ нь кантон (аймаг, орон нутаг)-ы захиргаа, фермерүүдийн холбоодтой хамтран, парламент болон засгийн газраас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж, хөдөө аж ахуйн бодлогыг боловсруулахад идэвхтэй үүрэг гүйцэтгэн, хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, үйлдвэрлэх, дотооддоо болон хилийн чанадад худалдан борлуулах шаардлагатай үндсэн нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг. Энэ нь эргээд хөдөө аж ахуйн малчид, тариаланчдын нийт хүн амд болон байгаль орчинд өгөөжтэй үйл ажиллагаа эрхэлсний татаас болдог байна. Малчид, фермерүүдийг дэмжих төрийн болон төрийн бус байгууллагууд дангаараа буюу хамтран үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээрийн нэг нь Швейцар улсын хөдөө аж ахуйн үндэсний хэмжээний төрийн бус байгууллага болох Швейцарын фермерүүдийн холбоо (Swiss Farmers Union) юм. Тус холбоонд 25 кантоны фермерүүдийн нийгэмлэгийн 49.363 фермер өрх гишүүнээр элссэн байна. Мөн 25 кантоны мэргэжлийн

²⁷⁴ <https://www.blw.admin.ch/blw/en/home/das-blw.html>

байгууллага болон төрөл бүрийн худалдааны нийгэмлэгүүдийн төлөөлөгчид тус холбоонд гишүүнчлэлтэй байна. Тус холбооны Хөдөө аж ахуйн танхим нь (Agricultural chamber) 106 гишүүнтэй, Удирдах хороо нь (Executive committee) 24 гишүүнтэй байна.

Холбоо нь дараах салбар, чиглэлүүдийг хариуцсан алба, хэлтсүүдтэй байна. Үүнд:

- Agrisano буюу ХАА-н салбарын даатгал
- Agristat буюу ХАА-н салбарын статистик мэдээлэл
- Agriprof буюу ХАА-н боловсрол, мэргэжлийн сургалт
- Agriquali буюу ХАА-н бүтээгдэхүүний чанарт тавих хяналт
- Agriexpert буюу мэргэжилтнүүдийн зөвлөгөө, сургалт
- Agrimpuls буюу ХАА-н салбарын гадаад харилцаа

Холбооны зорилго нь:

- Бодлогын түвшинд:
 - Бүтээмжтэй, олон талт хөдөө аж ахуйг хөгжүүлэх
 - Үйлдвэрлэгчээс шударга үнэ тогтоох
 - Фермерүүдийг эдийн засгийн бусад салбартай дүйхүүц орлоготой болгох
 - Эрсдэлээс сэргийлэн урт хугацаанд төлөвлөх
 - Өрхийн фермийн аж ахуйг тогтвортой хөгжүүлэх
- ХАА-н бүтээгдэхүүний тэнцвэртэй, ил тод зах зээлийг бий болгох
- Залуу фермерүүдэд сайн боловсрол олгох.

Дээрх зорилгуудын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:

- ХАА-н салбарт бүхэлд нь нөлөөлж буй зах зээлийн болон үнийн асуудлыг шийдвэрлэх
- Олон нийттэй харилцах
- Бүтээгдэхүүний маркетинг, сурталчилгаа хийх
- Фермийн үйл ажиллагааны талаар боловсрол олгох
- Фермер өрх айлуудад үйлчилгээ үзүүлэх
- Зах зээлийн түншүүдтэй харилцаа холбоо тогтоох зэрэг болно.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Agricultural policy <https://www.blw.admin.ch/blw/en/home/politik/agrarpolitik.html>
- Constitution of Swiss Confederation <https://www.fedlex.admin.ch/eli/cc/1999/404/en#a104>
- Federal Office for Agriculture <https://www.blw.admin.ch/blw/en/home/das-blw.html>
- Agricultural subsidy reform in Switzerland
- Swiss Agricultural Policy <https://www.cbd.int/financial/pes/swiss-pesagriculturalpolicy.pdf>
- Swiss Farmers' Union <https://www.sbv-usp.ch/en/>
- <https://eldala.kz/kz/novosti/kazahstan/13133-v-kazahstane-zapushchen-proekt-auyl-amanaty>
- <https://atameken.kz/kk/news/50001-aul-amanat-pomozhet-selchanam>



Холбоо барих:
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Улсын Их Хурлын Тамгын газрын
Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн
Утас: 51-264536, 51-264759